



*Керри
Дил*

Теодор Драйзер

Т.ДРАЙЗЕР

КЕРРИ ЭГЧ

www.kiebooks.com

СОРОНЗОНГИЙН ТАТАХ ХҮЧ, ГАМШГИЙН ЭРХЭНД

Чикаго хот орохоор өдрийн галт тэргэнд сууж яваа Каролина Миберийн бүхий л эд агуурс гэвэл: матрын дууриамал арьсан хулдацтай хямдхан хөвхөн хайрцаг, дотроо төмөр замын билет, Ван-Вьюрен гудамжинд суудаг эгчийнхээ хаягийг тэмдэглэсэн алгын чинээ цаас, дөрөвхөн доллартай шар ширэн түрийвч байлаа.

Энэ бол мянган найман зуун наян есөн оны явдал. Каролина дөнгөж арван найман настай. Сортоолог боловч баахан ичимхий, юм үзэж нүд тайлаагүй, бас залуу зандан насныхсанж элдэв сайхан хүсэл мөрөөдөл толгойд нь багтаж ядах ажээ. Гэр орноо орхин гарахдаа сэтгэл нь бага зэрэг гонсойж байсан нь ямар ч л байсан сайхан юмнаасаа саллаа гэж хоргодсоных биш байлаа.

Ээж нь хамгийн сүүлчийн удаа үнсэхэд нулимс нь гүйлгэнэж, аавынхаа өдрийн цагаар ажил хийдэг салхин тээрмийн дэргэдүүр галт тэрэг давхин өнгөрч байхад хоолойд нь нэг юм тээглэх шиг болж, хэзээний танил хотынх нь зах хязгаар жирэлзэн ногоорч, төрсөн гэр орныхонтойгоо угаас төдий л зузаан байгаагүй барилдалгааг үүрд таслан салан одож буй тэрхэн агшинд цээж нь ихэд давчдан гүнээ сүүрс алдаж явлаа.

Тэр охин ойрын нэг буудал дээр буугаад гэртээ буцаж болох л байлаа. Өдөр бүр зорчин байдаг галт тэргүүдээр бүх орон даяар холбоотой болсон тэр нэгэн их хот сэтгэлийнх нь үзүүр, замын уртад буй бөлгөө. Чикаго хотоос өсөж өндийсөн төрөлх Колумби хот ч нэн их охол бишээ. Хэдэн зуун бээрийн зай буюу хэдэн цагийн газар гэдэг юу билээ?

Каролина, эгчийнхээ хаягийг тэмдэглэсэн цаасаа нэг харснаа өөрийн эрхгүй бодолд автав. Тэгснээ түргэн түргэн жирэлзэн өнгөрөх нов ногоон газар орны байдлыг их л удаан ажиглаж явна. Төдөлгүй анх замд гарахад төрж байсан сэтгэгдэл нь алгуурхан хуучирч шинэ шинэ бодол галт тэрэгнээсээ түрүүлэн толгойд нь үүсэн эргэлдэх Чикаго гэгч ямар хот болохыг тааварлан төсөөлхийг хичээлээ.

Арван найман настай охин, төрсөн гэр орноосоо гараад эсхүл сайн хүмүүстэй золгож гэр орондоо байснаас илүү өөдрөг явдаг, эсхүл ёс суртахууны талаар нийслэлийнхний занд автаж бүр бишдэнэ. Тийм юманд дундаж гэж байдаггүй ажээ.

Өөртэй нь зүйрлэхэд нянгийн төдий бага боловч хамаагүй илүү хүнлэг чанартай хүнийг их хот хорлонт арга баашаараа эрхэндээ оруулан дурыг нь татах нь хашир долиггор этгээдээс ч дутахгүй. Эрх мэдэлдээ орж ирсэн амьтны сэтгэл зүрхэнд хамгийн дээд болосвон хүний нарийн аргаар нэвтрэн орох лут чадал их хотод бий. Түмэндэнгийн мяралзах гэрэл хайр сэтгэлтэнгүүдийн тормолзон гялалзах нүдний тод өнгөнөөс бүдэггүй ажээ. Заль мэхгүй гэнэн хонгор сэтгэлтний ёс суртахууныг уналт л хүн биш болгоход голдуу дөхөм болдог. Чих дөжрөм үсэр их шуугиан, буцлан оргилох мэт амьдралын урсгал, үүрэндээ бужигналдах хэдгэнэ зөгий мэт шороон түмэн эд бүгд л цочирдон гайхсан сэтгэлийг үймүүлэн хөдөлгөнө. хажуугаас нь “мэдэлтэй байгаарай” гэж шивнэх зөвлөгч үгүй, хашир суугаагүй хүний чихэнд тэр хүч ямар их хуурамч нялуун байдлаар дуулдан биедээ татдаг гэж санана! Үнэн мөн чанарыг нь олж мэдээд тийм амаргүй эдгээр хүчин зүйлийн гаднах өнгө нь уянгалан эгшиглэх хөгжиммэт хачин сайхан сонсдон эхлээд биеэ барьсан байдлыг алдагдуулж дараа нь сэтгэл санаагийг нь султгаад эцэс сүүлд нь хүний хамгийн эгэл санаа бодлыг гуйвуулан замыг нь алдуулна.

Каролина буюу гэр орныхон нь энхрийлэхдээ Керри эгч хэмээн нэршсэн тэр залуу хүүхэнд үзсэн

харснаа ажиг, учры нь тунгаан бодох чадвар хараахан суугаагүй ажээ. Өөрийгөө юм бүхнээс илүүд боддог аминчхан зан нь тийм их тодроогүй боловч зан араншингийнх нь гол шинж болж байлаа. Залуу халуун насны хүсэл мөрөөдөлд урам бадарсан шилжилтийн насандаа цэврүү шиг булбарай, хожим бие галбир сайтай баймаар, нүд нь төрлхийн хийморь сэргэлэн байдлыг илтгэсэн, нэг үгээр хэлэхэд Европоос цагаачлан ирэд дөнгөж хоёр үе мултарсан дунд ангийн америк эмэгтэйн сайхан дүрийг шингээжээ.

Керри, эрдэм мэдлэгийн ертөнцийн нууцаас дэндүү хол учир ном хэвлэл уншихыг шохоорхохгүй. Маяглан сээтэгнэх гэж юу байдгийг хараахан мэдэхгүй байв. Толгойгоо танихилзуулан гэдрэг хаяж чадахгүй, гараа хийх газраа олж ядан жижиг хөлөө эвдүй муутай болхидуу алхана. Гэсэн ч гаднаасаа аятайхан харагдах хүсэл төрж амьдралын сайн сайхан юу болохыг төлхөн ойлгоод эд хөмрөгийг төлөө тэмүүлэх болжээ.

Керри эгч нэг ёсондоо, том хотыг уландаа гишгэн байлдан дагуулагчийн олз нь болж хувирах тийм нэгэн ялалт алсдаа ирнэ гэсэн бүүр түүр ухаан жолоогүй хүслэнд автан муухайн зэвсэгтэй чадуухан биетэй атал азаа үзэхээр хатан зориг гарган дайрах морьтон батаар шиг л байлаа.

- Энэ чинь Висконсин муж улсын хамгийн сайхан рашаан сувиллын бэсрэг газрын нэг шүү дээ гэж нэг хүн хэлэх чимээ чихнийх нь дээхэн талд сонсдов.

- Өө, тийм үү? Гэж Керри үл мэдэг тулгамдсан янзтай хэлэв.

Галт тэрэг, Вокиш өртөөг өнгөрчээ. Ард нь сууж яваа нэг эр, өтгөн гэзэг үсий нь ажин шохоорхож байгааг Керри аль хэдийн тааварлажээ. Тэр хүн суудалдаа тайван сууж чадахгүй өөрийг нь шохоорхож буйгч зөнгөөрөө гадарлав. Охин угаас даруухан зантай, таньж мэдэхгүй хүнтэй хамаагүй ярих эвгүй гээд түүнд нүүр өгөлгүй дөлөх нь зүйтэй гэж бодож байсан боловч юм үзэж нүд тайлан долиггоршсон хөршийнх нь зориг, татах хүичн давамгайлж Керри арга буюу ам нээхэд хүрчээ.

Тэр хүн, урагшаа алимгүй бөхийж суудлынх нь арыг тохойлдоод өөрийгөө тун аятайхан замын хань юмдаа гэж бодуулах санаатайгаар,

- Үнэхээр сайхан газар шүү, буурчийн газруудынх нь гоёыг яана. Чикагийнхан энд амарцгаадаг юмдаа. Та, янз нь, энэ нутгийг мэдэхгүй хүн шиг байна, тийм үү? Гэхэд Керри,

- Үгүй, мэднэ, би өөрөө Колумби хотод байдаг, харин энд урьд ирж үзээгүй гэхэд,

- Тэгвэл та Чикагод анх удаа ирж байгаа юм шивдээ гэв.

Тийнхүү ярьж суухдаа Керри, тр хүнийг сэмхэн ажиглаж хараад авчээ. Улаа бутарсан хацартай, цайвардуу сахалтай, толгой дээрээ нарийн эсгий бүрх малгай тавьсан харагдана. Тэгээд эргэнгээ царай руу нь ширтэн харав. Биеэ хамгаалах зан, эмэгтэй хүний аальгүй зан хоёр харцанд нь илхэн.

- Би анх удаа явж байгаа хүн гэж хэлээгүй шүү! гэж Керрийг хэлэхэд нөгөө хүн нь өөрийнхөө эндүүрсэнд гайхаж буйг илэрхийлэн ялдамхан инээвхийлж:

- Өө, надад тэгж санагдсан юм л даа.

Тэр бол худалдааны том хөрөнгөтөн пүүсийн жинхэнэ доншуур наймаачин бөгөөд тэр үеийн этгээд хэлэнд “бөмбөрчин” гэж нэр зүүсэн тийм хүмүүсийн нэг ажээ. Сэтгэлгээ нь эмзэгхэн залуухан эмэгтэйчүүдийн сэтгэл зүрхийг татах зорилгоор хувцас хунар, зан байдлаа тааруулдаг байсан тийм хүмүүсийг тодорхойлон, наяд оны үед Америкт ихэд дэлгэрсэн нэлээд сүүлийн үеийн бас нэг нэр ч тэр хүнд илт таарах юм. Тийм хүмүүсийг “анжгай” гэдэг байжээ.

Түүний дөрвөлжин хээтэй хүрэн өнгийн ноосон костюм тэр үедээ шинэ зүйл байсан бөгөөд сүүлдээ худалдаа-үйлдвэрийн хүний ерийн хувцас болжээ. Хантаазных нь ханхар энгэрийн цаанаас цагаан ягаан өнгө хосолсон ёудалтай цардмал цамцны энгэр цухуйна. Гадуур цамцных нь ханцуй мөн тийм судалтай зузаалсан нударга, “мигуйн нүд” хэмээх ердийн шар гартаам шитгэсэн алтадмал том тээглүүр харагдана. Хуруундаа хэд хэдэн бөлзөг хийсний дотор тамган тэмдэгтэй том томбогор бөгж байна. Хантаазных нь жижигхэн халааснаас цагны алтан оосор унжиж дээр нь Хандгайн нууц одонгийн зоос санжигнана. Костюм нь арай ч жадгар юм уу гэмээр. Гял цал болтол арчсан зузаан ултай хүрэн шаахай, саарал өнгийн зөөлөн бүрх ганганд нь нэмэр болно.

Керрийн хөгжлийн хэр хэмжээнд бөуй хүнд, тэр үл таних хүн үнэхээр сонирхмоор санагдах агаад хальт хармагцаа түүнд татагдсан нь арга буюу. Тиймэрхүү хүмүүс энэ хорвоод алга боллоо гэхэд тэдний зэгсэн ажилттай хэрэглэдэг арга бааший нь миний бие энд дүрслэхийг соёрхом уу. Сайн хувцас гэгч тэдэнд хамгийн чухал зүйл мөн, тийм юмгүйгээр мань улс амбан явахгүй. Эмэгтэй хүнд шунан хорхойтохын тулд бие бялдрын хувьд чийрэг байх нь бас чухал. Ертөнцийг жолоодогч хүч ба асуудлын тухай огт боддоггүй тэдний оюун санаа нь ч, үйл ажил нь ч авангар хомхой сэтгэлдээ хөтлөгдөхөөсөө, ужид цэнгэлд ханах цадахыг үл мэдэн шуналдаа л хөтлөгдөнө. Тэдний арга бааш хэзээд эгэл. Давын өмнө сээвгэрүүдийг хүсэмжлэн тачаадахын эрхээр хүчтэй болдог зориг бол түүний го нэг шинж мөн. Залуу хүүхэнтэй уулзлаа гэхэд үл ялих царайдах маягтайгаар нүүрэмгий атлаа аяы нь дагасхийн эргүүлж эхлэнэ. Цаад хүүхэн нь сээтэгнэж эхэлбэл мань гайхал зангиа бүчийг нь эвтэйхэн засах байдал үзүүлэн хэрэв “загатнасан газар нь маажих шиг болбол” даруй чи, би гээд эхэлнэ. Жишээ нь, их дэлгүүрт ороод лангуугий нь тохойлдон зогсоод худалдагч хүүхэнд санаа өгмөөр хэд хэдэн асуулт тавтна. Илүү хээнцэр дэгжин хүмүүсийн дунд юмуу галт тэрэг, түүнчлэн хүлээх өрөөнд бол нэлээд болгоомжилно. Тэгээд аяы нь олж болмоор амьтан харагдвал сайн хүн болох гэж байдгаараа мэрийнэ. Тэнгэрийн байдал ярьж, вагоны үүд хаалгыг хачин сайхан ялдамхан нээж, хөвхөн хайрцаг савнаас нь зөөлцөж өгөх гэнэ., гэвч энэ нь бүтэхгүй бол хажуу хавирганд нь сууж дараачийн галт тэргэнд сууж аога болчихоос нь өмнө эргүүлдэхийг оролдоно доо. Толгой дор нь жинтүү тавьж өгөх, энэ номыг уншихгүй юу гэхэ, хөлд нь исэр тавьж өгөх, цонхных нь хөшгийг буулгаж өгөх мэтээр элдэв дээдээр үйлчилнэ. Буух газар нь ирэхэд санасан нь бүтээгүй бол тээшнээс нь барилцаад хамт гарахгүй хоцорно доо.

Хувцас хунарын талаар эмэгтэйчүүдийн хэн нэг нь гүн ухааны зохиол бичвэл таарна. Хичнээн нас залуухан гэхнээ бүсгүй хүн хувцас хунар мэдэхдээ догь байдаг. Эрэгтэй хүний хувцсыг үнэлэн үзэхдээ, тэр эрийг сонирхох тал байнаа уу үгүй юу гэсэн нэг заагархуу юм баримталдаг бололтой. Тэр заагархуу юмнаасаа доогуур орсон эрийг нэгч хяламхийхгүй. Өөрийнхөө хувцсыг эр хүний хувцастай зүйрлэж бодох бас нэг зааг байдаг байна. Керрийн тохой хавиар хоргодоод байгаа тэр хүн л Керрийг яг тийм зүйрлэл хийхэд хүргэжээ. Хувцсаа тэр хүнийхтэй зүйрлэх юмгүйг Керри мэдлээ. Хар тасамтай муу хөх бошинз нь дэндүү олхтогүй бас гутал муутайгаа ч саналаа.

- Танай хотод миний таних хүн олон бий шүү. Бэлэн хувцасны дэлгүүрийн Морган-рот, бөс даавууны дэлгүүрийн Гибсон ч гэх юмуу...өөр...гэж нөгөө хүн олон үг дэлгэв.

- Өө, тийм үү? Гэж Керри хариулахдаа тэр дэлгүүрүүдийн цонхон дээр боов горьдсон хүүхэд шиг хичнээн цаг баран халаглан зовдог байснаа санав.

Доншуурч, таарах түлхүүрий нь олоод анхаарлы нь татав бололтой гэдгээ мэдэв. Тэгээд хэдхэн хормын дараа мань эр бүр хүүхэнд ойртон суугаад бэлэн хувцас худалдах талаар байгуулсан гэрээ хэлэлцээ, өөрийнхөө тэнүүчилсэн тухай, Чикаго хот боло тэндхийн зугаа цэнгэлийн талаар ярьж эхэлжээ.

-Та Чикагод очиж байгаа болохоор тэр хот танд их таалагдаж дээ. Тэнд ах дүү садангаас чинь бий биз дээ?

-Би эгчийндээ очихоор явж байгаа юм.

-Линкольны цэцэрлэгт хүрээлэн, Мичиганы модот талбайг заавал үзээрэй. Тэнд ёстой мундаг мундаг байшин барилга босч байгаа шүү! Ёстой л хоёрдугаар Нью-Йорк даа. Гайхалтай хот шүү. Үзэх юм мундахгүй, олон театр, үй түмэн хүн амьтан, сайхан сайхан байшин, тун сайхан санагдана даа!

Тэр хүний ярьж буйг сайн дүрслэн төсөөлөх гэж Керри оролдтол гэнэт сэтгэлд нь гуниг төрөв. Тэр аугаа их юм бүхэнтэй өөрийгөө зүйрлэхэд даанч эрхийн чинээ өчүүхэн санагджээ. Жаргалд дураараа умбах тийм газар ирж буй биш гэдгээ Керри сайн мэдэх боловч тэр хүний ярьж хэлж байгаа бүхэнд нэг л горьдол төрмөөр санагдана. Сайхан хувцастай энэ хүн өөрт нь сүйд болж байгаад баярлана.

Нэрд ир гарсан нэг жүжигчин эмэгтэйн тухай ярьж өөрийг нь тэр жүжигчинтэй төстэй байна гэхэд Керри инээдээ барьж чадсангүй мишилзэв. Уг нь ухаан мулгуу хүүхэн биш гэхнээ тэгж хэлэхэд нь жаахан хөөрчээ.

- Та Чикагод нэлээд байх юм байгаа биз дээ? гэж тэр хүн аанай эрээ цээргүй ярингаа асуулаа.

- Үнэндээ сайн мэдэхгүй байна гэж Керри булзангуй хэлсэн нь ажил олдохгүй бол яана гэсэн бодол толгойд нь харван орсных ажээ.

- Ямар ч болтугай хэдэн долоо хоног болох юм байгаа биз дээ? гэж хөрш нь нүд рүү нь шимтэн харж асуув.

Тэр хоёрын хооронд болсон зүйл, ярилцсан үгнээс нь илүү учиртай байв. Залуу хүүхэнд гоо үзэсгэлэнгээс нь илүү ид шидтэй гэмээр гоо чанар нь буйг мань эр гадарлажээ. Тэр хүн эр хүний шалиг зангаар л марзганаж байна гэж Керри сайн ойлгох боловч бүсгүй хүн гэгч тимй явдлаас айх мөртлөө дотроо баярлаж байдаг билээ. Керри өөрийнхөө жинхэнэ санаа сэтгэлийг нууж хаахад нь тус болдог эмэгтэй хүний ялимгүй аальгүй байдал гаргаж сураагүй байсан болохоор тун ч эгэл байлаа. Харин зарим талаар нэлээд зоримог мэт санагдана. Түүнд ухаалаг, хашир сайн найз байсан бол, жишээ нь, эр хүний нүд рүү ингэж битгий их ширтэж бай гэж хэлэхсэн.

- Та юугий нь сонирхоод байгаа юм? гэж Керри асуудах цаадах нь:

- Зүгээр л, би өөрөө Чикагод хэдэн долоо хонох болохоор асуусан юм. Пүүсийнхээ бараа таваарыг сайн үзэж шинэ шинэ загвар бэлтгэх юм. Тэр зуураа би таныг энэ хоттой танилцуулж болно шүү гэв.

- Бүү мэддээ, та чадах болов уу... Үгүй, би яах бол, би эгчийндээ байх хүн шүү дээ, тэгээд...

- Эгч чинь дургүйцлээ гэхэд хоёул аргаж болно шүү дээ гээд хэзээний за-зүй болмон юм шиг, өврийн дэвтэр, харандаагаа халааснаасаа гарагж ирээд:

- Таны хаяг юу билээ? гэхэд Керри эгчийнхээ хаягтай цаасыг гаргаж ирэх гэж түрийвчээ уудлав.

Хамт яваа хүн нь өмднийхөө арын халааснаас зузаан гэгчийн түрийвч гарган нээхэд өдий төдий ногоон дэвсгэрт учиргүй олон зурвас, тасалбар харагдана. Керрийн таньдаг хүмүүсийн хэнд нь ч тийм түрийвч байдаггүй байсан учраас сайхь түрийвч сүрхий их сэтгэгдэл төрүүлэв. Ер тийм хашир жуулчин, тийм ганган дэгжин хүн насандаа үзээгүй явжээ. Түрийвч, гялалзсан хүрэн шаахай, цоо шинэ гоё костюм, хөдлөх гишгэх, хэлэх үг бүр нь тод томруун-энэ бүхнээс бодвол хөлгүй баян хүн байна гэж охин нэгэнт бодсон учир тэр хүний юу гэж хэлхий нь хэрэг болгож сонсохоор шийдсэн бололтой.

Түрийвчин дотроосоо пүүсийнхээ “Бартлет, Карио ба Түнш” гэсэн гоё гэгчийн, доод талынхаа зүүн буланд “Чарльз Дрүэ” гэсэн нэмэлт бичигтэй дармал үсэгтэй нэрийн хуудас гаргаж ирэв.

- Миний нэр энэ. “Дрүэ” гэдэг, эцэг маань франц хүн байсан гэж Керрид нэрийхээ хуудсыг өгөхдөө хэлэв.

Дрүэг түрийвчээ цааш нь хийх хооронд Керри нэрийнх нь хуудсыг харж байлаа. Дрүэ цамцныхаа дотуур халааснаас бөөн захидал гарган ирж нэг зураг зааж хэлэх нь:

- Энэ бол манай пүүсийн байшин. Стейт-Лейкстрит гудамжны буланд байдаг юм гэлээ.

Тэгж хэлэхдээ их л бардсан янзтай байв. Тийм пүүсэнд алба хаана гэдэг эрхбиш зүгээргүй, тийм бодол хүүхэнд төрөөсэй гэж мань эр хүсэв.

- Таны хаяг юу билээ? гэж дахин асуугаад өврийнхөө дэвтрийг бэлтгэв.

- Керри Мибер. Ван Бьюрен-стритын Баруун тал, гурван зуун тавин дөрөвдүгээр байшин Нэнсоных гэж удаанаар хэлэв. Дрүэ хаягий нь нарийн сайн бичиж аваад дахин түрийвчээ гарган ирж тэмдэглэлийнхээ дэвтрийг далд хийв.

- Би танайхаар нэг дэх өдрийн орой очвол та гэртээ байх болов уу?

- Байх байх аа.

Үгү гэдэг бол маш олон бодол, мэдрэцийн сүүдэр төдий юм гэдэг тун үнэн шүү! Үг бол үл сонсдох эрмэлзэл, мэдрэцийг холбогч үл мэдэг сонсдох өчүүхэн шижим юм.

Тэр хоёр галт тэрэгний дотор цөөн хэдэн үг харилцан сольж, түрийвч, цүнх гаргаж, нэрийн хуудас сонирхон хажр байсан боловч нэгнийх нь жинхэнэ сэтгэл бодол нөгөөдөө хичнээн таавар мэт буйг ухаараагүй буй за. Нэгнийхээ дотор юу гэж бодож байгааг аль нь ч, эр нь ч, эм нь ч

тааж мэдэх нэвтрэхий ухаантай байсангүй. Хүүхнийг биедээ татаж чадсан эссэнээ марь эр сайн мэдэхгүй л байлаа. Хаягаа өгөөгүй цагт арганд нь ороогүй гэсэн үг гэдгээ эмэгтэй нь ойлгосонгүй. Харин сүүлд нь бодохноо тэр хүний эрхэнд орчихлоо гэж хүүхэн ухаар чбайхад, хаягий нь авснаараа одоо ч гартаа оруулав гэж санй эр боджээ. Тэгээд хоёул ямар ч болтугай холбоо хэлхээтэй болсноо ухаарав. Мань эр, өөрийнхөө санасан зоргоор яриагаа чиглүүлж залах боломжтой болж эхлэх нь тэр. Бүр үг хэл нь олширч эхлэхэд нь хүүхэн ч биеэ нэг их барихыг болив.

Чикаго хотод ойртоход дохионы гэрэл гялс гялс мяралзана. Галт тэргүүд хажуугаар хурдлан өнгөрнө. Тэгшхэн эрчилгүй талын дундуур цахилгаан шугамны багана эгнээ эгнээгээр хотын зүг дэлхэн ойртох мэт. Тэртээ хол хотын зах нэгэнт нүднээ тусах болж үйлдвэрийн өндөр яндангууд тэнгэр самардан ёрдойлдоно.

Хашаалаагүй бөгөөд эргэн тойрондоо ургасан мод ч үгүй хоёр давхар модон байшингууд энд тэнд ганц ганцаараа олонтаа харагдах нь давшин айсуу их цэргийн толгойн сэргийлэхийн түр оромж мэт.

Угаас ухаан сэргэлэн, хэзээ ч жуулчилж яваагүй хүүхэд хүн том хотод орйтож ирэхдээ сонин хачин юм үзэгдэнэ гэж бодно. Ялагнгуяа гэрэл, харанхуй хоёр тэмцэлдэж, бүх амьд ертөнц нэг байдлаас нөгөө байдалд шилжиж байдаг үдшийн бүрэнхий мэт тийм нууцлагтай цагт бүр ч хачин санагдах билээ. Айсуу шөнийн тийм шайхашиг уу! Ядарч чилээрхсэн хүнд хичнээн таатай санагдана! Урьдын хүслэн мөрөөдлийг хичнээн их сэргээнэ вэ! Чилээрхсэн хөдөлмөрчин хүний дотор: “Би удахгүй толгой мэдэлтэй болно! Цэнгэлдэгч олны дотор орж тэдэнтэй цуг жаргана. Тэр сайхан гудамж, цэлийсэн гэрэлтэй дэнлүү, зоог бэлдсэн хурц гэрэлтэй өрөө тасалгаа тэр бүгд минийх. Амрах жаргахын замд хөтөлдөг театр, лаврин, хурал хуй, жуулчлал, зугаалан цэнгэх дуу хуурын замд хөтлөгч жим харгуй тэр бүхэн шөнө болсон хойно бүгд минийх болно!” гэсэн бодол төрж сэтгэлийг зогооно... Хүн төрөлтэй бүхэн албан тасалгаа буюу үйлдвэрийн газарт чиг чигтээ ажилд дарагдан бахй боловч үдшийн жаргаланг мөрөөдөн хүсэмжлэх мэдрэц бие сэтгэлийг гижигдэнэ. Өөрөөр хэлэхэд, тэр болгон гүйцэд болж өгдөггүй тий мэдрэц хамгийн хэнэггүй хүнд боловч төрж, мөрөн дээрээс нь нүсэр хүнд ачаа аваад хаяих шиг санагдана.

Керри цонхоор гадагш харав. Залуу хүүхэн том хотыг шохоорхон сонирхоход зальтай эр ч аяы нь дагахаас аргагүй болж хотын гайхамшгийн тухай ярихдаа урьд урьдынхаасаа өөрөөр ажих болжээ.

- Энэ бол Чикаго хотын баруун хойд хэсэг. Чикаго гол тэнд харагдаж байна гэж Дрүэ булингартай голыг заахад буржин чулуут эргийн ёрдойлдсон хар хар багана руу хамраан шаасан гурван дарвуулт хөлөг онгоцууд багшралдах нь алс холын далай тэнгисээс ирсэн бололтой.

Гэлт тэрэг ёнгинотол дуугаран дугуй нь түчигнэн тачигнан явсаар галын тэртээ гарав.

- Чикаго улам томорсоор байгаа, тун сайхан хот, үзэх юм танд мундахгүй их гэж Дрүэ цааш нь ярихад Керри бараг үгий нь сонсолгүй өнгөрсний учир гэвэл гэнэт гэр орноосоо холдож хүний газар гав нагцаар тийм хязгааргүй амьдрал хүслэнгийн далайд орж явчсанаа бодоод өөрийн эрхгүй айсан ажээ. Амьсгаа нь давчдаж зүрх нь цохилон бөөлжис нь ч цутгах шиг болов. Тэгэхлээр нь нүдээ аньж энэ бүхэн дэмий хоосон бодол. Колумби хот энүүхэнд бий гэж итгэхийг оролдож нэг үзлээ.

Галт тэрэгний үйлчлэгч хаалга үүд тачигнуулан онгойлгож:

- Чикаго, Чикаго! Гэж хашгирна.

Галт тэрэг явсаар аалзны шүлс шиг хэрээлдсэн олон төмөр замтай газар орж очиход чих дөжрөм тар түр, түг таг дуун тасрахгүй болов. Керри муу хөвхөн хайрцгаа нэг гартаа барьж нөгөөдөө түрийвчээ чанга гэгч нь атгав.

Дрүү ч босож, хөлийнхөө дадмаг хөдөлгөөнөөр өмдөө засаад цоо шинэ шар хөвхөн хайрцгаа авлаа.

- Таны ах дүү садан чинь тосно биз дээ? Чемоданы чинь би барих уу? гэхэд Керри түргэнээр:

- Үгүй яах юм! Юугаа хийх вэ зүгэр. Эгчийг ирэхэд та минийхажууд битгий байгаарай гэв.

- За гэж тэр хүн өчүүхэн ч гомдсон байдлагүй хэлээд- Гэсэн ч юмыг яа мэдэх вэ, хэрэв эгч чинь ирэхгүй бол би ойролцоо байж байгаад өөрий тань эгчийнд чинь аваачиж өгье гэв.

Урьд ердөө тиймрэхүү байдалд орж үзээгүй тул эвгүйвтэр байсан боловч хүн тэгж хамламжлах тун аятайхан санадсанд Керри:

- Та их сайн хүн юмаа гэв.

- Чикаго! Гэж дахиад л үйлчлэгчийн багалзуурдах сонсдоно.

Галт тэрэг мөлхөх мэт удаан явсаар дөнгөж сая гэрэл нь цэлс цэлс асах асар том хүнхгэр саравчтхй буудалд хүрэв. Зорчигчид бүгд босон гарах гэж хаалган дээр шавааралдав.

- За хүрээд ирлээ шүү дээ, бид чинь. Баяртай, нэг дэх өдөр хүртэл баяртай гэж Дрүү үүд рүү дөхөнгөө хэлэхэд Керри:

- Баяртай гэж хэлээд сарвайсан гары нь атгалаа.

- Эгч чинь ирээд аваад явахаас нааш би нүд салгахгүй шүү!

Керри тэгж хэлхий нь сонсоод өөдөөс нь харж инээмсэглэв.

Зорчигчид цөөрөн цөөрсөөр Дрүү, Керрийг харахгүй байгаа царай гаргана. Буудал дээр хийморь муутай, ядарч зүдэрсэн царайтай нэг бүсгүй хүн Керрийг танив бололтой ухасхийж:

- Өө, сайн уу, Керри гэж хэлээд дүүгээ эв дүй муутай тэврэв.

Нөгөө халамжтай байсан орчин нүд ирмэхийн зуур хувирахыг Керри гадарлав. Хөл хөдөлгөөн, дуу шуугиан, огт үзээгүй сонсоогүй цоо шинэ байдлын дунд тийнхүү ороход цэвдэг хүйтэн үнэн байдал бие бэтгэлий нь жиндүүлж эхлэв бололтой. Юуны чинь зугаа цэнгэл, нар нь шингэдэггүй жаргалын ертөнц! Юуны чинь аагаа барж ядсан тарган цатгалан жаргал! Сэтгэлийн гүн шаналгаа, хүнд хүчир ажлын арилшгүй ул мөр эгчийнх нь царайд бичээстэй мэт тод амуй.

- Цаадуул чинь сайн сууж байна уу даа? Ээж, аав бүгд эсэн мэнд үү? Гэж тэр авгай асуухад Керри

хару үг хэлэх боловч нүдний нь хараа тэртээ алсад тусна. Хүллээх тасалгаа, гудамжны аль руу нь ч орох тэртээ буланд Дрүү зогсож харагдана. Дрүү ч эргэн харлаа. Керри өөрий нь олж харсныг эгчийнхэ хамт явааг нь Дрүү мэдээд инээвхийлснээ цааш явав. Керри ч ганцаараа үүний нь ажиглаж амжлаа. Холдоод явчихы нь харахдаа Керри нэг их юм алдчих шиг болжээ. Бүр бараа нь тасрахад түүнийг үгүйлж эхэлсэн байна. Одоо эгчтэйгээ уулзсэн биш, бүр ч ганцаардмал болох шиг, ажигч үгүй оволзонн долгиолох их далайн мандалд гав ганцаар хаягдан хоцрох шиг санагджээ.

ҮГҮЙРЛИЙН ГАЙ, БОРЖИН МӨНГӨ ХОЁР

Жилдээ тавиад мянган хүн гаднаас ирж байдаг бөгөөд ирсээр ч байгаа Баруун ван Бүрьен гудамжинд, тэр үедээ дан барй гэж нэрлэгдэж байсан байшингийн гуравдугаар давхарт Керрийн эгч Миннийнх суудаг байлаа. Үдэш болоход хүнсний дэлгүүрүүдийн гэрэл урд талынх нь цонхоор ярайж тэр хавийн хүүхдүүд тоглон бужигналдана. Хөлсний морин тэрэгнүүдийн жижиг хонхны хангир жингэр дуу чимээ нэг ойрхон нэг холдон дуулдах нь Керрийн чихэнд үлгэр домог мэт сайхан санагдана. Минни, түүнийг урагш харсан цонхтой нэг өрөөндөө оруулахдаа Керри гудамжны дуу шуугиан, хөл хөдөлгөөн, тал тал тийшээ олон бээр үргэлжлэн тэлсэн аварга том хотын хүнгэнэх нөр их чимээг цонхоороо ажин гайхан зогслоо.

Хэнсон авгай буюу Керрийн эгч хэдэн үг солилцсоны дараа оройн хоол унд бэлтгэх гэж жаалаа Керрид бариулаад гал тогоондоо ороход хүргэн ах нь Керрийгээс хэдэн юм асуусан болоод оройнхоо сонин уншин суув. Тэр бол Амекрикт төрсөн швед эцэгтэй дуу цөөнтэй хүн, эдүгээ ярганы газрын хөргүүрийн галт тэргэнд цэвэрлэгчээр ажилладаг ажээ. Эхнэрийнхээ эгч дүү нар ирж байна уу үгүй юу түүнд огт падгүй ажээ. Харахад нэг их онцгой юм алга гэж Керрийн талаар длотроо бодов. Ганц сонирхсон юм нь Чикагод Керри ажил олох болов уу гэдэгт байв.

- Том газар. Хэд хоногоос нэг ажилд орно биз дээ. Ирсэн хүн болгон л тэгж байгаа юм чинь гэжээ.

Энэ бол түүнийг ажилд орж орон байр, хоолныхоо мөнгийг олох хэрэгтэй шүү гэсэн илт санаа юм. Тун их харамч хахир хүн бөгөөд хотын баруун хэсэгт хоёр ч хэсэг жаахан газар худалдаж авах гэж мөнгий нь хэдэн сарын турш цувруулан төлж байгаа юм байж. Тэндээ нэг мэдэхэд өөрийн гэсэн орон байшинтай болох хүсэлтэй ажээ.

Хоол болтол Керри тэднийхийг баахан ажиглаж амжив. Ер нь эмэгтэй хүнд байдаг ажигч нарийн гярхай чанар Керрид ч бий.

Тэднийх ядуухан, зүдрүү амь зууж байдгийг тааварлав. Өрөөнүүдийнхээ ханыг өнгө ая нь таараагүй цаасаар хулджээ. Шалан дээрээ муухан журам дэвссэн, зочны өрөөндөө нохойн хэл шиг нарийхан нимгэн хивсэрхүү юм хаяжээ. Гэрийн тавилгын хувьд гэвэл тун гавихгүй энд тэндээс зээлээр олж тавьсан бололтой.

Керри хүүхдий нь тэвэрсээр гал тогооных нь өрөөнд орж Миннитэй аар саар юм ярин сууж байтал хүүхэд уйлахад Керри босож бүүвэйлэн явахад Хэнсон сонингоо орхин орж ирээд хүүхдээ аваад явлаа. Энэ бол түүний сайн чанар ажээ. Яггүй тэвчээртэй хүлцэнгүй хүн. Хүүхдэдээ тун ч онгог бололтой.

- Алийв, алийв, за-за гэж хүүхдээ аргадан өхөөрдөн үглэхэд нь швед аялга мэдэгдэж байлаа.

- Эхлээд чи хот үзнэ биз дээ? Сайн өдөр цөмөөрөө явж Линкольны цэцэрлэгийг үзүүлэмз гэж Мини хоол идэх хоорондоо хэлэв.

Хэнсон юу ч дуугарсангүйг Керри ажлаа. Өөр л юм бодоод байгаа бололтой.

- “За, би маргаашнаас энэ хавиар ажил эрнээ. Баасан, бямба гээд хоёр ч өдөр байна, амжих байлгүй, хаагуур явбал дээр бол?” гэж Керри асуухад Минни тайлбарлаж эхлэх гэсэн боловч

нөхөр нь урьтаж:

- Ийшээ гэж зүүн тийш гараараа заагаад-энэ бол зүүн тал гэснээ Чикаго хотын ерөнхий байдлын талаар насандаа анх удаа тун ч дэлгэрэнгүй ярих шиг боллоо.

“Фрэнклин гудамжийн дагуух том том байшингуудаар, яг л эргийн цаад талаар шүү дээ, тэгээд л явбал дээр шүү” Тэнд олон хүүхэн ажилладаг. Чи ч гэсэн гэрээ олоход амар. Эндээс нэг их холгүй гэж хүргэн ах нь эцэст нь дүгнэв.

Керри толгой дохиод эгчээсээ айл хөршүүдий нь асуулаа. Олигтой сайн мэдэхгүй учраас өөрийнхөө мэдэх хирээр бага сага ярихчаа болоход нөхөр нь хүүхэдтэйгээ ноололдсоор байлаа. Тэгснээ босоод хүүхдээ эхнэртээ тушаагаад:

- Маргааш өглөө эрт босох хэрэгтэй, одоо хэвтлээ гээд хөлийн өөрийн цаанах унтлагынхаа харанхуй өрөө рүү алга болон одов.

- Ярганы газар ажилтай их хол, өглөө тав хагаст босохгүй бол амждаггүй юм гэж Минни тайлбарлав.

- Та өглөө хэдэд босож хоол ундыг нь бэлддэг вэ?

- Тав хорийн алдад.

Керри аяга таваг, сав суулга угааж, Минни хүүхдээ тайчиж унтуулахаар хэвтүүлж тийнхүү тэр нэг өдрийн ажлыг дуусгав. Минни ажилдаа их л сурамгайг Керри ажаад гэр орны ажилд өглөөнөөс шөнө хүртэл борви бохисхийлгүй зүтгэдэг байх нь гэж бодлоо.

Дрүэтэй уулзахаа больдог ч юм билүү гэж бодсоноо лав л эднийд ирүүлэх хэрэг алга гэж шийдэв. Хэнсоны байж байгаа ёр, Миннигийн доромж байдал, ер нь тэднийх гэдэг айл шар наран бор хоног өнгөрөхөөс цаашгүй болох нь илт байлаа. Хэнсон өдөр бүр урд талынхөө өрөөнд орж ирээд сонингоо уншсаар есөн цагт унтаад дараа нь Минни дагаж дугжраад байх юм бол өөрийг нь тэр хоёр яа гэх улс вэ? Ямар ч атугай хэн нэг хүнтэй маасганахыг бодохын оронд ажилд орж хоол унд, сууцныхаа мөнгийг төлдөг болох нь давын түрүү хэрэгтэй юм байна гэж бодохоос Дрүэтэй танилцсан нь дэмий мэт санагдлаа.

“Ямар ч гэсэн энд л ирүүлж болохгүй” гэж Керри дотроо бодов.

Тэгээд эгчээсээ үзэг бэх сураглаж гал тогооных нь зуухан дээрээс аваад арван цагт Минни-г орондоо ороход Дрүэгийн нэрийн хуудсыг цүнхнээсээ гарган авч захидал бичиж эхлэв. “Таныг би энд ирүүлж чадахгүй нь байна шүү, надаас захидал очтол хүлээж байгаарай. Манай эгчийн байр дэндүү жаахан юм” гэж бичээд ву гэж төгсгөх билээ гэж нэлээд мэгдсэнээ галттэргэнд хэрхэн танилцсан тухайгаасаа бичье үү гэсэн боловч айгаад чадсангүй. Харин тийнхүү сайхан танилцаж байсанд нь эгэл үгээр талархаад эцэст нь юу гэж хэлж ёслох билээ хэмээн бодсоноо “таныг хүндэтгэн ёсолсон” гэж бичих гэснээ болиод “танд үнэнч” гэж орхиод нэрээ тавив. Тэгээд захидлаа нааж хаяглав. Унтах орноос нь өөр юу ч үгүй жижигхэн өрөөнийхөө задгай цонхон дээр эргэдэг сандал дээр суугаад шөнийн харанхуйд хотын гудамж хэрхэн үзэгддэгийг дув дуугүй ажиглав. Сүүлдээ өөрийнхөө бодолд ядран сандал дээрээ нозоорон байсхийснээ нойр хүрэн тул хувцсаа тайчин орондоо орлоо.

Өглөө нь наймаг цагт сэрвэл Хэнсон аль хэдийн ажилдаа явсан, эгч нь зочны өрөө болдог хоолныхоо өрөөнд юм оёод сууж байв. Хувцас хунраа өмссөнийхөө дараа жаахан юм идэж уугаад хотын хаагуур хаагуур явбал дээр болох талаар эгчтэйгээ зөвлөв. Минни эгч нь урьд уулзсанаас хойш их л өөрчлөгдсөн харагдана! Одоо хэдийгээр гүжирмэг боловч туранхай, хорин долоо хүрч, өтлөх маяг орсон авгай болжээ. Үзэл бодол нь нөхрийгөө дагаж залуу үеийнхнээсээ хавьгүй явцуу болсон нь түүний зугаа цэнгэл, хүлээсэн үүргийн талаар юу гэж ярьж байгаагаас нь тодорхой байлаа. Дүүгээ санасандаа урьсан хэрэг биш, харин дүү нь гэр орондоо нийц муутайг мэдээд энд ирвэл ажил төрөлтэй болжамиа аргалаад явах байлгүй гэж бодсон юмсанж. Керрийг ирлээ гэж баярлах боловч ажил төрлийнх нь талаар нөхөртэйгээ адил бодолтой байлаа. Ядахнаа долоо хоногт таван долларын ажил хийсэн ч эхний үед болоо шүү дээ гэж бодно. Үйлдвэрийн газар орвол нь шинэ хүнд хамгийн таарах ажил. Тиймэрхүү нэг томхон үйлдвэрт орчихвол болох нь тэр. Тэгж байтал юу ч болох юм билээ гэж бодно. Цаашдаа хэрхэхийг хэн нь ч тодорхой мэдэхгүй байлаа. Ахиж дэвших ийм тийм ажил төсөөлөгдөхгүй ажээ. Хүнтэй суух гэрлэх талаар ч найдахаар юм бодогдсонгүй. тэр хотод нэгэнт ирсэн хойно, тэгсгээд байтал юмыг яаж мэдэх вэ, аз гэж байдаг л гэж бодоцгоодог бололтой. Иймэрхүү нааштай итгэл найдвар бүхий нөхцөлд Керри маань тэр өглөө ажил эрэхээр гарчээ.

Керрийн араас дагаж явахын өмнө, ирээдүй нь ямар болох тэр нөхцөл байдлыг авч үзье. 1889 онд Чикаго хот маш хурдан хөгжиж байсан учраас тийшээ очих зоригтой хүмүүс, залуухан эмэгтэйчүүд ч амжилт олно гэж найдах нэлээд үндэстэй байсан юм. тус хот тасралтгүй хөгжиж байсан олон тооны үйлдвэр худалдааныхаа газраар алдаршин дуурсагдах хүмүүсийн өмнө өргөн их бололцоо нээн өгч байв. Тийм учраас шинэр хөгжихийг хүссэн буюу нэгэнт хөрөнгө зөөрөө барж ажил төрөл нь баларсан хүмүүс, өөрөөр хэлбэл, эсхүл найдлагатай, эсхүл найдлагаа алдсан элдэв бусын хүмүүс тус орны өнцөг булан бүрээс цуглан ирсээр байлаа. Энэ бол таван зуун мянга орчим хүнтэй мөртлөө нэг сая хүнтэй нийслэл хотын дайтай санаа бодол, эрмэлзэл, ажил үйлстэй хот юм. Байшин барилга, гудамжууд нь нийтдээ далан таван шоо дөрвөлжин бээр газрыг хамарсан тархмал маягийн хот болоод байсан бөгөөд хүн амьтан нь худалдаа наймаа эрхлэх нь гол биш харин хүн ард шинээр хүчээ сорих ирээдүйтэй их үйлдвэрүүдийг цогцлон барьж байлаа. Шинэ шинэ байшин барилга сүндэрлэн босгож буйн дохио болох алхны чимээ энд тэнгүй дуулдана. Том том үйлдвэрийн газрууд баригдаж буй нь тэр. Төмөр замын хоршооллууд ирээдүйг нь аль хэдийн мэдээд хуурай ба усан замын тээвэрт зориулан урт урт зурвас газруудыг эзэмшин зам гүүр тавьж байна. Хот түргэн өсөж байгааг угтан хотын зах, хээр газар хүртэл гудамжны трамбай хэмээх чиргүүлт тэрэгний төмөр зам барьж байна. Ирээдүйн олон байшин барилгын анхны хараацай болсон ганц нэг байшин торхойх хотын зах хяугаарыг нь хүртэл олон бээр үргэлжлэх маш олон газраар гудамж суваг рагаж байна. Цас, бороо салхинд ямагт шавхуурдуулдаг тийм газруудад ч шөнөжин унтралгүй асаж салхинд ганхах хийн дэнлүү үзэгдэнэ. Байшин барилга агуулахын газрын хажуугаар өнгөрсөн нарийхан банзан зам зарим нь бүр хотын зах хүрсэн харагдана.

Төв хэсэгт нь ажилд орох гэсэн хүмүүс голдуу эргэлдэж байдаг том том бөөнөөр худалдаалах пүүс, наймааны газрууд байна. Төрөл бүрийн пүүс тус тусдаа өөрийн гэсэн байшин барилгатай байгаа нь Чикагогийн нэг онцлог мөн бөгөөд бусад хотод тийм байдаггүй билээ. Сул газар хангалттай байснаас ийм бололцоо олгожээ. Тийм учраас пүүсүүдийн албан хонтоорууд нь доод давхартаа шууд гудамж руу харсан нэлээд сүр бараатай байдаг байна. Цэлгэр том толин цон эдүгээ ердийн хэрэг боллсон боловч тэр үед дөнгөж үүсч байсан болохоор доод давхрын албан тасалгаа хонтоорыг их л гоё ганган сүрлэг болгож байлаа. Дэргэдүүр нь явж өнгөрөх хүмүүс нүд хужирлахад, гялгар модон хаалт, сүүн шилээр хамгаалалт хийсэн тасалгаан дотуур “дэгжин

хувцастай” ихэмсэг эзэд цагаан цамцны зах гял цал оргиулан уарагш хойш хөлхөх буюу хэд бүлгээрээ нэг газар бөөгнөрөн ажилдаа дарагдсан албан хаагчил нь толгой дээш татах завгүй бөхийн суугаа харагдана. Үүд хаалган дээрх дөрвөлжин чулуун дээр гууль буюу дицээр эл пүүсний нэр хаяг, ажил төрлийг товчхон бөгөөд тодорхой зарласан байна. Хотын төв хэсэг нь нийтдээ жирийн хүнд хэрдхийн сэрдмээр сэтгэгдлийг төрүүлж, баян хоосны ялгааг аль аль талаар тод харуулах гэсэн мэт аж.

Угаас зүрх муутай Керри, худалдаа наймааны тэр суурлэг газар очихоор явжээ. Ван-Бүрбен гудамжийг уруудан зүүн тийш явах тусам сүрлэг сайхан байшиншууд цөөрөн цөөрсөөр сүүлдээ элдвийн агуулах газар, нүүрсний хашаа тааралдах болж бүр сүүлдээ голын тэртээ очоод мурхардаж байв. Ажил олж хийх гэсэн ариун сэтгэлтэй Керри зоримог алхах агаад дур сонирхлыг нь татмаар газар бүрийн ойр очиж алхаагаа удаашруулан ажигласхийн явна. Хязгаар төгсгөлгүй үргэлжлэх тэр их хүч чадлын бэлэг тэмдэг болсон газраар алхах тусам сүрдэж халшран эмээнэ. Энэ том том байшин юу юм бол? Энэ хачин газар юу хийдэг, яадаг юм бол? Хүний хувийн хэрэгцээндээ хэрэглэдэг юм хийдэг. Колумби хотынхоо гантиг чулуун эдлэлийн газар юун төлөө байдгийг Керри мэдэх боловч хашаагаараа дүүрэн төмөр зам, бух тэрэгтэй, гол мөрнөөр аялах хөлөг ачих том том өргүүр толгой дээгүүр сүртэйеэ нүүгэлтэх энэ газар Керрийн өчүүхэн ертөнцөд үл багтнам. Зах хязгаар нь үл харагдах төмөр замын буудал, мөрний уснаа багшрах халаг, нөгөө эрэг ойг нь даган ярайх асар том үйлдвэрийн газрууд ч өөрцгүй оньсого таавар мэт харагдана. Ажлын хувцастай хормогч зүүсэн эр, эм хүмүүс ажил хөөцөлдөн бужигналдах нь задгай цонхоор үзэгдэнэ. Урт урт гудамж нь хоёр талаасаа өндөр өндөр ханаар хашигдсан хадан хавцал мэт агаад уудам цэлгэр албан тасалгаанууд нь их зантай дээгүүр ноёдын маадайн суух орд аятай санагдана. Тийм албан тасалгаанд ажилтай хүмүүс мөнгө тоолох, гоёж гоодох, хөлсний тэргээр зугаалахаас өөр ажил хийдэггүй байх л гэж Керри бодов. Тэд юугаар худалдаа наймаа хийдэг яах гэж юм хийдэг энэ тэрний талаар тун ч бүүр түүрхэн ойлголттой байв. Юм бүхэн гайхмаар хачин, аварга том, асар уудам санагдах тул тэр хүчирхэг газрын аль нэгнийх нь үүдийг татаж ороод надад ямарч хамаагүй таарч тохирмоор ажил байна уу хэмээн сураглая гэж бодохоос зүрх алдан хулчийж байлаа.

ХУВЬ ТАВИЛАНГАА ТУРШНАМ. ДОЛОО ХОНОГТ ДӨРВӨН ДОЛЛАР ХАГАСЫН ХӨЛС

Керри, голын цаад эрэг дээрх бөөмийн пүүсний хороололд очоод алиных нь үүдийг татъя даа хэмээн тал тал тийш харан сүрдмээр сайхан хөшигтэй цэлгэр том том цонх руу харвал хүмүүс ажил эрж яваа хүн юм даа гэж бодсон бололтой ажиглаж байгаа мэдлээ. Урьд нь хэзээ ч ингэж явж үзээгүй болохоор бүр зориг мохжээ. Ажил эрж яваа хүн юм даа гэж хүмүүс бодож байна гэхээс яагаад ч юм ичиж, ажилдаа яарч байгаа хүн шиг царай гарган хурдан хурдан алхан явахаар шийдэв. Ингэж явсаар зөндөө олон худалдаа, үйлдвэрийн газрын үүдээр хаалгы нь таталгүй өнгөрөн гарчээ. Тийнхүү явсаар хэд хэдэн хороолол өнгөрсөн хойно “ингэж яваад ямар хэрэг бүтээх билээ” гэж бодмогцоо байшингуудын хаяг нэр усыг ажиглаж эхэлсэн боловч алхаагаа төдий л сааруулсангүй. Төдхөн нэг том хаалга яагаад ч юм анхаарлыг нь татав. Зэс самбар дээр хаягаа жигтэйхэн гоё хийсэн, дотор нь хүн амьтан мэдээж зөгий батгана шиг язганах зургаа долоон давхар байшингийн хаалга бололтой. “Эднийх л эмэгтэй хүн ажилдаа авч магадгүй” гэж Керри бодоод гудамж хөндлөн гарч үүдэнд нь хүрч очив. дөхөн очтол шоо дөрвөлжин хээтэй бор саарал даавуун костюмтай залуу цонхоор нь харагдав. Түүнийг энэ газар ажилтай хүн эсэхийг Керри мэдээгүй хирнээ шимтэнгүй харахтай нь зэрэг зовоод үүдий нь таталгүй шууд цаашаа өнгөрөн явлаа. Гудамжны нөгөө талд “Шуурга ба хаан” гэсэн хаягтай зургаан давхар байшин сүндэрлэн харагдахыг үзээд яагаад ч юм горьдлоготой санагджээ. Тэр бол бөс барааны эдлэл бөөнөөр худалдаалдаг, голцуу эмэгтэйчүүдийн ажилладаг пүүс ажээ. Дээд давхруудад нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа нь тодхон харагдаж байв. Кеери ямар ч атугай орж үзэхээр шийдэв. Гудамж гатлан гараад шууд орц руу очтол тэндээс хоёр эрэгтэй хүн гарч ирээд яг хаалган дээр нь зогсдог байна. Цахилгаан мэдээний газрын хөх цэнхэр хувцастай шуудан хүргэгч хажуугаар нь гарч шатаар өгсөн цааш явчлаа. Явган хүний замаар үерийн ус мэт миегнэн явах хүмүүс хажуугаар нь гарахдаа яах ч учраа олохгүй дэмий бүлтэгнэн зогсож байгааг нь ажиглаад байх шиг санагдахлаар Керри бас л ичиж зориг шантран давдаггүй даваа юм байна гэж бодоод өнөөх хоёр хүний дэргэдүүр явж өнгөрөх зүрх хүрсэнгүй.

Тэгээд ихэд гонсойж хоёр хөл жирэлзүүлэн тэр чигээрээ бодож санасан ч юмгүй алхлав. Хороолол хорооллыг ардаа хийсээр л байлаа. Гудамжнуудын өнцаг буланд дэнлүүний гэрэлд Медисон, Монро, Ласаль, Кларк, Диаборн, Стейт гэсэн нэрүүд гялалзах агаад тийнхүү том том чулуу дэвссэн явган хүний хатуу замаар таваргасаар хөл нь чэцэж эхлэв. Гэсэн ч тэр хотын өнгө жавхаа, цэвэр цэмцгэр байдал сэтгэлий нь тэжээх бөлгөө. Өглөөний нарны элч улам чангаравч гудамжны сүүдэр талыг барин явахад сэрүүн таатай. Дуниартан цэлийх хөх тэнгэр өөд харахуйяа урьд нь ажиглаагүй бишрэм сайхан нь гойд.

Керри дэндүү зүрхгүй шантрамтгайдаа бухимдаж эхлэв. Өнөөх “Шуурга ба Хаан” гэдэг пүүсэнд заавал орж гомдлоо бардаг хэрэг хэмээн бцаад явлаа. Замд нь гутлын үйлдвэрийн том пүүс тааралдаж шил толь шиг том том цонхных нь цаана бусад албан хаагчдаасаа сүүн шилэр халхавч хийсэн пүүсийн даамлын өрөө харагдав. Яг тэр дүлий шилэн халхавчны урд талд, гаднаас орох хаалганы дэргэдэх ширээний ард буурал өвгөн суух агаад өмнөө зузаан далбагар том дэвтэр дэлгэжээ. Керри орж зүрхлэхгүй нэлээд хэдэн удаа урдуур нь явж өнгөрснөө өөрийг нь анзаарсан хүн хар алга гэж нягтлаж аваад бушуухан шиг ороод үүдэнд нь хулганан зогслоо.

- Залуу хүүхэн, хэрэг зориг юу вэ? гэж өнөөх буурал өвгөн овоо уриалагхан байдалтай асуухад Керри,

- Би...танаас.... үгүй ээ... танайд хийх ажил байгаа болов уу л гэж явна гэж түгдчихэд нөгөө хүн инээмсэглэж,

- Одоохондоо алга. Одоохондоо юм алга. Дараагийн долоо хоногт ирээрэй, заримдаа хүн хэрэгтэй болдог юм гэв.

Керри, хариугий нь дуугай сонсон эв хавгүйхэн ухарсаар гарахдаа тэр хүний тийнхүү овоо эелдэг байгаад нь нэлээд гайхав. Өөдөөс нь элдэв муу үгээр утаж, хүйтэн цэвдгээр харьцан доог тохуу хийх биз гэж бодож байсан чинь тэгсэнгүй! Доромж үг сонсож, ичиж зовоогоогүй нь хачин сайхан санагджээ.

Тэгээд овоо зоригжоод бас нэг байшинд оров. Бэлэн хувцасны пүүс аж. Зэс хөндлөвчүүдийн цаана дөч эргэм насны сайхан хувцастай эрчүүл харагдахыг бодохул энд улам олон хүн ажилладаг бололтой. Оруут нь үйлчлэгч жаал гүйн ирж,

- Та хэнтэй уулзах гэв? гэхэд Керри,

- Даамалтай чинь уулзахсан гэв. Жаал хүү ярилцан зогсож байсан гурван хүн дээр очиж хэлэхэд нэг нь хүрч ирээд,

- Юу гэв? гэж ёозгүйхэн асуухад Керри нэгмөсөн хулчийж,

- Танайд ажиллах хүн хэрэгтэй болов уу? гэж түгдрэн хэлэв.

- Хэрэггүй ээ! гэж нөгөө хүн огцом хэлээд л цааш эргэх нь тэр.

Керри бүр балмагдан гарахаар эргэхэд үйлчлэгч хүү үүдийг уриалагхан нээж өгөв. Керри бушууцхан шиг л олны дунд орж авахын мөн болов. Түрүүхэн овоо нэг урам орж байсан бол одоо бүр нам цохиулах шиг болжээ.

Тэгээд нэг газар ямар ч тодорхой зорилгогүйгээр гудамж метрлэн худалдааны хээнцэр хээнцэр олон пүүсээр орохыг эс зориглон дэргэдүүр нь өнгөрөн явсаар авай. Тэгсээр явтал үд болж, хоол цай ч үгүйлэгдэж эхэлжээ. Хоолных нь үнэ хямд байж магадгүй гэсэн нэг зоогийн газар орж үзэхүл түрийвчинд байгаа хэдээс нь даанч ахдах тул маш их зовлоо. Ганц таваг шөл авч түргэхэн шиг идээ гарав. Аяга шөлөнд хүч орсон Керри маань сураггүй эрлээ үргэлжлүүлэх зоригтой ч болжээ.

Чухам алинд нь орёе доо гэж шийдэх ядан явсаар хэд хэдэн байшин өнгөрөөгөөд сүүлд нь өнөөх “Шуурга ба Хаан” гэдэг пүүсэнд орж үзэхээр болов. Орж очвол хэдэн хүн тэрүүхэнд нь ярилцан зогсон өөрийг нь анзаарахгүй байх тул Керри яаядаа хэмээн арггаа баран толгйо гудайлган газар ширтэн зогсож байтал ашгүй хаавчийн цаанах олон ширээний нэгний ард суух албан хаачгдын нэг нь,

- Хэнтэй уулзах нь вэ? гэж асуув. Керри,

- Хэнтэй нь яах вэ, нэгэнтэй нь уулзмаар байна. Би ажил эрж байгаа юм гэлээ.

- Тэгвэл та Мак Манус гуайтай л уулзах хэрэгтэй дээ. Сууж бай даа гэж хананы хажуугийн сандал руу заасны бичиж байсан зүйлээ яарамгүй үргэлжлүүлэв. Тэгтэл гаднаас нэг пагдгар тарган эр

орж ирэв.

- Мак манус гуай! Энэ залуу хүүхэн тантай уулзах гэсэн юм гэнэ гэж нөгөө хүн хэлэв.

Намхан нуруутай тэр ноёныг эргэж хараад Керри босож дэргэд нь очвол,

- Та юун тухай явна, авхай? Гэж илт сониучлан харж асуув.

- Танайд хийчих ажил юу байдаг бол гэж явна.

- Чухам ямар ажил?

- Өө, ямар ч яах вэ

- Бөс бараа, бөөнөөр худалдаалах талаар туршлага байна уу?

- Үгүй ноёнтон

- Түргэн бичигч юм уу машины бичээч хийж байсан биш биз?

- Үгүй, ноёнтон минь

- Тэгвэл танд тохирох таарах ажил манайд байхгүй юм байна даа. Манайх дандаа мэргэшилтэй ажилчин авдаг юм.

Керри гарахаар урамгүй ухарч эхлэхэд нь Мак манус ноён өрөвдөж,

- Та урьд ажил хийж явсан уу? гэж асуув. Керри бас л,

- Үгүй, ноёнтон минь гэв.

- Тэгвэл манайх шиг ийм бөөний худалдаалах пүүсэнд танд тохирох ажил олдохгүй юм байна даа. Их дэлгүүрүүдээр орж асуусангүй юу?

Керри орж асуугаагүй гэдгээ хэлэв.

- Би бол хамгийн түрүү их дэлгүүрүүдээр орох байсан. Тэнд тан шиг ийм залуу хүүхнүүд байнга хэрэгтэй байдаг юм гэж их л нөхөрсгөөр харж хэлэв.

Хүн тэгж нөхөрсөг зан гаргасанд нь Керри баярлаж,

- Танд баярлалаа гэв.

Керрийг гарахаар явахад нөгөө хүн хойноос нь,

- Та их дэлгүүрүүдээр заавал ороорой гээд цааш явав.

Тэр үед их дэлгүүр гэдэг газар их амжилт олж эхэлж байсан боловч даанч цөөхөн байжээ. Мянга найман зуун наян дөрвөн оны алдад Америкийн нэгдсэн Улсын анхны гурван их дэлгүүр Чикаго хотноо буй болсон юм. Керри “Дейли Ньюз” сонины зарлалаас хэдэн дэлгүүрийн хаягийг

тогтоож авсан учир шууд эрэлд гарчээ. Мак Манус ноёны хэлсэн үгийн ачаар урам нь дахин сэргэж, ямар нэг найдлага байж болох юм хэмээн итгэж эхэлжээ. Тэгээд тийм дэлгүүрийн нэгээр орох санаатай таамгаар баахан алхав. Бодит үндэсгүй боловч горьдон хайж яваа хүн бэрх мөртлөө амин чухал юм хөөцөлдөхдөө сэтгэл нь ямар амархан хууртана вэ! Явж явж эцэст нь цагдаагаас асуувал цаадах нь эндээс хоёр хороолол яваад “Зах” гэдэг дэлгүүрт очно хэмээн зам зааж өгчээ.

Жижигхэн худалдааны асар том тэр газрууд хэзээ нэгэн цагт алга болж гэмээ нь тэдгээрийн байдлыг тодорхой өгүүлбэл тус үндэстний худалдаа эдийн засгийн хөгжлийн түүхэнд сонирхолтой бүлэг болох билээ. Худалдааны тийм арга тэгтлээ цэцэглэн хөгжиж байсан явдалдэлхийд хэзээ ч байсангүй. Уг жижиглэн худалдаалах аргыг дээд зэргийн ашигтай болгох зорилгоор тийм хоршооллыг бий болгосно бөгөөд тэр нь арвилан хэмнэх нарийн зарчмын үүднээс нэг бүхэл нэгдэлд хамаарсан олон зуун дэлгүүрээс бүрдсэн ажээ. Тэдгээр нь үзэсгэлэн гоёмсог, хөл ихтэй нижгэр өөдрөг байгууллага болж, чиг чигтээ удирдлага бүхий олон худалдагчийг ажиллуулна. Жижиг бараа, хувцас хунар, бичгийн хэрэгсэл, үнэт эдлэл, гайхам сайхан өнгө өнгөөрөө ялгаран гялалзаж олон хүний дундуур алхах зуур лангуу бүр дээр өрсөн эд бараа анхаарлы нь аргагүй татна. Жижиг эдлэ, эрдэнэсийн зүйл бүхэнд дур сонирхол нь салахын аргагүй татагдавч Керри зогсолтгүй явсаар байлаа. Энд байгаа юм бүхэн түүнд хэрэгтэй, юм бүхнээс нь авчмаар санагдах аж. Хөөрхөн гутал, оймс, хуниастай гоёмсог банзал, сүлжмэг, тууд, сам, түрийвч бүгд л хэрэгтэй боловч ганцы нь ч авах бэлгүйдээ сэтгэл нь тун их гонсойно. Зүсэм талх хайж, хоосон гуяа ганзгалан яваа болохоор дэлгүүрийн худалдагч түүнийг хармагцаа ажил хийж хөлс олох хэрэгтэй гуйлгачин гэж тааварлах л байв.

Гвч Керрийг хүйтэн цэвдэг, өнгө мөнгөний, урам хугалсан ертөнцөд гэнэт хаягдсан, биеэ барьж чаддаггүй, хэтэрхий эмзэгхэн сэтгэлтэй хүн гэж бодож болохгүй ээ. Тийм хүн биш юм шүү. Ер эмэгтэйчүүд өөрсдийгөө гоёж гооддог юмны талаар ихээхэн эмзэг байдаг л даа.

Керри, эмэгтэй хүний гоёл чимэглэлийн шинэ, дэгжин хээнцэр юм болгонд өөрийн эрхгүй татагдах тул лангуун дээрх юм болгоныг нүд хорхойтон харж, өөрийг нь өчүүхэн ч тоохгүй дйрчих шахам тэмүүлэх гоё ганган хувцастай авгай хүүхнүүдийг харахуйяа зүрх нь шимширч байв. Энэ хотын тарган цатгалан авгайчуудын зан араншинг Керри огт мэдэхгүй байлаа. Өөрөөс нь хавьгүй дээр санагдах тэр их дэлгүүрийн худалдагч нарын тухай ч огт төсөөлөлгүй ажээ. Тэд голцуу нүдэнд дулаахан, тэр ч бүү хэл хөөрөхн хүүхнүүд бөгөөд хэр баргийн юманд ажрахгүй хэнэггүй харагдах нь тэднийг сүрхий ёсорхог ёмбогор байдалтай болжээ. Тэд аятайхан, тэр ч байтугай ганган хувцасласан харагдана. Тэдний хэн нэгтэй нь хараа тулгарахад Керрийн хувцсыг голж, ер нь аль ч талаараа тоогдох юмгүй хүүхэн байна гэж бодож буй нь илт аж. Атаархах сэтгэлийн дөл Керрийн зүрхэнд дүрэлзэв. Том хотод бүсгүй хүнийг гоёж гоодож чадах эд хөрөнгө, хээнцэр юмс, тухтай тавлаг амьдрал хичнээн их байдгийг Керри бүүр түүр төсөөлж эхлэв. Тэгээд ч гоё ганган бошинз, дэгжин эд агуурст шунан шүлэнгэтэх нь туйлын их болов.

Их дэлгүүрийн албан тасалгаа нь хоёрдугаар давхартаа ажээ. Асууж сураглан заалгаж авчээ. Хонтоорын үүдэнд бас ажил сурсан хэд хэдэн хүн аль түрүүний хүлээж байв. Тэд өөртөө нь адилхан ч том хотын хүмүүс учраас зовж хулчийсан байдалгүй, итгэл төгс ихэмсэгдүү харагдав. Керрийг үзмэгцээ эрээ цээргүй ажиж эхлэв. Дөчин таван минут болсон хойно Керрийн орох ээлж болов.

- За ингэхэд та урьд өөр дэлгүүрт ажиллаж байсан уу? гэж эргэдэг сандлын ард, цонхны наахан

талд суух огцом хөдөлгөөнтэй, түргэн зантай байрын залуу врей асуухад Керри,

- Үгүй шүү, ноёнтон минь гэж үнэнээ хэлэв.

- Өө, ажиллаж байгаагүй юм уу? гээд цоо ширтэв.

- Үгүй, ноёнтон минь гэж Керри бас л давтан хэлэхэд цаадах нь,

- Бид бага ч гэсэн туршлага суусан залуу хүүхнүүд авч ажиллуулахад дуртай байдаг юм. Та манайд тэнцэхгүй юм шиг байна гэв.

Керри ингээд л дуусдаг юм бол уу яадаг юм бол гэсхийн зогсонож байтал нөгөө ерьей залаа,

- Та дэми йхүлээгээд хэрэггүй, бид цаашаа ажил ихтэй улс шүү гэхэд нь бушуухан үүдний зүг чиглэв.

- Хүүе, байзнаа! Та хаягаа надад өгчих. Заримдаа манайд хүүхнүүд түр хэрэг болох ажил гардаг юм гэж нөгөө хүн хэлэв.

Керри гадаа гараад нулимсаа арай ядан барилаа. Дөнгөж сая ийм муухайгаар хөөгдөж гарсан төдийгүй өдөржин муугаа үзэж хоосон таваргасандаа эцэж ядран, сэтгэлээр унан гутарч эхэлсэн хойно уйлах гэдэг нь арга байж уу даа. Дахиж өөр дэлгүүрээр ордог юм билүү гэж бодохоо болиод олны дотор орж сэтгэлээ бага болтугай ч тайтгаруулах хэмээн гудамжаар тэнүүчлэх болов.

Дэмий тэнэсээр голын эргээс холгүй орших Жэксоны гудамжаар орж хөл хөдөлгөөн ихтэй сайхь гудамжны өмнө биеийг барин яарамгүй алхав. Гэнэт боолтны цаасан дээр “Савлагч, оёдолчин эмэгтэйчүүд авна” гэсэн зарлал үүдэн дээрээ наасан газар харагдсанд Керри орёе уу, байя уу хэмээн тээнэгэлзэж байснаа орохоор шийдэв. Байшингийн нэг давхрыг хүүхдийн малгай үйлдвэрлэдэг “Шпайгель ба кампани” эзэлдэг аж. Дотроо машин, ажлын ширээ пиг дүүрэн тавиастай, өргөөшөө тавин тохой, уртаашаа наяд орчим тохой тэр гэрэл гэгээ муутай харахуйвтар өрөөний хамгийн харанхуй өнцөг буланд л чийдэн асаж харагдана. Энд олон эмэгтэй, цөөн тооны эрэгтэйчүүд ажиллаж харагдан. Нүүр ам нь хүртэл нэл тос болж, шороо тоосонд дарагдсан тэр хүүхнүүд хэлбэр хийц муутай хөвөн даавуун халаадтай ихэнх нь майжгий шаахай хөлдөө угласан харагдана. Бараг бүгд ханцуйгаа шамлаж чөргөр гарынхаа шууг гаргажээ. Зарим нь бүгчимдэж энгэр заамаа задгайлжээ. Тэд, агаар хий бараг орох нь үгүй муухай нөхцөлд ажилладаг учраас цонхийж, нуруу бөгтийж эхэлж байгаа, авдаг хөлс нь шальгүй, жинхэнэ хар ажилчид гэдэг нь харваас илт. Гэтэл ичиж зовохыг мэдэхгүй, сониуч зантай, хэгжүүн ярьдаг яриатай, этгээд хачин үг урсгадаг улс ажээ.

Керри, ийм газар ажиллаад ч хэрэг алга хэмээн ихэд зовон ийш тийш бүлтэгнэн харж байв. Зарим нь түүнийг хулгай нүдээр ажихаас биш үнэндээ тоож байгаа хүн ч байсангүй. Тэр цехэд байгаа хүн бүр юун хүн орж ирээд зогсоно вэ хэмээн бүгд ажиг сэжиг авах хүртэл Керри зогсож байв. Нэг нь мастертаа мэдэгдэхэд пиджаакгүй бөгөөд дотуур цамцныхаа ханцуйг тохойгоо хүртэл шуусан, энгэрэвч хэдэрсэн нэг хүн хүрч ирээд,

- Та надтай уулзах гээ юу? гэхэд Керри ер нь шуудхан асуух нь дээр гэлгийг ойлгосон болохоор,

- Танайд хүн хэрэгтэй байгаа юмуу? Гэлээ.

- Та хүүхдийн малгай оёж чадах уу?

- Үгүй шүү, ноёнтон минь.

- Та урьд иймэрхүү ажил хийж явсан нь уу?

- Үгүй.

- Хмм! Гэж мастер бодлогоширхийн чихнийхээ арыг маажиж-манайд хүн хэрэгтэй нь хэрэгтэй гэхдээ туршлага дадлагатай хүн чухал. Шинэ хүн аваад сургаж байх цаг зав алга гээд дуугаа хураан цонхоор гадагш харав. Тэгснээ,

- Гэвч бид таныг хамгийн сүүлчийн дамжлага дээр авч болох юм даа гэв.

Тэр хүнийг тийм эгэл зөөлөн байгаад нь Керри жаахан зүрх орж,

- Долоо хоногт ямар хөлс өгөх вэ? гэхэд цаад хүн,

- Гурван доллар тавин цент гэв.

- Ө!, гэж Керри золтой л хашгирчихсангүй биеэ барин хэлэв.

- Одоохондоо бидэнд хүний хэрэг алга л даа гэж Керрийг ямар нэг боодолтой юм сонирхон харж буй мэт ажсаар хэлснээ,- Даваа гаригийн өглөө ирвэл ажилд авч болох л мю гэхэд нь Керри,

- Танд баярлалаа гэж дуулдахтай үгүйтэй хэлэв.

- Хэрэв ирэхээр болвол элгэвчтэй ирээрэй гээд мастер гуай, Керрийг өргүүр шатны дэргэд орхин одоодоо ядахдаа нэр усы нь ч асуусангүй.

Тэр газрын байж буй ёр, долоо хоногт гуйранчны хөлс өгнө гэхийг бодохоос Кеери их санасан газар хоосон хонолоо гэгчээр сүрхий урам хугаравч ажил эрж, олон газраар орж үйлээ үзэж тамаа цайж нүүрээ улайгаж явсан болохоор адаг сүүлд нь ажил байна гэдгийг дуулсандаа урамшив. Гэтэл нэг ихийг хүсэх тэнхэлгүй санагдавч даанч тийм ажилд ормооргүй санагдана. Керри хэзээ ч ингэж явж үзээгүй охин. Хөдөө нутгийнхаа сайхан агаар орчинд айвуу тайвуу амьсгалд идээшсэн хүн тийм бүгчим муухай газар махаа идэж маягаа химлэх ёсгүй гэж бодогдоно. Хир тоосондоо баригдаж явж үзсэнгүй. Эгчийнх нь ч гэсэн гэр орондоо ядуу ч болтугай нь цэвэр сууж байна. гэтэл энд хир тосонд заваарсан, дээвэр нь хүртэл навтгар намхан, ажиллдааг хүүхнүүд нь шалдир, балдир, ийм амьдралдаа хорсон гонсойсоор зүрх нь чулуу болж, хүнээ байж хорон санааны сав болсон хүмүүс гэмээр санагдана. Гэсэн ч ажил өгч байгаа нь их юм даа. Ажил эрсэн хүн анхныхаа өдөр нэг юм олж байгаа бол Чикаго хот тийм ч айхавтар эвтэршгүй цайз биш аж. Бомооргүй бол дараа энэнээс арай дөмөг юм хайдаг хэрэг.

Гэтэл цааш нь эрээд эрээд сэтгэлийг зогоох юм олдсонгүй. Догь сайхан газруудаар ороход өөдөөс нь арай л хөөх нь дутаж байлаа. Орсон газрууд нь бас л далгатай хүн хэрэгтэй гэсэн үг хэлнэ. Зарим нь зодох нь халаг хүйтэн аашилна. Бэлэн хувцасны нэг үйлдвэрээр орж дөрөвдүгээр давхарт нь гараад ажил сураглалат, харанхуй шахам өрөөнд даналзаж суусан пагпгар биетэй

нагжгар хүзүүтэй мастер эр,

- Байхгүй байхгүй! Мнайд ямар ч хүн хэрэггүй, наашаа бүү зүглэ гэж ирээд л хашгирчээ.

Нар гудайн шингэхийн алдад Керрийн горьдлого, зориг, тэнхээ нь ч барагдаж эхэллээ. Уг нь гайхмаар зориг гарган хөөцөлдсөний хариуд заавал ч нэг юманд хүрэх ёстой билээ. Эцэж ядарч яваа түүнд тэр асар том худалдаа, наймааны хороолол хүнийг даанч өрөвчих сэтгэлгүй, чулуу шиг зүрхтэй, мөс мэт хүйтэн сэтгэлтэй, хэмжээ хязгааргүй эрлэгийн газар мэт санагдав. Бүх хаалга үүдээ хаасан тийм газар тэмцэл хийх даанч ахдам ажээ. Тэгэхлээр энд ямар нэг олигтой ажил олдоно гэж бодоход бэрх болох нь илт болж байв. Тоо тоймгүй эргэтэй, эмэгтэй хүн хажуугаар нь тасралтгүй цувна. Чиг чигтээ өөр өөр эрмэлзэл сонирхол бүхий үй олон хүний тасралтгүй миегнэх урсгал Керрийг хатаж унасан навчийг урсган аваад явахын адил тул өөрийнхөө өчүүхэн, арчаагүй байдлыг ойлгож эхлэв. Ямар ч атугай бас нэг газраар оръё хэмээн ийш тийш харан хайх боловч орж зүрхлэмээр тийм газар тааралдаж өгөхгүй л байв. Өөдөөс нь өнөөх л доромжлол басамжлал угтах хойно зориг нь хүрэхгүй аж. Царай алдан гуйсан хариуд нь “үгүй” гэсэн ганц хариу ирнэ.

Бие сэтгэлээрээ ядарсан Керри адаг сүүлдээ Миннийнд яаж хүрэхээ бодов. Энэ бол өдөржин ажлын эрэлд явсаар ганзага хоосон буцдаг хүмүүсийн гунигт явдал билээ. Ван Бьюрений гудамж орж тэндээс морин трамвайд суух санаатай явж байтал нь гутлын том үйлдвэрийн газар тааралджээ. Шил толь шиг том том цонхных нь нэгээр дунд зэргийн настай нэгэн хүн жижигхэн ширээний ард суугаа харагдав. Муугаа үзэж, горь тасарсан хүн заримдаа азаа үзэх гэж нэг юм байдагчлан Керри тэр үйлдвэрийн газар шууд орж нөгөө гаднаас харагдсан хүн дээр очив. тэр хүн охиныг харан, алжааж ядарсныг нь ойлгон сонирхож буй бололтой,

- Юу гэж явна? Гэж асуув.

- Та намайг нэг ажилд авч үзэхгүй юу гэж Керрийг хэлэхэд цаад хүн нь овоо эелдэгдүү янзаар,

- Үнэндээ мэдэхгүй байна, та өөрөө ямар ажил сурч яваа хүн бэ? машины бичээч биш биз? гэв.

- Биш ээ.

- Мнайд бичээч, тооцооны нярав хэрэгтэй. Гэвч үүгээр тойрч яваад дээш гарч асуу л даа. Хэдэн өдрийн өмнө хүн хэрэгтэй гэж байсан юмсан. Браун гуай гэдэг хүн байгаа, очиж уулз.

Керри бушуухан шиг тойрч очоод өргүүр шатаар нь дээш гарав.

- Вилли, Браун гуайд хэлчихээрэй гэж шатчин тэнд ойрхон зогсож байсан жаалд хэлэв.

Вилли нь төдхөн буцаж ирээд Браун гуай таныг жаахан хүлээж байна уу гэсэн шүү, ингэсгээд ирнэ гэсэн гэж Керрид хэлэв.

Керрийн орсон өрөө нь агуулах газрын хажууд байсан болохоор тэр газрын ерөнхий байдал, хийдэг ажлынх нь талаар ямар ч төсөөлөл авч чадсангүй.

- та манайд ажилд орох гэсэн юм уу? Урьд гутлын үйлдвэрт ажиллаж байсан уу? гэж Браун ноёныг асуухад Керри,

- Урьд ажиллаж байгаагүй гэж үнэнээ хэлэв.

- Нэр чинь хэн билээ? гэж асуугаад нэрээ хэлэхэд нь - үнэнийг хэлэхэд манайд танд таарах ажил олодох нь уу үгүй юу сайн мэдэхгүй байна шүү. Харин та долоо хоногт дөрвөн доллар хагасын хөлстэй ажил хийх үү? Гэхэд Керри даанч олон газраар явж урамгүй үг сонсож байсан болохоор энэ хүний үг тун аятайхан сонсдов. Долоо хоногт эрхибиш зургаан доллар өгөх болов уу гэж горьдож байсан хэдий боловч арга буюу тэгье гэв.

Браун хаягий нь бичиж аваад,

- Даваа гаригийн өглөө найман цагт ир дээ. тэр болтол танд нэг ажил олоод байх болов уу гэж бодож байна гэв. Тэр хүнийг цааш явахад, Керри арай гэж нэг юм ажил олсондоо дотор нь онгойх шиг болов. Хамаг биенийх нь судсаар халуун цус гүйх шиг болж эхлэв. Сэтгэлийнх нь түгшээ ч сулраад явчих шиг. Хөл хөдөлгөөнт гудамжинд гартал нэг л өөр болоод явчих шиг. Хүмүүсийн алхаа гишгээ нь хүртэл цовоо сэргэлэн харагдана. Тэдний нүүр царайд инээмсэглэл байдгийг ч Керри сая л олж харав. Хоорондоо ярилцаж инээж хөхрөлдөж байх дуу чимээ Керрийн чихийг дэлсэх болсныг сая л мэдрэв. Цэлмэг тэнгрэ орой дээр нь дуниартана. Өдрийнхөө ажлыг дуусгасан үй түмэн хүн асар том байшингуудаас цутган гарч байв. Тэдний нүүр царайд баяр баясгалант байдал харагдах бөгөөд, эгчийнхээ гэр, хоол цайг бодохоос алхаа нь улам хурдасна. Керри ядарсан боловч хөлийнхөө өвдөж чилэхийг ч анзаарахгүй яаран алхана. Эгч нь юу гэх бол? Одоо ингээд л Чикагоийн урт өвөл эхэлхнэ, энэ гэрэл гэгээ, энэ олон хүн, элдэв хачин сонин бүхнийг яана! Ямар ч байсан мундаг том сайхан хот юмдаа. Ажиллах пүүс ч догь газар бололтой. Цонхнууд нь цэлийсэн том шмл толь л гэсэн үг. Ийм газар ажиллах магад сайхан байж таара. Дрүэгийн галт рэргэнд явж байхдаа хэлж байсан үг ч санагдлаа. Одоо амьдрал гэгч санаснаас хавьгүй дээр, хамаагүй урамтай, золбоолог мэт санагдав. Керри морин трамвайд суухад хамаг судсаар нь цус чөлөөтэй гүйсэн хэвээр, санаа сэтгэл хөхүүн болж Чикаго хотод сууж урьд өмнө нь амсаагүй аз жаргалыг эдлэх нь гэж бодлоо.

ХҮССЭН ХҮСЭЛ ХӨСӨРДӨЖ АМЬТНЫ ДООГ БОЛОВ

Керри хоёр өдрийн турш бөөн хүсэл мөрөөдөлд автан байв. Баян айлын хүүхэд болж төрсөнсөн бол зайлшгүй эдлэх жаргал цэнгэл хичнээн их байх бол гэсэн бодол толгой тархинд нь эргэлдсээр авай. Долоо хоногт авах дөрвөн доллар тавин центээ тухан хээхэнд тал тал тийш нь бодлоороо төдхөн цацаад дуусгаж байв. Керри, тэр хэдэн орой гэрт өнжихдөө цонхны дэргэд эргэлддэг сандал дээр суугаад гэрэл чимэг нь яралзах гудамж руу харж суухад нь авах цалин нь эмэгтэй хүний зүрх сэтгэлийг гижигдэх эд бараа, эрх танхи явдлыг мөрөөдүүлж байв. “Одоо ч сайхан амь зууна даа” гэж бодох аж.

Эгч Минни нь хүний ийм элчилгүй хүсэл мөрөөдөлд автахтай манатай, харин ч ням гаригийн үдийн хоолондоо зориулсан наян центээр юу авбал дээр юм гэж бодлогошрох, гал тогооныхоо галыг угаах зэргээс хэтрэхгүй.

Керри өдөр турш харрайлгасандаа баахан ядарсан боловч ахныхаа амжилтанд хөөрчихөөд өдөржин хэрхэн тэнүүчилж яаж хөглөж явснаа ярихад Минни сайшаан инээмсэглэнэ. Тэгээд бас ирж очих унааны зардалд цалингаасаа хичнээний нь өгдөг бол гэж асуув. Тэр тухай Керри огт бодолцоогүй боловч одоо бодоод ч гонсойсонгүй. Тиймэрхүү тооцоог бодож нэгээс нь нөгөөг хасахад ялгавар нь хичнээн болохыг эргэцүүлэн бодохооргүй тийм их баяр хөөртэй байв.

Хэнсон орой долоон цагт гэртээ ирэв. Хоолныхоо өмнө өлөн дээрээ хэзээний ааш муутай байдаг хүн болохоор ялимгүй дүнсгэр харагдана. Эн нь түүний байгаа янз, хэлэх үгээр илрэхээсээ дуу цөөтэй, өрөө өрөө дамжин хүрлийн алхах байдлаар илэрдэг аж. Орж ирмэгцээ дөнгө мэт муу гутлаа тайлж, шар өнгийн эсгийн шаахайгаа дуртай нь аргагүй углаад барааны савангаар нүүр гараа угааж, нүүрээ ув улаан болтол арчина. Тэгээд л үдшийнхээ хоол цайг зооглох бэлтгэлээ дуусгана. Дараа нь сонин уншин таг чиг сууна.

Залуу хүн тэгээд иймэрхүү ааштай байх нь Керрид тун ч эвгүй санагдана. Иймэрхүү ааш нь ойр орчныхондоо нөлөөлөн хариу дуугарахгүй бол амаа дэмий бузарлана гэж Минни айсандаа ганц ч үг хэлж зүрхэлсэнгүй байв. Харин Керрийн ярихыг сонсоод нүүр царай нь ялимгүй гийжээ.

- Тэгвэл чи чинь цаг алдсангүй шүү гээд инээмсэглэгчээ аядав.

- Алдаагүй шүү! гэж Керри бардам байдалтай хэлэв.

Хэнсон дахиад нэг юм асууснаа хүүхэдтэйгээ тоглоод хоолоо идэх зуур уг асуудлыг эхнэр нь дахин гаргаж ирэх хүртэл тэр сэдвийн талаар ярьсангүй.

Харин Керри тэдэнтэй адил дүнсийн сууж чадахгүй байв.

- Их л том пүүс шиг байна. Шил толь шиг том том цонхтой, маш олон ажилчин албан хаагчидтай! Надтай ярьсан хүн хэлэхдээ тун олон хүн хөлсөөр ажиллуулдаг гэсэн гэж Керри дуржигнуулахад Хэнсон,

- Одоо цагт хүний нүдэнд дулаахан хүн ажил олох тийм ч хэцүү биш гэв.

Керрийн баяртай байгаад, нөхөр нь ч зэгсэн дуу шуутай байгаад Минни овоо урам орж Чикаго хотын үзэсгэлэнт сайхан газруудын тухай, өөрөөр хэлбэл хэн ч гэсэн мөнгөгүй үзэж болох тийм

газруудын тухай ярьж эхлэв.

- Мичиган гудамжаар явж үзэх хэрэгтэй. Хичнээн гоё сайхан байшингуудтай гэж бодно! Гудамж нь тэр чигээрээ ямар сайхан гэж санана!

- Жекобсоны театр гэдэг нь хаана байдаг бол? гэж Керри огт өөр юм асуулаа. Тэр нь цуутай жүжгийн театр ажээ.

- Эндээс нэг их холгүй. Холгүй ч гэж дээ бүр ойрхон. Холстэд гудамжинд байдаг юм гэж эгч нь хариулав.

- Тэр театрт чинь очих юмсан! Би, тэр Холстэд гудамжаар өнөөдөр явсан байлгүй, тийм ээ?

Хамгийн жирийн гэмээр имй юм асуухад дор нь хариу хэлэх баймаар атал хэсэг түгдрэв. Хүний бодол санаа, үйл ажиллагаад нь гайхмаар нэвтэрч чаддаг. Театрт очъё гэж хэлмэгц л мөнгө зарах мэт юмыг үг дуугүй үл таашаадаг тийм санаа бодол нь Хэнсон, Минни хоёрт нэгэн зэрэг сэртхийн босоход хоол унд идэж уун зэгсэн хөгжөөнтэй байсан нь бишдэж эхлэв. “Тиймдээ” гэж Минни хэлэвч театрт очихыг энэ хоё таашаадаггүй юм байна гэж Керри ойлголоо. Хэнсоныг охоолоо идэж дуусан сонингоо шүүрч аваад урд өрөөндөө ортол нь тэр тухай яриа дахин гарсангүй.

Эгч дүү хоёр хоёулаа үлдэж аяга, таваг угаах зуур их зовох юмгүй ярилцаж эхэлсэн бөгөөд Керри амандаа байн байн дуу аялж байснаа:

- Нэг их холгүй юм бол би Холстед гудамжинд чинь очиж үзмээр байна. гурвуулаа өнөө орой театрт очъё л доо гэж Керрийг хэлэхэд Минни,

- Ээ, мэдэхгүй өнөө орой Свен явахгүй байлгүй. Өглөө эрт босож яваха ёстой гэхэд Керри,

- Арай ч үгүй гэхгүй байлгүй. Дуртай явна байх гэлээ.

- Үгүй дээ, театрт тун цөөхөн ордог хүн шүү.

- Зах яах вэ. Хоёул явах уу тэгвэл гэж Керри шалгаалаа.

Минний биш өөрөө театрт явъя уу байя уу гэдэг дээрээ явахгүй гэсэн хариу Миннид бэлэн байсан боловч дүүгийнхээ санаа бодлыг яаж өөр тийш залъя гэж бодсондоо ага буюу:

- Дараа л нэг үзье гэхэд Керри яагаад ингэж байгаа учры нь ойлгож,

- Надад жаахан мөнгө бий. Хоёул явъя, Минни! Гэв.

Минни толгой сэгсрэхэд,

- Цаадахыгаа ч хамт явъя гээч.

- Яах юм, цаадах чинь явахгүй гэж Минни хэлээд яриагаа зогсоох санаатай сав суулгаа хангинуулав.

Эгч дүү хоёр уулзаагүй хэдэн жил болоход Керри нэлээд өөр болжээ. Амь зуухын төлөө тэмцэх хэрэгтэй болоход угийн шатрамтгай зантай бөгөөд нэн ялангуяа тэгж тэмцэх хүч, хөрөнгө хүрэлцэхгүй болоод ирэхийн цагт аливаа наргиан, жаргал цэнгэлд жигтэйхэн дурлан тэр нь түүний нэг сүрхий зан болжээ. Энэ зангаа яагаад ч татаж чадахгүй аж.

- Өөрөөс нь асуугаад үз л дээ гэж Миннийг аргадав.

Керри ажилд орвол гэр орны маань орлогод нэмэр болно гэж л Минни бодож байлаа. Байрныхаа хөлсөнд өгөх мөнгө нэмэгдвэл гэр орныхоо зардлын талаар нөхөртэйгөө байсхийгээд яриа болохоо болино. Гэтэл Керри одоо ингэж зугаалж наргихын мөн болж байгаа хойно мөнгөө дэмий үрэхээс зайлахгүй. Зуршсан журмыг нь сахиж, аливаа зугаа цэнгэлийг орхин гагцхүү ажлын мөр хөөн махран хөөх дээр хүрэх аваас энэ хотод ирсний хэрэг юу билээ? гэж Минни бодов. Тийм ч нарийндаа хатсан, цэвдэг хүйтэн сэтгэлтэй бодол биү ажээ. Энэ бол борви бохисхийх зав өгөхгүй ширүүн амьдралд амиа аргалан яваа хувь заяандаа нэг их гонсойж гуньдаггүй эмэгтэй хүний л боддог бодол.

Сүүлдээ Минни цөхрөнгөө барж Хэнсоноос зориг гарган асуухдаа үнэндээ дүү охиныхоо хүслийг дэмжсэндээ ч тэгсэн хэрэг биш байв. Тэгээд нөхрийнхөө сууж буй өрөөг шагайж:

- Керри, чи бид хоёрыг театрт хамт явъя гэж байна гэхэд Хэнсон сонингоо уншихыг завсарлан Миннийн өөдөөс харах нь: “Ийм зангаа татсан нь дээр байх шүү” гэж хэлснээс тод байв.

- Би явахгүй. Юу үзэх гээд байгаа юм? гэж Хэнсон асуухад:

- Х.Жекобсоны театрт очих гэнэ гэв.

Хэнсон сонингоо үргэлжлүүлэн уншиж эхлэнгээ толгойгоо сэгсрэв.

Тэр хоёрын ийнхүү дургүй байгааг мэдээд тэдний аж төрөх ёсыг улам сайн ойлгов. Бодохоос хэцүү санагдавч юу ч гэж буруушаах арга олдсонгүй. Тэгснээ:

- Би доо бууж, гадаа жаахан зогсоодхоё гэв.

Миннийг юм хэлээгүй болохоор Керри малгайгаа өмсөөд доош буулаа.

Хэнсон хаалга хаагдах чимээнээр гал тогоондоо орж ирэн:

- Керри хаачих нь вэ? гэв.

- Шатны тэнд очиж зогсоё л гэнэ билээ. Гадаа жаахан гармаар санадсан юм байлгүй дээ.

- Яагаа ч үгүй байж мөнгөө театрт үрэхдээ яахав дээ!

- Жаахан сониуч зан гаргж байгаа биз. Юм бүхэн шинэ сонин харагдаж л байгаа байлгүй.

- Ай, бүү мэд гэснээ Хэнсон хөмсөг зангидаж хүүхдийнхээ дэргэд буцаж очлоо.

Керрийг юм юмны духанд хүрээгүй, мөнгө сангагүй шахам байж ийм сэхүүн загаж байгаа нь баахан шалиг үрэлгэнээ л харуулж байна гэж Хэнсон бодов.

Бямба гаригт Керри бас л гадаа гарч, их сонин сайхан санагдах голын тийш очсоноо буцаж, дэгжин сайхан байшингуудын нь өмнөх ногоон зүлэг нь модот гудамж шиг болгосон Жексон гудамжаар орон явлаа. Хөрөнгө нь зуун мянган доллараас давсан ганц ч болов хүн энэ гудамжинд байхгүй ч гэсэн хүмүүс хичнээн баян чинээлэг суудгий нь хараад Керри ихэд гайхан цочирдлоо. Грээс гарсан маань онолоо, яасан сайхан гудамж вэ, хүргэн ахын маань байр дэндүү давчуу, ядуу юм, сонин хачин зугаа найртай газар энд тэндгүй л байдаг юм байна гэж бодохын хамт бүр ч өөр юм санаанд нь орж Дрүэ хаана яваа бол, хаана суудаг юм бол гэж ч бодлоо. Даваа гаригийн орой ирж магадгүй, дэмий юм даа гэж бодох мөртлөө зүрхнийхээ угт түүнийг ирээсэй гэж бодож явав.

Даваа гаригийн өглөө Керри эртлэн босож ажилдаа очихоор бэлдлээ. Хөх өнгийн цоохор даавуун цамц, үжир даасан хүрэн өнгийн ноосон банзал өмсөж, Колумб хотод байхдаа зуны туж өмсөж болиосон жижигхэн сүрлэн бүрхээ тавилаа. Гутал нь ихэд хуучирч элэгдсэн, хүзүүнийх нь алчуур гэж байнга ээлжгүй хэрэглэсэн болохоор бүр ч тамтгаа алджээ. Одоо Керри пүүсний ажилчин эмэгтэйчүүдээс бараг ялгаагүй харагдах боловч угийн царайлаг тул нүдэнд дулаахан, дөлгөөхөн, хөөрхөн охин харагдана.

Төрсөн гэр орондоо өглөөний долоо нмйан цаг хүртэл унтаж заншсан Керри мэтийн хүн үүр цүүрээр босно гэдэг амаргүй. Өглөөний зургаан цагт босоод бөөн нойрмог амьтан гал тогоо руу шагайхад Хэнсон өглөөнийхөө хоол ундыг дуугүй ууж идээд дуусаж байхыг хараад муу эгчийнхээ ядуу зүдүү амь зууж явааг дахин мэдэрчээ. Керрийг хувцаслаж дуусах үеэр Хэнсон явсан болохоор Керри, Минни, тэдний жаал гурвуу хоол цайгаа идэж уув. Жаал нь өндөр сандал дээр суугаад, таваг, сэрээ хангинуулан байв. Урьд нь хийж үзээгүй огт мэдэхгүй ажил хийх цаг болж буйг бодохоос Керри сүрдэж эхлэв.

Өнөөх бадарч байсан сайхан хүсэл мөрөөдлөөс нь энд тэнд нь хэдхэн цог улайхын төдий үнс л үлджээ. Сэтгэлээр унах учир хоол цайгаа дув дуугүй идэж уухын сацуу гутлын үйлдвэр дээр үзсэн харснаа сэтгэлдээ ургуулан бодож байв. Үйлдвэрийн эзэн, томчуултай нүүр учран, хааяа хааяа ганган дэгжин хувцастай ноёд орж ирж харах байх гэж бүүр түүр тааварлан бодлоо.

- За чамдаа амжилт хүсье гэж Керрийг явахад нь Минни хэлэв. Эхлээд өнөө өглөөдөө явган явж үзэх нь зүйтэй, өдөр бүр ажил амжих нь уу үгүй юу долоо хоногт унаанд жаран цент өгнө гэдэг бага цалинтай хүнд их зардал юмдаа гэж тэр хоёр ярилцав.

- Орой ирээд юу болсныг яримз гэж Керри хэлэв.

Нар гийсэн гудамжаар ороход ажилчин хүмүүс, жижиг албан хаагч, хар ажилчдыг дааж ядталаа пиг дүүрэн суулгасан морин трамвай хоёр тал тийшээ цувах бөгөөд ойр хавийн барилгын үүд хаалгаар гарсан хүмүүс тэр олонтой нийлэн миегнэхийг хараад Керрийн сэтгэл яльгүй тавирч байлаа. Дээр нүд алдам хөх тэнгэр цэлийж, урьхан цэвэр салхи сэвгэнэх имй нартай сайхан, өглөө хэний ч болов сэтгэлийг сэргээх ажээ. Хүн шөнийн пад харанхуйд юм уу, өдрийн бүгчим давчуу цагаар айх эмээх, зовох бухимдах нь ихэсдэг атал нар гийсэн тийм орчинд үхэл гэдгийг ч түр зуур таг мартнам.

Керри, шулуухан алхсаар гүүрэн дээгүүр гарч тэндээсээ тавдугаар өргөн чөлөө тийш эргэв. Тэндхийн гудамж нь хар саарал чулуу, улаан хүрэн тоосгон ханатай, ангал мэт санагдана. Том том цонх нь цэвэрхэн гялалзана. Тоо томшгүй ачаатай тэрэг нүүгэлтэж, эрэгтэй эмэгтэй хүмүүс, охид багачуул зүг бүр яарна. Керрийн үе тэнгийн охид тааралдахдаа өөрийнх нь айж

хулчигнахыг зэвүүрхэх мэт хараад өнгөрнө. Керри энэ хотын асар их далайцтайг мэдрэхдээ энд амь зуух гэсэн хүн их юм мэдэж авууштайг төсөөлж байв. Мэдлэг чадваргүйгээ бодохоос зүрх нь шимширнэ. Юу ч хийж чадахгүй яана вэ гэж айна. Тийм ч юм ийм ч юм мэдэхгүй байна гээд л ажилд авахгүй байсан шүү дээ. Элдвээр харааж, муу муухайгаар нь дуудаад, ажлаас хөөж шившиг болговол яана?

Керри тиймэрхүү муу юм бодож өвдөг нь суларч амьсгаа нь давчидсаар Адамс гудамж, Тавдугаар өргөн гудамж хоёрын өнцөгт байдаг гутлын өнөөх том үйлдвэрийнхээ газар хүрч ирээд өргүүлээр нь дөрөвдүгээр давхарт гарвал ойр хавьд ганц ч хүн алга, харин баахан хайрцгийг байшингийн дээвэрт тултал эгнүүлэн хурааж гудамжлан зай гаргасныг үзэв. Керри хүн гарч ирэхийг хүлээн ихэд сүрдэн зогсож байлаа.

Удалгүй Браун ноён хүрч ирсэн боловч танихгүй байгаа бололтой:

- Юу гэж явна вэ? гэж асуулаа.

Керрийн зүрх ёгхийгээд:

- та намайг өнөө өглөө ирээрэй. Ажил байж магадгүй гэсэн билээ гэвэл Браун:

- Өө, тийм, тийм, нэр чинь хэн билээ гэв.

- Керри Мибер.

- “За миний хойноос яваарай” гээд хайрцагтай юм гудамжлан хураасан харанхуй газраар дагуулан явахад шинэ гутлын будагны үнэр хамраар хага ташна. Явсаар үйлдвэр рүү ордог төмөр хаалгаар ороход намхан дээвэртэй том гэгчийн өрөөнд цагаан цамцтай хөх энгэрэвчтэй эрчүүл ханцуй шамлан нүргэлэн түжигнэх машинуудын дэргэд ажил хийж байгаа харагдав. Керри царай улайлган нөгөө хүнийхээ араас даган шал ширтэн, тэр түжигнэлдэх машинуудын хоорондуур явав. Тэртээ буланд нь очоод бас нэг өргүүр шатаар зургадугаар давхарт гарав.

Браун дохио өгч дуудахад мастер нь ярайтал эгнэсэн машин, сандлуудын дундуур алхан шууд хүрч ирэв.

- Нөгөө охин чинь энэ дээ гэж хэлснээ Керри рүү харж – Энэ хүнийг дагаад яв гээд өөрөө эргэн одов. Керри шинэ даргаа даган өрөөний тэртээ өнцөгт байх ширээний дэргэд очлоо. Энэ бол албан хонтоор нь болдог булан ажээ.

- Урьд иймэрхүү газар ажил хийж байсан уу? гэж нэлээд албархуу асуув.

- Үгүй шүү, ноёнтоон.

Ийм хүн авах болсондоо дотроо дургүй байгаа боловч нэрийг нь бичиж аваад өнөөх түжигнэлдэх машинуудын дэргэд намхан намхан сандал дээр эгнэн суусан олон хүүхэн сууж буй газар руу дагуулан очиж, гутлын зуузайд машинаар нүх гарган суугаа нэг хүүхний мөрөн дээр гараа тавьж:

- Чи энэ хүүхэнд гэж Керрийг зааснаа-наадах ажлаа зааж өгөөд над дээр очоорой! Гэв.

Сайхь хүүхэн бушуухан гэгч босоод Керрид суудлаа тавьж өгөв.

- Хэцүү ажил бишээ, энэ ширийг ингэж бариад, ингэж хавчуулаад л машинаа ажиллуулна шүү гэж хэлээд эрэгтэй хүний шаахайн зулаг болох хэсэг шир барьж машинд тааруулан хажуугийн даравч төмрөөр даруулан машинаа явуулахад тажигнан ажиллаж зулагны ширний захаар оосорны нүх гаргаж эхлэв.

Керрийн ажиллахыг хараад хэсэг зогсож байснаа төвөггүй чадаж байгааг нь мэдээд яваад өгөв.

Баруун гар талын машины хүүхнээс ирсэн зулагны ширэнд Керри оосрын нүх гаргаад зүүн гар талынхаа хүүхэнд дамжуулах ёстой байлаа. Жигд хурдтай байхгүй бол өнөөх шир нь өөр дээр нь овоорч дараачийн хүний ажил саатах юм гэдгийг Керри нэн даруй ойлгов. Ийш тийш харах ч завгүй, хийх ёстой юмандаа санаашран улайрлаа. Баруун зүүн гарынх нь хүүхнүүд Керрийг ичингүйрэн зовж буйг ойлгоод нэг их сандруулахгүйн тулд туслах санаатай чадах ядахаараа ялимгүй аажуувтар ажиллаж байв.

Керри тийнхүү нэг хэсэг тасралтгүй ажиллахад машины дуу чимээ, ажлынхаа эрчимд хамаг юм мартагдан, амсхийх мэт болжээ. Сүүл сүүлдээ өрөөний гэрэл ч олигтой саруул биш нь мэдэгдэв. Шинэхэн будагтай ширний үнэр хамар цоргин ханхлах боловч тоосонгүй. Бусад хүүхнүүд өөр рүү нь хараад байгааг мэдээд удаан хөдөлж ажилд нь саад болж байгаа юм болов уу хэмээн баахан сандарч санаа нь зовно.

Нэг удаа ширээ арай буруу хийчихээд мунгинаж эхэлтэл мөрөн дээргүүр нь том гэгчийн гар хүрч ирээд тэрний нь засав. Мастер ард нь хараад зогсож байжээ. Керрийн зүрх булгилж, нүд нь эрээлжлэх шиг болоод бүр будилж эхлэв. Нөгөө хүн:

- Машинаа явуулаач, машинаа явуул. Дамжлага битгий саатуул гэлээ.

Үүнд Керри давхийн сэхээ авч ажлаа шаламгайлан мастераа яван явтал амьсгаа давчуухан байлаа. Явсан хойно нь дотор нь онгойх шиг томоор амьсгаа авлаа.

Өглөөний сэрүүн өнгөрөх тутамд өрөөнд улам бүгчим халуун болж байв. Цэвэр агаар амьсгалж ус уумаар санагдавч Керри босож эс зүрхлэв. Сандал нь налах түшлэггүй, хөл тавих хөндөлвч ч үгүй, учир их эвгүй, бүх бие нь хөшиж, нуруугаар нь өвдөж эхлэв. Керри дороо хавчигнан, нуруугаа махийлгаж тэнийлгэж олон янзаар үзэвч тус болсонгүй, ядарч эхэллээ.

- Босож болно шүү дээ. Босохыг хориглодоггүй юм гэж хажуугийнх нь хүүхэн олон таван оршил үггүй шууд хэлэхэд Керриөөдөөс нь талархлын нүдээр хараад “тэгье” гээд босоогоор нэг хэсэг ажиллахад мөр, шилэн хүзүүгээр нь өвдөж бүр ч дэмий болох нь мэдэгдлээ.

Тэр газрын бүдүүлэг байдал Керрид тун муухай санагджээ. Керри хаашаа ч харахгүй, тэнтэй ч үгийн солиогүй ажлаа хийхэд машины дуу чимээний завсраар эвгүй үг сонсдон нүдний буланд зохисгүй явдал ажиглагдана.

- Чи өчигдөр орой Харритайгаа уулзав уу, гэж зүүн гар талд нь ажилладаг хүүхэн дэргэдэхээсээ асууна.

- Үгүй.

- Шинэ зангиа зүүсэн байхы нь чи харсан бол доо. Хичнээн догь байсан гэж санана!

- Чшш! Гэж өөр нэг хүүхэн дуугараад ажилдаа улам шамдан бөхийв. Түрүүчийнх нь дуугай болоод гэмгүй царайлав. Мастер нь хүн болгоны ажлыг сүрхий ажиглан удаан алхана. Яваад өгмөгц нь яриагаа үргэлжлүүлцгээнэ.

- Хүүе, чи юу гэж хэлсний нь мэдэх үү? Гэж зүүн гар талын хүүхэн асуухад нөгөө нь,

- Юу гэсэн юм гэв

- Намайг “Мартины” тэнд Эди Харистай явж байхы минь харсан гэнэ.

- Аа, тэгээ юу?

Хүүхнүүд жиг жуг хөрөлдөв.

Үсээ дэндүү их ургуулсан хүрэн үстэй залуу ширний өөдөс дүүрэн сагс гэдсэндээ тэвэрч машинуудын хоорондуур хөл чирэн явахдаа Керрийн ойролцоо ирээд гэнэт нэг хүүхний тохойноос барьж авлаа.

- Зүгээр байгаач, балай амьтан! Гэж хүүхэн уурлав.

Хүрэн үст залуу марсайн инээнэ.

- Яасан хэврэг амьтан бэ? гэж цааш явуут хэлэх нь ямар ч намбагүй хүн болохоо илт харуулав.

Керрийн хөл бадайрч, нуруу хөшихөд босож суниамаар, сүүл сүүлдээ бүүр сууж чадахгүй болж байв. Үдийн завсарлага болохгүй, яасан удна вэ? Бүхэл өдөржин ажилласан юм шиг санагдана. Өлсөөгүй боловч, бүх бие нь суларч, ганц юм руу ширтсээр нүд нь чилжээ. Баруун талынх нь хүүхэн үүний нь ажиглаад Керрийг өрөвдөнө. Керри дэндүү хичээснээс биш, уг нь хүч чадал, ухаан бодол нэг их шаардах ажил биш ажээ. Гэсэн ч зулагны шир тасралтгүй хүрч ирээд байхад өөрийнхөө дамжлагыг амжуулах л хэрэгтэй, өөр ямарч арга байсангүй. Эхлээд Керрийн царвугаар өвдөж байсан бол сүүлдээ гарынх нь хуруу өвдөх болж, ганц маягийн хөдөлгөөн хийсээр сүүл сүүлдээ бүх булчин нь өвдөн зовоох болж, огиулмаар санагдав. Керри сайхь тамд төгсгөл алга гэж цөхрөнгөө барж байтал гэнэт өргүүр шатны хавиас хаанаас ч юм хонх дуугарах чимээ сонсдон завсарлага эхлэв. Хүмүүс гүнгэнэлдэн ярилцаж хөл хөдөлгөөн болов. Хүүхнүүд нүд ирмэхийн зуур суудлаа орхин, хажуугийн өрөөнд орцгоолоо. Баруун талаас тасаг дундуур эрэгтэйчүүд гарч ирлээ. Машины хурдан эргэлдэж байсан дамруудын эргэлт нэгэн үзэрэг бууран уудааширсаар зогсон ам гүм болоход хүмүүсийн ярилцах дуу хоолой нэг л хачин сонсдоно.

Керри босоод идэх юм руугаа явав. Хамаг бие нь хөшиж, толгой нь ялимгүй эргэх шиг, их цангасан байлаа. Боодолтой юм, хувцас хунар хадгалдаг модон хайср руу очих замд мастер нь тааралдаад тух сүрхий ширтэн ажигласнаа:

- за, ажилдаа дасаж байнаа уу? гэж асуухад керри түүнийг ихэд хүндэтгэх байдлаар:

- Болмоор юм шиг байна гэв.

За! Гэж мастер нь дуугараад өөр хэлэх юм олохгүй бололтой цааш явав.

- Ажлын нөхцөл байдал нь сайнсан бол энэ ажил тийм ч муу биш байв. Гэтэл тэр үед

хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах шаардлагыг үйлдвэрийн газарт огт хамаагүй мэт үздэг байлаа.

Машины тос, ширний будагны үнэр, бас хуучин барилгын шинхэг үнэр, холилдохлоор үнэхээр муухай, хүйтний улиралд ч үмхий самхай оргино. Оройдоо ганц удаа цэвэрлэдэг шалан дээгүүр нь элдэв хог новш өдөржин заваарна. Ажилчдад аль болох бага хөлс өгч, аль хүнд ажилд аль болох их зүтгүүлж чадвал ашиг төчнөөн их нэмэгдэнэ гэж бодоод ажлын нөхцөл сайжруулах талаар санаа тавьдаг хүн байсангүй. Хөлийн тавиур, сандлын эвхмэл аравч, ажилчдын гуанз, дээл хувцасны тохилог өлгүүр, цвэрхэн энгэрэвч, хормогч, хувцсаа үнэгүй индүүдэх индүүний талаар гэрэл гэгээ муутай, бохир, тэр ч бүү хэл үмхий самхай оргино, ер нь л юм бүхэн нь өөд муутай ажээ.

Керри, буланд тавьсан хувинтай уснаас аягыг уугаад, юмаа идэхдээ суух санаатай суудал хайв. Бусад хүүхнүүд нь цонхны тавцангаар зээглэн зогсож зарим нь нөгөө эрэгтэйчүүдийн орхин гарсан вандан дээр суужээ. Суудал бүр дээр нэг хоёроороо буюу хэдл хэдээрээ байх тул Керри тэдэнтэй танилцаж нийлэх зориг хүрсэнгүй, өөрийнхөө мухар сандал дээр очиж, идэх юсмаа өвдөг дээрээ задлав. Ингэж байхад өөрийнх нь тухай цаадуулын ярьж чалчих сонсдов. Тэдний ярианы ихэнх нь дэмий балай бөгөөд чихэнд чийртэй этгээд хаичн үг хэрэглэнэ. Тэр өрөөнд үлдсэн хэдэн эрэгтэй хүн, жигүүрлэн суусан эмэгтэйчүүдтэй тэртээ холоос үг хаялцан байв.

Цонхны дэргэдэх жижигхэн зайд вальс эргэсэн нэг хүүхэнд эрчүүлийн нэг нь :

- Хүүе, Китти! Хоёул бүжгэнд явах уу? гэхэд нөгөө нэг нь:

- Китти мэдээтэй л байж үзээрэй, үс гэзгий чинь биш болгочихоос сийхгүй хүн шүү, энэ чинь! Гэв.

- За, чамтай чамгүй болох байлгүй гэж хүүхэн хариу хэлэв.

Керри энэ мэтийн эрээ цээргүй үгэнд дасаагүй болохоор тэднүүсээс аль болох дөлөхийг зөнгөөрөө хичээнэ. Дасал болоогүй тийм яриа цаанаа л нэг бохир бүдүүлэг санагдана. Тэр залуучуудаас өөртэй нь тиймэрхүү юм яриузай гэхээс Керри ихэд зовж байлаа. Тэнд ажиллдаг залуучууд, ер нь Дрүүгээс бусад эрэгтэйчүүд бүгд болхи бүдүүлэг инээдтэй амьтад мэт санагдана. Керри, бүсгүй хүний зангаар хүнийг хувцсаар нь ялгаж, сайхан хувцасласан бол сайн сайхан хүн, ажлын муу хувцас хунартай л бол өөдгүй амьтад гэж болох ажээ.

Завсарлагын хагас цуаг төдхөн дуусаж, машины дуу түжигнэлдэн эхлэхэд Керри баярлах шиг боллло. Ядарч байлаа ч гэсэн олны дотор ажилд дарагдан ажиг сураггүй блох нь дээр санагдана. Гэвч ингэлээ гэээд нэмэр болсонгүй, нэг ажилчин залуу дэргэдүүр нь өнгөрөхдөө хавирга руу нь хуруугаараа хээв нэг чичив. Керри давхийн муухай харсан боловч цаадах нь аль хэдий нь цааг явж, нэг удаа эргэн харахдаа марсайтал инээж байв. Керри нулимсаа арай чарай барилаа.

Хажуугийн хүүхэн нь Керрийн байдлыг ойлгож:

- Тэгж л байг, тун дүрсгүй муухай амьтан байгаа юм гэлээ.

Керри юу ч хэлэлгүй ажлаа л шагайсаар. Иймэрхүү байдалд удаан байж болмооргүй санагдана. Ажил гэдэг бодсоноос огт өөр ажээ. Тэр өдрийн үдээс хойших хагасыг гадаа гарахсан, гадуур явж

дэлгүүр худалдааны үзмэрийн цонх, хотын сайхан барилга байшингуудыг харж олны дотор явахсан гэсэн бодлоор л өнгөрөөлөө. Колумб хот нь , гэр орных нь дотно сайн сайхан бүхэн нь санагдаж байлаа. Гурван цагийн алдад одоо зургаан цаг болж байгаа байх, дөрвөн цагийн алдад цагаа мартаад илүү цагийн ажил хийж байна гэж боджээ. Мастер гэгч нь өрөөгөө тасралтгүй эргэлдэн ганц хормын төдий ч амар заяа үзүүлэхгүй байв. Керри чихэндээ сонсдох ярианаас дүгнэн эднүүсийн хэнтэй нь хэрхэвч найзлахгүй юм хуна гэж шийдэ жбайлаа. Ганц янзаар суусаар хамаг мөч нь шархиран өвдөнө.

Малгайгаа өмсөөд урт хонгил дундуур явах зуур нэг залуу ажилчинтай хальт хараа тулгарсанд:

- Хүүе, Хонгор минь! хүлээзнэ, хамтдаа явья л даа гэлээ.

Энэ үгийг Керрид хэлсэн нь лавтай, гэвч Керри эргэж ч харсангүй өнгөрлөө.

Пиг дүүрэн хүнтэй өргүүр гатанд бас нэг хир, тос болсон залуу эргүүлэх санаатай нүүр рүү нь гөлрөөд байлаа.

Гадаа гараад найзаа хүлээж байсан нэг залуу Керрийг хамрагц инээмсэглэн:

- та бид хоёр нэг зүг явах юм биш биз гэж марзганах байдалтай хэлэь.

Керри урам ихэд хугарч баруун тийш эргэлээ. Булан тойрохдоо анх ажил сураглан очиж байхад байсан жижигхэн ширээ, шил толь шиг цонхоор харагдлаа. Гудамжаар үй олон гүжирмэг хүмүүс урьдын адил миегнэн цувсаар байна. Үйлдвэрийн тэр бүгчим цехээс гадаа гарахад Керрид ялимгүй ч гэсэн аятайхан ажээ. Дэргэдүүрээ өнгөрөх сайхан хувцастай хүүхнүүдээс Керри ичиж зовно. Хүнээс дор явах учиргүй төрсөн атал яахлаараа ийм байдаг билээ хэмээн дотроо эгдүүцэн гомдоно.

ШӨНИЙН ГЭРЭЛТ ЦЭЦЭГ, НЭР ХЭРЭГ БОЛОВ

Дрүү тэр орой ирсэнгүй. Захидлы нь аваад Керрийн тухай бодохыг түр орхин цаг зугаатай өнгөрөөхийг өөрөө хэрхэн ойлгогдгийнхоо хэрээр тэгж өнгөрөөлөө. Тэр орой, мань эр Кларк Монро гудамжны өннцөг дэх байшингийн дор байдаг кэгсэн нэрд гарсан “захирал” гэдэг ресторанд хооллов. Тэндээсээ гарч хотын захиргааны сүлрэг баайшингийн халз урдаас харсан Адамс гудамжнаа орших “Фицжеральд, Мой хоёр” гэсэн зоогийн газар орж гоёмсог ширээннийх нь ард суугаад нэг хундага цэвэр виски хөнтөрч, хоёр оромол навчин тамхи аваад нэгий нь татав. Энэ бол Дүрэгийн бодлоор дээдсийнхний ердийн аж төрөх маягийн хүрээнд багтах нэг л хэлбэр ажээ.

Дрүү архичин ч биш, мөнгөтэй ч хүн биш. Амьдралд хамгийн сайхан гэж боддог бүхэндээ шүлс залгин явах агаад иймэрхүү маягаар цагийг нөгцөөхийг тийм сайхан амьдралын салшгүй хэсэг гэж ойлгоно . Хана шал нь засмал гантигаар гялалзсан гэрэл гэгээ ихтэй, мөнгө шаазан сав суулгыг энд тэндгүй өрсөн, хамгийн гол нь олонд алдаршсан жүжигчид байнга орж суух дуртай газар гэж цуурайтах болсон “захирал” гэдээг сайхь рестораныг Дрүү өөдөлж яваа хүнд тохирох газар гэж бодно. Дрүү сайхан хувцаслаж, амт шимтгэй хоол зооглох дуртай боловч өөдрөг яваа хүмүүстэй танилцаж нөхөрлөхийг юм юмнаас эрхэмд үзнэ. Энэ ресторанд орж хоол зооглоход Жозеф Жефферсон олонтаа орж ирдэг гэж бодохоос, бас тэр үедээ тэр нь их цууриатай байсан өөр нэг жүжигчин Хенри Дикси хэдхэн ширээний цаана сууж байхыг харахаас сэтгэл нь өег байдаг ажээ. Улстөрийн бодлогочид, мөнгөний захын жууч панзчин, жүжигчид цугладаг, түүнлчэн хотын баян аальгүй зартай залуус ирж дэмий байлай юм донгосон наргиж суудаг сайхь ресторанд байнга тийнхүү сэтгэл өег байж болно.

“Захирал” реторанд мөнгийг баруун солгойгүй шидлэхээр толгой эргэм их амижлтанд хүрээгүй боловч нэг л цагт хүрнэ гэж найддаг тийм хүмүүсийн нэг нь :

- Тэнд тийм ийм хүн сууж байна гэхэд хариуд нь:

- Өө, тийм үү? Гэхэд:

- Тэгэлгүй яахав, таньдаггүй юм уу? Яагаав нөгөө Дуурийн их Театрын захирал байхгүй юу гэх мэт ярилцах нь олонтоо сонсогдоно.

Дрүү иймэрхүү үг сонсохлоор мөр цээжээ засаж хоолоо бүрч амтархан иднэ. Тэртэй тэргүй онгиороо, дээгүүр зантай хүн болохоор тиймрэхүү яриаг сонсоод бүр ч онгиороо зан нь хөдлөн дээгүүр санаа нь бүүр ч гаарна. Зуутын ногоо дэвсгэртүүдийг дэвхийтэл түрийвчлээд хайш яйшхан зарж байх нэг өдөр ирнэ гэж мөрөөднө. Одоо ч гэсэн тэр томчуулын зооглодог газардуртай цагтаа идэж суугаа юм чинь.

Адамс гудамжны “Фицжеральд ба Мой” зоогийн газрыг эрхэмлэдгийн учир нь энэ. Тэр бол Чикагодоо хамгийн хээнцэр “Захирал” рестораны нэг адил зөөлөн цахилгаан гэрэлтүүлэгтэй, шалын нь алаг эрээн паалантай тоосгоор нүүрлэсэн, хананы доод биеийг хар хүрэн чийтэй модоор хулдсан тул үзэсгэлэнт цэцгэн дэнгийн гэрэлд хугарч нэн сайхан харагдана. Урт лангуу нь нүд гялбам гэрэлд ярайн сүрлэг үзэгдэх агаад мөн л чийдсэн модоор хулджээ. Элдэв төрлийн болор, эрээн шилэн эдлэл, ухаанд оромгүй оло маяг хлбэр бүхий олонх сав энд тэндгүй гялалзана. Энэ бол том том далдуу модтой, улс орны хаанаас ч эрээд олохгүй шилдэг санй архи дарс, тамхи янжуур бүхий зоогийн газар юм.

“Захирал” ресторанд Дрүү, “Фицжеральд ба Мой” зоогийн газрын эрхлэгч ноён Г.В.Херствудтэй танилцжээ. Түүнийг ихэд өөдрөг яваа, хотдоо нэр хүндтэй хүн дуулжээ. Энэ нь өөлөх юмгүй үнэн байлаа. Херствуд насаар дөч шүргэж яваа, бие чийрэг, лагс сүрхий эршүүд бхйдалтай, өмссөн хувцас нь догь, цас шиг цагаан цамц гял цал гэхээс гадна үнэт чулуу алттай хатгуур зүү, цамцны ханцуйн тээглүүр зэрэг нь түүний өөдрөг догь яваагийн шинжийг нотлохоос гадна гол нь чадал чансаагаа мэддэг хүний нэг байв. Дрүү эл байдлыг шууд ойлгоод түүнтэй нөхөрлөдөг хэрэг хмээн шийдсэн тул танилцаад зогссонгүй, харин аяга тагш юм балгах буюу ороомол навчин тамхи татмаар санагдсан цагтаа заавал ч ордог болжээ.

Херствуд, нэлээд сонин хүн байлаа. Аар саар юманд авхаалжтай овсгоотой, хүнд аятайхан сэтгэгдэл төрүүлж чадна. Зоогийн газрын эрхлэгчийн алба нь нэлээд чухал ажил боловч санхүү эрхлэх эрх эдэлдэггүй нь гаслантай ажээ. Олон жилийнтурш хичээл зүтгэлтэй ажилласных зуушны мухлагийн худалдагч байснаа одоогийн алба хүртлээ дэвшжээ. Херствуд интоорын өнгөтэй зүлгэмэл хана бүхий жижигхэн өрөөтэй агаад тэндээ зоогийн газар захиалсан, авсан ба авах эд барааныхаа дансыг, тооцооны бичиг баримтаа жижиг ширээнд хадгална. Ерөнхий удирдлага, санхүүгийн ажлыг зоогийн газрын эзэд- Фицжеральд, Мой хоёр, түүнчлэн өдрийн орлого мөнгийг хянан тооцож байдаг мөнгөний нярав л мэднэ.

Херствуд ихэнхдээ гадаад даавуугаар хийсэн гоёмсог костюмтай, хуруундаа бөлзөгтэй, зангиандаа цэгээн очир алмас шитгэсэн маш гоё зүү хатгаж, цоо шинэ маягаар оёулсан гайхалтай сайхан хантааз өмсөж, бүдүүн алтан оосортой сайн чанарын цаг зүүчихээд зоогийнхоо газар дотуур хөлхөнө. Мань хүн хот даяар ихэд нэрд гарсан, хэдэн зуун жүжигчин, наймаачин, улс төрийн бодлогоч, бусад янз бүрийн хүмүүсийг нэр усаар нь мэдэх тул “Хашир минь сайн уу?” хэмээн дотно мэндлэх тул үүгээрээ өөрөө ч тэдний дунд нэр олж өөдрөг явах болжээ. Херствуд тэдэнтэй учирч мэндлэхдээ тэдний хэр чадал, зэрэг дэвийг харгалзан хэлэх шаталсан тогтмол үгтэй байв. Байнга орж гарч байдгаараа алба ажлы нь андахгүй болсон, долоон хоногт арван таван долларын цалинтай жижиг албан хаагч нартай бол “амрыг эрье” гэх атлаа нэр алдартай, өөрт нь талтай баячуулыг бол “Та мэнд сайн биз вээ?” Лагшин тунгалаг уу? хэмээнэ. Бас дэндүү баян, дэндүү их алдартай, дэндүү их өөдрөг яваа тийм гийчид байх тул Херствуд тэдэнтэй тийм нүүрэмгий уулзахгүй, жинхэнэ мэргэшлийн ая тал засан хүндэтгэж хувийнхаа нэр төр, бодол санааг илтгэн сүрхий догь царайлах ажээ. Харин нэг их баян ч биш, нэг их ядуу ч биш мөртлөө олонд нэртэй хэдэн хүнтэй үнэхээр дотно харилцаатай байв. Тэдэнтэйгээ дуртай ярилцаж, хэлэх ярих үгий нь анхааралтай сонсоно. Мань хүн хааяа хааяа зугаагаа гаргах гэж зарим клубт очиж морины уралдаан, биеийн тамирын тэмцээн, театрт ший жүжиг үзнэ, Херствуд бол хувьдаа сайхан морь тэрэгтэй, авгай, хоёр хүүхэдтэйгээ Линкольний цэцэрлэгийн ойролцоо гоёмсог харш мэт байшинд суудаг, америкийн “дээд хүрээлэнгийнхэн” гэгчийн төлөөлөгч бөгөөд амьдралынхаа төвшингөөр мөнгөний тулмуудаас нэг л шатаар доогуур хүн юм.

Херствуд, Дрүүг тун аятайхан хүн гэж боджээ. Эелдэг зан байдал, өмсөж зүүсэн нь таатай санагдав. Дрүүг үөбхөн жууч худалдаачин, тийм ажилд ороод нэг ир удаагүй хүн гэдгийн андахгүй боловч “Бартлаг, Карио, Түнш” гэдэг өөдлөн мандаж буй том пүүсэнд нэр сайнтай яваа хүн гэдгийг бас мэднэ. Херствуд, Карио ноёныг сайн таньдаг байсан болохоор заримдаа түүнийг найз нөхөдтэйгөө хамт ирэхэд тэдний ярианд оролцон ганц нэгэн хундага ч тулгана. Чарльз Дрүү өрийнх нь ажилд ч тустай нэлээд алиа хошин үгтэй хүн агаад эгзэгтэй үед инээдтэй сонин юм сайхан ярьчихна. Херствудтэй уулзаад морины уралдаан үзсэн тухайгаа, амьдралдаа тохиолдсон элдэв адал явдал авгай хүүхэнтэй харилцсан паянгаа хүртэл ярьж, очсон хт газруудынхаа зах

зээлийн байдал ямар байгаа тухай, ер нь нэг үгээр хэлэхэд ярилцаж суухад тун таатай хүн ажээ. Тэр орой, тайлангаа тавьж пүүснээсээ сайшаал шагнал хүртэж, шинэ шинэ загвар сонгон авч, ойрын сар хагасын дотор хаагуур хаагуур явахаа төлөвлөн боловсруулчихаад байсан болохоор дотор уужуу, зан ааш нь гэж жигтэйхэн сайхан байлаа.

Дрүэг наймаг цагийн алдад орж ирэхэд Херствүд:

- Өө, санй байна уу, Чарли минь! Ажил төрөл ажилттай юу? гэсээр угтав.

Тэр мөчид зоогийн газар хүн пиг дүүрэн байв.

Дрүэ түүнтэй гар барин малилзаж хоёул лангууны зүг явлаа.

- Баярлалаа, зүгээр.

- Тантай уулзаагүй бүтэн сар хагас боллоо. Хэзээ ирэв?

- Баасан гаригт ирсэн, ажил бүтэмж сайтай явсан.

- Больж доо гэж Херствүд хэлэв.

Ердийн байдалд хэзээд хэнэггүй байдалтай байдаг хар нүдэнд нь үнэнхүү халуун дотно сэтгэлийн өнгө тодроод явчлаа.

Цас шиг цагаан цамц, мөн тийм өнгийн зангиатай зуушны худалдагч захиалга авах гэж өмнө нь ирээд нахилзахад Херствүд,

- Та юу уух вэ? гэж Дрүэгээс асуухад Дрүэ:

- Хатуу виски гэв.

- Надад ч гэсэн бас нэг хундага гэж Херствүд хэлээд – Та эндээ удах уу, гэхэд:

- Лхагва хүртэл л байна. Энэ удаа Сен-Поль руу явна гэв.

- Бямбад Жорж Иванс ирсэн. Таныг түрүүчийн долоо хоногт Милуокид явж байна лээ, уулзлаа гэсэн.

- Тэгсээн, Жоржтой тааралдсан_ Ер нь аятайхан хүн шүү. Бид хоёр хамт бас нэлээд наргисаан.

Зуушны худалдагч тэр хоёрын өмнө шилтэй архи авчирч тавихад хоёр найз яриагаа үргэлжлүүлэхийн зуур архаа хундагалж байв. Дрүэ ёсыг дагаж хундаганыхаа гуравны хоёр хэртэй архи хийхэд Херствүд хэдхэн дусал хийгээд дээрээс нь рашаан хийв.

- Карио хаашаа алга болсон бэ? Үзэгдэлгүй хоёр ч долоо хоног боллло гэж Херствүд асуув.

- Хэвтсэн гэж дуулдсан шүү. Цаадах чинь тулай өвчтэй юм шүү дээ.

- Цагтаа овоо их мөнгө хураасан хүн дээ, тийм биз?

- Тиймээ, мөнгийг ч бишгүй л хүүдийлсэн. Харин насгүй болсон хүн. Ажилдаа бараг очиж чадахгүй байгаа.

- Ганц хүүтэй гэсэн байхаа?

- Тиймээ, нэг үрэлгэн лүд бий гэсэн гээд Дрүэ инээд алдахад Херствүд:

- Гэлээ ч гэсэн бусад түншүүд нь байгаа болохоор тэр хэдийхэн аранга болов гэж дээ гэхэд Дрүэ

- Тиймээ, тийм, би ч гэсэн тэрнийг нэг их хотойлгож чадахгүй биз гэж боддог гэв.

Херствүд цамцаа задгай тавьж, дотуур хантаазныхаа халаасанд хоёр гарынхаа эрхийг хурууг хийн лангуу налан зогсоно. Зангиа, бөгжинд нь гэрэл хугаран тунарахад нь бүхий л гадаад трөх нь улам ч сүрлэг дэгжин, тохилог бүхний амилсан дүр шиг харагдана.

Архи уудаггүй, шалдир балдир юм ярих дургүй тийм хүнд бол элдэв бусын юм ам булаалдан шуугилдах хүмүүс дүүрсэн өдөр шиг гэрэлтэй тэр цэлгэр өрөө амьдрал ба байгалийг хачин маягтай урвуулсан тэрч зүйл мэт санагдах бизээ. Эндхийн тод гэрэлд хургах зах сэжүүрээс сонссон хүнд цугларагсдын ямар хүмүүс болохыг тодорхойлоход нэн төвөгтэй байх бизээ. Луйварчингууд бол овт аргаа боловсруулахын тулд үүнээс илүү бөглүү булан олно, харин улс төрийн бодлогочид урт соргог чихтэй, аль нэгэн этгээд дуулчихаж тун болзошгүй учир ийм газар ирж нууц юмаа ярилцах гэж цуглахгүй нь лавтай. Энэ зоогийн газар цуглардаг тэр хүмүүс архинд дуртайдаа ч ирдэг юм биш бололтой, яагаад гвэл энэ хээнцэр үзэсгэлэнт газар ирдэг хүмүүсийн ихэнх нь архинд орсон улс биш ажээ. Гэлээ ч гэсэн чухам энд л цуглаж чалчдаг, энд л нийлж танил тал болдог нь цаанаа нэг шалтгаантай. Ямар нэг шунал тэчъяал, бүүр түүр хүсэл эрмэлзэл байсан учраас л иймэрхүү газар бий болсон хэрэг, тиймгүй бол хаанаас ийм газар байх билээ. Энэ бол эргэлзээгүй.

Жишээ нь Дрүэ энд жаргаж цэнгэх, дээгүүр хүмүүст тоогдох санаатай л байн байн ирдэг байна. Энд ирээд түүний уулздаг хүмүүс нь ч гэсэн өөрснөө нэг их нарийн ухаардаггүй ч гэлээ мөн л тиймэрхүү хэрэгцээний улмаас гадна гял цал өнгө, ерөнхий амьсгалд нь татагдан ирдэг байгаа хэрэг л дээ. Эцсийн эцэст үүнийг энд цуглардаг хүмүүс, голцуу биемахбодын хүсэлд авиагдан ирэх хэдий боловч энэ нь нэг их ч муу юм биш нийгмийн ёс суртахуун сайжирч буйн шинж гэж үзэж болмоор ажээ. Маш нижгэр дорвитой засаж янзалсан өрөөнд бясалган суухад ямар хор болох билээ. Муу нөлөө нь гэвэл амьдралыг эд, баялгаар хэмжиж боддог хүмүүст иймэрхүү юм үзээд энэ зэрэг явахсан гэх хорхойгий нь баахан хүргэнэ биз. Ийм тохиолдолд ч гэсэн уг нөхцөл байдалд буруу өгөх хэрэггүй, харин хүний төрөлхийн дотуур бодлыг буруушаалтай. Иймэрхүү нөхцөл байдлын улмаас муу дээлтэй хүн дөнгүүр дээлтэй хүнээс юу боловч илүү гарна гэж зүтгэх дээр хүрвэл үүнийг арвигүй атаа муу зан гэхээс өөрөөр тайлбарлаж болохгүй мэт. Хүний дургүй хүргэх архийг л зайлуулчихлаа гэхэд ийм зоогийн газар ирсэн хойноо эндхийн тохилог сайхан байдал тааламжтай сэтгэгдэл төрүүлсэн явдлыг хэн ч буруушаахгүй. Орчин үеийн хээнцэр дэгжин ресторанууд ихэд дэлгэрч байгаа нь ийм үзлийн зөв болохыг нотолж байна.

Гэлээ ч гэсэн гял цал гадна өнгө, дэгжин хээнцэр байдлын өмнө сөгддөг эмх замбараагүй, тодорхой зорилго, уйдаагүй сэтгэхүйн гэрч болсон биеэ тоосон хоосон чалчаа ярианд хамаг сэтгэлээ өгсөн ганаган дэгжин хувцасласан, хувиа хичээсэн өөдгүй хүмүүс, цэлийсэн гэрэлтэй тэр том танхим нь түүний хананы гадаах өнө мөнхийн оддын гялтганах ариун туяан дор зогсоод цэлийсэн гэрэлтэй энэхүү зоогийн газрыг харваас ужид цэнгэлийн хуурамч сарнайн ухаан

мансууруулам үнэр ханхалсан үлгэр таавар мэт агаад хивэн эрвээхэй бужигнасан шөнийн гэрэлт цэцэг шиг санагдах буйзаа.

- Энэ орж ирсэн хүнийг харав уу? гэж Херствүд, бортогон малгайтай, Алберт хунтайзын дээлтэй дөнгөж саяхан хоол чихчихсэн мэт тарган хацар нь улаа бугарсан ноёныг хараад хэлэхэд Дрүэ:

- Үгүй аль вэ гэлээ

- тэр л байна гэж Херствүд торгон бортого малгайтай хүн рүү нүдээрээ заахад Дрүэ түүнийг хальт хараад:

- Хэн гэгч вэ? гэв.

- Жюль Воллес, спиритч хүн гэж байгаа.

Дрүэ тэр хүнийг нилээд ажиж харснаа:

- Сүнс сүгээр оролдох хүн гэж хэлмээргүй харагдаж байна гэлээ.

- Тийм юмаар оролддог эсэхийг нь мэдэхгүй, ямар ч гэсэн их мөнгөтэй л болсон хүн гэж Херствүд хэлэхэд нүдэнд нь шуналын оч гялалзана.

- Би тиймэрхүү юманд нэг их итгэдэггүй. Та яадаг вэ?

- Юу гэлтэй юм бэ дээ. Цаанаа ямар нэг юм байж мэдэх л юм. Гэхдээ би энэ талаар толгойгоо зовоохгүй хүн шүү гэснээ: - Матсанаас, Та өнөө орой ийш тийшээ явах уу? гэлээ.

“Газрын нүх” үзнэ гэж Дрүэ тэр үед их алдаршсан хошин дуурийг нэрлэв. Херствүд цагаа гаргаж хараад:

- Тэгвэл одоо явсан нь дээр биз, найм хагас болчихож гэв.

Хүмүүс тарж эхэлсэн тул зоогийн газар хүн цөөрч байлаа. Зарим нь театр, зарим нь тус тусынхаа клубт очихоор явна. Хамгийн зугаатай ужид цэнгэлийнхээ ямар ч болтгуай энд цуглардаг шиг хүмүүсийн боддогчло ундарга болсон авгай хүүхнүүд дээрээ очихоор явна.

- Тийм байна, би явлаа гэж Дрүэ хэлэхэд Херствүд:

- Шийгээ үзчихээд орж ирээрэй өөрт чинь нэг юм үзүүлнэ гэхэд Дрүэ баярлан:

- Заавал ирнэ гэлээ.

- Гэвч өөрт чинь өнөө орой өөр ажил байхгүй биз? гэж Херствүд лавлахад Дрүэ:

- Юу ч байхгүй гэв.

- Тэгвэл, юмаа үзчихээд ирээрэй.

Дрүэ гарахынхаа даваан дээр:

- Баасан гаригт галт тэргэнд явахдаа нэг хөөрхөн гэгч охинтой танилцсан юмсан. Явахаасаа өмнө заавал ярьдаг ч юм уу олж уулзаг хэрэг гэхэд Херствүд:

- За, санаа зовоод яах вэ? болох байлгүй гэв.

Дрүэ, найзынхаа сэтгэлийг гижигдэх гэж аминчилсан байдлаар:

- Ёстой цэврүү шиг охин шүү гэлээ.

- Арван хоёр цагт шүү гэж Херствүд хэлэхэд Дрүэ гарч явахдаа:

- Тиймээ тийм гэв.

Ийнхүү, Керри шинэ амьдралын анхны үед бараг гарцаагүй тохиолддог золгүй хувь тавиландаа гомдон урвайж байсан яг тэр мөчид хамгийн шалди, балдир, хамгийн наргиан цэнгээнтэй газар нэрийг нь дурссан байна.

МАШИН ОХИН ХОЁР. ӨНӨӨ ҮЕИЙН БААТАР

Керри орой эргэж ирээд нэг л шинэ байдалтай болсныг мэдрэв. Чухамдаа ямар ч өөрчлөлт гараагүй байсан боловч Керри өөрөө өөр болсон учраас л учир байдлыг илүү сайн ухаарсан хэрэг. Урьд нь Керри ажилд орох боллоо хэмээн хх баяртай ирж байсан болохоор энэ удаа хийсэн ажлынхаа тухай ярьсаар баяр хөөртэй ирнэ гэж Минни хүлээж байв. Хенсон ч өөрцгүй, Керрийг сэтгэл хангалуун байх биз гэж боджээ.

Хенсон гаднаас орж ирээд хувцсаа ч тайлалгүй гал тогооныхоо үүдэнд очиж Керригээс:

- За ажил чинь ямар байна дуу? Гэв.

- Ай, их хэцүү юм, бүр дургүй хүрчихлээ гэж Керри хариулав.

Ажилдаа ядарч, гутарсан нь бүр андашгүй харагдана.

Хенсон, халуун усныхаа өрөө рүү орох гэснээ түр саатан:

- Ямар ажил юм, юү хийв дээ? гэхэд:

- Оёдлын машинаар юм оёх ажил гэж Керри хэлэв.

Хенсон, гэртээ орох олз омгийг л сонирхож байгаагаа өөр юм бодоогүй нь илт байлаа. Керри олж олсондоо баярлах байтал ийм үг хэлэх гэдэг чинь хэмээн Хенсон зэвүүцэв.

Минни, Керрийг ирэхээс өмнө их л хөхиүн байсан бол одоо гал тогоондоо нэлээд урвагар хөдөлнө. Керрийн тийм урамгүй үг сонссоноос хойш шарж байсан махных нь үнэр ч нэг их сайхан санагдахыг болив. Өдрийн туж үйлээ эдэлж эдэлж ирэхэд гэрийнхэн нь баяртай угтан сайхан хоол унд ширээн дээр дэлгэчихээд: “За яах вэ, ямар ч гэсэн тэсэхийг бод. Яваандаа аятайхан юм олдох” байлгүй гэлэг хүн байдагсан бол аятайхан л байлаа. Гэтэл тэгсэнгүй, бүх юм таал өнгөрчээ. Хүргэн ах, эгч хоёр нь түүнийг ажилд дэмий ялархаж байна, дуугүй л зүтгэвэл таарна гэж бодож байгааг ойлгов. Тэднийд суусны хөлсөнд долоо хоногийн дөрвөн доллар өгөх ёстой учраас ийм улстай хамт байх зовлон, гунигаас өөр юм өгөхгүй гэдгийг Керри ухаарчээ.

Минни нас нь талийж байгаа болохоор Керрид түших, зовлон жаргалаа хуваалцах хүн биш ажээ. Хэвшиж дадсан амьдралынхөө нөхцөл байдлаас цааш гарахгүй хүн болсон байв. Хенсонд сэтгээл тэжээх, баярлаж хөөрмөөр юм хааяа гардаг байлаа ч тэрнийгээ нууна. Санаа сэтгэлд нь юу ч болж байсан түүнээ ил гаргадаггүй нь сайн. Орхигдон эзгүйрсэн байшин шиг л дүлий дүмбэ орхисон эр. Гэтэл Керри бол залуу зандан насны ид хав, элдэв хүсэл мөрөөдөл оргилон яваа залуу хүн. Харин хайр сэтгэл, хүнтэй ханилах, ижилсэх ёсыг огт үзээгүй яваа хүн. Өөрийн дурламаар юм хийхсэн, сайхан хувцаслахсан, энд тэнд явж юм үзэж нүд тайлахсан гэж бодно. Иймэрхүү юманд л хамаг бодол нь эргэлдэх агаад өөрийнх нь бодлыг энд хэн ч дэмжихгүй байгаа болохоор алхам тутамдаа садаа тээг учирч байнам гэж бодох болов.

Керри, тэр өдрийн болсон явдлыг байн байн бодсоор Дрүэ хүрээд ирж магадгүйг мартаж дөхсөн боловч санахтайгаа зэрэг садангийнхнаа хайхрамжгүй байгааг бодохоос Дрүэг битгий ирээсэй гэж бодно. Гэнэтхэн хүрээд ирж гэм тэр хүнтэй юугаа ярьж, яах учраа ч үнэндээ олигтой мэдэхгүй байлаа. Хоолныхоо дараа Керри хувцсаа сольж өмсөв. Ялимгүй гоёсхийхэд нь Керри

царай орж том нүд нь дэрвэлзэн, хэзээний гуингтай мэт хошуу нь шөмбийсөн хөөрхөн бүсгүй болчихно. Нүүрэнд нь горьдлого, цөхрөл гуниг илэрнэ. Сав суулгаа хурааж угааж цэвэрлэсний дараа Миннитэй бага сага юм ярьж зогссоноо доош бууж орцны хаалган дээр гарч зогсохоор шийдэв. Дрүэг ирвэл тэнд тосъё гэж боджээ. Бүрх малгайгаа өмсөхөд Керрийн нүднээ баярын совин татах шиг харагдав.

Хар хүнээ сонингоо барьсаар гал тогооны өрөөнд орж ирэхэд Минни:

- Керри маань ажлаа голж байгаа бололтой гэхэд Хенсон:

- Ямар ч гэсэн тэр ажлаа хийзнэх хэрэгтэй. Цаадах чинь гадаа гараа юу? гэв.

- Тэгсэн.

- Би л чиний оронд байсан бол ажлаа хийх хэрэгтэй гэж хэлэх байна. Өөр ажил олтол хэдэн долоо ч хоног болох юм билээ.

Минни тэгж хэлнэ гэхэд нөхөр нь сонингоо уншиж эхэлснээ:

- Би л бол битгий гадаа гарч зогсож бай. Эвгүй юм шүү гэж хэлэхсэн гэхэд Минни:

- Би тэгж хэлье гэлээ.

Керри, гудамж ажиглаж хичнээн ч удаан хамаагүй зогсмоор санагдана. Сүүх, жаазанд сууж яваа тэр олон хүн хаашаа явж, хэрхэн зугаалдаг бол гэж үргэлж сонирхоно. Бодох нь даанч явцуухан болохоор зөвхөн мөнгө, гадны өнгө хувцас хунар, эсвэл зугаа наадмын төдийгөөс хэтрэхгүй. Заримдаа Колумб хотынхоо тухай цухасхан бодож заримдаа тэр өдрийн амссан зовлонгоо бодож уур эгдүү нь хүрэх боловч ерөнхийдөө явцуу хүрээт бодол дундаа л эргэлдэнэ.

Хенсоных хоёрдугаар давхарт суудаг тэр байшин доод давхартаа талх боовны дэлгүүртэй, Хенсон талх авах гэж доош бууж иржээ. Керри түүнийг дэргэдээ хүрч ирэн иртэл ажсангүй. Хенсон дэргэдүүр нь гарахдаа:

- Би талх авах гэж явна гэлээ.

Нэг хүний бодол нөгөөд яасан амар хүрнэ вэ. Хенсон талх авахаар гарсан нь үнэн боловч далимд нь Керри яаж байна гэдгийг л мэдэх гэсэн хэрэг. Керри ч түүнийг хамрагцаа санаагий нь ойлгож, яагаад ч юм өөрөө учры нь эс мэдэвч тэр хүнд үнэнхүү зэвүү нь хүрч үзэн ядах болов. Хенсон муу санаатай, хар сэртэй хүн гэдгийг ойлгож авав.

Заримдаа ялимгүй нэг бодлоос болж орчин тойрноо өөрөөр ухаарах нь байдаг. Керрийн бодол нэгэнт тасалдсан учраас Хенсоныг буцаад дээш явахад нь дагаж харав. Дрүэг ирж магадгүй гээд нэг хоёр мөтийн төдий горьдон харсан боловч ирсэнгүй. Тэгэхлээр Керрийн дургүй нь жаахан хүрэхийн хамт тоосонгүй юм болов уу гэж бас гоморхов. Керри буцаад орж ирэхэд Минни гал тогооныхоо өрөөнд дэнгийн гэрэлд юм оёж сууна. Гэрийн дотор нам гүм. Хенсон хэдийн дугжрахаар хэвтжээ. Ядарч цөхөрсөн Керри ч унтлаа гэхэд Минни,

- Тэгсэн дээр байлгүй. Өглөө эрт босно шүү дээ гэв.

Өглөө босоод ч дээрдсэн юм байсангүй. Керрийг өрөөнөөсөө гарч ирэхэд Хенсон явчихсан байв. Минни цай ууж суухдаа Керритэй бага сага юм ярилцаыхг оролдовч хоёуланд нь ярих олигтой юм ч олдож өгөхгүй. эг маг гэсээр байв.

Керри, дөрвөн доллар хагасын цалингаа сууц, хоолны хөлсөнд бараг бүгдийг нь өгөөд унаанд суух мөнгө ч үгүй үлдэх болохоор бас л өчигдөр өглөөнийх шиг хотын төв рүү явган алхлаа. Дандаа иймэрхүү юм бодохлоор эвгүй санагдах боловч өглөөний сэргэг цэнгэг агаар, нарны дуниартах сайхан гэрэл гэгээ тэр өдрийн анхны золгүй зовлонт явдлыг түр ч болтугай таягдан зайлуулах мэт ажээ.

Гутлын үйлдвэр дээр ажилласан хоёр дахь өдөр ь мөн л өнгөрч өгөхгүй байсан боловч урьдынхаасаа илүү хэцүү байсангүй, гэхдээ урам сэргээм шинэ сэргэг юм ч гарсангүй. Ерөнхий мастер нь эргүүл хийж яваад Керрийн дэргэд ирж зогсон:

- Та хаанаас гараад ирсэн хүн бэ? гэхэд Керри:

- Намайг Браун гуай авсан гэлээ.

- Өө, тэр авсан байж! Ажил л битгийн саатуулаарай.

Хамт ажилладаг хүүхнүүд нь Керрид өчигдрийнхөөсөө дор санагджээ. Тэд бол иймэрхүү амьдралдаа сэтгэл хангалуун, ер нь бүгдээрээ “эгэл борог” санагдана. Керри тэднийг бодохноо илүү ухаантай, жудаггүй бүдүүлэг үг ярьдаггүй байв. Хуваслахдаа ч гэсэн тэдний хавьгүй дүйтэй. Ялангуяа хажууд нь суудаг гол цохисон нэг хүүхний яриа чихэнд бүр ч чийртэй, балай санагдлаа.

- Би энэ ажлаас гарнаа. Хөлс нь имй бага. Өдөржин ингэж зүтгээд бие яаж тэсэх вэ гэж хажуугийнхаа хүүхэнд хэлэх нь сонсдоно.

Хүүхнүүд нь хөгшин, залуу эрэгтэйчүүдээс ер зовохгүй, тэдэнтэй ана мана үг хаялцах нь анх сонсхоод жигтэйхэн аймаар. Өөртэй нь ч гэсэн удахгүй тэгж харьцах нь эргэлзээгүй.

Үдийн завсарлагаанаар нэлээд танхай маягийн нэг залуу Керрийн дэргэд ирж:

- Сайн уу? Яасан хөөрхөн амьтан бэ? гээд хариуд нь “За чи згээр яв” гэсэн үг лав сонсоно гэж бодож байтал Керри юу дуугарлгүй эргээд явжээ. Сайхь эр чисэндээ марсайтал инээхчээ болсноо бушуухан зайлан одов.

Гэртээ ирэхэд урьд урьдынхаас ч уйтгартай тул цаг үргэлжийн гуингтай дүнсгэр байдал тэвчимгүй санагджээ. Хенсоныд орж ирэх хүн бараг байдаггүйг Керри ажлаа. Керри өрөөнөөсөө гарч доош бууж орцонд жаахан зогсож байснаа цааш явж үзэхээр шийдлээ. Зорьсон юмгүй аажуухан алхаж явааг нь хараад зарим хүн анхаарав. Гуч эргэм насны ганган сайхан хувцастай нэг эр хажуугаар нь гарахдаа Керрийн нүүр рүү сүрхий ширтсэнээ алхаагаа сааруулж:

- Үдшийн цагаар салхинд гарч байна уу? гэж асуухал нь Керри гайхан харж ялимгүй ухарсхийснээ:

- Юу? би таныг огт танихгүй юм байна гэхэд нөгөөдөх нь:

- Өө, тэр яах вэ, хамаагүй шүү дээ гэж нүүрэмгий хэлэв.

Керри хариу ганц ч үг хэлсэнгүй, бушуухан салахын мөн болж зугтаахдаа арай л багтарсангүй. Тэр хүний үд Керрид аймаар санагджээ.

Тэр долоо хоногийн бусад өдөр бас л ялгаагүй байв. Нэг хоёр орой нь бүр их ядарч унаанд сууж харив. Угаас тийм ч их чийрэг хүн биш учир өдөржин нэг янзаар суусаар зоо нуруугаар нь шархирч өвдөнө. Тэгээлд ч нэг удаа Хенсоноос өмнө унтжээ. Цэцэг, залуу хүүхэн хоёрыг шинэ газар идээшлүүлэх тэр болгон амжилттай болдоггүй. Илүү үржил шимтэй хөрс, хэвийн байдалтай өсөж торниход нь илүү сайн уур амьсгал шаардагдах удаа цөөнгүй тохиолдоно. Шинэ байдалд алгуурхан, рс цочмог бишээр идээшсэн бол Керрид хамаагүй дээр байхсан. Ажилд яарч оролгүй сэтгэлий хөдөлгөсөн тэр хотын байдлыг тодорхойхон мэдэж авсан бол хавьгүй дээр байхсан.

Бороотой анхны өдөр болоход Керри борооны шүхэргүйгээ мэдэв. Минни өөрийнхөө нэг хуучирч муудсан шүхрийг түр хэрэглүүлэв. Керри нэрэлхүү зантай хүн болохоор тэр явдал баахан төвөг уджээ. Мань хүн нэг томхон дэлгүүрээр орж доллар хорин таван центээр шүхэр худалдан аваад жаахан мөнгөнөөсөө хороов.

Тийм юм худалдаж авсны нь Минни хараад:

- Яах гэж ийм юм авсан юм? гэхэд Керри:

- Надад хэрэгтэй болоод л авсан гэв.

- Тэнэг юм хийж дээ.

Керри хариу үг хэлээгүй ч гэсэн тэгж хэлэхэд нь дургүй нь хүрэв. Үйлдвэрийн ажилчин хүүхнүүд шиг лойж явах юм бодоо юу, гайгүй байлгүй гэж Керри дотроо бодов.

Анхны бямба гаригийн орой Керри тэднийд сууж буйн хөлсөнд дөрвөн долларыг эгчдээ төлөв. Минни мөнгийг нь авахдаа баахан зовох боловч дутуу авчихвал Хенсонд юу гэж хэлэх ухаанаа олохгүй байв. Тэр сүрхий нарийн хүн болохоор гэр орныхоо зардалд гаргах мөнгийг эхнэртээ өгөхдөө инээд алдан энэ удаа яг дөрвөн долларыг дутуу өгсөн ажээ. Ийм аргаар өнөөх худалдан авч буй газрынхаа үнийг сар бүр ахиухан төлөхөөр төлөвлөжээ. Керрийн хувьд гэвэл хувцас олж өмсөх, юм хум үзнэ гэхэд долоо хоногт тавьхан центээр яах я учраа олохгүй байлаа. Керри энэ талаар бодсоор байгад сүүлдээ санаа сэтгэл нь ч үймэрчээ.

- Би гадуур жаахан явнаа гэж Керри хоолныхоо дараа хэлэхэд Хенсон:

- Ганцаараа юу, үгүй биз дээ гэв.

- Тиймээ ганцаараа.

- Яах нь вэ дээ гэж Минни үг хавчуулав.

- Би бага сага юм үзмээр байна шүү дээ гэж Керрийг хэлэхэд цаад хоёр нь өөрсөндөө дургүйхэн байгааг нь анх удаа гадарлалаа.

Керрийг малгайгаа өмсөхөөр өрөөндөө орох хооронд Хенсон эхнэрээсээ:

- Юу болоо юм бол? гэхэд Минни:

- Бүү мэд гэв.

- Оройн цагаар гэрээс гарахгүй байх нь дээр гэдгийг мэдвэл таарна даа.

Керри нэг их хол явсангүй, төдхөн буцаж ирээд хаалган дээрээ бага зэрэг зогсжээ. Маргааш нь хамтдаа Гарфильд цэцэрлэгт очсон боловч Керрийн санаанд огт таарсангүй. Хувцас муутай болохоор тэн дэмий санагджээ. Ажилдаа очоод хүүхнүүдийнхээ яриаг сонсоход тэд бага сага зугаалж наргиснаа хөөр баяр болгон ярих бөгөөд их л жаргалтай харагдана. Хэд хоног бороо зүсрэн орсон учир Керри ирж очихдоо арга буюу хөлсний тэргээр явав. Нэг орой Ван Бурен гудамжинд очиж унаанд суухаар явахдаа бороонд нэвт цохиулжээ. Тэр оройжин, Керри урд талын өрөөнд ганцаар суун явган хүний зам дээр гэрэл чийдэн хэрэхн тусахыг ажиглан бодлогшрон суулаа. Элдвийг бодсоор сэтгэлээр унаж байв.

Дараагийн бмяба гаригт бас л дөрвөн доллараа төлөөд тавин центээ цөхөрсөн байдалтайгаар халаасандаа хийлээ. Хамт ажилладаг зарим хүүхэнтэй танилцаж яриа хөөрөөгий нь ажихад тэднүүс өөрсөндөө арай л илүү мөнгөтэй явдаг байв. Тэр бас танил залуу харчуултай тэд нь ийш тийш юманд урьдаг байж. Керри, Дрүэтэй танилцсанаас хойш тэр зэргийн залуусыг тоохгүй болжээ. Ажлынхаа хөнгө, онгиороо залуучуудыг бүр ч үзэж чадахгүй. Тэдний нэг нь ч олигтой санагдсангүй. Үнэндээ тэдэнтэй ажлын цагаар л тааралдана.

Өвлийн шинжийг илтгэсэн хүйтэн салхитай хохилзуур өдөр ирлээ. Тэр салхи тэнгэрийн үүлийг зад шавхуурдан хөөж, үйлдвэрийн яндангийн утааг ийш тийш нь хөөж шавхуурдаж, хотын гудамж, уулзвар газруудаар сүрд сардхийн цахилах мэт ааашлах ажээ. Керри өвлийн хувцасны бодол боллоо. Одоо яах билээ? Дулаан хүрэм, өвлийн малгай, гутал аль нь байхгүй. Энэ тухайгаа Миннид хэлэх хичнээн хээцүү байсан ч хэлэхээс биш аргагүй тул зориглон:

- Өвөл болж байдаг, би яадаг билээ? Надад дулаан хувцас байхгүй. Малгай ч байхгүй гэж нэг орой хоёулхнаа сууж байхдаа хэлэхэд Миннийн царайд зовох байдал илэрч:

- Чи цалингийнхаа хагасыг өөрөө аваад малгай ав л даа гэж хэлсэн боловч Керрийн өгөх мөнгө бага болохоор асуудал босож ирнэ хэмээн дотроо их л зовж байлаа.

- Тэгвэл ихл сайн байна гэж Керри хэлээд бүр зориг орж нэг хоёр долоо хоног өнж л дөө гэв.

- Чи хоёр доллар өгөөд байж чадахгүй юу? гэж Миннийн асуухад Керри дуртайяа тэгье гээд хүнд байдлаас гарах зам олсондоо баярлан сэтгэл нь тавирч шууд юу юу авахаа тооцож эхлэн давын түрүү малгайтай болж атах хэрэгтэй гэж бодлоо.

Минни, Хенсонд яасхийж учрыг нь тайлбарласныг Керри хэзээ ч мэдээгүй юм. Хенсон юу ч хэлээгүй боловч дургүйцээн нь харваас илт байлаа.

Керри өвдөөгүйсэн бол бодсон нь бүтэх л байсан буй за. Бороо орсны дараа цочир хүйтрэхэд Керри нимгэн хувцаснаасаа салж садаагүй явж байлаа. Оройн зургаан цагт халуун цехээсээ гарахад өмнөөс нь хүйтэн салхи угтав. Бие нь агзасхийнэ. Өглөө болоход хамрын шуухнаа хүрсэн

байсан боловч ажилдаа очиж байж бүр ч дордоох нь тэр. Өдрийн туж үе мөч нь шархирч, толгой нь нэг л биш дүүрсээр байлаа. Ажил тарахын үед Керрийн бие бүр өвдөж хариад хоолоо ч бараг идэж чадсангүй. Минни үүнийг хараад юу болоо вэ гэж асуухад Керри:

- Яасныг өөрөө ч мэдэхгүй байна. Бие нэг л муу байна гэлээ.

Зуухны дэргэдээс зайлахгүй суух агаад бие нь агзасхийн шүд нь давжигнана. Унтаад өглөө болоход халуунтай байлаа.

Минни үнэхээр зовж сандарсан боловч гадна өнгөндөө гайгүй юм шиг царайллаа. Хенсон, Керрийг нутагтаа буцсан нь дээр юмдаа гэжээ. Гурав хоногийн дараа Керри эдгэрсэн боловч ажлаа алдсан нь ямарч эргэлзээгүй байлаа. Өвөл хаяанд ирсэн байдаг. Керри дулаан хувцас ч үгүй, ажил ч үгүй байдаг.

- Одоо яадаг билээ, мэдэх юм алга. Ямар ч ботугай даваа гаригт гадуур гарья, хийх юм эрх биш олдох байгаа гэж Керри хэлэв.

Энэ удаа Керрийн оролдлого даанч бүтэл муутай байлаа. Хувцас нь намрын хүйтэнд огт тохирохгүй болов. Байсан хэдэн мөнгөө малгайнд хамж өгөөд барчихлаа. Гурван өдрийн турш хотоор тэнэж сэтгэл санаагаар улам чунахад хүрчээ. Хүргэн ах, эгч хоёртойгоо ийм чнзаар байх улам улам хэцүү болж байв. Орой бүр зүрх шимширсээр ганзага хоосон буцаж ирнэ. Хенсон ч бүр мөс шиг хүйтэн царайлах болов. Ийм байдал удаан үргэлжилж болохгүйг Керри ухаарч байв. Мөд хамаг санасан бодсоноо хаяад нутагтаа буцахаас өөр замгүй санагдлаа. Дөрөв дэх өдөр эгчээсээ өглөөн хоолонд арван цент зээлж аваад өдөржин тэнэв. Хариугүй хямдхан ч хамаагүй ажилд орохыг бодож нэг жижигхэн рестораны цонхон дээр хоол зөөгч авна гэсэн зарлал байхаар нь горьдон орвол туршлагатай эмэгтэй авна гээд халгаасангүй.

Керри цөхрөнгөө бараад олон хүний дунд дэмий л тэнэж явтал гэнэт нэгэн хүн тохойноос нь барин, бие рүүгээ татлаа.

- Өө-хөө-хөө! Гэж хэлэх нь Керрид дуулдав. Дрүү мөн болохыг хармагцаа танилаа. Царай нь ягааран солонгын туяа татах мэт харагдах агаад нарны гэрэл сайхан ааш зангийн эх ударга мэт байлаа.

- За, Керри минь сайн уу? Тун хөөрхөн харагдаж байна, яагаад алга болчихсон бэ? гэхэд Керри, түүний тийм дотно үгийн эрхэнд автан инээмсэглэж:

- Би гэртээ л байсан гэв

- Би, таныг бүр тэр гудамжны нөгөө талд явахдаа хараад танилаа. Өөрийг чинь лав мөн гэж бодсон. Очиж уулзъя гэж явсан маань энэ шүү дээ, за тэгээд ямар шуу сууж байна даа?

Керри мөн л инээн:

- Зүгээр, дажгүй гэв.

Дрүү, түүнийг хөл толгойгүй ажаад тийм ч биш байна даа гэж бодно.

- За, өөрт чинь ийш тийш явах онцгой хэрэг байхгүй бол юм ярилцмаар байна.

- Үгүй, онцын юм алга.

- Тэгвэл хоёул нэг газар орж жаахан юм идэж ууя. Би тантай тааралдсандаа хичнээн их баяртай байна, бурхны өршөөлөөр л ингэж тааралдлаа даа!

Керри тийм их анхаарал халамж гарган сүйд майд болоход таатай санагдан дотор нь онгойж дуртайяа зөвшөөрсөн ч бас ялимгүй яая даа гэсэн царай гаргав.

- За, хоёул явах уу даа хэмээн Дрүэ Керрийг сугадан авахад түүний дотно нөхөрсөг занд сэтгэл зүрх нь уярлаа.

Тэр хоёр Монро гудамж хөндлөн гараад тэрр үед сайхан хоол, сайн үйлчилгээгээрээ алдаршиж байсан уудам саруул танхимтай тохилог, хуучин маягийн “Винзор” хэмээх ресторанд оров. Дрүэ гудамжны хөл хөдөлгөөнийг харж суух гэж яг цонхны дэргэдэх нэг ширээнд суулаа. Дрүэ энд сууж хоол зооглохдоо гудамжны байнга өөрчлөгдөх хөл хөдөлгөөнийг ажиг дуртайгаас гадна бусдыг ч харах, бусдад ч харагдах дуртай ажээ.

Хоёул тухлан суусны дараа Дрүэ:

- За, юу авах вэ? гэв.

Керри, хоол зөөгчийн авчирч өгсөн хоолны цэсийг харлаа. Их өлсөж явсан болохоор сайхан хоолны нэрийг уншихад хүртэл арааных нь шүлс асгаравч үнэ ихтэйгээс нь айх ажээ. “Шарсан тахианы мах-далан таван цент, “Мөөгтэй махан хуурга-нэг доллар хорин таван цент”,

Керри, тиймэрхүү хоол байдаг гэдгийг дуулсан мэт. Харин өөрөө мэдэж хоол захиална гэхэд ухаанд нь батамгүй санагдлаа.

- За би захиалаатахъя, хүүе! Хоол зөөгч өө! Гэж Дрүэ дуудав.

Ханхар цээжтэй, дугариг царайтай негр хүрч ирээд мэхийсхийж чих тавин далжийлаа.

- Мөөгтэй махан хуурга, дарсан лоольтой гэж Дрүэг хэлэхэд негр толгой дохин:

- Жа гэнэ.

- Шарсан жижиг төмс

- Жа

- Спарж

- Жа

- Кофе

- Жа, гээд негрийг явсны дараа Дрүэ, Керри рүү харж

- Би өглөөнийхөө хоолыг идээгүй явна. Дөнгөж сая Рок Айландаас ирлээ. Тантай уулзах үед хоол

идье гэж явсан байхгүй юу гэв.

Керри хариуд нь зөвхөн инээмсэглэсээр л байлаа.

- Юу хийж байв даа? Өөрийнхөө тухай бүгдий нь ярьж өгөөч. Эгч чинь сайн уу?

- Эгч сайн гэж Керри нэг дор асуусан олон юмных нь хамгийн сүүлчийн асуултад л хариулав.

Дрүүэ, Керрийг сүрхий ажиглан харснаа:

- Өвдөөгүй биз? гэхэд Керри өвдсөн гэж толгой дохилоо. Дрүүэ дуу алдаж:

- Үгүй ер, тэгнээ тэр. Одоо ч гэсэн царай чинь нэг л биш. Яагаад имй цонхигор байна гэж бодсон юм. Энэ хооронд юу хийж байв даа.

- Ажил хийсэн.

- Өө тийм үү! Хаана?

Керри ярьж өгөв.

- Роудс Моргантау, Скотт гэдгий чинь би мэднэ. Тавдугаар өргөн чөлөөнд байгаа биз. Нарийндаа хатсан улс даа. Яах гэж тэнд очсон юм?

- Өөр ажил олдохгүй болохоор нь гэж Керри үнэнээ хэлэв.

- Үгүй ер нь, яришиг байна даа. Тийм улсад ажил хийх хэрэггүй байсан юм. Их дэлгүүрийн урд талд байгаа биз дээ?

- Тиймээ.

- Олигтой газар огт биш. Иймэрхүү ажил хийх хэрггүй шүү, өөрт чинь таарахгүй.

Дрүүэ зогоос зайгүй чалчин, элдвийн юм асууж шалгаан, өөрийнхөө тухай ярин, ресторанаа элдвээр магтан байтал хоол зөөгч том гэгчийн тосгуур дээр арааны шүлс асгарам үнэр танар ханхалсан хоол авчирч өгөв. Дрүүэ үйлчлэх гэдгийг үзүүлж өглөө. Гуанзны ширээний цагаан хэрэгсэл мөнгөн сав суулганы дунд Дрүүэ өнгө жавхаа булаалцалдан хутга сэрээ барин гялалзлаа. Мах огтлоход бэлзэг гялалзан, илүү дутуу үгний ч хэрэг байсангүй. Хоолонд гара явуулж, талх, цай авч өгөх тоолонд цоо шинэ костюмных нь ханцуй шажигнана. Керрийн тавганд хоол хийх, хачир цай оройтуулж өгөх гэж зогоос зайгүй халамж сэтгэлийн дулаанд Керрийн бие дулаацаж төрлөө арилжих шиг болов. Эгэл жирийн хүмүүсийн бодлоор Дрүүэ үнэхээр сайхан хүн тул Керри түүнд нэгмөсөн татагдлаа.

Аз жаргалыг хайгч энэ өчүүхэн энэ охин тэр азтай тохиолыг их л хөнгөн хүлээж авлаа. Тэнд суухад мөр хавчуу санагдах авч рестораны уужим саруул танхим цээж дүүрэн амьсгалж тэнүүн байх бололцоог олгох мэт ажээ. Гудамжаар сайхан хувцастай хүмүүс хөлхөлдөхийг ажиж суухад ч аятайхан аж. Гусэн ч мөнгөгүй бол ямар тус байх вэ? Дуртай цагтаа энд ирээд хоол зооглож байх гэгч ямар сайхан бэ? Дрүүэ лав юмтай хүн байж таарна. Галт тэргээр байнга аялж, ийм сайхан хувцас хунар эдэлж, ийм сайхан газар хооллодог их чадалтай хүн юм даа. Яггүй мундаг

хүн байх нь, яагаад над мэтийн хүнд ийнхүү хайр хишиг хүртээнэ вэ? хэмээн Керри бодож суув.

- Тэгээд та өвдөж ажлаасаа гарсан байх нь ээ. Одоо тэгээд яая гэж бодож байна?

- Ажил эрнэ дээ гэж Керри хэллээ. Энэ сайхан ресторанаас гарахад гачигдал зовлон, өлсгөлөн нохой ул шиншлэх мэт дагана даа гэсэн бодол түүний дотор орж ирэх нь нүднийх нь харцанд тодорно.

- Өө, ингээд ч амбан явахгүй ээ. Ажил эрээд хэдэн өдөр болов?

- Дөрвөн өдөр.

- Хараач тэр. Та тэгж таарахгүй гэж өөр хүнд хэлж байгаа мэт хэлснээ-Тэр хүүхнүүд хөлс гэж бараг юм авдаггүй, тийм юмаар яаж амь зуух вэ гэж гар тэлэн зангах нь бүхий л үйлдвэр, дэлгүүрийн эмэгтэй ажилчдыг хамруулж буй мэт байв.

Дрүү, Керрийг ах нь дүүдээ сургах мэт анхааран тиймэрхүү ажил өөрт нь таарахгүй гэдгийг хэлчихээд, өөр юм ярьж эхлэв. Керри үнэхээр царайлаг харагдана. Тийм муу хувцастай байгаа хэр нь бие цогцос нь харааж гоолиг бөгөөд нүд нь дүрлэгэр, харц зөөлөн амуй. Дрүү нүүр рүү ширтэн харахад Керри түүний бодлыг ойлгож байлаа. Өөрт нь шохоорхон дурлаж байгаа учраас юу ч хайрлахгүй, аль болох сайн сайхан аашилж буйг Керри мэдэрч байв. Дрүү ч Керрид тун аятайхан санагдаж, цаашид улам улмаар таалагдаж болох юм. Үүнээс бүр ч гүнзгий нууц ямар нэгэн мэдрэц санаа бодолд нь харвах мэт болов. Харах бүр харцтай нь тулгарах тул харилцан ойлголцох мэдрэц яваа яваандаа бүр нэгдэн нийлэх мэт болно.

Дрүү сандлаа оройтуулан сууж:

- Хотын төвд үлдэж, надтай театрт юм үзэх юм биш үү? Гэв. Тэр хоёрын суусан ширээ жижигхэн ажээ.

- Ээ, үгүй ээ, чадахгүй гэж Керри хэлэв.

- Өнөө орой юу хийх вэ?

- Хийх ч юм байхгүй л дээ гэж Керри гунигтайхан хэлэв.

- Тэр сууж байгаа айл чинь нэг л онц биш үү?

- Юу ч гэлтэй юм бэ дээ....

- Ажил олдохгүй бол яая гэж бодож байна?

- Гэртээ буцдаг байх даа.

Ингэж хэлэхэд Керрийн хоолой ялимгүй чичирхийлэв. Яагаад ч юм Дрүүгийн нөлөө тун ихтэй мэт санагдана. Тэр хүн, охины байдлыг ойлгоход, Керрий ч ойлголоо гэдгийг ухаарч, хэн хэн нь үгээр илэрхийлэх хэрэгцээгүйгээр бие биеэ ойлголоо.

- Тэгэх хэрэггүй. Би тусалъя. Надаас жаахан мөнгө ав гэж Дрүү тэрхэн зуур чин үнэнээсээ

өрөвдөн хэлэхэд Керри татвасхийн:

- Өө, тэр ч үгүй шүү! гэлээ.

- Тэгээд яах гэж?

Керри бодлогошрон дэмий л толгой сэгсрэн сууна.

Дрүү түүнийг ер бишийн энхрий байдлаар харна. Хантаазных нь халаасанд нэлээд хэдэн үнгэгдсэн дэвсгэрт байсан болохоор чимээгүйхэн гаргаж ирээд атгаж амжив.

- Керри! Чи миний үгэнд ор. Би өөрт чинь тус больё. Өөртөө бага сага хувцас хунар худалдаж ав гэлээ.

Дрүү энэ талаар анх удаа ийм үг цухуйлгасан тул Керри үнэхээр хувцас муутайгаа шууд саналаа. Дрүү ингэж шулуухан эрээ цээргүй хэлсэн боловч яг л голыг нь олжээ. Керрийн уруул ялимгүй өмөлзөв.

Керрийн нэг гар ширээн дээр байхад Дрүү том халуун гараараа барьж:

- За, Керри минь ингэж болохгүй. ганцаараа яаж дөнгөх вэ? Би тусалъя л даа, болно биз дээ гээд хуруугий нь ялимгүй базахад Керри гараа суллах гэж оролдов. Гэвч Дрүү улам чанга атгахад Керри дахиж оролдсонгүй. Тэгээд ногоон дэвсгэртүүдээ гарт нь шургуулав. Керрийг авахгүй гэж шивнэж:

- Би зээлдүүлж байна шүү дээ, зээлээр өгч байна гээд хүчээр өгөв. Одоо Керри ийнхүү энхрийлэх сэтгэлийн хүрээнд орж ямар нэг юмаар холбоотой болсноо мэдлээ. Тэндээс гараад урагш Полк гудамж чиглэн юм ярилцсаар явав.

- Та тэр садангийнхаа улстай тийм ч таарамжтай биш юмаа даа гэж Дрүү яриа дундуураа оруулж хэлэхэд Керри сонссон боловч нэг л их анхаарсангүй.

- Маргааш хоёул уулзаад театрт өдрийн жүжиг үзье? Ирэх үү? Гэхэд Керри яах юм дээ гэсхийснээ тэгье гэжээ.

- Одоо завтай байгаа дэрээ аятайхан гутал, дулаан хүрэм авбал яасан юм бэ?

Дрүүг яваад өгөхлөөр шийдэж чадамгүй хичнээн олон юм бодогдохыг төсөөлж чадсангүй. Харин хамт байгаа цагт зовох юмгүй, маар байгаагаа ухаарч байлаа.

- Цаадуултайгаа тэсээд байзнаж л бай, би өөрт чинь тусална шүү гэж Дрүү салахдаа хэлэв. Түүнээс алж одохдоо, нэг их том гарын хүчээр зовлонгоос ангижраад явчих шиг санагджээ. Керри нуугьсан нов ногоо арван долларын хоёр дэвсгэртийг гартаа атган явна.

ЭД АГУУРСЫН ТАТАХ ХҮЧ. ЦАРАЙЛАГ ТӨРСНИЙ АЧ

Мөнгөний чухамхүү үнэн учир холбогдлыг тодорхой тайлбарлаж, ултай ойлгох явдал одоо хүртэл шаардлагатай байгаа юм. Мөнгө гэгч энэ зүйлийг юуны өмнө ёс суртахууны үүрэгтэй эд бөгөөд шударгаар зарсан хөдөлмөрийн хариуд олгох ёстой зүйл болохоос хууль бусаар хүчлэн авч байх зүйл биш гэдгийг хүн болгон ойлгосон тэр цагт манай нийгэм, улстөр, шашин шүтлэгийн тун олон балай явдал тасралтгүй арилах замдаа орох билээ. Керрийн тухайд гэвэл мөнгийг мөн л нийтийн адил ухаарч байлаа. “Мөнгө бол хүн бүрт байдаг зүйл, тэгэхлээр би ч гэсэн түүнийг олж авах ёстой” гэсэн бүр хуучны ойлголт Керрийнхтэй яг тохирч таарч байлаа. Одоо Керри аравтын хоёр зөөлхөн ногоон дэвсгэрт атгачихаад байхдаа хавьгүй их хүч чадалтай болсон мэт санана. Тэрхүү цаасанд нь ямар нэг татах хүч байгаа ажээ. Энэ мэтийн бодолтой хүнийг баахан боодолтой мөнгө өгөөд хүнгүй цөл арал дээр аваачаад тавьчихвал удаан хугацаанд өлсөж зовсны эцэст л мөнгө гэгч ямар ч хэрэггүй юм гэж ухаарах буй за. Тийм үед ч гэсэн Керри шиг хүн бол мөнгийг харьцангуй үнэ цэнэтэй зүйл гэж бодохын оронд ийм их хүчирхэг зэвсэгтэй хэрнээ түүнийгээ ашиглах бололцоогүйд гомдох бизээ.

Ядуу хүүхэн маань Дрүэгээс салаад яах ч учраа олохгүй алхаж явав. Хүний мөнгийн авахгүй байж чадсангүйдээ жаахан ичих боловч хүн тус больё гэж байхад хэрэггүй гэж татгалзах бололцоогүй гачигдаж яваа билээ. Одоо тусыг хүртсэндээ баярлаж, гоё гэгчийн хүрэм, товчтой дэгжин гэгчийн шаахай авч өмсөнө. Оймс, банзал... сэлтийг авна хэмээн түрүү авах өчүүхэн цалин хөлснийхөө хэр чадлыг хоёр дахин илүү үнэлж байсан шигээ энэ удаа атгандаа буй мөнгийг бас л хоёр дахин илүү үнэлэв.

Дрүэгийн тухай нэлээд зөв ойлгожээ. Түүнийг сайхан ч хүн, сайн ч сэтгэлтэй хүн гэж бодно. Ер нь Дрүэ хэнд ч тэгж бодогддог хүн. Юу нь муу байх вэ? Гачигдаж явааг нь ойлгоод, сайн санаанаасаа тус больё гэж мөнгө өгчээ. Дрүэ энэ зэргийн мөнгийг ядуу хар хүүд өгөхгүй бизээ, гэхдээ ядуу хар хүү гэдэг угаасаа түүнд ядуу залуу хүүхэн шиг энэрэх сэтгэлийг төрүүлэхгүй учиртайг бид бас бодолцох ёстой л доо. Эмэгтэй хүнд угаасаа нааштай хүн юм л даа. Төрөлхийн тийм зантай хүн аж. Гэхдээ гуйлгачин тааралдаад: "Ноёнтон минь, би өлбөрч үхэх нь, хишиг хайрлаач" гэхэд мань хүн хэдэн мөнгө хаялаа ч гэсэн түүнийгээ өгөөд л тэр хүнээ мартана уу гэхээс биш элдвийг бодож ухаанаа зарж суухгүй. Тийм юмны төлөө хэзээ ч ухаан зарж, цэцэрхэж явахгүй. Гоё сайхан хувцаслаж, эрүүл саруул хөхиүн баяртай явах байдлы нь харахул дэнгийн эрвээхэй гэлтэй. Хэрэв ажилгүй болж, зарим хүнд тохиолддог шигээр олон юманд нэрвэгдэн араараа тавиулчихлаа гэхэд Керри шиг л арчаагүйтэж, гэнэдэж, яахаа ч мэдэхгүй нүдний булай болох хүн.

Дрүэ, эмэгтэйчүүдэд их элэгтэй байдаг нь ямар нэг хорон санааных биш, тэдэнтэй ойртож, дотносож явах нь ямар ч хоргүй гэж бодно. Эмэгтэйчүүдийг эргүүлэх дуртай, тэднийг эрийнхээ чадлаар биедээ татах дуртай боловч хүтээн цэвдэг, нүнжиггүй зан гаргадаг хүн биш, төрөлхөөсөө л тэр явдлыг жаргал цэнгэлийн эрхэм дээд нь гэж үздэг зантай ажээ. Дрүэ биеэ магтах дуртай онгироо хүн, сайхан хувцасанд сүйд майд болон хөлгүй баярлаж байгаа нь хөнгөмсөг охин шиг санагдана. Үйлдвэрийн царайлаг ажилчин хүүхний толгойг дорхноо эргүүлж чаддаг шигээ өөрөө ч дол цохисон луйварчинд амархан идэш болох хүн. Өөрөө эелдэг зөөлөн ааштай, пүүс нь нэр сайнтайн ачаар бие төлөөлөгчийнхөө ажлыг амжилттай гүйцэтгэнэ. Хүмүүсийн дунд хөнгөн дэвүүр шиг хөөрцөглөн эргэлдэх бөгөөд түүнд оюуг билэг гэмээр ухаан ч заяагаагүй, ариун гэмээр бодол, өнө удаан хугацаанд хичээн баримтлах сэтгэл гэмээр юм ч үгүй ажээ. Орчин үеийн “Сафо хатагтай” түүнийг “гайхай”, Шекспир “цовойо хүү минь”, архичин

Кармо ухаалахг, өөдрөг ажилсаг хүн гэх байсан буй заа. Товчоор хэлэхэд Дрүэ ухааныхаа хэрээр л хөдөлдөг хүн.

Энэ хүнд илэн далангүй, эебэрхүү ямар нэг чанар байсны шилдэг нотолгоо бол Керри түүний өгсөн мөгийг авсан явдал юм. Зүрхнийхээ угт үмхий муухай санаа агуулсан өөдгүй амьтан бол яаж ч сайхан аашлаад арван таван цент ч атгуулж чадахгүй шүү дээ. Оюун ухаан нь өсөөгүй хүмүүс тийм арчаагүй байдаг юм бишээ. Зэрлэг араатанд ч гэсэн аюулыг урдаас зөгнөн мэдээд зугтах аргыг байгаль заяасан байдаг. Жирхний жижигхэн толгойд ч гэсэн хорноос ухаанаа гартал айх чадлыг байгаль заяасан байна. “Бурхан, бүтээсэн амьтдаа бүтнээр хадгалдаг” гэсэн үг гагцхүү адгуус амьтдад хамаарах бишээ. Керри ухаан бүрэн сууж, дол цохиогүй байсан ч гэлээ ухаангүй аймгийнхаа доторх хонь лугаа адил зөн ихтэй байж. Гэтэл Керригийн өөрийгөө хамгаалах зөн хичнээн хүчтэй байлаа ч гэсэн тэр нь Дрүэгийн халамж үзүүлэн эргүүлж байхад бараг хөндөгдсөнгүй.

Дрүэ түүнээс салаад, өөрийнхөө талаар сайн сэтгэгдэл төрүүлж чадсандаа баярлаж байв. Залуу хүүхнүүд ингэж хэцүүднэ гэдэг ясар хэрэг байх вэ, муу хэрэг шүү хөөрхий! Хөхөө өвлийн хүйтэн болж байхад өмсөх дулаан хувцас ч үгүй байх, даанч дээ! “Фицжеральд Мойн” пүүс рүү очиж ороомол навчин тамхи авдаг хэрэг гээд Керрийн тухай бодохоос хөл нь хөнгөрч байлаа.

Керри, хүргэн ахындаа очоод, тун баяртай байгаагаа нуух гээд чадсангүй. Гэхдээ мөнгөтэй боллоо ч гэсэн бас санаа зовох юм зөндөө гарлаа. Огт мөнгөгүйгий нь Минни мэднэ, тэгэхлээр яаж шинэ хувцас хунар авах вэ? Яавч болохгүй, хэрхэвч болохгүй. Хаанаас, юун мөнгө оллоо гэх юм билээ гэж тэднийд орж ирэхээсээ өмнө боджээ.

- За тэгээд юу болов доо? гэж Минни дүүгийнхээ ажил хайсан тухай нь асуув.

Керри, угаас худал хэлж чаддаггүй болохоор нэг юм бодоод огт өөрөөр хэлж эс чадав. Заримдаа чухам аргагүй чухал үед л арга буюу чин үнэнээс бага зэрэг хазайхад хүрнэ. Тэгэхлээр нэгэнт баяртай орж ирсэн хойно ажил хайгаад олсонгүй гэж гоморхохынхоо оронд:

- Ажилд авмаар горьдлоготой юм хэлсэн гэв.

- Хаана?

- “Бостон” их дэлгүүрт.

- Нээрэн үү гэж Минни шалгаалаа.

Керри цааш нь байн байн худал хэлэх хэрэггүй гэж бодоод маргааш л мэдэгдэнэ гэв.

Минни, Керрийн ааш тун сайхан байгааг далимдуулан Керрийг Чикагод ирснийг нь Хенсон юу гэж бодож байгааг хэлье гэж шийдээд:

- Чи тэр ажилд орж чадахгүй бол... гэснээ цааш нь чухам юу хэлэхээ мэдэхгүй түгдэрлээ.

- Би мөд ажилд орж чадахгүй бол буцна гэж бодож байна.

Минни уухайн тас болж:

- Свен ч гэсэн, ядахнаа өвлийн цагт харьсан дээр байлгүй гэж байдаг шүү гэв.

Керри, эгчийнхээ ингэж хэлэхэд тэднийх ажилгүй хүн гэртээ удаан байлгах дургүй байгааг дор нь ойлгов. Гэхдээ Миннид буруу өгсөнгүй. Хенсонг ч нэг их буруутай гэн бодсонгүй. Тийнхүү хэлсэн үгийг нь эрэгцүүлэн бодох хоорондоо Дрүэгээс авсан мөнгө маань сайн боллоо хэмээн баярлав.

Керри, хэдэн хормын төдийн дуугүй байснаа:

- Тийм дээ, би ч өөрөө тэгье гэж бодох юм гэв.

Буцна гэж бодохоос зэвүү нь хүрэх боловч түүнийгээ тайлбарлаж хэлсэнгүй. Тэнд буцаж очоод элэнцгийгээ хийх билээ, Тэндхийн юм бүхэн нь уйтгартай доожоогүйг Керри таван хуруу шигээ андахгүй юм чинь. Гэтэл энэ асар том хот оньсого таавар шиг олон нууцтай, хүний дур сэтгэлийг соронзон мэтээр татах ажээ. Тэрхэн хэд хоногийн дотор Керри хичнээн их боломж буйг гадарлажээ. Голж зугадсан тэр муу хуучин амьдралдаа буцаж очно гэж бодохоос Керри: Үгүй! Үгүй хэмээн арай л хашгирчихсангүй.

Тэр өдөр Керри эртэвтэр ирсэн болохоор энэ тэрийг эрэгцүүлэн бодохоор урд талын өрөөнд оров. Одоо яах билээ? Шинэ гутал хувцас авч гм эднийд өмсөж болохгүй. Хорин доллараасаа буцах хөлс хадгалмаар байдаг. Замын хөлсөө Миннигээс зээлэх ч эвгүй юм. Ер нь тэгээд хаанаас мөнгө олсон гэж хэлэх билээ? Энэ эвгүй байдлаас гарахын тулд жаахан ч атугай ажил хийдэг бол?

Энэ талаар Керри байн байн бодол боллоо. Дрүэ, маргааш өглөө өөрийг нь шинэ хүрэмтэй хүчр ирнэ гэж бодож буй, гэтэл болдоггүй. Хенсоных гэрт нь буцаахын мөн болж Керри ч тэднийхээс зайлж өгөхсөн гэж бодно. Гэвч ирсэн замаараа буцах хүсэл даанч алга. Ажил хийгэгүй атлаа мөнгөтэй болсныг нь энэ хоёр юу гэж бодох вэ гэж бодохоос ер нь хэрэггүй л авч хэмээн айх шиг ч, ичих шиг ч боллоо. Ингэж аливааг бодтол урам нь хугарлаа. Дрүэтэй хамт байхад бүх юм амархан ойлгомжтой байлаа. Гэтэл одоо хүний өгсөн хишиг буянг гартаа атгаж байгаа хэр нь түүгээрээ юуг ч хийж чадахгүйг бодохоос хоосон явснаасаа ч дор юм болсон мэт, тун ээдрээтэй, найдлага муутай санагдах болов.

Оройн хоолны үеэр, Керри урам муутай байгааг Минни ажаад өнөөдөр бас л бүтэлгүй юм болж дээ гэж бодов. Керри элдвийг бодсоор сүүлдээ Дрүэгийн мөнгийн дэмий авчээ, буцааж өгье гэж шийдээд маргааш өглөө хотын төв орж ажил хайя, үдэд уулзана гэсэн болзоондоо очихдоо хэлэдэг хэрэг гэж бодоод зүрх нь ёгхийн өнөөх зол заяагүй хэвээрээ үлдсэнээ мэдрэв.

Яагаад ч юм тэр мөнгийг барьж үзэхэд дотор нь онгойх шиг болж элдвийг бодож сэтгэлээ хичнээн зовоолоо ч гэсэн тэр бүхэн нэгмөсөн алга болох мэт санагдан хорин доллар үнэхээр гайхамшигтай, үнэхээр сэтгэл баярлуулах эд болж байв. Мөнгө! Мөнгө! Мөнгө гэгч юутай сайхан бэ? мөнгө ихтэй бол мондийн энэ их зовлонгоос бүрмөсөн ангижирч чадах ажээ.

Маргааш өглөө нь босоод гэрээс урьд урьдынхаас арай эрт гарлаа. Ажил хайх хүсэл нь баахан буурч, сэтгэл нь элдвээр дэнэгэлзэх хэдий боловч халаасанд буй мөнгө нь ажил төрлийн асуудлын хурц үзүүрийг дарж байв. Бөөний худалдааны хороололд дахин очоод аль нэг газар ажил сураглана гэхээс зүрх нь шимширнэ. Зүрхгүй хулчгар хүн юм даа гэж биеэ зэмлэж үзлээ. Гэхдээ бишгүй л олон удаа гуйж амаа бузарлана шүү дээ. Дахиад л тийм юм болох байлгүй.

Ингэж бодон баахан явснаа нэг үйлдвэрийн газраар орсон боловч бас ажилд авсангүй. Тэндээс гарахдаа тэнгэр минь хаяжээ _ ямар ч нэмэр алга гэж бодлоо.

Нэг мэдсэн, Диаборн гудамж хүртэл явчихсан байв. Тэнд “Зах” гэгч алдартай их дэлгүүр байдаг бөгөөд үзмэрийн цонх нь элдэв дээдийн бараа пиг лүүрэн, худалдан авагч хэзээд олонтой, авсан эд барааг нь хүргэж өгөх хөлсний тэрэг өдий төдийгөөр гадна нь зогсоно. Энэ бүхнийг харсан Керри биеэ зовоодог олон бодлоос ангижирлаа. Чухам эндээс хэрэгтэй юмаа худалдаж авъя гэж өчигдөр бодож байсан бол одоо ямар ч болтугай нүд хужирлан авах цамцаа харъя гэж бодлоо.

Энэ ертөнцөд хүссэн юмаа авах юмтай байлаа ч гэсэн ичиж зовоод ч юмуу, аль эсхүл шийдэж ядсаар сэтгэл санааны хувьд холбирхой байдалд заримдаа орох шиг тийм зугаатай байдал ер байдаггүй ажээ. Керри тэр дэлгүүрт ороод сайхан юмаар нүд хужирлан явахдаа чухам ийм байдалтай байв. Энэ дэлгүүр орж ажил сурагласан тэр өдрөөс хойш түүнд ихээхэн гүн сэтгэгдэл төрсөн ажээ. Тэр үед дэргэдүүр нь бушуухан явж өнгөрч байсан лангуу бүрийнхээ дэргэд Керри одоо саатан зогсож ажиглаж явна. Бүсгүй хүн болохоор сайхан харагдсан бүхнээ авахсан гэж халуун сэтгэл нь оргилохдоо: Энэ яасан дог зохих бол, тийм юм өмсчихөөд явбал мөн гоё оо! Гэж бодогдоно. Бэлхэнцэг тавилсан лангууын өмнө очоод, торго сүлжмэлийн ганган өнгөнд сэтгэл нь уярах шиг болов. Тэрнээс нэгийг нь авъя гэхэд дурных байлаа. Инжааын эдэлийн хэсэгт орж ээмэг, бугуйвч, хатгуур зүү, алт мөнгөн оосор ажиглан удаан зогслоо. Энд буй бүх юмнас авахын тулд хар нүдээ ухаад өгсөн ч бэлэн. Тэр хээнцэр ганган юмыг эдэлсэн байхад увдисын хүчийг эзэмшинэ гэж Керри бодном.

Гэхдээ ч гадуур дулаан цамцтай болох шиг чухал юм байсангүй. Тэгээд ч ормогцоо энэ намар шилдэг маяг болж байсан үзмэн хүрэн өнгийн, том том тана товчтой цамцыг л авъя, энэнээс илүү сайхан цамц хаанаас ч олохгүй гэж Керри бодоод шилэн хайрцаг, өлгүүр тавиур дээр тавьсан цамцнуудыг ажиглаж ажиглаж хамгийн сайхныг нь оллоо гэж дотроо ихэд баярлаж одоохон авъя гэж овоо шиддсэн хэр нь дахиад л эргэлзэн яая даа гэсээр байтал нь үд болох ч ойртож Дрүүтэй уулзах цаг нь ч болж, яршиг цаашаа мөнгий нь буцаагаад өгчихье гэж бодов.

Дрүү байшингийн буланд хүлээн зогсож байв.

- Сайн байна уу? Цамц чинь хаа байна, аваагүй юм уу? гэснээ хөл рүү нь харж – Гутал ч аваагүй гэж үү? Гэв.

Керри өөрийнхөө шийдийг нэлээд уичртай үгээр хэлэх гэж бодсон боловч самгардаад түүн бодож байсан үг нь ч орж ирсэнгүй, тэгээд.

- Би таны мөнгийг буцааж өгөхөөр ирлээ гэхэд Дрүү:

- Үгүй ер нь, яалаа гэнээ? За хоёул явъя. Патрижийн дэлгүүрээр орё гэв.

Керри цуг явлаа. Түүнтэй хамт явахлаах айх зовох юмгүй болж аливаа тээнэгэлзэх, болно болохгүй гэж эргэлзэх бодол нь ул мөргүй арилав. Одоо тун чухал мэт бодож байсан түрүүчийнхээ бодлын талаар олигтой үг хэлж чадахааргүй, юу гэж тайлбарлах ухаанаа олохооргүй болжээ.

- Үдийнхээ хоолыг идсэн үү - Лав идээгүй яваа даа. Энд, орё, хоёул гээд Дрүү Стейт-стратийн ойролцоох Монро дахь гоёмсог ресторанд дагуулан орж нэг буланд нь тухлан суугад хоол захив.

- Танаас мөнгө авах хэрэггүй байж. Шинэ хувцас авлаа гэхэд тэдний дэргэд яаж өмсөх вэ? тэд намайг хаанаас юун хувцастай болов гэнэ.

- Тэгээд яах гэж? Хувцасгүй явах гэж үү? Гэж Дрүэ асуугаад инээмсэглэхэд Керри,

- Нутагтаа л буцдаг байх даа гэж гунигтайхан хэлэв.

- Тэгж ярих хэрэггүй, тэгж болохынч хэрэггүй. Би бодлоо хэлэх үү? Тэднийд шинэ хувцас хунартай очихоосоо зовж байна гэл үү? Тэгвэл хөлсний нэг өрөө авч ганц долоо хоног ч гэсэн суувал яасан юм? гэхэд Керри толгой сэгсэрч аливаа бүсгүй хүний нэрэлхүү зангаар тунирхан гуйлгаж түүлгэхийг бодов бололтой. Аливаа эргэлзлийг нь үгүй болгож замаа засаж чадах сэх сүрхий зорилт Дрүэд тулгарах нь тэр.

- Гэртээ яагаад буцах гэж байгаа билээ?

- Энд ажил олдохгүй юм байна шүү дээ.

- Хүргэн ахынх чинь байлгаад байх янзгүй юү? Гэж тааварлан асуув.

- Чадал чинээ нь хүрэхгүй л дээ.

- Би бодож байгаагаа хэлье. Надаас бүү сал. Би өөрийг чинь даая.

Керри энэ үгийг нь сөргөсөнгүй. Иймрэхүү байхад нь ийм үг хэлнэ гэдэг онгорхой хаалгаар ариун салхи сэвхийн орж амьсгалыг тэтгэх лүгээ адил авай. Аятайхан, цэвэр, гангшан сайхан хувцасласан Дрүэ өөрийг нь аврах лэгсэг хүн шиг санагдав. Дуу хоолой нь ч аргагүй л анд нөхрийн дуу хоолой.

- Колумб хотод чоод юу хийх вээ? Тэнд эндхийнхтэй адилгүй, юу ч үгүй газар шүү дээ. Чикагод юу л бол байна. Энд нэг хөөрхөн өрөө авч суугаад хувцас хунартай болсон хойно нэг юм бодож болно шүү дээ гэж Дрүэ, Керрийн орхиж ирсэн газрын уйтгартай байдлыг өөрт нь сануулж хэлэв.

Керри, цонхоор гудамжны хөл хөдөлгөөнийг ажиглав. Чадалтай хүнд үнэхээр гайхаж бахадмаар сайхан хот юм. Хоёр сайхан хээр морь хөллөсөн сүүх тэргэнд тухтайхан суусан залуухан авгай намбалзан өнгөрөх харагдлаа.

- Буцаж харилаа гээд тэнд олигтой юу байгаа юм? гэж Дрүэ цаанаа ямар нэг муу санаа өвөрлөсөн шинжгүй асуув. Тэндээ очлоо ч гэсэн Керри амьжиргаагүй гэж Дрүэ бодсон хэрэг.

Керри гадагш харан яадаг юм билээ хэмээн бодлогошров. Хүргэн ах эгч хоёр нь энэ долоо хоногтоо ч буцах нь дээр гэж байдаг.

Дрүэ, Керрийн авах гэж буй хувцасны талаар үг сэджэ:

- Гоё цамц аваад өмсчихгүй яав аа? Авах хэрэгтэй. Би өөрт чинь мөнгө зээлдүүлж байгаа шүү дээ. Ердөө ч зовох хэрэггүй. Аятайхан өрөө хөлслөөд ч сууж болно. Би танд муу юм хийхгүй гэв.

Керри уг асуудал хаашаа эргэж буйг ойлгож байсан боловч тэр бодлоо илэрхийлж эс чадна.

Даанч арчаагүй болсноо ухаарч:

- Ажилд л орох юмсан гэлээ.

- Эндээ байх юм бол нэг юм олдож болох байлгүй. Харин явчих юм бол яаж болох вэ? Танай садангийнхан чинь энд байлгах дургүй байгаа биз дээ. Тэгээд л би өөрт чинь нэг өрөө олж өгье гэж байгаа хэрэг шүү дээ. Би яах ч үгүй, надаас бүү ай. Нэг байртай болсон хойно , ажилтай болж болох байлгүй.

Дрүү, Керрийн хөөрхөн царайг ажиглахад үнэхээр бал бурам шиг санагдах тул ухаан санаа нь сэргэж ирлээ. Бас тэгээд цаанаа л ямар нэг хүч чадалтай мэт. Ямар ч болтугай их дэлгүүрүүдийн эгэл жирийн хүүхнүүдтэй адилгүй, маанаг биш нь харваас илт.

Үнэндээ, Керри, Дрүүгээс илүү ухаантай, илүү намбатай хүн. Чухам тийм нарийн ширийн юм бодох чадалтай учраас л тийнхүү сэтгэл нь зовж ганцаардмал санагдаж байгаа хэрэг. Хувцас нь муу ч гэсэн биенд нь догь таарсан, цэвэрхэн төрх байдал нь ч цаанаа л нэг намбатай.

- Та тэгээд намайг нэг ажилд орж чадна гэж бодож байгаа юмуу? Гэж Керри итгэл муутай асуув.

- Чадахаар барах уу даа. Би ч тусална гээд Дрүү аягы нь ойртуулж цай хийлээ.

Керри өөдөөс нь ширтэн харахад мань эр сэтгэлий нь засан санаатай талбиун инээв.

- За, аан гэж бай. Хоёул эндээс гараад Татрит дэрүүрээр оръя, хэрэгтэй юмаа ав. Тэгээд би нэг өрөө олж өгье. Тэнд юмаа тавьчихаад орой театрт очъё.

Керри толгой сэгсрэв.

- Тэгвэл суудаг айлдаа оч л доо, болно шүү дээ. Тэр өрөөнд заавал байх хэрэгцээгүй. Юмаа л тэнд орхиж байхгүй юу.

Керри хоол идэж дуусан дуусталаа энэ талаар бодол болов.

- Хоёул дэлргүүрээр орж цамц үзье гэж Дрүү хэлэв.

Тэр хоёр хамт явж дэлгүүрээр ороход гял цал гоёмсог эд юмс Керрийн дурыг булаалаа. Сайхан хоол унд идэж уусныг хэлэх үү, бас Дрүүгийн хамт явахад түшигтэйг хэлэх үү, амнаас нь гарах үг бүр нь алт шиг санагдаж эхлэв. Тэгээд “зах” гэдэг их дэлгүүрт орж хараад шүлсээ залгиж байсан гоё цамцаа авахаар боллоо. Барьж үзэхэд бүр ч гоё санагдлаа. Худалдагч нь өмсгөж үзүүлэхэд Керрид сайхан зохилоо. Тэр цамцыг өмсөхөд Керри улам царай орж, хачин дэгжин харагдахад Дрүү баярлан:

- Янзтай сайхан таарч байна даа гэж дуу алдав.

Керри толины өмнө очиж харвал санаанд нь таарч, баярлан буйгаа нууж чадахгүй байв.

- Янзтай сайхан таарч байна. Одоо үний нь төлчих гэж Дрүү хэлэв. Керри,

- Есөн доллар юм байна гэхэд Дрүү,

- Дажгүй ав ав гэлээ.

Керри түрийвчээ уудалж аравтын хоёр дэвсгэртийнхээ нэгийг гаргаж ирэв. Худалдагч хүүхэн, энэ цамцаа одоо өмсөөд гарах юм байгаа биз дээ гэж асуулаа. Хэдэн хормын дараа хариулты нь авчирч өгөв. Цамц ч Керрийнх боллоо.

Керри, Патрижийн дэлгүүрээс гараад гутлын нэг дэлгүүрээр орж хөлдөө тааруулж эхлэв. Дрү дэргэд нь зогсож хараад:

- Тэр чигээр нь өмсчих гэхэд Керри толгой сэгсрэв. Керри, хүргэн ахындаа шинэ гуталтай очиж болохгүй гэдгээ мэдэж байв.

Дрүэ, түүнд цүнх, хос бээлий авч өгөөд:

- Оймсыг бол өөрөө сонгож ав. Маргааш эндээс банзал аваарай гэв.

Керри өөрийнхөө хийж буй энэ бүх явдлыг сүүлдээ лай болох юм биш биз гэж дотуур зовох аж. Тэгээд хүний тавьсан урхинд лавтай орох тусмаа бас л тийм, тийм юм хийгээгүй хойно гайгүй биз хэмээн биеэ хуурсаар байлаа. Ямар ч атугай мултрах зам бий гэж бодно.

Вобеш өргөн чөлөөнд хөлсний тохилог өрөө байдгийг Дрүэ мэдэх учир Керрид тэр газрыг харуулснаа:

- Одоо та өөрийгөө миний дүү гэж байгаарай гээд байрны эзэн авгайтай хөлс хэлэлцэн өрөө тасалгааг нь үзэж шилж, голж, ийм тийм хэмээн хэзээ язааны сурамгай наймаалцах аж. “Юмы нь нэг хоёр өдрийн дараа ирүүлнэ” гэж сайхан зан нь хөдөлсөн тэр бөйрны эзэн авгайд хэлэв.

Тэр өрөөнд хоёулхнаа үлдээд байхдаа ч Дрүэ зангаа хувиргалгүй гадаа гудамжинд байсан янзаараа ярина. Керри юмаа тэнд орхилоо.

- Өнөө оройдоо нүүгэд ирвэл яасан юм бэ? гэж Дрүэ асуухад Керри:

- Үгүй, болохгүй гэв.

- Яагаад болохгүй гэж?

- Би тэднийхээс ийм байдлаар гарахгүй гэв.

Дрүэ гадаа гараад явж байхдаа ч энэ талаар бас үг цухуйлгав. Нар шингэхийн алдад салхи тогтуун намуухан дулаан үдэш болов.

Дрүэ, Керритэй ярилцсаар суудаг айлынх нь талаар нэлээд юм мэдэв бололтой, тэгээд:

- Тэднийхээс гарах л хэрэгтэй, тэд баярлана уу гэхээс гомдохгүй. Би төвхнөхөд чинь тусална гэв.

Керри түүний ярихыг сонссоор элдэвмуу юм бодогдох нь гайгүй болов. Эхлээд хотоор явж юм үзүүлээд дараа нь ажилд оруулах талаар хөөцөлдөнө гэж Дрүэ ярилаа. Ингэнэ гэж өөртөө үнэхээр итгээд, мөд ажлаар хөдөө явчихаасаа өмнө Керрийг ажилд оруулна гэж шийджээ.

- За, одоо ингэ! Тэднийдээ очоод хэрэгтэй юмаа аваад ир гэхэд Керри яая даа гэсэн янзтай нэлээд бодсоноо чингэхээр болов.

Дрүү, орой найман цаг хагаст Пеория гудамжинд хүлээж байхаар болов. Таван цаг хагаст Керри хүргэн ахындаа очиж зургаан цаг гэхэд тэднийхээс гарахаар хатуу шийдэв.

“Бостон” их дэлгүүрээр орж ажил хайлаа гэж ярихы нь санаад Минни:

- Тэгээд авсангүй юу? гэхэд Керри авсангүй гээд нүднийхээ булангаар харав.

- Энэ намартаа ч дахин ажил эрэх хэрэггүй байх гэж би бодож байна.

Керри дуугүй л байв.

Хенсон гэртээ орж ирэхэд нүүр царайд нь өнөөх л үл тааварлам байдал илэрнэ. Нүүр гараа угаагаад сонингоо уншихаар явлаа. Оройн хоол идэх үеэр Керри ялимгүй бухимдуу байв. Хийх гэж буй алхам нь тийм ч ялимгүй хэрэг биш бөгөөд эднийд ингэж ад үзэгдэж суухын хэрэг алга гэж бодох нь улам даамжирлаа.

- Мартсан, юу ч олсонгүй юу, хө гэж Хенсон асуув.

- Үгүй.

Хенсон ийм хоолны савыг гэртээ орогнуулах ч гэж дээ, буцвал таарна, тэгэх л хэрэгтэй. Нэг буцвал дахиад хавар эргэж ирэхгүй биз гэж бодсоор хоолоо идэж гарав.

Керри өөрийнхөө хийх гэж буйг бодохоос айдас нь хүрэх боловч айлд ад болохоо болино гэж бодохоос дотор нь онгойно. Эднийхээс явлаа гэхэд эднүүс баярлахаас биш гомдохгүй юм чинь. Ялангуяа Хенсон мөн ч их баярлана даа. Шилээ л харуулж байвал юу болсон ч падгүй гэж бодох хүн шүү дээ.

Керри хоолоо идчихээд гар нүүр угаах өрөөнд орж:

- “Баяртай Минни. Би гэртээ буцахгүй Чикагод нэг хэсэгтээ байж ажил хайна. Зовох хэрэггүй шүү. Би алзахгүй” гэсэн үгтэй жижигхэн зурвас бичив.

Хенсон урд талынхаа өрөөнд сонингоо уншин сууна. Керри, эгчдээ аяга таваг угааж цэвэрлэхэд нь туслалцаад:

- Гадаа гарч жаахан зогсдог ч юм билүү, гэв. Керрийн хоолой зангирч арайл мэдэгдчихсэнгүй.

Минни, Хенсоны дургүй байдгийг мэдэх тул:

- гадаа зогсох онцгүй гэж Свен хэлдэг шүү дээ гэв.

- Өө, тийм үү? Үүнээс хойш зогсдогоо л больё.

Керри малгайгаа өмсөөд өнөөх зурвасаа хаанаа орхидог билээ хэмээн эгчийнхээ унтлагын өрөөний жижиг ширээний тэнд жаахан саатаж байснаа самны нь доогуур хийж орхилоо.

Гараад үүд хаамагцаа эднүүс юу гэж бодох бол хэмээн түр зогслоо. Ийнхүү ер бишийн юм хийж явааг Керри бодон бодсоор шатаар аяархан уруудлаа. Тэр байшингийнхаа гэрэлтэй орцыг нэг эргэж харснаа гудамжаар ороод салхинд гарч буй хүний байдлаар алхав. Харин булан ороомогц алхаагаа хурдасгалаа.

Керри тийнхүү тэднийхээс хурдан холдож байхад Хенсон эхнэрийнхээ дэргэд ирж:

- Керри бас л гадаа зогсох гэж гарав уу? гэхэд Минни,

- Тэгсээн. Дахин тэгэхгүй гэсэн шүү гэв.

Хенсон, шалан дээр тоглож буй жаалынхаа дэргэд очиж хуруугаараа гижигдэв.

Дрүэ хүлээж байя гэсэн байшингийнхаа буланд малилзан зогсох бөгөөд:

Сайн уу, Керри, Эсэн мэнд гарч ирэв үү? За, одоо хоёул тэргэнд суудаг хэрэг хэмээн ирэх бараанаар нь дуу алдан угтлаа.

ТЭСГИМ ӨВЛИЙН ШИНЖ. ХУВЬ ТАВИЛАНГИЙН ЭЛЧ

Хашир суугаагүй хүн гэдэг бол орчлонгийн давалгааны эргэлдэх хүчний дунд салхинд хөөгдөн буй өчүүхэн өөдөс лүгээ адил билээ. манай иргэншил хөгжлийнхөө дунд биенээ яваа учир бид гагцхүү зөнгөө дагадаг зэрлэг үедээ арай буй биш, бас ч гагцхүү оюун билгээрээ удирдлага болгодог шатандаа хараахан орж чадаагүй байгаа билээ. Барс үйлдэлдээ хариуцлага хүлээдэггүй билээ. Түүнд амьдралын хүч чадлыг байгаль заяасан учир тийм орчинд төрөөд хамгааллыг олдог ажээ. Гэтэл хүн араатны балар шугуйгаас нэн холдож чөлөөт хүсэлд ихэд ойртсоны эрхээр төрөлхийн зан нь хумигджээ. Гэвч чөлөөт хүсэл нь зөнгөө бүрэн халж, төгс удирдлага өгч чадах хүртлээ хангалттай хөгжөөгүй ажээ. Хүн мэдрэхүй хүсэлдээ сохроор захирагдахааргүй болсон хэдий боловч бас тэдгээрийгээ ямагт дийлдэг болж чадаагүй амуй. Араатан шинжээрээ амьдралын хүч лүгээ хэрэхн холбоотой болохыг хараахан гүйцэд сураагүй байна. Иймэрхүү завсрын шатанд буй учраас зөнгөөрөө байгаль лугаа шийдэж ч чадахгүй, чөлөөт хүслээрээ өөрийгөө нийцтэй байдалд ухаалгаар оруулж ч чаддаггүй ажээ. Тиймдээ л хүн гэгч амьтан өөрийнхөө хүсэл тачааллын хөдөлгөөний эрхээр явж салхинд хөөгдөн өчүүхэн өөдөс шиг заримдаа хүсэлдээ, заримдаа зөндөө хөтлөгдсөөр, нэгд нь алдвал нөгөөгөөр нь засч нэг дээр бүдэрч унавал нөгөө дээр нь түшин босож байдаг баримжаагүй хувирамхай амьтан юм. Бид ямар ч атугай аажим хувьслыг зогсолтгүй зүйл, туйлын хүслийг бөхөшгүй мөнхийн гэрэл гэж мэдсэндээ л сэтгэлээ зогоодог юм. Хүн хаанаас эгнэгт л сайн, муу хоёрын завсар хөл алдан явах билээ. Чөлөөт хүсэл, зөн хоёрын үөрчил алга болсон цагт, чөлөөт хүсэлд зөнгөө бүрмөсөн дийлэх хүчийг олгохын чухлыг бүрэн ухаарсан цагт хүний хувирамхай чанар арилна. Тэр цагт ухаарлын зүү нь үнэн мөнийн алс холын туйлыг гуйвалтгүй шулуухан заах болноо.

Керри мэтийн үй олон хүнд зөн билэг хоёр, хүсэл ухаарал хоёр бие биенийхээ дээр гарах гэж ямагт тэмцэлдэнэ. Керри, хүслэнгийхээ тэмүүлсэн зүг явлаа. Өөрөө тэмүүлэхээсээ тэмүүлэлдээ автсан нь илүү ажээ.

Минни, тарчлан гуних буюу өрөвдөж нэг их юм болоогүй ч гэсэн сэтгэл баахан доноголзож хоноод өглөө өнөөх зурвасы нь олоод:

- Энэ чинь юу вэ? Чи яасан гэж бодож байна, хэмээн хашгирахад Хенсон:

- Юу болоо вэ? гэв.

- Керри маань нэг газар очиж суухаар явсан байна шүү дээ.

Хенсон орноосоо ер бусын шаламгай огло харайн босож ирээд зурвасы нь уншлаа. Мань эр, зарим хүн морь гилэхдээ шогширдог шиг хэлээ шогширлоо.

- Хаана очсон юм бол? гэж Минни сонирхон асуухад Хенсон цэхэлзэн:

- Би яаж мэддэг юм. Яваад л өгч, хохь нь байхгүй юу гэв.

Минни самгардан толгой сэгсэрч:

- Ай, юу хийж байгаагаа мэдэхгүй л байна даа гэхэд Хенсон эвшээн суниаснаа:

- За чи тэгээд яах юм? гэлээ.

Минни, бүсгүй хүн гэсэндээ сэтгэл нь өрөвчхөн аж. Дүүгийнхээ хойноос яах бол, юу болдог бол гэж санаа нь зовж:

- Ээ, муу дүү мнинь, хөөрхий амьтан! Гэж сүүлд нь хэллээ.

Өглөөний таван цагт тэднийд ийм чухаг яриа болж байхад жаргалыг хайсан нөгөө өчүүхэн эмэгтэй шинэ байшиндаа гав ганцаар сэтгэл ихэд тээнэгэлзэн унтан авай.

Керри, тийнхүү шинэ нөхцөл байдалд орсноос элдэв дээдийн бололцоо үүд хаалгаа нээсэн мэт санагдана. Керри, жаргал цэнгэлд умбан бүхнийг мартан нойрсохыг хүсэгч тийм тавтиргүй хүн бишээ. Тэднихээс хэл зэлгүй явчсандаа сэтгэл нь зовж хөнжилдөө хөрвөхдөө нэг бодлын өөрийн толгой мэдэлтэй болсондоо баярлана. Бас ажил олдох болов уу яах бол, Дрүэ яах бол гэж бодно. Гэтэл тэр эрхэм, яахыгаа урдаас ямар ч баараггүй бодож төлөвлөсөн нь мэдээж. Зорьсноосоо буцдаг эр биш. Өөрөөр байхыг хүслээ ч гэсэн чухам яаж өөрөөр байхаа лавтай мэдэхгүй ажээ. Мах цусандаа шингэсэн хүсэлдээ хөтлөгдөн хөөцөлдөх л хүн. Керритэй жаргал эдлээсэй гэх нь өглөөнийхөө өег хоолыг зооглхоос ялгалгүй зүйл. Заримдаа хийсэн муу юмандаа өчүүхэн төдий гэмшиж өөрийгөө өөдгүй новш юм гэж боловч хоромхон төдий л тэгж бодоод өнгөрөхөөс биш даамай юм болгох нь гонж. Энэ бол үйлийн үргүй үнэн шүү.

Маргааш нь Дрүэ, Керри дээр орж ирээд их л хөхүүн, хөөрүү байв.

- Яагаад жаахан урамгүй байна? Явж хоол идье. Өнөөдөр дэлгүүрээр орж хувцас хунар авна биз гэлээ.

Керри өөдөөс нь том нүдээрээ дүрлийн харахад сэтгэлий нь зовоох элдэв бодол нь гэрэлтэх мэт.

- Ямар ч болтугай нэг л ажилд орох юмсан.

- Ажилд орж бололгүй яах вэ. Одоо тэр тухай зовох ямар хэрэг байна. Урдаар биеэ торд. Хот үз. Би муу юм хийхгүй.

- Муу юм хийхгүй нь хийхгүй л байх л даа гэж Керри итгэл муутайхан хэлэв.

- Шинэ гутал авсан биз дээ? Өмсчих. Үгүй мөн догь таарчээ. Маягтай гоё байна. Цамцаа өмс гэхэд Керри үгэнд нь орлоо.

- Ёстой нэг ургажээ гээд мань эр бэлхүүс хавиар нь барьж үзсэнээ хэд алхам ухран холпож ажиглаад:

- Одоо шин банзал л авах хэрэгтэй. За хоёул хоолонд оръё гэлээ.

Керри малгайгаа өмслөө.

- Бээлий чинь хаа байгаа вэ?

- Энд гэж Керри жижиг ширээнийхээ шургуулгаас бээлийгээ гаргаж ирлээ.

- За явъя.

Тийнхүү өглөөний бодогдож байсан муу ёрын юм бүрмөсөн замхарлаа.

Тийм юм бодогдох бүр иймэрхүү байдлаар төгсөж байв. Дрүү, Керри дээр ойр ойрхон байн байн ирнэ. Керри хааяа ганцаар тэнэх боловч ихэвчлэн Дрүү ирж гадуур хамт явна. Карсон, Пайрс хоёр дэлгүүрээр орохдоо Дрүү гоёмсог банзал, дотуур цамц, худалдан авч өгөв. Керри Дрүүгийн мөнгөөр бүсгүй хүний хэрэглэдэг аар саар юм худалдаж авсаар сүүл сүүлдээ танигдахын аргагүй, огт өөр хүүхэн болж харагдах боллоо. Толинд харваас Керрийн хэзээний боддог нь нотлогджээ. Үнэхээр царайлаг, тун хаархан харагджээ. Малгайных нь зохисныг яана. Хөөрхөн ч нүдтэй төржээ. Жижигхэн улаан уруулаа хазаж хөмхийгөө зуусхийж үзлээ, одоо л хүч чадалтай болсон мэт санагдлаа. Дрүү ч гэсэн үнэхээр бодь сэтгэлтэй болж таарлаа.

Нэг үдэш тэр хоёр, тухайн үедээ яггүй шагшигдаж байсан “Микадо” хэмээх дуурь үзэхээр явжээ. Театрт очихын өмнө Керрийн суудаг байшингаас нэлээд зайтай орших Диаборн гудамжинд байдаг Винзор хэмээх гуанзанд орохоор явав. Хүйтэн салхи үлээсэн цэхэлзүүр орой байлаа. Цонхоор харахад түрүүхэн шингэсэн нарны гэгээ тэртээ өрнө зүгт туяарах боловч дээшлэх тусам хөхөлзгөнө өнгөтэй болсоор хав харанхуй тэнгэртэй эн нийлж харагдана. Улаавтар нарийхан, урт үүл алс холын тэнгисийн усанд орших эзэнгүй арал мэт харагдана. Гэтэл гудамжны цаад талын модны шалдирсан мөчир сүүмэлзэхэд арван хоёрдугаар сарын тийм орой эцэг эхийнхээ голомтны цонхоор црагш харан суухад иймэрхүү харагддагсан хэмээх бодол Керрийн толгойд ороход тийнхүү ажиглахаа болиод жижигхэн гараа базлав.

- Юу болоо вэ? Дрүү асуухад Керри хошуу нь өмөлзөсхийн:

- Өө, бүү мэд, өөрөө ч мэдэхгүй байна гэв.

Дрүү нэгнийг тааварлан мөрөн дээр нь өрөөсөн гараа тавиад гары нь илж эелдгээр өгүүлэх нь:

- Элдвийг бүү бод. Одоо алзахгүй шүү дээ.

Керри цамцаа өмсөхөөр эргэхэд Дрүү:

- Өнөө орой энэ дулаан алчуураар хүзүүгээ ороосон дээр байх шүү гэлээ.

Тэр хоёр Вобеш өргөн чөлөөгөөр явж Адамсын гудамж хүрснээ баруун тийш эргэв. Их дэлгүүрүүдийн гэрэл аль хэдийн алтлаг шар өнгө гялалзуулан асчээ. Дааман хаалгуудын дэнлүү толгой дээр шард-ширд гэх бөгөөд албан газрын асар том том байшин барилгын цонхны гэрэл тэртээ дээр цэлийнэ. Жихүүн салхи шавхуурдан амьсгалахад уур савсана. Зургаан цагт ажлаа тарсан үй олон хүн гэр гэрийн зүг яаран тал тал тийш алхана. Нимгэн пальтотой нэг нь захаа босгож малгайгаа дарж өмссөн явна. Ажилчин хүүхнүүд хоёр нь хоёроороо, дөрөв нв дөрвөөрөө ярилцан инээж хөхрөлдөн явна. Энэ бүхэн бол цусан зүрхт, усан нүдэт хүн гэгчийн л амьдрал юм.

Гэтэл гэнэт нэг л танил нүд өөрийн нь ширтэхийг Керри мэдрэв. Хувцас муутай хэдэн хүүхнүүдийн нэг нь ажээ. Банзал нь хуучирч үжирсэн, үрчийж хорчийсон цамц нь даг дайр болж, урагдах дөхсөн ер нь уруу дорой царайтай амьтад харагдана.

Керри хүүхнийг өнөөх гутлын үйлдвэрт нэг дор ажилласан байсан хүүхнүүдийн нэг мөн болохыг харуут таньжээ. Харин цаадах нь эхлээд Керрийг таньж ядснаа сүүлдээ танив бололтой шимтэн

харав. Тэр хоёрын хоорондуур гатлахын аргагүй өргөн мөрөн урсах мэт Керрид санагджээ. Хуучин хувцас, оёдлын хуучин машин санаанд нь орж ирэхэд Керри сандран мэгдэж байж өмнөөсөө ирсэн хүнийг дайрчих дөхөв. Дрүэ огт ажиггүй явснаа сая сэтгхийн:

- Өөр юм бодож байж ингэв үү дээ гэв.

Тэр хоёр гуанзанд орж дараа нь театрт очлоо. Керри жүжгийг маш их сонирхжээ. Театрын өнгө жавхаа, үзэсгэлэн төгөлдөр байдлыг нүд салгалгүй ширтэн ажиглана. Керри бол өндөр алба, эрх дарх, алс холын улс гүрэн, ихс дээдсийн талаар дэмий их санаархан боддог хүн. Жүжиг тарахад Керри энд тэндгүй хөндөлдөх сүүх тэрэг, өдийн төдийн ганган дэгжин авгай хүүхнүүдээс нүд салгалгүй ширтэн байлаа.

- Жаахан хүлээзнэе, харья гэж Дрүэ хөлийн өрөөнд Керрийг саатуулан барихад тэнд ноёд, хатад, зэрэг дэвээрээ бөөмнөрч, цоо шинэ хувцасных нь хормой шар шүрхийн, сүлжмэг алчуур зангидсан хатагтай нар өвөр хоорондоо толгой дохин мэхэсхийн мэндэлж, амаа ангайсхийн цагаан шүд яралзуулан инээвхийлнэ.

- Жаран долоо, жаран долоо! Гэж сүүх тэрэгний дугаарыг зарлан дуудагчийн чанга хоолой тасхийв.

- Яасан сайхан юм гэж Керри хэллээ.

- Мундаг шүү гэж Дрүэ хариу хэлэв. Тэр ганган дэгжин ёсорхог цэмцгэр байдалд Дрүэ өөрөө Керрийгээс дутахгүй автана. Тэгээд гары нь халуун гараараа чангахан амтгав. Дараагийн агшинд Керрийн үд сэргэж жигдхэн цагаан шүдээ яралзуулан инээмсэглэн харав. Гадагш гарч явахдаа Дрүэ чихэнд нь:

- Та ёстой хөөрхөн байна шүү гэж шивнэв.

Тэр хоёр сүүх тэрэгний дугаарыг зарлан дуудагч гоцгын харалдаа хүчр очтол тэр хүн нэг жуузны хаалгыг онгойлгон хоёр хатагтайг суулгаж өгөв.

- Надаас бүү холд, бид хоёр ч тэрэгтэй болно гээд Дрүэ инээв.

Керрийн толгойд учир тоймгүй олон бодол эргэлдэж байсан болохоор хэлсний нь дуулсан нь юу л бол.

Тэр хоёр тийнхүү жүжиг үзээд дараа нь нэг ресторанд орж хөнгөн хоолложээ. Цаг орой болж буйг Керри анзаарах төдий болсон авч одоо түүнд гэр орныхоо тогтсон заншлаас хазайхад хэн ч саад болохгүй болжээ. Харин өөрөө ямар нэг заншилтай болж амжсан бол одоо тэрийгээ л дагах байв. Дадаж заншина гэдэг онцлог зүйл. Огт шүтдэггүй хүн ч гэсэн өөрөө итгэдэггүй хэр нь зуршил болсон залбирлаа унших гэж орноосоо босж ирдэг нь чухамхүү тогтсон заншлын хүч билээ. Заншилд автсан хүн хийж хэвшсэн юмаа хийлгүй өнгөрвөл санаа нь амар заяа үзэхийг больж, эргүй оргин тогтож ядах төлөлтэй болж, алдаагаа засахыг сэтгэл зүрх нь ямагт шаардах болно. Хэрэвзээ ер бусаар ихэд хазайсан аваас ямар ч атугай хуучин зуршилдаа эргэж ороод нэмэрт нь элдэв бусыг арга буюу хийхэд хүргэнэ. Тийм хүн, “Намайг бурхан өршөөг, би хийх ёстойгоо л хийсэн” гэж хуучин зуршил болсон үйлээ дахин үйлдсэний хойно хээв нэг хэлэх буйзаа.

Керрид хар нялхаас нь олгосон гэр орны хүмүүжил гэхээр шальтай юм байсангүй. Тийм хүмүүжил сайнтайсан бол амьдралын эгзэг осолтой юманд илүү ухаантай хандан сэтгэл нь зовохсон. Хоол идсэний дараа дотроос нь халуу оргиж, сэтгэл нь бүр ч тавирав. Орчин ахуйн элдэв сайхан үзэгдэл, Дрүэгийн зүгээс үүсэх үл үзэгдэх сайхан чанар, гуанзны амтлаг хоол, нам гүм хээнцэр орчин энэ бүхэнд Керри бие тавиран амарч, бүхнээс нүд салгалгүй ширтэж, сонстох бүхэнд чих тавин анхаарах болов. Керри тийнхүү дахиад л их хотын хуурмаг нөлөөнд илбэдүүлэн автжээ.

- За, хоёул явах уу даа гэж Дрүэ хэлэв.

Тэр хоёр хоол унд идэж уусан хойноо ч баахан сууж бие биеийг ажин нүднийх нь харц байн байн тулгарч байлаа. Дрүэгийн учиртайхан ширтэх нүдний харцнаас Керрийн биеэр ямар нэгэн хүч харван гүйх болов. Дрүэ юм ярьж тайлбарлаж байхдаа хэлж буй үгнийхээ баталгаа болгож буй мэтээр Керрийн гарыг байн байн барих ба сая я гэсэн явах уу даа гэхдээ дахиад л гарт нь хүрэв.

Тэндээс гараад хотын төв хэсгээр явахад хүний хөл татарч, хааяа ганц нэг хүн исгэчин алхлах ба шөнийн трамвай, зарим нэг ресторан гэрэлтэй харагдана. Вобеш өргөн чөлөөгөөр явахад Дрүэ ам хуурайгүй, элдэв аар саар юм ярин Керрийн гараас хөтөлж яриан дундаа далимдуулан гэнэ гэнэ чангахан атгана. Инээдтэй юм хэлээд харахад өөдөөс нь заавал харна. Тийнхүү мань хоёрын нүдний харц тулгарах нь олширлоо. Суудаг байшинд хүрч ирээд шатных нь анхны гишгүүр дээр хөл тавихад Керрийн толгой түүнийхтэй нэг түвшинд зэрэгцэн ирэв. Дрүэ гары нь атгаж аваад энхрийлэн илэнгээ нүүр рүү нь цоргих мэт ширтэхэд Керрид ямар нэг бодол төрж, сэтгэл нь догдлон харцаа буруулав.

Оройжин элдвийг бодон орондоо нойр хулжин сэрүүн хэвтэж байсан Минни яг энэ үеэр бөх гэгчийн дугжирч эхэллээ. Гарынхаа тохойг биеэрээ эвгүй дарж унтсан байж. Тэгээд дарагдсан булчин нь мэдрэлийнхээ зарим хэсэгт нөлөөлөн нойрон дунд нь бүүр түүрхэн хачин зүүд үүсгэжээ. Керритэй хоёул хуучин нүүрсний уурхайн амсар дээр очоод байх юм. дундуураа зам татуулсан өндөр гэгчийн овоолсон шороо гаргаж хаясан нүүрс харагдана. Тун гүн уурхай аж. Амсар дээр зогсоод харахад ёроол нь харанхайлах тэртээ дор одсон нойтон чулуун хана харагдана. Доошоо буудаг хуучин сагс, тасрах нь гэлтэй муу оосроос дүүжлээстэй харагдана.

- Хоёул энүүнд сууж доошилъя гэж Керриг хэлэхэд Минни:

- Үгүй, үгүй, больё хө гэнэ.

- За сууя л даа гэж Керри шалгаана.

Тэгээд байг, болоогүй гэж хорьсоор байтал нь Керри нөгөө сагсыг татаж ойртуулан өөрөө дотор нь суугаад доош явлаа.

- Керри, Керри буцаач дээ гэж Минни хашгиравч нэмэргүй Керри холдсоор бараа нь тасрав.

Минни гараа хөдөлгөлөө.

Өнөөх хуучин байдал нь өөрчлөгдөж урд хожид иүзээгүй нэл устай тийм газар болчихож. Банз юмуу, газар шороо ч юмуу ямар ч болтугай нэг юман дээр усны голд байх шиг, тэртээ үзүүрт нь Керри байгаа харагдана. Хоёул ийш тийш харж байтал өнөөх нь живж эхэллээ гэнэ, ус авах

чимээ Миннид тод дуулджээ.

- Керри, Керри наашаа яв гэж хашгиравч улам цааш холдсоор байна. Цаашаад л ухраад байх шиг, дуудаад дуу нь ч хүрэгүй болох шиг.

- Керри, Керри гэж дхаин бахирахад өрийнх нь дуу хоолой тэртээ хол дуулдах шиг болж үерийн ус энд тэндгүй хүрхрэн урсах аж. Нэг юмаа ор сураггүй алдчих шиг болон тарчилсаар гарч ирэвч насандаа хэзээ ч зовоогүйгээрээ гуньхарч эхэллээ гэнэ. Миннийн ядарсан тархинд зүүд нь янз янзнаар солигдрн хачин сонин, хар даран, Керрийг өндөр халил дээр нэг юмнаас барин зогсож байснаа гэнэт барьцаа алдан уналаа гээд хашгираад сэрэхэд:

- Минни! яав? Сэр, сэр гэж Хенсон сандран мөрнөөс нь угзчиж байв.

- Юу? яасан бэ? гэж Минни нойрмог дуугаар хэллээ.

- Сэр, сэр, нөгөө талаараа хэвт. Чи зүүдэндээ яриад байна шүү дээ.

Түүнээс хойш долоо хоног орчим хугацаа өнгөрөхөд Дрүү маш гангалчихаад “Фицжеральд, Мойн ресторанд орж ирэхэд:

- Санй байна уу? Чарли? Гэж Херствүд албан тасалгааныхаа үүднээс угтан мэндлэв.

Дрүү шууд явсаар шөнийн зоогийн газрын эрхлэгчийн ширээний дэргэд очлоо.

- Дахин хэзээ явах гэж байна даа?

- Удахгүй ээ.

- Яагаад манайхаар үзэгдэхээ болио вэ?

- Харин тиймээ, ажил гараад болсонгүй.

Тэр хоёр аар саар ердийн юм ярьсаар нэлээд хэдэн минут өнгөрөв.

Дрүү гэнэт нэг юм толгойд нь харван орж ирэх шиг:

- Өвгөөн, чи нэг оройг надад гаргахгүй юу? гэхэд Херствүд баахан гайхаж:

- Хаачих юм гэлээ. Дрүү инээмсэглэж:

- Манайд л очихгүй юу гэлээ.

Херствүдийн нүд учиртайхан гялалзаж уруулд нь үл мэдэг жуумалзах шинж илэрлээ. Тэгснээ Дрүүгийн нүүрийг гярхай ажиглаж догь эрийн байдлаар:

- Баярлалаа, дуотай очно гэлээ.

- Сайхан хөзөрдөнө шүү

- Би нэг шил шампан парс аваад очвол яах вэ гэж Херствүдийн асуухад Дрүү:

- Бололгүй яах вэ. Би таныг нэг хүнтэй танилцуулна гэлээ.

БОЛЗЛЫН ЕРТӨНЦ, АТААРХЛЫН НОГООН НҮД

Херствүдийнх хотын хойд хэсэгт Линкольны цэцэрлэгт хүрээлэнгийн ойролцоо, тэр үед энд тэндгүй үзэгдэх болсон гурван давхар тоосгон байшинд байлаа. Доод давхар нь гудамжтай бараг эн чацуу намхан, хоёрдугаар давхар нь цэлгэр том цонхтой, байшингийнхаа урд талд өргөөшөө хорин тав, уртаашаа арван тохой ногоон зүлэгтэй.

Ар талдаа жүчээтэй. Түүнд Херствүдийн морь тэрэг байна.

Арван өрөө бүхий байрандаа эхнэр Жүли, хүү Жорж, охин Жессикийн хамт сууна. Тэднээс гадна Херствүд авгайн санаанд тохирох хүн төдийн л үгүй учир байсгээд солигдож байдаг нэг шивэгчин хүүхэн тэднийд ажиллана.

- Жорж, өгчигдөр нөгөө Мэрийн чинь шлийг харж амарлаав шүү гэсэн үгээр хоол ундны цагт болдог яриа эхлэх нь цөөнгүй ажээ.

Тийм сэдвийг байнга сонсож бүр залхсан Херствүд хариуд нь голцуу:

- За яахав яахав гэнэ.

Үр хүүхдээ хар нялхаас нь өсгөж өндийлгөхдөө эрэлхэг зоригтой, шулуун шударга зантай болгон хүмүүжүүлэхэд хамаг хайр халамжаа зориулсан тийм эцэг эхийн голомтноос илүү сайн юм энэ хорвоод үгүй бизээ. Тийм ээлтэй сайхан нөлөөнд байж хэзээ ч үзээгүй хүмүүс, сайхан хөгжмийн гайхам эгшигт уяран нүднээ нулимс хуран ирэх учрыг яаж ойлгох вэ. Тийм хүмүүс, хүн зоны сэтгэл зүрхийг холбон донсолгодог удвист чавхдасыг хэзээд үл ойлгоно.

Херствүдийнх тийм уур амьсгалтай айл хараахан бишээ. Харилн бие биеийг хүлцэн хүндэтгэхгүй бол ямар олигтой айл байх вэ. Гэрийн тавилга хэрэгсэл нь эдний хүн болгоны санаанд тохирсон, тун өө хэлэх юмгүй догь. Цэвээр ноосоор хийсэн зөөлөн хивс, гоёмсог сандал, буйдан том гэгчийн төгөлдөр баян хуур, нэр үл мэдэх цоолборчны црласан цолмон бурхны дүр, хаанаас ч юм бүү мэд цуглуулсан өдий төдий том жижиг баримал мэт бишгүй их юмтай айл. Иймэрхүү аар саар юмыг бол гэрийн тавилга хэрэгслийн том пүүсүүд юмаа худалдахдаа тохилог айл ийм юмтай байх ёстой гээд дагалдуулан зардаг байж.

Эдний гал тогооны өрөөн дэх эргэнэгт хээр хуартай гял цал болсон болор галуун хүзүүт, бусад хэрэгсэл сэлтийг хэлэх өөгүй янзы нь олж ярайтал өрсөн байна. Энэ талар Херствүд хэнээс ч дутахгүй мэдлэгтэй хүн. Олон жилийн турш хийсэн албан ажил нь чухам энэ талын холбогдотой байсан болохоор арга байж уу. Тэгээд бас “нэг шинэ Мэри” тэдний үүдийг татав уу, үгүй юу түүнд гал тогооны хэрэгсэл гэгч юу болох, тэдгээрийг яах ийх тухай Херствүд тайлбарлахдаа онгод нь орох шиг болдог амуй. Херствүд хоосон үг дэлгэдэг чалчаа хүн биш, харин ч гэр орныхоо эд аж ахуйн ажлын талаар ихээхэн тэвчээртэй ханддаг, үнэхээр эрхэм хүний байдалтай байж чадна. Хэрүүл гуйхгүй, илүү дутуу юм ярихгүй, нэлээд ёсорхуу маягийн хүн. Засаж залруулж чадахгүй юм гарвал тэгсгээд л орхичихно. Боломжгүй юмыг болгох гэж оролдохгүй, харин баахан дөлөмтгий.

Нас залуу, ажилдаа амжилт гаргах гэж махран зүтгэдэг байсан цагтаа Жессика охиноо их эрхлүүлдэг байж. Гэтлэ өдгөө арван долоо хүрсэн тэр охин нь нэлээд гэжүүд, цанхаалаг зантай учир эцэг эхийн хайрыг төдийл элсэг хүртэх нь үгүй. Дунд сургуульд суралцах бөгөөд жинхэнэ

язгууртны амьдралын дайтай даналзана. Гагган дэгжин явах дуртай, хувцсанд санаа нь цадна гэж үгүй, хайр сэтгэл, хувийн гэсэ орон байрын тухай бодол нь толгойд нь эргэлдэх болжээ. Сургууль дээрээ эцэг нь том үйлдвэр пүүсийн эзэд юм уу эсвэл хам эзэн, үнэхээр баян айлын охидтой үерхэнэ. Тэд нь жинхэнэ хөлтэй баячуулын үх хүүхэд болохоор яриа хөөрөө нь дандаа ихэс дээдсийн хир хэмжээнд явагдана. Жессика, тэднийг л сургууль дээрээ хүн гэж үзнэ.

Херствүдийн хүү хорь хүрч яваа бөгөөд үл хөдлөх хөрөнгө борлуулах том пүүсэнд цалин сайтай ажил хийнэ. Аавынхаа буянгаар амьдрах учир гэр орны зардла гэж орох юмгүй, тэгээд цалингаа хурааж, хожим газар худалдан авахыг зорино. Авьяаслаг чадвартай, их ч дээгүүр зантай, бас ужид цэнгэлд дуртай, боловч тэр нь хараахан газар авч амжаагүй байж. Дуртай цагтаа гэрээсээ гарч, дуртай цагтаа ирнэ, түүнд хувьдаа бодсон алсын бодлого, зорилго, хүсэл буй. Эхтэйгээ хааяа хэдэн үг сольж, эцэгтээ аар саар зарим явдлаа ярих боловч нарийн ширийн юмаа ярихгүй, тэгс ингэс гээд өнгөрүүлнэ. Алсынхаа бодлыг хэнд ч хэлэхгүй. Ялангуяа гэрийнхний дотроос хэн нь ч тэр талаар эс шохоорхох учир уухайн тас гэж ханцуйдаа залбирна.

Херствүдийн эхнэр бол лоны дотор нэр алдар олохыг ямагт хичээж, өөрөөсөө дээгүүр явах хүн бүрт атаархана. Түүний мэдлэгийн хүрээ нь өөрөө эгнээнд нь багтаж гишүүн болж чадаагүй боловч багтахыг хүсдэг тэр “өчүүхэн бүлэг” баячуулын хэмжээнээс үл хэтэрнэ. Хичнээн ч санаархаад тэдний зиндаанд хүрэх сачийгүй гэдгээ бас ч гэж ухаардаг болжээ. Гэвч Жессика охиндоо найдан түүний хүчээр тийн дэвжиж магадгүй гэж горьдоно. Хүү нь ч гэсэн цагаа болоод ирэхээр эхийгээ баярлуулахыг хэн байг гэхэв гэж бодно. Нөхөр нь аюулын их олз омогтой, нэр сүрээр овоо яваа боловч чамлаж цаашид өмчийнхөө газрыг улам дориун болгохын хүслэн болно. Хесртвүдийн өмч хөрөнгө шалихгүй боловч олз омог сайтай, бас өөрөө Фицжеральд-Мойнд сууриа бэхжүүлсэн байлаа. Рестораны эзэн хоёр ноён, хоёул Херствүдэд сайн, түүнийг дотночилно.

Тиймэрхүү айлын дотрохи уур амьсгал ямаршүү янзтай байж таарахыг тааварлахад хялбар. Нэг ижил боловч мянга түмэн аар саархан яриа байн байн давтагдах нь гарцаагүй.

Баасан гаригийн нэг үдэш хоол идэж суух зуур хүү нь:

- Маргааш би Фокс Лейн явна гэхэд эх нь:

- Тэнд юу болох юм? гэж асуулаа.

- Эди Фарейнх шинэ онгоц авсан, намайг ирээрэй, сууж үзээрэй гэсэн юм.

- Ямар үнэтэй авсан юм бол? гэж эх нь шалгаав.

- Хоёр мянга гаруй доллараар. Их гоё эд гэсэн.

- Фарей өвгөн овоо олзтой байгаа юм байж дээ гэж Херствүд үг шургууллаа.

- Тийм байлгүй. Тэднийх одоо Австрали руу тамхи тээдэг болсон гэж Жэк ярьж байна лээ. Түүрүүчийн долоо хоногт Кемптаун руу баахныг явуулсан гэнэ лээ.

- Үгүй ер, сүрхий еэ! Дөрвөхөн жилийн өмнө тэднийх Медисон гудамжинд зоорь худалдаж авч байсан айл шүү дээ гэж Херствүд авгай хэлэв.

- Ирэх хавар тэднийх Роби гудамжинд зургаан давхар байшин бариулна гэж Жэк ярьж байна лээ.

- Үгүй ер. Гэж Жессика дуу ладва.

Ийм юм ярилцаж байсан тэр орой Херствүд гэрээс эртхэн гарах бодолтой байв.

- Би өнөөдөр хотын төв орох хэрэгтэй гээд Херствүд бослоо.

Херствүд авгай суугаагаараа:

- Даваа гаригт Мак Викерийн театрт очицгооно биз? гэхэд:

- Тэгэлгүйдээ гэж Херствүд тоомжир муутайхан дуугарав.

Херствүд хувцсаа сольж өмсөхөөр өгсөхөд цаадуул нь хоол ундаа идэж уусаар үлдэв.

Төдхөн үүд хаагдах чимээ сонсдов.

- Аав гараад явчих шив дээ гэж Жессика хэлэв.

Сургууль дээрээ болсон явдлын талаар заримдаа их онцгой зүйл мэт ярина.

- Манайхан Лицейд жүжиг тавина, би оролцоно гэхэд эх нь:

- Нээрэн үү? Гэв

- Нээрэн, тэгэхлээр надад шинэ бошинз хэрэгтэй. Маай сургуулийн ганган охид баргаараа тэр жүжигт оролцох гэж байгаа юм. Нөгөө Палмер, чинь Порция болж тоглоно.

- Тэр үү, нэрээнэ үү? Гэж Херствүд авгай асуулаа.

- Тэднийх Марта Гризвольдыг дахиад л урьсан байх юм. Өөрөө тоглож чадна гэж бодоод байгаа хүн л дээ.

- Тэднийх чинь хоосон айл, юу ч үгүй гуйранч гээ биз дээ? гэж Херствүд авгай тавлах байдалтай асуухад:

- Тийм ээ, юу ч үгүй, модоо барьсан айл гэж Жессика хэлэв.

Жессика, эрэгтэй оюутнуудын дотроос өөрийг нь царайлаг гэж үздэг нэлээд олон залууг шилж сонгож үерхэнэ.

- Херберт Крейн надтай үерхэх санаатай байдаг юм, та юу гэж бодож байна? гэж нэг орой эхээсээ асуув.

- Юун залуу юм?

- Зүгээр л нэг оюутан, гуяа ганзагалсан амьтан гэж Жессика шөмбөгөр уруулаа цорвойж хэлэв.

Харин савангийн үйлдвэрийн эзний хүү Блайфорд нэг удаа Жессикаг хүргэж ирэхэд огт өөрөөр

угтжээ. Херствүд авгай тэр хоёрыг ирж байхыг гуравдугаар давхарт эргэдэг сандал дээрээ сонин уншиж байхдаа олж хараад:

- Чи хэнтэй ирээ вэ? гэж Жессикаг шатаар өгсөн гарч ирэнгүүт нь асуухад Жессика:

- Блайфорд ноёны хүүтэй, ээжээ гэв.

- Өө, тийм үү?

- Тийм ээ. Намайг хамт цэцэрлэгээр явъя гэнэ гэж шатаар түргэн өгссөндөө улайсан Жессика хэлэв.

- За яах вэ, тэг тэг. Удах хэрэггүй биз дээ.

Тэр хоёрыг гараад явахад Херствүд авгай цонхоороо сонирхон ажиглав. Харахаас сэтгэл өөгшим, үнэхээр сайхан санагдах аж.

Херствүд , гэр бүлийнхнийхээ иймэрхүү уур амьсгалтай байдгийг гүнзгийхэн дүгнэн бодож үзэлгүй олон жилийг өнгөрүүлжээ.

Херствүд бол ахих гэж ухаан зулаггүй тэмүүлдэг хүн биш, харин ахих бололцоо бүрэн бүрдэх юмуу, ахихгүй байж хэрхэвч болохгүй болсон үед л хөдөлнө үү гэхээс наана нь даврахгүй. Ерөнхийд нь түүнийг өгөөтэй аваатай хүн гэж болно. Яагаад гэвэл заримдаа гэрийнхэн нь чиг чигээ бодоцгоон тоомжир муутай байвал гэр төрдөө нэмэртэй хэрэг гэж мээсийнэ. Шөнийн зоогийн газрынхаа эрхлэгчийн ажлыг л жинхэнэ амьдрал гэж бодно. Ихэнх цагаа тэнд л өнгөрөөнө. Орой гэртээ ирэхэд гал голомт нь тун сайхан санагдана. Хоол унд нь жирийн шивэгчийн гараар хийсэн гэхэд голцуу амтлаг байна. Хэзээд золбоолог хийморьтой харагдах хүү, охин хоёрынхоо яриаг заримдаа дуртай сонсоно. Нэрэлхүү зантай, сагсуу авгай нь гадаа гэртгүй дандаа гангалах өвчтэй боловч Херствүд түүнд нэг их дургүйлгэхгүй бас хэрэгсэхгүй навсайж байснаас ингэж байсан нь дээр юм даа гэж бодно. Бие биендээ хэзээ ч хайртай байж үзээгүй болохоор хайргүй болох, хөрөх гэхийн зовлонгүй. Ямар ч юмных нь тухай эхнэрийнх нь амнаас цэцэн цэлмэг ганц ч үг гарахгүй. Хоорондоо нэг их ярилцдаггүй болохоор маргаж хэрэлдэнэ гэж байхгүй. Өөөр өөрийн бодлыг тогтсон хэдэн цэнүүр үгээр илэрхийлнэ. Херствүд заримдаа залуухан, сэтгэлэн цовоо эмэгтэйтэй уулзаж учрахдаа эхнэрээ баахан голох боловч нийтийн дотор нэр нүүрээ бодон биеэ барьж зуурдын сэтгэлдээ гүнзгий автахгүй байна. Гэр орондоо хэрүүл шуугиан гаргавал эзэд маань муу юм санаж магадгүй гэж бодно. Тэд хэрүүл маргааныг хэрхэвч тэвчихгүй улс. Тийм албанд бу йхүн өөгүй сайхан зан ааштай, нэр сайтай, гэр орондоо ч үлгэр жишээч байх шаардлагатай. Тийм учраас Херствүд алхах гишгэх бүрдээ хаширлаж олон нийтийн газраар буюу үдэш орой, амралтын үеэр явахдаа эхнэртэйгээ буюу заримдаа хүүхдээ заавал дагуулж очно.

Херствүд орон нутгийнхаа рашаан сувиллын газар юм уу, Висконсин муж улсаас холгүй ямар эг газраар явж хэд хоног амрахдаа их л ёсорхуу, хатуу журам баримтлан очиж болох газраар нь явж, хийж болох зүйлийг нь хийж өнгөрөөнө. Тийм шаардлагатайг Херствүд андахгүй.

Түүний таньж мэдэх, дунд давхаргынханд багтдаг бэл мөнгө ихтэй хүмүүсийн зарим нь дэмий юманд орооцолдоход Херствүд харамсан толгой сэгсэрнэ. Тиймэрхүү юм ярихыг ч цээрлэнэ. Харин дотно нөхөд нь ярилцаад унавал тийм явдлыг эрс буруушааж:

- За яахав эр хүнд тийм юм байх л даа, гэхдээ болгоожилдоггүй нь л муу хэрэг, хашраас гэм суухгүй гэдэг биз дээ гэнэ.

Тиймэрхүү дэмий юм хийж байж баригдсан хүнийг нэг нүдээр үзэхийг болино. Ийм ч учраас Херствүд авгайдаа дотроо дургүй байлаа ч гэсэн хуучин янзаараа хааяа дагуулж явна, гэхдээ авгайтайгаа хамт байсан ч байгаагүй ч зарим найз нөхөдтэйгээ уулзаж учран, бага сага наргихаа хэнээр ч цагдуулахгүй. Авгай нь залуугийнхаа царайлаг толиотой хэвээр агаад эрчүүд түүнийг хулгай нүдээр шохоорхох тул Херствүд авгайгаа хааяа нэлээд сонирхон харах ажээ. Авгай нь наалинхай хөөрүү, магтаалд дуртай болохор үүнээсээ болоод ямар ч дэмий юманд орж магадгүй хүн гэж Херствүд сайн ойлгодог байв. Херствүд эмэгтэй хүнд нэг их итгэдэггүй тийм бодлын хүн. Авгай нь хэзээ ч Херствүд мэтийн бодолтой эрд бишрэм итгэл төрүүлэх тийм чанаргүй хүн амуй. Хайр сэтгэлий нь ид халуун дотно байх үед нэлээд итгэж болох байсан бол тийм цаг нэгэнт өнгөрсөн үед яаж ч мэдэх хүн гэж бодох болсон юм.

Сүүлийн нэг хоёр жилд гэрийнхэн нь мөнгөөр хэтэрхий их туйлдаг болсон санагдана. Жессика гоёж гангалахын төлөө хүн болсон шиг хөөцөлдөнө. Авгай нь ч охиныхоо дор орохгүйн тулд элдэв янзын хувцас хунар их авна. Херствүд урьд нь дуугүй л байдаг байсан бол сүүлдээ үг хэлэх болжээ.

- Жессикад энэ сарын мөнгөн дээрээс шинэ дээл авч өгөлгүй горьгүй гэж авгай нь нэг өглөө хэлэхэд гоё хантаазныхаа нэгийг өмсөн толины өмнө зогсож байсан Херствүд:

- Саяхан нэгийг авлаа гээгүй юу? гэв.

Авгай нь гоморхосхийн:

- Үдшийн нагц бошинз авсан шүү дээ гэхэд Херствүд:

- Жессика сүүлийн үед хувцсанд дэндүү их мөнгө зараад байх шиг байна гэв.

- Гэрийн мухар сахиад суултай нь биш, орох газар газар их болж шүү дэ гэж авгай хэлээд нөхрийнхөө амнаас тиймэрхүү үг анх удаа сонсож буйгаа ухаарав.

Херствүд хэсүүчлэхийг нэг их эрхэмлэдэггүй хүн, хааяа ийш тийш явубал авгайгаа л авч явна. Нэг удаа хотын зөвлөлийнхнөөс Филадельфи хот руу арав хоногийн зугаалга зохиох болж Херствүдийг хамт явъя гэжээ.

- Тэнд биднийг таних хүн байхгүй. Сайхан шиг жаргана даа. Жорж чи бидэнтэй хамт яв л даа гэж харах царайнаасаа маш маанаг бөгөөд ужид цэнгэлийн өвчинтэй нь илт тийм нэгэн оён зүүн нүдээ ирмэн хэлэхэд толгой дээрх торгон бортогон малгай нь донхолзоно.

Маргааш нь Херствүд авгайдаа:

- Жулиа, би хэд хоног гадагш явах боллоо гэхэд авгай нь сөрвөсхийн:

- Хаашаа? Гэхэд Херствүд:

- Филадельфид, ажлаар явна гэхэд авгай нь өөр юу хэлэх нь вэ гэсэн шиг нөхрөө сүрхий ширтлээ.

- Энэ удаа чамайг орхих л болж байна.

- Яах вэ яахав гэж авгай аман дээрээ хэлэх авч ихээхэн сэжигтэй байгаа нь ил байлаа. Явахаас нь өмнө баахан юм асууж шалгахад Херствүд, энэ ер нь хэн болоод ингэж их цагдах гээд байдаг юм гэж зэврүүрхэн болжээ.

Энэ удаагийн зугаалга Херствүдэд туйлын тааламжтай болж, хугацаа дуусаж буцах өдөр ирэхэд хамарсаж байлаа. Угаас бэлэн зэлэн худал хэлж сураагүй хүн болохоор авгайнхаа элдвийн юм шалгаахад тэр бүгдэд нь нарийн хариу өгхийг эрс татгалзан ерөнхий үгээр дүйвээтүүлэн өнгөөрөхийг хичээж байв. Гэтэл авгай тун их юм бодох болсон төдийгүй түүнээс хойш гадуур явах нь олширч, гоёх гоодох нь эрс нэмэгдэж, хариугаа авах гэсэн шиг театрт очих нь олширчээ.

Иймэрхүү байдал гэр бүлийн эв найрамдалд нэмэр болохгүй нь мэдээж. Тэр хоёрын харьцаа, ханилсан эр, эм гэсэн нэрнээс цаашгүй, ёс болгон хамт байхаас хэтэрсэнгүй. Цаг хугацаа улиран өнгөрөх тусам тэр хоёр улам улам хөндийрч хөрсөөр эрт орой нэгэн цагт ганц дүрсгээд л голомтоо эвдэх болоод байлаа.

ӨВӨЛ НЭГИЙГ САНАГДУУЛАВ. ХУВЬ ТАВИЛАН ЭЛЧЭЭ ИЛГЭЭВ

Эмэгтэй хүн, түүний үүргийн талаар хүмүүс юу гэж үздэгтэй холбогдуулан Керрийн стэгэл санааны байдлыг тайлбарлах нь зүйтэй билээ. Түүний хийсэн зүйл мэт хүний тиймэрхүү явдлыг цэгнэн үздэг дэнс байдаг юм. Нийгэмд бүхий л юмыг үнэлж байх тогтмол хэмжүүр байдаг л даа. Эр хүн бүхэн бодь сэтгэлтэй, эм хүн бүхэн ариун журамтай байх ёстой. Тэгэхлээр өөдгүй новш минь, яах гэж нүгэлд унаа вэ? гэсэн хуучин Библи судрын санааг баримтална. Спенсерийн, түүнчлэн орчин үеийн байгалийн шинжээч гүн ухаантны онолын ёсоор бол ёс суртахууныг мухар сүсгийн үүднээс үзэх учиргүй атал өдгөөгийн хүмүүс бидний ухаарал тэр талаар даанч балчир байна. Үнэндээ хувьслын хулуинд эгэл тохирохоос илүү гүнзгий, энэ талаар ертөнцөд хүчин төгөлдөр хуулинд тохирохоос илүү өргөн бөгөөд бидний одоогийн ойлголтоос даамай ажээ. Хүний сэтгэл зүрх юуны учир догдолно вэ? гэж давын өмнө асуумаар байна. Өрөвдөж гуних сэтгэл төрүүлэм зарим эгшиг дуу юуны учир даян дэлхийд мөнхөл хэсүүчилнэ вэ? Юу гэж тайлбарлавал зохих вэ? Сарнайн улаан цэцэг юуны хүчинд нартайд ч хуртайд ч дэлбээлнэ вэ? Угтаа ийм бодит зүйлсийн мөн чанарт ёс суртахууны суурь зарчим орших амуй.

Ай, мөн ч сайханюм боллоо доо! гэж санасандаа хүрсэн Дрүэ хөөрч байхад Керри муу совин татаж, “Аяа, би ер нь юугаа алдчихав даа?” гэж бодно.

Тэгээд бид ёс суртахууны үнэн мөн чанарыг олох гэж, зөв буруугийн талаар үнэн хариу олох гэж үеийн үед улиран ирсэн ээн асуудлын тухай их сүрхий ухаан зарж сонирховч будилсаар авай.

Зарим хүний, тухайлбал идэх хоолгүй өлсөж орох оронгүй салхи бороонд цохиулж явдаг хүмүүсийн бодлоор Керри зүйтэй юм хийж амьдралаа төвхнүүлэн, халуу дүүгсэн оромжтой болжээ. Дрүэ, Керрийг төвхнүүлэх гэж хотын баруун захын Огдан талбайд Юнион цэцэрлэгийн өөдөөс харсан байшинд тавига хэрэглэл бүхий гурван өрөө байр хөлслөн авчээ. Нов ногоон хивс мэт, цэцэг ногооноос нь анхилуун үнэр ханхалсан жижигхэн боловч үзэсгэлэнтэй тийм сайхан талбай өнөөгийн Чикагод хүний урманд нүд хужирлая ч гэсэн огт олдохгүй. Тэнд элдвийг бясалган суух юутай сайхан. Доторх жижигхэн нуур нь зайрмагтан, шалдарсан мод, ургамлын навчис зэрэгт бараандуу харагдах тэрхүү цэцэрлэг хамгийн тохилог өрөөнийх нь цонхоор ив ил байх нь үнэхээр үзэсгэлэнтэй. Өвлийн шавхуурдах салхинд найган гуйвалзах нүцгэн моддын ганжир гялалзах бөгөөд тэртээ алсад бусад хэд хэдэн сүмийн орой сэрвийлдэнэ.

Өрөөнүүдийнх нь тавилга хэрэглэл ч нэлээд дориун. Зочны өрөөнийх нь шалан дээр том том цэцгэн хээтэй хүрэн, шаргал, улаан өнгийн Брүүсель хивс дэвсжээ. Хоёр цонхных нь хооронд том босоо толь байна. Өрөөний нэг буланд том, пэмбэгэр, ногоон өнгийнх ямаан хилэн өнгөвтэй диван, хэдэн эргэдэг сандал, зураг, хвис, өөр аар саар зүйл байна.

Унтлагын өрөөнд Дрүэгийн бэлэглсэн хайрцаг, хананых нь шүүгээнд Керрид хэзээ ч байгаагүй тун олон янзын аятайхан хувцас байна. гурав дах өрөөг гал тогоо болгосон бололтой. Өглөөнийн хоол унд, түүнчлэн Дрүэгийн дуртай хясаа, бяслагтай хайрмал талх гэх мэт хөнгөн зууш бэлдэж байхын тулд Дрүэгийн зөвлөснөөр жижигхэн хийн зуух тавьжээ. Байранд нь халуун усны жижиг өрөө бас буй. Байр нь ерөнхийдөө их л тохилог, хийн гэрэлтүүлэг, төвийн халаалгатайгаас гадна ар талаар нь гөлтгөнө цаасан хамгаалалт хийсэн жижигхэн задгай зуухтай. Тийм зуух тэр үед анх удаа дэлгэрч, гэр оронд дулаан уур амьсгал бий болгодог аятайхан зүйл байлаа. Керри хичээж чармайсных, тэгээд ч бас угийн цэвэрч нямбай байдалд дуртайнх, доо бүр нямбай зан нь төлөвлшин, хэвшиж орон байраа өөд татаж чаджээ.

Урьд нь их гачигдаж явсан Керри маань одоо тийм гачлангаас ангижирч, өег тавтай нөхцөлд тухлан суух болсон боловч стгэл санаа ёс суртахууны хувьд олон шинэ бэрхшээл үүсэн гарч орчинтой харьцах харьцаа нь үндсээрээ эргэсэн тул өөрөө ч огт шинэ, огт өөр хүн болжээ. Керри өөрийгөө тольдож үзэхэд хэзээ хэзээнээс царайлаг болжээ. Дотор бодол санаагаа өөрийнхөө бэлдсэн үзлээр тольдож харвал баахан дор оржээ. Тийм хоёр дүрээ үзээд алинд нь итгэхийг шийдэж ядан тээнэгэлзэв.

- Чи мөн хөөрхөн өө! Гэж Дрүэ байн байн хэлэхэд Керри өөдөөс нь том нүдээ дүрлэлзүүлэн таатай харна.

- Чи өөрөө ч лав мэдэж байгаа биз гэж Дрүэг хэлэхэд:

- Өө, бүү мэд гэж Керри хариуд нь дотроо баярлан хэлэх боловч нээрэн тийм юм болов уу гэж тээнэгэлзэнэ. Гэхдээ өөрийгөө дөвийлгөн боддог зантай хүн болохоор магтаалд нь үнэнээсээ баярлана.

Гэвч өөрийг нь магтах дуртай Дрүэ түүний үнэн санаа биш байлаа. Керрийн чихэнд огт өөр дуу хоолой сонсдох шиг болж тийм дуу хоолойтой маргах, эвсэх аргалах хэрэг болж байлаа. Бодоод байхад өөрийнх нь санаа шудар ч биш, мэргэн зөвлөгч ч биш санагдана. Тэр бол хуучин хэвшил, зуршил өөрийнх нь гарч ирсэн ертөнц, хазгай ташаа төсөөлөгдөх өчүүхэн доожоогүй санаа юм. Түүнтэй зүйрлэхэд ард олны дуу хоолой бол үнэхээр Бурхны дуу хоолой мөн амуй.

- Өө, муу өөдгүй новш! Гэж тэр дуу хоолой цуурайтна.

- Яагаад? гэж Керри асууна.

- Хажуугийнхаа хүмүүсийг хар. Сайн хүмүүсийг хар. Чиний үйлдсэнийг үйлд гэвэл тэд хичнээн их зэвүүрцэх бол. Сайн охидыг хар. Чамайг тийм дор унасныг мэдвэл тэд нэг нүдээр харахгүй дээ. Чи балрахаасаа өмнө ядаж жаахан ч атугай эсэргүүцсэнгүй гэж чихэнд нь сонсдох шиг болов.

Керри, байрандаа ганцаар цонхоор цэцэрлэг ширтэн харж сууж байхад ийм үг чанга дуулдах шиг болно. Иймүг чихэнд хонх зүүсэн мэт дуулдаад байхгүй ч гэсэн юу ч хийгээгүй үед нь юмуу, амьдралынх нь сайн сайхан тал нэг их товойж мэдэгдэхгүй үед, Дрзэг эзгүй хооронд л дуулдах мэт болно. Эхлээд тун тод сонсдох шиг боловч лавтайүнэмшилтэй биш ажээ. Керри хариуд нь. Хөхөө өвлийн хүйтэн болох гэж байхад гон бие гозон толгой арга тасарч улин исгэрэх хүйтэн салхинаас айж, санаж сарьайсан хүсэл маань хөсөрдөх байсан шүү дээ гэж ямагт бэлэн хэлэх үгтэй байв. Түүний өмнөөс аргагүй шаардлагын дуу хоолой хариу хэлж байсан хэрэг.

Зуны нартай өдрүүд өнгөрүүт хот хар хүрэн нөмрөгөө хэдрэх шиг болж, тэр чигтээ ужиг удаан өвлийг туулдаг билээ. Хотын тоо тоймгүй олон барилга, гудамж, тэнгэрээ даган бүгд бараантан хөхөлзсөн саарал болно. Энд тэндгүй ёрдойх нүцгэн мод, салхинд бужигнах тоос, хог цаасны өөдөстэр зэвхий өнгөнөө нэмэр болно. Явган хүний урт нарийхан зам дээгүүр сүрд сүрдхийх салхин уйтгарыг төрүүлнэ. Үүнийг сэтгэл санааны хамаг нарийн нандиныг мэддэг дээд зэргийн ухаантан гэгддэг гагцхүү яриуу найрагч, уран зураач байтугай нохой, ер нь хүн бүхэн мэдрэх билээ. Санаагаа илэрхийлэх чадвараар дутуу ч гэсэн түүнийг хүн бүхэн яруу найрагчдын адил мэдэрнэ. Утсан дээр суух болжмор, байшингийн орцонд нуугдах муур, ачаагаа дааж ядан зүтгэх тэрэгний морь өвлийн урт ужиг, хахир цагийн хатууг мэднэ. Тэр бол амьтай, амьгүй бүхий голд

ордог зүйл. Хэрэв зугаа найрын зохиомол гал, ашиг орлого хөөцөлдсөн хөл үймээн хүний зугаа гаргах элдэв төрлийн худалдаа, янз бүрийн наймаачдын дэлгүүр пүүснийхээ гадна дотно, хүний дур сонирхол татахаар тавьсан үзмэр гудамж талбайгаар есөн жорын эрээн мяраан сонин хачин зарлал гэж байгаагүй ыбол, үй түмэн хүн гудамж талбайгаар үргэлж гүйлдэж байдаггүй бол өвлийн хахир хүйтэн улирал бидний сэтгэл зүрхэнд хичнээн сүрхий дарамт болохыг, гэрэл гэгээ, дулаан илчээ бидэнд зохих хэмжээгээр хүртээж чадахаа больдог өвлийн өдөр бидний сэтгэл санааг хичнээн их зовоохыг төвөггүй ойлгохсон. Тийм зүйлсийн эрхэнд бид аль зэрэг байдгаа тэр болгон ойлгодоггүй. Бид бол, үнэндээ, дулааны хүчэр бий болж, түүгээр дутахдаа сөнөдөг хорхой шавьж гэсэн л үг.

Зэвхий даасан тиймэрхүү жихүүн хүйтэн өдөр өнөөх далдын дуу хоолой улам улам дорой дуулдах болжээ.

Энэ мээтр сэтгэл нь үймрэвч Керри тэр болгон урвайх нь үгүй, угаас тийм ч хүн биш. Бас үнэнийг хатуу баримтлах тийм ухаантай ч хүн биш. Ямар нэг замбараагүй бодолд автан яах ч ухаанаа олохооргүй болох дээр хүрвэл дэмий бодлоор биеэ зовоохгүй.

Дрүү, энэ завсар өөрийн зиндааны этгээдүүдийн хэрээр Керрид их юм үзүүлэн зугаацуулж, ийш тийш явахдаа хүртэл хамт авч явах зэргээр учиргүй мөнгө зарж байлаа. Дрүү, хааяа хоёр гурван хоногоос хэтрэхгүй богино хугацаагаар явахдаа л үгүй юү гэхээс биш ямагт Керритэй хамт байна.

Дрүү, Керритэй тийнхүү эв аяа нэгэнт олсноос хойш төдий л удалгүй нэг өглөө:

- Керри, би өөрийн найз Херствүдийг бид хоёртой нэг орой өнгөрөөхгүй юу гэж урьсан шүү гэхэд Керри:

- Юун хүн юм? гэж сэжиглэсэн янзтай асуув.

- Өө, Фицферальд, Мойн зоогийн газрын эрхлэгч, тун аятайхан хүн.

- Тэр нь юу юм?

- Энэ хотын зоогийн тун сайхан газар. Эндээс нэг их холгүй, догь газар бий.

Дрүү, тэр хүндээ юү гэж хэлсэн юм бол, ямаршуу янзаар харьцвал зохих вэ гэсэн бодол Керрид орж ирэх тул түр балмагдах шиг болов.

Дрүү, бодлы нь тааварлаад:

- Зүгээр, зүгээр. Тэр хүн юу ч мэдээгүй байгаа. Чи одоо Дрүүгийн гэргийл байгаа биз гэж хэлэхэд Керрид нэлээд эвгүй санагджээ. Ямар ч болтугай Дрүү тийм ч соргог хүн биш юм шиг санагдав.

Керри түүний учиргүй амлаад байсны бодож:

- Бид хоёр яагаад номоор нь гэрлэж болдоггүй билээ? гэж асуув.

- Болно, болно. Хөөцөлдөж байгаа нэг ажлаа нэг тийш болгомцоо л гэрлэе.

Дрүэ, өв хөрөнгийн талаар маргаантай, хөөцөлдөх ажил их байгаа, учры нь олохоос нааш гэр бүл, хувийн ажил төрлийг бөөцийлж болохгүй байна гэж худал ярьдаг байв.

- Денверт явж ирээд, нэгдүгээр сард хоёул хуримаа хийнэ.

Керри энэ үгэнд нь нэлээд итгэж, нүглээс мултрах таатай зам нээгдэх шиг, бүх үйлс нь зөвөөр эргэж, үйлдсэн гэм нь цагаадмаар санагдав.

Керри, Дрүэд үнэн сэтгэлээсээ хайртай байсангүй. Ухаанаар илүү болохоор Дрүэгийн тамирыг ерөнхийд нь таньж эхэлжээ. Ингэж хүнийх нь мөсрийг үнэн зөв үнэлж чадаагүй бол керри бүр ч муу юманд орж болох байсан буйзаа. Ухаан жолоогүй шүтэж бишэрсэн бол хайры нь авч чадахгүй нь гэх буюу сонь буурсан үедээ юу ч үгүй хоосон хаягдчих вий хэмээн арчаагүй тарчлах байсан биз. Тэгээд Дрүэтэй амьдралаа бүрмөсөн холбож чадах эсэх талаар эхлээд бага сага зовниж байсан бол сүүлдээ Дрүэгийн тамирыг ерөнхийд нь таниад уужирч мань эр яах нь вэ хэмээн тайван хүлээх болжээ.

Херствүдтэй уулзаж танилцахад Дрүэгээс зуу дахин илүү ухаалаг хүн болохы нь мэджээ. Тэр бол наад зах нь эмэгтэй хүнтэй харьцахдаа ч гэсэн санаанд нь хамгийн таалагдах байдлаар байж чаддаг хүн юм. Нүүрэн дэр нь нэг их магтаж сүйд болохгүй, нүүрэмгий ч загнахгүй. Гайхмаар элэгсэг дотно байж чадна. Хөлтэй худалдаачин, эздийг зоогийнхоо газраар орж ирэхэд тал олж долиггоршсон хүн болохоор өөрт нь хэрэгтэй талтай хүнд бүр ч гайхамшигтай сэтгэгдэл төрүүлж чадах билээ. Царайлаг хүүхнүүдийн дотроос ялангуяа ухаалагий нь тун дээгүүр үзнэ. Херствүд бол эмэгтэй хүнд хамгийн таалалтай санагдах бүхний нь гүйцээж өгөхөд бэлэн буй буянины зүртэй, урсгал зөөлөн ааш, айвуу тайвуу, буурь суурь үзүүлж чадна.

Дрүэ сонин дээрээ соохолзоно гэгчээр анхандаа мөн Херствүдэрхүү зан гаргаж чадах боловч биеэ би гэдэг ойворгон хөөрүү хүн учраас түүнтэй адил намбатай байж чадахгүй, дэндүү хөнгөн хийсвэр, хөвсөргөн хүн ажээ. Хайр дурлалын урлагт төдий л долиггоршоогүй тийм авгай хүүхнүүдтэй бужигнана. Харин нэлээд туршлагатай буюу төрөлхийн цамаан бүсгүйчүүлийн дотор явай муутай байх аж. Керри хүүхэмсэгдүү боловч хайр дурлалын урлагт огт дүйгүй болохы нь Дрүэ мэджээ. Гэлээ ч гэсэн Дрүэ, сохор азаар л Керритэй ойртож амжсан хэрэг. Хэдэн жил өнгөрч, нэлээд долиггоршиж, амьдралдаа бага сага амжилт олсон үед бол Керри түүнд огтхон ч царай өгөөгүй, хавьтуулахгүй байх байсан билээ.

Херствүд, тэр хоёр дээр болзсон оройгоо ирээд байхдаа:

- Дрүэ, та гэргийдээ төгөлдөр хуур авч өгмөөр юм. Хөгжимдөж суувал зүгээр юм биш үү гэж хэлээд Керри рүү инээмсэглэн харав.

Дрүэн толгойд тийм бодол орж байсангүй. Тийн атал:

- Нээрэн зүйтэй юм байна шүү дээ гэж бэлэн зэлэн хэлэв.

- Өө, би хөгжимдөж чаддаггүй юм чинь яах юм гэж Керри зүрхлэн хэлэхэд:

- Тийм ч хэцүү юм биш. Та хэдхэн долоо хоноход тоглож чаддаг болно гэж Херствүд хэллээ.

Херствүд энэ орой бяр амтагдах шиг ухаан нь тун хурдан гүйж байв. Цоо шинэ, тун дэгжин

костюм өмсчээ. Сайн даавуу гэсэндээ гадуур цамцных нь энгэр индүүдсэн мэт толийно. Шоон хээтэй хантаазандаа дугариг танан товч, хоёр эгнүүлэн ярайтал хаджээ. Өнгө тунаран солонгорох торгон зангиа нь нэг их этгээд биш ч гэхнээ нүдэнд тусна. Түүний өмсөж зүүсэн нь Дрүэгийнх шиг гял цал болон нүдэнд тусахгүй боловч яс сайтай болохы нь шууд харагдана. Херствүд гоёмсог хар шевро гутлаа хувцасныхаа өнгөнд тохируулан тааруухан гялалзуулсан байхад Дрүэ лактай гутал өмсөөний нь зүйрлээд, шевро нь илүү кохимжтой юм гэх мэт аар саар юмыг Керри аяндаа бодлоо. Дрүэгийн өмсөж зүүдгээс огт өөр харагдсан тиймэрхүү юм Керрийн нүдэнд өртөх нь аргагүй.

Нэлээд ярилцаж суусны эцэст Херствүд:

– Гурвуул жаахан хөзөр тоглох юм биш үү, гэлээ.

Херствүд, Керрийн балаар огт юу ч мэдээгүй царай гарган тэр хавийн үг ганцыг ч цухуйлгахгүйг эвтэйхэн хичээнэ. Ер нь аливаа хүн харын талаар юу ч ярихгүй, ерөнхий юм ярьж байв. Ингэснээрээ Керрийг эвгүй байдалд оруулахгүй, санаагий нь амрааж, анхаарч халамжлан, бас ч инээдтэй яриа хөөрөөгөөрөө бишрүүлж эхлэв. Керрийн хэлэх үг нэг бүрийг тун их анхааран сонсож буй дүр үзүүлнэ.

- Би тоглодог дүрмий нь мэдэхгүй шүү дээ гэж Керрийн хэлэхэд Херствүд Дрүэд хандаж, тоглоомоор:

- Чарли минь, та чинь үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааюм биш үү? За гэсэн ч яах вэ, энүүхэндээ... бид хоёр заагаад өгнө биз гэлээ.

Херствүд эвий нь олж Дрүэд зөв юм хийжээ, зүйтэй хэмээн ойлгуулна. Херствүд ч энд ирсэндээ ихээхэн тааламжтай байгаа нь андашгүй харагдана. Дрүэ, түүнтэй урьд урьдаасаа улам дотно болов. Херствүдийн үнэлж буйгаас үндэслэн Керри өөрөөр үзэгдэх шиг болж, ер нь илүү хүндэтгэн үзэх ёстой юм байна гэж бодлоо. Тэгээд сэтгэл нь ч аюулын хөгжүүн болов.

- Алив хараатахья, танд юву ирж вэ гэж Херствүд Керрийн мөрөн дээгүүр маш намбатай өнгийж хөзрий нь түр зуурхан харснаа:

- Өө, дажгүй сайн хөзөр барьжээ. За одоо миний зааснаар л яваад байгаарай. Хар хүний чинь хожигдуулаатахья гэв. Дрүэ:

- Юү гэсэн үг вэ, та хоёр намайг хавсайдах юм бол би яаж тэсэх вэ. Херствүд хөзөрт эрлэг шүү дээ гэв.

- Тийм биш ээ. таны авгай надад ч гэсэн хишиг буянаа хшртээх нь. Ийм хүн хожихгүй яах юм?

Керри, Херствүд рүү талархан харж Дрүэ рүү инээмсэглэв. Херствүд гэмгүй сайн нөхрийн дүр үзүүлнэ. Тэднийд энэ орой зугаатай өнгөрүүлэх гэснээс өөр бодолгүй бөгөөд Керрийн хийж буй бүхнийг сайшаах ажээ.

- За явдаа гэж Херствүд өөрийн сайн хөзрийг зориуд барьж Керрид сөхөх боломж өгөөд. Анх тоглож байгаа хүн гэхэд сайн л явж байна шүү гэхэд Керри баярлан инээгэд сөхөв. Херствүд тусалж байгаа цагт хэзээ ч шүүгдэмгүй санагдана.

Херствүд, Керри рүү байн байн харагүй боловч хааяа харвал нүдэнд нь энхрий зөөлөн харц илэрнэ. Нөхөрсөг, бодь сэтгэлээс өөр шинж үл мэдэгдэнэ. Зальжин, алсын муу санагаа нууж, гэмгүй царайлах ажээ. Тийм хүн Керрид дотно санадах нь аргагүй өөрий нь их ч тоож байна гэж Керри бодлоо.

Херствүд нэлээд тоглосны дараа:

- ийм тоглоомыг хоосон явуулах ямар хэрэг байна вэ. Арав арван мөнгөөр дэнчин тавьцгаая хэмээн хантаазныхаа бутархай мөнгөний жижигхэн халаас руу хуруугаа явуулав.

- За тэгвэл тэгье гэж Дрүэ бас мөнгөө тэмтрэв.

Херствүд урьтаж атга дүүрэн аравтын шинэ мөнгө гаргаж ирээд “май, май” хэмээн хүн бүрт хувааж өгөв.

- Ээ, энэ чинь мөрийтэй тоглоом болж таарах нь. Муу хэрэг дээ гээд Керри хэлэв.

- Бишээ, зүгээр л наргиан байхгүй юу. Энэнээс л илүү дэнчин тавихгүй бол диваажинд очихоо очно гэж Дрүэ хэллээ.

- Юу болохы нь үзээгүй байж номчирхох хэрэггүй шүү дээ гэж Херствүд Керрид эелдгээр хэлэхэд Дрүэ инээмсэглэв.

- Нөхөр тань хожвол энэ тоглоом хичнээн олиггүй болохыг тайлбарлаж өгөх болно гэхэд писхийн инээлээ.

Херствүдийн ярьж буй дуу хоолойных нь өнгө, бүхий л намба нь тун тааламжтай байх тул Керри алиалж хэлсэн үгнийх нь утгыг ойлговь.

- Та хэзээ явах гэж байгаа вэ? гэж Херствүд асуухад Дрүэ:

- Лхагва гаригт гэв.

- Нөхөр чинь дандаа ажлаар ийш тийш яваад байх танд хэцүү байх даа? гэж Херствүд Керригээс асуухад Дрүэ:

- Энэ удаа надтай хамт явна гэв

- Та хоёр явахаасаа өмнө надтай театрт юм үзэх юм биш үү?

- Бололгүй яхав. Яах вэ? Керри?

- Тун дуртай үзэх байна.

Херствүд, Керрийг хожуулах гэж байдгаараа оролдлоо. Хожиход нь баярлаж хожлы нь тоолж мөнгий нь бодож цуглуулаад тоссон гарт нь өгөв. Оройн хоол идэхэд, Херствүд шил дарс гаргалаа. Тэгсгээд Херствүд явах болж эхлээд Керри рүү, дараа нь Дрүэ рүү харснаа:

- За, долоо хагас гэхэд яг бэлэн байгаарай. Би ирж та хоёрыг авна гэв.

Тэр хоёр Херствүүдийг үүдэн дээр гаргаж өгөхөд өөрийг нь хүлээж буй тэрэгнийх нь улаан дэнлүү харанхуйд тодхон харагдана.

- Херствүд Дрүэд их л нөхөрсгөөр,

- Таныг томилолтоор явах хооронд гэргийд чинь хааяа хань болж болно биз дээ гэхэд Дрүэ итгэсэнд нь баярлаж:

- Бололгүй яахав гэхэд Керри бас:

- Та сайн санаатай хүн юм даа гэв.

- Тэр нь юу юм бэ Танай нөхөр ч гэсэн миний оронд байсан бол энэ зэргийн санаа тавина шүү дээ гээд ялдамхан инээмсэглээд явлаа.

Керри тун сайхан сэтгэгдэлтэй хоцров. Тийм сайхан зантай хүнтэй ер тааралдаж яваагүй санагдана. Дрүэд ч гэсэн аятайхан санагджээ.

- Тун аятайхан хүн шүү. Миний сайн найз даа гэж Дрүэ тохилогхон жижиг өрөө рүүгээ орох зуур хэлэхэд Керри:

- Тийм бололтой гэв.

ДУРЫГ ТАТАХ ХҮЧ, ЗӨНГӨӨРӨӨ

Керри, амьдралын, чухамдаа амьдралын өнгөцхөн талыг сүрхий авхаалжтай тусган авч чадаж байлаа. Аливаа зүйлийг хармагцаа юуны өмнө надад таарах бол уу гэж бодно. Энэ бол ухаалаг овсгоотойг харуулах зүйл биш. Их ухаантангууд сэтгэлээр цөхөрдөггүй байхад ухаан муутай хүн сандрах нь их байдаг шүү дээ. Сайхан юм Керрийн сэтгэлийг татаж хамаг дур хүслий нь увдистай юм шиг булаана. Тиймэрхүү юм чихий нь дэлсэхэд чихээ байдгаар нь тавиад чагнадаг хүн дээ. Амьгүй юм гэгчийн дуу хоолой гэлтэй юмуу дурыг татахын хүч их ээ. Хад чулууны хэлийг хэн бидэнд орчуулан өгөх вэ. Петрик дэлгүүрээс худалдан авсан нэхмэл зах: “Хайрт минь би чамд яасан сайхан таарна вэ, чи надаас хэрхэвч бүү салаарай” гэх шиг болно. – Ай, яасан хөөрөхн жижигхэн хөл вэ би ч чамд ургасан юм шиг таарч байна. Ямар азаар би чамтай ингэж золгов оо” гэж шинэхэн торгон савхин гутал хэлэх мэт.

Тийм сайхан юмсыг нэгэнт гартаа барьж биендээ өмссөн хойно л дэмий л авч уу даа гж бодоход хүрнэ. Олж авсан арга замаа бодохоос сэтгэл нь зововч, гоёж гоодох дур хүслээ нэгэнт барьж чадахгүйгээс хойш элдвийг бодож биеэ зовоох хэрэггүй гэж итгэхийг байдгаараа чармайна. Ул нь эргэсэн хуучин муу гутлаа өмсөе дөө, яршиг гэж хааяа бодно. Нэрээ бодоод өлсөж цангаж, хатуу ажил хийж гачигдахын түмэн зовлонг давлаа ч гэсэн нооройж явна гэж бодохоос хэрхэвч хуучиндаа эргэн орхоыг хүсэхгүй ажээ. Хуучин муу хувцсаа өмсөөд гуйлгачин царайлж явах гэж үү? Хэзээ ч үгүй.

Дрүү, Керрийн хийж буйг зөв хэмээн улам өөгшүүлж байсан болохоор тийм юмны нөлөөг улам хүчтэй болгож байлаа. Хүний бодол хүсэл шуналдаа нийлж байгаа цагт тиймэрхүү үзэл бодлыг дэврээхэд зовлон байхгүй билээ. Керрийг үнэн голоосоо магтан биширч буй мэт царайлна. Бишрэн бахадсан янзтай ширтэн талимаарахад нь Керри арга буюу үнэмшин хөөрнө. Тухайн нөхцөл байдалд Керри царайлаг эмэгтэйчүүдийн байдлаар аашлах хэрэгцээ нэг л их байгаагүй боловч тэр талаар яггүй ахиц олж амжсан байв. Дрүү гудамжаар явж буй дэгжин хувцасласан царайлаг авгай хүүхнийг хараад заавал нэг юм хэлдэг зантай хүн. Өөрөө хувцас хунарт эмэгтэй хүн шиг луртай болоод ч тэр үү эмэгтэй хүний гоёлын талаар нэлээд мэддэг нь лав ухааных нь хүч биш л дээ. Жижигхэн хөлөө хэрхэн алхаж гишгэх, биеэ яаж намбатай байлгах, яаж толгой дээгүүр байлгах үергийг нь андахгүй гярхай ажиглана. Бөгсөө ялимгүй хаялсхийн товор товор алхан явах эмэгтэйг харвал ч амтлаг аяга тагш дарс бодоод арааных нь шүлс аяндаа асгарах архичин шиг болно. Тийм авгай хүүхний хойноос хүзүүгээ хугалах дөхөн, нүдний чадлаар ширтэн өлбөлзөнө. Шунал тачаалынх нь хорхой асахлаар хүйтэнд бөмбөгнөтөл дагжин чичирч буй балчир хүүхэд шиг салгалж алдана. Эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь эрхэмлэн шүтдэг гоолиг сайхан гэгчид ухаангүй дурлан биширнэ. Тэр шүтээнийх нь өмнө мань гайхал чин бишрэлт сүсэгтэн адил толгой гудайлган сүсдэн сөгдөх хүн.

- Чи саяын өнгөрдөг хүүхнийг ажиглав уу? Нэг их сайхан явах юм, тийм ээ? гэж Дрүү Керритэй анх удаа гадуур цуг зугаалан явахдаа асуухад Керри тэр хүүхний хойноос зэрэмхийн эргэж хараад “нээрэн тийм байна” гэж хэрэхдээ өөрийнхөө алхаа гишгээнд өө байгаа байж уу даа хэмээн сэрхийсэн аж. Үнэхээр тийм байсан бол олигтойхон харж аваад дууриах нь зүйтэй гэж бодов. Мэдээж, тэр хүүхэн шиг явж бололгүй яахав!

Тиймэрхүү магтан шагшрам олон юм тааралдах тусам Керри тусган авч заримы нь дууриадаг болов. харин Дрүү тиймэрхүү юм ярьж байх нь дэргэдэх хүндээ эвгүй гэдгийг ухаардаг байв. Бусдаам дор харагдаж байгаа юм болов уу гэж бодогдуулснаас биеэ тордвол хэний ч дор

орохооргүй гэсэн санаа агсан бол дээр гэдгийг ухаарсангүй. нас ахимаг, долиггоршон авгайд бол тэгж хэлэхгүй, харин Керрийг юу ч мэдэхгүй охин гэж бодоод л энэ ажээ. Дрүэ, Керригээс төрөлхийн ухаан дор болохоор түүнд бодогдуулснаа мэдэхгүй дэмий л сэтгэл зүрхий нь шимшрүүлсээр явах нь өөрийнхөө эрхэнд оруулан, дурлах хүнээ доромжилсон их л тэнэг хэрэг юм.

Керри, түүний заах үгийг дуулгавартай сонсохын хамт чухам юунд дуртай, ямар дутагдалтай хүн болохы нь гадарлаж эхлэв. Магтаж бахархах үгээ баран, илэн далангүй ярьдаг тийм эр, бүчгүй хүнд нэр нүүрээ алдаж эхлэнэ. Гэвч эмэгтэй хүн магтуулахыг дээдийн дээдэд үзнэ. Олон эмэгтэйн сэтгэлийг татъя гэсэн хүн тэр бүгдэд биеэ бүхлээр нь зориулах ёстой билээ.

Керри орон байрандаа байхдаа ч тэр чиглэлийн сургамж олныг сонсох ажээ.

Керрийн орсон тэр байшинд Стэндард театрын дарга ноён Франк Хэйл гэгч авгайн хамт суудаг байж. Авгай нь гучин тав эргэм насны, нүдэнд дулаахан, хар үстэй. Тэр хоёул өдгөөгийн Америкийн дунд давхаргын хүмүүсийн эгнээнд багтах бөгөөд хөрөнгө чинээ гэвэл базаалтай юм огт үгүй аж. Хэйл долоо хоногт дөчин таван долларын цалнитай. Авгай нь царайлаг, залуумсаг хүн болохоор гал тогоотой зууралдан, хүүхдэд дарагдан гэрийн мухар сахих хүсэлгүй. Тэднийх дэд давхарт нь мөн Дрүэ, Керри хоёрын даил гурван өрөөнд суух аж.

Керрийг тэнд суух болсноос хойш төдий л удалгүй Хэйл авгай, Керритэй танилцаж, ийш тийш хамт гардаг болжээ. Керрид өөр найз авгай хүүхэн байхгүй учраас театрын даргын авгайн ярих хов живээс л ертөнцийн байдлыг гадарлана. Хүмүүс гэдэг хичнээн бузар муухай явдалтай, эд мөнгөний хойноос үхэлдэж байдгийг авгайн мунхаг ухаанд нийгмийн ёс суртахуун хичнээн хуурамчаар үздэг зэргийг сонсоход Керрид их юм бодогдож нэг хэсэгтээ яах я учраа үл олох мэт болж байв.

Нөгөө талаар Керрийн төрөлхийн зан, санаа бодол чөөрт нь сайн нөлөө болж байв. Керри хэзээд аливаа юмны сайн талыг эрхэмлэх тэмүүлэлтийг нь үгүйсгэх аргагүй билээ. Тийм чанар сэтгэл зүрхэнд нь хатуу шигдээстэй амуй. Керрийн суудаг байрны нөгөө талын байранд Индиана муж улсын Эвансвалиас ирсэн нэг залуухан хүүхэн эхийн хамт сууна. Томхон төмөр замын нярвын авгай, охин хоёр юмсанж. Охин нь хөгжим сурахаар ирэхэд нь эх нь хань болж яваа юм байж.

Керри тэлдэнтэй танилцаагүй байсан боловч тийм нэг охины орж гарахыг олнтаа харжээ. Зочныхоо өрөөнд төгөлдөр баян хуурын ард суугаад хагжимдөхий нь цөөнгүй сонсжээ. Тэр залаа хүүхэн тун ганган дэгжин явах бөгөөд хөгжимдөн суухад хуруундаа хийсэн эрдэнийн чулуун бөгж нь гялалзана.

Керри хөгжимд их дуртай. Төгөлдөр баян хуурын эгшиг хангинахад ятгын утас доргих адил бүсгүйн зүрх сэтгэл хөдөлж уяран хүсэл мөрөөдөл нь жигүүрлэн нисэх мэт санагдана. Өөртөө байхгүй юмны хойноос мөрөөдөн хүсэмжлэх сэтгэл төрнө. Ингэхлээр нэгэнт олж авсан юмнаасаа тас зууралдах нь зүний хэрэг ажээ. Нөгөө охин нэгэн богино дууг бусдаас онцгой сайхан хөгжимдөх бөлгөө. Керри тэр дууг зочных нь өрөө задгай байхад тэр дороос чих тавин сонсоно. Хийх юмааолж ядан дэмий сууж байдаг буюу тэнэж байдаг хүмүүст сэтгэлийн гуниг төрүүлдэг хариуй бүрийн цагтсан билээ. Алс холын улс гүрнээр аялан явж элдэвжаргал цэнгэл элдэв хэмээн мөрөөдөл болсоор гэнэт бодит байдалдаа буцаж орохуй бахь байдгаараа байх тул гунигт автана. Керри цонхон дээрээ суугаад гадагш ширтэх бөгөөд Дрүэ өглөө арван цагт гэрээс гарчээ. Керри салхинд гарч алхаж байснаа орж ирээд Дрүэгийн уншиж байгаад орхисон М.Клейн

“Берта” хэмээх номноос уншсан боловч огт таалагдсангүй. Тэгэхлээр нь зүгээр суухаас гэж оройн цагаар өмсөхөд илүү зохимжтой хувцсаа сольж өмсөв. тэгснээ дахиад л тэртээ харагдах цэцэцрлэгт хүрээлэн дээгүүр ширтэв. Дандаа янз бүрийн наргин цэнгэж байх хүсэлтэй хүнд тэрүүн шиг их гуниг төрүүлэх юмгүй мэт санагджээ. Ийнхүү шиэ байдлынхаа тухай баахан бодол болон сууж байтал нь доод талын айлын зочны өрөөнөөс хөгжим эгшиглэхэд Керрийн бодол сарнин өөр юм бодогдох болов. Амьдралынхөө охор богино хугацаанд тохиолдсон хамгийн дөмөг бөгөөд хамгийн уятгарт үеийг нэхэн санавал тэрхэн агшнаа гэмших сэтгэл төрөв.

Имйрэхүү янзтай байтал нь Дрүү орж ирэхэд шинэхэн агаар сэвхийх мэт болов. Үдшийн барай бүрий болсон авч Керри гэрлээ асаагаагүй, задгай зуухны нь тал ч дөнгөж сүүмэлзэнэ.

- Кэд, чи хаана байна вэ? гэж Дрүү өөрийнхөө өгсөн энхрий нэрээр дуудахад Керри:

- Энд байнаа гэв.

Керрийн дууны өнгөнд нэг л гунигт аяс байх авч Дрүү тийм юм ойлгох хүн бишээ. Тиймэрхүү байдалтай байгаа эмэгтэй хүний сэтгэлийг засаж тайтгаруулах ухаангүй хүн болохоор шууд л чүдэнз зурж гэрлээ асаалаа.

Нулимсны ул мөр хацар дээр нь байгааг олж хараад:

- Өө, чи чинь уйлчихаад байсан юм уу? гэж дуу алдсанаа:

- Ингэж ч болохгүй шүү гэв.

Гары нь барьж аваад дотроо:ирэхгүй цудлаа гэж намайг санаж ганцаардсандаа л ингэсэн хэрэг гэж угаас өөрийгөө дөвийлгөн үздэг Дрүү бодов.

- За одоо зүгээр, зүгээр, хоёул энэ хөгжмийн аяар жаахан вальс эргэе гэж бас хэллээ.

Дрүү энэ мэтээс өөр олигтой юм бодож олох ч үгүй тул Керри түүнээс олигтой юм горьдоод хэрэггүй хүн гэдгийг лавтай мэдрэв. Ямар ч атугай түүний өөг бүрэн ухаарч хоёр биенийхээ ялгааг магадтай мэдэж чадаагүй гэхнээ гайгүй сайн гадарлав. Дрүү тийхүү анхныхаа ноцтой алдааг хийжээ.

Хөгжимчин охиныг оройн цагаар эхтэйгээ хамт гадуур гарахы нь ажаад Дрүү түүнийг магтан байдгий нь санаад бүсгүй хүн шалихгүй хээнцэр дэгжин юмаар хүний дур татаж чаддагийг Керри мэдээд өөрийгөө тольдож уруулаа ялимгүй жуумайлган толгойгоо үл мэдэг ганайлгаж үзэхэд төмөр замын мөнгөний нярвын охиноос ялгагдахааргүй болж буйгаа олж харлаа. хөгжимчин охин түүнчлэн өөр бусад хүүхнүүд шатаар уруудан буух зуур банзлынхаа хормойг ялимгүй татасхийхийг нь ч хараад Дрүү магтаж байсныг Керри санаж тэднийг дууриадаг болов. Ер нь Керри төрөлхийн дууриах авьяастай ажээ. Бусдын нүдэнд хэзээд маятайхан харагдаж гайхуулахыг боддог ганган дэгжин эмэгтэйчүүдийн тиймэрхүү арга барилыг Керри төдхөн эзэмшив. Товчоор хэлбэл, дэгжирхэх тухай ойлголт нь хоёр дахин өссөн тул гадна байдал нь өөр болж хүний нүдэнд тун аятайхан харагддаг хүүхэн болж хувирчээ.

Дрүү ч үүнийг нь мэдэж байв. Үс толгойдоо шинэ маягийн чимэг хэрэглж хөхөл үсээ огт өөрөөр чнзалж байхы нь нэг өглөө харжээ.

- Ингэж аялуулах чамд их зохиж байна шүү. Кэд гэж Дрүүг хэлэхэд Керри баярлаж:

- Нээрээ юу? гээд мөн тэр өдрөө өөр бус юм ч хийж үзлээ.

Мөнгөний нярвын охин сэмбэлзтэл алхдагийг аятайхан гэж магтдаг болохоор нь Керри бас л алхаж гишгэхээ нэлээд хөнгөн болгов. Нэг байшинд суудаг тэр залуухан хүүхний нөлөө хэр зэрэг их байсныг хэлэхэд бэрх бизээ. Гэсэн ч Херствүд тэднийд анх ирэхэд Керри Дрүүэтэй анх уулзаж байснаасаа хамаагүй дээр, дэгжин залуухан хүүхэн болчихсон байлаа. Урьдын хувцас хунар муутай, бүдүүн блохидуу байдлаас юу ч үлдээгүй арилсан байлаа. Царайлаг, голшиг, юмны учир төдий л мэдэхгүйн эрхээр баахан эмээнгүй, ялангуяа хүүхдэрхүү дүрлэгэр том нүд нь гадна өнгө маягт сүйд майд болдог эрчүүлийн шалиг занг арга буюу гижигдэнэ. Хуучирч өгөршиж буй юм шинэ сэргэг юманд хэзээний татагддаг жам бий. Залуу зандан насны амт шим, ариун нандин чанарыг үнэлэх сэтгэл нь мөхөөгүй сүүмэлзэж байсан Херствүдийн тэр галын дөл энэ удаа сэргэн дүрэлзэж эхлээд Керрийн царайлаг нүүр рүү ширтэн харахад тэндээс залуу насны хүчит туяа цацрах шиг санагдав. Дүрлэгэр нүднээс худал хуурмагийн өчүүхэн ч шинж илэхийг мань эр юманд үл итгэх зангаараа хайвч олж чадсангүй. Ялимгүй нэрэлхүү зантайг нь гадарлалаа ч гэсэн түүнийг өө биш чимэг гэж байсан буйзаа. Херствүд, тэргэндээ суугаад харих замдаа “Дрүүэ яаж энэ хүүхнийг урхидаж аваа юм бол” гэж бодож явав.

Херствүд, Керрийг анх хармагцаа Дрүүг дагуулахгүй хүн юм аа гэж ойлгожээ.

Морин тэрэг хурдлахад хоёр талаараа хийн дэнлүүтэй шонгууд түргэн түргэн ухран хоцрох мэт агаад Херствүд бээлтэй хоёр гараа зөрүүлэн суугаад цэлийсэн гэрэлтэй тэр нэг өрөө, Керрийн нүүр хоёрыг л дүрслэн бодож явна. Залуу насны гоо үзэсгэлэн гэгч юутай сайхныг бишрэн бодлогоширно.

“Баглаа цэцэг явуулах юм шүү! Дрүүэ юм бодохгүй байлгүй” гэж бодов.

Керри санаанаас нь хормын төдий ч гарч өгөхгүй байлаа. Дрүүэ өөрөөс нь илүү их эрхтэй гэдэг талаар огт тоож бодсонгүй. Аалзны шүлс мэт хэрсэн хэврэгхэн түмэн утасны дунд нүд эрээлжлэн аль нэгээс нь барьж авахыг найдна. Хожим хойноо юу болж шувтрахыг мэдсэн ч үгүй, мэдэхийг хүссэн ч үгүй.

Түүнээс хойш хэдэн долоо хоног өнгөрөхөд Дрүүэ доншуучлах ажлаар явж байгаад Омахад түр очоод буцах замдаа Чикаго хотод хуучин танил ганган дэгжин авгайтайгаа уулзжээ. Уг нь Огданд бушуухан очиж Керрийг гэнэт баярлуулах санаатай яарч явсан боловч тэр авгайтай уулзаад сонин хачин юм ярилцсаар бодож байснаасаа буцах нь тэр.

Хүн амьтны харчихвал дэмий юм гэж огт бодолгүй:

- Хоёул хоолонд орох уу, гэхэд цаадах нь:

- Боллолгүй яах вэ гэлээ.

Тэр хоёрын орсон зоогийн газар бол хуучин танилуудын бурахад хамгийн таарамжтай газар байлаа. Таван цагт уулзсан хоёр маань долоо хагас гэхэд л хоолоо идэж дуусчээ.

Дрүүэ нэг сонин тохиолдлынхоо тухай ярьж дуусаад марсайн инээж байтал гэнэт Херствүдийн

нүд харцанд нь тусав. Херствүд хэдэн найзынхаа хамт орж ирээд Дрүэг Керригээс өөр хүүхэнтэй сууж буйг хараад зохих дүгнэлт хийжээ.

Өө, муу өөдгүй золиг чинь ингэж байдаг вий гэж Керрийг дотроо өмөөрөн, хөөрхий тэр охиноор ингэж тоглоом хийж явдаг байх нь ээ” гэж бодлоо. Дрүэ тийнхүү Херствүдийн харж буйг мэдээд бажга алдан элдвийн хуумгай бодол тархинд нь ээлжлэн орж гарч байв. Херствүд харсан атлаа хараагүй царайлж буйг нь Дрүэ мэдээд эвгүй юм бодогдлоо. Эртүүд уулзаад Керрийг магтаж байсныг нь бодоод ямарч болтугай одоогийнхоо энэ явдлыг тайлбарладаг хэрэг гэж бодов. Хуучин танилтайгаа уулзаад хоол унд идэж уусаар жаахан удлаа гэхэд юу болдог юм гэж бас бодлоо.

Дрүэ анх удаа тийнхүү барьц алджээ. Ёс суртахууны талаар баахан эвгүй санагдаж Херствүд намайг яасан шалиг хүн бэ гэж доогдох биз, яавал ч яаг, нээрээн л тийм юмуу даа гэж амыг нь дагахаас биш. Керрийн чихэнд энэ явдал хэзээ ч сонсдохгүй, одоо хамт хоол идэж байгаа авгай юу ч олж мэдэхгүй гэж бодох авч нэг л зовлонтой санагдах бөгөөд өөрийгөө ямар ч гэмгүй гэж бодно. Хоолоо бушуухан дуусгахын мөн болж, тэр танилаа тэргэнд суулгаж өгөөд гэр лүүгээ явлаа.

“Сүүлчийнхээ явдлын тухай надад ярьсангүй. Өөрий нь түүнд хайртай гэж намайг итгэдэг гэж боддог байх нь ээ” гэж Херствүд дотроо бодов.

“Би өөрийг нь саяхан түүнтэй танилцуулж өгөөд байхад намайг өөр хүүхэнтэй орооцолдож явна гэж бодох ямар ч үндэсгүй” гэж Дрүэ ч бодож явав.

- Би таныг эртүүд харсан шүү гэж Херствүд сайхан зоогийн газраас салж чадахыг больсон Дрүэг хожим орж ирэхэд нь тохуурхан хэлээд эцэг нь хүүхэдтэйгээ харилцах адил долоовор хуруугаа гозойлгоход Дрүэ дуу алдан:

- Өртөөн дээр буутал яг тааралдсан хуучин танил маань цогтой тун ч царайлаг байсан юм шүү гэж тайлбарлахад цаадах нь:

- Одоо ч гэмээнэ аятайхан санагддаг биз дээ гэж мөн тохуурхсан янзтай хэлэв.

- Үгүй шүү, яг улаан тааралдчихаад яаж ч болоогүй юм.

- Одоо эндээ удах уу?

- Удахгүй ээ, хэдхэн хононо.

- Та тэр охинтойгоо ирж надтай хамт хоол идээрэй. Ер ньцаадахыгаа гэртээ дэндүү хориод байгаа юм биш биз? Би та хоёрт Жо Жефферсонд тусгай суудал авч юм үзүүлнэ гэхэд доншуучлагч:

- Хориод байгаа юм биш. Би заавал ирнээ гэв.

Херствүд тэгсэнд нь баярлаж Дрүэг Керрид тийм ч их хайртай биш юм гэж бодох боловч атаархах сэтгэл төрж сайхан хуцвасласан цовоолог янзын өөрөө сайн байдаг тэр доншуур худалдаачийг харахаас нүдэнд нь өрсөлдөн үзэлцэхийн цог гялалзаж эхлэв. Тэгээд Дрүэгийн

ухаан болон зан төрхийг өөчлөх гэж согогтой талы нь сонжиж эхлэв. Нэг үгээр хэлэхэд улы нь шагайх боллоо. Түүнийг гэмгүй сайн нөхөр гэж бодовч тэр хүүхэн дээрээс болоод их л дургүй хүрэх болжээ. Өрсөлдлөө гэхэд давчихмаар, дөрөв дэх өдөр болсон өнөөх явдлы нь Керрид хэлчихэд л дөнгөчихмөөр санагдана. Нүүрэн дээр нь гэмгүй царайлан инээж хөхрөн элдэвдээдийн юм ярих мөртлөө дотроо иймэрхүү муу санаж байхад Дрээ огт сэжиг аваагүй аж. Түүнд Херствүд мэт хүний нүдний харц, байдлаас нь тийм юм ойлгож авах чадал байсангүй. Цаадах нь шонхрын хурц нүдээр цоо ширтэн ажиж байхад мань эр ажиггүй инээн зогсож, урилгы нь хүлээн авлаа.

Энэ онцлог нь адармаатай шог жүжгийн гол баатар эмэгтэй маань тэр хоёрын алиных нь ч тухай бодох завгүй хамаг ухаан бодлоо шинээр бүрэлдэж буй нөхцөл байдалд тааруулахыг хичээх тул аль алинд нь сэтгэл зовсон юмгүй байна.

Нэг орой Керри толинд хараад хувцаслаж байхад Дрээ гэнэт орж ирээд:

- Кед, чи их дэгжирхдэг болж байна шүү гэхэд Керри инээж:

- Тийм бишээ гэхэд бүхэлхийгээр нь тэвэрч:

- Цэнхэр даашинзаа өмсчих, хоёулаа театрт очъё гэв.

- Ээ, яанаа өнөө орой Хэйл авгайтай цуг Үзэсгэлэнд очно гэхихсэн юмсан гэж Керри гэмшсэн байдалтай хэлэхэд Дрээ юм болсон янзтай:

- Ө, тийм үү, Би үзэсгэлэн үзэх нэг их дуртай биш гэхэд Керри эргэлзэнгүй боловч шийдсэнээсээ буцах бодолгүйгээр:

- За, яадаг билээ дээ гэтэл хаалгы тогших чимээ гары шивэгчин орж ирээд захиадал өгөн:

- Хариугий одоо авах юм гэнээ гэв.

Захидлыг задлах зуур бичгийг тавьж:

- Херствүдээс ирж гэж Дрээ хэлээд уншвал, “Та хоёр энэ орой надтай хамт явж Жо Жефферсоны тоглолт үзнэ шүү. Одоо миний урих ээлж, заавал ирээрэй” гэсэн бчиг байв.

- За, яах вэ? гэж Дрээ өөр төөр юм бодолгүй асуухад Керри шууд очъё гэж арай л хэлчихсэнгүй.

- Яахыг нь чи л мэддээ, Чарли гэж биеэ барин хэлэв.

- Дээд айлын авгайтай хамт явна гэснээ больж чадах юм бол хоёул очсон маань дээр бизээ.

- Чаднаа, чадна гэж Керри шууд хэллээ.

Дрээ хариу бичих цаас авч байхад Керри хувцсаа солихоор явлаа Тэр хүний урилганд яагаад тийнхүү дуртай очих болов гэж Керри өөрөө ч үнэнээсээ гайхаж ядна. Тэгээд үс гэзгээ аялуулах юм барьсаар гарч ирээд:

- Үсээ өгчигдрийнх шигээ л аялуулчих уу? гэхэд наадах нь тааламжтайгаар:

- Тэгээ, тэг гэв.

Дрүүгийн уур уцааргүй байгаад Керри баярлаж байв.

Херствүд өөрт нь аятайхан санагдсанаас Керри урилгы нь хүлээн авсангүй харин тэр хоёулантай нь хамт явж юм үзэх л аятайхан санагдсаных байжээ. Керри хамгийн зохидог хувцсаа өмсөөд дээд айлдаа орж учраа хэлээд гарлаа.

Тэр хоёрыг театрын хүлээх өрөөнд орж очиход Херствүд Керрийг биширсэн янзтай харж:

- Бид ч өнөө орой тун гайхмаар сайхан байна шүү гэхэд Керри давхийжээ.

- За, ингээд явна даа гэж Херствүд хэлээд тэр хоёрт замчлан дотогш оруулав.

Гагган улс үзье гэвэл тэнд л очууштай аж. Ёстой л “нүдээ бүлгийтэл” хувцаслацгаасан байв.

- Жефферсоны тоглохыг та урьд үзсэн үү? Гэж Херствүд Керрид ойртосхийн асуулаа.

- Үзээгүй шүү.

- Гайхалтай, гайхалтай гэж Херствүд зэрэг зиндааныхаа хүмүүсийн магтан шагшдагаар жүжигчнийг магтаж гарав. Херствүд Дрүүг хөтөлбөр олж ирээч гэж явуулчихаад Жефферсоны тухай хүнээс дуулснаа ярьж алдав. Дрүү ч тийм гайхмаар сайхан газар орж, гайхмаар сайхан суудалд сууж, хамт очсон нөхрийнхөө бишрэм намба байдлыг хараад хөл газар хүрэхгүй баяртай байв. Керрисанаандгүй Херствүдийн нүдний харцтай хэд хэд тулгарахад тэр хүний нүднээ хэнээс ч хэзээ ч үзэж яваагүй хайрын сэтгэл илрэх мэт санагдсан боловч ахин нэг харахад гараа сажиж буй байдлы нь ажвал огт хэнэггүй янзтай байх тул чухам учры нь лавтайяа мэдэх амаргүй ажээ.

Дрүү ярианд нь оролцох боловч Херствүдийг бодвол тун арчаагүй санагдана. Зүйрлэшгүй ухаантай дорвилог атлаа эгэл жир Херствүд тэр хоёрыг хоёулангий нь зугаацуулах агаад Дрүүгээс хамаагүй илүү гэдгий нь Керри төвөггүй ойлголоо. Гуравдугаар үзэгдлийн шувтаргын үе болоход Керри Дрүүг хөнгөн хуумгай залуугаас цаашгүй даанч урагшгүй эр юм гэж боджээ. Зүйрлэх тусам унхиагүй мэт санагдана.

Жүжиг үзээд гарахдаа Керри:

- Тун сайхан юм үзлээ гэхэд Дрүү:

- Үнэхээр сайхан юм гэв.

Керрийн сэтгэлийн тулалдаанд байр сууриа сүрхий ганхсаныг мань эр огт ухаарсангүй. Алс хязгаар нутаг нь атаатан дайсны гарт орж улс гүрэнд нь аюул учравч орд харшиндаа ужид цэнгэлд автан байсан Хятадын эзэн хаан шиг л байлаа.

- Энэ үдшийг надтай юм үзэж сайхан өнгөрөөсөнд баярлалаа. Сайхан нойрсоорой гэж Херствүд хэлээд Керрийн жижигхэн гарыг атгахад мань хоёрын хамаг биеэр сэтгэлийн гүйдэл харилцан дамжив.

Дрүэг ярьж эхлэхэд Керри тэрэгний суудалд толгойгоо арагшлуулан түших зуур:

- Би тун их ядарсан байх чинь гэв.

Тэгвэл чи жаахан амарч бай, би тамхиа татаадахья гээд Дрүэ тэрэгний өмнө талын задгай талбай руу гарч тэр эгзэгтэй байдлыг маанагтан огт анзааралгүй өнгөрөөх нь тэр.

ОРД ХАРШИЙН ТОД ГЭРЭЛ, ГОРИЛОЛ

Херствүд авгай нөхрийнхөө зан араншинг анддаггүй байсан боловч ёс суртахууных нь доголдлыг мэдэхгүй байв. Гэвч бишдэж эхлэхийг нь удалгүй гадарлажээ. Үнэнээсээ уурлавал ямар хүн болохы нь хэн ч таамаглахын аргагүй. Зарим эгзэгтэй үед чухам яахы нь Херствүд ч огт тухайлахгүй. Үнэн голоосоо уурлахы нь хэзээ ч үзээгүй ажээ. Ямар ч болтугай галзуу мэт аашлах авгай бишээ. Хүн бүхэн алдаа дутагдалтай гэдгийг мэддэг хүн болохоор хэн гуайд ч бараг итгэхгүй. Тун хашир хүн гэсэндээ аливаа дэмий хов живийн үгэнд орж дутуу дулимаг юм сонсохоос болгоомжилно. Уур хилэнгээ нэгмөсөн гаргаад дүрсхийгээд өнгөрөх ч хүн биш. Сэжигтэй юм дуулдлаа гэхэд ултайхан мэдэж аваад ухааны нь олох, хариугаа авахын тулд хүлцэн тэвчиж, элдвээр эргэцүүлэн бодож, яс зааж чадна. Гэхдээ эв нь таарвал өшөөгөө их бага аль нэгэн хэмжээгээр цаад хүндээ мэдэгдэлгүйгээр сэмхэн сэмхэн авч, хорлох ажлаа хойш тавихгүй. Энэ бол хүйтэн цэвдэг дотортой, биеэ бодсон, нүднийхээ хулгай харцаар ч үл илчлэх маш олон бодлыг тархи толгойдоо эргэлдүүлж байдаг ихээхэн дотуур тамиртай авгай ажээ.

Херствүд, авгайнхаа тиймэрхүү чанартайг ерөнхийд нь гадарлах боловч гүйцэд сайн ойлгоогүй аж. Херствүд түүнтэй ханилан суусаар амар жимэр, сэтгэл хангалуун яваа билээ. Эхнэрээсээ огт эмээдэггүй, эмээх ч шалтгаан байсангүй. Эхнэр нь ч ихсийн хүрээлэнгийн авгай хүүхний эгнээнд багтах хүслэнтэй байдаг болохоор нөхрөөрөө бахархах сэтгэл урьдын адил бага ч гэмээнэ буй. Бас нөхрийнхөө хөрөнгөний ихэнхийг нэрэн дээрээ болгож авлаа гэж битүүдээ баярлана. Херствүд гал голомтоо одоогийнхоос нэлээд дөнгүүр байх үед хаширлаж тэгсэн юмсанж. Авгай нь ч хэзээ нэгэн цагт гэр бүлдээ эвгүй юм тохиолдоно гэж бодсонгүй. Тиймэрхүү базаахгүй юмны сураг ажиг мэдэгдэж эхлэхийн хамт нөхрийнхөө ихэнх хөрөнгөд эзэн суух эрхтэйгээ гэнэ гэнэ бодож дотроо залбирна. Яалаа ч гэсэн идэх хоолтойгоо үлдэх учраас яаж ч тонгорч чадна гэж авгай нь бодоод додигор байхад, Херствүд авгайнхаа дургүйг хүргэчихвэл яаж ч мэднэ гэж айгаад их л болгоомжлох ажээ.

Херствүд, Керри, Дрээ гурвыг Мак-Викарын театрт юм үзэхэд Херствүдийн хүү Жорж Чикаго хотын бөс барааны бөөнөөр худалдаалах пүүсний хувь нийлсэн гурав дахь эзэн Кармаикл ноёны охинтой хамт зургадугаар эгнээнд сууж байжээ. Херствүд тшатрт юм үзэхдээ аль болох хойгуур суудал авч, ялимгүй урагш бөхийвөл урд талын зургаан эгнээний хүмүүст харагдахтай үгүйтэй байхыг хүсдэг учир өөрөө хүүгээ олж харсангүй. Ямар ч теарт мань эр ер нь ямагт бусдаас нуугдах маягтай сууна.

Тэгээд хүний хараанд орж амны зугаа болчихгүй юмсан хэмээн суудалдаа хөдлөх ч үгүй суух бөгөөд хүний нүдэнд өртөхөөс ихэд эмээн биеэ барин бэмбэгнэнэ.

Маргааш өглөө нь хоол, цагйаа идэж ууж байтал хүү нь:

- Аав, би таныг өчигдөр оройн харсан гэхэд Херствүд огт ажиггүйгээр:

- Чи Мак-Викарт ороо юу? гэв.

- Очсон

- Хэнтэй?

- Кармаиклын охинтой.

Херствүд авгай, нөхрөө сүрхий ажин харсан боловч огт сэжигтэй юм мэдэгдэхгүй учир тэр театрт ороод гарсан байж ч болох юмдаа гэж бодлоо. Тэгснээ:

- Хэр сайхан жүжиг юм дээ? гэхэд Херствүд:

- Тун сайхан, даанч хуучин – Рип Ван Винкл гэдэг жүжиг гэв.

- Хэнтэй үзээв? Гэж авгай нь гэмгүй царайлан асуув.

- Чарли Дрүэ, авгайтайгаа хамт. Мой ноёны найз нар. Чикагод түр ирээд байгаа юм гэнэ.

Херствүдийн ажлын онцлогийг бодохул энэ мэтийн явдалд сэжиглэхээргүй. Албаныхаа ажлаас болж авгайгаа тэр болгон юманд авч орох боломж байдаггүй байх гэж авгай нь бодно. Гэвч сүүлийн үед энд тэнд очъё гэж хэд хэдэн удаа гуйхад нь тийм ч ажилтай, ийм ч албатай гээд хамт яваагүй юм байж. Тэр өдрийн өглөө бас тэгж шалтагцсан байж.

- Би чамайг ажилтай юм байх гэж бодсон гэж авгайгаа маш болгоомжтой хэлэхэд Херствүд:

- Харин ажилтай байсан юм чинь. Очихгүй байж болсонгүй, тэгээд дараа нь шөнийн хоёр цаг хүртэл ажил дээрээ байлаа шүү дээ гэв.

Ийм үгээр амы нь түр зуур тагласан боловч авгайнхаа сэтгэлд нэгэнт эвгүй юм оруулжээ. Асууж сонирхсон зүйлд нь ийм хангалтгүй хариу өгч байсан удаа үгүй боловч, ер нь сүүлийн жилүүдэд зан нь баахан хувирч, хамт байхдаа гиюүрч уйтгарлах байдалтай өөр болсон аж. Одоо тэнгэрийн мандалд шинэ гэрэл гарч ирэхэд өрнө зүгийн хуучин гэрэл нь бүдгэрэн эхэлжээ. Нүүрээ нэгмөсөн буруулсан бол эргэж харахаас зэвүү нь хүрэх мэт амой. Гэтэл авгай нь нөхрийнхөө сэтгэл хувирсан ч анх толгой холбон ханилсан ам тангарагаасаа буцахыг нь хэрхэвч зөвшөөрөх бодолгүй байв.

Түүнээс хэд хоногийн дараа Херствүд авгай:

- Бид өнөө орой хотын төв орно. Чи Кинслейнхээр очиж Филлипс ноён, гэргий хоёртой танилцвал зүгээр байна. Тэр хоёр “Тремонт” зочид буудалд байх юм гэнэ лээ. Тэр хоёрт хот үзүүлэх гэсэн юм гэв.

Тэр Филлипс хэмээх эр эм хоёр нь мэдэх юмаар маруухан дэмий хүмүүс болохыг Херствүд мэдэх боловч пүрэв гаригийн өнөөх явдлаас болоод үгүй гэж чадсангүй. Тэгээд дурамжхан зөвшөөрөөд гэрээс гарахдаа их л ууртай байв.

“Үүнээс хойш, түүнээс цааш иймэрхүү дэмий юмыг таслан зогсоох юм хуна. Ажил мундахгүй байхад чин гийчин дагаад дэмийрч явах гэж юү гэсэн үг вэ” гэж дотроо бодов.

Түүнээс хойш Херствүд авгай төдий л удалгүй нэг театрт өдрийн жүжиг үзье гэхэд нь Херствүд:

- Хүнгор минь надад зав алга, ажилдаа дарагдаад байна шүү дээ гэхэд авгай нь нэлээд дургүйцэж:

- Өөр бусадтай юм үзэхдээ завтай л байдаг юм байх чинь билээ гэв. Херствүдийн уур хүрч:

- Тийм биш ээ! Алба ажлаас л болсон болохоос, өөр имийээ тиймээ юмгүй шүү дээ гэлээ.

- Тийм бол сайн л байна гэж авгай нь омогтой хэлээд хөмгийгөө зуув. Тийнхүү энэ эр эм хоёрын бие биендээ зэвүүцэх нь илт нэмэгдлээ.

Нөгөө талаар Дрүэгийн уулзаж танилцсан жижигхэн ажилчин хүүхнээ мөрөөдөх нь мөн энэ зэрэгтэй нэмэгджээ. Харин тэр залуу хүүхэн ирсэн газраа нэлээд идээшиж, шинэ найзынхаа нөлөөгөөр сүрхий хувирч байв. Керри бол өөрийн толгой мэдэлтэй, эрх дураараа амьдралын төлөө тэмцэгч хүний чанарыг хадгалсан хүн ажээ. Илүү сайхан амьдарч болох юм байна гэсэн найдлага түүнд унтраагүй бөгөөд нэг их юм сурч мэдэж базаагаагүй байгаа ч гэсэн юм сурах хүслэн нь оргилж байв. Хейл авгайн баян чинээлэг амьдрал, алба хэргэмийн талаар байнга шагшин ярих нь Керрид хүмүүсийн баян чинээлгийн ялгааг ухаарахад нэмэр болж байв.

Хейл авгай, цэлмэг тогтуун өдөр салхинд гарч өөрийнх нь бэнчин даанч хүрэхгүй сүрлэг сайхан орд харш, ногоорон дуниартах зүлэг нугыг харж үгээ баран магтана. Одоошгийн хойд Болдог хэмээгдэх тэр үеийн хотын хойд хэсэгт олон сайхан орд харш сүндэрлэн босож байжээ. Мичиган нугын хөвөөгөөр босгосон одоогийн энэ чулуу, хиймэл гантиган хана байгаагүй боловч сайхан зам тавьсан бөгөөд хоёр талаархи зүлэг нь нүүнд чимэгтэй, цоо шинэхэн гоё байшингууд нүд булаана. Өвлийн улирал өнгөрч хаврын урьхан цжлмэг өдөр налайсан нэг өдөр Хейл авгай сүүх тэрэг хөлслөн авч Керрийг зугаалганд урьжээ. Тэд Линкольны нэрэмжит цэцэрлэгээр дайраад Ивенсронд хүрч дөрвөн цаг гэхэд буцаад таван цагийн алдад хойд Болдогт хүрчээ. Эрт, хаврын өдөр төдий л уртгүй байсан болохоор их хотод үдшийн баруй бүрий болж байв. Энд тэнд дэнлүү асан гэрэл нь нэвт харагдах тунгалаг ус лугаа төстэй үзэгдэнэ. Зөөлөн намуун агаар нь бие сэтгэлд тааламжтай. Хаврын өдрийн сайхныг Керри мэдрэв. Элдвийн хүсэл мөрөөдөл төрнө. Толигор засмал замаар алхахад хажуугаар нь сүүх тэрэгтэй хүмүүс гэнэ гэнэ явж өнгөрнө. Тийм нэг тэрэг зогсоход гоцго нь яаруухан үсрэн буугаад сүүхний хаалгыг онгойлгоход оройн зугаалганаас буцаж ирж буй бололтой нэг ноён яаралгүй бууж буй харагдлаа. Дөнгөж ногоорч буй өргөн зүлэгний цаад талд гэрэл дэнлүү асахад баян чинээлэг айлын өрөөний доторхи тавилга ярасхийн харагдав. Түшлэгтэй сайхан сандал, ширээ, цэмцгэр өрөө тасалгаа зэрэг нь Керрид тун гойд санагджээ. Балчир ахуй цагт зүүдэндээ үзэж байёсан үлгэр домгийн орд харш, шилтгээннүд одоо урдуур нь эгнэлдэн харагдах аж. Цэцэг навчин хээ угалзтай шил бүхий хаалган дээр нь талст сүүн дэнлүүнүүдийн гэрэл тусах, хээ хуар, угалз болсон тэр гонх хаалганы цаана суудаг хүмүүс дутагдах гачигдахын зовлон мэдэхгүй, дандпаа жаргал эдлэн суудаг байх гэж Керри бодлоо. Тэр гойд сайхан санагдсан гудамлан жирийх хээ хуар болсон орцоор нь ороод шатаарнь өгсөж, тэр их баян хээнцэр эд агуурсны дунд нь орж эзэмдэн өөрийнх болговол уй гуниг, гансрал нь өргөс аваад хаячих шиг дороо арилж зүрхнийх нь шимшрээ төдхөн алга болохсон!... Керри гайхан сэтгэл хөдөлж, мөрөөдөлд автан нүд салгалгүй харан харан гунихрахдаа цуцашгүй хүслэнгийн уриалан дуудах дуу хоолой чихэнд нь сонсдох мэт авай.

- Ийм байшинтай болбол мөн сайхан аа! гэж Хейл авгай хэлэхэд Керри:

- Орчлонд жаргалтай хүн ердөө байдаггүй л гэлцэх юм байна шүү дээ гэв.

Өөрөө хүрч чадахгүй болохоор стгэлээ хуурч энэ муу усан үзэм чинь түүхий юм байна шүү дээ гээд явсан үнэгний үлгэрээр Керри тиймэрхүү онолыг бишгүй олон удаа сонссон байж.

- Орд харшинд л сууж байвал жаргал цэнгэлгүй ч хамаагүй байдаг юм байлгүй дээ гэж Хейл авгай ёжлов.

Керри байрандаа орж ирээд саяхан үзсэн харсантайгаа зүйрлэвэл үнэхээр доожоогүй санагджээ. Тавилга хэрэглэлээр базаахгүй, гуравхан жижиг өрөө яаж эгнэх билээ. Урьд нь өөрөө юутай байсан билээ гэдэгтэй биш, харин саяын үзэж харсантайгаа л зүйрлэсэн хэрэг л дээ. Нүдэнд нь өнөөх сайхан орд харш үзэгдэх шиг, чихэнд нь намбалзан явах сүүх тэрэгний түжигнэх чимээ сонсдох шиг болно. “Энэ Дрүэ ер нь юун хүн бэ? Би хэ билээ?” гэж Керри цонхныхоо дэргэдэх эргэдэг сандал дээр суучихаад Воррен, Эшленд гудамжны гэрэл цаанаа нь мяралзах дэнлүүний тод гэрэлд цэлийх цэцэглэгийг ширтэнэ. Керрийн сэтгэл дэндүү их донслох учир хоол унд идэж уумгүй, эргэлддэг сандал дээрээ суугаад л амандаа дуу аялахаас өөр юм хиймгүй санагдав. Аль хэдүйн мартчихсан дууны ая орж ирэхэд зүрх нь ёгхийн гуниглан суулаа. Колумб хотод байдаг хуучин байшин, эргийн Болдог хавийн орд харш, нэг авгайн өмсөж явсан жигтэйхэн сайхан бошинз, өдөр явж байхад нүднээ тусаж байсан нэг их сайхан газар санаанд нь ээлж дараалан орж ирээд гуньж мөрөөдөх сэтгэлийг төрүүлсээр авай. Хязгааргүй гансралд орох атлаа бүүр түүр хүсэл мөрөөдөлд автана. Адаг сүүлд нь бодоход хамаг амьтанд хаягдаж, ганцаардсан хөөрхий амьтан мэт бодогдоод уруул нь өмөлзөж байв. Керри амандаа дуу аялан цонхныхоо дэргэд харанхуй бүрий болтол удаан суухдаа хэзээ ч имй сайхан явж үзээгүй гэдгээ эс ойлгоно.

Тиймэрхүү янзтай сууж байтал нь шивэгчин хүүээн орж ирж Дрүэ ноён, хатагтай хоёртой уулзах гэж Херствүд ноён ирээд байна гэв.

“Чарлийг явчихсан гэж мэдээгүй юм байлгүй” гэж Керри бодлоо.

Тэр өвөл, Керри зоогийн газрын эрхлэгч энэ ноёнтой тун цөөхөн уулзалдсан боловч аль нэг юмнаас сэдэвлэн түүний тухай бодсон удаа олон бөгөөд анх уулзаад төрсөн сэтгэгдэл нь арилж мартагдахгүй байжээ. Одоо тэр хүнийг ирлээ гэхэд юуны өмнө биеэ тольдож харснаа дажгүй гэж бодоод угтахаар гарлаа.

Херствүд хэзээ язааныхаараа ганган дэгжин харагдана. Дрүэг эзгүйг мэдээгүй гэдгээ хэлэв. Гэсэн ч нэг их гонсойсонгүй, иэгээд яриа хөөрөөнийхөө сэдвийг Керрийн сонирхлыг татах зүг рүү эргүүлэв. Эвий нь олоод ярихдаа эзтэй сурмаг, гайхмаар эвсэгхэн ажээ. Яриагий нь дуртай сонсож байвал тиймэрхүү улсын яриа хөөрө аяндаа урсдаг л даа. Керри түүний яриаг дуртай сонсохыг Херствүд мэдсэн учир сонирхлы нь татсан есөн шидийн юмны тухай өчүүхэн ч түгдэрч зоволгүй урсгаж гарлаа. Мань эр сандлаа ялимгүй дөхүүлж сууснаа яриан дундуур дотночлох маягтайгаар дуу хоолойгоо гэнэ гэнэ намсган, ямар ямар газар орноор аялан ямар улстай танилцаж тааралдаж явснаа ярилаа. Тэгж ярьсаар тэр газар орноор явж үзэхсэн гэсэн хүслийг Керрид бий болгож дөнгөхийн хамт өөрийгөө бодь хүн гэж бодогдуулах гэсэн санаагаа агшин төдий ч мартаггүй чармайсаар байв. Керри ч тэр хүнийг жигтэйхэн биширч эхлэв. Херствүд зарим үгээ онцлон тэмдэглэхийн тулд инээвхийлэн хүүхний нүүр рүү удаан харахад Керри нүднийх нь харцанд соронзон лугаа татагдах адил болно. Мань эр тийнхүү тун эвтэйхэн аргаар биедээ татсаар байв. Нэг удаа ярьсан зүйлээ тун ин онцгойлон хүч оржжлу буй байдал үзүүлэхдээ гарт нь хүрэхэд Керри инээмсэглэхээс өөр яасан ч үгүй. Херствүдийн яриа нь Керрийн хамаг бие сэтгэлийг уусган шингээх цацараг мэт маш сонирхолтой, ухааны нь сэргээж сэлбэх шиг санагдана. Ямар ч болтугай түүний нөлөөгөөр Керри ихэд сэргэж, өөрөө ч байдгаараа хөгжиж баяслаа. Бусад хүнтэй байснаас түүнтэй байхад ухаан нь илүү задрах шиг санагдана. Керрийг ч хэн хэнээс илүү өргөмжилж буй өчүүхэн ч шинж мэдэгдэхгүй, гэтэл Дрүэ бол шал өөр хүн.

Дрүэг байсан ч байгаагүй ч Херствүдтэй уулзах цаанаа л дотно байх тул Керри ингэж

бодохоосоо аймаар санагддаг болжээ. Керри угаас үг цөөнтэй, өөрийн бодлыг олигтойхон товхийтэл ярьж чаддаггүй. Харин сэтгэл зүрхээр тун гүнзгий ажээ. Дрүэтэй хэзээ ч ячин сэтгэлийн үг ярилцаж байсангүй. Харин харц, сэтгэц гэж яривал ямар эмэгтэй түүнийгээ нууж байлаа? Сэтгэл санааны хувьд Дрүэтэй хэзээ ч ойр дотно байгаагүй, байх ч үндэсгүй ажээ. Дрүэтэй учрах үедээ Керри ядарч явсан болохоор энэ хүний ачаар нэг аврагдсан, тэгээд ч эрхэнд нь арга буюу оржээ. Гэтэл одоо Керрийн дотор ургасан өөр хүчтэй бодлыг Дрүэ шиг хүн ухаарч чадахгүй. Херствүдийн нүдний харц бүр нь Керрид сэтгэлтэй хүний хайртай нүд төдийгүй түүнээс ч илүү ихийг хэлэх ажээ. Тэр нүдний харц даруйхан хариу шаардах хөнгөн харц бишээ.

Хүмүүс хүний хэлсэн үгийг дэндүү их сонждог. Үг л их юм хийдэг мэт бодоцгооно. Үнэндээ үгэнд хэдийхэн хүч байх билээ. Далд буй их хүслэн мөрөөдлийг бүүр түүрхэн илтгэхээс хэтэрдэггүй юм. Хэл саад болохгүй цагт л зүрх зүрхээ ойлгодог.

Керри, Херствүдтэй ярихдаа чухам үгий нь биш, цаана нь юу нуугдаж байгааг л сонжиж байв. Тэр хүний гадаад төрх, нийгэмд эзлэх байр суурь нь түний өмнөөс хичнээн эрхэм зүйлийг хэлсэн гэж бодно! Улам улам дотносон наалинхайтах нь Керрийг хайрын гараар илбэх мэт агаад тэр нь үл үзэгдэх учир үргээн цочоосонгүй. хэлж буй үг нь нүдэнд нэгэнт үзэгдэхгүй болохоор бусад хүмүүс юу гэх бол, өөрөө ч юу гэж хэлье дээ хэмээн зовох юм гарахгүй байв. Херствүд ярь ярьсаар Керрийг биедээ татан, нөгөө хүнээс нь хөндийрүүлэн, тэрнийх нь эрхийг алдагдуулж, шинэ эрх эдлэх зүг хөтөлсөөр буй атлаа ингэж байна даа гэмээр ганц ч үг үл хэлнэм бөлгөө. Тэр хоёрын яриа нь тайзан дээр тоглож буй ямар нэг жүжгийн дагал хөгжмийн ая мэт байв.

- Та нуурын хойд эргээр байдаг орд харшуудыг үзсэн үү? Гэж Херствүд гэнэт асуув.

- Яг өнөөдөр л үзлээ. Хейл хатагтай бид хоёр явсан юм. Үгүй мөн сайхан юмаа?

- Тун сайхан шүү.

- Тийм сайхан байшинд суух юмса гэж Керри бодлогошрон хэлэв. Херствүд түр дуугүй байснаа:

- Таны аз дугаж дээ гэж хэлснээ алгуурхан харцаа дээшлүүлэн нүүр рүү нь шууд ширтлээ.

Загатнасан газры нь маажсанаа Хцертвүд сая ойлголоо. Одоо мань эр санаагаа хэлэх ялимгүй ч гэсэн боломж цухуйх нь энэ. Тэгээд Керрид дөхөсхийн тайвнаар ширтсээр байв. Эгзэгтэй агшин боллоо гэдгийг андсангүй. Керри хөдлөх гэсэн авч тэр хүний хамаг татах хүчинд хүлэгдсэн мэт яаж ч чадсангүй. Херствүд ч хүлгээ улам чангалах нь зүйтэй гэж бодоод ширтэн ширтсээр байж суухад улам ч хэцүү болох ахуйд үйлдвэрийн өчүүхэн ажилчин эмэгтэй гүн усаа хөл алдаж, барьж байсан тулгуурууд нь алдагдах шиг болов.

- Та намайг битгий ингэж ширтээд байгаа ч дээ гэж эцэст нь дуу алдахад:

- Харахгүй байж чадахгүй байна шүү дээ гэв.

Керри үг дуугаралгүй, яавал ч яаг гэсэн байдалтай болоход Херствүд бүр зоригжиж:

- Таны амьдрал өөрт чинь таатай биш байгаа биз дээ? гэхэд Керри нам дуугаар:

- Тийм гэв.

Херствүд одоо минийх боллоо гэж бодоод Керрид бүр ойртон гары нь барьтал:

- Та яаж байна гээд босон харайлаа.

- Уучлаарай, санаандгүй юм боллоо гэж Херствүд жишим ч үгүй хэлэв.

Керри тэгээд л зайлчихаж болох байсан боловч тэгсэнгүй, харин ч яриагий нь цааш сонсоход Херствүд сонин сонин юс дуртайяа ярьж гарлаа. Тэгсгээд Хесртвүд явахаар босоход Керри эрхэнд нь орж буйгаа мэдлээ.

- Та бүү зов, яваандаа юм бүхэн сайхнаар эргэх байлгүй гэж Херствүд элэгсгээр хэлэхэд Керри үнэндээ юу хэлэхээ мэдэхгүй байсан тул юу ч гэсэнгүй. Херствүд гараа сарвайж:

- Та бид хоёр сайн нөхдийн ёсоор байна биз!? гэхэд Керри:

- Тэгнээ гэв.

- Тэгвэл тантай уулзах хүртэл хүн хард ганц ч үг цухуйлгах хэрэггүй шүү гээд гары нь атгасан хэвээр хэлэв.

- Тэгнэ гэж амлаж чадахгүй шүү гэж Керр хулмалзсан янзтай хэлэхэд Херствүд:

- Нөхдийгөө хайрладаг байх хэрэгтэй шүү дээ гэжтун эгэл байдалтай хэлэв. Керри түүнийг дотроо өрөвдөж:

- За энэ тухай дахин ярихаа больёе гэхэд нь Херствүд ч байрлан:

- За, за тэгье гээд шатаар бууж сүүх тэргэндээ ороход Керри гадаах үүдээ хаагаад өрөөндөө орж тлиныхоо өмнө очин, сүлжмэл өргө захаа авч эртээдхэн худалдаж авсан матрын арьсан гоёмсог бүсээ тайлав.

- Муухай юм болж байна. Хөдлөх гишгэх бүртээ буруу юм хийгээд байх боллоо гэж Керри үнэхээр ичиж зовсондоо бодов.

Керри өтгөн хүрэн үсээ задлан унжуулаад энэ үдшийнхээ явдлыг нэхэн санаад:

- Одоо ер нь яалтай юм бэ, мэдэхийг ч байлаа гэж дуулдах төдий хэлэв.

- Надад сайн юм, мэдж авлаа гэж Херствүд зам зуураа бодож явава.

Тэгээд шөнийн зоогийн газрын эрхлэгч маань сэтгэл хөөрсөндөө аль арван таван жилийн өмнө мэддэг байсан нэг дууны аяыг албандаа хүрч очих хүртэл бүхэл дөрвөн бээрийн замд зогсоо зайгүй аялан исгэцсээр явлаа.

ИТГЭМЛЭХ ЖУУХ БИЧГИЙН НЬ АВЛАА. ЭХ АДАГГУЙ БУЖИГНААН

Херствүд, Керритэй уулзсанаас хойш дөнгөж хоёрхон долоо хоног болоод тэднийд дахин очжээ. Керри санаанаас нь гарч өгсөнгүй. Хүлцэнгүй номхон байсан нь бодохоор горьдож санасандаа хүрэхийг тэсэж ядан хүлээнэ.

Керрийг хүсэмжлэх нь жирийн нэг шалиглал биш, тун ч гүнзгий учир шалтгаантай асанж. Олон жилийн турш хуурай, шим нь бараг барагдсан хөрсөнд зэвэрч байсан дур хүсэл гэнэт сэргэж дэлбээлэн цэцэглэх шиг болсон ажээ. Керри, түүний урьд өмнө тааралдаж байсан эмэгтэй нарын дотроос хамгийн дээд нь байсан байж мэднэ. Херствүд гэр бүл болж өнгөрсөн ертөнцийн явдлаас шүүн бодохул ахных нь шийд тун ч хуумгай, алдаатай байсан нь илт байжээ. Тэгээд бодох бүрдээ хэрэв би дахиад гэрлэх юм бол яавч ийм авгайтай суухгүй гэж бодно. Мөн үүний зэрэгцээ эмэгтэйчүүд лүгээ харьцсан туршлагаасаа дүгнэлт хийгээд ер нь базаахгүй улс гэж бодох болжээ. Олон юман дээрээс тэгж муугаар бодох болсон юм байж. Керритэй танилцахаас өмнө уулзаж учирч байсан авгай хүүхнүүд бүгд ячлгаагүй, хувиа хичээсэн, бүдүүн тоймын болхи санагдана. Найз нөхдийнх нь авгайчуулд нэг ч олигтой юм байхгүй, өөрийн нь авгай гэхлээр өөрт нь жаргал цэнгэл болж чадахгүй, хүйтэн цэвдэг, тулга тойрсон юухан хээхнээр хөөцөлдсөн хүн юм. Нийгмийн сайн эрсийн ужид цэнгэлд умбаж байдаг газрын тухай яриа мань эр тийм газар олныг мэднэ түүний зүрхийг чулуу шиг хатуу болгожээ. Тэгээд эмэгтэй хүн бол гоо үзэсгэлэн, гоёл чимгээрээ олз хайдаг л амьтан гэж тэдэнд итгэхээ больсон юм байж. Тэдгээд тэднийг хажуугаараа гарахад үл итгэсэн харцаар цоо ширтэнэ. Гэхдээ сайхан эмэгтэйг хүндэтгэхгүй байдаг тийм ч тэнэг эр биш. Тэр ч бүү хэл ариун явдалт бүсгүй хүн хаанаас бий болдог бол гэж тээнэгэлзэх ч үгүй, шууд л малгай аван мэхэс тонгосхийн ёслохоор үл барам түүний дэргэд зохисгүй муу үг хэлэх хүний амыг ч таглахаас буцахгүй. гуйланчдын шөнийг өнгөрөөдөг газрын эзэн ирланд хүн буюу Английн хишиг буян хүртээх газрын албатнаас ч дутахгүйгэр хөл алдах хүн юм. Өөрөө яагаад ингэж байгаагаа Херствүд эрэгцүүлэн бодох ч хүн биш.

Амьдралдаа базаахгүй олон юмтай учирч учирчихаад гэнэт гэнэн хонгор, гэмгүй амьтантай учирсан Херствүд мэтийн хүн эсхүл биеэ мэдэж холхон явах, эсхүл дур шуналдаа хөтлөгдөн хөөцөлдөж эхлэнэ. Керри шиг хүүхнийг Херствүд мэтийн хүн их л алгуур аргалахгүй бол өөр арга байхгүй. Тийм насны хүмүүс залуу хүний сэтгэлийг гагцхүү амьдралынх нь гачигдлаар далимдуулж татна уу гэхээс биш өөр арга тэдэнд байдаггүй. Хэрэв ялаа нэгэнт аалзны шүлсэнд орооцолдчихвол уу, аалз дуртай болзлоо тулган байж учры нь олно шүү дээ. Гэнэн хонгор бүсгүй их хотын хөлгүй амьдрал дунд зүг чигээ ч мэдэхгүй болох үед амархан олз хайгч этгээдүүд арван гурван мэхээ хийдэг ажээ.

Херствүд анх удаа Дрүэгийн урилгаар тэдний рүү явахдаа, авгай нь нүдээ бүлтийтэл гоёж гоодчихсон хүүхэн л байгаа биз гэж бодсоор иржээ. Тэднийд элдэв дээдийн аар саар юм ярьж төдхөн тэд нарыгаа мартчих юм боджээ. Гэтэл нас залуу, үзэсгэлэн гоо хүүхэн байхыг хараад ихэд татагдав. Керрийн нүдний зөөлөн харц, ичимхий зан байдлыг ажваас түүнд шалиг авгайчуулын шунал огт үгүй. Энэ эмэгтэй алдаагаар аль эсхүл амьдралын эрхээр доншуур худалдаачны занганд орсон байна гэдгийг Херствүд даруй ойлгоод, өөрөө сонирхож эхлэхдээ түүнийг өрөвдөх боловч өөрийн болгох гэсэн далдын санаагүй байсан хэрэг бишээ. Энэ хүүхэн Дрүэтэй байснаас надтай байвал өөрт нь хавьгүй дээр гэж боджээ. Дрүэг ийм хүүхэнтэй болсонд нь Херствүд амьдралдаа үзээгүйгээр атаархжээ.

Керри, Херствүдтэй сүүлчийн удаа уулзсанаас тахуунаараа Херствүдийг дагуулахгүй нь мэдээж.

Их хотод хээрийн сайхан салхи шиг амьтан ирж хөдөөний тунгалаг нарны цацрал нүдэнд нь гялалзана. Түүнд хар муу санаа, авангаар зан гэж байхгүй. Гэхдээ аль алиных нь эх сурвалж агчсан эрхтэн шиг байх л даа. Мэл гайхаж, цэл хөхөрсөн хязгааргүй их хүслэнгээсээ болоод шунах авангарлах ухаанаа ч одоохондоо олохгүй байгаа ажээ. Их хотод ирээд зүг чигээ ч олоогүй олон юмны учрыг ойлгож чадаагүй амуй. Херствүд түүнийг дөнгөж саяхан боловсорч гүйцэж байгаа жимс, дөнгөж дэлбээгээ нээсэн цэцэг хэмээн залуу халуун насы нь, эвдрээгүй зан төрхөнд нь унах болов. Дэргэд ь байхад зууны аагим халуунд аахилж уухилж сандарч явсан хүн гэнэт хаврын зөөлөн сэвшээ салхитай золгох шиг санагджээ.

Керри, Херствүдтэй сүүлчийн удаа уулзсанаас хойш яах ийх тухайгаа зөвлөн ярилцах хүнгүй болохоор ганцаар толгойгоо өвдтөл бодовч тууштай дүгнэлт хийж чадалгүй тэгсгээд орхижээ. Дрүү ямар ч атугай тус болсон хүн, бараг өчигдөрхөн муугаа үзэж явахад минь ач болсон хүнд сайн санахаас өөр хар муу санаж болохгүй гэж дүгнэлээ. Сайхан ч хүн, сайн санаатай ч хүн гэж бодоод яагаад ч юм амиа хичээсэн чанарыг нь эзгүй хооронд нь мартжээ. Гэсэн ч түүнээс хагацахын аргагүй тийм нандин сэтгэл байсангүй. Дрүү ч тийм гүн зузаан барилдалгаатай баыхг хүсэхгүй нь харагдаж байв.

Үнэнийг хэлэхэд доншуур худалдаач маань хөнгөмсөг шалиг зантай хүн болохоор ямар ч эмэгтэйтэй учирсан төдхөн сонь нь буурдаг ажээ. Тэгээд өөрийгөө хүүхний тэнгэртэй хүн гэж бодчихоод насан туршаа нэгээс нөгөөд очиж жаргалаа эдлэн хөөрцөглөж явна гэж боддог байж. Зарим нь нүүр өгөхөө болих юмуу, босгоороо алхуулахгүй байлаа гэхэд нэг их гонсойхгүй. Нас залуу, цус шингэн, ажил нь өөдрөг яваа хүн болохоор насан турш ингэж явсаар хорвоог барах юм бодно.

Херствүдийн хувьд гэвэл Керрид хамаг бие сэтгэлээрээ унаж өгчээ. Тодорхой төлөвлөсөн юмгүй боловч ямар ч атугай Керрийг биедээ татан буулгаж авахаар буцалтгүй шийдэв. Сормуус буулган, нүд буруулж, ичиж зовоод байхлаар нь энэ бол шунал тачаалын шинж гэж Херствүд бодно. Тэгээд байн байн уулзаж, гары нь атгаж, санаагий нь мэдэхсэн, цаашдаа яах бол хэмээн тэсэж ядан сонирхоно. Херствүд сэтгэлийн их донсолгоо, шаналгаа үзсэнгүйгээр олон жил болжээ. Одоо залуу зандан ансныхаа явдлыг сэргээж, сорьтой баатар эр шиг зоримог болов.

Ажил алба нь оройн цагаар яаж дураараа явах бололцоотой. Ер нь Херствүд хэзээний үнэнч сайн ажилтан гэж эзэддээ элэгтэй хүн болсон болохоор чөлөбөб зав гарган явахад цаадуул нь гоочилдоггүй байв. Зоогийн газрын эрхлэгчийнхээ үүргийг өдрийн ямар ч цагаар гялалзуулдаг хүн гэж мэдэх учир Херствүд хэдийд ч гараад явсан ялгаагүй, юу ч гэхгүй. Түүний цэвэрч нямбай, эелдэг зөөлөн ааш, намба нь тэр газрын нэр, ажилд тун сайн нөлөөтэй. Түүнээс гадна Херствүд олон жилийн туршлагаараа зоогийн газрынхаа чухал хэрэгцээт зүйлсийг арван хуруу шигээ мэднэ. Тэдний хүсний мухлагийн худалдагч, туслах ажилтан ганц нэгээрээ буюу олноороо ажлаас гаран солигдлооч гэсэн ялгаагүй, тэднийхээр байнга ирж идэж ууж наргиж байдаг хүмүүст үзүүлэх үйлчилгээнд өөрчлөгдсөн дордсон юм огт мэдэгддэггүй нь Херствүдийн чадамгай ажиллгааны ач ажээ. Өглөө орой гадуур гарлаа ч гэсэн арван нэг-хоёрын хооронд заавал буцаж зоогийнхоо газрыг хаахаас нэг хоёр цагийн урьд ирнэ.

“Жорж оо! Юм хүмээ шүүгээ савандаа хийгээд улсаа бүгдийг явах хүртэл өөрөө байсан дээр шүү” гэж Мой ноён нэг дуаа хэлснээс хойш Херствүд тэр олон жилийн тур тэр үгийг хууль шиг баримталдаг болжээ. Зоогийн газрын эзэд таван цагаас хойш эргэж ирэлгүй олон жил болсон боловч Херствүд тэднийг өдөр бүр ирж шалгадаг юм шиг тэр нэгэн удаа өгсөн зааврын нь

хэлбэрэлтгүй биелүүлнэ.

Керритэй уулзсанаас хойш хоёрхон өнүүд баасан гаригийн орой дахин уулзахаар шийдэв Тэсэж даанч чадахгүй болжээ.

- Ивенс, намайг хүн асуувал таван цагт ирнэ гээрэй гэж зоогийн газрын мухлагийн ахлагчид Херствүд хэлээд Медисон гудамж руу түргэн түргэн алхаж очоод морин трамвайд сууж хагас цагийн дараа Керрийн суудаг Огден-Скверт хүрэв.

Керри яг тэр үеэр салхинд гарах гэж цагаан саарал пальто дэгжин цамцаа өмсчихөөд малгай, бээлийгээ бэлдэж толины өмнө очиж бошинзондоо сүлжмэл захаа хийж байтал шивэгчин нь Херствүд ноён ирснийг мэдэгдэв.

Керри тэр үгийг сонсоод давсхийн биеэ барьж, гийчний өрөөнд түр хүлээж байна уу гэж хэл гэхихээд хувцас хунараа яаравчлан засаж эхлэв.

Тэр агшинд Керри, тэр хүнийг ирсэнд нь баярлаж гомдохоо алий нь ч мэдсэнгүй. Баахан цочмогдсон болохоор айсан буюу баярласандаа биш харин сэтгэл донсолсондоо нүүр нь халуу оргижээ. Юу ярих бол гэдгийг нь Керри таахыг ч оролдсонгүй, харин яагаад ч юм энэ хүн анад аятайхан санагдах юм, болгоомжтой л байх юм шүү гэж бодов. Тэгээд захаа дахин нэг засаад доошоо буув.

Сэтгэл ихтэй эрхлэгч маань ч баахан балмагдасхийх шиг бөгөөд энэ удаа шийдтэйхэн шиг байх хуна гэж бодож байтал дээрээс бууж байгаа Керрийн товор товор алхлах чимээ сонсдоход зориг нь мохож эхлэв. Керри, өөрт нь ямар байхыг лавтай мэдэхгүйдээ Херствүд зүрхшээх аж.

Харин Керрийг ороод ирмэгц залуу хүүхний үзэсгэлэн гоод сэтгэл нь сэргэж эхлэв. Эгэл боловч голшиг бие, бас нүүрэмгий биш тэр хүүхэн сэтгэлтэй хүнд хэзээдбурам сэргэмээр харагдана. Керрийн санадарсан нь Херствүдийн зоригийг чангалав.

- Сайн байна уу? Өнөөдөр гадаа тун сайхан байна, сууж байж чадсангүй гэж Херствүд давгай хэлэхэд Керри гийчнийхээ өмнө очиж зогсуут:

- Үнэхээр сайхан өдөр. Би ч гэсэн салхинд гарах гэж байсан юм гэв. Херствүд энэ үгийг нь сносоод:

- Өө, тийм үү? Тэгвэл хамт гарах уу, малгайгаа өмсчих гэж олзуурхан хэлэв.

Тэр хоёр цэцэрлэг дундуур гаран Вашингтоны модот гудамждаар оров. Энэ бол цардмал замтай, цаашилсхийвэл сүрлэг том том харш ярайн харагдана. Энэ гудамжинд хотын өрнө хэсгийн олон баячуулынх байх бөгөөд залуухан авгайтай хамт олны нүдэнд ил яваагаа бодохоос Херствүд дотроо ялимгүй бухимдаж байв. Гэтэл нэг догол гудамжинд “тэрэг хөлсөлнө” гэсэн хаяг харагдаж мань эрийг эвгүй байдлаас ангижрах бололцоо бий болоход Керрийг өөр нэг цэцэрлэгт гудамжаар зугаалъя гэлээ. Тэр үеийн цэцэрлэгт гудамж гэдэг нь энгийн гудамжнаас ялгагдахаар юмгүй байв. Керрид үзүүлэх гэсэн тэр газар нь бас л өрнө хэсэгт байх боловч нэлээд зайдуу бөгөөд хүн амьтан цөөтэй ажээ. Дуглас цэцэрлэг, Вашингтон буюу өмнөд цэцэрлэг хоёрыг холбодог гудамж юмсанж. Засмал сайхан зам нь өндөр ургасан өвстэй хээрийн дундуур таван бээр яваад зүүн тийш эргэнэ. Түүгээр явахад хүн хартай тааралдаж, хүүхэнтэй ярихад нь саад

болох юмгүй ажээ.

Херствүд зориуд номхон морь тэрэг шилж авсан бөгөөд төдхөн хүний нүд чихнээс далд газар очжээ.

- Морь жолоодож чадах уу? гэж Херствүд асуухад Керри

- Ер үзээгүй шүү гэв. Керрид жолоогоо өгөөд өөрөө элгээ тэврэн сууснаа Керрийг ажиглан инээмсэглэнэ.

- Амархан байгаа биз дээ, харахгүй юу.

- Номхон морь байн л даа.

- Тэгсгээд ямар ч морийг жолоодож чадах юм байна даа.

Херствүд ярианыхаа сэвдийг өөрчилж ажил хэргийн чанартай болгох ашгныг отож, хоёр дахин дуугай болж Керрийн үг яриаг бас тиймэрхүү зүгт хандуулахыг оролдсон боловч болж өгсөнгүй, хээв нэг ярьсаар л байлаа. Гэсэн ч Херствүд байн байн дуугай болчихоод байхлаар Керрийн анхаарал татагдаж бодлы нь тааварлав. Херствүд огт хамаагүй өөр юм бодох шиг гөлийх боловч чухам яагаад тэгж байгаа нь аяндаа мэдэгдэх тул одоо л эзгэгтэй үе болж буйг Керри ухаарч байв.

- Тантай танилцаад өнгөрөөсөн хэдэн орой шиг тийм сайхан жаргал нада байсангүй олон жил болжээ гэж Херствүд бодлогошронгуй хэлэхэд Керри хөнгөмсөг маягтай боловч тэр хүний дуу хоолойн учирлах өнгөнд уярч:

- Тийм гэж үү ? гэв.

- Би эртэд энэ үгээ хэлье гэж бодсон бодовч эв нь олдож өгөөгүй юм даа.

Керри хариуд нь юу гэж хэлэхээ сайн мэдэхгүй байх тул дуугай л үгий нь сонсож байлаа. Анх уулзсан цагаасаа тохитой томоотой ийм хүнийг ийм тийм гэж бодож болохгүй гэж санаж байсан хэр нь одоо дахиад л түүнд татагдаж эхэлжээ.

- Өнөөдөр би өөрийнхөө сэтгэлийг өөрт чинь хэлье гэж бодоод л зориуд ирлээ гэж Херствүд их л төв байдлаар хэлэв.

Херствүд угаас романтик, тэр бүү хэл, иймэрхүү нөхцөл байдалд бүр ч наалинхай зан гаргаж чадах хүн учраас үг хэл гүйцэгдэхгүй уран цэлмэг болоод явчихна. Түүний цэцэн цэлмэг үгнийх нь мөн чанар гэвэл биеэ хүчлэн барьж буй байдал, сэтгэлийн мэдрэц, дуу хоолойн өнгөөр тодрох ажээ.

- та, бодохул-гээд гар дээр нь алгаа тавьснаа цааш хэлэх үгээ яаж эвлүүлэхийг бодож дуугай болсноо-миний сэтгэлтэй болсныг мэдэж байгаа гэв.

Керри, түүний ийм үгийг сонсоод хөдөлж ч чадсангүй. Энэ хүний нөлөөнд дөрвөн мөчөө баглуулчих шиг болжээ. Хайр сэтгэлийнхээ үгийг илэрхийлэхийн тулд Херствүдэд нямбаны газрын чив чимээгүй байдал хэрэгтэй, тийм байдлыг Керри ч сахиж, нүднийхээ өмнүүр цэлийх

тэгш хээр талыг гөлрөн ширтэв. Херствүд түр зуур хүлгэлзэн дуугүй байснаа түрүү хэлсэн үгээ дахин нэг давтаж хэлэхэд Керри, дуулдахтай үгүйтэй:

- Та битгий ингэж ярь л даа гэв.

Керри чухам нэг юм дуугарах хэрэгтэй байсандаа л ингэж хэллээ гэдгийг мань хашир ойлгоод:

- Керри гэж нэрий нь дотночлон хэлээд, надад сэтгэлээ хайрлаач. Би бол хайрлах хүнгүй, үнэндээ ганцаардсан амьтан, намайг хайрлах хүн алга. Миний амьдралд сэтгэл тэжээж, сэргээх тийм ч юм алга. Дандаа л ажил хөөцөлдөж, өөрт минь ямар ч хэрэггүй хүмүүсийн төлөө үйлээ барж яваа хүн шүү дээ. Ийм хүнийг өрөвдөж сэтгэлээ хайрлаач, Керри минь гэлээ.

Хесртвүд ингэж хэлэхдээ өөрийгөө нээрэн ч өрөвдмөөр хөөрхий амьтан юм гэж бодов. Ер нь хэлж буй үгэндээ өөрөө үнэмшчихээд өөрийнхөө амьдралыг үнэхээр тийм гэж итгэхийг хичээв. Тийм ч учраас хоолой нь чичирч хажуугийнхаа хүний өрөвдөх сэтгэлийг улам булаана.

Керри өвөрдөж хайрласан том нүдээр харж:

- Хаанаас, та аз жаргалтай явалгүй яах вэ. Та амьдралыг их мэддэг хүн шүү дээ гэхэд Херствүд гунигтайгаар:

- Чухам аа, амьдралыг дэндүү сайн мэддэгтээ л зовж явна шүү дээ гэв.

Нийгэмд дээгүүр байр эзэлдэг, нэр нөлөөтэй хүн ингэж байгаа нь Керрид гүнзгий сэтгэгдэл төрүүлэв. Байдал ингэж өөр болж буйг бодохоос Керрид хачин санагдана. Ийм богино хугацаанд хөдөөний явцуу амьдрал, хуучин хувцас мөрөөс нь шувтран унах шиг алга болж, их хотын ээдрээт амьдрал оры нь эзэлчихдэг байна. Мөнгө ихтэй, дээгүүр албатай ийм хүн дэргэд нь суучихаад учирлаж байх бүр ч хачин санагдана. Харваас гачигдал зовлонгүй амьдрадаг, хүч нөлөө ихтэй, дээгүүр албатай үнэ цэнэтэй юм өмсөж зүүдэг ийм хүн ингэж гуйж гувшиж байх! Ийм юмыг зөв шударгаар онож хэлье гэхнээ Керрийн ухаан үнэндээ хүрэхгүй байв. Учры нь олно гэвэл толгойгоо зовоохын нэмэр гэж бодоод тэр хүний халуун сэтгэлийн илчинд баясах нь түүдэг галын дэргэд дулаацах бээрсэн жуулчин мэт авай. Керрид эргэлзэх юм хумсын чинээ ч үлдэлгүй, дур шуналынх нь дөлд мэлтэгнэн хайлчих шиг болов.

- Та намайг аз жаргалтай, хүн юундаа зовдог юм? гэж бодож байх шиг байна. Уулзаж учирдаг хүмүүс нь дандаа хүний үнэргүй өнгөн дээрээ мэхэлзэвч, үнэн чанартаа цэвдэг сэтгэлээс өөр бодолгүй хүмүүсийн цугладаг тийм газар өдөр болгон цагаа бараад, сэтгэлийнхээ үгийг ярьж, жаргал зовлонгоо хуваалцдаг ганц хүнгүй байх юм бол хүн өөрийгөө аз жаргалтай явна гэж болохгүй шүү дээ.

Тиймэрхүү зовлонг Керри өөрөө биеэр амсаан болохоор Херствүдийн үг тун оновчтой болов. Тоож үздэггүй хүмүүсийн дунд орж, ганцаардан явах ямаршүү байдгийг Керри андахгүй. Тийм юмыг андахгүй! Одоо чгэсэн ганцаардахгүй байгаа гэж үү. Таньж мэдэх хүмүүсийн дотроос хэн өрөвдөж байна? Хэнч байгаагүй. Харж үзэх хүнгүй, ганцаар хаягдаж, бишгүй тэнүүчилж үзсэн.

- Хэрэв та намайг хайрлавал, хэрэв би тантай уулзаж учирдаг найз чинь болохул элэг минь дэвтэхсэн. Тэгээгүй цагт сэтгэл ямагт дутуу, тогтож сууж чадахаа болилоо. Цаг ч өнгөрч өгөхгүй тарчлаах юм даа. Тантай уулзаж танилцахаас өмнө бодох санах юмгүй дэмий сууж, хэрэг явдлын

хар аяыг дагадаг байж. Өөрийг чинь харснаас хойш танаас өөр юм бодогдохоо болилоо.

Энэ хүн надгүйгээр үнэхээр сууж байж чадахаа больжээ гэсэн эрт урьдын хуурамч бодолд автсан Керри тэр ганцаардаж гансарсан эрийг өрөвдөж эхлэв. Ийм сайн сайхан яваа хэр нь ингэж зовж, гамайг гуйж царайдаж байгааг нь дээ би ч гэсэн өөрөө түшиж тулах хүнгүй ганцаар яваа шүү дээ. Ямар олиг байх вэ дээ гэж бодлоо.

- Би муу хүн биш шүү. Намайг замаа алдаад завхарч яваа хүн гэж бодож магадгүй, тийм биз? Нуух юу байх вэ? заримдаа болчимгүй зан гаргаж мэдэхээр байдаг, гэхдээ биеэ дор нь л татдаг даа. Хэрэв та миний амьдралыг өчүүхэн ч болтоугай бодвол би хуучин хэвдээ орж амьдралаа өөд татахад минь та л хэрэгтэй байна гэж албатай юм шиг тайлбар тавин учирлахад Керри түүнийг өрөвдсөн нүдээр харах нь бишдэж буй түүнийг үэнэ мөний нь замд оруулаад, х ишиг буянаа хүртээхэд бэлэн байгаагийн илрэл агаад дотроо: "Ийм хүний сэтгэлийг ариутгаж ядах юу байх билээ? Ийм сайхан хүнд хэдийхэн алдаа эндэл байх билээ? Их л бодож ялихгүй осол байгаа биз? тэр зэргийн юм байлгүй яах вэ" гэж бодно.

Ийнхүү Херствүд өөрийгөө Керрид тун их өрөвдөлтэй амьтан шиг бодогдуулж дөнгөв.

Ийм л юм байдаг юм байх даа? гэж Керри дотроо бодов.

Херствүд, нэг гараараа бүсэлхийгээр тэврэхэд Керри яаж ч чадсангүй. Нөгөө гараараа хуруугий нь аяархан атгалаа. Хавырн зөөлөн салхи савхийж, зам дээр хэвтэх өнгөрсөн намрын хуурай өвс навчийг хийсгэв. Жолоо нь алдуурсан морь залхуу нь хүрсэн мэт шогшино.

- Керри, чи надад хайртай юу, хэлээч? Гэж Херствүд дөнгөж дуулдахаар хэлэхэд Керри духайлаа.

- Хайрт минь намайг хайрлах сэтгэл байна уу? үнэнээ хэлээч гэж Херствүд сэтгэл догдлон гуйлаа.

Цаадах нь дуугарсангүй боловч мань эр санасандаа хүрч буйгаа мэдэрч:

- Хэлээч дээ, хайрт минь хэмээн бие рүүгээ татахад уруул нь хариугүй нийлэх дөхнө. Гары нь чанга атгаж байснаа тавиад хацры нь иллээ.

- Хайртай биз? гээд уруулаа уруулд нв наав.

Хариу хэлэх гэсэн Керрийн уруул хөдлөв. Херствүд сайхан нүдээ гялалзуулан бөөн баяртайгаар:

- Одоо чи миний хонгор, миний хайрт мөн биз! гэв.

Цаашид юу болсныг хэлбэл Керри толгойгоо мөрөн дээр нь аяархан буулгажээ.

НҮДТЭЙ СОХОР, НЭГЭН НӨЛӨӨ АРИЛАВ

Тэр орой Керри өрөөндөө бие тавиран, сэтгэл амран тун сайхан байв. Херствүдийн хайрын сэтгэл, бас өөрөө түүнд хайртайдаа баярлан ням гаригийн орой дахин уулзах болзоогоо бодон баясаж суув. Хэдийгээр нууж хаах хэрэгцээгүй мэт боловч чухам ийм зорилгоор л Керри хотын төв орж түүнтэй уулзахаар болжээ.

Керрийн ирж явааг Хейл авгай цонхоороо хараад “Хм, нөхрийгөө эзгүйд өөр хар хүнтэй зугаалдаг хүүхэн байх нь. Нөхөр нь яасан санаа амар амьтан бэ?” гэж бодов.

Иймэрхүү бодол ганц Хейл авгайн толгойд орсон төдийгүй Херствүдэд хаалга онгойлгож өгсөн шивэгчин ч бас л тиймэрхүү юм боджээ. Тэр бол Керрийг угаас ёозгүй, хүйтэн цэвдэг амьтан гэж боддог байж. Нөгөө талаар тааралдах бүрдээ ямар нэг аятайхан үг хэлж өнгөрдөг эгэл жирийн зантай Дрүүд тэр шивэгчин их сайн бөгөөд Дрүү бол ер нь бүсгүйчүүдэд дандаа тэгж нялуурхдаг зантай л хүн дээ. Харин Херствүд тийм биш, нэлээд ёсорхуу хямсгардуу байх учир тэр мэтийн хүүхэнд аятайхан санадахгүй. Яагаад Дрүү ноёнг эзгүй хойгуур Херствүд ноён ирдэг бол, Дрүүн хатагтай энэ хүнтэй хаачдаг юм бол гэж бодно. Ингэж бодсоноо гал тогооны тогооч хүүхэнд хэлчихжээ. Тэгсгээд шивэр авир яриа тэднийхээр нэг болов.

Керри Херствүдэд сэтгэлтэй болсноо гэнэт хэлсэн боловч хойшид чухам юу болох талаар бодоогүй байв. Эхний үед сэтгэлтэй болсон Херствүдийнхээ хайр, эрэхмсэг намба, сайхан төрснийг нь үргэлж бодох тул Дрүүг бараг мартаж байлаа. Анхны орой гэртээ ирээд Херствүдтэй хэрхэн зугаалж явснаа эхнээс нь эцсийн нь хүртэл нэгд нэгэнгүй нэхэн санасаар өнгөрөөжээ. Амьдралдаа анх удаа амраг хайрынхаа сэтгэлийг арвинаарторгилохыг мэдэрч огт өөр шинэ байдал бий болсныг мэдлээ. Урьд хожид үзэгдээгүй хүч нэмж, хамаг юм нүдэнд нь өөрөөр харагдан, алс тэртээд цоо шинэ гэрэл сүүмийн үзэгдэх шиг болжээ. Херствүд ариун замд оруулж, аминд нь орох хүч мэт бодогдоно. Ер нь сүүлийн үед болсон явдлуудаас Керри өөрийгөө буруу замаас гарах боломжтой боллоо гэж ихэд хөөрч байгаа нь сайшаалтай хэрэг юм. Гэхдээ Херствүд алсдаа чухам яах бодолтой байгаа нь мэдэгдэхгүй боловч ийм их хайртай хүн улам л сайн сайхныг хийнэ гэж Керри баттай итгэнэ.

Гэтэл Херствүд хойшдоо нэг их төвөггүйхэн шиг жаргаж цэнгэхийг л эрмэлзэнэ. Ийм явдал амьдралд нь арилдаг болж мэднэ гэж ч бодсонгүй. Алба ажилдаа суурьшсан, ар гэр санаанд нь хүрэхгүй ч гэсэн боломжийн бөгөөд өөрийн толгой мэдэлтэй л яваа хүн билээ. Керрийн хайр сэтгэлийг ужид цэнгэлдээ нэмэр хандив болох зүйл гээд хувь заяагаар олдсон тэр жаргалаа ханатлаа эдэлнэ хэмээн шүлэгтэнэ. Энэ хүүхэнтэй жаргалаа эдэллээ гэхэд амь ажилд алинд нь ч саад огт болохгүй гэж бодно.

Ням гаригийн орой Керри тэр хоёр Адамсын зүүн гудамжин дахь тэргүүн зэргийн нэг ресторанд орж тэндээсээ гарч хөлсний морин тэргэнд сууж гучин есдүгээр гудамжны ойролцоох Коттежгров модот гудамжин дахь тэр үедээ нэрд гарч байсан шөнийн зоогигийн газар луу явав. Керри, өөртэйгөө суух гэж тийм их хайртай юм байна гэж түүнийг хайрынхаа сэтгэлийг илчилснээс нь хойш бодох болсныг Херствүд ажиглажээ. Гэвч Керри түүнд яагаа ч үгүй нэг их нүүр өгөхгүй туршлага суугаагүй дурлалцсан хосуудад л байдаг тэр хэмжээнд нялуурах төдийхөн байдлаар мань эр тийм ч амархан идэш болохгүй хүүхэн юм гэж ухаараад нэг их улайран шавдалгүй биеэ барилаа.

Херствүд анхнаасаа Керрийг эр нөхөртэй гэж боддог царай гаргасан болохоор одоо ч гэсэн тэр хуурамч зангаа хэвээр байлгахаас аргагүй болов. Керрийг бүрэн ялахал нэлээд даваа байна, чухам хичнээн даваа байгааг тааж чадахгүй байлаа.

Огдан-Скверт буцаж ирмэгц Херствүд тэргэнээс гаралгүй,

- Дахин хэзээ уулзах вэ? гэхэд Керри өөрөө ч хэлж чадахгүй учир:

- Мэдэхгүй байна гэв.

- Дараачийн хоёр дахь өдөр “Зах” дээр уулзвал яасан юм? гэхэд Керри толгой сэгсэрч:

- Ийм түргэн үү? Яах юм гэлээ.

- Тэгвэл ингэе. Би баруун Хорооллын шууданд өөрөө авахаар захидал бичье, та хоёр дахь өдөр тэр захидлыг очиж авах уу? тэгэх үү? Гэхэд Керри тэгье гэлээ.

Дэлбэгч, Херствүдийн тушааснаар Керрийн байрны наад талын байшингийн дэргэд хүрч ирээд зогсов.

- Сайхан нойрсоорой гэж Херствүд ч шивнээд морин тэрэг ч хөдөллөө.

Энэ явдал улам газар авах шинжтэй байтал Дрүэ ирчихжээ. Маргааш орой нь Дрүэг орж ирэхэд Херствүд жижигхэн тасалгааныхаа бичгийн ширээний ард сууж байснаа доншуур худалдаачны орж ррэхийг хараад:

- Өө, сайн уу, Чарли? Буцаад ирэх нь энэ үү? Гэж нөхөрсгөөр мэднлэхэд Дрүэ оройтон ирж өрөөнийх нь үүдээр шагайн инээмсэглэж:

- Тэглээ гэв. Хертсвүд суудлаасаа босож:

- Өө, больж доо. Хэзээний гялалзаж явдаг хүн дээ гэж тоглов.

Тэр хоёр, танил тал хүмүүсийнхээ тухай, сүүлчийн үед дуулсан сонссон юмаа харилцан ярив.

- Гэрээрээ орсон уу? гэж Херствүд сүүлд нь асуухад Дрүэ:

- Ороогүй, одоо л харьж яваа маань энэ гэв.

- Би хүүхний чинь эргэж танайхаар орсон шүү. Ганцаараа уйдаж суух ямар сайн байхав гэж бодлоо.

- Их сайн байна, цаадхи чинь зүгээр биз дээ.

- Зүгээр, зүгээр. Өөрийг чинь их санадаг бололтой. Та бушуухан очиж хамт гарч уйтгары нь сэргээмээр юм даа.

- Тэгнээ одоохон очлоо гэж Дрүэ инээмсэглэн хэлэв.

- Лхагва гаригт та хоёр надтай хамт театрт очихгүй юу? гэж Херствүд сүүлд нь хэлэхэд Дрүэ,

- Баярлалаа, найз минь, цаадахи чинь юу гэх нь вэ мэдээд хэлье гэв.

Тэр хоёр тийнхүү их л найрсгаар саллаа.

Дрүэ тэндээс гараад Мэдисон гудамжаар эргэхдээ “Энэ мөн сайн хүн шүү гэж” бодлоо.

Дрүэ уг нь сайн нөхөр, гэхдээ Керрид хань болох хүн биш гэж Херствүд өрөө рүүгээ эргэхдээ бодов.

Керрийн тухай бодмогц дотор нь хачин сайхан болно. Тэгээд явал доншуур худалдаачныг араар нь тавьдаг билээ хэмээн бодов.

Дрүэ гэртээ ороод, Керрийг тэвэрч үнсэхэд Керри дотроо юм бодсондоо ялимгүя чичирхийлэв.

- Тун их амжилттай сайн явж ирлээ шүү.

- Тийм үү? Өнөөх надад ярьж байсан Ла-Кроссе дахь ажил чинь юу боло доо?

- Яриангүй сайнхан бүтсэн. Түүнд бүхэл бүтэн нэр төрлийн бараа худалдсан. Бернштейн пүүсний төлөөлөгч гээд бас нэг инээдтэй амьтан тэнд байсан, дэгээ шиг хамартай еврей хүн. Мань эр юу ч худалдаж чадсангүй. Би түүнийг долоо нугалчих хүн гэдгээ аргагүй л нэг үзүүлсэндээ.

Нүүр гараа угааж хувцсаа солих гэж ханцуйныхаа тээглүүрийг тайлан зуур яаж яаж явснаа тасралтгүй ярьсаар агаад Керри сонирхолтой яриаг нь бөрийн эрхгүй дуртай сонсож байлаа.

- Манай конторынхон бүгд гайхсан. Энэ жилийн дөрөвдүгээр улиралд манай пүүсний төлөөлөгчдийн дотроос надаас илүү бараа борлуулсан хүн байхгүй. Зөвхөн Ла-Кроссед би гурван мянган долларын бараа борлууллаа шүү дээ гээд Дрүэ хөөрцөглөн яриад түмпэнтэй усанд толгойгоо дүрж хүзүү чихээ гараараа үрчихдээ үлээж тугиж байхад Керри түүнийг ажихын хамт энэ хүнд урьд ямар байснаа одоо юу болчихоод байгаа тхауй элдвийн юм бодов. Дрүэ нүүрээ арчих зуур:

- Би зругаан сард нэмэгдэл авна. Ийм их орлого оруулж байхад надад өгөх л ёстой. Авахаа л авна, харж л байгаарай гэхэд нь Керри:

- Тэгэх л байлгүй дээ гэв.

- Тэгээд бас миний яриад байдаг өнөөх нэг жаахан ажил маань бүтвэл хоёул гэрлэнэ дээ гэж Дрүэ үнэн голоосоо ярьж буй мэт хэлээд толины өмнө очиж үсээ самнахад нь Керри:

- Чарли, чамайг надтай суух бодолтой гэж би итгэхгүй байна гэж гунигтай хэлэв. Саяхан Херствүдийн хэлж байсанд зоригжоод Керри ингэж хэлжээ.

- Өө, юү гэсэн үг вэ? сууна! Сууна гэж Дрүэ дуу алдаад:

- Чи яагаад ингэж бодох болов? гээд Керри рүү огцом эргэн ойртоход Керри түүнээс зугтмаар

анх удаа санагджээ. Керри хөөрхөн нүдээрээ эгцлэн харж:

- Ингэж яриад зөндөө удлаа шүү дээ гэв.

- Би ч өөрөө бодоод л байна. Гэвч бодсоноо хийхэд мөнгө л мэднэ шүү дээ. Одоо нэмэгдлээ авбал санасан бодсоноо биелүүлэхэд болно байх, болгоно доо. Битгий зовоод бай л даа хонгор минь гэхдээ мөрий нь өхөөрдөн алгадахад Керри үнэхээр итгэх найдвайргүйг мэдрэв.

Салхины хүрд шиг энэ эр надтай суух ямар ч бодолгүй бөгөөд өөрийн албан ёсны хүлээсэнд оруулснаас эрх дураараа явж байсан дээр гэж боддог хүн болохыг Керри сайн ойлгожээ.

Харин Херствүд бол үнэн үгтэй, буурь суурьтай хүн шиг санагдана. Хүний амьдралаар тоглох хүн биш бололтой. Өрөвчхөн сэтгэлтэй, хүнийг үнэлж ч чаддаг хүн. Дрүүг бодвол, үнэхээр амьдралдаа хэрэгтэй хүн гэж үзэж байна.

- Худлаа л даа. Та надтай хэзээ ч суухгүй гэж Керри зэмлэнгүй хэлэв. Хэлсэн үгийнх нь өнгөнд ялимгүй бардах шинж илрэвч арчаагүй гомдол давамгайлж байв.

- Жаахан хүлээзнэ. Харж л байгаарай, нэгэнт сууна гэснээс хойш сууж л таарна гэж Дрүү эцэст нь хэлэв.

Керри үнэн худлы нь сонжиж нүүр рүү нь ширтвэл огт үл тоомсорлох, жишимгүй байдал илхэн тул бодолдоо эргэлзсэнгүй. гэрлэнэ гэрлэнэ гэж ам дүүрэн амлахаас цаашгүйг нь лавтай мэдлээ. Дрүү, гэрлэх асуудлыг аятайхан шиг аргалчихлаа гэж хувьдаа бодоод:

- Хүүе, өнөөдөр Херствүдтэй уулзсан чинь чи бид хоёрыг театрт хамт орохгүй юу гэсэн шүү гэхэд тэр нэрийг сонсмогц дотор нь палхийсэн боловч ингэснээ мэдэгдэлгүй биеэ барьж чадав. Тэгээд

- Хэзээ гэнэ вэ? гэж жишимгүй царай гарган асуув.

- Лхагва гаригт, очих юм бхйгаа биз дээ?

- Чамайг очъё гэж байгаа бол яахав гэж Керри сэжиг төрүүлмээр биеэ барьж хачин хэлэхэд Дрүү мэдсэн боловч дөхнөгж саяхан гэрлэх тухай ярианаас болоо биз гэж боджээ.

- Манайхаар нэг ирсэн гэж байна билээ.

- Тэгсэн. Сайн өдрийн орой энүүгээр ирсэн.

- Тийм үү? Түрүүчийн долоо хоногт юмуу, тэр хавьцаа л ирсэн юмуу гэж бодсон шүү.

- Тэгэхдч бас ирсэн гэж Керри хэлэхдээ түүнд сэтгэлтэй хоёрын юу ярилцсаныг яаж мэдэх билээ. Керри мэл гайхахдаа буруу юм хэлчихэж энэ хоёрхын хооронд эвгүй юм болуузай хэмээн дотроо их л зовлоо.

- Тэгвэл хоёр ё дахин ирсэн байх нь уу? гэж Дрүү анх удаа нүүрэндээ ялимгүй гайхсан шинж илрүүлэн хэлэв.

Херствүд нэг удаа ирснээр хэлсэн нь Керрид тодорхой болсон ч гэмгүй царайлж:

- Тэгсэн шүү гэв.

Дрүэ, найзынхаа хэлснийг буруу ухаарсан юм байх гэж бодоод нэг их юм болгосонгүй боловч жаахан сониучлах маягаар:

- Юу гэж ярьж байна даа? гэхэд Керри:

- Намайг ганцаараа уйдаж байгаа байх гэж бодлоо гэнэ билээ. Өөрийг чинь зоогийн газраар нь очилгүй удсан болохоор яачихсан юм бол гэж бодлоо гэж байсан.

Дрүэ, найзынхаа тийнхүү санаа тавьсанд нь их баярлан:

- Жорж үнэхээр сайн хүн шүү. Заа хоолоо идэх үү дээ гэлээ_.

Прүэг Чикагод буцаж ирснийг Хесртвүд мэдээд Керрид имй үгтэй захидал бичжээ.

“Хайрт минь, чамайг эзгүйд танайхаар очсон гэсэн шүү. Чухам хэд гэдгээ хэлээгүй, мань хүн нэг удаа гэж ойлгосон байх. Юу гэж хэлснээ надад мэдэгдээч! Үүний хариуг тусгай зарлагаар явуулаарай. Би чамтай уулзмаар байна. Гурав дахь өдрийн хоёр цагт Жексон-Сруп гудамжинд надтай уулзаж чадах уу? Театрт очихоосоо өмнө хоёл уулзаж ярилцах юм байна”.

Керри тэр захидлы нь хоёр дахь өдрийн өглөө шуудангийн Баруун Хорооллын хэсэг дпээрээс аваад хариугий нь дор нь бичив.

“Таныг хоёр дахин ирсэн гэсэн шүү. Юм бодохгүй байх шиг байна лээ. Сруп гудамжинд очихыг л бодъё. Ер нь тун эвгүй вч болж байна. Би их л буруу юм хийж байх шиг байна”.

Херствүд, Керритэй болзсон газраа уулзаад сэтгэлий нь тайвшруулжээ.

- Сэтгэлээ бүү зовоо, хонгор минь. Цаадахыг чинь дахиад явах хооронд хоёул нэг юм бодноо. Хүнд худал хэлэх зовлонгүй болох вч хийнэ гэхэд нь Керри надтай юу юугүй суух юм байна гэж итгээд сэтгэл нь сэргэж, Дхзэг яван явтал аргалж л байя гэж боджээ.

Херствүд театрт очих оройн тухай зөвлөхдөө:

- Намайг урьд урьдынхаасаа нэг их илүү анхаарах хэрэггүй гэхэд нь Керри түүний сүрхий ширтдэгийг санаж:

- Та харин намайг битгий их ширтээд байгаарай гэв.

- Үгүй, үгүй гэж Херствүд Керригээс салж явахдаа гары чанга атгаж өнөөх үгүй үгүй гэсэн харцаараа нүүр рүү нь ширтэхэд Керри хуруугаараа зааж:

- Тэ-эр, дахиад л гэхэд Херствүд:

- Жүжиг эхлээгүй байна шүү дээ гэв.

Херствүд, Керрийн хойноос энхрийлэн харж зогсохдоо түүний залаа нас, ноо үзэсгэлэнд архианаас илүү мансуурав.

Театрт очоод Херствүд л хонжжээ. Керри урьд нь аятайхан хүн гэж боддог байсан бол одоо улам илүү дуртай болж хөдлөх гишгэх бүрий нь ажиглан дотроо бахдаж байлаа. Тэр хоёрт үйлчилж байгаа юм шиг зогсоо зайгүй чалчих хөөрхий Дрүэг Керри арай л мартчихсангүй.

Херствүд бол өчүүхэн ч сэжиг үл төрүүлэх ухаалаг овжин хүн. Магадгүй, найздаа урьд урьдаасаа арай ч илүү анхаарал тавьж байсан бөгөөд зүрхний хээ хайртай хүний өмнө түүнийг даажигнах, битүүгээр доромжлох тийм байдал огт гаргах хүн биш ажээ. Өөрөө муухай юм хийж буйгаа ойлгож байсан болохоор нөхрийгөө бас нэмэрт нь битүүгээр доромжлох санаагүй байна.

Гагцхүү тэдний үзэж суугаа жүжгийн дотор л Дрүэг даапаалсан мэт нэг шог үзэгдэл гарчээ.

“Гэрээ” гэсэн үзэгдэлд, эхнэр нөхрийнхөө эзгүй хойгуур нууц амрагийнхаа нялуун үгэнд уруу татагдсан тухай харуулжээ.

- Хохь нь больж, тийм мал шиг хар хүнийг тэгж л байвар таарна гэж Дрүэг хэлэхэд Херствүд:

- Юмыг яаж мэдэх вэ, нөхөр нь өөрийгөө огт өөгүй хүн гэж боддог байсан бөйх л даа гэж эелдгээр хэлэв.

- Эхнэрээ алдчихгүй гэж бодвол илүү анхаарах хэрэгтэй шүү дээ.

Тэд театраас гараад үүдэнд бужигнах ганган дэгжин үй олон хүний дундуур явав.

- Ноёнтон гуай, та нэг шөнө хоргодох орны мөнгө хайрлаач гэх дээ Херствүдийн хажууханд дуулдав. Херствүд энэ үед л Керрид нэг юм хэлж байлаа.

- Ноёнтон минь, надад унтах газар алга, бурхан минь.

Гачигдал зовлонд үнэхээр нэрвэгдсэн, яс арьс болтлоо турсан, гуч эргэм насны нэг хүн тийнхүү гуйлга гуйж байлаа. Түүнийг хамгийн түрүүнд олж харсан Дрүэ дотроо их өрөвдөн арван цент өгөв. Херствүд бараг ажигласангүй, харин Керри төдхөн мартжээ.

ХУУЧИН ХҮЛЭЭСНИЙ ЛАЙ. ЗАЛУУ НАСНЫ ГАЙХАМШИГ

Херствүд, Керрид сэтгэлтэй болох тусам гэрээ мартагч дөхөж, гэр орондоо хамтаатай юм бүхэнд хайхрамжгүй хандах болж байв. Өглөөнийхөө хоол, цайг идэж уухаар эхнэр, хүүхэдтэйгээ сууж байхдаа хүртэл огт өөр юм бодчихсон алмайрах болов. Уншдаг сонинхоо дотроос хүү, охин хоёрынхоо завааны нь гайхах шалиг сэдэвтэй юмыг илүү их сонирхох болжээ. Авгайгаасаа ихэд хөндийрсөн учир тэр хоёрын хоорондуур бие биеэ үл хайхрахуйн гүн их мөрөн зааг татан урсах болов.

Керритэй танилцсанаасаа хойш хотын төв рүү орой болгон явахдаа Херствүдийн хөл нь хөнгөрдөг болов. Үдшийн баруй бүрийд гудамж талбайн дэнлүү ч өөдөөс нь мишээх мэт санагдана. Нууц амрагийн хөлийг хурдасгадаг, аль язгуурын мартагдах дөхсөн урам одоо сэргэснийг мэдэрч байлаа. Өмссөн дэгжин гоё хувцсаа Керрийн нүдээр хардаг болж, залуу хүүхний нүдээр харахад тоогдохоор гангалдаг болжээ.

Сэтгэл санаа ь тийм болчихоод ьбайхад авгайнхаа дуу хоолойг сонсох юмуу, гэр орны аргагүй чухал ажил шаардагдахад дотор нь палхийж, би чинь хоёр хөлдөө дөнгөтэй хүн юм гэж бодно.

Авгай нь аль хэдийн чихэнд нь чийр болсон дуугаар:

- Жорж, морин уралдааны улирлын билет авч өгөөч гэв. Херствүдийн зэвүү хүрч чанга дуугаар:

- Заавал бүгдийг нь үзэх гээ юу? гэхэд нь авгай нь:

- Тийм гэлээ.

Тэр морины уралданаа гэгч нь Өмнөд хорооллын Вашингтон цэцэрлэгт мөд нээгдэх ёстой бөгөөд тэнд шашин шүтлэг багатай, хуучны ёсыг төий л үхширтэл баримталдаггүй тийм хүмүүс очдог юм байж. Херствүд авгай хэзээ ч улирлын билет авахыг шаарддаггүй байсан хэрнээ энэ жил хэд хэдэн учир шалтгаанаар тэнд байнгын суудалтай болохоор шийджээ. Нэгд гэвэл, тэдний хөрш, нүүрсний ажлаар хөлжиж мөнгөжсөн яРамсей гэгч эр эм хоёр улирлын билеттэй юм байж, нөгөө талаар, морины

Уралдаанд хорхойтой, тувт мөрий тавьж байдаг, тэднийд их таалагддаг эмч Бийл энэ жил шүдлэн үрээгээ уралдуулна гэсэн юм байж, гуравт гэвэл, Херствүд авгай, нас бие гүйцэж, улам царайлаг болж буй охин Жессикаа баячуулд харуулж, баян хүнтэй суулгах санаатай ажээ. Бас өөрөө таних хүмүүсийн дунд тийм юм үзэж, гайхуулж суух дуртай байсныг хэлэх юун.

Херствүд, тэр үгий нь сонсоод нэг хэсэг бодол болон дуугүй байв. Тэр хоёр хоёрдугаар давхарт гийчнийхээ өрөөнд оройн хоол идэхээр сууж байв. Энэ бол Херствүд, Керри, Дрүэ хоёртой театрт очиж “Гэрээ” гэдэг жүжиг үзэх орой байсан бөгөөд хувцсаа сольж өмсөх гэж л гэрээрээ орсон байж.

- Үзэх цагтаа л билетий нь авч байвал болохгүй юу? гэж Херствүд хатуу үг хэлэхгүйг хичээн асуухад авгай нь шууд:

- Үгүй ээ гэв. Херствүд зэвүү нь хүрч:

- За, чи битгий нэг их уурлаад бай, би зүгээр л асууж байна гэхэд авгай нь:

- Уурласан хүн алга. Чамаас улирлын билет авч аль гэж л гуйж байна гэж эрс хэлэв.

Херствүд авгай руугаа тунгалаг ширүүн нүдээрээ ширтэж:

- Тийм ч амархан олддог юм биш, эрхлэгч нь надад тийм билет өгөх болов уу, үгүй болов уу л гэж бодож байна, өөр юм алга гэв.

Тэгээд Херствүд үнэхээр хэнд нь хэлбэл олдох бол гэж бодлоо.

- Худалдаад л авч орхихгүй юу гэж авгай нь хэгжүүрхэв.

- Чи амархан юм ярьж байна. Улирлын билет гэр бүлээрээ авахад нэг зуун тавин долларын үнэтэй шүү дээ.

- Чамтай маргах хэрэг алга, тийм билет л авах хэрэгтэй байна, өөр олон таван үг алга гэж авгай эрс шийдэмгий хэлээд их л ууртайгаар босож үүд рүү явлаа. Херствүд урамгүй боловч дуугаа намсган:

- За яах вэ, аваад өгүүж гэлээ.

Оройн хоол идэхэд бас нэг сандал хоосон байх нь Херствүдийн суудал билээ.

Өглөө болоход Херствүдийн уур дарагдсан бөгөөд үдийн алдад өнөөх билетий нь олж авсан боловч хамаг асуудал хэвээрээ үлджээ. Херствүд цалингийнхаа ихэнхийг гэртээ өгдөг боловч цаадуулынх нь үрлэг хэтэрхий их учраас дургүй нь хүрдэг болжээ. Маргааш нь Жессика ээждээ:

- Ээж та дуулсан уу,, Спенсерийнхэн явах гэнэлээ шүү дээ? гэхэд:

- Үгүй, дуулаагүй, хааша явах нь вэ?

- Европоор явна гэнэ. Жоржина өчигдөр надтай уулзаад тэгж байна лээ. Нэлээд онгирч байгаа боллолтой гэхэд:

- Хэзээ явахаа хэлээ юу?

- Нэг дэх өдөр юмуу даа. Сонинд зарлуулах байлгүй, дандаа л тэгж байдаг даа.

- Тэгцгээж л байг. Бид ч гэсэн явахаа л явна гэж эх ньохиныхоо сэтгэлийг тайвшруулж хэлэв.

Херствүд сонингоо уншиж байх зуур нэг сөрвөсхийн харснаа юу ч хэлсэнгүй.

- Нью-Йоркаас Ливерпуль руу далайн хөлгөөр явна. Зуны ихэнхийг Францад өнгөрүүлнэ гэж ирээд л жигтэйхэн онгирч байна гэж Жессика танил охиныгоо элэглэн дууриагаад – муухай их онгирч байна лээ. Европод очихыг саахалт айлаараа орохоосоо ч амархан юм шиг ярьж байгаа юмаа гэв.

- Атаархсандаа болоод л чамд тэгж санагдаа биз гэж эцэг нь хэлэв.

Охиныхоо тийм их атаач занг бодохоос зэвүү нь хүрчээ.

- Битгий сэтгэлээзовоо, охин минь гэж Херствүд авгай уруул цорвойв.

- Жорж яваад өгөө юу? гэж Жессика нэг өдөр эхээсээ асуухад нь нэг юм болж дээ гэж Херствүд бодоод:

- Хаашаа явсан юм? гэж толгой өлийлгөн асуув. Урьд нь хэн хаашаа явсныг огт сонирхдоггүй байв. Эцэг нь иймэрхүү юмыг хичнээн их эмзэгхэн боддог болсныг Жессика анзааралгүйгээр:

- Битон руу явсан гэлээ.

- Яах гэж тийшээ явсан юм бол? гэж Херствүд асуухдаа иймэрхүү юмаар хөөцөлддөг болсондоо дотроо зэвүүрхэв.

- Теннисний тэмцээнтэй юм гэнэлээ.

- Надад юу ч хэлээгүй шүү дээ гэж Херствүд доторх шаналгаагаа нууж ядан хэлэв.

- Мартчихсан юм байлгүй дээ гэж авгай нь хажуугаас хошуу нэмэв.

Херствүд урьд өрхийн тэргүүлэгч эцэг хүний хувьд тэдэндээ аюулын хүндтэй хүн байв. Ялангуяа охинтойгоо овоо дотно. Гэвч дотно гэдэг нь ёс төдий болохоос, эцэг үрийн халуун дотно хайр биш байсан бөгөөд хүүхдүүд нь гэр орныхоо явдлыг эцэгтээ падгүй гэсэн байдалтай ер хэлдэггүй байжээ. Тэдний амьдралын нарийн ширийн юмыг Херствүд огт мэдэхгүй. Хоол ундан дээрээ л хааяа тааралдана уу гэхээс биш тэр болгон тааралдахыг больжээ. Заримдаа тэдний хэн нэг нь тэгж ингэж гэдгийг тохиолдлын маягтайгаар сонсон уу гэхээс биш эзгүй хойгуур нь юу юу болсныг, одоо яах гэж буйг нь чих тавин сонсовч ухааны нь олохгүй өнгөрөх явдал олонтаа тохиолдох болжээ. Жессика өөрийн явдлыг өөрөө л мэдэх ёстойгоос биш өө хэнд ч падгүй гэх болж. Хүү Жорж нь ч гэсэн өөрцгүй хэнээр ч заалгахгүй гэсэн аавын цээж гаргадаг болсон байлаа. Энэ бүгдийг Херствүд мэдэж, өөрийг нь тоохгүй болцгоосонд нь гоморхон зэвүүцнэ. Ажлынхаа газар нэр хүндтэй атал гэр орондоо үнэ цэнэгүй хүн болж хувирахыг хэрхэвч тэвчимгүй санагдана. Авгай нь ч гэсэн өөрцгүй нэг их тоомжиргүй, биеэ би гэсэн амьтан болсонд бүр ч аазгай нь хөдөлнө. Херствүд тэвчээр гарган дуугүй байж, хэрэгтэй мөнгийг нь өгсөөр л байлаа.

Херствүд гэр орнырондоо тоогдохыг байлаа ч гэсэн хайрлах хүнтэй гэж сэтгэлээ зогооно. Эднүүс яавал яаж л байг, надад Керри бий шүү дээ гэж бодохдоо Керритэй хэдэн оройг сайхан өнгөрөөж байснаа санаж Дрүэгээс салгаж аваад аль нэг жижигхэн тохилог өрөөнд түүнийгээ хүлээлгэн байх цаг ирнэ гэж бодохоос сэтгэл нь сэргэнэ. Дрүэ, намайг арай эхнэр хүүхэдтэй хүн гэж Керрид ярих далим гарахгүй биз гэж Херствүд найдна. Юм бүхэн санаснаар нь сэтгэлчлэн бүтэж байсан болохоор хойшид ч санаа зовоох юм гарахгүй гэж итгэнэ. Керрийг ятгасаар өөрийн болгох цаг удахгүй ирнэ, тэр цагт жаргалаа эдэлнэ гэж шүлэнгэтнэ.

Театрт хамт юм үзсэнээс хойш Херствүд Керрид өглөө болгон захиа бибиж шууданд хийгээд хариу нэхдэг байв. Херствүд зохиолчийн авьяас билэггүй боловч амьдралын туршлага, улам бүр оргилон буй хайр сэтгэлийнхэ хүчээр үг хэл нь овоо эвлэх болжээ. Ажлынхаа газрын жаахан өрөөд бичгийн дасгал хийх бололцоотойн дээр багц дугтуй сайхан үнэртэй захидлын цаас авч

ширээний шургуулганд хийжээ. Шөнийн зоогийн газрын эрхлэгч тийнхүү байнга юм бичиж суудаг болсонд нөхөд нь баахан гайхна. Тэнд ажилладаг мухлагийн худалдааны таван хүн эрхлэгчийгээ тийнхүү бичиг сачгийн ажлаар толгой өндийх завгүй шахам оролддог болсонд нь их л хүндэтгэнэ.

Херствүд өөрөө гэсэн үг нь аяндаа урсан орж ирдэг болсонд гайхна. Хүний үйл ажиллагааг удирдаж байдаг байгалийн хууль ёсоор түүний бичиж байсан зүйлүүд өөрт нь эргээд нөлөөлж байв. Үгээрээ илэрхийлж байгаа тэр бүхий л нарийн нандин зүйл нь түүний биемахбодид ч тусгалаа олж эхэлжээ. Шинээр олсон өгүүлбэр бүхэн нь ухааных нь царыг тэлж байв. Үгээр илэрхийлж байсан дотоод сэтгэлийн хүч нь өөрт нь нөлөөлсөөр ваай. Керри бол хэлж буй үгтэй минь тэнцэх хүн гэж Херствүд итгэж байлаа.

Залуу нас, гоо үзэсгэлэн нь ид цэцэглэж яваа Керрид үнэндээ Херствүдийн унах нь аргагүй. Долингоршсон амьдралаар залуу насныхаа гоо үзэсгэлэнг бузарлаагүй байгаа бахдууштай. Хөөрхөн нүдээр тормолзон харах нь цөхөрсний шинж тэмдгийг үл илэрхийлэх бөгөөд сэтгэл нь догдолж уйтгарлан гуньж гутрах явдал байвч гүнзгий ул мөр үлдээлгүй гагцхүү харах харц, хэлэх үгнийх нь өнгөнд болгоомжлолын шинж бий болжээ. Заримдаа ярихдаа бюуу дуугүй байхдаа ч уруул ам нь өмөлзөсхийн уйлах нь уу гэмээр харагдах нь гутралаас болдог биш зүгээр л зарим үг хэлэхэд ам нь эвлэхгүй тэгдэг бөгөөд энэ нь их л өрөвдөлтэй өнөөрдмөөр сэтгэгдэл төрүүлэх ажээ.

Түүнд давилуун зан байхгүй. зарим хүүхэн гоо үзэсгэлэндээ эрдэж дэрэлхүү аашилдаг бол амьдрал тийм зааг түүнд бий болгосонгүй. Өөрт нь хүний хайр халамж хэрэгтэй байхад яаж давилуун зан гаргах билээ л. Одоо ч гэсэн биедээ итгэж чадахгүй эмээнгүй байх боловч урьдынтайгаа бас адилгүй болсон нь амьдралдаа багагүй юм амсаж үзсэнийх бизээ. Керри, жаргал цэнгэл, ихэс дээдсийн хүрэлэнг мөрөөдөх боловч чухам энэ нь юу болохыг мэдэхгүй байлаа. Хүний рээн бараан амьдралын мөч бүр нь ямар нэг зүйлийн учир утгыг нээн өгөх бүр түүний хүслэн нэмэгдэж юм бүхнийг мөрөөдөх болж байлаа. Зарим хүн нэг мэдэхнээ л гоо үзэсгэлэн үлэмжийн төгөлдрийн туйлд хүрсэн байх жишээтэй амуй.

Керри, сэтгэлийн ихээхэн хөдөлгөөтний хүний эгнээнд багтах хүн. Олон юмнаас болж элэг нь эмтэрч ядуу дорой амьтдыг үнэн голоосоо өрөвдөнө. Зовлонд дарагдаж ухаан бодол нь эргэсэн, царай нь цонхийж, хувцас нь навтас болсон тийм хүмүүсийг хараад зүрх аандаа шимширнэ. Орой болохоор тэртээ Баруун хорооллын аль нэг үйлдвэрийн газар ажиллаж байгаад гэр рүүгээ хаьж яваа муу хувцастай явуу хүүхнүүд цонхны нь дэргэдүүр амьсгаадсаар өнгөрөхийг хараад үнэн сэтгэлээсээ өрөвдөж хөмхийгөө зууж, гунигтайгаар толгойгоо сэгсрэн гүн бодолд автана. “Даанч ядуу улс юм даа, хөөрхий. Эдлэх юм, өмсөх хувцасгүй байх шиг хэцүү юм хаанаа байх вэ” гэж бодно. Үжирч гандсан хувцас хунары нь хараахс нүд хальтрах ажээ.

“Ийм атлаа хийх ажлынх нь хэцүүг ээ!” гэж бас бодно.

Заримдаа зээтүү барьсан ирланд хүн, хүрз барьсан нүүрсичн, гагцхүү хар хүч шаардах хар ажлын амширик хүмүүсийг гудамжинд явахы нь хараад ихэд өрөвдөнө. Урьд өөрөө зовлонгийг нь амсаж байсан боловч одоо нэгэнт ангижирсан тэр хүнд хүчир ажлыг бодохоос ухаанд нь багтамгүй санагдана. Заримдаа цонхных нь хажуугаар гарах хүний дүрс гурилын тээрэм дээр ажиллаж байгаад ирэхдээ нүүр ам нь нэл гурил болчихсон ирдэг нас дээр гарсан аавы нь санагдуулна. Хамаг чадлаараа алхдаж байгаа гуталчин, дархны газрын төмөр улайсгадаг зоорины жижигхэн цонхоор харагдах тугалга гүйлгэгч ажлынхаа ширээний ард гадуур цамцаа тайлж, ханцуйгаа

шамлан юм хийх слесарь энэ бүгдийг харахад хуучин гурилын тээрмийн тухай өөрийн эрхгүй бодогдоно. Их л гунигтай санагдах боловч үүнийгээ тэр болгон үгээр илэрхийлэх нь үгүй. Саяхан өөрөө дотроос нь мултарч гарсан бөгөөд наана цаанагүй сайн мэдэх хүнд хүчир хөдөлмөрийн ертөнцийн ядуу хүмүүсийг бодохоос өрөвдөнө. Херствүд, сэтгэлтэй болсон залуу хүүхнийхээ хичнээн сайхан нандин сэтгэлтэйг мэдэхгүй, өөрөө чухам тийм зан төлөвт нь татагдсанаа ухаарахгүй байла. Хайр сэтгэлийн гүн учир шалтгааныг өөрөө ойлгох гэж оролдсонгүй. Уг нь Керрийн усгал зөөлөн харц, эмэгтэй хүний жинхэнэ намба төрх, амьдралд итгэсэн бодь сайхан санаа сэтгэлд нь л унасан хүн дээ. Анхилмал сайхан үнэр, цагаан лавайн үзсгэлэнт өнгөө Херствүдийн хэзээ ч гүнд нь хүрч чадаагүй, тийм гүн уснаас хүртдэг учры нь яагаад ч ухаарч чадахгүй тийм орчноос үүссэн сараанаа цэцгэнд Херствүд татагдсан хэрэг билээ. Лавайн сайхан өнгөтэй, онгон сэргэг сэтгэлийг сэргээж, амьдралыг утгатай болгох байсан болохоор л Херствүд тэр цэцгэнд шохоорхсон хэрэг.

Эд агуурсын хувьд ч гэсэн Керри овоо нэг юм юмтай болсон байлаа. Өмсөж зүсэн нь хэлэх өөгүй биш ч гэсэн төрсөн биенийх нь гоо үзэсгэлэнд нэмэр болжээ. Өндөр өсгийтэй жижигхэн шаахай хөлд нь зохисныг яана. Бүсгүй хүний гоо үзэсгэлэнд аар саархан эд өлөг хичнээн чухал байдгийг Керри сүрхий ойлгосон бөгөөд ялимгүй мах суун бөйргашиж буй учир улам ч цэврүү шиг харагдах болжээ.

Херствүд нэг өглөө Керрийг Монроэ гудамжинд байдаг Жефферсоны цэцэрлэгт уулзъя гэж бичжээ. Дрүэг ялангуяа гэр орондоо байхад нь Керри дээр очих нь эвгүй юм гэж боддог болжээ.

Маргааш нь Херствүд тэр жижигхэн сайхан цэцэрлэгт үдийн нэг цагт ирж замын нэг хажууг эмжин ургасан голт бор цэцэгт модны ногоон гнавчны дор, нэгэн модон сандал дээр суугаад хүлээж байлаа. Ид хаврын шинж хэвээрээ шахам тийм үе байлаа. Тэрүүхэнд харагдах жижигхэн цөөрмийн усанд сайхан хувцастай хэдэн хүүхэд далбаат онгоц хөвүүлэн тоглож харагдана. Ногоон сүмийн сүүдэрт мончуургаа бүсэндээ хавчуулж, хоёр гараа элгэндээ тэвэрсэн цагдаа байна. Том хайч барьсан өвгөн цэцэрлэгч бут сондуул аялуулан бөртөгнөнө. Дээш харвал ирж буй зуны хөх тэнгэр цэлийн, модны өтгөн мөчрийн дотор завгүй их ажилтай болжморууд дэвхрэлдэн үглэн шулганана.

Херствүд тэр өглөө гэрээс бас л уруу царайтай гарчээ. Зоогийнхоо газар ирээд захидал бичих хэрэгцээгү йбайсан болохоор нэг хэсэг дэмий холхив. Харин цэцэрлэгт ирмэгц дотор нь онгойж хийморь сэргэснийг нь бодоход сэтгэлийн түгшээгээ дарж чаддаг хүмүүсийн шинж билээ. Одоо сэрүү татсан ногоон моддын дунд суух зуур сэтгэлтэй хүний талимаартсан нүдээр энэ тэрийг ажиж байна. Хажуугийн гудамжуудаар чих дөжрөм дуу ихт тэргүүд зөрөлдөх боловч чихэнд нь чийр болох байтугай алс холын үл мэдэг анир мэт санагдах агаад хааяа жингэнэж хангихнах хонхны дуу хөгжмийн эгшиг уянгалах мэт амуй. Хесртвүд орчноо ажин хараад одоогийнхоо амьдралд огт хамаагүй элдэв юмыг нэхэн санав. Эхнэр аваагүй, нийгэмд олигтой байр суурь эзэлж чадаагүй байсан цагаа саналаа. Танил хүүхнүүдтэйгээ уулзан бүжиглэн, гэрт нь хүргэж өгдөг үүд хаалган дээр нь хүлээн зогсдог байснаа саналаа. Болдогсон бол хуучнаа хэвээр нь болгохсон гэж бодохдоо Херствүд дотроо нээрэн ч болмоор санагдсандаа ингэж бодов бололтой.

Хоёр цаг болоод Керри улаа бутарсан хацартай, ширүүн гар ч хүргэмээргүй сайхан амьтан товор товор алхсаар хүрч ирлээ. Худалдаж аваад удаагүй одтой цэнхэр торгон тууз бүхий том хүрээтэй бүрх малгайгаа өмссөн байлаа. Сайн чанарын нарийн хөх ноосон даавуун банзал, нарийхан нарийхан хөх судалтай цав цагаан цамц өмссөн нь ургасан мэт зохижээ. Хөлдөө хүрэн өнгийн

гоёмсог шаахай углажээ. Бээлийгээ гартаа барьсаар байв.

Херствүд бахдан харж:

- Хайрт минь хүрээд ирэв үү гэсээр босож гараас нь барьж авлаа.
- Ирэлгүй яах вэ, намайг ирэхгүй нь гэж бодоо юу? гэж Керри инээж хэлэв.
- Лавтай ирнэ гэж бодоогүй шүү.

Херствүд нүүр рүү нь харахдаа яарсандаа халууцан хөлөрсөн байхыг үзээд халааснаасаа сүрчиг ханхалсан торгон алчуур гарган нүүрнийх нь хөлсийг аяархан аярахан дарж арчив.

- За, одоо мөн сайхан байна даа гэж Херствүд энхрийлэн хэлэв.

Тэр хоёр тийнхүү уулзан хамт байхдаа бие биеийнхээ нүд рүү ширтэн их л баяртай байна. Баахан тэгж байснаа Херствүд:

- Чарли хэзээ явах нь вэ? гэж асуухад Керри:
- Мэдэхгүй, гэр орны ажил нэлээд байна гэж байна лээ гэв.

Херствүд хөмсөг зангидан юм бодож хэсэг дуугүй байснаа:

- Чи салчих гэж өөдөөс нь харж хэлэв.

Тэгээд цөөрмийн дэргэд тоглож байгаа хүүхдүүд рүү хараагаа шилжүүлэх нь салах сарнихыг даанч шальгүй юм гэж үзсэн шиг байлаа.

- Салаад хаашаа очих вэ? гэж Керри хэлээд бээлийгээ нухлан хамгийн ойрхи нэг мод руу харлаа.
- Өөрөө хаана баймаар байна?

Ингэж асуусан дууных нь өнгөнөөс уламжлан Керри, энэ хотод л лав байж болохгүй шүү дээ гэж хэлмээр санагдаж:

- Энд л лав байж болохгүй гэжээ.

Херствүд ийм үг сонсоно гэж зүүдлээ ч үгүй байв. Энэ хотоос гарч явах дэр хүрнэ гэж огт бодсонгүй. Тэгээд:

- Яагаад тэр билээ? гэж зөөлнөөр асуулаа.
- Яагаад гэвэл... би энд баймааргүй байна.

Херствүд, Керрийн энэ үгийн учрыг муухан гадарлав. Керри нэг их шамдаж хэлээгүй болохоор хариу үг нэн даруй хэлэх хэрэгцээгүй байв.

- Тэгвэл би ажлаасаа гарахад хүрэх нь ээ.

Түүний хэлж байгаагаас бодоход ажлаасаа гарах нь тийм ч их сүйдтэй юм биш мэт. Керри цэцэрлэгийн байдлыг ажиж юм хэлэлгүй байснаа:

- Би түүнтэй нэг дор байхыг хүсэхгүй байна гэж Дрүэтэй нэг хотод байх хүсэлгүйгээ хэлэв.

- Чикаго хот том шүү дээ, хонгор минь. Өмнөд хороололд шилжлээ гэхэд л Америкийн өөр нэг хэсэгт нүүж очсоноос өөрцгүй болно.

Тэр хороололд суулгая гэж аль түрүүний бодож байсан бололтой.

- Ямар ч болтугай түүнийг энд байгаа цагт би хүнтэй суухгүй. Тэрнээс оргох хүсэл алга.

Гэрлэх тухай үг сонсоод Херствүд толгой руугаа татуулах шиг болов. Хэлж буй үгнийх нь цаана ямар санаа байгааг мань эр ойлгоод тийм ч амар шийдэх юм биш гэдгийг ухаарч, хоёр эхнэртэй болж таарах нь гэсэн бодол толгойд нь зурвасхийв. Энэ ер юугаар төгсөхийг гадарлахад хэцүү болж, шалиглах гэсэн ажил нь ахиц олох нь бүү хэл харин ч өөрөө энэ хүүхнийг хүндэтгэж үзэхээс өөр замгүй болов. Тэгээд Херствүд өөдөөс нь харвал Керри улам ч хөөрхөн харагдах тул ийм хүүхний амраг байх ямар их аз завшаан бэ, юу л болбол юу болтугай, дүүрсэн хэрэг, хөөцөлдөх л хэрэгтэй гэж бодлоо. Керри амархан бууж өгөхгүй байгаа нь Херствүдэд сайхан санагдаж хөөцөлдөх ажлаа урамтай хэрэг болох нь гэж бодлоо. Өөрснөө гуйгаад ирдэг хүүхнүүдээс хамаагүй ялгаатай юм гэж бодсоноо тэдний тухай бодохоо нэн даруй болив.

- Чухам хэзээ явах юм бол? гэж Херствүд тайван асуухад Керри толгой сэгсрэв. Херствүд, хэсэг дуугүй байснаа:

- Та ер нь их зоримог эмэгтэй юм гээд нүүр рүү нь ширтлээ.

Керри дотроо ихэд баярлан сэтгэл нь догдолж, өөрийг нь ийнхүү бишрэн гайхаж бас өндрөөр үнэлж байгаа хүндээ талархаж: - Тийм их зоримог санагдаж бахйна гэж үү? Яавал таарах байсан юм бол доо гэж зориг муугайхан хэлэв.

Херствүд гара базалж дахин тэртээ харагдах ногоон зүлэг ширтлээ. Тэгснээ оволзон хөөрөх сэтгэлдээ дийлдэн:

- Тэр хүнээ орхиод над дээр ир л дээ, би таньгүйгээр сууж чадахаа больсон хүн. Хүлээхийн хэрэг юу байна, тэглээ гээд та аз жаргалтай байх юм уу? гэв.

- Аз жаргалтай манатай, ямар байгааг та андахгүй шүү дээ.

- Тэгвэл та бид хоёр цаг хугацаа дэмий алдаж байна шүү дээ. Таныг аз жаргалтай бишийг мэдсээр намайг аз жаргалтай байж чадна гэж бодоогүй биз дээ? Би ер нь өдөржин танд захидал бичсээр өнгөрөх болсон гэж түрүүчийнхээ янзаар ярьж байснаа дуу нь өндөрсөж – Керри минь аан гэж байгаач хэмээн сэтгэлийнхээ гүн догдлолыг дуу хоолойныхоо хүчээр илчлэх гэж чармайн – Би таньгүйгээр амьдарч чадахгүй нь ээ, ийм л байна! Би одоо яах вэ, надад хэлж өгөөч! гэж гарынхаа алгыг дээш харуулан цөхөрсөн байдалтай хэлэв.

Хэрхэхийг өөрөө сэдсүгэй хэмээн эрх мэдэл олгосонд Керри баярлан, хүндийнх нь жин үл мэдэгдэх тийм ачаа үүрэх болсонд сэтгэл нь баясаж:

- Та жаахан хүлээзнэ л дээ, би хэзээ явахы нь мэдээдэхье гэж дотночилсон байдалтай хэлэхэд Херствүдийн сэтгэл ихэд догдолсон хэвээр:

- Тэгээд ямар хэрэг байна даа? гэв.

- Тэр хооронд нь нэг тийш явах юм бодвол яасан юм?

Керри, Херствүдийн алсын санааг лавтай мэдэж чадаагүй атлаа арга баашинд нь орж, эмэгтэй хүний өрөвчхөн сэтгэлдээ хөтлөгдөж байлаа. Харин Херствүд эний нь ойлгосонгүй, яавал Дрүүгээс салгаж холдуулах вэ гэж бодохын хамт Керри өөртөө хэр зэрэг хайр сэтгэлтэйг нь мэдэхсэн, яасгээд үнэний нь хэлүүлье дээ гэж бас бодно.

Яваандаа хүний жинхэнэ хүсэл мөрөөдлийг халхлан байдаг агаад зам дээр нь тохиолдох саад тотгорын учрыг тодотгож тэгснээрээ мултран гарах ямар нэг гарц зааж өгдөг тийм адармаатай асуудал Херствүдийн толгойд харьяан орж ирэх шиг болжээ. Хэлсэн тэр үг нь санаж байсантай нь таараагүйгээр үл барам бодлоос нь урьтаад амнаас нь гарчихжээ.

Херствүд, Керрийн өөдөөс эгцлэн ширтэж үнэн голоосоо хэлж буй мэтээр – Керри, Керри, хэрэв би рэх долоо хоногт юмуу, эсвэл энэ долоо хоногт, бүр, өнөөдөр ч юмуу өөр дээр чинь гэнэт очоод, би энд ганц минутын төдий байх бололцоогүй дахин хэзээ ч эргэж ирэхгүй боллоо гэвэл та намайг дагаад явах уу гэлээ.

Сэтгэлтэй бүсгүй нь итгэл дүүрэн нүдээр харж Херствүд үгээ хэлж дуусахаас ч өмнө хариу нь бэлэн болж:

- тэгэлгүй яах вэ гэлээ.

- Юу ч гэж маргахгүй, юу ч гэж цааргалахгүй юу?

- Танд хүлээх завгүй бол, хаанаас цааргалах вэ.

Хэлсэн үгэнд нь үнэнээсээ итгэснийг Херствүд мэдэн инээмсэглэж, нэг хоёр долоо хоног хичнээн аятайхан байж болох боломжийг харав. Тоглосон юм даа гэж хэлээд үнэнээсээ итгэж байгааг нь болиулж болох байсан боловч тийнхүү итгэж байгаа нь тун сайхан санагдсагн тул мань хүн хэлэхээ болихоор шийджээ. Тэгээд бас нэг бодол орж ирмэгц:

- Энд гэрлэх зав гарахгүй бол яах вэ? гэхэд Керри,

- Зорьсон газраа очмогц л гэрлэвэл болох нь тэр шүү дээ гэхэд Херствүд:

- Би бас тэгж бодсон гэв.

- Уухай.

Энэ өглөө Херствүдэд урьд урьдаас улам ч илүү цэлмэг сайхан санагдаж, яаж ийм мэргэн бодол орж ирэв гэхээс инээдэ барьж ядна. Тийм үг олж хэлж байж л Керрийн сэтгэлийг мэдэж чадлаа. Тэгэхлээр одоо эргэлзэх юм алга болж бушуухан дур хүслээ хангахыг бодов.

- За би өөрийг чинь нэг л мэдэхэд очоод аваад ирнэ дээ гэж тоглосон маягтай хэлэхэд Керри,

- Тантай гэрлэхээс нааш хамт байхгүй шүү харин гэж бодлогошронгуй хэлэв. Херствүд:

- Тэгэлгүй яах вэ гэж нялуурхан хэлээд гары нь атгалаа.

Юм бүхэн тодорхой болов гэж бодохоос Керри туйлын их баярлана. Херствүдийг аврагч ачтай хүн юм даа гэхээс улам хайрламаар санагдана. Гэтэл Херствүдэд гэрлэх бодол огт үгүй, харин Керри нэгэнт ийм сайн, ийм сэтгэлтэй байгаа хойно зуурдын жаргал цэнгэл маань саадгүй болов хэмээн боджээ.

- Жаахан хамт алхах уу даа гээд Херствүд суудлаасаа босож тэр сайхан цэцэрлэгийг нүд хэсүүлэн харав.

- За тэгье гэв.

Тийнхүү нэг залуухан ирланд хүний хажуугаар алхан өнгөрөхөд тэр хүн мань хоёрыг атаархсан нүдээр харж “Яасан сайхан хос вэ?” лав баян улс байх гэж” боджээ.

МУНХАГ АЛАДИН, ОРЧЛОНГИЙН ХААЛГА

Дрүэ Чикагод буцаж ирснээс хойш өөрөө гишүүнээр орсон Хандгайн Нийгэмлэг гэгчийнхээ талаар нэлээд анхаарах болсон аж. Саяынхаа явалтаар нийгэмлэгээ тун чухал ач холбогдолтой юм гэсэн бодолтой болсон байлаа. Өөртэй нь ижил нэг доншуурч хэлэхдээ: “Тун их ашигтай юм шүү. Хазенштабыг харахгүй юу. Уг нь суусан газраасаа шороо атгах ухаантай хүн биш, өөдрөг пдүүсэнд ажилладаг хүн, гэхдээ ганц түүгээр хол явахгүй, гэсэн ч сасонд дээгүүр байр суурь эзэлдэг, тэрнийхээ ачаар л тийм сүрхий болоод байгаа юм” гэжээ.

Дрүэ тийм юм сонсоод энэ талаар анхаардаг хэрэг гэж даруй шийдсэн байж. Тэгээд буцаж ирмэгц нууц нийгэмлэгийнхээ төвөөр оржээ.

- Дрүэ та тун цагаа олж ирж дээ, та бидэнд их тус болох байна гэж нийгэмлэгийн орон нутгийн нэртэй зүтгэлтэн Гарри Квинсел гэгч хэлжээ.

Ажил төрлөө хэлэлцсэн хурлын дараагаар хүмүүс нь дүнгэр дүнгэр ярилцан байхад Дрүэ тэдний дунд хуучин олон танил нөхөдтэйгээ уулзан марзганан чалчиж байв.

- та нар тэгээд ямар юм хийе гэж байгаа юм гэж Дрүэ нууц нийгэмлэгийнхээ гишүүнээс их л эелдгээр асуун инээмсэглэхэд цаадах нь:

- Хоёр долоо хоногийн дараа нэг жүжиг тавих санаатай, тэгээд нэг залуухан хүүхэн болж тоглох эг эмэгтэй хэрэг болох нь ээ, тийм хүн олох юмсан, уг нь тийм ч хэцүү юм биш л дээ гэхэд Дрүэ:

- Олдолгүй яах вэ гэв. Тэдэнд тус болохсон гэж бодсондоо л “бололгүй яах вэ” гэхчхэнээс биш, чухамдаа бэлэн хүн бодож хэлээгүй байжээ.

- Бид одоо юу хийх санаатай байгаага танд ярьж өгье гэж ноён Квинсел цааш нь ярихдаа: - Бүлгийнхээ дотор төхөөргийг бага сага өөрчилж янзлах хэрэгтэй байна. Одоохондоо дансандаа мөнгө шөөх шальтай юмгүй байга болохоор жаал мөнгө олох санаатай л нэг жүжиг тавих гэсэн юм гэхэд Дрүэ:

- Зүйтэй, зөв санаа байна гэж сайшаав.

- Манайд хэд хэдэн авьяаслаг залуу байгаа. Жишээ нь, гарри Бербек гэдэг залуу негр болж тоглохдоо тун чадамгай, Мак-Луис эмгэнэлт дүр сайн харуулна. “Толгодын дээгүүр” гэдэг уран уншлага хийж байхы нь та үзсэн үү?

- Үгүй шүү.

- Хичнээн сайхан уншдаг гээч.

- Та тэгээд намайг нэг залуу хүүхэн олж өгнө үү гэл үү? Ямар юманд тоглуулах гэж байгаа юм? гэж тэр хүнтэй ярьсаар одоо залуу нь хүрч салахын түүс болсон Дрүэг асуухад:

- “Дэнлүүний гэрэлд” гэж Квинсел хэлэв.

Тэр нь Августин Дэйлийн алдартай зохиол том том театруудын тайзан дээр гардаг бас сай

дурынхны клуб театраар тоглож, сүүлдээ хэцүү амьдралтай хэсгий нь хасаж товчлон тоглогчдын тоог ч хүртэл цөөлөн гаргадаг болсон сонин жүжиг ажээ. Дрүэ тэр жүжгийг нэг удаа үзсэн юмсанж. Тэгээд:

- Их сайхан жүжиг. Олон ч хүн үзэж их мөнгө орно доо гэв.

Амжилттай болно гэдэгт бид ч гэсэн найдаж байгаа, харин та Лаурагийн дүрд тоглох залуу хүүхэн олж өгөхөө мартуузай гэж ноён Квинсел, Дрзэгийн баахан яарч байгааг ажаад хэлэхэд Дрүэ:

- Зоволтгүй, би олж өгнө гээд гарахдаа Квинселийн хэлсэн үгийг мартаж тэр жүжгээ хэзээ, хаанаа тавих гэж байгаагий нь асуусангүй.

Гэтэл нэг хоёр хоногийн дараа Дрүэд нэгэн захидал ирсэн нь энэ ирэх баасан гаригт “Дэнлүүний гэрэлд” жүжгийн анхны сургуулийг хийх учир өнөө танил хүүхнийхээ хаягийг бидэнд даруйхан хэлж өгнө үү, бид цээжлэх үгийг нь хүргүүлэх гэсэн юм гэсэн байв. Дрүэ уншиж үзээд:

- Ээ лүд ээ! гэснээ улайсан чихээ маажиж танил хүүхнүүдийн маань дотроос хэн нь чадах бол гэж бодоод хамгийн ойр гэртэй нэг хүүхнийг бодож орой гарахдаа уулзъя гэж шийдээд гэрээс гарч морин вагонд суугаад явж байснаа бас мартчихжээ. Гэртээ бцаж ирээд “Ивнинг ньюз” гэдэг сонингий нэг буланд Хандгай Нийгэмлэгийн орон нутгийн салбараас 16-нд Эврей Холлд “Дэнлүүний гэрэлд” гэдэг жүжиг тоглоно гэсэн зарлал байхыг хараад:

- Ээ, лүд ээ, бас мартчихаж! Гэж дуугарахад Керри :

- Юу болоо вэ? гэж асуулаа.

Тэр хоёр гал тогоо болгож болмоор бөгөөд Керри заримдаа хоол унд бэлддэг жижиг өрөөнийхөө ширээнд хамт сууж байж. Керри энэ орой юу болсон юм нэлээд аятайхан юм өөрөө бэлдсэн байв.

- Манай нийгэмлэгийнхэн нэг жүжиг тавих гээд нэг хүүхэн хэрэгтэй байна. Намайг олж өгөөч гэсэн юм.

- Ямар жүжиг тавих гэж байгаа юм бол?

- “Дэнлүүний гэрэлд”

- Хэзээ?

- 16-нд

- Чи тэгээд олж өгөхгүй яасан юм?

- Надад мэдэх хүн алга гэснээ Дрүэ гэнэт сэрвэсхийн харж,

- Хүүш, чи чинь жүжигт тоглож орхихгүй юмуу? Гэхэд Керри,

- Би юу? Чадахгүй байлгүй гэлээ.

- Чадахгүйгээ яаж мэдсэн юм? гэж бодлогошронгуй хэлэхэв нь Керри,

- Би ер тоглож үзээгүй юм чинь гэлээ.

Гэвч тэгж асуусанд нь Керри баярлаж нүд нь сэргэв. Яагаад гэхэд тайзны урлагаас илүү сайхан юм байдаггүй мэт санагддаг ажээ.

Дрүү угаас нэг юманд зоривол салдаггүй хүн болохоор цаадуулдаа хүн олж өгнө гэж амлаад худалч болохгүйн тулд Керрийг шахахаар шийдэв.

- Дажгүй, чи чадахаа л чадна.

- Би яаж чаддаг юм гэж Керри цааргалавч үзээд алдахыг хүсэх мөртлөө бас айгаад байлаа.

- Чадна даа, оролдоод үз л дээ, тэдэнд ч хэрэг болно, чамд өөрт чинь сайхан байхгүй юу.

- Больё доо, чадахгүй байх, яришиг гэж чин үнэнээсээ хэлэв.

- Чи чадахаа л чадна, би мэдэж байна _ Бишгүй дээ бүжиглээд, хүн амьтан дууриагаад байдгийг чинь харсан. Би мэдээд хэлж байна, чамд авьяас бий, чи чадахаа л чадна гэж Дрүү хоргоолоо.

- Би тийм биш ээ гэж Керри эмээсэн янзтай хэлэв.

- За тэгвэл би нэг юм хэлье. Чи тэнд оч, үз. Сонин шүү дээ. Бусад тоглох хүмүүс ч гэсэн дадлагагүй тий сүрхий биш л дээ. Тэд тайзны урлаг юугаа л мэдэв гэж.

Энэ улс ер нь ямар дүүрчихсэн амьтад байдаг юм гэж Дрүү дотроо бодоод хөмсөг зангидсанаа:

- Надад аяга кофе өгөөч гэв

- Чарли, би чадахгүй байх гэж бодож байна. Чи намайг чадна гэж бодож байгаа юмуу?

- Чадалгүй яадаг юм, яриан байхгүй. Чадахаас илүү чадна. Болмоор байгаа биз дээ. Би бүр тэгж бодоод л гэртээ ирсэн шүү дээ.

- Ямар жүжиг тавих гэж байгаа гэлээ?

- “Дэнлүүний гэрэлд”

- Намайг юунд нь тоглуулах гэж байгаа гэлээ?

- Нэг гол дүрд л тоглуулах гэж байгаа байх, би үнэндээ яг хэлж мэдэхгүй байна. Юун тухай гардаг юм бол?

- За байж, юу гэлээ гэж Дрүү нэхэн санахыг оролдож эхлэв. Ер нь Дрүү иймэрхүү юманд нэг их дүйтэй хүн биш болохоор – За байз, нэг хүүхнийг хонгил шиг муу юманд суудаг эр эм хоёр хулгайлдаг юм. Мөнгөнд нь болоод, тэгээд мөнгий нь дээрэмдэх гэж л тэр байхгүй юу даа. Цааш нь яадаг ч билээ санахгүй байна гэв.

- Намайг юунд тоглуулах гэсний нь чи мэдээгүй юм шив дээ? гэж дахин лавлахад нь Дрүүэ:

- Үнэнийг хэлэхэд мэдэхгүй байна гээд хэсэг бодсоноо: - Хүүе, байз саналаа саналаа! Лаура!
Чамайг Лаура болгох юм байна гэхэд Керри:

- Тэр Лаура гэдэг нь юун хүн юм, яадаг юм? гэж бас шалгаалаа.

- Кэд минь, би яагаад ч санахгүй байна. Уг санах л ёстой л доо. Тэр ч байтугай урьд нь би тэр жүжгийг хэд хэд үзсэн хүн шүү дээ. Нэг л охины тухай гараад байдаг юм. Бүр жаахан охин байхад нь байх аа гээд том гэгчийн амтат боов сэрээдэн ам дүүрэн үмхлээ. Тэгснээ:

- Усанд живүүлдэг, ... а... үгүй.. биш, биш... тэгдэггүй гээд цөхөрсөн байдалтайгаар гараа сажсанаа – бби чамд тэр жүжгийг олоод ирүүж, үнэндээ би бүр мартчихаж, санаанд юу ч орж ирэхгүй байна гэлээ.

Керри тайзны урлагт дуртай, тэнд авьяас сорьж үзэх юмсан гэж халагдах боловч төрөлхийн аймхай гэрэвшүү хүн болохоор яахаа сайн шийдэж чадахгүй:

- Яадаг юм билээ, чадахгүй байхаа даа гэснээ - Чи намайг чадна гээд байгаа хойно ямар ч гэсэн очоод үздэг юм билүү гэхэд Дрүүэ, уухайн тас:

- Зүйтэй, тэгэлгүй яах вэ! гэж дуу алдан, Керрийг улам зоригжуулах санаатай хэлэхдээ өөрийнх нь сэтгэл хөдөлж: - Би чамайг чадахгүй гэж бодсон бол юу гэж тийм юманд тоглуулах гэж гэртээ зориулд ирээд чамайг хоргоох билээ? Чи чадахаа л чадна, чамд ашигтай юм болно гэлээ.

- Хэзээ очих вэ? гэж Керри бодол болон асуув.

- Тав дахь өдөр анхны үзлэгтэй гэсэн. Би өнөө орой очоод чамд үгий нь аваад ирье.

- За яах вэ, тэг л дээ гэж Керри хүлцэнгүй байдалтай хэлээд - Үзээд л алдъя. Хэрэв би чадахгүй бол буруугий нь чи хүлээнэ шүү гэлээ.

- Чаднаа чадна. Энд яаж тоглодог билээ тэрүүн шигээ л тоглох хэрэгтэй. Байдгаараа л байх хэрэгтэй. Чи чадна даа! Би чамайг тоглоод алиалж байхы чинь хараад жүжигчин болбол сайн жүжигчин болох юм байна гэж бишгүй боддог байсан.

- Нээрэн үү? Гэж Керри асуухад доншуурч:

- Нээрээн гэлээ.

Дрүүэ тэр орой гэрээс гараад явахдаа тэр хүүхний цээжинд хичнээн илчтэй дөл үүсгэснийг бараг мэдээгүй байхаа. Керри, цаашдаа театрын урлагт таарах өрөвч эмзэгхэн сэтгэлтэй байлаа. Сэтгэл нь хойрго идэвхигүй мэт байдаг нь идэвхитэй ертөнцийг тольдож байгаа гэсэн үг. Бас үзсэн сонссон бүхнээ дууриан дүрсэлж чаддаг байсан нь учиртай билээ. дадлага хийгээгүй мөртлөө үзсэн жүжгийнхээ зарим баатруудыг дууриан толины өмнө эргэлдэж байхдаа их чадамгай байдаг ажээ. Хүний дууны өнгө, содон онцгой яриаг тэр чигээр нь давтаж хэлнэ. Сүүлийн үед хэд хэдэн сайхан жүжигт тоглосон нэг эмэгтэйн гайхалтай дүрийг дууриан нүүрийн болон биеийн хөдөлгөөн хийдэг болж өрөөндөө ганцаар байхдаа энэ талаар ихээхэн цаг зарж байв. Дрүүэ чингэж байхад нь хэд дахин тааралдсан боловч зүгээр л тольдож байна гэж боддог байж. Гэтэл

үнэндээ бол Керри аль нэг жүжигчний хөдөлгөөн намбыг дууриах гэж оролддог байв. Дрүэ заримдаа тоглоомоор зэмлэх янзтай хэлэхэд Керри ч өөрийгөө үнэхээр дэмий юм хийж байна хэмээн зэмлэдэг байлаа. Гэтэл энэ бол үзсэн харснаа дууриан дүрслэх жүжигчний төрөлхийн тэмүүлэл аж. Амьдралыг дүрслэн дууриах бол театрын урлагийн үндэс гэдгийг хэн бүхэн мэдэх билээ.

Одоо Дрүэ тайзны урлагт авьяастайгий нь магтахад Керри туйлын их баярлана. Магтаалынх нь үг Керрийн бодолд хааяа орж ирдэг боловч итгэл болж чадахгүй эрээвэр хураавар байсан авьяасы нь нэгэн цул болгон ширээж нийлүүлэх шиг болов.

Керрид бусдын адил биеэ би гэх явдал бас бий. Бололцоо нь олддогсон бол хүний хийж чадсаныг хийж чадна гэж бодно. Театрын тайзан дээр сайхан хувцасласан эмэгтэй жүжигчдийг хараад өөрөө оронд нь тоглохсон ямар байх бол, яасан сайхан бэ гэж бодох явдал хичнээн олон байсныг өгүүлэх юун. Театрын гял цал орчин, хүмүүсийн сэтгэлийн түгшээ, ганган дэгжин хувцас хунар, хүмүүсийн алга таших, энэ бүхнийг бодохоос сэтгэл нь их хөдөлж өөрөө чадмаар санагдан олонд авьяасаа гайхуулж болмоор бодогдоно. Тэгж бодох ч үнэхээр сайхан байдаг байжээ.

Дрүэг гарсан хойно эргэлддэг сандал дээрээ цонхныхоо дэргэд бодол болон суулаа. Ургуулан бодохдоо юм бүхнийг арай хэтрүү тусгадаг даврах гэмтэй билээ. Гарт нь таван мөнгө атгуулбал мянга долларын тухай л бодох жишээтэй. Тун олон жүжгийн эмгэнэлтэй дүрд тоглоод хоолой нь чичирч, сэтгэл зовж буй мэтээр бодож сууна. Хээнцэр баян амьдралыг харуулсан театрын тайз нүдэнд нь үзэгдэх шиг болж үзэгч олон өөрөөс нь нүд салгалгүй ширтэн бахархаж буй санагдана. Керри эргэлддэг сандал дээрээ ганхан найган суухдаа ганцаар хаягдсан хүний ганихрал хууртсан хүний уур хилэн, дийлдэж муугаа үзэж буй хүний гаслан зовлонг бодон сэтгэлээ хөдөлгөж байв. Тайзан дээр үзэгдэж байсан хамаг сайхан эмэгтэйчүүдийг нэхэн санаж, ер тайзны урлагийн гайхамшигтай бүхэн нүдэнд нь үзэгдэж татарсан ус эргээд түрэн орж ирэх лүгээ адил бүх юм санаанд нь оров. Керри үнэн байдалд хараахан түшиглээгүй шийд гаргаж сэтгэл нь дэндүү хөөрч байх шиг.

Дрүэ хотын төв орохдоо нийгэмлэгийнхээ салбараар орж Квинселтэй уулзах гэж их л додигор байдалтай эргэлдэнэ. Квинсел түүнээс:

- Таны олж өгнө гэсэн залуу хүүхэн чинь хаана байна? гэв.
- Олсон шүү гэж Дрүэг хэлэхэд Квинсел түүнийг хэлсэн үгэндээ хүрсэнд нь зэгсэн гайхаж:
- Тийм үү? Их сайн байна, алив хаягий нь аваатахъя гээд цээжлэх үгий нь бушуухан явуулах гэж хаягий нь бичиж авахаар цаас харандаа гаргаж ирлээ.
- Та үгий нь явуулах гээ юу? гэхэд цаадах нь:
- Тийм гэтэл Дрүэ:
- Надад өгчих, би өглөө бүр тэдний хажуугаар гардаг юм гэлээ.
- Хаягий нь та хэлж өгөөч, бидэнд яаралтай мэдэгдэх юм гарвал хэрэгтэй болно шүү дээ.
- Огден талбай, хорин ес.

- Нэрий нь хэн гэдэг юм?

- Керри Маденда гэж түгдрэлгүй овгий нь зохиож хэлэв. Нийгэмлэгийн гишүүд нь Дрүүэг гоонь эр гэж мэддэг байсныг энд тэмдэглэсүгэй.

- Тайзанд яг таармаар нэр бхйх чинь юу вэ гэж Квинсел хэлэв.

- Яг үнэн!

Дрүүэ жүжгийн үгийг авч очоод Керрид өгөхдөө их ач тус болж буй хүний байдал гаргажээ.

- Тэр хүн энэ дүрийг хамгийн сайхан гэж байна лээ шүү, чи тоглож чадна биз?

- Үзэхээс нааш хэлж мэдэхгүй байна. Үзээд алдья гэж нэгэнт хэлчихсэн хойноо л үнэндээ айгаад байх юм.

- Дажгүй! Юунаас айсан юм? Тэнд нэг сүрхий жүжигчид байхгүй, бүгд л адил, чамаас илүү гарах хүн байхгүй.

- Ямар ч гэсэн үзье.

Керри айж байсан ч нэгэнт тоглох жүжгийн үгийг гартаа авсандаа баярлана. Дрүүэ хувцас хунараа өмсөх зүүх гэж баахан мунгинаж байснаа аль түрүүний санаагий нь зовоож байсан нэг юмаа одоо хэлэхээр шийдэж:

- Керри, тэд хөтөлбөрөө хэвлүүлэх гэж яараад овог нэрий чинь асуухлаар би чамайг Керри Маденда гэдэг гэхихсэн, яах вэ дээ? гэхэд Керрид тийм нэр өгсөн нь жаахан хачин санагдавч:

- Яах вэ, болно гэж нүүр рүү нь харж хэлэв.

- Ямар ч гэсэн тимй овог нэртэй байж бай., юмыг яаж мэдэх вэ, бүтэлгүй болбол гэхэд Керри түүний хашир болгоомжтойд баярлаж:

- Яг үнэн, зүйтэй шүү гэв.

- Би чамайг өөрийнхөө эхнэр гээгүй бүтэлгүй болбол чамд дэмий юм болно. Намайг цаадуул чинь андахгүй. гэхдээ би чамайг сайн тоглож чадна гэж бодож байгаа. Ер нь тэгээд тэдний алинтай ч дахин уулзахгүй байх даа.

- Тэр яах вэ, надад хамаа алга! Гэж Керри зоримогхон хэлээд ямар ч гэсэн тоглоод үзье гэж хатуу шийдэв.

Дрүүэ санаа амарсан бололтой сүүрс алдав. Дахиад л гэрлэх тухай үг гарч ирэх вий гэж булай айж байсан бололтой.

Уншиж үзвэл Лаурагийн дүр нь дан уй гашуу, нус нулимсаар дүүрэн байв. Түүнийг зохиогч Августин Дейли, тэр үеийн амьсгалыг тусгай эмнэлэгт шүлэг бичдэг заншлыг дагаж уул жүжгийг бичжээ. Тэр дүрд уй гашуу болон жүжиглэх байдал, гунигт хөгжим, сунжруу дэлгэрэнгүй үглэн тайлбарласан үгийн аль аль нь багтжээ.

“Хөөрхий амьтан, Мартин, чи явахаас нь өмнө аяга сархад заавал өгөөрэй” гэсэн үгийг Керри уянгалуулан уншлаа.

Тайзан дээр ярих үг нь тун бага байсанд Керри гахайж, бас тэгээд бусдын ярихыг чагнаад тайзан дээр байх, тэгэхдээ бусад жүжигчдийн ярианы ая утгаар жүжиглэх ёстойгоо мэдэхгүй байв.

- Чадах юм шиг байна гэж Керри бодов.

Маргааш орой нь Дрүэ хүрч ирээд Керри тэр өдөр уншиж судалж амжуулсан зүйлдээ сэтгээл нэлээд өег байгааг мэдээд:

- Кедди, за юу болж байна, болох нь уу? гэж асуухад Керри инээж:

- Зүгээр, би баргий нь цээжилчихлээ гэж бодож байна гэв.

- Яасан сайн юм, за заримы нь сонсох уу гэхэд нь Керри ичингүйрч:

- Шууд босонгоо ярьж чадахгүй байх шүү, яана...

- Чадалгүй яах вэ? тэнд очоод үзүүлэх гэж байгаа биш, санаа зоволтгүй гэлээ.

- Ай мэдэхгүй, нэг л биш.

Тэгж байснаа бүжгийн өрөөнд болдог үзэгдлээс тоглож нэг мэдэхнээ Дрүэг ч мартчихаад уг зүйлээ гүн сэтгэлээр тоглох орхив.

- Их сайн . Гойд сайхан боллоо. Кедди, чи ёстой дог жүжиглэх юм гэж Дрүэ бахархан баярлав.

Керри жигтэйхэн чадмаг тоглож рольдоо итгэн туяхан бие нь хөл дээрээ арай чарай тогтож байснаа юу юугүй шалан дээр мууран унах үед Дрүэ ухасхийнн босож өргөж аваад тэврэн инээлээ.

- Ингэж унаад биеэ бэртээчихнэ гэж бодохгүй байна уу?

- ЯАлаа гэж!

- Гайхмаар сайхан тоглож байна. Би чамайг үнэндээ ийм сайн тоглоно гэж бодоогүй шүү.

- Би ч өөрөө бодоогүй гэж Керри баяртай хэлээд баярласандаа нүүр нь улаа бутарна.

- Одоо чи чадахаа харууллаа. Миний үгэнд итгэ, бүтэлгүй болно гэж болохын ч хэрэг алга.

ХААЛГААР ШАГАЙХАД НҮДНЭЭ ИТГЭЛ ТӨРЛӨӨ

Керрийн амьдралд маш чухал ач холбогдолтой тэр жүжгийг анх төлөвлөж байснаасаа илүү их анхаарах болсон байв. Жүжигт анх удаа тоглох гэж байгаа Керри жүжгийнхээ үгийг авсны маргааш нь Херствүдэд тэр тухайгаа бичжээ.

“Би жүжигт тоглох гэж байгаа, нээрэн шүү, тоглох дүрийнхээ үгий нь хүртэл хүлээж аваад байна” гэж Херствүдийг үнэмшихгүй болов уу гэсэндээ дурджээ.

Херствүд тэр захидлы нь дуртай уншаад инээмсэглэв. “Юу болох бол, заавал очиж үздэг хэрэг” гэж бодоод дор нь хариуг нь бичиж “амжилт олно гэдэгт чинь өчүүхэн ч эргэлзэхгүй байна. Маргааш өглөө цэцэрлэгт ирж надад бүгдийг ярьж өгөөрэй” гэжээ. Керри очиж уулзан өөрийнхөө мэдсэн сонссон бүхнийг ярьж өгөв. Херствүд:

- Зүйтэй, сайн байна. Чихэнд чимэгтэй сонсдож байна. Чи ухаантай хүн болохоор сайхан тоглож чадна гэдэгт чинь би итгэж байна гэв.

Тэр хүүхнийг урьд тийм их баяртай явахыг Херствүд үзээгүй билээ. Ямагт гунигтай мэт байдаг нь ор сураггүй алга болжээ. Ярьж хөөрөхдөө хацар нь улаа бутарч нүд нь золбоотой гялалзана. Тийм юм хийх болсондоо хийморь нь бүр сэргэж, хэдийгээр сүрдэх боловч цаанаа туйлын их баяртай харагдана. Бусдлад өчүүхэн төдий санагдах тэр явдал Керрийд нэн чухал бодогдож сэтгэл нь нуухын аргагүй ихэд хөдөлсөн байлаа.

Үүнийг нь Херствүд мэдмэгц өөрөө ч баярлаж авьяаслагт нь уярч эхэлжээ. Ер нь эхлэлийн чанартай боловчиг зүй ёсны өндөр эрмэлзлэлтэй байх нь амьдралд хамгийн чухал зүйлийн нэг билээ. Тийм эрмэлзэлтэй хүн өнгөтэй золбоолог, хүчтэй байдаг юм.

Керри тийм бурханлаг зоригжлынхоо эхний нөлөөнд л сэтгэл нь сэргэжээ. Юуны ч духанд хүрэхгүй атал сэтгэлтэй хоёр хүн нь зэрэг зэрэг магтан сүйд майд болоход баярлахаас ч өөр яах билээ. Керрид сэтгэлтэй учраас ч аливаа сэдэж буй буюу хийж буй юм бүхэн нь тэдэнд аятайхан мэт санагдах аж. Керри дол цохиж догьшроогүй болохоор амьдралдаа тохиолдсон анхны боломжоос шүүрэн авч түүнийгээ амьдралын алтан сангаас арвихан хүртэх ид шидтэй очир гэж мөрөөдөж байнам.

Үгүй байз, би тэр Хандгай нийгэмлэгийн чинь тухай мэднэ шүү, би гишүүн нь, сасон хүн байхгүй юу гэж Херствүд хэлэв.

- Харин та намайг хэлсэн гэж тэрүүнд хэлэж болохгүй шүү!

- Яалаа гэж, хаанаас хэлэх вэ.

- Та өөрөө очьё гэж бодож байгаа бол оч л доо, харин таныг яагаад мэдчихсэн юм бол гэж асуувал юу гэх билээ?

- Би очих нь очно, гэхдээ цаадахад чинь чамайг хэлсэн гэж бодохооргүй юм бодож оломз, энэ талаар би даая, зоволтгүй гэж Херствүд эелдгээр хэлэв.

Хандгай нийгэмлэгийнхний дотор Херствүд ихээхэн нөлөөтэй байсан болохоор энэ асуудлыг

сонирхож байгаа нь тэртэй тэргүй их учиртай юмсанж. Ямар ямар нөхдөө адгуулж очдог билээ. Керрид цэцэг барих юм шүү энэ тэр гэж бодохдоо тэр жүжгийг жижнхэнэ баяр болгон хувиргаж Керрийг нэрд гаргахыг хүсчээ.

Түүнээс хойш нэг хочр хоног болоод Дрүү Адамс гудамжны зоогийн газраар үдээс хойш таван цагийн алдад ороод ирэхийг нь Херствүд сэмхэн харчихав. Тэдн худалдаачин, жүжигчин, үйлдвэрийн газруудын эрхлэгч, улс төрийн бодлогоч гэх мэт өдий төдий ганган дэгжин хүмүүс байсан бөгөөд зарим нь толгойдоо өндөр бортгон малгай тавьж, гартаа бөгж, зангиандаа очир алмас зүү хатгасан, цас шиг цагаан цардмал захтай цамц өмссөн харагдана. Шил толь гялалзах лангууны нэг үзүүрт дэгжин хувцастай, баахан биеийн тамирчдын дунд алдартай боксчин Жон Салливен зогсоно. Тэд их л чанга чанга дуугаран ярилцана. Алхах гишгэх бүрт нь чахрах цоо шинэ шаргал өнгийн шаахайтай Дрүү баяр ёслолын байдалтайгаар лангууны хажуугаар өнгөрөв.

- Ө, сайн байна уу, эрхэм ээ, би таныг юу болоод алга болчихоо вэ, дахиад л хөдөө явсан юм байх гэж бодож байлаа шүү гэж Херствүд түүнтэй мэндлэв. Дрүү хариуд нь мишээв.

- Ойр ойр мэдэгдэж байхгүй бол таныг нэрсийнхээ жагсаалтаас хасах дээр хүрэх нь байна шүү гэхэд доншуур худалдаачин,

- Одоо яана гэх вэ, ажилдаа дарагдаад яах ч арга алга гэв.

Тэр хоёр чанга чанга ярилцан байгаа нэр цуутангуудын дундуур явж лангууны хавь очиход Херствүд зууртаа театрын хорхойтой хэд хэдэн хүнтэй гар барин мэндлэв.

- Танай салбар жүжиг тавих гэж байгаа гэ л үү? Гэж урьд нь юу ч сонсоогүй царайлан асуухад цаадах нь:

- Та хэнээс дуулаа вэ? гэв.

- Хэнээс ч дуулсангүй, хоёр долларын үнэтэй, хоёр билет ирүүлсэн байна лээ, хэр зэргийн жүжиг юм бол? гэж Херствүд гэмгүй царайлан хэлэхэд Дрүү:

- Би сайн мэдэхгүй, намайг жүжигт тоглох нэг эмэгтэй хүн олж өгөөч гэсэн юмдаг гэлээ. Херствүд хээв нэг:

- Би ч үзмээргүй л байна, гэхдээ оруулах нэмэр хандиваа өгөлгүй яах вэ. Ер нь хэр зэрэг болж байгаа юм бол? гэв.

- Зүгээр бололтой. Олсон мөнгөөрөө жаал зугаа шинэчлэлт хийх бодолтой юм байх.

- Зүйтэй шүү дээ. Амжилттай болох байлгүй. Дахиад нэг аяга уучих уу?.

Херствүд одоо өөр юм ярих хэрэгцээгүй болов. Дараа, жүжиг тоглоход хэдэн хүн дагуулаад очсон ч яагаад ирэх болов гэвэл эд маань очъё гээд болдоггүй гэж хэлэх үгтэй болжээ. Дрүү ч гэсэн сүүлд эвгүй юм болж юун магад гээд урьдаас хаяагаа манаж:

- Нөгөө хүүхэн маань ч оролдох байх шүү гэхэд, Херствүд:

- Яалаа гэнээ? Нээрэн үү, хүүе? Гэв.

- Нээрэн, тэднүүс нэг хүн дугаад байна, хүн олж өгөөч гэхлээр нь Керрид хэлсэн чинь оролдоод үзье гэсэн юм.

- Үгүй ер зүйтэй л байна даа, сайхан хэрэг, өөрт нь ч гэсэн аштай юу, урьд тоглож байсан дадлага туршлагатай юм бол уу?

- Ердөө үгүй!

- Тэглээ ч гэсэн, энэ нэг их сүриэй жүжиг биш шүү дээ.

- Авьяастай хүүхэн юмаа. Үнээ амархан цээжилж, тун сайн тоглох бодолтой гэж Дрүэ, Керрийн авьяасыг хэрхэвч басаж болохгүй гэсэн мэтээр хэлэв.

- Үгүй ер, айхавтар амьтан!

- Нээрэн шүү, өчигдөр орой би бүр гайхсан, үнэхээр сайхан тоглож байна.!

- Тэгвэл бэлэг зэлэг бэлдэх хэрэгтэй юм байна, би цэцэг бэлтгүүлье.

Дрүэ талархсан байдалтай инээлээ.

- Жүжгийн дараа надтай оройн хоолонд ороорой.

- Керри амжилттай тоглох байх гэж найдамж байна шүү гэж баярласан Дрүэ хэлэв.

- Очиж үзэх юм байна. Лав сайхан тоглох байх.,

- сайн тоглуулах ч хэрэгтэй юм шүү гэж Херствүд хэлээд сайхан зан гаргадаг овжин байдлынхаа салшгүй нэгж шинж болсон зальтай түргэн инээдэг янзаараа инээвхийлэв.

Яг энэ үед Керри анхны давталганд ороод байв. Тэр үзлэгийг ноён Квинсел даргалж Миллис хэмээх нэг залуу туслалцаж байлаа. Нэлээд туршлагатай залуу байсан боловч хэнд ч олигтой тоогдсонгүй. Туршлагандаа дулдуйдан их л ажил хэрэгч хандах боловч эндхийн жүжигчдийг хөлсний мэргэшлийн жүжигчид биш харин сайн дурын хүмүүс атал мэргэшлийн мэтээр үзэж баахан хатуу ширүүн харьцаж байв. Керри хаашаа хэрхэн хөдлөхөө мэдэхгүй гэнэт зогсмогц тэр залуу:

- Эрхэн Маденда авгай та тийм байдалтай зогсож болохгүй, нүүр царайндаа сэтгэлийнхээ хөдөлөгөөнийг итлгэн гаргах хэрэгтэй, танихгүй хүн ороод ирэхтэй зэрэг сэтгэл тань их хөдөлсөн байх ёстой. Иймэрхүү маягтай алхах ёстой гээд өөрөө тайзан дээр бөгтөсхийн хавчигнаж, явж үзүүлэв.

Энэ нь Керрид дургүй хүрмээр санагдсан боловч цоо шинэ газар анх удаа ирээд, бас танихгүй олон хүн өөртэй нь адил юм уу, илүү зовсон байдалтай байхад, ямар ч атугай гологдохгүйг бодох учраас тэсэж номхон хүлцэнгүй байхаас өөр өргөгүй болов. Тэгээд тэр хүний зааснаар тайзан дээгүүр явсан боловч уг нь ийм байдалтай явах ёсгүй гэж өөрөө боджээ.

Үүний дараа Пэрлийн дүрд тоглох бас нэг залуу хүүхнийг зааж:

- За одоо Морган авгай та наашаа суу. Бамберег та наашаа, ингээд зогс, За одоо юу гэж хэлэх билээ, хэлээд байгаарай гэнэ.

- “хэлээч” гэж Бамберег зориг муутай хэлэв. Бамберегр бол Лаурад сэтгэлтэй залуугийн дүрд тоглох санаатай оролдож байсан юм байж. Лаура нь ядуу, харц гаралтай учраас тэрний нь мэдээд Рэй яая даа хэмээн эргэлзэнэ.

- Юу гэнэ ээ? Жүжгийн чинь үгэнд юу гэсэн байна даа?

- “Хэлээч” гэж байна хэмээн Бамберегр цааснаас нүд салгалгүй хэлэхэд найруулагч:

- тэгэх нь тэгж байгаа, гэхдээ сэтгэлий нь хөдөлгөөн гарч өгөхгүй байна шүү дээ! Ихэд цөхөрсөн байдалтайгаар хэлэх ёстой. За одоо дахиад хэл дээ! гэхэд Бамберегр том дуугаар:

- Хэлээч дээ! гэв.

- Биш биш, тэгж болохгүй, ердөө ч тэгж болохгүй байна, “Хэлээч” гэдгээ иймэрхүү маягтай хэлэх ёстой гэж сургамжлав. Бамберегр хэлсний нь дууриан:

- “Хэлээч дээ” гэхэд найруулагч:

- Одоо овоо дээрдэж байна, цааш нь гэлээ.

Морган хатагтайн ээлж болж:

- нэг орой аав, ээж хоёр нь опер үзэхээр явах гэж Бродвейгээр ороод явж байтал тэнд гуйлгачин хүүхдүүд тэр хоёрыг бүчээд авав гэтэл найруулагч гараа Морган руу сарвайлган өндөсхийж:

- Байз байз, та хэлж байгаа үгэндээ сэтгэлийнхээ хөдөлгөөнийг харуулах хэрэгтэй байна шүү гэлээ.

Морган хатагтай зодох нь уу гэж айсан мэт өөдөөс нь сэрвэсхийн харахад нүдэнд нь зэвүүцэл илэрхий харагдана. Найруулагч, тэр хүүхний зэвүүцэж байгааг нэг их тоосонгүй боловч дууныхаа өнгийг бага зэрэг зөөлрүүлж:

- Морган авгай та, сэтгэлийн хөдөлгөөнтэй зүйл ярьж байгаа гэдгээ санах хэрэгтэй. Та бол их гунигт зурсамж бүхий юм ярьж байгаа хүний үгийг гаргаж хэлэх ёстой шүү дээ. Биеэ барьсан сэтгэлийн түгшээг илэрхийлэх ёстой. За тэгээд Гараад явтал нь гуйлгачин хүүхдүүд тэр хоёрыг бүчээд авав” гэсэн янзтай хэлэх учиртай шүү дээ гэв.

- За мэдлээ гэж Морган хатагтай хэлэв.

- За цааш нь юу билээ, үргэлжлүүл гэв.

- Ээж, задгай мөнгө гаргаж ирэх гээд халаасандаа гараа хийтэл цэл хүйтэн жижигхэн гар түрийвчинд нь хүрч байлаа.

Найруулагч сайшаасан байдалтай толгой дохин:

- Их сайн байна гэлээ.

- Хулгайч байна! Яг мөн байна! гэж Бамбергер хэлэхэд найруулагч ухасхийн дэргэд нь очоод:

- Тийм биш, ингэж хэлж болохгүй, харин

- Хулгайч уу? Тийм гэж үү? Гэж хэлнэ гэлээ.

Зарим дүрд тоглох улс нь ямар нэг үг хэлэхдээ нүүр царайгаа ямар болгох тухай байтугай дүрийнхээ хэлэх үгийг ч гүйцэд тогтоож чадаагүй санагдсан тул Керри санал болгож зориг муутайхнаар:

- Бид эхлээд дүрүүдийнхээ үгийг бүгдээр хэлээд үзвэл яадаг бол, тэгвэл бидэнд илүү ашигтай биш үү? Гэхэд Квинсел ноён хажуугаас:

- Маденда хатагтайн санаа тун зөв байна шүү гэв.

Тэр хүн гэртээ хажууд суугаад тун их анхаарч заримдаа найруулагчийн анзаараагүй зүйлийг хэлж өгч байв. Найруулагч ялимгүй зовсхийсэн байдалтайгаар:

- Тэгвэл тэ debate л дээ, нээрэн хэрэгтэй ч байж магадгүй гэв.

Тэгснээ гэнэт ухаарсан юм шиг, эрх мэдэлдээ эрдсэн янзаар:

- За одоо бүгдээрээ тус тусынхаа дүрийн үгийг ярьж үзүүлэх хэрэгтэй харин сэтгэлийн хөдөлгөөнийг мартаж тун болохгүйг анхааруулья гэлээ.

- “Миний ээж”, тэр гарыг барин авч чанга атгахад ёо гэх сулхан дуу гарахад ээж харвал жижгхэн ноорхой охин зогсож байлаа” гэж Морган хатагтай хэлэхдээ Бамбергер рүү нэг харж, жүжгийнхээ үгтэй дэвтэр рүү нэг харж байв.

- “Их сайн байна” гэж найруулагч одоо бүр бууж өгсөн байдалтай хэлэв.

- “Хулгайч!” гэж Бамбергер дуугарахд найруулагч:

- Чангахан! Гэв. Хөөрхий Бамбергер:

- “Хулгайч” гэж бүр хашгирав.

- “Тийм ээ хулгайч” гэхдээ тав зургаахан настай дагина шиг царайтай охин байлаа. Боль чи, юу хийж байгаа юм? гэж ээж асуухад тэр хүүхэд “хулгай хийх гэсэн юм гэлээ”.

“Хулгай хийх муухай гэдгийг чи мэдэхгүй юу?” гэж аав асуухад “Мэдэхгүй, гэхдээ өлсөх л айхавтар юм” гэв. “Хэн чамайг хулгай хий гэсэн юм?” гэж ээж асуухад нөгөө хүүхэд, гэртээ хаалганы дэргэд зогсож байгаад гэнэт зугадаж буй өөдгүй маягийн авгай руу зааж “Бид тэр авгайг хөгшин Иуда гэдэг юм” гэлээ.

Морган хатагтай сахь үгээ олигтой хэлж чадаагүйд найруулагч цөхөрсөн янзтай тайзан дээгүүр урагш хойш алхаж байснаа Квинсел ноёны дэргэд очиж:

- Та энэ хоёрын талаар юу бодож байна? гэхэд наадах нь итгэл муутайгаар:

- Өө сэвий нь дардаг л байх даа гэв.

- Ай мэдэхгүй. Энэ Бамбергер гэзэг хүн чинь дүрдээ нэг л таарахгүй байна.

- Өөр хүн байхгүй шүү дээ. Харрисон биднийг ам мөлтөс чадчихлаа. Өөр хүн олдох уу? гэж Квинсел нүд эргэлдүүлэн асуухад найруулагч нь:

- Бүү мэд дээ. Энэ хүн л лав таарахгүй нь гэв.

Яг энэ үеэр нь Бамбергер:

- “Пэрл, чи тоглоомоор хэлж байгаа биз!” хэмээн дуу алдан хэлэх сонсдов.

- Та хараач. Ингэж байгаа хүнийг яана гэх вэ? Бүү үзэгд! Гэж найруулагч гараар амаа халхлан Квинселд шивэгнэв.

- Болгохыг бодохоос биш гэж Квинсел сэтгэлий нь зассан байдалтай хэлэв.

Үзлэг тийнхүү үргэлжилсээр Лаура болж тоглох Керрийн ээлж болов. Лаура сэтгэлтэй хүнтэйгээ ярилцаж тохирох ёстой байтал хархүү нь Пэрлээс үг сонсоод суухаа больё гэсэн захидал бичсэн боловч явжжлу амжаагүй байжээ. Бамбергер, Рей Пэрлд дөнгөж хариу хэлэн:

- Ирэхээс нь өмнө би явчъя. Ирлээ шүү, хөлийнх нь чимээ гарлаа. Хожимдлоо гэсээр захидлаа халаасандаа чихэж байтал нь Лаура-Керри орж ирээд:

- “Рей” гэж зөөлнөөр дуудлаа.

- “Хатагтай, хатагтай Кортленд” гэж Бамбергер түгдчин хэлэв.

Керри түүнийг хамрагцаа тэнд байгаа бусад хүнийг огт мартав. Керри рольдоо итгэж, зохиогчийн зааснаар хэнэггүйхэн инээмсэглэн сэтгэлтэй хүнийгээ тэнд байгаагүй мэтээр цонхны зүг эргэв. Үүнийг Керри тун эвтэйхэн урлагтай гүйцэтгэсэн тул тун сайхан харагдав.

Керри, Бамбергер хоёрыг ажиж байсан найруулагч:

- Энэ хүүхэн чинь хэн билээ? гэхэд Квинсел:

- Маденда хатагтай гэв.

- Нэрий нь мэднэ л дээ, харин ямар ажилтай юу хийдэг юм бол?

- Мэдэхгүй шүү, манай нийгэмлэгийн нэг гишүүний л танил юм гэнэлээ.

- Бусдаасаа хамаагүй илүү тоглож байна, ядахнаа тоглож байгаа зүйлдээ сонирхолтой байна.

- Тэгээд бас царайлаг ч хүүхэн юм, тиймээ?

Найруулагч хариу үг дуугаралгүй цааш явлаа.

Хоёрдугаар үзэгдэлд Керри бүжгийн танхимд өөрт нь дургүй хүмүүстэйгээ уулзах хэсгийг бүр ч аятайхан тоглосон тул найруулагч тэсгэлгүй сайшаан инээмсэглэж дэргэд нь очиж хэдэн үг солихыг соёрхов.

- Та урьд тайзан дээр гарч байсан биз? гэхэд Керри үгүй гэж үнэнээ хэлэв.

- Та тун сайн тоглож байна, танд тайзны авьяас байна гэж бодлоо гэхэд нь Керри зовмон янзтай инээмсэглэв.

Найруулагч, Керрийг орхиод, жүжгийнхээ үгийг ямар ч урлаггүй давтаж байсан Бамбергерын дэргэд очлоо.

Морган хатагтай тэр явдлыг ажсан учир Керрийг хар нүдээрээ атаархан ширэв татлаа.

"Мэргэшлийн нэг муу жүжигчин юм байлгүй" гэж дотроо доромжилсон үгэндээ өөрөө баясахын зэрэгцээ Кеерийг үзэн ядна.

Сургуулилт дуусаж Керри гэр өөдөө сэтгэл хангалуун явлаа. Найруулагчийн хэлсэн үг чихэнд нь дуулсаар мэт агаад энэ орой болсон бүх явдлаа Херствүдэд ярихсан гэхээс тэсэж ядна. Хичнээн сайн тоглосныг минь мэдэг! Дрүэд бас гайхуулахыг бодовч асуухаас, нааш дуугай байх юм шүү гэж бодоод бага зэрэг тэссэн боловч нэг мэдэхнээ ярьчихжээ. Гэтэл цаадах нь тэр орой өөр юм бодоод олигтой анхаарч бөгсөнгүйд нь урам хугарч дургүй нь хүрэв. Дрүэ, Керрийг трэтэй тэргүй санй тоглохы нь мэдэж байсан болохоор хэрхэний нь сонсоод сэтгэл нь амарсан аж. Дрүэг тийнхүү тоохгүй байгааг нь Керри мэдрэн Херствүдтэй бушуухан уулзахыг хүсэв. Энэ хорвоод Херствүд л ганц анд нөхөр нь мэд бодогдоно. Маргааш өглөө нь Дхүэ Керрийн тайзны амжилтыг бахархан сайшаасан боловч өчигдөр орой нэг их тоож өгөхгүй байсан болохоор нэг их хөөрч хөвийрсөнгүй.

“Энэ захидлыг авах үед чинь би цэцэрлэгт хүлээж байя, ирээрэй” гэж Херствүд бичжээ. Кеерийг очиход Херствүд өөдөөс нь өглөөни й нар мэт угтав.

- За хонгор минь, ямар болсон бэ? гэхэд Керри, Дрүэгийн тоохгүй байсны санаж нэг их хөөрсөн байдал үзүүлэлгүй:

- Овоо болсон шүү гэв.

- Чухам яасан, юу болсон, сонин санагдав уу? надад бүгдийг нь ярьж өгөөч.

Өгчигдөр оройнх нь сургуулилт яаж хэрхэн явагдсан тухайг нарийвчлан яри тусам Керрийн сэтгэл хөгжүүн болж байв.

- Сайхан хэрэг, би их баярлаж байна, очиж заавал ч үзнэ, Дараа хэдийд сургууль хийнэ гэнэ вэ?

- Хоёр дахь өдөр, харин, гаднын хүн оруулахгүй юм гэнэлээ.

- Би яаж ийгээд орчихно гэж Херствүд учиртайхан хэлэв.

Керри гонсгордуу байсан бол Херствүдийн их сонирхон анхаарч байгаад урамшин баярласан боловч дараачийн сургууль дээр битгий очоорой гэв.

- За тэгвэл миний санаанд хүртэл тоглоорой. Сайн тоглоосой гэж хүсэх байна. Тэр жүжиг ерөнхийдөө амжилттай болбол их чухал болох юм шүү, бид сайн болгохыг хичээнэ, та ч чармайгаарай.

Керри урамшин хөөрч:

- Чадах чинээгээр чармайлгүй яах вэ гэлээ.

- Сайн хүүхэн шүү гэж магтаад нэг хуруугаа гозолзуулан дамшигласнаа:

- Хамгийн санй тоглохын төлөө чармайхаа л бүү мартаарай гэхэд Керри:

- Чармайн аа гэж ам дүүрэн хэлэв.

Тэр өглөө бүх хорвоо нарны гэрэлд бүхлээрээ гийсэн ч юм шиг, цэлмэг хөх тэнгэр тэр чигээрээ дотор нь ороод ирсэн ч юм шиг Кеерид санагджээ. Зорьсондоо итгэл төгс тэмүүлэх хүмүүс баяртай байлгүй яах вэ? тэднийг сайшаан мишээх хүмүүс нь ч баяртай байлгүй яах вэ.

ТЭГ ТАТСАН ГАЗРЫН ЦААНА МЭНДГҮЙ УУЛЗААД, БАЯРГҮЙ САЛСАН НЬ

Арван зургааны орой Херствүдийн овжин гар юу чаддагаа харуулжээ. Херствүд нөлөө ихтэй олон найзаа тэнд очоорой гэхэд л Квинселийн худалдсан билет бодож байснаас нь хавьгүй олон байжээ. Өдөр тумын сонингуудад дөрвөн мөр зарлал гаргасан байв. Херствүд “Таймс” сонины ерөнхий эрхлэгч өөрийн найз Харри Мак-харрен гээг хүнээр дамжуулан энэ ажлыг зохиожээ.

Түүнийг нэг орой Херствүдийн зоогийн газар сүүлчийнхээ аяга сархадыг уучихаад гэр рүүгээ гарахаар болоод байхад Херствүд:

- Харри, та нэг тус болохгүй юу? гэхэд цаадах нь:

Энэ сүрхий хүн бас хүнээс юм гуйдаг байх нь ээ хэмээн дотроо олзуурхан, дуртай гэгч нь :

- Юу юм бол? гэв.

- Хандгай нийгэмлэгийн эндхийн салбараас өөрсдийн хүчээр нэг жүжиг тавих гэж байгаа юм. Тэгээд тэр тухай сониндоо хэдэн үгээр мэдээлж болохсон болов уу л гэж байгаа юм гэхэд Мак-Харри,

- Бололгүй яахав, Жорж, би үүнийг таны төлөө хийж гүйцэтгэе гэлээ.

Херствүд ар хударгаар нь ажиллаж байсан болохоор нийгэмлэгийн гишүүд нь өөрсдийнхөө тэр сэдсэн жаахан ажлыг тийнхүү олны сонирхол их татаж буй учраыг олохгүй, Квинселийг л иймэрхүү ажил хөөцөлдөхдөө гарамгай хүн юм гэж бодоцгоожээ.

Арван зургааны орой бодоход Херствүдийн найз нар гэж сенаторынхаа дуудлагаар цуглаж буй ромчуудын адилаар цутган орж иржээ. Керрийн төлөө Херствүд тийнхүү гоё ганган хувцасласан сайн санаа өвөрлөсөн, бодь сэтгэл баримталсан хүн олныг ирүүлэх гэж оролджээ. Жүжигт анх удаага атоглох гэж байгаа залуу хүүхэн маань үгээ сайтар цээжилж, сэтгэлдээ шингээж чадсандаа дотор нь овоо уужрах шиг авч ганган дэгжин өдий төдий хүний нүдний өмнө тайзны хурц гэрэлд гарч очно гэхээс өөрийн эрхгүй чичирнэ. Жүжигт эр эм нийлсэн хориод хүн тоглоно. Ямар болох нь бүгдээс шалтгаална гэж сэтгэлээ тайвшруулахыг оролдовч ганцаараа алдаа хийж баларвал яана гэхээс яс нь хавталзаж байв. гэнэт үгээ мартчихаад паг болбол яана, дүрийнхээ сэтгэл санааг гаргаж чадахгүй болбол яана, ер нь хэрэггүй л энэ жүжигт тоглоно гэж оролдлоо гэж бодно. Хэлэх үгээ ч мартаад дүрийнхээ намбыг ч алдаад олны өмнө нүүр улайлган, юу ч хэлж чадахгүй, жүжгийг нь тэр аяар нь нураавал яанаа гэж айна.

Бусад жүжигчдийн тухайд гэвэл Бамбергерийг найруулагч нь голсоор байгаад хасчээ. Морган хатагтай үлдсэн боловч Керрид атаархаж өшөөндөө өөрөөс нь дутахгүй тоглох юм хуна гэж хатуу шиддсэн аж. Рейн дүрд ажилгүй байсан мэргэшлийн нэг жүжигчинг урьжээ. Тэр нь нэг их чадамгай жүжигчин биш ч гэсэн бусдыгаа бодвол яадаг бол ийдэг бол гэж сүрдэж зовохгүй байв. тэр хүн урьд театрын жүжигчин байсан гэдгээ хэрхэвч мэдэгдэж болохгүй гэсэн заавар авсан хирнээ тайзан дээгүүр хэзээ ёзооны долигоршон янзтай бараг хэн гэдгээ мэдэгдчихмээр ханхалзана.

- тун амархан, үзэгчдээс зовох хэрэг юу байхав хамгийн гол нь дүрийнхээ санааг гаргах л амаргүй гэж Морган хатагтайд жүжигчний нялуун зан гарган хэлж байв.

Керри түүнийг харахаас зэвүү нь хүрэх боловч дургүй байгаагаа нууж чадахуйц жүжигчний авьяастай байсны дээр ялангуяа тэр орой ямар ч болтугай түүнд хуурамчаар сэтгэлтэй байх хэрэгтэй байлаа.

Зургаан цагийн алдад Керри тайзнаа гарахад бэлэн болов. хэрэгтэй бүхнийг урьдаас жин тан болгожээ. Өглөөнөөс эхлэн нүүрээ будаж гоодох дасгал байн байн хийж, нэг цагийн алдад үнээдахин нэг давтан мадаггүй болгоод үзэш болохыг хүлээх зуур үгээ хааяа хааяа лавлан харж байв.

Тэр удаа нийгэмлээс унаа ирүүлэв. Дрүэ, Керритэй хамт тэргэнд сууж гадаа гарснаа тамхи авна хэмээн бууж ойрийн дэлгүүр рүү явав. Шинэхэн жүжигчин маань саатан хүлээж байсан цаг нь болж сэтгэл ихэд догдлон үзэсгэлэн гоо Лаура охин болж хувирахаар жүжигчний өрөөнд оров.

Хийн дэнлүүний хурц гэрэл, жуулчлалаар явахыг завдан буй хүмүүс хувцас хунараа чихэж ундуй сундуй задгай орхисон авдар сав юмуу гэмээр энд тэндгүй харагдах уруул хацрын уоан будаг, нүүрний оо, цагаан будаг, шатаасан илчүү, бэх, сормуусны будаг, хиймэл үс, хайч толь мэтийн нэрлээд нэрлээд бармигүй янз бүрийн зүйлс нь цаанаа л нэг гайхамшигтай сайхан уул амьсгалыг бий болгох мэт ажээ. Керри энэ том хотод ирээд хүчтэй сэтгэгдэл төрсөн зүйл олон боловч тэр бүхэн нь хэтэрхий ахдаж томдсон мэт санагддаг амуй. Ядуу охинд харахаас сүрдэж алсаас сониучлах төдий хүртээлтэй байсан олон орд харшийг бодвол энд огт өөр сэтгэгдэл төрүүлжээ. Ороод очиход өөдөөс нь хүн тосож халуун дотноор “Хонгор минь, наашаа ор” гэх шиг болов. Энд үүд хаалгаа цэлийтэл нээсэн өгөөмөр газар мэт санагджээ. Том үсгээр бичсэн зарлал, сонинд бичсэн зүйл, тайзны ганган засал, хүрэлцэн ирж буй гоё сайхан сүүх тэргүүд, энд тэндгүй харагдах алаг эрээн цэцэг, хүмүүсийн хоорондоо дүнгэр дүнгэр ярилцах чимээ тэр бүхэн Керрид гайхмаар сайхан санагдана. Хоосон зүүд биш бодит үнэн байлаа. Бүгдийг үзэж болох онгорхой хаалга энд буй мэт. Керри харанхауйд бүдчин хадчин явсаар гэрэлтэй газар гарсан хүн шиг энэхүү талст эрдэнэсийн гэрэл цацарч, жаргал цэнгэлийг бэлэгдсэн гэмээр газар ороод ирэх нь тэр.

Керри жижигхэн өрөөндөө хувцсаа яаруухан сольж өмсөх зуур Квинсел ноён ийш тийш яаран харайлгаж буй чимээг сонсов. Морган Хогленд хоёр хатагтай сандчин бэлдэж, жүжигт тоглох хорин хүн хориул л юу болж төгсдөг бол хэмээн санаа зьвон холхилдож байгааг харахаас энэ байдал удаан үргэлжлээсэй, одоо амжилттай тоглочихоод хэзээ нэг цагт жинхэнэ жүжигчин болчихвол яасан сайхан бэ хэмээн бодож байлаа. Тэгж бодохоос сэтгэл нь тун их хөдөлж хамаг авьяасчадлаа дайчлах урам зориг оргилж, хүсэл мөрөөдөл чихэнд нь хуучны дууны уянгат ая сонсдох мэт болов.

Яг тэр үед театрын хөлийн өрөөгөөр бас нэг сонирхолтой явдал болж байв. Хесртвүд санаачлага гарган хөөцөлдөөгүй бол нийгэмлэгийн гишүүд нь хэзээний нэг их анаарадаггүй байсан болохоор тийм олон хүн ирэх болов уудаа. Херствүдийн үг нөлөөтэй жинтэй байж. Аль болохоор гангалж ирэхийг ч нөхдөдөө захисан байв. Дөрвөн лоожийн суудал бүгд эзэнтэй байлаа. Нэгд нь Норман Мак-Нил дозтор хүртэл авгайтайгаа сууж харагдана. Бас нэгд нь бөс барааны худалдаачин, хувь хөрөнгө нь дор хаяад хоёр зуун мянган доллартай Воркер ноён суужээ. гурав дахий нь нүүрсний нэрт худалдаачин, дөрөв дэхий нь Херствүд нөхдийнхөө хамт худалдан авчээ. Тэдний дотор Дрүэ ч байв. Тэнд очсон хүмүүс үнэнийг хэлэхэд хотын алдар цуутан биш, хөлгүй баячуул ч биш, харин нилээд чинээлэг буюу тус нийгэмлэгийн гишүүд л байлаа. Тэд бие биенийхээ хэр чадлыг андахгүй. Тэд бага зэрэг хөлжиж сайхан байшинтай буюу, сүүх тэрэгтэй

болсон, аятайхан хувцасладаг худалдааны ертөнцөд итгэл хүлээсэн нэгнийгээ ихэд хүндэтгэдэг улс. Тийм учраас хүн төрөлтний амжилтын дээд хязгаар гэж хэлэх нь юу юм ч гэсэн, ухаалаг бөгөөд ажил төрөлд чадамгай, буурь заадаг, овоо дөнгүүр ажил хийдэг, бас хүн хартай эвлэгхэн харилцаж чаддаг болохоороо Херствүд тэднийхээ дотор томхон амьтан байлаа.

Тэр орой Херствүд онгод нь орсон юм шиг байв. “Кектор” гэдэг зоогийн газраас хэдэн нөхрийнхөө хамт шууд иржээ. Хөрийн өрөөнд дөнгөж түрүүхэн тамхиа худалдаж аваад ирчихсэн Дрүэтэй уулзаж тэнд байсан хүмүүсийн тухай болон Хандгай нийгэмлэгийн талаар баахан ярилцав.

Херствүдийг дотогш ортол суудлын ар талын зайд баахан хүн бөөгнөрөн юм ярилцан инээлдэх нь цэлийсэн гэрэлтэй баяр ёслолын байдалтай тэр том рөөнд нь илхэн харагдана. Херствүд нэг хүнийг хараад:

- Яасан сонин хүн бэ? уулзсангүй уджээ гэхэд цаадах нь:

- За, ноён Херствүд сайн уу? гэв.

- Тангай уулзсандаа их баяртай байна гээд Херствүд гары нь дотноор атгав.

- Янз нь амжилттай болох нь шиг байна.

- Найдаж болмоор байна.

- Гишүүд нийгэмлэгээ их дэмжлэг болоо шив дээ гэхэд Херствүд:

- Тэгэх л ёстой доо. Би л лав үүнд баяртай байна гэлээ.

Цамцных нь цардмал зах жигтэйхэн ёрдойсон нэг пагдгар эр Херствүдээс:

- Сайн уу? Жорж? Ажил бүтэмжтэй юу? гэж асуув.

- Бүтэмжтэйгээр барах уу.

- Та чинв яагаад энд ирээ вэ? Гишүүн биш биз дээ?

- Сайн санаа минь хөтөлж авчирлаа. Хуучин найз нөхөдтэйгээ уулзах таатай биш үү? Гэхэд Херствүд хариу хэлэхэд нөгөө хүн:

- Авгай тань яасан бэ? гэв.

- Ирээгүй, бие нь чилээрхээд ирж чадсангүй.

- Харамсалтай хэрэг байна даа, ерөнхийдөө гайгүй биз дээ?

- Гайгүй, гайгүй, ялимгүй л чилээрхсэн.

- Таныг Сент Жо руу авгайтайгаа хамт явж байхад нэг үзсэн юм гээд тэр тарган эр баахан залхуутай юм ярьж эхэлтэл ашгүй Херствүдийн шинэ шинэ танил орж ирэн трэ уяггарт ярианаас

ангигжруулав.

Баруун хорооллын оршин суугч, хотын зөвлөлийн гишүүн, бас тус нийгэмлэгийн гишүүн нэг хүн:

- Сайн байна уу? Жорж, ажил төрөл ажилттай юу гэхэд:

- Баярлалаа, ажил өөдөрөг, та хотын зөвлөлд сонгогдсон гэл үү? Гэв.

- Тэгсэн шүү, бид өрсөлдөгчөө төлөөгүй амархан ялсан гэж төрийн зүтгэлтэн сайрхав.

- Одоо Хеннеси юу хийх бол?

- Тэр чинь тоосгоны үйлдвэртэй хүн, тосгон дээрээ очих байлгүй.

- Тийм юмуу? Би мэдээгүй шүү. Ялагдаад их уурласан байх даа.

- Тэгсэн бололтой гээд зальжнаар нүд ирмэв.

Тэгсгээд Херствүдийн ирээрэй гэж урьсан бүр илүү дотно нөхөд нь сүүх тэргүүдээр хүрэлцэн ирж эхлэв. Тэд цайныхаа хувсыг өмсөж гоё ганганаараа гайхуулан, их л маадгар, гэхэг дохог хэмээн орж ирцгээнэ.

- Бид ч ингээд цуглаж орхих шив дээ? гэж Херствүд дөрнөгж орж ирж буй дөчин тав эргэм насны хүнд хэлэхэд тэр нь:

- Яг үнэн гэснээ,, Херствүдийн мөрнөөс татаж ойртуулан инээмсэглэж:

- Сайхан юм үзүүлэхгүй бол толгойгүй болно гэж мэдээрэй гэв.

- Жүжиг ямар хамаа байх вэ? хуучин найз нөхөдтэйгээ уулзахын тулд ээн зэргийн үнэ төлж болдог юм байгаа биз дээ? гэж Херствүд хариу тоглов.

- Их сонин жүжиг гарах нь уу даа? гэж нэг нь Херствүдээс асуухад мань эр хариуд нь:

- Би өөрөө ч мэдэхгүй байна, олигтой юм болох юм болов уу гэснээ гараараа сайхан зангаж:

- Масоны нийгэмлэгийн хувьд... гэв.

- Хүн олон цугласан байна шүү, тийм ээ?

- Тийм байна. Хүүе, ноён Шэнехен саяхан өөрийг чинь сураад байсан, заавал олж уулзах хэрэгтэй шүү.

Ийнхүү ганц хүний хүссэн ёсоор тэрхүү жижигхэн театрт баячуул цугларч торго дурдан дээл хувцас намирч, цардмал цагаан цамц гял цал хийж, тоглоом наадмын үг энд тэндгүй сонсодсон тийм нэгэн орой болжээ. Хөшиг нээгдэхээс хагас цагийн өмнө Херствүдийг харсан бол дарайсан цардмар захтай цамцтай, зангиандаа очир алмас зүү хатгасан тав зургаан хүнтэй харилцан ярилцан мөн ч догь харагдаж байх ажээ. Эхнэртэйгээ ирсэн эрхмүүд нь Херствүдийг овог нэрээр нь дуудан гар барина. Билет шалгагчид тэр хүмүүсийн өмнө хүндэтгэл илэрхийлэн бөхөлзөн

нахилзаж, сөхдөг сандлууд тар түрхийн дуугарч байхад Хесртвүд тэр танхимыг нүдхэсүүлэн сэтгэл хангалуун янзтай ажиглан харав. Тэнд цугласан хүмүүсийн нэрээ хичээсэн эрмэлзлийг Херствүд нийтэд нь төлөлөөн гялзалзаж буй бололтой. Зиндааныхан нь түүнийг тоож, зулгуйдаж, бараг л толгойлогчоо гэж үзэх нь холгүй мэт. Ер нь тэднийхний дунд дээгүүр жаалж, нэг ёсондоо их хүн гэж тооцогдож байдаг бололтой.

ХҮСЛЭНГИЙН ЕРТӨНЦӨД ӨНГӨРӨӨСӨН НЭГ ЦАГ, ДУУЛДАХЫН ТӨДИЙ ГОМОРХОЛ

Сүүлчийн бэлтгэл дуусаж хөшиг нээгдэхэд бэлэн болов. Жүжигчд нүүр амаа будах ажлаа дуусган зархим нь хүлээн суусан байв. Удирдаач, дохиураараа занган дэлдэхэд хөлсний найрал хөгжимчид оршил хөгжим эгшиглүүлэв. Херствүд дуугаа хурааж Дрүэ, найз Сэгер Моррисоныхоо хамт суудал руугаа явав.

- за одоо жаал охиноо яаж тоглохыг нь харна даа гэж Херствүд Дрүэд бусдад дуулдахааргүй хэлэв.

Тайзан дээр уг жүжгийн анхны үзэгдлийг зочны өрөөнд болж байгаа байдлаар зургаан жүжигчин эхлэн тоглов. Дрүэ, Херствүд хоёр, Керрийг гарч ирээгүй байхад шивнэлдсээр байв. Нэгдүгээр үзэгдэлд Морган хатагтай, Хогленд хатагтай, Бамбергерын оронд орсон мэргэшлийн жүжигчин Пэттон нар гарч ирсэн байв. Пэттон бусдаас гаргууд биш боловч хэрэггүй байдлаараа ялгаатай харагдах ба тийм байх нь ч үнэндээ тун чухал санагдана. Морган хүүхэн,

Пэрл болж тоглохдоо дэндүү их бэмбэгнэж байв. Хоглендын дуу сөөнгө сонсдоно. Бүгдийг өвдөг чичирч цээжилсэн үгээ л зүгээр уншиж буй мэт байлаа. Жүжиг муу болоход үзэгчид суудалдаа хавчигнаж аяндаа дургүйцэж эхэлдэг атал энд цугласан хүмүүс тэгсэнгүй, харин зовж байгаагийг нь ойлгон тэсгээд гэрэвших нь гайгүй болох биз хэмээн сайн санаа өвөрлөн тэвчиж байв.

Херствүд огт чимээгүй суув. Угаас тэр жүжгийг нэг их чухалд тооцоогүй гагцхүү Керрийг амжилттай тогловол хөхүүлэн магтаж цэцэг барих гэж гол нь бодож байсан хүн л дээ.

Жүжигчдийн анхны цочоо гарч тайзан дээгүүр овоо зоригтой алхаж гишгэх болсон авч сэтгэлийн ямар ч хөдөлгөөнгүй, үг яриа нь үзэгчдийн залхуу хүргэж эхлэв. Төдөлгүй Керри гарч ирлээ. Херствүд Дрүэ хоёр харуугаа л Керрийг сөхөрч унах нь үү гэмээр өвдөг нь жигтэйхэн чичирч буйг харав. Тайзан дээр хөлөө арай ядан чирэн гарч ирмэгцээ:

- Өе, эрхэм ноёнтой та дөнгөж сая ирэв үү. Бид таныг найман цагаас хойш хүлээж байна гэж ямар ч сонирхолгүй, дуулдахтай үгүйтэй хэлсэн учир нөхдийнх нь дотор палхийв.

- Айчихаж гэж Дрүэ шивнэхэд Херствүд дуугарсангүй.

Одоо хэлэх үг нь үзэгчдийг инээлгэх ёстой байлаа. Керри:

- Энэ чинь намайг өвчнөөс аврагч үрэл гэсэн үг дээ гэв.

Гэвч энэ үгээ даанч олхтогүй хэлэв. Дрүэ суудалдаа хавчигнахад Херствүд шаахайныхаа хоншоорыг ялимгүй хөдөлгөв.

Дараа нь Лаура Керри заналхийлж буй аюулыг сөрж суудлаасаа босож “Пэрл, та ингэж хэлэхийн хэрэг юу байна, хүнтэй суугаагүй охиныг нөхөртэй хүний нэрээр дуудаж араар нь тавина гэсэн хуучны үг байдаг шүү дээ” гэсэн үгийг гунигтайгаар хэлэх байсан атал Керри ямар ч сэтгэлийн хөдөлгөөнгүй хэлэв. Дүрдээ ердөө ч итгэж чадахгүй, зүүд нойрон дундаа байгаа мэт харагдана. Тэртэй тэргүй чадахгүй юм байна гэж бодсон мэт байв. Керрийг бодвол Морган хүүхэн нэлээд сэхээ авч ядахнаа үгээ овоо тод хэлж байлаа. Дрүэ тайзнаас нүдээ салгаж үзэгчдийг ажвал

хүмүүс ингэсгээд өөрчлөлт гарах байх гэж итгэсэн янзтай дув дуугай сууцгана. Хесртвүд, керрийг сай тоглуулахаар илбэдэн ховсдож буй мэт нүд салгалгүй ширтнэ, зүрх зоригийнхоо зарим хэсгийг дамжуулахыг хичээж буй мэт харагдах ба Керрийг ихл өрөвдөх ажээ.

Үзэгчид, амь зуухын эрхээр зарлага болсон, өрөөсөн гартай, ухаан нь муудаж яваа хурхираа хэмээх хочтой жижигхэн америк цэргийн хүн, өнөөх мэргэшлийн жүжигчин хоёрын яриаг сонсож овоо сэргэв. Тэр хоёрын яриа зохиогчийн бодсончлон болоогүй боловч өөрснөө нэлээд инээдтэй харагдана. Тр хоёрын дараа Керри гол дүр болон гарч ирэв. Харваас Керри биеэ захирч чадаагүй байв. Бусдыг үймүүлэгч өөдгүй этгээдийн дүрд тоглож байгаа жүжигчинтэйгээ хоёул даанч арчаагүй мануухай мэт зогссоор цааш ороход нь үзэгчид санаа нь амрах шиг шүүрс алдацгаав.

- Дэндүү зовоод байгаа юмуу даа гэж Дрүү үгэндээ итгэл муутай хэлэхэд Херствүд:

- Та очиж зоригжуулах үг хэлбэл дэр байх гэв.

Дрүү, туслахын тулд юу ч хийхээс буцахааргүй байв. Тэгээд бушуухан хажуу хаалганд нь очиж дотогш оръя гэхэд манаач нь ашгүй оруулав. Керри, дахин гарах ээлжээ хүлээж байж. Сэргэлэн цовоо байдаг нь ул мөргүй алга болсон харагджээ. Дрүү шимтэн харж:

- Керри юунаас ингэтлээ айсан юм? Болиоч, чи минь. нэг их хүн айлгамаар улс алга байна шүү дээ гэхэд Керри:

- Би өөрөө ч мэдэхгүй байна. Чадахгүй юм байна л гэж бодогдоод байх юм гэлээ.

Дрүүг ийнхүү орж ирсэнд Керри баярлажээ. Бусдыгаа сандарчихлаар өөрөө санаагаар улам унасан байж.

- Керри, битгий зовооч дээ, бие захир, юунаас нь айсан юм? Яаж тоглохыг үзүүлээд өг гэж Дрүү ятгалаа.

Дрүү ийнхүү сандран ятгахад Керри овоо уужирч эхлэв.

- тун муу тоглов уу?

- Муу биш. Зоригтой л тоглох хэрэгтэй байна. Чи өөрөө надад үзүүлж байсан шигээ л тогло. Толгойгоо жаахан ганагардуу байлгах ёстой байх шүү.

Керри гэртээ хэрхэн тоглож байснаа санаж одоо тэрнээсээ дутуугүй сайн тоглож чадах ёстой гэж биеэ дайчилж эхлэжээ.

Дрүү, Керрийн гар дахь үгийг нь хараад одоо дугий нь тоглох юм? гэхэд Керри:

- Рей, бид хоёрын яриа, би түүнтэй суухгүй гэх тэр хэсэг гэв.

- Цовоохон, зоригтойхон л тогловол болох нь тэр. Зовох хэрэг байхгүй, энд ерөөс хүн байгаа гж бодох хэрэггүй.

- Маденда хатагтай, одоо таны ээлж болж байна гэж мартсан үгий нь сануулах үүрэгтэй хүн

хэлэхэд, Керри:

- Ө, яана аа гэчихэв.

- Ингэж айхын хэрэг юу байна, аа? Керри зоригтойхон байгаач. Би чамайг эндээс харж байя гэж Дрүэ хэлэв.

- Нээрэн үү?

- Нээрэн, за яв, айж болохгүй шүү.

Үг сануулагч ч дохио өгөв.

Керри бас л зориг муутайхан алхах боловч бага зэрэг сэхээ авсан бололтой. Дрүэтхарж байгаа гэж санав. Тэгээд эелдэг, нэлээд тайван дуугаар:

- Рэй гэж хэлэх нь дуулдав.

Энэ нь сургуулилтын үед найруулагчид хамгийн их таалагдсан хэсэг аж.

“Одоо л сэхээ авч буй бололтой” гэж Херствүд бодов.

Керри энэ үзэгдлийг үзлэг дээр тоглосон шигээ сайн тоглож чадаагүй боловч ерөнхийдөө овоо болов. Үзэгчид хараад лав л дургүй нь хүрсэнгүй. Бүх жүжигчин ерөнхийдөө гайгүй аятайхан тоглож эхэлсэн тул ганц Керрийг ажаад байх нь үгүй болов. Жүжигчид онцгой адармаатай хэсгээс бусды нь зэгсэн тглож эхэлсэн болохоор ерөнхийдөө гайгүй болж мэдэх байв.

Керри сэтгэл ихэд догдолж шаналсан байдалтай бууж ирээд Дрүэгээс:

- За ямар болов? Арай гайгүй юу? гэж асуув.

- Түрүүчийнхээс дээр боллоо. Ингэж л тоглох хэрэгтэй. Амьд дүр харуулах хэрэгтэй шүү дээ. Сая чи түрүүчийнхээсээ мянга дахин илүү тоглолоо. Одоо улам цовоо байвал таарна. Чи чадахаа л чадна. Үзэгчдийг гайхаж биширтэл нь тоглоод өг.

- Нээрэн илүү сайн тоглосн гэж үү?

- Илүү, миний бодоход л дээр болсон. Дараа нь юу билээ?

- Бүжгийн өрөөн дэх үзэгдэл.

- Энийг чи ёстой амархан чадна шүү дээ.

- Ай, мэдэхгүй, яадаг бол.

- За, за ингэхээ боль. Надад тоглож өгсөн шүү дээ. Түүн шигээ л тоглож орхи. Өөрийнхөө өрөөнд л байгаа юм шиг бод. Энэ үзэгдлээ сайн тоглож орхивол гайхмаар сайхан амжилт болно шүү, яриангүй. Чи тун сайхан тоглож чадна. Мөрий тавьсан ч би буцахгүй. Юугаар мөрий тавих вэ? Хэл л дээ.

Дрүү бол сайн санаалах сэтгэлээ үийнхээ өнгөөр гаргадаг хүн юм. Керрийг тэр үзэгдэлд тун санй тоглоно гэдэгт үнэхээр итгэж олонд гайхуулаасай гэхээс сэтгэл нь дэвэрч урамшин хөөрч байв.

Дрүү тийнхүү сайн ятган, зоригжуулж, үнэхээр санй тоглож чадна гэсэн итгэл трөөүлжээ. Дрүүгийн үгийг сонсох тутам амжилт олох хүсэл нь сэтгэж урьдын урам зориг нь эргэж ирэх шиг болов.

- Чадмаар санагдаж байна шүү.

- Тэгэлгүй яах вэ, битгий ай.

Ийн ярилцаж байхад тайзнаа Ван Дэм хатагтай болон тоглож байсан жүжигчин Лаураг сүнсгүй муухай гүтгэв. Керри түүнийг сонсоод зорх нь булгилж, самсаа нь сарталзаж эхлэв. Рэй болж тоглож байсан мэргэшлийн жүжигчин, “Нийгэм, доромжилсон этгээдээсээ өшөө аймаар авдаг юм. Сибирийн чонон сүргийн тухай та сонсон уу? Сүргийн дотроос нэг нь доройтвол бусад нь түүнийгээ бариад идчихдэг гэсэн. Ээ жишээ нэг их аятайхан биш санагдавч хүний нийгэмд чонорхуу явдал байгаа юм шүү. Лаура нийгмийг цаагуур нь дайрлаа гээд нийгэм өөрөө цаагуураа хуурамч юм болохоор өшөөгөө авч байгаа юм” гэлээ.

Керри, “Лаура” гэж дуудахыг сонсоод давхийв. Тухайн явдал гаслантай санагдав. Ад шоо үзэгдсэн хүн ямар байдаг вэ сэтгэл нь тийм болж ирлээ. Керри уур хилэн бадраасан санаа бодолд автан хүлээн зогсоно. Хажуудаа юу болж байгааг огт сонсохоо больж гагцхүү чамархайнхаа судсыг түг түг лдугшихыг л мэдэрнэ.

- За, хүүхнүүд минь, юмаа сайн харж байгаарай. Ийм муухай хулгайч орж ирж байгаа цагт тун гэмтэй шүү гэж Ван-Дэм муухай царайлан хэлэхэд Керрийн дэргэд зогсож байсан үг сануулагч:
- Үгээ гэв.

Гэтэл Керри энэ үгий нь сонссонгүй урам зоригтоо хөтлөгдөн ургаш тэмүүлэн намбатай алхан гарч ирээд олны өмө гоёмсог, омог бардам байдалтай байсан бол үзэгдлийнхээ шаардлага дагуу аажмаар царай нь цонхигор, хөдөлгөөнгүй хөөрхий амьтан болон хувирахад цаадуул нь ихэд зэвүүрхэн ухрав.

Херствүдийн нүд бай байн анивчиж байгаа нь уг явдалд нөлөөлөгдсөнийх буй заа. Хамгийн араар суусан хүмүүст ч чин халуун сэтгэлийн илч хүрч очих мэт. Хорвоог жиүвүүлж чадам хүчтэй шунал тэчъяалын шидэт хүч аяндаа мэдэгдэх амуй. Саяхан хүртэл анхаарал тун сул байсан үзэгчид одоо тайзнаас хараагаа салгаж чадахыг болив.

- “Рэй, Рэй, чи дэргэд нь яагаад очдоггүй билээ?” гэж Пэрл орилов.

Хүн бүхэн, бардам бөгөөд зэвүүцлийг илэрхийлэн зогсох Керри рүү ширтэн хөдлөх бүрийд нь дагалдан хөдөлж, харсан зүг рүү нь хараагаа дагуулж байв.

Пэрлд тоглон буй Морган хүүхүнэ дэргэд нь тулан очиж:

- “Гэртээ харья” гэхэд Керри-лаура:

- “Үгүй, түүнтэйгээ үлд” гэж утга төгөлдөр өнгөтэй хэлэв. Түрүү нь чухам иймэрхүү өнгөтэй

хэлэх л дутагдаад байсан билээ.

Тэгснээ сэтгэлтэй хүн рүүгээ бараг л яллах маягтай зааж:

- “Энэ хүн удаан зовохгүй” гэж зүрх шимшрэм туйлын эгэл байдалтай хэлэв.

Керри ер бусын авьяас гарган тоглож эхлэхийг Херствүд харлаа. Хөшиг хаагдах үед үзэгчид нижигнэтэл алга ташсан нь үнэхээр сайн тоглосны баталгаа болов. Херствүд Керрийн гоо үзэсгэлэнг гайхахаас гадна өөрийнх нь огт хүртээлгүй юманд тийм авьяастайд нь бахархаж, ийм сайхан амьтан минийх болно гэж бодохоос баярлан:

- Сайхан боллоо! Гэж хашгираад сэтгэл хөдлөсөндөө огло харайн боосж тайзны цаагуур ордог хаалга руу явав.

Жижигхэн өрөөнд нь орвол Керри Дрүэтэй хоёул байв. Сайхан тоглосонд нь улам дуртай болж хамаг сэтгэлийнхээ үгийг урсгаж гармаар санагдавч Дрүэ дэргэд нь байгаа болохоор чадсангүй. Дрүэ ч гэсэн Керрид Херствүдээс илүү дурлаж ямар ч атугай одоохондоо түүнийгээ илэрхийлэх илүү боломжтой юм.

- Ёстой сайхан тоглолоо, догь агуу сайхан болсон шүү. Би чамайг энэ зэрэг тоглож чадна гэж бүр мэдээд байсан юм, сүрхий амьтан юмаа чи гэж Дрүэ үгээ олж ядан магтсаар байв.

Керрийн нүд сэргэж:

- Ннээрэн тийм сайн тоглолоо гэж үү? Гэнэ.

- сайнаар барах уу! Чи хүмүүсийн алга ташихыг сонссон биз дээ.

Үзвэрийн танхимд алга таших бүдэгхэн чимээ дуулдсаар байв.

- Сэтгэл санаандаа буусан юмыг тэр чигээр ь гаргаж чадлаа л гэж бодсон.

Яг тийн ярилцаж байхад нь Херствүд орж очжээ. Дрүэд дуртай биш байгааг мань эр тааварлаж, Керрид наалдан байгааг нь харахаас атаат сэтгэл цээжинд нь оволзов. Дэмий л нааш нь явуулж дээ гэж биеэ агшин зуур нэг зэмлэв. Гэвч бие хүчлэн барьж Керрийг зүгээр гэмгүй нөхөр мэтээр баяр хүргэн магтав. Энэ бол бие захирч чадсан ялалт байсан тул түүндээ урамшиж нүдэнд нь хэзээний овжин инээмсэглэл нь илрэв. Тэгээд Керрийг шимтэн харсаар:

- Дрүэ хатагтай та, тун сайхан тоглож үзэгч олныг баясуулж үнэхээр чадлаа гэж би хэлэх гэсэн юм гэхэд Керри түүний санааг сайтар ойлгож:

- Танд их баярлалаа гэв. Дрүэ, тийм хүүхнийг эзэмшиж байгаадаа бахдаж:

- Би ч гэсэн тун сайхан тоглосон шүү гэдгийг өөрт хэлж байгаа юм гэв.

- Та үнэхээр сайхан тоглосон шүү гэж Херствүд Керрийн чанх өөдөөс харж хэлэхэд түүний нүдэнд хэлсэн үгнээс нь илүү утга санаа байгааг алгууралгүй ойлгон баяртайгаар инээд алдав.

- Одоо үлдээд байгаа хэсгүүддээ бас ийм сайхан тоглох вч бол бид таныг эхээс төрөхөөсөө

жүжигчин байж л гэж бодох нь байна шүү гэхэд Керри дахин инээмсэглэв.

Керри, Херствүдийн тэсэж ядан байгааг ойлгоод түүнтэй ганцаар байх юмсан гэж бодов. Херствүдийн орж ирсэнд Дрүэ дурамжхан байгааг ойлгоогүй байж.

Херствүд, Дрүэгээс болж Керритэй юу ч ярьж чадаагүй байгаадаа эгдүүцнэ. Тэгээд Фауст шиг гадна өнгөндөө бөхөлзөж нахилзсаар гарч явсан боловч дотроо атаархан шүдээ тас зууж байлаа. “Муу золиг чинь, дандаа ингэж саад болох санаатай юу?” гэж бодсоор Херствүд суудалдаа буцаж ирээд суув. Ийм байдалтай болсноо бодохоос нэг хэсэг үг ч дуугарах тэнхэлгүй болов.

Дараачийн үзэгдэл эхлэхээр хөшиг нээгдэхэд Дрүэ суудалдаа буцаж ирэв. Дрүэ их л хөөрч мээсийсэн байдалтайгаар Херствүдэд нэг юм шивэгнэхэд цаадах нь тайз руу анхаараад сонсоогүй царай гаргав. Тайзан дээр Керри гарч ирээгүй, зөвхөн оршил хөгжим эгшиглэж байв. Херствүд үнэндээ тайзан дээр юу болж байгааг ч ялгаж мэдэхээргүй, хөөрхий болсон байдлаа сэтгэн мэлийн сууж байсан ажээ.

Жүжиг цааш үргэлжилсээр боловч Херствүдийн хөмсөг зангидаатай хэвээр. Үзэгч олон Керрийг голчлон анхаарах болов. Ийм жүжигт олигтой тоглох хүн гэж байдаггүй юм уу даагэж түрүүхэн бодож байсан хүмүүс маань одоо болохоор хүн бүрийг сайн тоглох ёстой хэмээн нөгөө нэг хэтрүүлэг рүү оржээ. Гэхдээ нийтээрээ гагцхүү Керрийг сонирхоно. Керри анхны үзэгдлийн сүүлчийн хэсэгт тоглосон шигээ тийм гойд сайхан тоглохгүй байгаа л гэсэн ер нь л тун аятайхан тоглож байв.

Херствүд, Дрүэ хоёул түүний голшиг уран хөөрхөн биеийг бхархан харж дурлан шунаж байлаа. Керри тийм эгзэгтэй нөхцөлд гойд авьяасаа харуулсан нь хамаг сайн сйахнаа алтан хүрээтэй жаазан дотроосоо нүд гялбам гэрлээр үзүүлэх шиг болж гоо үзэсгэлэнгээ даамай жинтэй болгожээ. Дрүэ түүнийг хөдөөний л нэг хүүхэн гэж үздэгээ болив. Гэртээ очоод хоёулхнаа болсон цагт ханатлаа магтхаыг хүсэн жүжиг төгсөх цагийг тэсэж ядан хүлээнэ.

Гэтэл Херствүд Керрийг гоё харагдах тусам өөрөө улам арчаагүй болох мэт санагдан, хажууд суух найзаа дотроо зүхэн хараана. Ядахнаа санаагаа ханатал олигтойхон алга ташиж ч болохгүй, дандаа худалд царайлах шиг айхтар зовлон байхгүй мэт бодогдоно.

Сүүлчийн үзэгдэлд Керри гаргуунд санй тоглоход сэтгэлтэй хоёр хүн нь нүд салган чадахгүй ширтэн суулаа.

Херствүд, тайз руу ширтэхдээ Керрийн гарч ирэхийг л хүлээв. Төдхөн гарч ирлээ. Зохиогч нь бусад жүжигчдийг үлдээгээд Керрийг тайзнаа гаргав. Керри тийнхүү үзэгч оны өмнө ганцаар гарч ирэхийг Херствүд анх удаа үзэв. Керри орж ирэхдээ түрүү түрүүчийнхээсээ улам ч илүү урам зоригтой болсон харагдана. Жүжгийн төгсгөл ойртох тусам Керри улам сайн тоглосоор байв.

- “хөөрхий муу Пэрл! Жаргал үзэхгүй явах юутай хэцүү вэ. Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэн гаргадаг улсыг бодоход бүр ч аймшигтай юм даа” гэж Керри үнэн голоосоо өрөвдсөн хүний дүрээр хэлэв.

Керри хаалганы гуя налан холхи тэнгисийг ширтэн учтгартай зогсоно.

Херствүд, Керрийг ч өөрийгөө ч гүнээ их өрөвдөж эхлэв. Керри яг л өөртэй нь ярьж байгаа юм шиг санагдана. Хүний сэтгэл хөгжмийн эгшигт уярдгийн адил Керрийн дуу хоолой, хөдөлгөөн намбанд нь Херствүд уяран мансуурах болов. Үзэгч хүн бүшд ганц өөртэй нь ярьж буй мэт санагдана гэдэг бол жүжигчний үнэ чадвар билээ.

- Гэтэл тэр хүүхэн түүнтэй ханилан суугаад сайн сайхан явж болох л байна шүү дээ. Усгал зөөлөн ааш нь, уран хөөрхөн царай нь ямар ч айлын чимэг болох хүүхэнсэн” гэж Лаура-Керри хэлэв.

Тэгээд Керри үзэгдчийн зүг эргэсэн боловч яг л гав ганцаар байгаа мэт хэнийг ч тухайлан эс хараад ширээний дэргэдэх сандал дээр сууж түүн дээр буй хэдэн номын хуудсыг сөхөж үзнэ.

- “Нэгэнт хоншоор дутсан юмыг хүсэн мөрөөдөхийг больё, ийм нэгэн хүн байдгийг хорвоод хоёрхон хүнээс бусад нь бүү мэдэг, харин одоохон гэргий нь болох гэж байгаа тэр нэгэн гэмгүй охины жаргалыг өөрийн жаргал хмээн бодъё” хэмээн шивэгнэж үл мэдээг сүүрс алдан хэлэв.

Пич Блоссомын дүрд тоглож буй жүжигчин эмэгтэй Керрийн яриан дундуур орж ярьж эхлэхэд Херствүд үнэнээсээ харамсаж, суудал дээрээ ууртай гэгч нь займчив. Эржин танын од гялалзах бор бошинз намируулж хүзүүндээ сувдан сондор зүүсэн, цагаан лавайн өнгөтэй нүүр царай, туяхан биеийнх нь намбатайхныг биширсэн Херствүд Керрийн жүжиглэхийг л хараад баймаар байсан хэрэг. Керри их ядарч хэн нэгний туслалцаа түүнд хэрэгтэй мэт санагджээ. Тоглож буй жүжгийнхээ дүрийг харуулж тийм байдалтай харагдаж байгааг Херствүд мартаад босон харайж очих шахав. Керри дахин ганцаар үлдэж сэтгэлийн хөдлөгөөн ихтэйгээр:

- “Ямар ч аюул нөмөрвөл нөмрөг, би тэр хотдоо буцна. Чадвал нуугаад, эс болбол хэлээд явна” гэв.

Тайзны араар морьдын төвөргөөн дуулдаж:

- “Үгүй, би өнөөдөр дахиад морь унахгүй. Цааш нь авачаад уя” гэх Рэйн дуу сносдов.

Рэй орж ирлээ. Херствүдийн амьдралд эмгэнэл болсон янаг амрагийнх нь явдалд ч , ер бишийн адармаатай хувь заяанд нь ч их үүрэг гүйцэтгэх ёстой үзэгдэл эхлэв. Учир юу гэвэл Керри тэр үзэгдлийг өөртөө тун их холбогдолтой гэж бодож байсан болохоор эхнийхээ үгнээс эхлэн урам зориг ыбадрангуй тоглож гарав. Улам бүр чадамгай тоглож буйг Херствүд, Дрүэ хоёул ажиж мэдлээ.

Лаура сэтгэлтэй байсан хүндээ хандаж:

- “Би, таныг Пэрлтэй яваад өгсөн гэж бодсон юм” гэлээ.

- “Би замынхаа хагаст ороод хамт явсан хүнээ замын тэртээ нэг бээрийн зайд орхисон”

- “Пэрлэтэйгээ муудчихаагүй биз дээ?”

- “Үгүй... тэгсэн. Бид хоёр ер нь дандаа муудаж байдаг хоёр”. Манай барометр ямагт “үүлтэй”, “бүрхэг” гэж зааж байдаг шүү дээ.

“Та хоёрын чинь хэн буруутай байдаг юм?” гэж Керри сэтгэл амгалан асуудад Рэй биеэ өмөөрч:

- “Би л лав бруугүйдэг. Чадах ядахаараа л оролддог, гэтэл тэр...”

Пэттон ингэж ярихдаа үхээнц байдалтай байсан боловч Керри чадварлаг хөдөлгөөнөөрөө үүний нь нөхөөж:

- “Гэлээ ч гэсэн тэр чинь таны гэргий. Эхнэрээ хайрлах гэр бүлийн амьдралд хамгийн чухал байдаг байх. Муудалцаж, зовлон эдлэхийн хэрэг байхгүй” гэж хэлэх үгээ дуусгаж байгаа Рэйн нүүр рүү эгцлэн харж дуу хоолойгоо зөөлрүүлж царайдсан янзтай хэлээд жижигхэн хоёр гараар элгээ тэврэв.

Херствүд амаа ялимгүй ангайн харж сууна. Дрүү суудал дээрээ ханхалзан сэтгэл хангалуун янзтай байх Керригээс зүйрлэшгүй муу тоглох нөгөө жүжигчин:

- “Миний эхнэр нь ч миний эхнэр л дээ...” гэж эв хавгүй хэлэв.

Гэвч энэ нь Керрийн тоглолтонд муугаар нөлөөлдсөнгүй. Тэр ч бүү хэл ер нь түүний тийм арчаагүй тоглохыг ч огт анзаарсангүй. Муу жүжигчин байтугай модны хожуултай хамт тоглолоо ч сайхан ч тоглочихоор байв. Өөрөө жүжгийнхээ утга санаа учир холбогдлыг гүн гүнзгий тусгаж чадсан болохоор хамтран тоглох жүжигчдийн тоглолт ч нөлөөлж эс чадна.

- “Та гэмшиж байгаа биз дээ?” гэж Лаура зэмлэнгүйгээр асуухад Рэй жижигхэн гараас нь шүүрэн барьж:

- “Би таныг алджээ. Намайг жогтой нүдээрээ харж, сээтэн хаясан ахны тийм хүүхний л урхинд оржээ. Танаас л боллоо, та намайг юу гэж хаясан юм бэ?” гэхэд, Керри сэтгэлээ барьж ядсан байдалтай аажуухан эргэснээ дахин сэтгэлт хүн рүүгээ эргэж:

- “Рэй, би таныг өөртэйгөө бүхий л талаар адилхан тийм сайн эмэгтэйд хайраа үүрд өгч дээ гэж бодсон юм. гэтэл одоо яасан аймаар үг хэлнэ! Таныг аз жаргалаас тань юу төөрүүлээд байдаг юм бэ?” гэв.

Энэ асуултыг хэн бүхэнд хамаатай мэтээр тун эгэл жирийн байдалтай тавьсан учир үзэгч бүхэн дотроо сэрдхийлээ. Гэтэл Лаурад сэтгэлтэй байсан хүн нь тэсгэлгүйгээр:

- “Лаура, урьд та надад ямар байсан билээ, дахин тийм болооч дээ” хэмээн дуу алдахад Керри туйлын жээлдгээр:

- “Танд би урьдынхаа хэвээр байж чадахгүй л дээ, харин таны хувьд нэгэнт үхсэн Лаурагийн чинь сэтгэлээр ярьж чадах байна” гэв.

- “Тэгвэл яана гэх вэ, өөрөө л мэд” Херствүд суудал дээрээ займчин урагшаа налсхийлээ, үзэгчид одоо яах бол хэмээн таг чиг чимээгүй чагнана.

Керри, сандал дээрээ урвайн суух сэтгэлтэй хүн рүүгээ гунигтайгаар харж:

- “Таны мэлмий туссан эмэгтэй чинь ухаантай буюу унхиагүй, царайлаг буюу царай дорой, баян буюу хоосон, ямар ч байлаа танд өгөх буюу эс өгч мэдэх нэг л юмтай, тэр бол сэтгэл зүрх нь билээ” гэв.

Дрүүгийн хоолой зангирч эхлэв.

- “Гоо үзэсгэлэн, ухаан, хамаг бүхний нь худалдан авч болох авч сэтгэл нь юугаар ч хичнээн ч их мөнгөөр худалдан авч үл болох эрдэнэ юм” гэв.

Керрийн хэлэх үг өөрт нь зориулсан мэт тул Херствүд гүнээ шаналан суулаа. Хоёулхнаа байгаа юм шиг санагдан, сэтгэлтэй хүүхнийхээ өрөвдмөөр атлаа үзэсгэлэн гоо харагдахы нь бодохоос нулимсаа барьж ядан сууна. Дрүү хажууд нь бас бодол болон суухдаа Керрид одоо урьд урьдынхаасаа огт өөр хүн болно, гэргийгээ болгоно, заавал сууна, ийм хүүхэнтэй суухгүй бол ямартай суух вэ гэж шийдэж байв.

Керри, сэтгэлтэй хүнийхээ хэлсэн үгийг бараг сонсолгүй, дуу хоолойгоо хөгжмийн гунигт аянд тааруулан:

- “хариуд нь танаас тун шалихгүй юм шаарддаг юм шүү. Нүдэнд тань үнэнч хайр, дуу холойнд тань эелдэг зөөлөн ая, ажил төрөл, зорилгыг минь ухаарч чадсангүй гэж дотроо голох буюу зэвүүцэхгүй л байхыг гуйдаг юм. Санасан сарвайсан бүтэхээ ыольж хамаг юм цаашаа харах цагт сэтгэлийг танв тэжээх цорын ганц юм хайр сэтгэл үлдэнэ... та ургаа модыг хараад сүр хүчий нь бахадна. Гэтэл сайхан анхилуун үнэрээсээ өөр юу ч өгч чадахгүй өчүүхэн хөөрхий цэцгийг өрөвдөх хэрэгтэй шүү дээ... Эмэгтэй хүний бэлэглэж чадах цорын ганц юм бол хайр сэтгэл нь гэж тун нухацтай эелдгээр хэлээд: -Гэхдээ эмнэгтэй бидний амьд явах насан турш хадгалах цорын ганц эрдэнэ маань хайрын сэтгэл юм даа” гэж үгээ төгсгөв.

Херствүд Дрүү хоёул залуу жүжигчнийг илбэдүүлсэн мэт ширтэхдээ хамгийн сүүлд хэлсэн үгийг нь бараг сносолгүй гагцхүү тайзнаа ер биш намбатай чадамгай тоглох хүний хөдөлгөөнийг даган харсаар байв.

Тэр хоёрын толгойд түмэн бодол давхцан орж ирж байв. Керрийг тайзан дээр дахин раргаж ирүүлэх гэж үзэгчид урин алга нижигнүүлэхэд тэр хоёр ч адилхан мэрийлээ. Дрүү алгаа өвдтөл ташсаар сүүлд нь суудлаасаа босон харайв. Керри тайзан дээр гарч ирвэл өөдөөс нь том гэгчийн баглаа цэцэг барихыг үзээд дороо хүлээн зогсов. Херствүдийн бэлдсэн цэцэг аж. Керри, Херствүдийн суудал руу харж харцтай нь тулгараад мишээв. Херствүд, сэтгэлтэй хүүхнээ тэврэх гэж арай л суудлаасаа огло үсэрсэнгүй. Эхнэртэй хүн байж болгоомжтой байхаа ч мартсан байлаа. Өөрийг нь андахгүй мэдэх хүмүүс тэнд байгааг ч бараг мартжээ. Энэ хүүхнийг л өөрийн болговол яасан ч яадаг юм гэсэн янзтай харагдана. Одоо дахин мунгинахгүй. Дрүүг замаасаа зайлуулна. Тонилгоно, ганц ч өдөр хойш тавихгүй, доншуур худалдаачинд Керрийг дахин эзэмшүүлэхээ больё гэж бодлоо.

Херствүд сэтгэл нь ихэд хөдөлсөн учир суудалдаа ч сууж чадахгүй байв. Гүн бодолд автан хөрийн өрөө рүү орсноо бүр гадаа гарч үзлээ. Дрүү тайзны араас гарч ирээгүй л байлаа. Жүжиг хэдхэн минутын дараа дуусах байв. Херствүд, Керритэй хоёулхнаа уулзаж хайр сэтгэлээ хэлж, эрхний хайрынхаа үгийг шивнэн шивнэн хэлэхийг хүсэвч наанаа инээмсэглэж, худал царай гарган арга буюу бөхөлзөж нахилзаж байдагтаа бухимдан уур нь хүрнэ. Хүсэж горьдсон маань талаар өнгөрөх нь гэж бодохоос цухалдаж, элэг зүрх нь өвдөж ёолмоор болно. Ядахнаа л оройн хоолонд урьбя гэхнээ баахан худал хэлж хуурмаг байдал гаргахаас нааш бүтэхгүй ийм байдалтай байгаага бодохоос боож үхмээр санагдана. Тгж байснаа эцэст нь тайзны араар орж Керрийн бие ямар байгааг нь асуучя гэж шийдэв. Жүжиг төгсөж жүжигчид хувцсаа сольж хоорондоо ярилцан гэр гэрийн зүг яарч байв. Дрүү хөөрч, шунал тачаалдаа автан зогсоо зайгүй чалчсаар байв.

Зоогийн газрын эзэн маань маш их тэвчээр гарган биеэ барина.

- Одоо гурвуул эндээсээ оройн хоолонд орно биз дээ? гэж дотроо бодож байгаатайгаа огт үл нийцэх хоолойгоор Херствүд хэлэхэд Керри өөдөөс нь харж инээмсэглэн элэгсгээр:

- Тэгэлгүй яахав гэлээ.

Жижигхэн жүжигчин маань хязгааргүй баяртай байв. Одоо л хүний хайр авна, хүний хайр сэтгэлийг татна гэдэг юу болохыг ухаарч мэдэрч байна. Хүн бүхэн шагшин гайхаж, хүн бүхэн түүнтэй танилцахыг хүснэ. Амжилт олсны ачаар өөрийн толгой мэдэлтэй явахын анхны шинж мэдрэгдэх авай. Түрүүчийн явдал одоо өөрөөр эргэж, сэтгэлтэй хүнээ аргадах биш, харин ч аргадуулах чадалтай болж байв. Үнэндээ өөрөө ингэж бодоогүй болов аяндаа тийм болох ёстой билээ. Керрийг бэлэн болмогц гадаа хүлээж байсан сүүх тэргэнд орж сууцгаан ресторан руу явав. Дрүэг орж суухаас өмнө Херствүд амжиж орсон тул Керри гары нь халуунаар атгаж талархсанаас илэрхийлэхэд Херствүд арайл ухаан алдсангүй хайр дур нь бялхан оргилох тул сүнсээ худалдаад ч болтугай энэ хүүхнийг өөрийн болгохоос буцахааргүй болов. “Яасан хэцүү юм, яасан тамтай юм” гэж арай л хэлчихсэнгүй.

Дрүэ трэ өдөр нэг их юмхийж бүтээсэн хүн шиг сүржигнэн хувиа огтхон ч тавиагүй нь мэдээж хэрэг. Хоолон дээр түүний эцэс төгсгөлгүй чалчих нь Херствүдэд нажидтай санагдана. Херствүд гэрийн зүг явахдаа дур хүслээ эс хангаваас үхтүгэй хэмээн бодож байжээ. Мань эр далим гарган “маргааш” гэсэн үг хэлж амжихад Керри түний нь ойлгожээ. Тэгээд Дрүэг тэр сайхан олзтой нь орхиж ябах болсондоо хорсон түүнийг алчихсан ч гар чичрэмгүй санагджээ. Керри ч гэсэн тусгүй вч болж байгааг бодохоос хачин урамгүй санагдана.

- Сайхан нойрсоорой! Гэж Херствүд дуу хоолойндoo хуурамчаар нөхөрсөг өнгө оруулахыг хичээж хэлэв.

- Та сайхан нойрсоорой гэж жижигхэн жүжигчин эелдгээр хэлэв.

Херствүд одоо Дрүэг үнэн голоосоо үзэн ядаж дотроо “Тэнэг, солиот. Би чамайг даа, учры нь олохоо л олно удахгүй. Маргааш хэн нь хэнийгээ дийлдгээ харна гайгүй” гэж зүхсээр байв.

Дрүэ, Керрийн гарыг чанга атгаж магтах үгээ олж ядан:

- Гайхамшигтай охин юмаа. Энэ хорвоод чам шиг ийм охин ховор биз гэв.

СЭТГЭЛИЙН ДУУДЛАГА, ТЭЧЬЯАЛЫН ТЭМҮҮЛЭЛ

Херствүд мэтийн хүмүүс өөрсдийн шунал тэчьяалыг туйлын нүргээнтэй гаргадаг юм. Бодол болох буюу хүсэн мөрөөдөх байдлаар илрэх нь биш. Тийм хүмүүс сэтгэлтэй хүнийхээ цонхны дор горилон зогсохгүй, уйтгарлан шаналах буюу давшгүй бэрхшээлд тулгарлаа гээд гомдоллохгүй. Херствүд тэр шөнө есөн шидийн юм бодсоор нойр муутай хонож өглөө эрт босмогцоо сэгэл зүрхнийхээ хайртыг бас л хүчлэн мөрөөдөж бодож эхлэв. Керрийг уоьд урьдынхаасаа илүү бишрэн хүсэмжилж замд нь Дрүү саад болох тул шаналан зовсоор бие сэтгэл хоёр нь биш болж иржээ. Сэтгэлитэй хүний нь хөтсөргөн хөмсөгтэй зантай тэр нэг муу доншуур худалдаачин эзэмшиж байгаа гэж бодохоос Херствүд хэн хэнээс илүү, юутай ч зүйрлэшгүй ихээр өөрийгөө шаналгаж байв. Энэ адамраатай байдлыг төгсгөл болгож Дрүүг замаасаа зайлуулахны тулд Херствүд юу чхийхээс сийхгүй байлаа.

Одоо яах ва? Херствүд бодол болсон хэвээр хувцсаа өмсөн эхнэртэйгээ хамт нэг тасалгаанд байгаа боловч түүний байгаа эсэхийг ч анзаарахгүй байна.

Өглөөнийхөө хоол ундыг идэж уух дуршил нь тун ч базаасангүй. Хоол нь цааш явж өгөхгүй байж. Тавган дээрх хүйтэн маханд хутга ч хүргэсэнгүй орхижээ. Сонины мэдээ үзсэн болж гөлийн суусаар аягатай кофегоо ч хөргөжээ. Уншсан болж байхад нь зарим зүйл нүдэнд нь онцгой тусавч анхаарлаа төвлөрүүлж чадахгүй огт ойлгоогүй өнгөрнө. Жессика охин нь хоолондоо орж ирээгүй байх агаад Херствүд авгай мөн өөрийн бодолд автан ширээний нөгөө талд таг дуугүй сууна. Эднийд саяхан ирсэн шивэгчин нь ширээнээ алчуур тавихаа мартсаныг дув дуугүй сууж байсан Херствүд авгай гэнэт мэдээд уур нь хүрч:

- Мэгги, би чамд хэлсэн шүү, дахиж хэлэхгүй, сайхан мэдээрэй чи! Гэв.

Херствүд вагайгаа хяламхийлэн харвал царай барайлган сууж байв. Тийм янзтай байгааг нь хараахас одоо бүр ч их зэвүү нь хүрнэ.

- Жорж, чи чинь хэзээ амралтаа авна гэж шийдсэн гэлээ? Гэж авгай нь гэнэт асуув.

Тэднийхэн ийм үеэр зуныхаа амралтын тухай ярилцдаг байж л дээ.

- Шийдээгүй байгаа. Ажил гэж жигтэйхэн.

- Нэг тийш явцгаая гэж бодсон бол түргэхэн шийдмээр юм даа.

- Цаг тулчихаад байгаа биш дээ.

- Хүлээсээр байтал зун өнгөрөх хэрэг үү гэж авгай нь хэлээд цөхөрсөн янзтайгаар мөрөө хавчисхийлгэлээ.

- Яах гэж дандаа ингэж байдаг юм? Би ямар ажилгүй хүн үү?

- Би лавтай мэдэж авах гэсэн юм гэж авгай омогдов.

- Чи ч гэсэн өөрөө нэг их яарах шаардлагагүй шүү дээ. Морин уралдаан дуусахаас нааш хаашаа ч явахгүй биз дээ? гэж нөхөр нь өөрийнхөөрөө зүтгэв.

Огт өөр юм бодож байхад нь тийм яриа гаргаж ирсэнд Херствүд уурссан хэрэг.

- Явж ч магадгүй байх шүү. Жессика удаан хүлээж чадахгүй гэж байна лээ.

- Тэгвэл чи юу гэж улирлын билет авна гэсэн юм?

- Пүү, би чамтай хэрэлдэх гэж ердөө ч бодоогүй байна гэж Херствүд авгай зэвүүцэж буйгаа тодорхой илэрхийлэн хэлэв.

Ингэж хэлчихээд гарахыг завдахад Херствүд мөн суудлаасаа босож:

- Хүүе, чи ер нь сүүлийн үед зангаа хувиргаад байх чинь, ярилцаж ч болохгүй болоо шив дээ, гэж ихээхэн шийдэмгий байдалтай хэлэхэд нь авгай нь арга буюу зогслоо.

- Надтай ярилцаж бололгүй яах вэ гэж “ярилцаж” гэсэн үгээ их нухацтай хэлэв.

- Аа тийм бий чи, хэрэв чи хэдийд явахыг минь үнэхээр хүсэж байгаа бол бил хэлээд өгье, лав л сараас нааш ярихгүй, амжихааргүй бол түүнээс ч илүү удах байх шүү гэв.

- Тэгвэл бид чамгүй явна.

- Уухайс, тийм үү? Гэж Херствүд ёжлонгуй хэлэв.

- Тийм ээ, явна шүү.

Херствүд авгайнхаа их шийдэмгий байгааг хараад нэлээд гайхсан боловч уур нь улам шатлаа. Тэгээд өндөр дуугаар:

- Явах эсэхийг чи ганцаараа мэдэхгүй байх аа. Чи ер нь сүүлийн үед хүнийг их захирах санаатай болж шүү! Хамаг хэргийг чамаар мэдүүлэхгүй шүү. Явах гэж яараад байгаа бол явж л бай, харин намайг яаруулаад дэмий.

Херствүд учиргүй их уурлаж хар нүд нь ёлтолзож байв. Барьж байсан сонингоо хумхиад ширээ рүү шидлээ. Авгай нь ганц ч үг нэмж хэлсэнгүй. нөхрийнхөө хамгийн сүүлд хэлсэн үгийг сонсоод дуугай цааш эргэн гарч явав. Херствүд хэдэн хором хэртэй яая даа гэсэн байдалтай зогсож агснаа сууж аягатай зофогоо балгаад босож малгай_ бээлийгээ авах гэж доод давхар руугаа буулаа.

Авгай нь ийм юм болно гэж огт бодсонгүй. Харин хоолонд орж ирэхээсээ өмнийн л ганц юм бодоод оёг муутайхан байж. Морины уралдаан огт санаанд хүрсэнгүй гэж Жессика хэлсэн байж. Бас энэ жил олигтой хүмүүстэй ч танил тал болж чадаагүй юм байж. Өдөр болгон морины уралдаанд очих гэдэг нь тэр ганган царайлаг хүүхэнд тун уйтгартай санагдахаас гадна ядахнаа хүмүүс энэ жил тэгэхээс тэгэх гэсэн юм шиг рашаан сувилал, Европ тивээр явна гээд хачин эрт гараад явжээ. Жессикатай сээтэгнэж байсан хэдэн залуу Вокиш руу явжээ. Тэгэхлээ Жессика тэр рашаан сувилал руу явмаар байна гэхэд эх нь нийлжээ

Херствүд авгай энэ асуудлыг нөхөртэйгээ ярилцах гэсэн байна. Тэгээд хоолондоо орж ирэхдээ тэр тухайгаа ярих санаатай байсан боловч нөхөр нь нэг л биш учраас амнэжж чадахгүй байв. Ер нь хэрүүл юунаас болов гэж Херствүд авгай дараа нь өөрөө ч учры нь олж ядан бодсон билээ.

Гэвч нөхрийнхөө нэгэнт зэрлэг хэрцгий этгээд юм гэж бодоод явч ингэж омогдуулахгүй, хол хэвтэнэ яадгий нь үзүүлнэ хэмээн зориг шийджээ.

Херствүд ч гэсэн тэр хэрүүлийн уршгаар хжлынхаа газар ирж тэндээсээ Керритэй очиж уулзан уулзатлаа ааш муутай байв. Болзсон газраа очиж суухдаа огт өөр юм бодож хайр, сэтгэл, хүсэл шунал, тэмцлийн тухай бодолд автан, Керрийн ирэхийг тэсэж ядан хүлээв. Керригүйгээр шөнө ч шөнө биш, өдөр ч өдөр биш санагдана. Түмэн зүйлийн бодол тархинд нь эргэлдэж далайвчтай юм шиг урдуур нь дүүлэн дүүлэн өнгөрөх шиг болно. Ямар ч болтугай Керрийг өөрийн болгож авна гэж тангараглаж байв.

Керри, өчигдөр орой Херствүдээс салж явснаас хойш хүслэн жаргалын ертөнцөд умбах мэт байхдаа Дрүүгий зогсоо зайгүй чалчих үгийг сонсохдоо өөртөө хамаарах хэсгийг нь анхаарч түүнд хамаарах хэсгийг нь хайхралгүй, ер нь боломжийн хэрээр Дрүүд нэг их царай өгөхгүй санаатай байсан бөгөөд толгойд нь дөнгөж сая олсон амжилтынхаа тухай бахархан бодох бодол дүүрэн байв. Өөрийнх нь олсон амжилтанд Херствүдийн чармайлт их нэмэр болсон санагдана. Херствүдийн байдлыг бодохоос их л өрөвдөнө. Мөн үүний хажуугаар бусдыг үргэлж царайдаж явсна хүн буянаа бусдад хүртээдэг хүн болон хувирахад ямар ялгаа гарахыг ялимгүй боловч мэдэрч эхэлж буй нь түүний олсон амжилтын ач юм. Нэг үгээр хэлбэл Керри их л баяртай байлаа.

Маргааш нь тэр жүжгийн тухай сонинд юу ч бичээгүй байсан тул уг явдал тэгсгээд жирийн олон юмсын дотор замрхан өнгө жавхаа алдаж эхэлжээ. Дрүү ч гэсэн түүний тухай одоо ярих нь багасав. Керрийг урьдынхаасаа өөрөө бодож өөрөө харьцах хэрэгтэй гэж зөнгөөрөө тааварлаж байв. Тэгээд маргааш өглөө нь өрөө өрөө дамжин орж гоёж гоодон гарч явахыг завдан байхдаа,

- Би энэ сарын дотор ажил төрлөө янзлалчихаад чамтайгаа хуримаа хийж амжих байх гэж бодож байна. Энэ тухай яг өчигдөр би өмгөөлөгчтэйгөө ярилцсан гэхэд Керри, одоо доншуур худалдаачинг бага зэрэг ёжлох чадалтай болсноо мэдэрч:

- Та ч яахав худлаа л ярьж байгаа биз гэлээ.

- Хаанаас үнэн. Чи миний хэлж байгаа үгэнд итгэхгүй байна гэж үү? Гэж Дрүү ер бишийн шамдангуй, царайдсан янзтай хэлэв. Керри хариуд нь инээснээ:

- Итгэлгүй яахав дээ, итгэж л байна! гэв.

Энэ удаа Дрүүгийн баттай ингэж явдаг нь тийм ч ноттой биш мэт санагджээ. Өөрөө юм ажиглах талаар тун гавьдаггүй хүн боловч сүүлийн үед нэг л ухаан нь олдохгүй юм болоод байх болсныг бүүр түүр гадарлаж байлаа. Керри урьдын адил өөртэй нь хамт байгаа чгэсэн хуучин шигээ арчаа муутай царайдангуй байхыг больжээ. Хэлэх үг ярианд нь арай өөр маяг тодрох болж эрхэнд нь орсон амьтан шиг аяа нь дагахаа нэгэнт больжээ.

Тэр бүгдийг бодохоос доншуур худалдаачин, бишдэж магадгүй нь гэж сэтгэл нь түгшиж юмыг яаж мэдэх вэ гэжж Керрийг овоо тоодог сайхан үг хэлдэг, тагтдаг болсон аж.

Дрүүг гэрээс гарав уу үгүй юу Керри, Херствүдтэй очиж уулзах бэлтгэлээ хийв. Хувцас хунараа өмсөж, нүүр ам, толгойтой үсээ бушуухан аялуулаад шатаар яаравчлан суулаа. ойролцоо замын уулзвар дээ Дрүү тэр хоёр зөрсөн боловч бие биеэ олж харсангүй.

Дрүэ, контортоо танилцуулах чухал хэрэгтэй нэг баримт бичгээ мартчихсанаа санаад гэр рүүгээ буцав. Дээш хурдан гүйж гараад өрөөндөө орвол тэнд нь ганц шивэгчин хүүхэн цэвэрлэгээ хийж бхйв. Дрүэ гахайж:

- Үгүй ер. Керри яваад өгөө юу? гэж өөрөөсөө асуух мэт хэлэв.

- Танай гэргий юу? Тэгсэн, таван минутын өмнө гараад явчихсан.

“Хачин юм даа. Явна гэж надад юу ч хэлээгүй. Хашаа явсан юм бол?” гэж Дрүэ дотроо бодлоо. Дрүэ хэрэгтэй бичгээ хөвхөн хайрцаг дотроос олж авч халаасандаа хийчихээд өөртөө сайн байдаг, аюулын царайлаг залуу шивэгчний зүг эргэж инээмсэглэн:

- Чи энд юу хийж байгаа билээ? гэж асуухад цаадах нь гар дахь хиртэй алчуураа мушгингаа сээтэгнэн:

- Цэвэрлэгээ хийж байгааг харж байгаа биз дээ? гэв.

- Ядарч байна уу?

- Нэг их ядраагүй ээ.

- Би чмад нэг юм үзүүлье гэж Дрүэ дэргэд нь очин халааснаасаа нэг жижигхэн зураг гаргав. Тэр нь тамхины пүүснээс зарлал болгож хэвлэсэн зүйл байж. Тэр зурган дээр судалтай үхэр гартаа барьсан царайлаг хүүхнийг өнгө нь янз янзаар хувирдаг болгож хийсэн байж. Ар талынх нь зээрэнцгийг эргүүлэхэд улаан, ногоон, шар, цэнхэр хэд хэдэн өнгө болон хувирах тул түүнийг шивэгчин хүүхэн ихэд сонирхож байхыг Дрүэ мэдээд:

- Их ухаалаг хийсэн байгаа биз? Урьд нь имй юм үзээгүй биз? гэж тайлбарлан яаж ажиллуулахыг нь зааж өгөнгөө хэлэхэд шивэгчин:

- Гайхмаар сайхан юм байна! гэлээ.

- Авч болно шүү. Харни яасан хөөрхөн бөгж хийгээ вэ? гэж доншуур худалдаачин хуруундаа хийсэн жирийн нэг бөгжий нь магтав.

- Танд тийм хөөрхөн харагдж байна гэж үү?

- Тийм, ёстой хөөрөхн бөгж байна гэв.

Тэр хямдхан бөгжий нь сонирхож байгаа хүн болж далимдуулан гары нь барилаа. Ямар ч болсон анхыхаа алхмыг хийв бололтой. Дрүэ хуруугий нь барьж авснаа огт мартчихсан юм шиг чалчсаар байв. гэтэл шивэгчин гараа эвтэйхэн сугалж аваад хэд халхам холдон цонхны тавцан налан зогсов. Дрүэг дахин ойртож очиход жаахан зайлсхийж сээтэгнэсэн байдалтайгаар:

- Та ийм удаан хаачсан бэ? Ажлаар явсан уу? гэхэд Дрүэ:

- Ажлаар яваад ирсэн гэлээ.

- Хол явсан уу?

- Нэлээд хол.

- Ийш тийш дандаа явах сайхан санагдах уу?

- Үгүй, тийм сайхан санагдахгүй. Сүүлдээ залхдаг юм шүү.

Хүүхэн цонхоор гадагш харж:

- Би жаахан явж үзэх юмсан гэснээ – танай найз Херствүд чинь хаачсан бэ, үзэгдэхгүй байх чинь? Гэж гэнэт асуув. Ингэхдээ тэр шивэгчин хов хэлэх сайхан завшаан олдлоо гэж бодсон байна.

- Энд, хотдоо байгаа, Яагаад асууж байгаа билээ?

- Зүгээр л... таныг ирснээс хойш энүүгээр ганц ч үзэгдсэнгүй болохоор л ...

- Та яаж таньдаг болсон юм?

- Мэдэлгүй яах вэ, зөвхөн энэ өнгөрсөн сард хичнээн ч ирэв дээ.

- Боль доо, биднийг энд ирснээс хойш манайхаар тоотой ирсэн юм чинь гэж Дрүүэ юу ч бодолгүй хэлэв.

- Та тэгж бодож байна уу? Их юм мэдэж байгаа хүн юм даа гэж хүүхэн инээмсэглэн хэлэв.

Дрүүэ нэлээд юм бодов бололтой төв байдал гаргавч тэр хүүхнийг үнэнээсээ тэгж хэлж байгаа юмуу эсхүл тоглоом хийж байгаа юмуу ялгаж мэдсэнгүй.

- Зальтай амьтан юм даа, юундаа инээгэд байгаа юм?

- Өө, онц юмгүй ээ.

- Ойрын үед та тааралдсан уу?

- Үгүй, таныг ирснээс хойш ердөө тааралдаагүй. Ингэж хэлээд шивэгчин хүүхэн тас тас хөхрөв.

- Урьд нь?

- Тааралдалгүй яахав.

- Олон удаа юу?

- Бараг өдөр болгон!

Тэр хүүхэн хов зөөх их дуртай тул Дрүүэг тийм үг сонсоод ямар болж байна хэмээн сүрхий сонжин харав.

- Хэнтэй уулзах гэж ирдэг байх нь вэ? гэж Дрүүэ итгэж ядсан янзтай асуудах цаадах нь:

- Дрүүэ хатагтайтай гэв.

Үүнийг сонсоод Дрүэ шивэгчин рүү мэлийн харснаа төдхөн сэхээ авч хүний инээдэм доог болохгүйг хичээн биеэ бариад:

- Тэглээ ч гэсэн яахав дээ? гэв. Шивэгчин хариуд нь:

- Нээрэн тийм дээ гэж аяы нь дагуулж хэлээд толгойгоо далжисхийлгэв.

Дрүэ шаварт бүр гүнзгий суух шиг болж:

- Херствүд ноён чинь миний хуучин сайн нөхөр гэв.

Хэдэн хувийн өмнө бол мань эр тэр хүүхэнтэй нэлээд марзганах байсан боловч одоо тэгэх тэнхэлгүй болов. Тэр ч бүү хэл, дороос нөгөө шивэгчинг хүн дуудахад сэмхэн сүүрс алдаж санаа нь амрах шиг болов.

Шивэгчин хүүхэн:

- За би явахаас гээд бараг гүйх шахам хурднаар шатаар уруудав. Дрүэ, тэр хүүхнийг хүн дуудаж салгасанд нь харамссан мэт царайлан:

- Дараа уулзан шүү гэлээ.

Хүүхнийг тийнхүү явсан хойно Дрүэ биеэ сул тавин бодож эхлэв. Нүүр нь амархан хувирдаг хүн болохоор сандарч балмагдсан байдал илэрхий харагдана. Керри тийм олон удаа уулзсан байж юу ч хэлэхгүй өнгөрөх гэж үү? Херствүд худал хэлсэн юм гэж үү? Шивэгчин хүүхэн ер нь юу хэлэх гээд байгаа юм бол? Ер нь сүүлийн үед Керрийн зан ааш арай өөр болоод байгаа шүү. Херствүд манайхаар хэддахин ирсэн бэ гэхэд Керри зовж байх шиг санагдсан, одоо л бодохноо учиртай байж. Ер нь нэг л биш дээ.

Дрүэ сайн бодох гэж цонхны дэргэдэх эргэлддэг сандал дээр сууж хоёр хөлөө ачин суув. Царай нь тун ёоз муутай хүрхийжээ. Толгойд нь янз бүрийн бодол уралдан орж ирнэ.

“Тийм биш юмаа. Керрийн зан ааш өөр болоогүй. Яалаа гэж намайг маллах вэ. хаанаас. Тиймэрхүү сэжигтэй юм огт байгаагүй. Өгчигдөр орой ч гэсэн бишгүй л сайн байсан шүү дээ. Херствүд ч өөрцгүй. Зүгээр л байцгаасан” гэж бодоод тэр хоёр тэгж маллах ёсгүй гэж дүгнэв.

Тэгж бодож байснаа бүр ганцаараа ярьж:

- Заримдаа бүр хачин зан гаргах нь гаргадаг болсон юм байна шүү. Одоо ч гэсэн хувчсаа хам хум өмсөөд надад юу ч хэлээгүй мөртлөө гараад явчсан байна шүү гээд шилээ маасанаа хотын төв орохоор босов.

Хөмсөг нь зангидаастай хэвээр л. Хөлийн өрөө рүү ортол нөгөө шивэгчин хүүхэн өөр нэр өрөө цэвэрлэхээр явж байгаад тааралдав. Толгой дээрээ цагаан малгай тавьчихсан хөөрхөн нүдээрээ инээмсэглэхийг хараад Дрүэ өөрийнхөө зовиурыг бараг мартав. Явж өнгөрөх зуураа мэндэлж буй мэтээр мөрөн дээр нь гараа хээв нэг тавилаа. Хүүхэн мөн л дооглосон байдалтайгаар:

- Уур тань гараа юу? гэхэд Дрүэ:

- Би уурлаагүй шүү гэв. Цаадах нь мөн л инээсэн хэвээр:

- Би таныг уурлаж байна гэж бодсон гэв. Дрүү аль болох тайван байгаа царай гаргаж:

- За боль доо, дэмий вь яриад яах вэ. нээрэн үнэн юм яриад байгаа юмуу? Гэхэд цаадах нь:

- Үнэн байлгүй яах вэ гэснээ зориуд хов хэлж муу санаалж байгаа хүн биш царай гарган – зөндөө олон удаа ирсэн, таныг чинь мэдэж л байгаа байх гэж бодсон гэв.

Дрүү маллуулж байгаагаа мэдлээ. Одоо мань хүн цагаандаа гарч:

- Оройг энд өнгөрөөдөг хэрэг үү? Гэхэд:

- Заримдаа. Заримдаа хоёул хамт гараад явна.

- Бас л орой юу?

- Тиймээ. Харин та тэглээ гээд ингэтлээ айхтар битгий уурла л даа.

- Би ердөө ч уурлаагүй байна. Танаас өөр хүн мэдэх үү?

- Мэдэхээр барах уу гэж тэр хүүхэн огт онцын юм биш мэтээр хэлэв.

- Хамгийн сүүлд хэзээ ирсэн бэ?

- Таныг ирэхээс өмнөхөн.

Доншуур худалдаачин хөмхийгөө тас зуулаа.

- Өөр хүнд битгий хэлээрэй гэж Дрүү гары нь зөөлхөн атгаж хэлэхэд шивэгчин хүүхэн:

- За яахав гэж Дрүү явахдаа хэлээд нэлээд гонсгор байвч, шивэгчин хүүхэнд яггүй нөлөө үзүүлж чадав гэж бас дотроо бодсон байна.

- Чамтай ярилцана, учры нь олно, дахин намайг ингэж маллах эсэхий нь үзэхээ л үзнэ гэж Дрүү дотроо зүхэн явлаа.

СЭТГЭЛИЙН ДУУДЛАГА, ТАЧЬЯАЛЫН ТЭМҮҮЛЭЛ

Херствүд, Керригээс олон минутын урьд ирчихсэн байв. Цус нь өөдөө хөөрч орох байх газраа олж ядан байв. өчигдөр орой дур сэтгэлий нь тэгтлээ их татаж тарчлаасан хүүхэнтэйгээ уулзахын тэсэж ядан хүлээнэ.

- Хүрэд ирэв үү чи минь гэж Херствүд тэсгэлгүй баярлан дуу алдахад нар нь гарч хөл нь газар хүрэхгүй баярлах боловч цаанаа эмгэнэлийн шинж бач цухуйлгана.

- Ирлээ гэж Керри хэллээ.

Тэр хоёр аль хэдийн тохиролцсон мэт үг сүтгүй нэг зүг хамт чиглэн явав. Херствүд түүнтэйгээ хамт яваадаа ухаангүй хөөрч, бошинзных нь сэрчигнэх чимээ хөгжмийн эгшиг мэт сонсодно.

- Сэтгэл ханамжтай байна уу? гэж Херствүд Керрийн өчигдөр оройн тоглолтыг нь бодож асуухад Керри өөдөөс нь:

- Та өөрөө? Гэж асуув.

Мишээлээрээ шагнасны хариуд Херствүд баярлан гары нь чанга атгалаа. Тэгээд:

- Гайхмаар сайхан болсон гэхэд Керри баяртайгаар инээв.

- Тийм сайхан тоглодог жүжигчин үзэлгүй их уджээ гэж Херствүд нэмж хэлэхдээ бчигдөр орой хэрхэн биширч байснаа санаж одоо тэр чадамгай жүжигчин өөртэй нь хамт байгааг бодохоос бахардмаар байв. Энэ хүний ингэтлээ сүйд болж байгаад нв Керри туйлаас баярлав. Бодохоос сэтгэл санаа нь сэргэж дотроос нь гэрэл гэгээ нэвт тусах мэт санагдана. Херствүдийн хэлж байгаа үг бүр нь тэр хүний хичнээн сэтгэл хангалуун байгааг илтгэнэ. Керри түр дуугүй байснаа:

- Та надад тун сайхан цэцэг явуулсан байдаг шүү, гойд сайхан цэцэг гэхэд:

- Танд л сайхан санагдсан бол боллоо гэж Херствүд эгэл байдлаар хэлэв.

Өөрийнхөө хүсэл зорилгыг шууд хэлж чадахгүй, хойш тавьж байгаага мань эр хормын төдий ч мартсангүй. _Ярианыхаа сэдвийг яасхийн энэ зүг чиглүүлье дээ хэмээн бодохдоо одоо л цаг нь болсон шиг байна. Керритэйгээ хамт байна гээд санаа шийдэн түс тас хэлье гэтэл ямар шүү янзтай, чухам юу гэж хэлье дээ хэмээн учраа сайн олохгүй дүлэгнэж байлаа. Тэгснээ гэнэт:

- Гэртээ сайн хүрсэн биз? гэж асуухдаа хоолой нь дурамжхан өнгөтэй гонгино.в

- Сайн хүрсээн гэж Керри цовоолог хэл.в

Херствүд алхаагаа удаан болгож өөдөөс нь цоо ширтэх мэтээр жигтэйхэн сүрхий харахад Керрийн дотор ч чнзтайхан л болж байв.

- Надтай яая гэж бодож байгаа вэ? гэж Херствүд асуухад Керри баахан зовж чухам юу гэж хэлэхээ мэдэхгүй шийдэрлэх цаг болж байгааг мэдэрч байв. Тэгснээ:

- Үнэндээ мэдэхгүй байна гэв.

Херствүд хөмхийгөө зууж дороо зогсоод шахайныхаа хоншоороор өвс оролдоно. Тэгснээ Керри рүү гуйж царайдсан байдалтай харж:

- Та тэр хүнээсээ салахгүй гэж үү? Гэв.

Керри сэтгэлийнхээ хөдөлгөөнд хөтлөгдсөн, ямар чбодолгүйгээр, барих мюгүй хөл алдан хөвөх шиг болсон учир:

- Мэдэхгүй байна гэлээ.

Керри ихэд балмагдаж эхэлсэн нь аргагүй. өөрт нь тун аятайхан санагдсан, их тус болсон, ямал чболтугай хайр сэтгэлий нь таттал нөлөө үзүүлсэн тийм хүнтэйгээ улаан нүүрээрээ учран ярьж байгаа хэрэг шүү дээ. Цоо ширтэм нүднийх нь хараа, эелдэг дөлгөөн сайхан ааш зан, сайхан хувцасладаг байдал энэ бүгд нь биширмээр сайхан санагдсан хэвээр ажээ. Харахаас л өөрийн эрхгүй татагдаж, бишрэм хамгийн сайхан, нүдэнд дулаахан хүнийхээ цоо ширтэх нүднээс буруулж чадсангүй, зөн төхий нь буруушааж чадахгүй, хайр сэтгэлийг нь таашаалаа. Гэлээ ч гэсэн сэтгэлий нь зовоох юм олон буй за. Юу гэж боддог бол? Дрүү юу гэж хэлсэн бол? Эхнэр нь гэж байдаг болов уу, үгүй бол уу? Надтай суух бол уу? шүгүй бол уу? гэж бодно. Түүнтэй ийнхүү ярилцан хэлэх үгэнд нь уяран нүдэнд нь энхрий хайрын гэрэл цацарч байхдаа ч Дрүү намайг гэргийгээ болгож аваагүй гэж хэлсэн болуу үгүй болуу? Гэж бодож байлаа. Ер нь Дрүү яухам юу гэх, яах хүн гэдэг тлааар огтхон ч төсөөлөх юмгүй байжээ.

Гэхдээ Херствүдийн сэтгэлтэй байгаад Керри юундаа чгонсойх билээ. Өөрийнх нь тухай юу ч сонссон байлаа зовох юм ердөө ч алга. Энэ хүн үнэн санаанаасаа үгээ хэлж байх шиг байна. Харин би яадаг билээ? гэх мэтээр Керри шийдэж ядан Херствүдийн хайртай дуртайд нь баярлан дэмий л хөөрөх боловч тоо тоймгүй олон бодолд дарагдаж байлаа.

- Та цаадах хүнээ орхиод явахгүй яасан юм? Би өөрийг чинь төхнүүлж... гэж эелдгээр хэлтэл Керри:

- Өө, боль доо! гэв.

- Юу боль гэж? Керри, энэ чинь юу гэсэн үг вэ?

Хэлсэн үг нь Керрийн зүрх рүү зүү шивэх мэт санагдсан тул нүүр царайд нь бачимдан зовсон янз ил болов. Гэрлэх тухай үг хэлэхийн оронд “төхнүүлэх мөвхнүүлэх” гэсэн үг гаргаж ирдэг нь муухай.

Херствүд тун эвгүй үг хэлснээ мэдлээ. Тэгээд хэлсэн үгээ цагаатгах санаатай хичнээн оролдовч болж өгөхгүй байв. Гэсэн ч Керрийн дэргэд байгаадаа элэг нь дэвтэж ухаан нь сэргэх тул зогсоо зайгүй ярихын хамт цаашдаа яах ийх тухайгаа хүчлэн бодож байв.

- Та хүсэхгүй байна гэж үү? Би таньгүйгээр амьдарч чадахгүй болж байгааг та мэдэж байгаа, андахгүй байгаа... Ийм байдал удаан үргэлжилж болохгүй, та ч өөрөө ойлгож байгаа байх гэж Херствүд их л гүн хүндэтгэлийн өнгөтэй хоолойгоор айлдахад:

- Мэдэж байна гэж Керри хэлэв.

- Би чадах байсан бол юу гэж таныг гуйх вэ, юу гэж тангы царайдах билээ, даанч чадахгүйдээ л ингэж байна шүү дээ. Керри чи над руу хараач. Өөрийгөө над шиг боллоо гэж бодоод үзээч. Намайг орхиод явъя гэж өөрөө бодохгүй биз дээ? гэхэд Керри гүн бодолд автан толгой сэгсрэв.

- Тэгвэл яагаад одоохон нэгмөсөн шийдчихэж болдоггүй билээ? гэхэд Керри нам дуугаар:

- Мэдэхгүй байна гэлээ.

- Мэдэхгүй байна гэж уу? ай, Керри минь, яагаад ингэж хэлнэ вэ? Намайг ингэж бүү зовоогооч. Үнэнээ хэлээч.

- Би үнэнээ л хэлж байна шүү дээ гэж Керри эелдгээр хэлэв.

- Тийм биш байна. Ингэж хэлэх ёсгүй... ялангуяа миний сэтгэтэйг мэдсээр байж ингэж хэлэх ёсгүйсэн. Өчигдөр оройн явдлыг санасан ч.

Херствүд сүүлчийнхээ энэ үгийг их л тайван байдалтай хэлэв. Одоо биеэ барьж чадсан бололтой, гэвч нүдий нь ажвал сэтгэлийнх нь догдлоо, хамаг дотоод бодол санаа нь ил байв. Керри дуугай л байна. Жаахан азнасны дараа Херствүд дахин ам нээж:

- Миний сэтгэлийг баярлуулдаг хүн байж ингэж хэлж болох уу? Надад хайртай биз дээ, тийм ээ? гэж Керрийн сэтгэлийг уяртал хачин сайхан дуугарсанд Керрийн эргэлзээ дороо арилж:

- Тийм ээ гэж үнэн сэтгэлээсээ халуун дотноор хэлэв.

- Тэгвэл над дээр ирэх үү? Бүр өнөө орой яваад ирэх үү?

Керри хэдийгээр балмагдах байдалтай болсон боловч толгой сэгсэрлээ.

- Би илүү удаан хүлээж чадахгүй нь, дэндүү түргэн санагдаж байгаа бол бмяба гаригт болгох уу? гэж Херствүд шамдан шахлаа.

Керри балмагдсандаа болоод Херствүд өөрийг нь Дрүэгийн эхнэр гэж боддог байх ёстой гэж санаж байснаа ч мартаад зориг муутайхан:

- тэгвэл та надтай хэзээ гэрлэх вэ? гэж асуув.

Херствүд, Керригээс ч илүү адармаатай асуудалд тулгарч бага зэрэг давхийсэн боловч толгойдоо цахилгаан мэтээр гялалзан орж ирэх олон болыг мэдэгдэлгүйгээр өнгөрч чадаад энэ золигийн асуудлаас болз энэ сайхан эхлэлээ боллаж орхихгүйг хичээн тайван байдалтайгаар:

- Хэдийд л бол хэдийд, өөрөө л мэд гэхэд Керри:

- Бямба гаригт болох уу? гэхэд Херствүд толгой дохилоо.

- Бямба гаригт гэрлэхээр бол би тэндээс гарлаа.

Зоогийн газрын эрхлэгч, тун их зүдэрч байж олж авч байгаа тэр хөөрхөн гайхмаар гоё юмнаасаа нүд салгалгүй ширтэхдээ хачин хачин юм бодож байв. Хайр сэтгэл нь одоо эрүүл ухаанд

захирагдахааргүй тийм шатандаа хүрсэн байлаа. Ийм их хайр сэтгэлтэй байхад хэр баргийн саад тотгорыг юман чинээ хаанаас бодох вэ? Ямар ч бэрхшээл тохиолдсон давахаар шийдэж амьдралын хатуу үнэн байдал ямар ч юм тулгаж байсан мөчөөрхөн дийлэхээр шийджээ. Юу л бол юуг амлахад бэлэн болэ хэрхэхийг заяа мэдтүгэй хэмээн хувь тавиландаа даатгахад бэлэн байлаа. Ямар ч болтугай Сугаавадийн оронд орж тэнд юу болдгоо харахаар санаа шийджээ. үнэн мөний замаас гажиж байгаад ч болтугай амьдралдаа ганц удаа аз жаргал амсахыг боджээ.

Керри түүнийг энхрий нүдээр харж, юм бүхэн сэтгэлчлэн бүтэх шиг болсон тул мөрөн дээр нь толгйогоо тавимаар санагдав.

- За тэгвэл би бэлэн байхыг бодъё гэв.

Айх эргэлзэхийн шинж тэмдэг бас л тодхон байх түүний хөөрхөн царайг Херствүд сноирхон ажаад ийм гайхам үзэсгэлэнт царай насандаа ч үзээгүй гэж бодлоо.

- Маргааш хоёул уулзъя, тэгээд яах ийхийгээ ярилцана гэж Херствүд баяртайгаар хэлэв.

Херствүд зорьсон хэрэг нь ингэж нааштайгаар бүтсэнд учиргүй их баярлан Керритэй хамт алхаж явахдаа хэлсэн үг нь цөөн боловч илэрхийлсэн хайр сэтгэлийнх нь явдал даамай их байлаа. Хагас цаг хиртэй болхоод амьдрал ажлын хатуу хууль уулзаагаа дуусгахыг шаардаж байгааг Херствүд сая мэдлээ. Тэгээд их цовоо сэргэлэн байгаа дүр үзүүлэн:

- Маргааш хүртэл баяртай хэмээн салахдаа хэлэхэд Керри:

- За тэгье гэж цовоолгоор хариу хэллээ.

Керри, Херствүдийг чмн сэтгэлээсээ хайртай хүн юм гэб үрэн итгэж сэтгэлий нь булааж чадсан тэр сайхан хүнээ бодоод сүүрс алдсан байна. Тэгээд бямба гаригт бэлэн байхаар бүр шийджээ. Түүн дээрээ очиж жаргах цагтайгаа золгож ажээ.

ЦАХИУРЫН ГАЛ, ГЭРИЙН ХЭРҮҮЛ

Херствүд авгайн хардах сэтгэл нь хайр сэтгэлийнхээ хамт унтрах нь байтугай харин ч цаашдаа үзэн яадах чанар болон хувирахад хэзээд бэлэн байсан болохоор тэдний гэр бүлийн хэрүүл үссэн ажээ. Бие бялдрын хувьд урьд эхнэртээ тоогдож байсан нь одоо ч гэсэн хэвээр шахам боловч зан байдлын талаар үнэ цэнээ алдаж эхэлсэн байна. Херствүдийн хувьд гэвэл авгайгаа анхаарч халамжлахаа байсан учир эмэгтэй хүн ийм байдлыг шууд гэм үйлдсэнээс ч дор үздэг хойно яаж олигтой санагдах билээ. Хүн өөртөө өөр хүн ямар байгаагаар нь сайн буюу муу гэж үнэлдэг. Херствүдавгай нөхрийнхөө хайхрамжгүй болсонд бүхий л талаар муу санах болж хөдлөх гишгэх бүрийд нь хэлэх үг бүрий нь сонжиж өөлөх болжээ. Тэгсээр бүр сүүлдээ дандаа хар муу санаж хардах сэрдэх нь лаамжирчээ. Бусадтай харьцахдаа хуучин хэвээр атлаа өөртэй нь нэг л өөр боллоо гэж өчүүхэн төдий юман дээрээс Херствүд авгай хардана. Биеэ гоёж гоодохыг Херствүд их хичээдэг болсон нь нэг л учиртай гэж бодно. Үнэндээ ч Херствүд Керритэй танилцсанаас хойш бүхий л талаар хачин өөр болж дэгжирхэх нь андашгүй харагдана. Авгай нь араатан амьтан аюулыг газрын тэртээ холоос үнэрлэн мэддэг шиг гадарлаад л байж.

Угаас түс тас бөгөөд зоримог зантай Херствүдийн зан байдал авгайнх нь тжр бодлыг улам нотолж байв. гэр бүлийнхээ дотор гүйцэтгэх ёстой аар саар зүйлийг огт сонирхохоо больж, тэр ч

байтугай тийм юм сонсохоосоо бүр эгдүүцдэг болж, авгайнхаа ёжтой хэлсэн үгийг шууд хэрцгийгээр няцааж байсныг бид хэдийнээ мэдэх билээ. Аоёлу бие биендээ хөрч эхэлснээс л тэгж байнга толхилцох болсон байна. Тэгэхлээр, борооны хар үүл бүрхсэн тэнгэрээс азарган бороо хэдийд ч асгаж мэдэх билээ. Херствүд авгай нөхрийнхөө тийнхүү огт жишимгэй байгаад дотроо ихэд уурсан хоолныхоо өрөөнд орж очвол цаадах нь тлины өмнө үсээ ааг зоог аялуулж байв. Энэ үед Херствүд ажилдаа явчихсан байж.

- Хоолноосоо битгий ингэж хожигдож байгаач. Идэхгүй байсаар хөргөчих вь гэж эх нь охиндоо хэлэв.

Угаас тайван эх нь энэ удаа их л сэтгэл үймэрсэн агаад Жессика ширүүн шуурганы сүүлчийн дайралтад тийнхүү өртөх учиртай байжээ.

- Би өлөрхөөгүй байна, ээж ээ гэж Жессика хэлэв.

- Тэгвэл чи тэрнийгээ хэлэхгүй яасан юм? Чамайг бүхэл өглөөжин хүлээхийн оронд шивэгчин аль хэдийн цэвэрлэгээгээ хийчихгүй юу.

- Надад цаадах чинь уурлахгүй дээ гэж Жессика ёоз муутайхан хэлэв.

- Тэр уурладаггүй юм бол би уурлаж байна. Ер нь чи надтай бүү ингэж ярь. Эхтэйгээ ийм жаахнаасаа ингэж ярьж болохгүй байх шүү.

- За, ээж та битгий хашгичаад бай, өнөө өглөө юу болчихоо ввэ?

- Юу ч болоогүй, хашгичсан хүн алга. Ер нь чи намайг толгойгийн чинь илээд байхаар хэнийг ч болтугай хүлээлгэж байхад яадаг юм гэж бодож байгаа юм биш биз? Тэгүүлэхгүй шүү. Жессика огт үл тоомсорлох байдлаас биеэ шууд өмөөрөх байдалд шилжиж:

- Би хэийг ч хүлээлгээгүй. Би өлсөөгүй байна гэж хэлсэн. Хоол идэх хүсэл ч алга гэв.

- Чи надтай яаж ярьж байгаагаа сайхан мэдээрэйхө, ингүүлэхгүй шүү. Сайхан мэдээрэй чамайг ингүүлэхгүй.

Жессика үгий нь гүйцэд сонсолгүй толгой ганасхийлгэн дээлнийхээ хормойг дэрвүүлэн гарч байгааг нь харвал хэнэр ч заалгахгүй, чамд падгүй гэж бодсон бололтой.

Сүүлийн үед эднийд иймэрхүү тар түрхийх явдал олширчээ. Баахан дураараа, амиа бодсон хүмүүсийн хооронд тийм харьцаа гарцаагүй л дээ. Хүү нь дөнгөж хорь хүрч байгаа мөртлөө өөрөө өөрийнхөө явдлыг мэднэ гэсэн юм шиг бүр аавын цээж гарган ханхалздаг болжээ.

Гэрийнхэн нь үгэнд нь улам орохоо больж, өдөр ирэх тутам учир нь ойлгогдохгүй амьтад шиг санагдах тул Херствүд угаас бүгдэд хүндлүүлж тэрнийгээ чухалд үзэж байсан хүн болохоор одоо ийм байдлыг үзээд маш их зэвүүцэж байлаа. Авгай нь Вокишад эртхэн явах талаар өөртэй нь маргаж байсан мэтийн аар саар маргаанаас болж Херствүд өөрийн байдлыг ойлгож эхэлсэн байв. Одоо өөрөө мэдэлгүй болж цаадуул нь дахирах болоод, өөрийнх нь нэр хүндийг барж, бас ч байн байн басамжлах санаатай дооглож элдвээр даажигнах болсонд нь Херствүд тэвчиж чадахгүй уурлах болов. Уураа барьж ядахдаа эндээс л зайлж санаа амрах юмсан гэж хүртэл

бодно. Ер нь эднүүс л хамаг хүссэн санасанд минь хүрэхэд булаа их садаа болж байна гэж боддог болжээ.

Авгай нь шил заах боловч Херствүд гэр орондоо захирах, хянах ёс төдий эрхийг эдэлсээр байв. Херствүд авгай, нөрөхтэйгээ элдвээр марган гэжүүдлэхдээ ингэх эрхтэй гэж бодно. Өөрийнхөө ингэж аашилж байгааг зөвтгөх ганц ч баримтгүй, нөхрийнхөө эсрэг гул барин тэмцэх ганц ч нарийн мэдээ сэлтгүй, хар сэрийнхээ хүчийг азарган бороо мэтээр буулгах гэвч туйлбартай, маргашгүй баримт олдохгүй байв.

Гэвч төдий л удалгүй байтал нөхийнхөө нууц паянгийн ул мөр дээр бууж чаджээ. Херствүдийн хөрш Бийл эмч хэмээх нэг сайхан хар хүн Херствүд Керри хоёрыг Вашингтоны цэцэрлэгт гудамжаар тэргэнд суугаад зугаалж явснаас аойш хэдхэн хоногийн дараа Херствүд авгайтай гэрийнх нь гадаа тааралджээ. Бийл эмч, Херствүдтэй тэр өдөр зөрөхдөө харьт харан таньсан боловч авгайтайгаа юмуу охинтойгоо хамт явж байна гэж бодоод өнгөрсөн байжээ.

- Та чинь зугаалж явахдаа танил нөхөдтэйгөө мэндлэхээ больдог хүн вч биз дээ? гэж Херствүд авгайд тоглоомоор хэлэхэд цаадах нь:

- Би танивал мэндлэлгүй яах вэ? та намайг хаана харсан юм? гэв.

- Вашингтоны цэцэрлэгт гудамжинд гэж Биил хэлээд Херствүд авгайг нэн даруй санах байх гэж нүүр рүү нь харвал цаадах нь толгой сэгсэрчээ.

- Яагаав дээ. Хойд өргөн чөлөөний ойролцоо. Та нөхөртэйгөө явж байсан шүү дээ.

- та андуурсан шиг байна гэж Херствүд авгай хэлсэн боловч нөхрийнх нь тухай хэлсэн болохоор нэн даруй хар аван үүнийгээ огт мэдэгдсэнгүй. Биил эмч цааш нь:

- Таны нөхрийг л лав сайн таньсандаг, харин та биш, охин чинь хамт явсан байж болох юм. Таныг гэж лавтай танвьсан биш л дээ гэв.

Жессика нь сүүлийн хэдэн долоо хоног ямагт өөртэй нь хамт явж байсан болохоор охиноо биш гэдгийг Херствүд авгай мэдэж байсан хэрнээ:

- Тийм байж болох юм шүү гэж яаравчлан хэлэв.

Херствүд авгай биеэ барьж аанай чадсан төдийгүй харин ч цааш нь бага сага юм мэдчих санаатай оролдов. Тэгээд өөрөө мэдэж байгаа царай гарган их л тайван байдалтайгаар:

- Үдээс хойш биз дээ? гэж асуулаа.

- Тийм тийм, хоёр гурван цагийн алдад.

- Жессика байж таарна гэж Херствүд авгай хэлэхдээ уг асуудлыг нэг их тоогоогүй царайлав.

Биил эмч ч гэсэн бага сага юм бодсон боловч өөрт нь ашиггүй энэ яриаг цааш шргэлжлүүлэхээ больё гэж бодсон ажээ.

Херствүд авгай тийм юм сонссоноос хойш хэдэн цаг, тэр бүү хэл хэдэн өдөр бөөн бодол болов.

нөхрийгөө цэцэрлэгт гудамжаар өөр нэг эмэгтэйтэй явж байхы нь Биил эмч харж гэдэгт эргэлзэхгүй байжээ. Херствүд, авгайдаа хэлэхдээ ажилдаа дарагдаад ямар ч зав чөлөө гарахгүй байна гэж байсан. Айлаар хамт хэсэх юмуу наргиан цэнгэлийн газраар явъя гэхэд нь хичнээн удаа татгалзаж байсны нь бодохоос Херствүд авгайн уур жигтэйхэн ир хүрнэ. Театртөөр хүмүүстэй юм үзсэн, үнэн ч юмуу худлаа юмуу бүү мэд. Одоо бас өөр авгайтай хамт тэргэнд суугаад явж байсан байна, нэг л учиртай даа. Ер нь сүүлийн үед юм л бол ажил ихтэй завгүй гээд гэр орныхоо ажлыг ч хайхрахаа байсан болохоор өөр бусад нэр ус сонсоогүй ямар ч амьтад байдаг юм билээ, хэн мэдэх билээ? Сүүлийн сар гаруйн дотор л лав жигтэйхэн уцаар ууртай болж гэр орныхоо ажлыг яаж ийж байгааг огт хайхралгүй дандаа л ийм ч ажилтай тийм ч ажилтай гарлаа гээд яваад өгдөг болсон, яагаад тэр вэ?

Тэр ч байтугай ер нь авгайгаа урьдын адилаар харахаа больж, юм л бол өөлөх санаатай, их өтөлж байна, сонин биш болж байна, нүүрэнд чинь үрчлээ суулаа гэж хэлэхийн халаг болж элдэв дээдээр голох өөчлөх болсныг бодохоос бас өөрөө өнгө зүсээ насны эрхээр алдаж байхад хар хүн нь улам гялалзаж дэгжирхээд олны цэнгээнтэй газруудаар урьдын адил бусдад гайхагдаж байхад би гэдэг хүн... гэж Херствүд авгай бодсон боловч цааш нь үргэлжлүүлэлгүй охилоо. Ерөнхийдөө тун олиггүй болсон сагагдаж нөхөртөө улам өшөөрхөн шүд зууж байв.

Тэр дуулсан явлынхаа талаар үг гаргаж ярилцъя гэж бодовч яг гарцаагүй нотлох баримт олдож өгөхгүй байв. Гэвч хоёр биендээ үл итгэх, муу санаа нь улам улам их болж бие биендээ амархан уурлаж уцаарлан хэрэлдэж толхилдох нь их болж байлаа. Вокиш руу явах талаар зөрөлдсөн нь тиймэрхүү олон явдлын эхлэл болж өгчээ.

Хандгай нийгэмлэгийн клубт Керри тоглосны маргааш нь Херствүд авгай охиныхоо хамт морин уралдаанд очихдоо гэрийн модон тавилгын том үйлдвэрийн эзний хүү Барт Тейлор гэдэг залууг дагуулж очсон байж. Тэд гэрээс эртхэн гарч явах зуураа Хандгай нийгэмлэгийн гишүүн, Херствүдийн хэдэн найзтай санамсаргүй тааралджээ. Тэдний хоёр нь өчигдөр орой нь нөгөө жүжгийг үзсэн улс байж. Хэрэв Жессикагийн найз залуу түүнд хамаг анхаарлаа тавьж хөл алдаагүй бол тэр жүжгийн талаар ерөөс үг ч цухуйлгалгүй өнгөрөх байсан ажээ. Херствүд авгай яаж дуугүй байх вэ гэсэндээ өөртэйгөө мэндэлсэн хүмүүсийн мэндийн хариуд үг хэлээд зогссонгүй, цааш унжирсан яриа болгон, тэдний нэгнээс нь их л сонин юм дуулжээ. Биеийн тамирын гоёмсог костюмтай, мөрөн дээгүүрээ хоёр нүднийхээ дуранг оосорлон дүүжилсэн тэр эрхэм:

- Та өчигдөр орой манай дээр болсон үдэшлэгт ирж чадаагүй тань тун харамсалтай гэхэдэ Херствүд авгай юу хэлж байгааг нь ойлгохгүй өөдөөс нь мэл гайхан юу ярьж байнаа? Юун шүдэшлэг? Миний огт сонсоогүй юм ярих чинь юу билээ? гэж арай л хэлчихсэнгүй дэмий хэсэг гайхаж байтал нөгөө хүн нь:

- Харин би танай хар хүнтэй уулзсан гэв.

Херствүд авгай жигтэйхэн гайхаж байснаа тун их сэжиглэн:

- Тийм, харин сонирхолтой болсон биз? Манай хүн надад олигтой тодорхой юм яриагүй шүү гэж болгоомжтой хэлэв.

- Их сайхан болсон. Би ер сайн дурын уран сайхны театр тийм чадалтай байхыг үзээгүй юм. Нэг эмэгтэй жүжигчин л гайхмаар сайн тоглосон доо.

- Тийм байхаа гэж авгай амы нь дагуулав.

- Тө өөрөө ирж чадаагүй тань л харамсалтай хэрэг. Таны биеийг бага зэрэг чилээрхсэн гэж дуулсан.

“Чилээрхсэн гээн шүү” гэж Херствүд авгай хэлсэн үгий нь давтан хашгирах дөхөж огт худал юм ярьж, яах гэж тэгсэн юм бол гэж асууж шалгаамаар санагдсан боловч биеэ хүчлэн бариад шүд зуух дөхөн:

- Тийм ээ, харамсалтай юм болж гэв.

Танил нь ярианыхаа сэдвийг өөрчилж:

- Өнөөдөр олон хүн цуглах нь шив дээ, тийм ээ? гэлээ.

Зоогийн газрын эрхлэгчийн гэргий цааш лавтган сонирхохыг хүсэвч тийм боломж олдсонгүй. Өөрийг нь өвдөөгүй байтал өвдсөн гэж хэлдэг нь ямар хэрэг гараад худал хэлж вэ гэж дотроо гайхан бодлоо. Хамт явахгүй гэсэн бас нэг шалтгаан гарчээ, тэгээд үг зохиосон байна, ямар учиртайг нь олохоор шийджээ. Суудалдаа суунгаа Хертсвүдийн найз гэж биеэ танилцуулсан нөгөө хүнээс нь:

- Та өчигдөр оройн жүжгийг нь үзсэн биз дээ? гэхэд цаадах нь:

- Очсоон. Харин та ирээгүй шүү дээ гэв.

- Бие миь жаахан базаахгүй байсна л даа гэж Херствүд авгай худал хэлэв.

- Танай нөхөр тэгж хэлсээн. Тун сайхан жүжиг болсон . Санаснаас хамаагүй сайхан болсон шүү.

- Олон хүн ирсэн үү?

- Зөндөө олон хүн. Хандгай нийгэмлэгийнхэн бүгд ирсэн байх аа. Харрисон хатагтай, Барнес хатагтай, Коллинз хатагтай гээд л танай айз нараас олон хүн байсан.

- Бараг бүгдээрээ ирээ шив дээ. _

- Яг үнэн. Авгай маань тун их сонирхсон.

Херствүд авгай хөмхийгөө зуулаа.

“Ингэдэг бослно хүн бий. Найз нөхдөд маань бие нь муу, ирж чадсангүй гэж хэлдэг байна”, “Яах гэж ганцаараа явах гээд байдаг болсон юм бол? Нэг л учир байна даа” гэх мэтээр тэр оньсгогыг тайлан санаатай бодол болно.

Херствүдийг орой гэртээ ирэхэд авгай нь түүнээс хамаг учрыг лавлан олж өшөөгөө авахсан гэсэн бодолтой байв. Яагаад ийм хачин зан гаргадаг болсон учры нь мэдье гэж шийдсэн байна. Өөрийнх нь сонссоноос ч их юм цаанаа бий гэдгийг Херствүд авгай зөнгөөрөө гадарлах аж. Өглөө муудалцаж байсан уур нь гараагүйгээр үл барам үл итгэх нь улам их болсон тул бүр зэвүүн муу үгээр ч ёжилмоор санагдаж байв. Тэгээд нүдэнд нь олиггүй өнгө ёлтолзож хөмхийгөө зуун

амаа жмийгээд гэр орондоо хэрүүл шуугиан дэгпээх аюулын биелэл болсон амьтан тайван сууж чадахгүй хөлхөнө.

Харин Херствүд гэртээ тун сайхан зантай ирсэн нь мэдээж. Керритэй уулзаж тохиролцсон болохоор хөл газар хүрэхээргүй баярлан дулж хашгирах нь халаг байв. Өөртөө болон олсон амжилтаараа, Керригээр бахархаж байв. Бүх хорвоо ертөнц гэмгүй сайхан санагдаж авгайгаа ч азадлахааргүй байв. Авгайгаа хажиглахгүй, тайван сайхан байх, сэргэж эргэж ирсэн залуу халуун насны жаргал цэнгэлийг эдэлмээр санагдана.

Тийм учраас тэр орой гэр орон нь онцгой гэгээн саруул, ээлтэй сайхан мэт санагджээ. Урд талынхаа өрөөнд орж очиход оройн сонин харагдав. Шивэгчин нь авчраад зохих газар нь тавьсан боловч Херствүд авгай авахаа мартаад орхиод босож байж. Хоолных нь өрөөнд шаазан, болор сав өрсөн цас шиг цагаан бүтээлэгтэй гал тогооны зуухны гал улалзаж оройн хоол бэлэн болж байв. Хүү Жорж нь саяхан худалдаж авсан гөлөгтэйгөө тоглож байгаа харагдана. Жессика зочныхоо өрөөнд төгөлдөр баян хуур дарж цовоолог вальс бүжгийн эгшиг дуу өрөө бүгдээр нь цуурайтаж байв.

Херствүдийн бодлоор тэднийхэн бүгд ааш зан сайтай байж хөгжиж наргиж баймаар санагдана. Бүгдэд нь хэнд нь ч ялгаагүй нэг сайхан юм хэлж баясгамаар ч юм шиг. Херствүд, зассан ширээ, өнгөлж чийдсэн тавилга хэрэглэл бүхнээ нүд хэсүүчлэн харж баяссанаа босож зочныхоо өрөө рүү оров. Ороод очиход авгай нь үс гэзгээ аялуулан баахан бодолд дарагдсан янзтай харагдана. Хэдэн таатай үг хэлж, юу гэвэл за гэж байгаад сэтгэлий нь тайтгаруулья гэж Херствүд бодож байсан боловч авгай нь юу ч дуугарсангүй. Тэгэхлээр нь түшлэгтэй сандал дээр сууж сонингоо дэлгэн уншиж гарлаа. Хэдэн минутын дараа мань эр, Чикаго, Детройт хоёр хотын бейсболын багийн тэмцээний талаар соньхон сурвалжлаг уншиж байгаад инээд нь хүрч байхад Херствүд авгай сэмхэн хулгай нүдээр ажиглаж байв. нөхөр нь их сайхан зантай, инээмсэглэн байгааг хараад сайхан санагдах байтугай бүр ч зэвүү нь хүрэв. Хүнийг тоохгүй ад үзэж байж ба ингэж маяглаад, алзганаад байх. Чи тэгч л бай, хамаг муугий чинь уудалж хэлэх үггүй болтол чинь гөлөлзүүлж бах таваа ханана даа, ямар чадалтай үгээр яаж шиг хэлдэг билээ гэхээс авгай халаглаж байв. Тэгээд уур хилэнгийнх нь гялалзсан сэлэм сэтгэхүйнх нь хэврэгхэн утаснаас Херствүдийн толгой дээр буухаар болжээ.

Гэтэл Херствүд сонингоо уншсаар бөгөөд тэр хотод ирсэн нэг хүн мөрийтэй тоглоомын газар орж мундраа тавьсан тухай юм олж уншаад сандал дээрээ эргэлдэж өхөрлөө. Авгайнхаа анхаарлыг татах гэж – Ха- Ха – Ха! Үгүй мөн инээдтэй юм болж дээ гэлээ.

Гэвч авгай нь гэзгээрээ оролдсон болж анхаарах байтугай, хяламхийсэн ч үгүй, Херствүд сандал дээрээ лахин нэг эргэлдсэнээ өөр нэг зүйлийг угшиж эхлэв. Тэгснээ сайн зантай байгаагаа мэдэгдэж нэг аятайхан юм хэлмээр санагдав. Жулиа маань өглөөний хэрүүлээс болж бухимдсаар байна, сэтгэлий нь засчих юу байхав. Өөрөө буруутай л даа, гэхдээ яахав Вокиш руу явах гэж яараад байгаа бол явж л байг, түргэхэн тусмаа сайн л биз. Эгзгий нь тааруулаад ингэж л хэлье, тэгээд болно биз гэж бодлоо.

- “Иллинойс Централ” төмөр замыг эргийн болдгоос зайлуулна гэсэн зарга үүссэн гэдэг шүү дээ, Жулиа чи сая энэ тухай уншив уу, гэхэд арай ядан ам нээж:

- “Үгүй” гэж их ширүүн хэлэв.

Авгай нь тун ёозгүй дуугарсан тул Херствүд болгоомжлов.

- Тэд аль хэдийн ингэж ёстой байсан юм гэж Херствүд эхнэртээ зориулж хэлэхээсээ өөртөө хэлж байгаа юм шиг дуугарав.

Нэг л биш гэдгийг мань хүн гадарлажээ. Цааш нь сонингоо унших боловч ер нь юу болох гээд байна даа хэмээн дотроо түгшин өчүүхэн дуу чимээг боловч чих тавин ажиж байв.

Үнэнийг хэлэхэд Херствүд шиг тийм ухаантай, ажигч, овсгоотой хүн толгойдоо өөр их юм бодож байгаагүй бол хаанаас уур унтуу болж буй авгайтайгаа иймэрхүү байдалтай харьцах билээ. Керри йг бодохоос тэр хүүхэн тийнхүү за зүй болсныг бодохоос Херствүд гэр орныхныхоо зан ааш базаахгүй байгааг ч анзаарсангүй. тэр орой тэднийхэн тийм ч аятайхан байсан биш ажээ. Херствүд л буруу ойлгосон байв. Уг нь гэртээ урьдынхаа хэвээр орж ирсэн бол одоо тулгарч буй аюулыг сөрөхөд өөрт нь арай хөнгөн байхсан билээ.

Херствүд сонингоо хэсэг уншиж байснаа ам нээснийх ямар ч болтугай ярилцах хэрэгтэй, энэ авгайн янзаар бол тийм ч амархан хэл амаа ололцохгүй нь гэж бодоод үг өдөв.

- Тэр гадаад тоглож байгаа нохойг Жорж хэзээ авсан юм? гэхэд эхнэр нь:

- Би яаж мэддэг юм гэж хэгжүүрхэв.

Херствүд сонингоо хажуу тийш тавиад цонхоор алмайран харна. “Ямар ч болсон уурлахгүй юм шүү, аятайхан тэвчээртэй байж байгаад эв зүйгээ олох юм шүү” гэж дотроо бодож байв.

- Өглөөний уур чинь гараагүй л байгаа юм уу? Тийм юман дээрээс маргалдахаа больё” хө. Вокиш руу явмаар байгаа бол яв л даа гэв.

Энэ үгийг авгай нь сонсоод огцом эргэж:

- Энд ганцаараа үлдээд бас нэг юмтай шалиглах гэж үү? Хэмээн хорсон уурлаж дооглосон байдалтай хэлэв.

Херствүд алгадуулсан юм шиг цочирдон юу ч хэлж чадсангүй. Эв дүйгээр оролдох санаатай аажуу уужуу байсан байдал нь нүд ирмэхийн зуур алга болж биеэ өмөөрч хэлэх үгээ бэлдэж эхлэв. Тэгээд биеэ тэгшлэн сууж шийдсэн янзтай хүйтэн царай гаргах эхнэрийнхээ өөдөөс ширтэн харж:

- Чи ер нь юу гэх гээд байна? гэхэд авгай нь огтхон ч тоолгүй тольдож үс гэзгээ оролдож байснаа:

- Чи миний юу хэлэх гэж байгааг өөрөө сайн мэдэж байгаа шүү дээ гэж маш их юм олж сонссон боловч одоогоор тоочих хэрэггүй хэмээн нөөцөлж байгаа хүн шиг хэлэв.

- Би мэдэхгүй ээ гэж Херствүд өөрийнхөөрөө зүтгэх боловч юу гаргаж ирэх бол гэж дотроо зовж гилбэлзэхийн байлаа.

Авгай нь ихээхэн шийдмэг байх учир мань эр энэ тулалдаанд нэг их давамгайлж чадахгүй болов.

Херствүд авгай дуугай л байлаа.

- Хм! Гэж Херствүд дуугараад толгойгоо далжисхийлээ.

Энэ арчаагүй хөдөлгөөнөөрөө өөрийнхөө бантаж байгааг л харуулжээ. Авгай нь одоо л үхлийн цохилт буулгая гэсэн шиг, зэрлэг аратан мэтээр өөдөөс нь харж:

- Би маргааш өглөө л Вокиш явлаа, чи мөнгөө өгөөтөх гэлээ.

Херствүд өөдөөс нь гайхаш нь барагдсан янзтай харав. Авгай нь хэзээ ч ингэж хүйтэн харж, ийм шийдэмгий ийм тоомсоргүй байсан удаагүй билээ. Ер нь хамаг эрх мэдлий нь булаан авах гэж санаа шийдсэн мэт тун янзтай харагдана. Херствүд ямар ч тэвчээр гаргаад тус болохгүйг мэдээд өөрөө довтолгоонд орохоор шийдвэ.

- Чи ер нь юу гэх гэд байна вэ? надад өгөөтөх гэнэ үү, тэгнэ вий чи! Өнөө орой юу болчихоо вэ? гэж хэлэнгээ босон харайлаа.

- Юу ч болсон юм алга. Надад тэр мөнгө л хэрэгтэй. Намайг явсан хойно савсганадгаараа савсганах юм байгаа биз гэж авгай улам уурсан хэлэв.

- Савсганах гэнэ шүү. Юу ярьж байна? Чи надаас юу ч олж долоохгүй. Чи ер нь юу гэх гээд байгаа юм, хэлээтэх!

- Чи өгчигдөр орой хаачсан бэ? Вашингтоны цэцэрлэгт гудамжаар хэнтэй хамт явсан? Жоржийн театрт юм үзэж байхад чи хэнтэй хамт байсан? Чи намайг өөртөө маллулчих маанаг юм гэж бодоо юу? “Ажил их, завгүй”, “очиж чадахгүй”, “ирж чадахгүй” гэчихээд л энд тэнд хэсүүчилж, намайг бие нь муу ирж чадасангүй энэ тэр гэж худал үнэн хэлж байхад чинь би бас гэрийн мухар сахиад чамд маллуулаад суух юм гэж бодоо юу? Чамд дахни дээрэлхүүлэхгүй шүү. Намайг ч тэр, хүүхдүүдийг ч тэр тархидах гэвэл дэмий шүү. Яамтай одоо тэгж суудаг цаг өнгөрсөн гэж мэдээрэй гэж авгай нь улайм цайм хэлээд тавьчихлаа.

Херствүд мухардаж хэлэх үггүй олсондоо дэмий л:

- Худал битгий хэл гэв.

- Худал гэнээ, хэ-хэ! Хичнээн худал гээд яах юм, би нэгэнт л бүгдий нь мэдэж байгаа юм чинь гэж галзуу мэт хэлснээ биеэ бага зэрэг барилаа. Херствүд нам боловч эрс дуугаар:

- Худал, худал гэж би хэлж байна. Чи хичнээн сарын турш элдэв муу хов жив хөөцөлдөж явсаар одоо юм мэдэж авлаа гэж бодож байх шиг байна. Чи нэг юм гаргаж ирээд намайг чадчихна гэж санаа юу? Тэр дэмий, гонж. Энэ айлд байгаа цагт би эзэн нь шүү. Чамд байтугай хэнд ч толгойгоо мэдүүлэхгүй, мэдэв үү чи? гЭж уур хилэн бадарсан нүдээрээ ширтсээр дэргэд нь тулж очлоо.

Тэр авгайн хүйтэн цэвдэг, омгорхог дээрэлхүү байдлы нь харахаас багалзууры нь шахаад авчихмаар ч санагджээ.

Авгай нь дооглож доромжилсон байдалтай өөдөөс нь мэлийн харж байснаа:

- Би чамайг захираагүй. Би чамд юу хүсэж байгаагаа л хэлж байна гэж тун хүйтэн, омогтой хэлсэн тул Хертсвүдийн зориг мохож эхлэв.

Одоо мань эр дайрч давшлах байтугай, нотолгоо ч шаардаж чадахааргүй болов. Ямар ч болтугай гарцаагүй баримт гаргах хууль эрхийн асуудал сэдэх, хамаг эд хөрөнгө нэр дэрээ байгаа гэдгээр гул барих нь авгайн нүдэнд ил байгааг ойлголоо. Херствүд одоо дарвуулгүй болчихоод салхины аясаар хөөгдөн буй асар том хөлөг онгоц мэт байв. Тэгснээ жаал сэхээ авч:

- Чи ингэхэд юу ч олж долоохгүй гэлээ.

- Долоох нь уу, үгүй нв үү үзнэ дээ. Би эрхээ тодотгуулна. Хэрэв та надтай ярилцахыг хүсэхгүй байгаа бол өмгөөлөгчтэй ярилцах юм байгаа биз.

Херствүд авгай ингэж сүрхий хэлж чадсанаар цаадахдаа цохилт өгч амжив. Хоосон сүрдүүлэг биш гэдгийг Херствүд ойлголоо. Тун адармаатай асуудалд орж буйгаа ухаараад юу ч гэж хэлэхээ мэдэхгүй мухарджээ. Тэр өдрийн өнөө их баяр баясгалан тэр чигээрээ алга болж сэтгэл нь зовж, уур нь хүрч, арчаагаа алдав. Одоо яана даа?

- Яавал яа, өөрөө л мэд. Чамтай ингэж дэмийрч байх хүсэл арга гээд Херствүд гарч одлоо.

СЭТГЭЛИЙН ЗОВЛОН. БАС НЭГ АДАРМАА

Керри өрөөндөө хүрч ирээд угаас шийд муутай хүн болохоор дахиад л түгшиж, дүлэгнэж эхэлжээ. Херствүдэд за гээд хэлчихдэг маань зөв болов уу, буруу болов уу нэгэнт за гэчихсэнээс хойш ам буцах хэцүүеэ гэж бодно. Херствүдтэй юу юу ярилцсан, яасан ийснээ бүгдийг нэхэн санавал түүний сүйд болон яоьж байсан үгэнд эргэлзмээр юм цөөнгүй байсныг одоо л ухаарчээ. Нөхөртэй хүүхэн гэж бодож байхад нь өөртэй нь сууна гэдэг маань ч юу билээ гэж бодлоо. Бас Дрүү өөрт нь хичнээн их тус болсныг санаж, одоо ганц ч үг хэлэлгүй гэнэт орхиод явчих даанч муухай юм даа. “Одоо бишгүй л сайн сайхан сууж байна, амьдрал гэдэг айхавтар шүү дээ, энэ зэрэг байж эзтэй загнах юу л болох бол? Юмыг яаж мэдэх вэ. Зовлон мундахгүй шүү дээ, гуйлгачин ядуу хүн хичнээн олон байна. Үйл тамаа үзэж яваа бүсгүйчүүл олон, юу болохыг хэн мэдэх вэ? Өлсөж явсан цагаа мартаж болохгүй. Шилсэн юм шилд, голсон юм голд гэдэг” гэх мэтээр бодлоо.

Керри, Херствүдэд хичнээн их татагдаж байсан хэр нь түүнд ухаан жолоогүй унаж өгөөгүй нь сонин билээ. Үгий нь дуртай сонсож, инээн баяссаж, таалан сайшааж байсан боловч шалдаа буусангүй. Херствүдийн зориг дутаж, ухаан жолоогоо алдтал шунан тачаадах, аливаа ёс горим, онол, эрүүл саруул ухаан гэгчийг хэрэгсэхээ болин үхэлдэн тачаадах тийм хүч дутсанаас л Керрийг эрхэндээ бүрмөсөн оруулж чадсангүй. Тийм их шунал тачаал эр хүнд нэг л удаа, тэгэхдээ, залуу насанд нь тохиолдож насныхаа ханийг олж авснаар төгс болдог билээ.

Херствүд одоо янагийн ухаан жолоогүй халуун хайраар дурлавч хижээл хүн болохоор гал халуун залуу зандан насныхдаа яаж хүрэх билээ. Гэхдээ л Керрийг биедээ татаж, нээрээ ч хайр сэтгэлийн нь булаачихав уу даа гэж бодмоор болсныг бид үзлээ. Керри үнэн зүрхээсээ хайрлаагүй хэрнээ хайртай мэт санаж байсан мөч бий. Эмэгтэй хүнд тийм явдал цөөнгүй л тохиолддог л доо. Энэ бол хүнд хайр сэтгэлээ өгөх хүсэлтэй байдаг хүний хайрыг авах дуртай байдгаас билээ. Хайр ивээлд нь орж, бөөцийлүүлж, хөөрхийлүүлж байх нь эмэгтэй хүний салшгүй нэг чанар юм. Үүн дээр нь төрөлхийн нялуун зан ааш нэмэр болбол эр хүнд үгүй гэж хэлэх бэрх болдог ажээ. Нэгэнт иймэрхүү байдалд орвол хүнд хайртай сэтгэлтэй болчихлоо гэж боддог байх юм.

Керри гэртээ эргэж ирээд хувцсаа сольж өмсөөд өрөөгөө янзлав. Шивэгчний хийсэн ажил санаанд нь хэзээд хүрдэггүй ажээ. Ялангуяа сандал ширээг аялуулахдаа Керрийн цонхны дэргэд тавьж суудаг сандлы нь заавал ч үгүй тэртээ буланд аваачаад тавьчихдаг байж. Өнөөдрийн хувьд гэвэл Керри бөөн бодол болж байсан болохоор тэр зэргийн юмыг ч ажиглахааргүй байв. Таваг цаг болж Дрүүг орж ирэхэд Керри өрөөнийхөө юм хумыг аялуулсан байв. Доншуур худалдаачны сэтгэл ихэд хөдөлж тэсэж ядсан байдалтай харагдах бөгөөд Херствүдтэй ямар учиртай болохы нь нэн даруй мэдэж авахаар зориг шийджээ. Өдрийн туж тэр тухай бодсоор сүүлдээ бүр залхаж бушуухан л учры нь олохын мөн болж байж. Нэг их сүйдтэй юм болохгүй биз гэж бодовч ам нээхээсээ нэлээд халгана. Орж ирэхэд нь Керри эргэдэг сандал дээрээ гадагш вь харан сууж байв.

Өөрийнхөө бодолд ядарсан бөгөөд Дрүүг нэг их яаруу мэгдүү, оёг муутай орж ирэхий нь мэдсэн Керри гэмгүй царайлан:

- Чи чинь яагаад нэг их үсчиж харайгаад байна даа? гэв.

Дрүү тээнэгэлзсэн хэвэр байсан тул одоо Керритэй улаан нүүрээрээ учраад байхдаа чухам яахаа мэдэхгүй болчихов. Манж зан гаргаж чаддаггүй, бас ажигч, гярхай хүн биш. Тэгээд:

- Гэртээ хэдийд ирэв? Гэж тэнэг юм шиг асуув.

- Гэртээ юу? Ирээд цаг хэртэй болж байна.. Юу гэж?

- Өглөө намайг эргээд орж ирэхэд чи байхгүй байсан. Нэг тийш яваад өгсөн юмуу гэж бодсон юм.

- Тэгсээн. Гадуур гарсан юм гэж Керри хээв нэг хэлэв.

Дрүү гайхасхийн харна. Иймэрхүү юманд дүй муутай болохоор чухам юунаас эхлэхээ мэдэхгүй дэмий л мэл ширтэхэд нь Керри тэссэнгүй.

- Намайг ингэтлээ юугий нь ширтээв? Юу болчихоо вэ? гэхэд Дрүү,

- Яасан ч юмгүй, бодож л байна гэв.

Түүний тийм хачин байхлаар Керри бүр гайхаж:

- Юун тухай боддог билээ? гээд инээв.

- Үгүй ээ, онц юмгүй.

- Тэгвэл намайг яах гэж хачин ширтээд байгаа юм?

Дрүү гоёлын ширээний дэргэд малгай бээлийгээ авч гартаа бариад, аахаар шаахар юм хуруугаараа оролдон инээд хүрмээр маягтай зогсон Керрийг ширтсээр байхдаа “Энэ хөөрхөн хүүхэн надад үл таалагдах юм хиймгүйсэн гэж бодсоноо ер нь яагаа ч үгүй байлгүй” гэж сэтгэлээ амраахыг бодовч шивэгчин хүүхний хэлсэн үг чихэнд нь жингэнээд тун ч болсонгүй. Санаснаа шууд хэлээд тавьчихъя гэж бодовч чухам юунаас эхлэхээ мэдэхгүй ажээ. Тэгж тэгж зориг муутайгаар:

- Өнөө өглөө чи хаачаа вэ? гэв.

- Яагаав, гадуур салхинд гарсан гэж байна.

- Өө, тэгээ юм бий.

- Тэгсэн. Юугий нь асуугаад байсан юм?

Бага сага юм дуулж гэж Керри бодлоо. Тэгээд мэлзэхээр зэхэв. Хацар нь үл мэдэг цайна. Дрүү дэмий булзааруулсхийж:

- Би тийм биш юмуу гэж санасан гэв.

Керри өөдөөс нь ширтэн харвал цаадах нь нэг их шийдмэг биш, итгэж ядсан байдалтай бөгөөд нэг их сүйд болохооргүй байгааг бүсгүй хүний зөнгөөр мэдээд алдагдах дөхөж байсан зориг нь

сэргэв.

Керри хөөрхөн духаа атируулж:

- Чи яагаад ийм яриа гаргаж ирэв? Өнөө орой нэг л хачин байх чинь гэв.

- Нэг л хачин байна шүү, үнэндээ

Хоёр биеэ хэсэг ширтэж байснаа Дрүү зүрх гарган уг асуудалдаа орж:

- Херствүд та хоёрын хооронд юу болоод байгаа юм? гэв.

- Херствүд бид хоёрын хооронд? Юу гэх гээд байна?

- Намайг эзгүй хооронд зөндөө олон удаа ирээгүй юу?

- Зөндөө олон удаа гэнэ шүү гэж Керри үгэнд гүйцэгдэж байгаа хүний байдалтай давтаж хэлээд – Тийм биш ээ, тэгээд чи юу гэх гэсэн юм? гэлээ.

- Чамайг түүнтэй хамт ийш тийш явдаг байсан, цаадахы чинь манайд орой болгон ирдэг байсан гэж надад нэг хүн хэлсэн.

- Тийм юм байхгүй шүү, худал, хэн хэлж байна?

Керрийн царай час улайсан боловч оройн бүдэг гэрэлд Дрүү түний нь ажсангүй. Гэвч Керри худалд гэхээс өөр юм хэлж чадахгүй болохоор Дрүү, учиртай нь учиртай юм байна гэж гадарлан:

- Хэн ч байсан яахав, үгүй юм биз дээ? гэхэд Керри:

- Тэгэлгүй яахав, хэдэн удаа ирсний нь чи өөрөө мэдэж байгаа шүү дээ гэв.

Дрүү түр дуугай болон бодолхийлснээ:

- Би чиний хэлснийг санаж байна гээд өрөөн дотуур тогтож ядан хөлхөхөд Керри түүнийг сандарсан байдалтайгаар нүд дагуулан харснаа бага зэрэг уужирч:

- Гэхдээ би чамд тийм юм хэлээгүй шүү гэв.

Дрүү хэлсэн үгий нь огт анхаарахгүйгээр:

- Би л бол тийм хүнтэй нэрээ холбохгүй. Цаадах чинь эхнэртэй хүн шүү дээ гэхэд Керри:

- Хэн? Хэнийг хэлж байна? гэж түгдчив.

- Яагаав, Херствүд гэж Дрүү хэлээд хэлсэн энэ үг нь ямар нөлөө үзүүлж байгааг ажиж, ёстой л үхлийн цохилт өгнө гэгч шиг болхоыг мэдэрлээ.

- Херствүд! Гэж Керри дуу алдан босон харайв. Тэр үгийг сонссоноор царайных нь өнгө хэд дахин хувирч, ухаан нь орж гарч байх шиг болв.

- Хэн чамд ингэж хэлэв? Гэж Керри энэ асуудлыг хэтэрхий сонирхож өөрийгөө улайлгаж байгааг ч мартжээ.

- Би мэднэ шүү дээ. Мэддэг л байсан юм чинь гэж Дрүү хээв.

Керри юусан билээ хэмээн эргэцүүлэн бодохыг оролдов. Харваас барьц алдаж арчаагүй байдалтай байвч хулчганан бууж өгөх шинжгүй байлаа.

- Би чамд хэлж байсан шиг санаж байна.

- Үгүй, чи хэлээгүй, чи ердөө ч тийм юм хэлж байгаагүй гэж Керри гэнэт хэлд орж байгаа юм шиг мэтгэв.

Дрүү түүнийг гайхан харна. Энэ бол шинэ зүйл байлаа.

- Би чамд хэлж байсан л санагдах юм.

Керри уруу царайлан тсалгааг тойруулан харснаа цонхны дэргэд очив.

Дрүү гоморхсон байдалтайгаар:

- Би чиний төлөө гэж явж байхад чи тэр хүнтэй, тэгэх ёсгүй байсан шүү дээ гэхэд Керри:

- Чи юу? Чи юу? Чи миний төлөө юу хийсэн юм? гэв.

Худал хэлж баригдсандаа, Херствүдийн итгэл эдвсэн хорон муу санаа, Дрүүгийн хуурамч занг бодохоос, одоо Дрүү өөрөөр нь тоглоом хийж бах таваа ханаж байгаа энэ бүгдийг бодохоос ичих уурлах зэрэгцэн өчүүхэн толгойд нь элдэв дээдийн юм бодогдоно. Энэ бүхэн Дрүүгээс боллоо гэсэн ганц бодол товойж ирлээ. Энэ бол эргэлзээгүй. Яагаад энэ хүн тэр Херствүдийг, эхнэртэй тэр хүнийг гэртээ дагуулж ирсэн атлаа надад ганц ч үг хэлсэнгүй вэ? Херствүдийн хорон муу санаа ч яамай харин яах гэж Дрүү тэгсэн байна? Яагаад надад урьдаас хэлдэггүй билээ? Ийм муухай итгэл алдсан юм хийсэн атал одоо дэргэд минь ирж зогсчихоод ачирхан гайхуулж байна!

Дрүү хэлсэн үгээ Керрид ямар их хорсол төрүүлж байгааг бараг анзааралгүй:

- Энэ чинь л надад тааламжтай байна. Үнэндээ би чиний төлөө их юм хийсэн гэв.

- Чи юу? ээ-хэ? Чи намайг малласан л байх. Чиний хийсэн юм чинь л энэ дээ. Чи хуучин найз нараа нааш нь чирч авчирч худал танилцуулж байсан байна. Чи намайг бас... Үгүй ер гээд гаслан хоолой нь тасалдаж хоёр жаахан гараа тас атгав.

- Гэлээ ч гэсэн энд чинь ямар холбоо байна, би л мэдэхгүй юм байна гэж Дрүү хэлэв.

Керри нэлээд сэхээрч шүд зуун:

- Чи мэдэхгүй л байна уу? Аргагүй, чамд мэдэх юм байдаг юм уу? Ер нь байдаггүй байх. Чи анхнаасаа надад хэлж болох байсан биз дээ, тийм ээ? Чи хэлэхгүй байсаар байгаад л хожимдсон хойно нь их юм болж байна. Тэгээд одоо ул шагайж, хүнээс хов сонсож ирчихээд бас миний төлөө их юм хийсэн гэж их ачирхаж байна гэлээ.

Дрүү, Керрийг иймэрхүү зан гарган гэж ердөө ч бодоогүй байж. Керрийн дургүй хүрч уур нь шатаж, нүд нь ёлтолзон, уруул ам нь татвалзан, доромжлуулснаа бодохоос хамаг бие нь салганав.

Дрүү жаахан буруу юм хэлчихлээ гэдгээ мэдсэн боловч өөдөөс минь арай ч ингэж хэлэх ёсгүй гэж бодоод зөөлнөөр:

- Чиний улыг хэн шагайсан юм? гэхэд Керри шулуухан:

- Чи! Чи бол зэвүү хүрмээр, биеэ хичээсэн адгийн муу хулчгар маьтан, чамд эр хүний нүнжиг бага ч гэсэн байсан бол юу гэж ийм юм болох вэ гэв.

Дрүү бүр мэл гайхан амаа ангайж:

- Би хулчгар хүн биш ээ харин чи яах гэж бусад харцуултай шалиглаж явдаг байна, учры мэдмээр байна гэлээ. Керри дуу алдан:

- Бусад харцуултай гэнээ! Бусад харцуул гэнэ шүү. Хэнтэй гэдгий нь өөрөө мэдсээр байж бусад харцуултай гэдэг чинь юу гэсэн үг вэ? Би Херствүдтэй хамт явдаг байсан, гэвч хэний буруу вэ? Чи тэрнийг нааш авчраагүй юу? Чи л манайд ирж надтай уулзаж барьж бай гэж хэлсэн биз. Тэгээд одоо өнгөрсөн хойно нь намайг тэр хүнтэй ойр явах хэрэггүй, цаадах чинь эхнэртэй хүн гэдэг чинь юу вэ гэв.

Керри “эхрнэтэй хүн” гэсэн хоёр үгэн дээр дуугаа тасалдуулж гараа чанга базлав. Херствүдийн зальт муу санааг бодохоос зүрх рүү нь хутга шааж байгаа юм шиг санагдана.

Керри “Өө” гэж мэгших боловч биеэ хүчлэн барих тул нулимс унагасангүй.

- Намайг эзгүй хойгуур чамайг тэрүүнтэй гүйх юм гэж би даанч бодоогүй гэж Дрүү б ас хэлчихэв.

Керри түүний хачин ийм зан байдлыг харахаас уур нь шатаж:

- Бодоогүй гэнэ. Бодоогүй л дээ, чи ч! Бах таваа хэзээ ханадаг билээ л гэж бодож байсан байх. надаар тоглоом, доог тохуу хийхийгээ л бодож байсан байх. Надаар тэгж тоглож чадахгүй гэдгийг одоо би харуулаад өгнө. Одоо би чамтай ингэж суудгаа болилоо. Чи муусайн хар новшнуудаа аваарай гээд түүний өгсөн жижигхэн гоёлын зүшг хуу татан авч шалан дээр хүчтэй гэгч нь шидээд өөрийн гэсэн юм хумаа цуглуулж авах гэж буй мэтээр зангав.

Дрүү инэгэхий нь хараад уурлахын хажуугаар бас дотроо бахдаж байв. Тэгээд түүнийг гайхан харсаар:

- Чи юугий нь ингэтлээ уурлана вэ? надад буруу юм байхгүй шүү. Чиний төлөө гэж явахад чи ингэж дэмий юм хийж байх чмар хэрэг байна гэв.

Керри толгойгоо ганасхийлгэн, амаа ангайсхийн:

- Чи миний төлөө юу хийсэн юм? гэхэд Дрүү өрөөгөө нүд хэсүүлэн учиртайхан харж:

- Миний хийсэн юм багадаагүй байх. Би чамайг хувцасласан, үгүй гэх үү? Чамайг хаана очъё

гэвэл тэнд чинь аваачдаг байна. Чи надтай л адилхан юм үздэг, надаас ч илүү үздэг байсан шүү дээ гэв.

Керрийг юу ч гэж муу хэлж боллоо гэхэд харин хүний ач мэддэггүй хүн гэж болохгүй юм шүү. Ачий нь ачаар хариулсан гэж Керри бодно. Одоо уурандаа болоод юу гэж хариу хэлэхээ сайн мэдэхгүй, дроншуур хуждалдаачинд сүнсгүй муухай доромжлуулав л гэж бодно.

- Би чамаас гуйгаагүй шүү!

- Ямар ч гэсэн би өгдөг, чи авдаг байсан.

- Чамайг ятгаж байгаад юмы чинь авдаг байсан гэх нь үү? Чи надад юугаараа нэг их ачирхах юм? Чи энэ авч өгсөн хувцас надад хэрэггүй. Би өмсөж зүүх я үгүй. Энэ муусайн юмнуудаа одоо ч болтугай нь ав! Би энд одоо ганц хормын төдий байхгүй явлаа.

- Сайхан юм болох нь шив дээ. Эдэлдгээ эдэлж хүнийг ашиглачихаад адаг сүүлд нь орхиод явна гэнэ. Ёстой эм хүний зан мөндөө. Чамайг юу үгүй явж байхад би аминд чинь орсон, одоо өөр хүнтэй болохоороо би хэрэггүй болоо юу? Ер нь иймэрхүү юм болох ч болов уу гэж би дандаа боддог байсан л даа гэж Дрүэ тэр хүүхнийг алдах нь гэсэндээ уур шатаж хэлэв.

Ачийг нь бачаар хариулж шударга биш юм хийлээ гэж бодохоос мань хүн үнэхээр зэвүүцнэ.

- Тийм биш ээ, би хэнтэй ч яваагүй. Харин чи өөдгүй, олиггүй муу зан гаргадаг байсан. Угаасаа ч чи тийм хүн л дээ. Би чамайг үзэн ядаж байна, мэдэв үү? Үзэн ядаж байна, чамтай одоо ганц ч минут хамт байхгүй. Чи бол адгийн гэснээ үг нэмж хэлэлгүй орхиод. Тийм байсан бол ингэж ярихгүй л байсан байх гэв.

Керри малгайгаа авч, оройн цагаар өмсдөг энгийн жижигхэн бошинз дээрээ гадуур цамцаа өмсөв. Толгойтой буржгар үснээс нь хэдэн ширхэг улайж халууцсан хацарт нь наалджээ. Уурлаж, гутарч гомдсон нь тулйгүй. Том нүдэнд нь нулимс гүйлгэнэх боловч зовхи нь хуурай. Юм хүмээ энд тэнд дэмий л зөөж тавин өрөөн дотуур итгэл муутай алмайран хөлхөх бөгөөд ямар нэг юм шийдэж буй мэт боловч энэ хэрүүл эцсийн эцэст юугаар төгсөхийг огт ухаарахгүй шинжтэй.

- Ингээд их сайхнаар төгсөх болж байх шив дээ? Юмаа боож баглаж аваад, “баяртай” юу? Дэндүү хэтэрч байна. хэрэв чи Херствүдтнй шалиглаагүй бол ингэхгүй байсан байх. Би энэ муу байранд байх ч үгүй. Надаас болж чи эндээс явах хэрэггүй. Чи эндээ бай, надад пад алга. Харин чи надад тун муухай юм хийж байна шүү.

- Би чамтай хамт амьдрахгүй, хамт байх хүсэл алга. Энд чамтай хамт байхдаа чамаас хоосон сагсуу үгнээс өөр юм би сонсоогүй.

- Үгүй ер, өөр хэлэх юм алга уу?

Керри үүд рүү явлаа. Дрүэ ухасхийн өмнө нь гарч:

- Чи хаачих нь вэ? гэхэд:

- Алив, битгий саад хийгээд бай, би явлаа гэв.

- Чи хаачих гэж?

Дрүү зөөлөн сэтгэлтэй хүн байсан болохоор хэдийгээр уур зэвүү нь хүрч байсан ч гэсэн хашаа ч явахаа сайн мэдэхгүй байгаа Керрийг хараад өрөвджээ. Керри хариу үг хэлэхгүй үүд рүү лтэмүүлэн дахин нэг ухасхийснээ тухайн түгшүүртэй байдлын давж чадалгүй тэсгэлгүй уйллаа.

- Кэд минь сайн бод. Ингэж явах гээд тэмүүлэхийн хэрэг юу байна? Чамд очих газар ч байхгүй шүү дээ. Эндээ байж байгаад тайвшрах хэрэгтэй. Би чамайг яах ч үгүй. Би эндээс яваад өгье гэж Дрүү аргадаж хэлэв.

Керри уйлан мэгшсээр үүдний тэндээсээ цонхны дэргэд очлоо. Үг ярьж ч чадахгүй болжээ.

- Сайн бод.

- Би чамайг бариад байх гэсэн юм биш. Очих газраа очиж бололгүй яахав, яваарай, харин сайн л бодож үзэх хэрэгтэй. Бурхан минь, би юу гэж чамайг албаар хорих билээ.

Керри хариу үг хэлээгүй болов аргадсанд нь бага зэрэг тайвширч байлаа.

Хэлж буй үгий нь сонсоод Керрид элдвийн юм бодогджээ. Юмны зүй зохисыг эрхибиш гадарлах ухаан нь самуурч эхлэв. Нэгнийг бодохул сэтгэл түгшинэ, нөгөөг бодохул уур хүрнэ. Өөрөө болон Херствүд, Дрүү болчимгүй зан гаргаж, мөн тэр хоёр сайхан аашилж ач тус болж байсан, эднийхээс гараад явнаа гэхэд урьд нэг удаа үйл тамаа үзсэн тэр өрөвдөх сэтгэлгүй ертөнц өөдөөс нь угтана, байя гэхнээ өөрийн гэх орон нэгэнт бишээс хойш сэтгэлийн там гэхчлэн бодохоос байх суух боломжгүй санагдаж, хүчит далайн шуурганд салхины аясыг дагаан хөөгдөх зангуугаа алдсан өчүүхэн онгоц мэт санагдах ажээ.

Дрүү нэг ухаан сийлсэн бололтой, дэргэд нь тулан очиж мөрөн дээр нь гараа тавьж:

- За чи миний хэлэх үгийг сонс гэхэд Керри:

- Боль хэмээн зайлав.

- Харин нулимсаа байн байн арчих алчуураа нүднээсээ салгасангүй.

- Хэрүүл хийсэндээ зовох хэрэггүй. Ингээд л өнгөрөг. Ямар ч болтугай энэ сарыг шувтартал эндээ бай, тэгээд дараа нь яамаар байна, өрөө л мэд. Тэгэх үү?

Керри дуугарсангүй.

- Тэгвэл дээр байх шүү. Одоо явах гээд хэрэггүй, хаашаа чо чих билээ.

Керри бас дуугарсангүй.

- Ингэж тохирвол дахин энэ тухай ярихаа больё, би я явъя гэхэд Керри нүүрээ дарж байсан алчуураа аажмаар буулгаж цонхоор гадагш харав.

- Тэгэх үү? цахав?

Бас л хариу байдаггүй.

- Тэгэх үү? Гэж Дрүэ дахин ахсуулаа.

Керри цонхоор гөлрөн харсаар л:

- За дуугараач дээ, миний хэлснээр болох уу? гэхэд Керри араг буюу хариу хэлэх болж:

- Мэдэхгүй л байна даа гэв.

- Чи миний үгэнд орохул хоёул энэ тухай лахин ярихыг больё, тэгэх үү? Тэгвэл чамд л дээр байх.

Керри түүний үгийг сонсож ухаалаг хариу өгөхийг хичээвч ухаан нь төвлөрч өгсөнгүй. Хүн тийм эелдэгхэн зан гаргаж, өөрт нь сайн хэвээр байхад муухай юм боллоо гэж Керрийн сэтгэл шаналж, тун арчаа муутай байна.

Дрүэгийн тухайд гэвэл, хартай хүн ямар байдаг билээ, тийм л байлаа. Маллуулж байсанпаа уур нь хүрнэ, хүүхнээ алдах гэж байгаадаа гол нь гонсойно, дийлдэн ббуж өгч байгаадаа харамсана. Ёстой эх толгой нь олдохооргүй хачин юм бодож байв. Гэлээ ч гэсэн хамгийн гол нь Керрийг эзэгнэх эрхээ алдахгүйг бодох тул түүнийг явуулахгүй аргалах, өөрийнх нь буруу гэдгийг ойлгуулах хэрэгтэй байлаа.

- За тэгж тохирох уу? гэж шавдуулав.

- Би бодож байж болно гэж Керри хариулав.

Асуудлыг нэг тийш болгоогүй ч гэсэн бага зэргийн ахиц гарсан хэрэг байлаа. Бие биентэйгээ зүгээр ярьж эхэлж байгаа болохоор хэрүүл нь ингэсгээд өнгөрөх төлөвтэй. Керри ичиж, Дрүэ гонсойно. Тэгээд зарим юмаа хөвхөн хайрцганд хийх байдал үзүүлж эхлэв.

Керри түүнийг нүднийхээ булангаар сэм ажиглаж, эрүүл саруул хэдэн юм бодож эхлэв. Энэ хүн алдаа хийх нь хийсэн, гэхдээ би өөрөө яалаа? Хар амиа хичээсэн хүн гэлээ ч намайг хайрлаж сайн санаа гаргаж байсан шүү дээ. Сая ингэж хэрэлдэхдээ ч гомдмоор муу муухай үг хэлсэн ч үгүй. Харин Хертсвүд гэдэг бол энэ хүнээс ч хавьгүй их худалч хүн юм. Нэг их хайр сэтгэлтэй дурлаж, унаж өгч байгаа юм шиг байсан нь огт худал байж. Эр хүн гэдэг тун муухай юм даа. Эний нь мэдсэнгүй бас хайртай байсны минь яана. Одоо түүнтэй тэгж явахаа больдог хэрэг. Дахин уулзах ч үгүй. Захидал биээд бодож байгаагаа цөмий нь хэлнэ дээ. Тэгээд цаашдаа яах вэ? Дрүэ нэгэнт битгий яваач гээд байгаа хойно орон байранд нь байж л байя. гэсгээд хэл амаа ололцвол хуучин янзнаараа шиг байгаад байж болох нь шиг байна. Толгой хорогодох оронгүй гадаа гудамжинд гарч явснаас энд байх нь дээр гэж бодлоо.

Энэ хооронд Дрүэ шургуулганы нүднүүдээс цамцны зах, тээглүүлр мэтийг маш удаан их л шамдан эрж байж буй байдал үзүүлэв. Нэг их яарахгүй байгаа бололтой. Керрид дурладаг нь буурсангүй. Өөрөө гарч явснаар л хамаг асуудал дуусна гэдэгт итгэж чадахгүй байна. Ямар нэгт арга хэрэглэж, ямар нэг байдлаар өөрийгөө цагаатгаж, Керрид бурууг нь ойлгуулж, эв зүйгээ олоод Херствүдийг замаасаа бүрмөсөн зайлуулах хэрэгтэй гэж Дрүэ бодно. Тэр хүний ичих зовохоо мэдэхгүй хоёр нүүр гаргасны нь бодохоос их зэвүүрхэв. Дрүэ түр дуугай байснаа Керри юу хийх бодолтой байгааг нь сонирхож:

- Театрын тайзанд авьяасаа сорих бодолтой байгаа юу? гэхэд Керри:

- Энэ тухай бодсон юм алга гэв.

- Хэрэв хүсвэл би тусалж болно шүү. Тэр талаар надад олон найз нөхөд бий.

Керри энэ удаа хариу дуугарсангүй.

- Мөнгөгүйгээр эндээс явж болохгүй. Би тусалж болно шүү. Энд хүн гар хоосон явж тун болохгүй газар шүү.

Керри эргэлддэг сандал дээр урагш хойш холхисон шиг л дуугай сууна.

- Би чамайг лахин тийм хэцүү байдалд оруулахыг хүсэхгүй байна гэснээ Дрүэ дахиад л аар саар юм авч хөвхөн хайрцгандаа хийж эхлэв. Керри сандал дээр ганхсаар байна.

- Чи ер нь чухам юу болсныг надад бүгий нь ний нуулгүй ярьчихгүй юмуу, тэгвэл чи бид хоёр энэ тухай дахин ярих хэрэг алга. Ингэхэд чи Херствүдэд сэтгэлтэй болсон юм биш биз дээ? гэхэд Керри:

- Дахин ярилцахаа больё. Яагаад ийм үг гаргаж ирж байгаа юм? Чи л хамаг буруутай шүү дээ гэв.

- Би буруугүй ээ.

- Үшүй, чиний л буруу. Чи тийм хов живийг надад хэлэх ёсгүй байсан шүү дээ.

- Чи тэгэхдээ түүнтэй тийм их сүйд болоогүй юм байгаа биз дээ? гэж Дрүн үнэхээр сүйд болсон юмгүй гэсэн хариу сонсож сэтгэлээ амраах санаатай асуув.

Эвлэрлээ гэсэн чинь иймэрхүү инээдэмтэй юм болж байгаад залхаж эхэлсэн Керри:

- Надад энэ талаар ярих хүсэл алга гэв.

Дрүэ оролдож байсан юмаа ч орхиод өрөөсөн гараа, учиртайхан өргөж:

- Кэд, ингэж байхын хэрэг юу байна? Чи надад үнэнээ л хэлчих л дээ гэж шалгаав.

Керри уурлавал л хэрэг нь бүтэх юм шиг бодож:

- Хэлэхгүй. Юу ч болсон байг чамаас л болсон хэрэг гэхэд Дрүэ дүрсхийн уурлаж хийж байсан юмаа орхиод:

- Тэгвэл чи түүнд сэтгэлтэй юм шив дээ гэхэд Керри:

- За боль доо гэв.

- Аа тийм үү, би чамд маллуулахгүй. Чи тэр хүнтэйгээ яаж сээтэгнэдэгсэн өөрөө мэд, гэвч намайг маллах гэвэл дэмий. Үнэнээ надад хэлбэл хэл, байвал бай, харин би чамд адхин маллуулахгүй гэж өндөр дуугаар Дрүэ омогдоод хайрцагтаа хийх юмаа чихэж хийгээд өмөө авч

байгаа юм шиг угз татан шүүрч авав.

Тэгснээ юм хүмээ хийхэдл эвтэйхэн гэж тайлчихаад байсан гадуур цамцаа өмсөж, бээлийгээ аваад үүд рүү явав.

- Чи дуртай газраа тонилоорой. Чи намайг юу ч мэдэхгүй хүүхэд шиг бодож байна уу, тийм биш гээд үүдээ угз татан нээж гараад тасхийн савав.

Керри, доншуур худалдаачин залуугийн гэнэт тийнхүү уур шатсанд мэл гайхаж, тийм хүлцэнгүй номхон байсан хүн чинь гэнэт ийм болох гэж хэмээн итгэхгүй байв. Хүний сэтгэл санааны үнэн эх ундаргыг энэ хүүхэн яаж ойлгох билээ. Хайр сэтгэлийн жинхэнэ дөл гэдэг бол амаргүй зүйл. Тэр бол албины гал мэт сүүлмэлзэж дэгж дэрвэсээр үлгэр домгийн жаргалант ертөнцөд оччихдог зүйл. Тэр бол төмрийн дархны хөөрөгний дүрэлзэх гал л гэсэн үг. Харин хар сэрээр тэжээл болгох нь дэндүү олон буй.

ЦАХИУРЫН ГАЛЫН ҮНС, ЦОНХНОО ҮЗЭГДЭХ НҮҮР

Тэр шөнө Херствүд гэртээ харилгүй хотын төвд үлдэж ажлаа тарсан хойно “Палмер” зочид буудалд нэг өрөө хөлслөн авчээ. Авгайнх нь загнасан байдал түүний бүх ирээдүйн амьдралыг аюулд учруулах янзтай байсан тул мань хүн ухаан сийлэх гэж тархиа зүйртэл бодож байв. Авгайнх нь сүрдүүлэг чухам юунд хүргэж болохыг тодорхой төсөөлөхгүй байсан боловч тэр чигээрээ зүтгэх юм бол тэн их төвөг татахыг мэдэрч байлаа. Зориг шийдэмгий байсан бөгөөд хэрүүл хийхдээ дийлсэн нь тун явдалтай байв. Цаашаа юу болдог бол? гэж Херствүд бодол болон албан тасалгаандаа урагш хойш баахан хөлхөн, зочид буудлын өрөөнд орж ирээд ч бас баахан хөлхсөн боловч ямар ч дүгнэлт хийж чадсангүй.

Харин Херствүд авгайн хувьд гэвэл нэгэнт дийлж эхэлснийгээ ангайж сууж байгаад алдах зорилгогүй байлаа. Одоо нэгэнт нөхрийгөө үнэндээ номхтгоод авсан болохоор түүнд дуртай болзлоо тулгаж болох бөгөөд хэлсэн үг бүр нь хууль шиг болох ажээ. Одоо байн байн шаардах мөнгий нь Херствүд үг дуугүй төлж байхгүй бол хохь нь болно. Тэрний яах нь хамаагүй. Гэртээ ирнэ үү байна уу ээ талаар авгай нь огт тоохгүй байна. Ирэхгүй байлаа гэхэд гэр орных нь ажил түүний оролцоогүйгээр улам ч аятайхан байх ажээ. Авгай өөрөө хэнээр ч мэдүүлэхгүй юу дуртайгаа хийх болно. Тэгээд өмгөөлөгчтэй, бас нэг эрүүлчтэй уулзаж яаж яаж болхо тухайгаа зөвлөлдөхөөр шийджээ.

Херствүд өрөөн дотуур тасралтгүй хөлхөж, өөрийн байдлыг эргэцүүлэн, “хамаг хөрөнгөө энэ авгайн нэг дээр болгодог мөн тэнэг хэрэг шүү, даанч тэнэг, золиг шиг маанаг хэрэг болжээ” хэмээн амандаа үглэсээр байв.

Зоогийн газрын эрхлэгч хийдэг албан ажилд нь ямраар нөлөөлөх тухай ч бодлоо. “Авгай хэрүүл маргаан үүсгэх юм бол би ажил ч үгүй болно. Миний нэр сонинд муу хэлэгдэх юм бол эд нар намайг хална шүү дээ. Найз нөхөд маань яана” гэж бодов. Авгайгаасаа болэ элдвийн үг ярианд орно гэхээс мань эрийн уур бүр шатаж байлаа. Сонингуудад юу гэж бичих бол. таних мэдэх хүн бүр гайхах байх даа. хариуд нь юм хэлж худал гэж хэллээ ч гэсэн хүн бүхэн сонирхоно, хүмүүсийн хэл аманд орно. Тэр цагт Мои ноён надтай уулзаж ярилцъя гэнэ, тэгээд юу болхоыг хэн мэдэхэв хэмээн бодно.

Иймэрхүү юм бодсоор байтал духанд нь жижиг жиижигхэн атираа тогтож, магнайных нь хүйтэн хөлс гарч байлаа. Тугаар төгсөхийг атааварлах аргагүй болж яаж ч бултаж булзаараад гарах гарцгүй болсон сагадана. Ийм юм бодож байснаа гэнэт Керрийн тухай% түүнтэй ирэх хагас сайнд хэрхэх гэж хэлэлцсэн нь санаанд оржээ. өөрийнх нь ажил явдал тийнхүү хичнээн адармаатай болоод байсан ч гэсэн хүүхэнтэй ярилцаж тохиролцсон тухайгаа бодоод гонсойсонгүй. Тэр ч байтугай тэр бол энэ бүхий л сэтгэлийн там болсон бодлын дотор сэтгэлий нь зогоох ганц бодол байлаа. Нэгэнт тохиролцсон тэр асуудлаа аятайхан шийдэж болно, шаардлага гарч гэмээнэ Керри бага зэрэг хүлээхэд дургүйлэхгүй, баяртай хүлээн авах биз гэж бодно. Тэр хоёр уулздаг газраа уулзах болзоотой байлаа. Херствүдийн нүдэнд түүний хөөрхөн царай, бие цогцос тэр чигээрээ харагдах шиг болоход амьдрал яагаад ийнхүү хүн хүний жаргалыг санасан санаагаар нь болгодоггүй байна хэмээн гоморхоно. Тэгтэл авгайнх нь занал сүрдүүлэг дахин бодогдож духных нь хөлс чийхарч, нүүрэнд нь атираа сууж эхлэв.

Өглөө нь Херствүд зочид буудлаас шууд ажил дээрээ ирж бичиг захидлыг шүүрдэн үзвээс ер бишийн юм байсангүй. Урьд нь яагаад юм муу мэдээ байх болов уу гэж зовж байсан болохоор

харин одоо баярлах шиг болов. Ямар ч мэдээ байхгүй байгаа нь сайн мэдээ гэсэн үг болоод байв. Зуур замдаа хоол идмээргүй, огт дуршилгүй байсан бол одоо дуршил орж Керритэй уулзахын өмнө нэг юм иддэг хэрэг хэмээн “Грэнд Пэсифик” цайны газар орж аяга кофе, хэдэх ширхэг зөөлөн боов идэхээр явлаа. Аюул нэгэнт өнгөрөөгүй боловч биеллээ олж илрээгүй бөгөөд таг чиг байгаа нь сайхан хэрэг мэт санагдана. Бодох цаг их гарч байвал гарах зам олох бололцоо олох юу магад. Ер нь энэ явдлаас болж сүйд болоод, гарах зам олох гэж зовлонгоо эдлэх цаг ирэхгүй байх гэж ч бодлоо.

Гэвч цэцэрлэгт хүрч ирээд Керрийг хичнээн хүлээвч ирж өгсөнгүйд сэтгэлээр унаж эхэлжээ. Хүлээн суудаг дуртай газраа цаг гаруй хүлээгээд ирсэнгүйд нь Херствүд босож тэр хавиараа баахан хөлхлөө. Гэрээс гарч болохгүй юм болсон юм болов уу даа? Манай авгай арай мэдчихээд очиж буусан юм биш байгаа даа? Арай үгүй байлгүй. Дрүүг юм олж мэдээд манан хаддуулсан юм биш байгаа гэж Херствүд огтхон ч сэжиглэхгүй байлаа. Элдвийн юм бодох тусам сэтгэл нь илүү их зовж сүүлдээ, гэрээч гарч чадахгүй ямар нэг шалтгаан гарсан юм байлгүй, тэгээд ирж чадахгүй нь гэдгээ мэдэгдсэн юм бичээгүй байх нь хэмээн сэтгэлээ засаж үзлээ. Өнөөдөр тэрнийгээ мэдэгдэх байлгүй, одоо ингээд очиход захиа ирчихсэн ширээн дээр минь байх байлгүй, очоод харья гэж бодлоо.

Нэг хэсэг хүлээн байснаа болиод Мэдисоны зүг явах тэргэнд суухаар их л гонсгор алхлаа. Ядахнаа тэр өглөө цэлмэг хөх тэнгэрийн нөр хөвөн цагаан үүлээр халхлагдаад, салхи баруунаас эргэж Херствүд зоогийнхоо газар хүрч ирэхийн алдад тэр өдөржин орох маягтай нарийн шиврээ бороо зүсэрч эхлэв.

Херствүд зоогийнхоо газар ормогц захидал бичгүүдийг шүүрдвэл Керригээс юу ч алга байв. Авгайгаас нь ч зэгсэн бас алга байв. Тийм ололн юмны тухай бодож боловсруулах байтал дээрээс нь бас нэг юм гараад ирээгүйд нь Херствүд төрсөн одондоо залбирав. Өрөөн дотуураа ердийн байдлаар санаа амар алхаж үзэх гэсэн боловч үгээр ч илэрхийлэхийн аргагүй сэтгэл нь зовоод болж өгсөнгүй.

Нэг цаг хагаст “Ректор” хэмээх газар хоол идчихээд эргэж ирвэл зарлага өөрийг нь хүлээж байлаа. Херствүд тэр атигар хүүг сэжиглэсэн байдалтай харахад цаадах нь:

- Намайг хариуг нь аваад ирээрэй гэсэн юм шүү гэв.

Херствүд авгайнхаа гарын үсгийг танив. Захидлыг задлан тайван байдалтайгаар уншаад үзвэл их л албаны царайтай, эрс хүйтэн үгтэй захидал байв.

“Миний шаардах мөнгийг нэн даруй ирүүл. Тэр мөнгө чинь одоо хэрэг болоод байна. Чи гэртээ ирнэ үү байна уу өөрөө л мэд. Надад мяар ч падгүй. Харин надад мөнгө хэрэгтэй байна. Тийм учраас энэ зарлагаар хойшлуулалгүй явуул” гэсэн байв.

Херствүд захидлыг уншиж дуусаад гартаа барин нэг хэсэг зогсов. Авгайнхаа тэр хэгжүү хүйтэн загнаж буй байдлыг бодохоос зэвүү нь хүрч уушги зүрх нь амаараа гарах дөхөв. Уурандаа: “Чамайг чөтгөр шулмас алгадаг” гэсэн дөрөвхөн үгтэй хариу бичье гэж бодсон боловч биеэ барьж, яршиг ч юм уу даа гэж бодоод зарлага хүүхдэд “хариу өгөхгүй” гэв. Тэгээд сандал дээр лагхийн суугаад гөлрөн байхдаа ингэдэг маань юу ч болох бол гэж бодлоо. Юу гэх бол? Адгийн муу хог чинь. Хүнийг айлгаж сүрдүүлж байгаад сөгдүүлэх санаатай юу? Одоохондоо очиж нэгийгээ үзэж нэхийгээ тайлах юм хуна, ингэдэг л хэрэг. Яасан их дэрэнгүй, дээгүүр ааштай

этгээд вэ гэж эхэндээ боджээ.

Гэвч төдий удалгүй хаширлаж эхлэв. Хамаагүй ингэж болохгүй, аргалах хэрэгтэй. Бүр туйлдаа хүрвэл авгай лав зүгээр суух хүн биш. Нэг юм хийхээр шийдвэл тэрнээсээ ббуцах зантай хүн биш гэдгийг Херствүд мэдэх аж. Юу юугүй өмгөөлөгчид заалдаж мэдэх л хүн шүү гэж бодоод шүдээ тас зууж аяархан:

- Гайтай новшийг! Намайг ихээхэн оролдох гээд байвал би чамайг хашраагаад өгнөө гайгүй. Махы нь зулгааж байгаад ч болтугай чамайг ингэж галзуурдгий чинь болиулна даа гэж зангаад суудлаасаа босож цонхоор харвал зүс бороо орж эхэлсэн байлаа. Хүмүүс захаа босгож зарим нь өмднийхөө шуумгийг эргүүлсэн байв. Шүхэр бариагүй нэг нь гараа халаасандаа хийжээ. Шүхэртэй нэг нь түүнийгээ дэлгэсэн нь гудамж тэр аяараа хуйларч атиралдах, хүврэлдэх дээвэр мэт харагдана. Замсгал замаар том жижиг тэргүүд их дуутайгаар харжиг наржиг гэлдэн явах бөгөөд хүмүүс борооноос чадах чинээгээрээ халхлахыг хичээнэ. Херствүд энэ байдлыг ажиглахын оронд авгайтайгаа уулзаж дээрэнгүй зан гаргадгаа боль хэмээн шаардах, их цорволзвол тахий нь хага цохино гэж бодож байв.

Дөрвөн цагт бас нэг бичиг ирснийг уншвал хэрэв тэр мөнгийг энэ орой ирүүлэхгүй бол маргааш өглөө Фицжеральд, Мои хоёрт мэдэгдэнэ, мөнгөө авахын тулд өөр арга ч хэрэглэнэ гэж шууд бичсэн байв. Херствүд тийм туглнан шаардсан бичиг уншаад арай л хашгирчихсангүй. Тэгээд одоохон мөнгий нь явуулъя, өөрөө аваачиж өгье, өөртэй нь ярилцъя, одоохон явдаг хэрэг гэж шийдээд, малгайгаа өмсөж шүхрээ эрэв.

Хөлсний тэрэг дуудаж суугаад бүрзгэр бороо орсон бүрхэг тэнгэрийг дор хотын хойд хэсгийг зүглэн одлоо. Замдаа юу юу гэж хэлэх ярих тухайгаа нарийвчлан бодох тул дотор нь овоо уужирч байв. Юу сонсоо бол? Яагаа бол? Керрийг мэдчихсэн юм болов уу? аль... эсхүл... Дрүү. Хаашаа ч хөдөлгөхгүй юм мэдэж авчихаад отож байгаад баллаж орхиё гэж байгаа юм биш байгаа даа? Муухай зальтай амьтан. Юмтай болоод л хүнийг ингэж айлгах санаатай байгаа хэрэг гэж бодоод Херствүд дэмий л юм боллоо, мөнгий нь өгүүлчихдэг байж гэж зовно. Гэвч одоохон өгчих юм чинь гайгүй ч боло уу, ямар ч болтугай ороод харъя, хэрүүл хийхгүй л байх юмсан гэж бодно.

Байшиндаа хүрэхийн алдад өөрийн байдлын тун бэрхтэйг улам илүү ойлгож явал нэг арга олж энэ хэцүү байдлаас мултаръя даа хэмээн дахин дахин бодлоо. Тэрэгнээс буугаад довжооны шатаар өгсөхөд зүрх нь жигтэйхэн цохилон. Түлхүүрээ гаргаад орох гэсэн чинь дотроосоо түлхүүр хийлттэй байв. Бариулаас ь бариад түлхэж үзвэл үүд түгжээтэй. Тэгэхлээр нь хонх дарав. Чимээ алга. Дахиад хүчтэйхэн дарлаа. Хариу бас л алга. Дахин галзуу мэт хэд хэд дахин жингэнэтэл дарсан боловч бас л байдаггүй.

Довжоон дээрээс буулаа. Гал тогоо руу ордог нэг хаалга бий ажээ. Хулгайчаас хамгаалж төмөр сараалж хийсэн ажээ. Тэр үүдэн дээр очвол бас түгжээтэй гал тогооны өрөөнийх нь цонх нь хаалттай байв. Юу болж байна аа? Хонхыг дахин дараад хүлээлээ. Хаалгай тайлахаар хэн ч ирэхгүй болхоор Херствүд тэрэг рүүгээ буцлаа. Том гэгчийн брезентэн цувныхаа юүдэнд, улаан нүүрээ нуусан дэлбэгчид:

- Эд нар нэг тийшээ явсан бололтой гэж уучлалт гуйж байгаа юм шиг байдалтай хэлэхэд дэлбэгч:

- Тэр цонхоор залуухан хүүхэн харагдсан шүү гэв.

Хөрстүд тийш нь харсан боловч хүний нүүр харагдсангүй. Тэргэнд баргар царайлан суухад сэтгэл нь зовох, амрах зэрэгцэв.

Ингэж хүнээр тоглоом хийдэг хэрэг үү? Гэрт нь оруулахгүй мөртлөө мөнгө нэхэж авна гэнэ. Бурхан минь, энэнээс илүү даварна гэж яаж байж болох вэ!.

ЦАХИУРЫН ГАЛЫ ҮНС, ДӨРӨӨН СУР ТАСРАВ

Херствүд, ажилдаа буцаж ирэхдээ бүр ч их мэгдлээ. Бурхан минь, бурхан минь, юу гээч болж байна аа энэ чинь. Яагаад ийм гай ийм богино хугацаанд гэнэт дайрдаг билээ? Яагаад ийм болчихдог билээ, ер учры нь олохыг байлаа. Огт санаандгүй, зүүдлээ ч үгүй байтал ийм болчихно гэдэг үнэхээр ер бишийн, данаач балай, даанч гайтай хэрэг ээ хэмээн тэвдэн бодож байв.

Мөн үүний зэрэгцээгээр Керри гэнэ гэнэ бодогдож, тэнд бас юу болчихоо юм бол? Өглөө л уулзана гэсэн атал одоо бүр орой болчихоод байхад ирэх нь бүүү хэл ядахнаа захиа бичиг, сураг ч алга, маргааш хоёул уулзаад Хашаа очих билээ? ӨӨр бусад үйлтэй юманд самгардсаар байж энэ талаар гүйцэд ч шийдсэн юмгүй байгаага мань эр бас ойлголоо. Тийм их сэтгэлээ өгсөн хүн маань ердийн үед бол өөрийнхөө зорьсонд хүрэхийн тулд яахаас ч буцмааргүй байж болох боловч, одоо ийм болчихоод байгаа хүн яах билээ? Бас дэмий юм сонсчихсон юм бол уу? Тийм юм сонсчихоод одоо чамтай инэгж байдгаа болилоо гэвэл яана? Ер нь энэ царайгаар тийм юм болж мэдэх л байна.

Өнөөх нэхсэн мөнгий нь явуулаагүй л байлаа. Херствүд хонтоорынхоо гялгар шалан дээгүүр, гараа халаасандаа хийчихээд хөлхөнө. Духных нь арьс атирч, шүдээ тас зуужээ. Нэг ширхэг сайхан ороомол навчин тамхи татахад дотор нь ялимгүй онгойх шиг болсон боловч тэр бол түүнд нүүрлэсэн гайг арилгах бүхнийг ангаах эм биш билээ. Дотор нь бухимдаж тэсэхүүеэ бэрх болоход гэнэ гэнэ гараа тас атган хөлөөрөө шал дэвсэнэ. Хамаг зүрх сэтгэл нь донслон шаналахад хүн гэгч хэдий хэр зэргийн ийм донсолгоог дааж чаддаг юм бол гэж бодогдоно. Лав л сүүлийн хэдэн сард уугаагүй ихээр саадтой устай архи, энэ орой уужээ. Херствүдийг одоо сэтгэлийн их хямралтай хүний жишээ болгож болох байв.

Оройн туж бодоод бодоод адаг сүүлд нь өнөөх нэхсэн мөнгий нь эхнэртээ явуулахаар шийдсэнээс өөр юу ч хийж чадсангүй. Яахав ийхэв гэж хоёр гурван цагийн турш ганцаараа үймэрч тарчилсаар эцэсь нь нэг дугтуй авч мөнгөө хийгээд удаан гэгч нь наалаа. Тэгээд зоогийнхоо газрын зарлага хүү Херрийг дуудаж:

- Үүнийг энэ хаягаар аваачаад өгчих. Херствүд авгайд өөрт нь өгөөрэй гэхэд зарлага:

- За ноёнтон гэлээ.

- Өөрийг нь байхгүй бол буцаагаад аваад ирээрэй.

- За, ноёнтон

- Чи миний авгайг үзсэн үү? Таних уу? гэж Херствүд тэр жаалыг явах гэхэд нь болгоомжтойгоор асуув.

- Өө, үзсэн, ноёнтон, танина.

- За больж, явдаа, түргэхэн ирэхийг бодоорой.

- Хариу авчрах уу?

- Үгүй биз дээ.

Зарлага ч явлаа, зоогийн газрын эрхлэгч маань ч золгүй юмаа бодож эхлэв. За ингээд явуулчихлаа, одоо нэг их бодоод ч байхын хэрэггүй болжээ. Өнөөдөр бут ниргүүлсэн болохоор одоо эвлэхэрийг л бодохоос өөр замгүй болов. Ингэж ч чадуулах гэж байх уу даа. Авгай нь зарлагтай уулзаад бах тав нь ханаж зэвүү хүрмээр муухай инээж байгаа нь үзэгдэх шиг болов. Авгай нь тэр дугтуйг авахдаа л дийлснээ мэднэ. Болдогсон бол тэр захидлаа эргүүлж аваад өгөхгүй байхсан. Херствүдийн амьсгаа давчдаж, нүүрнийхээ хүйтэн хөлсийг арчлаа.

Херствүд сэтгэлээ жаахан ч гэсэн амраах санаатай босож архи дарс уугаад зогсож байгаа хэдэн нөхөд дээрээ очлоо. Тэгээд тэр хавийн юмсыг сонирхож мартагнах гэсэн нь огт болж өгөхгүй гэр орныхон нь бодогдож тэнд юу болж байгаа бол гэсэн бодол толгойноос нь огт салж өгсөнгүй. Зарлагаас дугтуйтай мөнгийг аваад авгай юу гэх бол гэдгийг л Херствүд бодоод байв.

Цаг дөичн таван минут хэртэй болсон хойно зарлага хүрч илрээ. Орж ирмэгцээ халаасаа ухахгүй байгааг нь харвал дугдуйтай мөнгөө өгчсөн бололтой.

- За яав? Гэж Херствүд асуулаа.

- Би өөрт нь өгсөн шүү ноёнтон.

- Авгайд уу?

- Тиймээ , ноёнтоон.

- Хариу өгөв үү?

- “Цаг нь болсон байхаа” гэж байна лээ.

Херствүд ууртайгаар хөмсөг зангидав.

Энэ орой өөр юу ч хийж амжихаас нэгэнт өнгөрчээ. Шөнө дунд хүртэл одоо яадаг билээ хэмээн өөрийнхөө байдлыг элдвээр бодсоор сүүлд нь өчигдөр оройнх шигээ нөгөө “Пальмер Хайус” гэдэг зочид буудал руугаа явав. Өглөө болоход бас юу болох бол гэж нойр нь хулжаад тун ч муу унтав.

Дараа өглөө албан хонтоортоо орж шуудан бичиг сачгийг айх, горьдох хоёрыг зэрэгцүүлэн шүүж эхлэв. Керрийгээс ч сураггүй, харин авгайгаас нь юм алга байсанд мань эр гэсэн их баярлав. Нэхсэн мөнгий нь явуулчихсан, авгай тэр мөнгийг авсан гэж бодоод сэтгэл нь овоо уужирч нэгэнт ирнгэсэн хойно уур нь бага зэрэг тайтгарч харин ч эв найрамдал сэргэж болох найдвар төрж эхэлсэн байна. Ширээнийхээ ард суугаад бодож эхлэхдээ лав л ойрын нэг хоёр долоо хоногтоо юм болохгүй байх, тэгвэл тэр хооронд бас нэлээд ухаан сийлж амжих цаг гарахсан гэж горьдлоо.

Ухаан сийлж эхлэхдээ Керрийг бодож Дрүэгээс түүнийг салгаж аваад яах тухайгаа бодов. Одоо яах билээ? Энэ тухай бодоод эхэлмэгц Керри яагаад уулзах ч үгүй, захидал бичих ч үгүй байна вэ хэмээн эрэгцүүлэн бодоход зүрх нь шимширч эхэлдэг байна. Тэгээд Баруун хорооллын шуудангаар өөрөө авах захидал бичиж яагаад ирж уулзсангүй вэ гэдгий нь лавлаж уулзахаар

шийдэв. Энэ захидал нь даваа гаригаас нааш хүрэхгүй болж таарах учраас урам нь хугарч түргэхэн хүргэх арга болох ёстой байв. Гэвч ямар тийм арга байх билээ? Хүн зардаг юм бил үү, аль эсхүл өөрөө тэргээр очдог юм бил үү гэж боловч мэдэгдчих байх гэж бодлоо. Ингэж бодсоор лав хагас цаг өнгөрлөө. Ингэж цагаа дэмий барж байснаас гээд шууд захидал биччихээд дахин бодол болов.

Цаг өнгөрсөөр, хүсэл мөрөөдөл болсон Керритэйгээ уулзах найдвар нь ч замхарсаар байлаа. Урьдын болзсоноор бол яг энэ үе түүнтэйгээ баяртайгаар золгож байх ёстой байсан атал үл өнгөрчихөөд байхад юу ч болсон юмгүй. Гурван цаг боллоо. Дөрөв, тав, уургаан цаг ч боллоо. Чиг үгүй, чимээ ч үгүй. Аргаа барсан эрхлэгч маань өрөөн дотуураа хөлхөж ингэж муугаа үзэж байгаага бодохоос нол нь харлана. Хөл ихтэй бямба гариг дуусаж оройн мөргөлийн цаг болж байхад түүнд хийж амжсан юм юу ч алга. Ням гаригт зоргийн газар нь хаалттай, өөрөө гэртээ орох эрхгүй, зоогийн газрын хөл үймээнгүй, Керритэй уулзаж чадахгүй тийнхүү өдөржин ганцаар өөдгүй олон гунигт юм бодон суух болжээ. Тэр бол насандаа үзээгүй хамгийн муу өдөр байлаа.

Даваа гаригийн хоёр дахь удаагийн шуудангаар харахаас албаны царайтай нэг захидал ирснийг Херствүд сонирхон уншвал “Макгрегор Жеймс, Хейн” шүүхийн тамга тэмдэгтэй бөгөөд доторхи үг нь “Эрхэм ноёнтон”, “Бид хичээнгүйлэн хүсэх байна” гэх мэт ёсорхог агаад хатагтай Жулиа Херствүд өөрийн тэтгэмж болон хөрөнгийн эрхийн талаар бидэнд заалдсан тул эрхэм таны бие нэн даруй бидэнтэй ирж уулзвас баярлха байна гэж мэдэгдсэн байлаа. Херствүд уг захидлыг хэд дахин анхааралтай уншаад толгойгоо л сэгсрэв. Гэр бүлийн хямрал сая л эхэлж буй мэт санагджээ.

“Үгүй ер мөн хачин юмдаа, мэдэх юм алга” гэж Херствүд ганцаараа яриад захидлыг эвхэн халаасандаа хийв.

Ядахнаа Керригээс сураг тасарчээ. Эхнэртэй гэдгий маань мэдчихээд хуурамч муу санаа гаргалаа гэж муудсан гэж лавтай бодов. Чухам ийм үед л Керри түүнд хамгийн их хэрэгтэй байсан атал түүнийгээ алдана гэдэг бүр ч гашуудалтай ажээ. Одоохон л захидал ирэхгүй бол өөрөө явж очоод уулзъя гэж шалгаадаг ч юм бил үү гэж бодлоо. Түүнд хаягдлаа гэж бодохоос гол нь ёстой харлана. Үнэн зүрхнээсээ дурлан хайрлаж байсан хүнээ алдана гэхээс цаадах нь улам ч үзэсгэлэн гоо санагдах аж. Керригээс ядахнаа ганц үг сонсохсон гэж хүсэх бөгөөд дүрийг нь ухаан бодолдоо ургуулан санахыг оролдл. Өөрөө ямар ч юм бодог хамаагүй би л адлдахгүйг хичээх хэрэгтэй. Юу л болвол болог энэ ажлыг нэн даруй нэг тийш болгодог хэрэг гэж шийдэж байв. Өөртэй нь очиж уулзаад гэр орныхоо хамаг хярмралыг нэгд нэгэнгүй ярья, ямар байдалтай болчихоод байгаага хэлье, өөрийнх нь хайр сэтгэл надад одоо хичнээн их хэрэгтэй байгааг хэлье. Ингэхэд яалаа гэж бүр цаашаа харчихав, арай ч үгүй байлгүй, ууры нь гарч уужиртал нь, уучлах сэтгэл төртөл нь гуйгаад байдаг хэрэг гэж шийдлээ. Гэтэл өөр нэг юм гэнэт бодогдон “Тэндээ байхгүй, тэндээсээ яваад өгсөн байвал яана” гээд босон харайлаа. Тийм их юм бодоод зүгээр тайван сууж чадахыг больсон байв. Гэсэн ч босон харайлаа гээд тус болсонгүй.

Мягмар гаригт мөн бахь байдгаараа байсан бөгөөд Керритэй очиж уулзахаар биеэ хүчлэн явсан боловч Огдайн талбайд хүрэхийн алдад хүн дагаад байх шиг санагдсан тул очих газраа хүрэлгүй замаас буцав.

Гэлээ ч ингэж явсан нь зүгээр ч өнгөрсөнгүй. Бцуаад явахдаа Рэндольф гудамжны морин вагонд сууж хүний нүднээс далдуур явлаа гэсэн чинь хүүгийнхээ ажилладаг пүүсний бараг эгц өмнүүр

гардаг байна. Тэгэхэд зүрх нь жигтэйхэн цохилжээ. Урьд нь хүү дээр ирж хэдэн ч удаа уулзаж байсан ажээ. Гэтэл одоо өдий болохоод хүү нь ганц ч үгтэй захидал бичсэнгүй, аавыгаа алга гэж үгүүлж байгаа хүүхэд алга. Хувь заяа гэдэг хүнээр мөн хачин тоглодог юм байна даа. Херствүд ажил дээрээ эргэж ирээд нөхдийнхөө дэмий ярианд оролцож үзлээ, ингэхэд сэтгэлийнх нь зовлон бага ч гэсэн намдаж буй мэт санагдав. Тэр орой мөн “Ректор” гуанзанд хоол идчихээд бушуухан зоогийнхоо газар ирэв. Энэ газрынх нь хөл үймээн шуугиан л түүний сэтгэлийг зовлонг мартагнуулах шиг болдог ажээ. Херствүд аар саар олон жижиг юм хийж хүн болгонтой алмайдуухан байдалтай ярьж байлаа. Хүмүүсийг бүгд явснаас хойш ганцаараа ширээнийхээ ард суусан хэвээр байж гагцхүү шөнийн манаач гадна үүд сайтар түгжээтэй эсэхийг түлхэн шалгаж үзэж байхад л сая явлаа.

Лхагва гаригийн өглөө “Мак”Грегор, Жеймс, Хейн” газраас бас нэг нялуун үгтэй бичиг ирснийг Херствүд хүлээн авав. Уг бичгийн үгийг сийрүүлбэл:

“Эрхэм хүндэт ноён! Жулиа Херствүд хатагтай танаас гэр бүл цуцлан тэтгэврээ тогтоох тухай заалдсан явдлыг шүүхэд шилжүүлэх асуудлыг бид маргаашийн пүрэв гаригийн өдрийн нэг цаг хүртэл хүлээх болов. Хэрэв таны бие тэр хүртэл хариу өгөхгүй бол бид таныг тохиролцох талаар огт хүсэлгүй байгаа юм хэмээн үзэж уг асуудлыг зохих ёсоор явуулахыг танд хичээнгүйлэн мэдэгдэж энэхүү бичгийг хүргүүлэв” гэхчилэн өгүүлээд ёсолжээ.

“Тохиролцох, тохиролцох” гэнэ шүү! гэж Херствүд цөхөрсөн янзтай дуу алдав. Тэгээд дахин толгой сэгсэрлээ. Одоо юм бүхэн тодорхой болж цаашид юу болохыг Херствүд мэджээ. Очиж тэдэнтэй уулзахгүй бол тэд шүүхэд хэргийг шилжүүлж орхино. Очих юм бол сонсохоос уур хүмээр олон балай болзол тулгаж эхэлнэ. Нөгөө захидлаа эвхэж түрүүчийнхтэй хамт нэг дор хийв. Тэгээд малгайгаа өмсөж гадуур салхинд жаахан байхаар шийдэв.

ХУВЬ ТАВИЛАНГИЙН ЭЛЧ УНАЛАА. ГАРАХ ҮҮД ХАЙВ.

Дрүэг явсан хойно ганцаараа үлдсэн Керри түний хөлийн чимээ холдохыг чагнан юу болж байгааг ч олигтой төсөөлхгүй байлаа. Лав л уур нь ихэд шатсаныг сайн мэдэж байв. Нэлээд хугацаа өнгөрсөн хойно Керри, Дрүэг эргэж ирэх эсэхий нь одоохондоо биш ч гэсэн, ер нь ирэх бол уу гэж бодох болов. Үдшийн харанхуй нөмөрч эхэлсэн өрөөнүүдээ нүд хэсүүчлэн харвал түүнд урьд урьдынхаас огт өөр юм бодогдов. Тэгснээ тольтой шүүгээнээсээ чүдэнз авч зураад хийн дэнлүүгээ асааж, эргэлддэг сандал дээр суугаад элдвийг бодож эхэллээ.

Керри нэлээд цаг өнгөрсөн хойно буй болсон байдлыг үнэнээр нь ойлгож авав, юу гэвэл ганцаараа үлдсэнээ мэдлээ. Дрүэ эргэж ирэхгүй бол яана? Ингээд бүр сураггүй алга болбол яана? Тэгвэл ийм сайхан байранд суудаг хөг өнгөрөх нь тэр. Эндээс явахаас өөр замгүй болно.

Керри бол Херствүдтэй танилцаад түүнээм ямар ч тусдэмжлэг авч байгаагүйг нь энд өгүүлэх нь зүйтэй билээ. Түүний тухай бодохоос зүрх нь шимширч харамсаж байв. Үнэнийг хэлэхэд Керри тэр хүний худалч хуурамч, заль мэх гаргаж байсны нь бодохоос туйлын их зэвүүцэн гайхаж байлаа. Тэр хүн бол хүнийг яаж ч чадчихаасаа сийхгүй этгээд юм. Түүнээс болж одоогийнхоосоо долоон дор байдалд орж ч болох л байж. Гэлээ ч гэсэн Керри тэр хүнийг оргүй мартаж, түр байдал, зан араншинг нь бодохгүй байж эс чадна. Тэгж худал хэлсэн нь л даанч хачин, даанч муухай санагдана. Тэр чанар нь Керрийн сэтгэл зүрхээрээ мэдэрч, ухаанаараа төсөөлж байсан тай нь даанч өдөр шөнө шиг харш болжээ.

Керри тийнхүү цорын ганцаар үлдэж энэ тухайгаа юм юмнаас млүү бодох болов. Одоо яах билээ? дахин ажил хайхад хүрэх хэрэг үү? Хотын худалдаа үйлдвэрийн газруудын үүд хаалгыг сахих хэрэг үү? Харин театрт орьё гэвэл яах бол? Дрүэ энэ тухай хэлж байсан. Ер нь энэ талаар ямар нэгэн горьдлого байна уу үгүй юу гэх мэтээр Керри элдвийн юм бодож эргэлддэг сандал дээрээ эргэлдсээр байтал цаг ч явж шөнийн харанхуй болов. Юу ч идэж уулгүй тэндээ сууж есөн шидийн юм бодсоор байлаа.

Тэгж байтал гол нь харлан өлсөж буйгаа мэдээд арын өрөө рүүгээ орвол өглөө тэр хоёрын идэж байсан хоолны жаахан үлдэгдэл шүүгээнд байв. Түүнийг харахад хачин сонин юм бологдхоын хамт идэж уух юм одоо юм юмнаас илүү чухал санагдав.

Керри ууж идэж сууснаа ер нь ингэхэд хэдий мөнгөтэй байгаагаа мэдсээр санагдан босож очоод гоёлынхоо ширээн дээр тавиастай байсан цүнхээ нээж үзвэл долоохон доллар хэдэн задгай мөнгө л байлаа. Тийм жаахан мөнгөтэйгээ бодохоос зүрх нь өвдөж эхлэв. Харин орон сууцныхаа хөлсийг сар дуустал төлчихсөнөө бодоод баярлав. Бас уурандаа болоод аль түрүүний гараад явчсан бол юу болох байсан бол тэгсэн бол бүр ч балрах байж, одоо ингээд байгаа маань яамай гэж бодов. Одоо бол ядахнаа нэлээд цаг хугацаа хожиж болох байна, ингэж байтал юм бүхэн гайгүй болох ч юм билүү, хэн мэдэхэв гэж бодож байв.

Харин Дрүэ яваад өгсөн, энэ юу болох вэ? Үнэн голоосоо уурлаагүй байх. Сүр л үзүүлсэн болов уу. Тэгэхлээр буцаад ирнэ байх, ихж таарах бол уу? Тэр буланд таяг нь байна, энд бас нэг зах нь байна, шүүгээн дотор хавах намрынх нь нэг пальто байгаа. Керри ийш тийш харж бас түүний өөр олон юм байгааг бодож, заавал ч эргэж ирэх юм гэж итгэхийг хичээсэн мөртлөө бас өөр нэг юм бодогдож айх шиг болов. Эргээд ирлээ гэж бодъё. Тэгвэл яах вэ? Ингэж бодохоос бас нэг айхтар асуудал гараад ирэх шиг болов. Түүнд тайлбарлаж тоочих болно, түүнийхийг зөв гэж хэлэх

хэрэгтэй болно. Түүнтэй хамт нэг дор суур яриа байж болохгүй ажээ.

Баасан гаригт Керри, Херствүдтэй уулзах болзоотой байсан, тэр цаг нь өнгөрснийг санаж, тэр цагт заавал очно гэж хичнээн амласан боловч, яг тэр үеэр ямар гай тохиолдсоноо тов тодорхой мэдэрлээ. Сэтгэл санаа нь ихэд хямрах тул ямар ч болтугай зүгээр сууж болохгүй гэж бодоод хүрэн өнгийн борогдуу бошинзоо өмсөж арван нэгэн цагт хотын худалдаа үйлдвэрийн төвөөр яадаг ч бай ажил эрэхээр гарчээ.

Арван аоёр цагийн алдад орох янзтай байсан бороо нэг цаг гэхэд асгаж эхэлсэн тул Керри арга буюу гэрийн зүг эргэж хүлээн суухаас өөр замгүй болсон байхад Херствүд мөн тэр үеэр сэтгэл санаагаар унаж тэр гайтай өдрийн хагасыг барж ядаж байжээ.

Маргааш нь бямба гариг тул үйлдвэр худалдааны олон газар хагас ажиллана. Урьд шөнийн орсон борооны улмаас агаарт чийг ханхлан, гудамжны мод, зүлэг новногооноор гялалзан, нарны гэрэл гийсэн цэлмэг сайхан өдөр байлаа. Керрийг гэрээс гарахад зэрэг зэрэг баясгалантайгаар жиргэх болжморуудын дуу угтлаа. Сайхан цэцэрлэгийн дундуур ороод явж байхдаа Керри амьдрал гэгч зовлонгүй хүмүүст үнэхээр золтой зүйл юм даа, ийм аятайхан амьдралаас минь үл хагацаах ямар нэг юм тохиолдоосой хэмээн байн байн бодож явна. Керри, Дрүү болон түүний мөнгийг ч, Херствүдтэй уулзахыг ч хүссэнгүй, гагцхүү сэтгэлийн зовлонгүй амах жимэр байхыг хүсэх бөгөөд саяхан хүртэл тийм л байсан, ямар ч болтугай одоо ингээд ганцаардан байгааг бодвол хавьгүй их аз уаргалтай байжээ хэмээн бодно.

Хотын үйлдвэр худалдааны төв ороход нэгэнт арван нэг цаг болчихоод ажил тарах ойртоод байв. Керри тэнд очоод урьд энэ газраар явж үйлээ үзэж явснаа санаж сэтгэл хямарсан тул ажил мөд дуусах гэж байгааг эхэндээ мэдсэн ч үгүй. Тэгээд алгуур аажим алхахдаа ямар нэг ажил хийх нь хэрэгтэй, гэхдээ нэг их яарах шаардлагагүй гэж биеэ хуурч байлаа. Ажил олох бэрхтэй байсан боловч бас хэдэн хоногтоо ажилгүй байсан бололцоотой байв. Түүнээс гадна дахин урьдынхаа адил махаа идэж маягаа хэмлэх юм гэж Керри бас ч бодохгүй байлаа. Ямар ч болтугай хүний нүдэнд ч гэсэн арай өөрөөр харагдах хувцас хунартай болжээ. Биеэ авч яваа байдал нь ч огт өөр. Аятайхан хувцастай байгаа болохоор эрчүүл, сайхан хувцастай эрчүүл урьд нэг нүдээр тоож хардаггүй байсан бол одоо гял цал оргисон сүрлэг маягтай хориг саадуудынхаа цаанаас мишээн угтаж, нүдэнд нь бүлээн өнгө тусах болов. Ингэх нь Керрид урмыг буй болгох боловч лавтай итгэлийг хаанаас төрүүлэх билээ. Керри өөрийн санаанд таарч тохирсон ажлаа хийнэ, харин хүний арганд орж ивгээлээр нь амь зуухгүй гэж бодно. Ариун цагаан хөдөлмөрөөрөө л амь зууна гэж бодно.

Орж ажил сураглая гээд үүдэн дээр нь очиход “Дэргүүр бмяба гаригт нэг цаг хүртэл ажиллана” гэсэн сайхан зарлалтай байв. нэгэнт ийм ол яая гэхэв гэж бодоод бас хэд хэдэн газар очвол бүгд тийм цагийн хуваарьтай бөгөөд цаг харвал арван хосроос арван таван минут өнгөрч байсан болохоор одоо орж ажил сурагласны хэрэг өнөөдөртөө үгүй юм байна гэж Керри шийдээд морин вагонд сууж Линкольны цэцэрлэгт хүрээлэнд очихоор явав. Тэнд нүд хужирлах юм хэзээд байдаг цэцэг ногоо, зэрлэг ан амьтан, нуур цөөрөм. Керри тэр бүхнийг ахин үзэж бага зэрэг сэргээд даваа гаригийн өглөө эрт босож ажил хайна гэж шийдлээ. Гэтэл ням гаригаас даваа гариг хүртэл юу ч болж мэдэх билээ.

Тэр ням гаригийг Керри бас эргэлзэх, зовох найдах, нэг горь таслах байдалтайгаар өнгөрүүлэв. Хагас цаг тутамд шахуу одоо л нэг юм бодохгүй бол горьгүй шүү гэсэн юм бодогдхо нь суран ташуураар хорстол ороолгохтой нэгэн адил мэт санагдана. Заримдаа өөрийхөө байдлыг нэг их

яадгаа алдтал болохоо байсан биш, тэгсгээд арга нь олдох байлгүй гэж бодож байв. Тийм үедээ Дрүүгийн хэлж байсныг санаж театрын тайзан дээр амжилт олох юу магад гэж бодно. Тэгээд энэ талаар л ажил хайж үзье гэж шийдэв.

Даваа гаригийн өглөө Керри эртхэн босож хувцас хунаараа хичээнгшилэн тааруулж өмсөв. Тайзан дээр авьяасаа сорихын тулд хаана очих нь зүйтэй болохыг Керри огт мэдэхгүй байсан тул ямар ч гэсэн нэг театраар орёе гэж бодлоо. Нэг театрт ороод дарга нь хаана байдгийг мэдэж аваа ажил сураглах нь зүйтэй юм шиг санагджээ. Орон тоо байвал авах биз, байхгүй бол хаана очихыг хэлж өгөх байлгүй гэж бодов.

Керри, театрынхны талаар юу ч мэдэхгүй учир олонд нэлээд алдаршиж байсан дарга нь Хендерсон гэж олны ам сайтай хүн байжээ. Керри тэр театрт хоёр гурван удаа сайхан жүжиг үзсэн бөгөөд өөр бусад сайн жүжиг тоглодгий нь сонсжээ. Хендерсон гэдэг нь ямар хүн юм бол, түүнтэй уулзлаа гэхэд юу гэж хэлэх билээ гэж бодож байгаад уулзсан цагтаа эрхбиш хэлэх үг олдох болов уу гэж бодлоо. Тэгээд тийшээ явлаа. Хаалгаар нь овоо зоригтой ороод цааш ханан дэр нь тэр театрт тоглосон жүжигчдийн холбогдолтой зураг ярайтал байрлуулсан хээнцэр гоёмсог, алт мөнгөн хээ угалзтай жааз гялалзсан тэр хөлний өрөөнөөс цааш билет зардаг хөл үймээнгүй касс руу алхах гэтэл гэнэт зориг нь мохож ганц ч алхаж чадсангүй. Тэр дооо хоногт оперын алдартай хошин жүжиг ч тоглож байсан тул театрын доторхи сүрлэг жавхлант байдал Керрид хачин аймаар санагджээ. Ийм сүрхий газар над мэтийн хүнд таарах юу байв гэж дээ хэмээн Керри сүрджээ. Анх тэгж зориг граргаж байснаа бодохоос давхийн цочих шиг болов. Тэр сүрхий зурагнуудыг жаахан харж зогсож байснаа бушуухан гарч одов. Ингэснийгээ аюулаас зэгсэн эсэн мэнд мултарлаа гэж боджээ. Ер нь энэ талаар ажил олж хийх гэж оролдох шиг шал тэнэг юм үгүй мэт санагдана.

Тэр өдрийг Керри иймэрхүү байдлаар л барлаа. Тэндээс гараад бас хэд хэдэн театрын хавиар очсон боловч дотор нь оролгүй гагцхүү гадна талаас нь ажиглав. Хамгийн том нь гэвэл Мак Викерын театр, Оперын том театр хоёр л байлаа. Энэ хоёр театр тэр үедээ хамгийн их алдартай нь байлаа. Керри дахин сэтгэлээр ихэд унаж эхлэв. Нэгэнт зиндаан нь хүрэхгүй тэр нийгэмлэгийн сайн сайхныг хичнээн ч мөрөөдөөд нэмэргүй болохыг бодох тусам Керрийн зүрх шаналж байв.

Орой нь Хейл авгай орж ирээд баахан юм донгоссон болохоор Керри тэр өдөр тохиолдсон хувь тавиландаа гомдоллож олигтой бодож ч чадсангүй. Харин орондоо орохын өмнө баахан муу муухай юм бодогджээ. Дрүү ч ирсэнгүй, Херствүд тэр хоёрын алинаас нь ч сураг гарсангүй. Үлдсэн хэдхэн доллараасаа нэгий нь хоол унд, унаанд зарчихсан байлаа. Ажил олдохгүй иймэрхүү байдал удаан үргэлжилж чадахгүй нь мэдээж.

Оргосноосоо хойш ганц уулзалдаагүй эгчийнхээ суудаг Ван-Бьюрен гудамж, одоо хэзээд ч буцаж очихгүй Колумб хотоо ч өөрийн эрхгүй нэхэн санав. Гэхдээ тэнд толгой хоргодохыг огтхон ч бодсонгүй. Херствүдийн тухай байн байн бодох боловч санах бүр элэг нь эмтрэх шиг болно, тэгж муухай хуурч мэхэлж байсан хойно арга байж уу.

Мягмар гариг болоход бас л бахь байдгаараа шийдсэн ядсан, бөөн бодол болсон байдал Керрийг орхисонгүй. Урьд өдрийнхөө бүтэлгүй явдлаас болоод одоо ажлыг тийм их шамдан хайхгүй байлаа. Гэвч биеэ дэндүү хулчгар амьтан гэж зэмлээд сүүлдээ Чикагогийн театрт дахин нэг очиж үзэхээр шийдээд гарав. Зүрх алдаж байсан боловч очиж ороод билет зардаг газар нь ойртоход билет зардаг аятайхан хувцасласан хүн Керрийг шохоорхон:

- Уран сайхны удирдаачтай юу, театрын даргатай юу, алинтай нь уулзах гэсэн юм? гэж асуухад давхийн цочих шиг болж:

- Хэнтэй нь ч уулзахаас мэдэхгүй байна шүү гэлээ. Нөгөө залуу:

- Театрын дарга хотоос гадагш явсан, та өнөөдөртөө түүнтэй уулзаж чадахгүй гээд Керрийн зовж байгааг ажиглан, - Та ямар хэргээр явж байгаа юм бэ? гэж асуулаа.

- Би нэг ажилд л орох санаатай яваа хүн.

- Тэгвэл та уран сайхны удирдаачтай уулзсан нь дээр байх, харин тэр хүн одоогоор энд алга байна гэхэд нь Керри дотор амрах шиг болж:

- Хэдийд ирэх юм бол? гэж асуув.

- Арван нэг, арван хоёр цагийн хооронд уулзаж болно доо. Заримдаа хоёр цагаас хойш ирдэг юм шүү.

Керри баярлалаа гэж хэлээд бушуухан гарч одоход нөгөө залуу тэр алтадмал савны хажуугийн нэг цонхоор араас нь ажиглан харж “царайлаг хүүхэн” гэж дотроо бодоод түүнтэй тийнхүү аятайхан ярилцсанаас нэхэн санаад баярлаж байв.

Оперын Их театрт тэр үедээ их алдаршиж байсан алиа хошин жүжгийнхэн ирж тоглож байжээ. Керри уран сайхны удирдаачтай нь уулзъя гэв. Тэр даргын эрх мэдэл ун бага бөгөөд жүжигчдийн дотроос орон онгойлоо гэхэд Нью-Йоркаас нэн даруй орны нь хүн ирэх учиртайг Керри хэрхэн мэдэх билээ.

- Өрөө нь дээд давхарт байдаг юм гэж кассны хүн хэлж өгөв.

Даргын өрөөнд хэдэн хүн байсны хоёр нь цонх налсхийн зогсоно. Нэг нь бичгийн ширээний ард суух хүнтэй ярилцана. Тэр суугаа дарга нь юмсанж. Керри орж очоод төдий хүн байхад нь айдас нь хүрч эхлэв. Ялангуяа цонхны дэргэд зогсох хоёр жүжигчин өөрийг нь сүрхий ажиж эхэлсэн болохоор ийм олон хүний өмнө ажил эрж байгаагаа хэлэх дээр хүрэх нь гэж бодохоос бүр балмагдаж байв.

- Би яана гэх вэ. Тайзны араар гадны хүн оруулж болохгүй гэсэн хатуу дүрмийг ноён Фроман нэгэнт тогтоосон болохоор хэрхэвч болохгүй, үгүй, үгүй гэж тэр дарга ярьж байв.

Керри эмээн зогсож байлаа. Тэр өрөөнд хэд хэдэн сандал байх боловч хэн нь ч суу гэж хэлсэнгүй. Даргатай ярилцаж байсан хүн их л урамгүйгээр гарч одов. Тэр эрхэм дарга ширээн дээрээ байгаа уаас бичгийг тэрнээс чухал юм гэж байхгүй гэсэн янзтайгаар их л анхааран уншиж эхлэв.

- Өнөөдөл “Херальд” сонинд Нэт Гүдвиний тухай бичсэнийг та уншсан уу Хэррис? Гэж зогсож байгаа хоёрын нэг нь асуухад, нөгөө нь:

- Үгүй шүү, юу байсан юм бол? гэв.

- Өчигдөр орой Хүүли театрт сүрхий үг хэлсэн байдаг, өөрөө уншаарай.

Хэррис, ширээн дээрх сонингоос Херальдын тэр дугаарыг эрж эхлэв.

Дарга, Керрийг сая л олж харсан бололтой:

- Ямар хэргээр явна? Гэж асуулаа. Илүү билет байна уу гэж л яваа хүн байх гэж боджээ.

Керри тэртэй тэргүй бага үлдсэн хамаг зоригоо шавхан дайчлав. Театрт урьд өмнө нь ажиллаж байгаа болохоор авахгүй гэж лав хэлнэ гэж бодоод ажилд орох санаатай гэснээс зөвлөлгөөн авах гэсэн юм гэж хэлэхээр шийдэв.

- Тайзны урлагт ороход юу хэрэгтэй байдаг бол та надад хэлж өгөхгүй юу гэж Керри асуулаа. Энэ бол уг асуудлыг ярилцах хамгийн зүйтэй арга байв. Ширээний ард залран суусан тэр эрхэм Керрийн энэ үгийг сонсоод нэлээд сонирхож ер нь ийм эгэл асуудал тавьж байгаа байдал нь таатай санагдсан тул жуумалзав. Нөгөө хоёр нь ч гэсэн шоолох байдлаа нуусхийн бас жуумалзав. Удирдаач Керрийг мэл ширтэн харж:

- Юу ч гэж хэлэтэй юм дээ, мэдэхгүй байна, харин та урьд нь тайзан дээр тоглож байсан туршлага байна уу? гэлээ.

- Шалихгүй ээ. Сайн дурын уран сайханчдын тоглолтонд л оролцож байсан хэмээн тэр хүний сонирхож эхэлснийг алдагдуулахгүйн тулд хариулав.

Уран сайхны удирдаач, Керри болон нөгөө хоёр хүндээ зохих ёсны сэтгэгдэл төрүүлэх санаатай ихэмсэг байдал гаргаж:

- Та ер нь театрын урлаг судалж байсан удаатай юу? гэж асуулаа.

- Үгүй шүү, ноёнтон.

- Хм! Тэгвэл надад хэлж мэдэх юм алга даа. Та тайзны ажлыг юунд нь сонирхоо вэ? гээд тэр хүн сандлаа гэдрэг налах бөгөөд Керри өмнө нь зогссоор байлаа.

Керри, тэр хүний ширтэн харахад бага зэрэг зовох боловч нааштай байгааг нь бодоод инээвхийлэв. Тэгээд:

- Амь зуух хэрэгтэй байна шүү дээ гэв.

- Өө, тийм бий. Зүйтэй л хэрэг байна. Гэхдээ иймэрхүү юмаар амь зуух хүсэлтэй байгаа хүнд Чикаго таарамж муутай, Нью-Йоркт л их боломж бий. Энд найдвар муутай л байх шүү гэж тэр хүн Керрийн царайлаг байдалд татагдан эелдэг зан байдал зэргий нь бодоод дотнохон танилцахыг горьдон хэллээ.

Керри, тэр хүн өөртэй нь ийнхүү ярилцан соёрхож зөвлөж байгаад нь талархан инээмсэглэв. Инээхий нь тэр хүн хараад арай өөрөөр ойлгож эвтэйхэн шиг маасганаж болмоор санагджээ. Тэгээд нөгөө хоёртоо дуулдахааргүйгээр “суу” гэж дэргэдэх сандлаа гараар дөхүүлэхэд цаад хоёр нь нүд ирмэлцэв.

Нэг нь юу юугүй,

- Би явлаа, үдээс хойш уулзъя, Барни гэхэд удирдаач:

- За тэгье гэлээ.

Нөгөө нэг нь сонин барьж аваад уншиж байгаа дүр үзүүлэв.

- Та өөрөө ямар юманд нь тоглоё гэж бодож байна? гэж удирдааё зөөлхнөөр асуухад Керри:

- Бодсон юм алга, гэхдээ эхлээд вунд нь ч яах вэ гэж бодож байна гэв.

- За тийм байдаг байж. Өөрөө энэ хотод суудаг уу?

- Тийм ээ ноёнтоон

Удирдаач малилзан инээмсэглэн,

- Та урьд дагалдан тоглогч болж үзээгүй юу? гэж дотночлох маягтайгаар асуув.

Керри, тэр хүний нялуун шалиг занг гадарлаж эхлэв. Тэгээд:

- Үгүй ээ гэв.

- Хүүхнүүд голцуу л тийм юмнаас эхэлдэг юм. Тайзны урлагт дасгал болох тун сайн арга юм шүү гээд Керрийг найрсаг ятгах байдалтайгаар харлаа.

- Би мэдэхгүй явжээ.

- Хэцүү нь ч хэцүү л дээ. Гэвч аз таарвал болдог тал бий гэж хэлснээ тэр хүн гэнэт мартсанаа санах шиг болж цагаа гарагж ирэн харснаа – Би хоёр цагт уулзаантай, тэгэхлээр одоо үдийнхээ хоолыг идэх хэрэгтэй байна. Та надтай хамт явж хоолонд орохгүй юу? Тэнд яриагаа үргэлжлүүлж болно шүү дээ гэв.

Тэр хүний увайгүй занг нэгмөсөн мэдсэн Керри:

- Өө, үгүй ээ, үгүй, би өөрөө бас хар тай уулзах ажилтай гэлээ.

Дэндүү түргэдлээ, одоо ч эргэж ирэхгүй яваад өгөх биз гэж бодсон удирдаач:

- Тун базаахгүй хэрэг байна даа. Сүүлд ирээрэй, би сураглаад юм олохыг бодъё гэлээ.

- Танд баярлалаа гэж Керри хэлээд бушуухан гарлаа. Керрийн хоолой ялимгүй чичирхийлж байв.

Удирдаачийн гаргасан шалиг занг баргий нь мэдэлгүй өнгөрсөн, нөгөө нэг залуу нь Керрийн гарсан хойно:

- Царайлаг хүүхэн байна шүү гэхэд увайгүйтэж байж сайхан юм алдсандаа гонсойсон удирдаач:

- Аюулын царайлаг харагдсан шүү. Харин жүжигчин болж энэ насандаа чадах авьяасгүй, дагалдан тоглогч болбол юу юм гэхээс ыбиш яавч явахгүй хүүхэн гэв.

Энэхүү ялимгүй явлаас болж Керри Оперын театрын даргатай уулзахаа бүр больё гэж бодсон боловч сүүлдээ очихоор шийдэж уулзвал цаадах нь овоо тохитой томоотой хүн байсан боловч театрын урлагт эхэлж орох хүн энд биш харин Нью-Йоркт л очсон дээр, энд оролдоно гэдэг бол огт дэмий ажил гэжээ.

Гэвч Керри горь тасралгүй Мак-Викарын театр дээр очвол мэдлийн ганц хүнтэй нь чтааралдсангүй. Тэднийх “Хуучин голомт” гэсэн жүжиг тавьж байгаа юм байж. Уулзах гэсэн хүн нь байсангүй.

Тэгж явсаар байтал нь дөрвөн цаг болж гэрийн зүг нэлээд ядарсан байдалтай буцав. Горьдлогоо тасартал хайж, ормоор бүхий л газраар орё гэж санаа шийдсэн боловч хараахан үр дүн муутай л байлаа. Керри морин вагонд сууж дөчин таван минутын дараа гэхэд Огден Плэйстээ хүрсэн боловч Баруун хорооллын шуудангийн салбараар орохоор шийдэв. Тэндээс Херствүдийн захидлыг авдаг байсан ажээ. Бямба гаригт бичсэн нэг захидал хүлээн аваад задалж уншвал дотор нь элдвийн бодол төрж байлаа. Маш халуун дотно үгтэй, болзоондоо яагаад ирсэнгүй вэ, дараа нь яагаад сураггүй болов, гэж туйлын их гомдож шалгаасан байсан байх тул Керри түүнийг өрөвдөх шиг болов. Хайртай нь гарцаагүй үнэн гэж бодлоо. Эхнэртэй мөртлөө тэрнийгээ хэлэлгүй хайр сэтгэлээ өгнө гэдэг ч даанч гайтай хэрэг юм даа гэж бодоод хариу захидал бичхээс яах вэ гэж шийдсэнээ, жаахан байзнаж байгаад захидал бичихдээ эхнэртэйгий чинь мэдлээ, хүнийг ингэж мэхэлж байсанд чинь туйлын их зэвүү хүчр байна гэж бичхээр болов. Үнээс хойшоо иймээ тиймээ гэлгүй ингээд л харилцаагаа тасаллаа гэдгээ мэдэгдэхээр шийдэв.

Өрөөндөө орж ирээд тэр захиагаа шууд бичхээр суусан болов эвлүүлж бичнэ гэдэг тийм ч амар ажил биш өайсан тул нэлээд цаг баржээ.

“Та надаас яагаад ирж уулзсангүй вэ гэж асуух хэрэггүй байх. Та яах гэж ингэж муухай хуураа вэ? Одоо тантай дахин уулзана гэж бүү бодоорой. Яалаа ч гэсэн үгүй шүү. Үгүй ер, ийм муухай юм яаж хийж чадна вэ. Та намайг хичнээн их чадаж, гай тарьснаа гүйцэд ойлгохгүй дээ. Та намайг бодож сэтгэлээ зовоохгүй болно гэдэгт итгэж байна. Одоо дахин уулзах хэрэг алга. Баяртай” гэж бичив.

Өглөө нь Керри тэр захидлаа байшингийн буланд байдаг шуудангийн хайрцагт дуртай дургүй хийхдээ зөв юм хийж байна уу буруу юм хийж байна уу хэмээн эргэлзсээр байжээ. Тэгээд морин вагонд суугаад хотын төв рүү явав.

Их дэлгүүрүүдэд ажиллах орон тоо тун гардаггүй тийм үе байжээ. Гэвч Керри цэвэр цэмцгэр хувцасласан царайлаг хүүхэн болохоор түүнийг бусад ажил хайсан эмэгтэйчүүдээс өөрөөр үзэж байсан бөгөөд улиг домог болсон өнөөх л асуудаг – таны мэргэжил юу вэ? Их дэлгүүрт урьд ажиллаж байсан уу? Туршлага байна уу? гэх мэтийн юмаа асуудаг байв.

“Зах”, “Си ба кампани” мэтийн том том их дэлгүүрүүдэд очиход мөн адил “Одоогоор ажлын орон тоо байдаггүй үе, дараа ирээрэй, тэгэхэд ажил гарч магадгүй” гэсэн хариу өгч байв.

Керри өдөржин тэнсээр бүр ядарч урам хугарсан амьтан гэртээ хүрч ирвэл эзгүй хойгуур нь Дрүэ ирээд явсан байв. Өөр юмаа бас авсан байх гэж харвал тиймгүй шиг байв. Арай цөмийг аваад явчсан биш байлаа. Нэлээд удаан хугацаагаар лав ирэхгүй бололтой. Одоо яах билээ? Ганц нэг өдрийн дараа гэхэд л энэ хатуу хорвоод бас ганц биеэр муугаа үзэх болдог хэрэг үү? Хувцас хунар гэх ч юмгүй болно. Керри ингэж бодоод хоёр гараа элгэндээ тэвэрдэг зангаараа тэвэрч

хуруу гараа хүчтэй базалж эхлэв. Нүдэнд нь халуун нулимс хурж хацры нь даган урслаа. Керри гон бие гозон толгой болжээ, хөөрхий.

Дрүү үнэхээр ирээд явсан байж_ Харин ирэхдээ Керрийн бодсоноос өөр зорилготой байсан ажээ. Дрүү, Керритэй уулзаж, юмаа авах гэж ирлээ гэж хэлээд явахынхаа алдад түүнтэй эв зүйгээ ололцохыг оролдоно гэж бодож байжээ.

Тэгээд ирэхэд нь Керри байхгүй байсанд Дрүү урам хугарчээ. Керрийг хол яваагүй, мөд хүрээд ирэх болов уу хэмээн тэр хавиараа эргэлдэж байв. Шатаар хөлийнх нь чимээ гарлаа гэж бодоод байн байн чагнаж бхйв.

Орж ирэхэд нь дөнгөж сая ирээд ийнхүү эзгүй хойгуур нь орж ирсэндээ их зовж буй мэт царайлах гэж хөлийн чимээ гарлаа хэмээн чагнах бүрдээ зэхэж байжээ. Тэгээд зарим хувцас маань хэрэг болоод аваахс биш гэж хэлнэ, тэр далимдаа ямар шүү бхйдалтай байгааг нь асууж мэдэх бодолтой байжээ.

Хичнээн их хүлээгээд Керри ирсэнгүй. Дрүү авдар сав уудлахаа больж, цонхоор гадагш харах болов. Тэгснээ сандал дээр суув. Керри алга л байна. Дотор нь цухалдаж эхлэхэд янжуураа татаж эхэллээ. Тамхиа татангаа босож өрөөн дотуур холхиж эхлэв. Цонхоор харвал үүл бүрхээд бороо орох шинжтэйг үзээд гурван цагт ажил хэргийн болзоотой байснаа ч саналаа. Тэгээд хүлээгээд дэмий юм байна гэж бодоод явах болж шүхэр, пальто хоёроо барьж авлаа. Ямар ч болсон энэ хоёр юмаа аваад явъя, уг нь авах хэрэгцээгүй ч гэсэн Керрийг жаахан айлгаж магадгүй гэж бодсон ажээ. Маргаш бусадюмаа авахаар ирж далимд нь Керри ямар шүү янзтай бодолтой байгааг нь мэдье гэж шийджээ.

Керритэй уулзаж чадсангүй явах болсондоо Дрүү үнэнээсээ харамсав. Ханан дээр Керрийн жижгэвтэр зураг байгааг харахад өөрийнх нь бэлэг болох цамцыг өмссөн бөгөөд нүүрэнд нь хэзээ хэзээнээс илүү гунигтай байдал тодрох ажээ. Түүнийг хараад элэг нь эмтрэх шиг болж нүдийг нь ширтэж үзэхэд хачин их энрхийлэм санагджээ:

- Кэд, чи наддаа тусгүй юм хийсэн шүү гэж Дрүү түүнтэй уулзаад хэлж буй мэтээр хэлэв. Тэгээд үүд рүү эргэснээ ийш тийш нэг сайтар харж аваад гарч одлоо.

АЮУЛ НӨМӨРСӨН ЦАГТ БУРХАНДАА ЗАЛБИРДАГ

“Мак Грегор, Жеймс Хейн” өмгөөлөх газраас эцсийн шийд мэдэгдсэн бичгийг Херствүд аваад гадуур гарч дүнсгэр царайлан баахан дэмий л алхаж байгаад эргэж ирэхэд нь Керригээс тэр өглөө бичсэн захидал иржээ. Гарынх нь үсгийг танимагц мань хүн хамаг бие нь сэрдхийн бушуухан гэгч задлав. Задлах зуураа “надад хайртай болоод л бичээ шүү дээ, тэрнээс биш юу гэж бичихэв” гэж бодов.

Уншиж үзсэнийхээ дараа сэтгээлэр унаж хэдэн минут болсон боловч сүүлдээ “надад сэтгэлгүй бол юу ч бичихгүй байх ёстой” гэж бодов. Сэтгэлээ засах гэж ингэж бодсон хэрэг. Уншаад үзэхэд тэгж горьдмоор юм огт алга байсан боловч Херствүд гол санаагий нь өөр байх ёстой гэж боджээ.

Тов тодорхой үгээр тэгж зэмлэн зэвүүцсэн захидал байхад л тийм юмаар сэтгэлээ зогоох гэж оролдох нь өр зүрх өвдөм биш гэлээ гэхнээ хүний л нэг эрхэм чанар гэлтэй. Олон жилийн турш санаа сэтгэлээр өөгш цатгалан явсан хүн маань одоо тийм юмаар сэтгэлээ зогоох гэж оролдоно гэдэг бол хайр сэтгэлийн нүднээ үл үзэгдэх ид шидэт хүлээсний хүч буюу.

Хертсвүд, өмгөөлөгдчийн газраас ирсэн бичгийг түр мартагнахад хацар нь ула бутрах дөхөж байлаа. Керри л өөрийг нь хаяж орхихгүй бол энэ их будлианаас мултарчих юмуу ер нь базаалтай юм болж чадахгүй мэт санагдана. Керрийг л алдахгүй байх юм бол авгай яавал ч яаг гэж бодно. Тэгээд сэтгэл зүрхээ эзэмдүүлсэн тэр хүнтэйгээ хамт амьдран жаргах юм бодон босож өрөөн дотуураа холхлоо.

Гэвч удалгүй өнөөх л зовлонт хэрэг нь бодогдож туйлын их ядрах шиг болов. Маргаашийн тухай, авгайтайгаа гэрлэлтээ цуцлах тухай бодол болов. Юу ч хийж амжаагүй байтал үд өнгөрчихлөө. Дөрөвт арван тавхан минут дутуу байв. Таван цаг гэхэд өмгөөлөгчид тарчихна. Маргаашийн үд хүрэтлх хугацаа л үлдэв. Тэгж бодсоор байтал бас арван таван минут өнгөрөөд таван цаг болох нь тэр. Тэгэхээр тэдний тухай өнөө оройдоо бодохыг бүр болиод Керрийн талаар бодож эхлэв.

Херствүд өөрийгбөө зөвтгөх гэж огт оролдохгүй байгааг тэмдэглүүштэй юм шүү. Энэ талаар огт санаа зовохгүй байв. хамаг бодол нь Керрийг л ятгаж эргүүлэхэд л чиглэж байлаа. Буруу нь юу байх билээ. Үнэн голоосоо хайртайгаас хойш ядаг юм. Энэнээс л тэх хоёрын аз жаргал шалтгаалах юм. Тэр Дрүү л зам дээрээс зайлдаг болоосой гэж бодов.

Керрийн талаар иймэрхүү сайхан юм бодож байснаа гэнэт маргааш өглөө гэхэд шинэ цамц хэрэгтэй болохыг Херствүд сая саналаа. Тэгээд Пальмер зочид буудал руу явах замдаа цамц, тав зургаан зангиа худалдаж авав. Дотогш орвол Дрүү гартаа түлхүүр барьчихсан шатаар өгсөж байгаа харагджээ. Дрүү биш юм бол уу. Эд нар байраа түр сольсон юм бол уу гэж бас бодлоо. Тэгээд жижүүрийн ширээ рүү шууд явж очоод:

- Дрүү ноён энд байгаа юу? гэж асуухад жижүүр:

- Байгаа байхаа гэж хэлээд бүртгэлээ сөхөж үзсэнээ:

- Тийм байна гэв.

- Өө тийм үү. Гэж Херствүд дуу алдахдаа их сонирхож байгаагаа нуух санаатай оролдож-Ганцаара байгаа юмуу гэв.

- Тийм гэж жижүүр хэлэв.

Херствүдийн дотор хачин болоод явчсан тул тжэр байдлаа илчлэхгүй, нуухын тулд буруу харж уруулаа зуув. “Ямар учиртай юм бол? Мууцалцсан байж таарах нь” гэж бодов.

Херствүд баярлаж өрөө рүүгээ бушуухан шиг ороод дотуур цамцаа солив. Тэгээд л Керрийг ганцаараа байгаа бол уу, аль эсхүл өөр газар оччихсон юм бол уу бушуухан явж мэдэхээр шийдэв.

“Тэнд очоод үүдэн дээрээс нь Дрүэ ноён байгаа болов уу? гэж асуух юм шүү. Тэгвэл Дрүэ байна уу үгүй юу, Керри бас хаана байгааг ч мэдэж болно” гэж Херствүд бодож байна.

Ингэж бодохоос мань хүний булчин шөрмөс ч чангараад ирэх шиг боллоо. Үдшийнхээ хоолыг идмэгцээ л тийшээ явахаар шидйжээ. Зургаан цагт өрөөнөөсөө гарахдаа тэр хавиар Дрүэ харагдана уу үгүй юу хэмээн сайтар ажиглаж байснаа хоолонд орохоор уруудав. Явах гэсэн юмандаа адган яарах учир хоол нь ч хоолой руу нь чвж өгөхгүй байлаа. Гараад явснаа Дрүэг хаана байгааг нь лавтай мэдэхийн тулд зочид буудалд буцаж ороод жижүүрээс:

- Ноён Дрүэ гараад явчсан уу? гэв.

- Гараагүй, өрөөндөө байгаа. Та нэрийхээ хуудсыг явуулах уу, яах вэ? гэхэд Херствүд:

- Үгүй. үгүй. би дараа уулзъя гэж хэлээд гарч одов.

Мэдисон гудамжинд очиж Огден Плейс явдаг вагонд суув. Үүдэнд нь энэ удаа их л зоригтой очиж хонхы нь дарахад шивэгчин хүүхэн гарч ирэхэд нь:

- Дрүэ ноён байгаа юу? гэж эелдгээр асуув.

- Хотод байхгүй байгаа шүү гэж тэр хүүхэн хэлэв.

Керри, Хейл хатагтайд тэгж хэлж байхы нь тэр сонссон юм байж.

- Дрүэ хатагтай гэртээ бий юу?

- Байхгүй, театрт очсон.

- Өө, тийм үү гэж Херствүд нээлд сандарснаа дараа нь нэг их чухал хэргээр явж байгаа цуарайлан, -Ямар театрт очсон юм? гэж асуухад шивэгчин хүүхэн чухам аль театрт очсоны нь мэдэхгүй байсан боловч Херствүдэд нэгэнт муу учраас зориуд зовоох гэж “Хүүли театр” руу явсан гэж худал хэлэв.

Зоогийн газрын эрхлэгч “баярлалаа” гэж хэлээд бүрх малгайдаа гараахүргэх төдий болсноо яваад өгөв.

“Хүүли театраар ордог хэрэг” гэж Херствүд шийдэж байснаа сүүлдээ тэнд очлоо гэхэд Керри ямар нэг хүнтэй цуг байгаа, тэгэхлээр тэнд очих ямар ч хэрэг алга гэж бодоод явахаа байв. Харин өглөөгүүр уулзаж болох юм байна. Өглөөгүүр эртхэн юу юм гэхээс биш үдээс өмнө өнөөх өмгөөлөгч нар дээр нь очих ёстой билээ. Ингэж бодохоос асаж байсан гал дээр ус асгах мэт болж бүр урам хугаран зоогийнхоо газар хүрч ирээд сэтгэлийнхээ зовлонг бага ч болтугай

НИМГЭЛЭХИЙН МӨН БОЛЖ БАЙЛАА.

Их тасалгаанд их л олон ноёд ажил ярилцан дүнгэр дүнгэр гэлцэж байв. Кук тойргийн хэсэг улс төрийн бодлогочид зоогийн газрын тэртээ буланд интоорйын модон ширээ тойрон суугаад ямар нэг асуудал хэлэлцэж харагдана. Хийх ажилгүй дандаа тэнэж явдаг хэдэн залуу лангууны дэргэд зогсоод цаг орой болсон боловч театрт очно хэмээн ярилцаж байв. Гангалах санаатай хувцасласан, толгой дээрээ бортгон малгай тавьсан, улаан хамартай нэг эрхэм гав ганцаараа тэртээ нэг буланд архи шимэн сууна. Херствүд үүдэн дээрээс тэдгээр ноёдод толгой дохиод өрөө рүүгээ орлоо.

Арван цагийн алдад Херствүдийн нэг найз Фрэнк Тентор гэдэг хүн үүдэн дээр нь ирж шагайгаал ганцаараа байхад нь орж ирэв. Тэр бол морин уралдаан, спорт сонирхдог хүн юм. Орж ирэнгээ:

- Сайн уу, Жорж? Хэмээн дуу ладв.

- Сайн, сайн байна уу, Фрэнк. Суугаач гэж жигтэйхэн өрөөнийхээ хэдэн сандлын нэгийг заав. Түүнийг үзээд Херствүд ялимгүй сэргэх шиг болов.

- Юу болоо вэ? Жорж. Баахан царай дортой харагдах чинь, морины мөрий алдаа юу? гэхэд Херствүд:

- Өнөө орой бие маань базаахгүй байна. Өчигдөр л хамрын ханиад хүрчих шиг болов гэлээ.

- Виски уучих, Жорж, мэдүүштэй юм шүү гэхэд Херствүд инээмсэглэв.

Тэр хоёрыг тийнхүү юухан хээхэн ярилцаж байтал бас хэдэн танил улс гаднаас орж ирж, арван нэгэн цагт театраас тараад нэлээд жүжигчин, хэд хэдэн нэртэй жүжигчин орж ирэв.

Тэгээд дээдсийн хүрээлэнд багтахыг шүлэнгэтэн хүсдэг хүмүүс тэр хүрээлэнд нэгэнт багтсан улсыг бараадан зулгуйдаж байдаг газар болсон америкийн зоогийн газруудад үүсдэг хамгийн утга учиргүй яриаүүсэх нь тэр. Херствүд бол нэр цуутай хүмүүсийн зиндаадн байхыг л хичээдэг хүн. Өөрийгөө тийм хүсүүийн нэг гэж бодно. Хэнийг ч зусардан бялуудчлахгүй өөрийг нь доогуур үздэг тиймэрхүү хүмүүсийн дунд ороходоо өөрийнхөө эзэлж буй байр суурийг бас мартдаггүй ухаалаг байж чадлаг хүн. Өнөөдрийн цугласан эдгээр хүмүүсийн дотор жинхэнэ эрхэм ноён шиг гялалзаж, нэн цуу ихтэй цөөдуул нь түүнийг өөрсөдтэйгээ адилаар үзэж байгаад нь Херствүд их мээсийж байлаа. Тиймэрхүү тохиолдолд манай хүн ахиухан уучихаа ч мэднэ. Зоогийн газраа тиймэрхүү хүмүүстэй нийлж наргивал Херствүд ээлжиндээ заавал мөнгий нь төлж яг л тэдэнтэй адил тус зоогийн газар орж ирсэн гаднын хүн шиг байна. Тиймэрхүү хүмүүсийн дотор орчихоод нэртэй цуутай хүмүүс инээдтэй ханиадтай юм ярьж суухад нь Херствүд мөн л улаан зээрд болтлоо нэлээд хөлчүүрхсэн байдалтай царай улайлган, хөхүүн байдалтай сууж байв. Энэ оройн хувьд ч гэсэн тийм хүмүүстэй нийлж санаагий нь зовоож байсан муу ёрын бодлоосоо бага зэрэг ангижран байгаадаа баялрлана. Төдхөн бүгдээрээ халамцаж эхлэжээ. Иймэрхүү байдалд америк хүмүүс инээдтэй марзан юм ярих нь онцгой их байдаг юм.

Арван хоёр цаг болж зоогийн газар хаахад хүмүүс гарч явцгаалаа. Херствүд хүн бүртэй элэгсгээр гар барин салах ёс гүйцэтгэж байлаа. Түүний бие тун дажгүй байна. Ухаан нь саруул боловч ургуулан бодож хүсэмжлэх нь арай ч хэтрүү юмуу даа гэмээр байв. Өнөөх сэтгэлийн нь зовлон

нэг их сүйдтэй ч юм биш мэт санагдах болов. Албан тасалгаандаа орж бичиг дансан сөхөж, мухлагийн худалдаачид болон мөнгөнийхөө няравыг явахыг хүлээж байв. Тэд нь ч тэгсхийгээд явах нь тэр. Хүмүүсийг бүгдийг явсан хойно хаалагныхаа түгжээ, цоож цуургаа шалгах нь эрхлэгчийн үүрэг төдийгүй түүний бүр заншил болсон билээ. Банк хааснаас хойш орсон мөнгөө мөнгөнийхөө авдарт хийж цоожилдог. Мөнгөний авдрын цооны нууцыг мөнгөний нярав_ эздээс өөр хэн ч мэдэхгүй. Гэсэн ч Херствүд болгоомжилж орой болгон мөнгөний авдар, цоожийг шалгаж үзээд өрөөгөө цоожлон мөнгөний авдрыг гэрэлтүүлэх зохих гэрлийг асаагаад гардаг байжээ.

Тэр шөнө Херствүд ширээгээ цоожлоод мөнгөний авдрыг шалган бариулаас нь татан үзтэл хаалга нь нээгджээ. Урьд өмнө нь тийм зөрчил гарч байгаагүй атал энэ орой юу болов гэж Херствүд нэлээд гайхан цааш лавлан харвал дотор нь мөнгө харагдав. Юуны өмнө мөнгөтэй шургуулгууды нь шалгаж үзээд хаая гэсэн бодол толгойд нь орж иржээ.

“маргааш өглөө Мэйхьюд сануулж хэлэх юм шүү” гэж бодлоо. Мөнгөний нярав нь хагасхан цагийн өмнө гарахдаа цоожныхоо цуургыг дарж авдрынхаа хаалгыг хаасан гэж лавтай бодож байсан байх л даа. Чингэхийгээ ер нь мартдаггүй хүн байсан юм. гэвч тэр үдэш баахан олон юманд самуурч, хувийнхаа ажил хэргийг хэрхэн хөтлөх тухай хамаг ухаанаа зарж байж алмайрсан бололтой.

Зоогийн газрын эрхлэгч “ямар ч болсон үзэд орхиё” гэж мөнгөний авдрын доторхи шургуулгуудыг татаж харав. Яах гэж ингэж байгаа шалтгаанаа өөрөө ч сайн тухайлахгүй байлаа. Одоо өөрөө онцгой эвгүй байдалд ороод байгаа учраас л ингэж байгаа болохоос биш жирийн цагт тийм илүү зан гаргах хүн биш билээ.

Тийнхүү үзэхэд яг банкнаас талбин олгодог мөнгө шиг мянга мянгаар толгойлсон бололтой мөнгө харагджээ. Чухам хичнээн мөнгө байгааг мэдээгүй боловч багцаагийн нь авахаар ажиглав. Тэгснээ мөнгөтэй шургуулгын хоёр дахий нь татан гаргаж ирэв. Түүн дотор өнөөдрийн орсон мөнгө нь байлаа.

“Фицжеральд, Мои хоёр мөнгөө ингэж орхиж байсан удаа ер үгүй дээ, лав мартсан хэрэг байх” гэж Херствүд бодов.

Шургуулгатай мөнгийг хараад хэсэг хөдлөхгүй зогсов. Гэтэл чихэнд нь “Тоолоод үз” гэж шивэгнэх шиг болжээ. Тэгээд шургуулгатай багц мөнгийг атгаж үзсэнээ буцаагаад тавьчихлаа. Дандаа тавьт зуутын дэвсгэртийг мянга мянгаар толгойлсон байна. Арван тийм боодол байна гэж Херствүд боджээ.

“Мөнгөний авдрыг хаахгүй яах гэж ингээд байгаа билээ” гэж дотроо бодоход “чи ер нь насандаа түмэн доллар түрийвчиндээ хийж явж үзсэн үү?” гэж асуух шиг болжээ.

Үнэнийг хэлэхэд тийм их мөнгөтэй явж байснаа огт санахгүй байв. Олон жилээр хуримтлуулж байж хөрөнгөө дөчин мянган долларт хүргэсэн боловч бүгд авгайнх нь нэр дээр байдаг ажээ.

Иймэрхүү юм бодохоос дотор нь эвгүй болж шургуулгууды нь хийж хаалгы нь хаагаад одоо гагцхүү нэг товрууг дарахад л тэр мөнгөнд шунан шийдэж ядах хэрэгцээгүй болох байлаа. Гэтэл ингэсэнгүй, харин ч цонх руу очиж хөшгий нь буулгав. Дараа нь саяхан өөрөө цоожилсон үүднийхээ түгжээг шалгаж үзэв. Яагаад ийнхүү сэжиглэх болов? Яагаад хүн харын нүднээс

нуугдах болов? Тэгснээ лангууны нэг үзүүрт очиж тохойлдон зогсоод бодлогошров. Чингэж байсхийснээ өрөөнийхөө үүдийг онгойлгож гэрлий нь асаав. Ширээнхээ ард суугаад шургуулгы нь нэхээд элдвийн хачин юм бодогдов.

“Мөнгөний авдар цоожгүй, үзэгдэх төдий завсар байна. Оньс нь хараахан буугаагүй байна” гэж шивэгнэх мэт санагдав.

Элдэв дээдийн муу юм бологдсоор зоогийн газрын эрхлэгчийн толгой сүүл сүүллдээ бүр эргэж эхлэв. Урьд өдрийн хамаг будлиантай үйл явдал дахин санагдаж эхлэв. Тэр хар будлианаас мултарч болох боломж энд байгаагч мань эр бодож байна. Ийм их мөнгөтэй болсон цагт юу ч хийж чадна. Энэ мөнгийг, Керритэй хоёуланг өөрийн болговол уу болох нь тэр гээд боссоноо газар ширтэн таг чиг зогслоо.

“За тэгээд яах санаатай байна даа?” гэж асуух шиг болоход Херствүд хариу хэлэх санаатай гараа алгуурхан өргөснөө шилээ маажив. Зоогийн газрын эрхлэгч маань уг нь иймэрхүү балмад юм үйлдэх тийм ч тэнэг хүн бишсэн. Гэвч одоо өөрөө даанч онцгой хүнд бэрх байдалд ороод байгаа билээ. судсанд нь нөлөөлж байсан архи толгойд нь гарч тухайн байдлыг тун аятай байгаа мэт санагдуулав. Түмэн доллартай болох боломжий нь ч сайхан өнгөөр будаж, өдий их мөнгөтэй болсон цагт агуу их боломжууд аяндаа бий болно гэж бодлоо. Керрийг өөрийн болгож чадна, чадахаа л чадна. Авгайгаасаа ангижрна. Өнөөх мэдэгдэл бичгийг маргааш хэлэлцэх гэж зоволгүй орхиж болох л байна гэж бодсоноо буцаж очоод мөнгөний авдрын товчин дээр дарж хаалгы нь цэлийтэл онгойлгон мөнгөтэй шургуулгы нь бүр гаргаж ирлээ.

Нэгэнт гаргаж ирээд үзэхэд тийм юмыг авалгүй орхино гэдэг бол тэнэг хэрэг юм байна шүү гэсэн бодол төрөв. Үнэхээр тийм. Керритэй олон жил жарган, амар жимэр амьдран суух бололцоо олдох болно.

Бурхан минь! Айхад аргал хөдөлнө гэгчээр хэн нэгэн хүн шилэн дээрээс нь чанга гараар дарах шиг санагдав. Ийш тийш харвал хэн ч байхгүй. Гагцхүү гудамжаар хэнэ нэгэн хүн хөлөө чирэн явж өнгөрөх чимээ гарав. Херствүд шургуулгатай мөнгөө авдарт нь буцааж хийгээд мөнгөнийхөө авдрын хаалгыг дутуу хаав.

Эргэлзэж тээнэгэлзэхийг мэддэггүй тийм хүмүүс бол үүрэг, хүсэл хоёрынхоо тэнцэтгэлийг олохгүй юм л бол дагжин чичирч байдаг зориг муутай хүмүүсийн зовлонг яаж ойлгох билээ. Шидэт цагийн “тэг”, “Байг”, “Тэг”, “Байг” гэж сүртэйгээр уохилохыг хэзээ ч сонсоогүй тийм хүмүүс шүүн бодох чадалгүй байдаг. Сэтгэлийн их хөдөлгөөнтэй, их ёсорхуу хүмүүс л санаа сэтгэлийн мөргөлдөөнд ордог гэж бодохул тийм бишээ. Хүсэл нь муу үйл рүү хөтлөхөд хүний адаг байлаа ч гэсэн зөв үү буруу юу гэж срдхийх бөгөөд тэр нь бол хүч чадлынхаа хувьд түүний муу чанар луугаа тэнцүүхэн харьцаанд байдаг юм. Энэ бол зөв бурууг ухамсарласны хүч биш, яагаад гэвэл араатан муу үйлээс тойрохдоо буруу зөвийг ухамсарласандаа биш байдаг. Хүмүүс ухамсартайгаар хандахын урд заавал зөндөө татагддаг. Чухамхүү зөнгөөрөө гэмт хэргээс татгалзаж байдаг юм. юмыг ухаалгаар боддоггүй хүн байлаа гэхэд гагцхүү зөн нь түүнийг гэмт хэргийн аюулыг ухамсарлан, буруу муу юм хийхээс айлгадаг юм.

Анхныхаа, урьд нь хийж үзээгүй муу юм үйлдэхдээ хүний бодол тээнэгэлздэг байна. Сэтгэцийн өнөөх шидэт цаг нь нэг зөвшөөрөх шиг, нэг хорих шиг чаг чаг гэнэ. Тиймэрхүү янзаар ухаан нь хоёрдмол байдлын хооронд түлбэрч байгаа хүмүүс бол цаашдын явцыг гагцхүү танин мэдэхийн үүднээс сонирхох ажээ.

Херствүд шургуулгатай мөнгийг эргүүлж хиймэгцээ сэтгэл нь тайвширч, зориг орох шиг болов. Хэн ч түүнийг хараагүй. Цор ганцаараа байсан юм чинь. Юу хийх снаатай ббайсны нь хэн ч мэдэхгүй. Ингээд хамаг юмыг одоо дотроо сайн дэнслэн болох хэрэгтэй болов.

Архины хөлчүүрэл нь бас л гараагүй байлаа. Чухам юунаас гэдгээ мэдэхгүй нэг л юмнаас айн, духных нь хөлс чийхарч, гар нь салганаж, сархад нь нөлөөгөө тавиагүй байлаа. Цаг хэд болж байгаагч анзаарсангүй. Өөрийнхөө байдлыг дахин бодож үзэхэд тэр их мөнгө ямагт нүдэнд нь харагдан, тийм мөнгөөр юу хийж болох тухай толгойд нв бодол эргэлдсээр байлаа. Жижигхэн өрөө рүүгээ нэг орох гэснээ дахин үүд рүү явж, тэгснээ дахиад л мөнгөний авдрын дэргэд буцаж очоод онгойлгов. Нөгөө их мөнгө харагдлаа! Ингэж харлаа гээд ямар буруу байх билээ.

Херствүд шургуулгатай мөнгийг дахин татаж, гартаа атгаад үзлээ. Гарт зөөлхөн, эвсээрхэн, авсаархан, яасан ч жижигхэн юм, аваад явахад тойвгүй юм байна гэж бодлоо. Авах нь ч авнаа, халаасандаа л хийчихье гээд үзвэл арай ч багтахгүй бололтой. Тэгээд юм хийж явдаг жижигхэн уугаа саналаа. Тийм уутгай шүү дээ. Тэрүүнд бүгд багтана. Хэн ч юу аваад явж байгааг нь мэдэхгүй. Жижигхэн өрөөндөө буцаж ороод булангийн нэг тавиур дээрээс уугаа авч ширээн дээрээ тавьчихаад мөнгөний авдар руу очлоо. Яагаад ч юм мөнгөө тэр том өрөөнд ууталж авах дургүй байв.

Эхлээд толгойлсон мөнгийг авч, дараа нь өдрийн орлого болох толгойлоогүй мөнгийг нь авлаа. Ер нь бүгдий нь хамааар шийдлээ. Хоосолсон шургуулганууды нь эргүүлж хийгээд төмөр хаалгы нь бараг л хавхийн хаах шахаад хажууд нь нэг юм бодож зогсов.

Иймэрхүү нөхцөл байдалд хүний ухаан бодол тээнэгэлзэх нь тайлбарлахад бэрхтэй боловч яах аргагүй үнэн байдаг юм. Херствүд түс тас шийдэмгий байж чадахгүй дахин дахин бодож, явал дээр юм, яах нь зүйтэй вэ гэж зовсоор байлаа. Керрийг бодохоос, өөрийнхөө байдлыг бодохоос тийм юм хийхээс аргагүй гэж ойлгох боловч бас л тээнэгэлзсээр байв. Үүний улмаас ямар муу юм болж, ямар зовлонд орохыг тэр мэдэхгүй байв. Ийм юм хэрхэвч хийж болохгүй тухай ёс суртахууны чанар огт бодогдохгүй байна, ямар ч нөхцөл байдлын дотор бодогдохгүй бизээ.

Бүх мөнгийг гар уугандаа хийснээ дараа Херствүд гэнэт хачин муухай санагдаж ерөөсөө больдог хэрэг сүйдтэй юм болно. Цагдаа хөдөлж эрж сураглан зугтаахад хүрнэ гэхэд хаашаа зугтаах вэ? Ай, бүү үзэгд хэрэг хийчихээд зугтаана гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэгээд бүх мөнгий нь гаргаж хоёр үургуулганд нь хийв. Сандрахдаа мартаад мөнгий нь хоёр шургуулганд солиод хийчихжээ. Хаалгы нь хаах гэж завдталаа гэнэт буруу хийснээ санаад дахин онгойлгов. Хоёуланг гаргаж ирээд мөнгий нь зөв хийх гэж байтал аймшигтай юм болов, ёстой аймаар юм болжээ.

Мөнгий нь гаргаж аваад байтал авдрынх нь хаалга хавхийтэл оньслогдон хаагдчихлаа. Оньс нь буучихаж. Аяндаа ингээд хаагдчих гэж үү? Херствүд бариулаас нь угз татлаа. Хаагдчихсан байв. Бурхан минь. Одоо ч болхооо байлаа, баларлаа.

Мөнгөний авдар тийнхүү хаагдчихмагц Херствүд сандран духных нь хөлс бурзайн хамаг бие нь чичирч эхлэв. Ийш тийшээ нэг харснаа түргэн зуур шийдэх хэрэгтэй болсноо ойлгов. Одоо цаг алдаж болохгүй болжээ.

- Дээр нь тавьчихаад явчвал, хэн тэгснийг тэд мэднэ, намайг хамгийн сүүлд гардаг юм чинь мэдэлгүй яахав. Бас өөр юу ч болох юм билээ, мөнгө нь алга болчихвол ч яах юм билээ гэж ганцаараа ярилаа.

- Эндээс л ямар ч болтугай мултрах хэрэгтэй гэж бодов.

Жижигхэн өрөөндөө түргэн орж өлгүүрээс пальто, малгай хоёроо өмсөж, ширээгээ цоожлоод гар цүнхээ авав. Ганц гэрэл үлдээгээд бусды нь унтраав. Хэнэггүй байдал гаргах гэж оролдовч тун болж өгөхгүй, ийм юм хийж байгаадаа харамсаж байв.

- Дэмий л юм хийлээ. Алдаа болов гэж шивнэнэ.

Гадаа гараад үүд хаалга шалгаж явсан танил манаачтай мэндлээд цааш шалмагхан алхав. Хотоос аль болох хурдан гарах хэрэгтэй.

“Юуны өмнө хаашаа явах галт тэрэг байгааг мэдэх хэрэгтэй” гэж бодоод цагаа харвал нэг цаг хагас болж байв.

хамгийн ойрхи эмийн нэг санд орж тэнд байгаа утсаар нь ярих гэж жижүүрийн хүнээс нь:

- Утсаар ярьж болохсон болов уу? гэж асуухад цаадах нь толгой дохив.

Херствүд утасны дэвтрээс шүүрдэж олоод, арван зургаа дөчин гуравд гэж Мичиган Централ өртөө рүү залгуулав.

- Дейтройд руу галт тэрэг хэдэн цагт явах вэ? гэж Херствүд асуув.

Касны хүн явах хуваарийг нь хэлэхэд Херствүд:

- Тэгвэл өнөөдөр дахин явахгүй хэрэг үү? Гэв.

- Унтлагын вагонтай галт тэрэг байхгүй гэснээ харин гурван цагт явах шуудангийн буухиа тэрэг байгаа шүү гэж цаадах нь хэлэхэд:

- Их сайн. Тэр чинь Дейтройтод хэдийд очдог юм бэ? гэж асуув.

“Дейтройт л хүрчихвэл цааш нь эргэ гатлаад Канад руу орно, тэндээсээ Монреаль руу явах ямар зовлон байх билбб” гэж бодоод үдийн алдад Дейтройт хүрнэ гэж дуулаад дотор нь онгойх шиг болж шүүрс алдав.

“Мөнгөний нярав арван цагаас нааш мөнгөнийхөө авдрыг онгойлгохгүй. Тэгэхлээр, үдээс өмнө миний хойноос гүйцэж ирэхгүй” гэсэн бодол толгойд нь эргэлдэнэ.

Тэгснээ Керрийн тухай бодож түүнийг маш богино хугацаанд авч явах арга сүвэгчлэх хэрэгтэй гэж бодов. Юу ч болтугай түүнийг авч явна даа гээд Херствүд хамгийн ойр зогсож байсан хөлсний морин тэргэнд гүйн чоиж суугаад:

- Огден талбай. Хурдхан явбал нэг доллар илүү өгнө шү гэв.

Дэлбэгч морио шавхуурдан дэргүүлэв. Тийнхүү явах зуураа хэрхэх ухаанаа сийлж байлаа. Керрийн байгаа байшингийн үүдэн дээр хүрч очмогцоо бууж довжоогоор нь өгсөн гараад хонхы нь хүчтэй дарав.

- Дрүү авгай гэртээ байгаа юу? гэж асуухад ихэд гайхсан шивэгчин хүүхэн:

- Байгаа гэжээ.

- Бушуухан хувцаслаад гараад ир гээч. Нөхөр нь осолд ороод байна. Эмнэлэгт хэвтсэн, тэгээд уулзах хүсэлтэй байгаа юм гэж хэл.

Хүүхэн дээш хар хурдаараа гүйлээ. Херствүд ихэд мэгдсэн байсан бөгөөд дуу хоолойнх нь өнгө итгэмээр байсан тул шивэгчин хүүхэн үнэмшжээ. Керрийг сэрээхэл бошинзоо шүүрэн авангаа:

- Юу болоо вэ? гэв.

- Дрүү ноён осолд орсон гэнэ. Эмнэлэгт хэвтсэн гэнэ, тантай уулзмаар байна гэнэ, дор морин тэрэг хүлээж байна гэв.

Керри бушуухан гэгч нь хувцаслаад шивэгчний хэлснээс өөр юу ч бодсонгүй доошоо гүйхээрээ ирлээ.

- Дрүү бэртсэн, тэгээд тантай уулзъя гэж байна. Бушуухан явъя гэж Херствүд дуржигнуулан хэлэв.

Керри ихэд санарч байсан тул тэр бүхнийг үнэн гэж боджээ.

- Ороод суу, суу гэж Херствүд түүнийг тэргэнд оруулаад сүүлд нь өөрөө шурдхийн оров.

Дэлбэгч мориныхоо амыг залав. Херствүд өндийсхийн Керрид дуулдахааргүйгээр:

- Мичиган- Сентрал өртөө рүү аль болох хурдан яваарай гэж тэрэгчинд хэлэв.

ЦАГААЧ, БОСУУЛ ХОЁР. СЭТГЭЛ ХОРГОДСОН СҮНС

Хэдхэн байшин өнгөрөөд явж байхад Керри сая бага зэрэг сэхээ авч нойр нь шөнийн сэрүүн агаарт сэргэж:

- Чухам яасан юм бол? Их бэртэж үү? Гэхэд:

- Үгүй, нэг их сүйдтэй юм болоогүй байх гэж Херствүд дүнсгэрдүү хариулав.

Херствүд одоо Керрийг аваад явж байгаа ч гэсэн сэтгэл нь зовсон хэвээр, гагцхүү хуулийн мөрдлөгөөс бушуухан яаж мултардаг билээ л гэж бодож явав. Тийм учраас хүнтэй юм хүм ярилцаж өчүүхэн ч хүсэлгүй байв.

Ярих хэрэгцээ гарвал хэдхэн үгээр хариу болгох байлаа.

Керри, Херствүдтэй шийдэж чадаагүй нэг том асуудал байгаагаа огт мартаагүй байгаа боловч санаа нь өөр юманд зовж байгаа учраас тэр тухай бодохгүй байлаа. Энэ хачирхмаар аялал юу ч гэсэн төгсөг гэж бодов бололтой.

- Хаана байгаа юм?

- Урд хэсэгт. Түргэн хүрэхийн тул галт тэргээр явахаас өөр замгүй гэж Херствүд тодорхой бус юм хэлэв.

Керри юу ч хэлсэнгүй. Морин тэрэг дэргүүлсээр л. Керри, шөнө цагаар тэр хот ямар хачин харагдахыг ажиглаж явна. Арагш сугаран хоцрох шиг эгнээ эгнээ чийдэн, барайн харагдах байшингуудыг харна. Керри, Дрүэг сүрхий бэртсэн гэж бодоод:

- Яаж байж тийм осолд орсон юм бол? гэж асуув.

Херствүд түүнийг ойлгож байлаа. Тэгээд нэг их худалд хэлээд яахав гэж боловч аюулаас мултарлаа аргалж байхыг л бодохоор болов.

- Би яг нарийн мэдэхгүй байна. Өөрийг чинь бушуухан шиг олоод аваад ирэхгүй юу гэж утастсан. Нэг их айх хэрэггүй, харин таныг л заавал авчраарай гэсэн гэв.

Херствүд ихээхэн хэнэггүй ярих тул Керри үнэмшээд дуугай болон бодлогошров. Херствүд цагаа харснаа дэлбэгчийг түргэлж үз гэв. Байдал хэдийгээр түгшүүртэй байсан боловч Херствүд дажгүй царайлан явлаа. Галт тэргэнд амжиж суугаад хотоос санаа амар гарахсан гэж л бодсоор байв. Керри үгнээс нь гарахгүй шинжтэй яваад нь баярлаж өөрийгөө мөн ч зайтай эр шүү гэж бодож байлаа.

Тэгж явсаар өртөөн дээр хүрэхэд Херствүд тэргэчинд таван доллар атгуулаад Керрийг сугадан буулгаж түүнтэй хамт өртөө рүү яаран оров.

Херствүд, Керрийг хүлэх тасалгаанд орхиод:

- Эндээ хүлээж байгаарай, би билет аваад ирье гэв.

- Дейтройт явах галт тэрэг хөдлөхөд хэдэн минут үлдээд байна? гэж Херствүд жүжүүрийн кассчингаас асуухад тэр хүн:

- Дөрвөн минут үлдэж байна гэв.

Херствүд аль болохоор хүн амьтны анхаарал таталгүй байж хоёр билет худалдан авлаа. Билетээ аваад уухилан ирэхэд Керри:

- Хол явах юм уу? гэхэд:

- Үгүй, нэг их холгүй, гэхдээ галт тэргэнд түргэн суухгүй бол болохгүй гэв.

Буух суух тавцан дээр очоод Херствүд Керрийг урагшаа гарган өөрөө билет шалгагчид билетээ үзүүлэхдээ Керрид үзүүлэхгүй гэсэндээ тэгжээ.

Цааш нь яаран явж очиход суудлын болон ачааны галт тэргүүд жирийн харагдах бөгөөд тэдгээрийн дунд өдрийн цагаар явдаг ердийн хоёр галт тэрэг байгаа үзэгдэнэ. Тийм галт тэргийг хэрэглээд удаа ч үгүй байсан, хүн олон суухгүй байх гэж төмөр замын захиргаа үздэг байсан учир билет шалгагч үйлчлэгч хоёрхон хүн явуулдаг байв.

Херствүд Керри хоёр тэр өдрийн ердийн галт тэргний арынхад нь суув. Дөнгөж суутал нь “сууж гүйцэлээ” гэж зарлах бүдэг дуу гарахд галт тэрэг ч хөдлөв.

Ингэж явах нь Керрид хачин мэт санагдсан боловч юм хэлсэнгүй дуугай л байлаа.

- Бие чинь зүгээр биз? гэж Херствүд дотор нь онгойсон бололтой сүүрс алдан эелдгээр асуухад Керри:

- Тун сайн гэж товчхон хариулав.

Керрийн сэтгэл ихэд үймэрч байсан болохоор Херствүдтэй хэрхэн харьцах тухайгаа ч бодож амжаагүй байв. Бушуухан л очиж Дрүэ ямар байгааг мэдэхсэн гэж бодно. Херствүд түүнийг хараад л дотроо юу бодож байгааг андсангүй. Дрүэг тийнхүү бодож байгаад нь ч Херствүд дургүйцсэнгүй. Сэтгэл нь зовох нь аргагүй, ер нь ч тэгээд энэ бол хүний сайн чанарыг л харуулж байгаа хэрэг шүү дээ гэж бодов. Тийм чанартайд нь Керрид их дуртай байгаа тал ч бий. Харин сүүл сүүлдээ юу гэж хэлдэг билээ гэхээс л санаа нь зовж эхлэв. Гэсэн ч одоо энэ зүйл хүртэл гол биш санагдана. Үйлдсэн гэмт үйлдлээ, ингэж оргож яваагаа бодохоос сэтгэл нь шаналж байлаа.

“Даанч тэнэг юм болжээ, даанч тэнэг юм болжээ, ингэж эндүүрэх гэж байх уу даа” гэж дотроо гасалж байв.

Херствүд одоо эрүүл саруул ухаанаараа бодоход ийм юм хийсэндээ итгэж ядна. Хууль цаазнаас оргон зугтаж байгаа этгээд болж хувирснаа бодоход ухаанд нь багтахгүй санагдана. Тийм явдлын тухай уншдаг л байсан, тийм юм бодохоос аймаар санагддаг байсан ажээ. Гэтэл одоо өөрөө тийм болчихоод байгаа болохоор яагаад тийм болсноо бодоод л суухаас өөр яахав. Ирээдүйн амьдрал нь Канадтай шууд холбоотой учир түүнд л бушуухан хүрэхийг бодно. Гэхдээ өчигдөр орой болсон явдлууд байн байн бодогдоход дандаа л алдаа хийгээд байсан санагдана.

“Гэлээ ч гэсэн надад өөр арга байгаагүй шүү дээ” гэж дотроо зөвтгөнө.

Нэгэнт ийм болсон хойно өнгөрөө гэж бодох боловч дахиад л өчигдрийн хэрэг толгойноос нь салахгүй байсгээд л бодогдох ажээ. Ингэж ямар ч ашиггүй дэмий шаналан байснаас Керритэй юу гэж ярилцах үгээ ч сэдэж чадахааргүй явлаа.

Галт тэрэг нуурын эргийн өртөөнүүдийн хажуугаар түжиг тажиг өнгөрч Хорин дөрөвдүгээр гудамжны хавьд очоод хурдаа хасахад дохионы шовгор, зам заасан сумууд цонхоор яралзан харагдаж байв. Бух тэрэг урьдчилан сэргийлэх богино дохио байн байн өгч, хонх нь жингэнэж байв.

Үйлчлэгч нар гартаа дэнлүү барьсаар вагон дотуур явж үүд хаалга, завсрын гарц зэргийг түгжиж байгааг бодоход хол явахын бэлтгэл байлаа.

Удсан ч үгүй галт тэрэг хурдаа авч нам гүм гудамжууд Керрийн нүдний өмнө хурдан хурдан жирэлзэн өнгөрнө. Аюултай зөрлөг, гарц ойртоход галт тэрэг дохио чимээгээ ойр ойр өгч байлаа.

- Хол юмуу? Гэж Керри асуухад Херствүдүд:

- Үгүй, тийм холгүй гэв.

Херствүд, түүний гэнэнг бодохоос инээдээ барьж явлаа. Учры нь олигтойхон хэлж арга зүйгээ ололцье гэж яарах боловч Чикагогоос холдох хэрэгтэй байв.

Дахиад хагас цаг хэртэй хугацаа өнгөрөхөд Керри хол явах нь гэж мэдээд сэрдхийн:

- Хаашаа явж байнаа энэ чинь? Чикагогоос гараад явчих шиг? Гэв. Галт тэрэг үнэхээр хотоос аль хэдийн гараад Индиана муж улсын нутгаар хурдлан явлаа.

- Чикагогоос гарсан шүү, гарах ч гарсан гэж Херствүд хэлэхэдээ цаанаа нэг янзтай байсан тул Керри энэ даруй сэжиг авч хөөрхөн хөмсгөө зангидаж:

- Чарли дээр очихоор яваа биз дээ? гэж асууцхад оодоо шийдэх цаг болсныг ойлголоо. Эрт орой боловч заавал үнэнээ хэлэх ёстой байсан нь мэдээж. Тэгээд Керрийн өөдөөс усгал зөөлнөөр харж толгойгоо үл мэдэг сэгсрэв.

- Юу болоод байнаа? Гэж Керри дуу алдан асуулаа.

Очно гэсэн газраасаа өөр тийш яваад нь Керри хэдрхийн цочжээ. Херствүд юу ч хэлсэнгүй, гагцхүү гуйж царайдсан байдлаар усгал зөөлнөөр харна.

- Та намайг хаашаа явуулаад байнаа? Гэж айж гэлэмсэн дуугаар асуув.

- Керри, тайван сууж байгаач, би хэлж өгье. Би таныг өөр хотод аваачих гэсэн юм.

- Үгүй ер, болиоч, би татай явахгүй гэж Керри бараг хашгирч хэлэв.

Керри, тийм цадиггүй явдалд нь гайхаш тасарч байв. Толгойд нь тэгнэ чинээ бодол огт ороогүй байж. Ушуухан л эндээс зайлж зугтъя гэснээс өөр юм бодогдсонгүй. хурдлан давхиж буй галт тэргийг зогсоогоод л орхивол энэ хүний бузар ажлыг цэс болгож болох билээ. Тэгээд Керри

босож үүд рүү тэмүүлэв. Нэн даруйхан шийдэхгүй бол өнгөрнө гэдгийг ойлгож байв. Херствүд гараас нь зөөлхөн барьж:

- Тайван бай, тайван бай! Яарах явдалгүй. Миний үгийг сонс, би учры нь тайлж өгье. Жаахан хүлээ л дээ гэнэ.

Керри бас л явах гэж тэмүүлэх боловч Херствүд явуулахгүй бариад байсан тул арга буюу буцаж суудал дээрээ суув. Вагонд хүн цөөхөн, тэгээд тэд нь нойрмоглож явсан болохоор тэр хоёрын энэ явдлыг хэн ч ажигласангүй.

- Би яавч үгүй. Би буцлаа. Та яасан хачин хүн бэ хэмээн эсэргүүцээр байв. Нүдэнд нь нулимс гүйлгэнэжээ.

Одоо Херствүдэд бас нэг сүрхий бэрхшээл тохиолдож эхэлсэн тул мань хүн өөрийнхөө тухай болон өөрийн байдлыг бодлох сэхээгүй болж гагрцхүү тэр хүүхнийг ятган аргацаахын төлөө үхэлдэх хэрэгтэй болов. Ингэхгүй бол ихээхэн муу юм болж мэдэх ажээ. Херствүд өөрийн хамаг уран үгээ зарж эхлэв.

- Керри, аан гэж бай л даа. Битгий ингээд бай, би танд муу юм хийх гэж огт бодоогүй. Танд харамсмаар ямар ч юм хийх гээгүй байна.

- Ий-ий-ий хэмээн Керри мэгшин уйлж эхлэв.

- За боль доо, зүгээр бай, битгий уйл. Миний үгийг сонсооч дээ. Би яагаад ингэх болсноо хэлж өгье, өөр яах ч арга олдоогүй юм, үнэн шүү, Нээрэн шүү! utr dgay dgay uea.6

Керрийн цурхиран уухилахаас Херствүд тун их айж байв. Хэлж буй үгий нь огт сонсохгүй байгаа хэрэг...

- За, Керри, үг сонсооч дээ.

- Үгүй. Намайг тавиатах, үгүй бол үйлчлэгчийг дуудлаа шүү. Та яасан ичгүүрээ барсан хүн бэ? Тантай хамт явахгүй гээд мэгшин уйлах тул үгээ ч гүйцэд хэлсэнгүй.

Херствүд дахин мэгдэж эхлэв. Керрийн ингэж дургүйцэх нь аргагүй гэдгийг ойлгож байсан боловч түүний аль болох бушуухан тайвшуурах нь чухлыг бас ойлгож байлаа. үйлчлэгч билет шалгах гээд орж ирэх болохоор дуу шуугиан болж, будлиан л гаргахгүй юмсан, юу боловч Керрийг ятгаж уужруулах хэрэгтэй гэж бодов.

- Галт тэрэг зогсоогүй цагт та эндээс гарахгүй шүү дээ. Жаахан хүлээж бай, дараачийн өртөө хүртэл хүлээзнэ. Үнэхээр буух гээд байгаа бол тэнд л буухаас биш. Би таныг хорихоо больё. Харин миний хэлэх үгийг сонс л доо. Яагаад ингэсэн учрыг минь дуул л даа.

Керри түний хэлж байгааг огт сонсохгүй байгаа мэт, буруу харан харанхуй шөнө түнэртэх цонхны наана зогсоно. Галт тэрэг ой талын дэргэдүүр гулсах мэт хурдална. Хүн хар үл үзэгдэх ойн замын хаалт мод ойртох бүрд галт тэрэг уйтгарт дохиогоо уянгалуулан удаан дуугаргана.

үйлчлэгч орж ирээд галт тэрэг хөдлөхийн өмнөхөн суусан хоёр хүнд билет олгоод бусдынх нь билетийг шалгаж эхлэв. Дэргэдээ ирмэгч Херствүд хоёр билетээ үзүүлэв. Керри цааш хараад

зогссон хэвээр хөдөлсөнгүй. Наашаа ч харсангүй.

Үйлчлэгчийг гараад явахад Херствүд сэтгэл амарч сүүрс алдав.

- Та намайг хуурлаа гэж уурлаж байгаа байх. гэвч би таныг хуурах гээгүй юм шүү Керри. Тангараглахад бэлэн байна. Би тэгж хуурах гээгүй. Би өөрийгөө татаж дийлэхгүй байна, тантай уулзсан анхны тэр агшнаас тангүйгээр амьдарч чадахгүй байна.

Херствүд түүнийг дахин хуурснаа юманд чинээнд үл бодон дурдахгүй байх бөгөөд одоо эхнэрийгээ саад болохыг байсан гэдгийг бушуухан хэлэхээр яарч байлаа. Харин саяхан хулгайлсан мөнгшөнийхөө тухай бодлыг огт санахгүйг хичээж байв.

- Надтай юм ярих гээд хэрэггүй, би таныг үзэн ядаж байна. Амар заяа үзүүлээд аль, дараачийн буудал дээр л бууя гээд Керри дургүй нь хүрсэндээ хамаг бие нь чичирч байлаа_

- За яах вэ, гэхдээ минийг хэлэх үгийг сонс л доо. Бид хоёр хайр сэтгэлтэйгээ ярилцсан шүү дээ. тэгэхлээр миний үгийг сонсох л ёстой баймаарсан. Би танд ямар ч муу юм хийхгүй. Надаас салаад харих гэж шийдэх юм бол би буцахын чинь мөнгийг өгье. Миний тухай юу ч гэж бодож байлаа гэсэн та намайг өөртөө хайртайг болиулж чадахгүй шүү гэдгийг л би хэлж байна, Керри минь гээд өөдөөс нь маш энрхийлсэн байдлаар харсан боловч цаадах нь хариу өгөлгүй дуугай сууна.

- Та намайг хуурлаа муухай юм хийж байна гэж бодож байгаа байх, гэхдээ би санаатайгаар тэгсэн юм биш тэгж бодож бодохгүй, би таныг хуурах гээгүй, би эхнэрээсээ салчихсан. Одоо тэр намайг яах ч эрхгүй. Би түүнтэй дахин хэзээ ч уулзахгүй. Тэгээд л би өнөөдөр тантай хамт энд явж байна шүү дээ. Тэгээд л би таныг аваад явж байна шүү дээ.

- Та чинь Чарлийг бэртсэн гэж хэлээ биз дээ гэж Керри уурандаа хашгирч - Та намайг дахиад л хуурсан байна. Намайг дандаа малладаг байсан, одоо бүр өөртэйгөө хамт оргуулж байна гэж хэлээд тун их зэвүүцэх учир босон харайгаад дэргэдүүр нь өнгөрөн гарахад Херствүд энэ удаа яасан ч үгүй. Керри өөр суудал дээр очиж суув. Херствүд дэргэд нь очиж суугаад.

- Керри, надаас битгий зугат, би учры нь ярьж өгье. Миний үгийг л сонс, тэгвэл ойлгомжтой болно: Би авгайгаасаа бүр салсан гэдгээ дахиж хэлье. Тэр бид хоёр, хоёр биенээсээ холдоод олон жил болсон улс, тэрнээс биш би юу гэж тантай ингэх билээ_. Удахгүй гэр бүлийнхээ баталгааг цуцлуулж авна. Түүнтэй дахин хэзээ ч уулзахгүй ингээд дуусах нь тэр. Та бол надаас хамгаас илүү хайртай цорын ганц эмэгтэй. Та надтай л байх юм бол би өөр ганц ч хүний тухай бодохгүй.

Керри түүнийг үгийг сэтгэл ихэд дэнэгэлзсэн байдаотой сонсох бөгөөд хичнээн муугаар бодлоо ч гэсэн Херствүд үнэн голоосоо ярьж байх шиг санагдана. Түүний дуул хоолойн өнгө, хөдөлж барьж байгаа бүхий л байдал нь Керрид ямар нэг хэмжээгээр нөлөөлж эхлэв. Гэсэн ч Керри наашлах чнзгүй байв. Эхнэтэй байсан мөтрлөө тэрнийгээ хэлэлгүй хуурч байсан, одоо бас худлаа хэлээд аваад гарсан, даанч аймшигтай муухайн хүн гэж бодгдсоор амуй. Гэвч тийнхүү сэтгэлийн зориг гаргаж байгаа нь ялангуяа өөрт нь хайр сэтгэлтэйн улмаас тэгж байгаагийн нь бодохоос бүсгүй хүн тийм юманд их дуртай байдагчлан бас үнэлж явав.

Эгзэгтэй асуудлыг нэг тийш болгоход хурдлан яваа галт тэрэгний хөдөлгөөн ихээхэн нөлөөтэй байв. Тэрэгний дугуй жирэлзэн өнгөрч, хээр тал газар ард ухран хоцрох тусам Чикаго хот тэртээ

хол хаягдсаар байлаа. Галт тэрэг зогсолтгүй жийгүүлсээр ахуйд Керри тун хол газар явчлаа гэж бодов. Заримдаа хашгичин хэрүүл шуугиан дэгвдээвэл хүмүүс ирж туслах байх гэж бодно, заримдаа нэгэнт өдий газар явчаад байгаа хойно яагшаад ч тус нэмэргүй болов хэмээн бодно. Тэр хооронд Херствүд явал оновчтой үг хэлж өөртөө татдаг билээ хэмээн бодсоор байв.

- Керри минь, надад өөр ямар ч арга олдож өгөөгүй учраас л би ингэсэн хэрэг шүү дээ, бодож үзээч гэхэд Керри огт анхаараагүй мэт бхйв.

- Өөртэй чинь гэрлэхээс нааш надтай хамт явахгүй юм байна гэж бодоод л би хамаг бүхнийг орхиод таныг авч явахаар шийдсэн минь энэ. Би одоо өөр хотод очихоор явж байна. Эхлээд Монреальд очно, тэндээсээ таны хаашаа явна гэсэн зүг рүү явах байна. Нью-Йоркт очиж сууя гэвэл тийшээ очих л байна өөрөө мэдтүгэй.

- Би тантай яагаад ч явахгүй. Энэ галт тэрэгнээс л буух хэрэгтэй байна. Хаашаа явж байгаа юм?

- Детройт.

- Үгүй ер, гэж Керри дуу алдах бөгөөд тийм хол газар очих болсондоо улам халширмаар санагдав.

- Надтай хамт явахгүй юм биз дээ? гэж Хертсвүд эс явбал их аюул болох мэтээр асуугаад – Та надаас салж явах хэрэг огт байхгүй, би таныг яах ч үгүй. Монрель, Нью-Йорк хотыг үзчихээд, буцмаар санагдвал буц л даа. Өнөө шөнө буцсанд орохноо тэгээд буцсан нь дээр биш үү гэлээ.

Ингэж хэлэхэд нь авмаар бодмоор юм хэлж байх шиг Керрид анх удаа санагдав. Үгүй гэж өөрийнхөөрөө зүтгээд зүтгээд нэгэнт нэмэргүй болохоор харин тэгж хэлснээр нь явбал зүгээр мэт бодогдов. Монреаль, Нью-Йорк хот! Одоо ийм хурднаар дөхөж яваа тэр том, тэр сонин хот орноор очих гэвэл л очиж болох байна шүү дээ. Ингэж дотроо бодовч бодож байгаагаа мэдэгдэхгүй байлаа.

Херствүд, зөвшөөрч ч магадгүй хэмээн тааварлаад өөрийнхөө чармайлтыг дахин нэмэгдүүлэв.

- Бодоод үз л дээ, Керри минь, намайг юугаа орхиод явж байгаа хүн гэж бодно. Би Чикагод дахин хэзээ ч эргэж очиж чадахгүй. хэрэв та надтай хамт байхгүй юм бол би тэндээсээ үүрд гарч ганцаараа амьдрахаар болсон хүн шүү. Намайг цорын ганцааранг минь орхиод явах юм гэж үү?

- Та битгий элдвийн юм яриад бай гэж Керри хүчлэн хэлэв.

Херствүд дуугай болов.

Галт тэрэг зогсох янзтай хурдаа сааж байх шиг санагдав. Санаа нэгэнт шидйсэн бол одоо л түүнийгээ хийдэг цаг болж дээ. Керри дурамжхан хөдлөн босохыг завдав.

- Битгий яв, Керри. Хэрэв та надад хэзээ нэгэн цагт сэтгэлтэй байсан бол надтай хамт явж байгаад бүхнийг зохих ёсоор нь эхэлье хоёул. Би таны хэлснээр л явна. Би таныг надтай сууя гэвэл гэрлэх л байна, буцаад явна гэвэл явуулаад өгье. Та жаахан бодож эргэцүүлж үз л дээ. Би танд хайр сэтгэлгүй бол юу гэж таныг гуйж гувших билээ. Керри минь, би таныгүгээр амьдарч чадахгүй, яагаад ч чадахгүй, бурхны өмнө тангараглах байна.

Херствүдийн хэлсэн үгэнд хичнээн их шийдэмгий бөгөөд сэтгэл догдлом өнгө байсан болохоор Керри бага зэрэг зөөлөрч эхлэв. Керрид дэндүү хайртай бөгөөд энэ хэцүү цагт түүнийг алдана гэж бодохоос Херствүдийн дотор гал шатах мэт болж байгаа ажээ. Херствүд гары нь шүүрэн барьж аваад хамаг зүрх сэтгэлээрээ гуйн хүсэж буйгаа илэрхийлэв.

Галт тэрэг одоо бараг зогсох дөхөн сул зам дээр зогсох хэдэн вагоны хажуугаар аажуухан өнгөрч байв. Гадаа хав харанхуй, юм бүхэн бүргэлзэнэ. Цонхон дээр усны дусал үзэгдэхийг бодвол бороо шивэрч эхэлсэн бололтой. Керри нэг буугаад, явмаар шийдсэнээ болиод тээнэгэлзэж, баахан үймэрч эхлэв. Галт тэрэг зогслоо, Херствүд ч ятгасаар байлаа. Галт тэрэг арагш ялимгүй ухарсхийснээ чимээ тасрав.

Керри яах ч учраа олохгүй суусаар байв. Түүнийг эргэлзсээр байхад цаг минут минутаар өнгөрсөөр байлаа, Херствүд ч ятгасаар л.

- Хэрэв та намайг буцъя гэвэл буцаах уу? гэж Керри түүнийг нэгэнт длийлээд эрхэндээ оруулчихсан юм шиг асуув.

- Буцаалгүй яах вэ, тэгнэ гэдгийг та мэдэж байгаа.

Керри, түр өршөөл үзүүлсэн хүний янзтайгаар түүний хариу хэлсэн үгийг сонсов. Цаашдын үйл явдал өөрийнх нь нарт орж гэж бодсон бололтой.

Галт тэрэг нэг л их удалгүй хөдөлж төдхөн хурдаа авах давхилаа. Херствүд одоо ярианыхаа сэдвийг өөрчилж эхлэв.

- Их ядарч байгаа байх даа?

- Үгүй ээ.

- Ортой өрөөнд оруулж өгөх үү?

Керри үгүй гэж толгой сэгсрэв. Гэвч Херствүдийн хүн халамжлах сайн чанар Керрид тун аятайхан санагддаг байсан нь энэ удаа түүний муухай заль гаргаж өөрийг нь хичнээн бэрх байдалд оруулаад байгаа ч гэсэн мөн тааламжтай санагдлаа.

- Тэг л дээ, тэнд өөрт чинь тун аятайхан байх болно гэж Херствүд шалгаав.

Керри дахин толгой сэгсрэв.

Тэгвэл ядахнаа миний пальтог дэрлээд хэвт л дээ гээд босож хавар намрынхаа хөнгөн пальтог Керрийн толгой дэрлэхэд эвтэйхнээр эвхэв.

- Уухай, тэгээд жаххан амрахыг бод гэж Херствүд энхрийлэн хэлэв.

Тэгж үгэнд нь орсон явдалд Херствүд баярлахдаа Керрийг үнсээд авмаар байв.

Херствүд, дэргэд нь сууж бодолдоо дарагдаж эхлэв.

- Ширүүн бороо орох шинжтэй гэж нэг хэсэг дуугай байснаа хэлэв.

- Тийм байж магадагүй гэж Керри хариу хэлэхдээ хав харанхауйн дунд шинэ ертөнц рүү галзуу мэт хурдлан яваа галт тэрэгний цонхоор салхинд гуядагдан орж ирэх бороон дусалд дотор нь онгойх шиг болсон бололтой.

Херствүд, Керрийг түр ч болтугай номхотгож авсандаа баяртай байлаа. Түүнийг нэгэнт аргалж авсан хойно одоо өнөөдрийнхөө хийсэн алдааны тухай бодолд автаж эхэллээ. Бодохоос тэсэмгүй айхтар зовлонтой санагдана. Яах гэж энэ муу мөнгийг хулгай хийв, ингэж хулгай болох ч гэж дээ гэж гасална. Урьдынхаа байдлыг ингэж хөнгөн хуумгай юмнаас болж алдаад одоо ямар ч их мөнгөөр түүнийгээ нөхөж чадахгүй болжээ. Ямар ч мөнгөөр одоо найз нөхдөө, сайн нэрээ, гэр бүлээ, тэр ч байтугай урьдын Керригээ эргүүлэн олж чадахаасаа өнгөрчээ. Өөрөө өөрийгөө Чикаго хотноос хөөлөө, өөрөө өөрийгөө эзэлж байсан сууринаас гаргалаа. Өөрөө өөрийгөө тонон дээрэмдэж, хүндээ хөнгөнөөс өгч, сайхан амралт жаргал, зугаатай үдэш шөнийхөө ужид цэнгэлийг алджээ. Яах гэж тэр билээ? Херствүд ингэж бодох тусам тэвчихийн аргагүй санагдаж байв. Одоо хуучин байдалдаа орж болохгүй гэж үү? Урьд шөнийнхөө хулгайлсан гайтай хэдэн мөнгийг эргүүлж өгөөд хамаг учраа хэлбэл яах бол? Мои ноён учрыг ойлгож юу магад. Зоогийн газрынхан гэмий нь уучлаад хуучин ажилд минь үлдээж магадгүй яа?

Жин үдийн алдад галт тэрэг Детройт хотод хүрч ирлээ. Хертсвүд ч ихээхэн мэгдэж эхлэв. Одоо цагдаагийн газар эрж сураглах ажлаа лав эхэлсэн байх ёстой. Том том хотын цагдаагийн газруудад мэдэгдэж эрж хайж эхэлсэн байгаа биз. Хэрэгтэнгүүдийгн тийм аргаар барин авдгийг мань эр мэдэх билээ. Ингэж бодохоос амьсгаа нь давчдаж царай нь хувхай цайна. Гар нь ямар нэг юмнаас барин авах гэж байгаа аятай салганан чичирч ч байх шиг. Цонхоор юм сонирхож байгаа мэт худал царайлан шал дэвсэнэ.

Керри түүний сэтгэл ихэд тэвдүүн байгааг ажигласан боловч юу ч хэлсэнгүй. Яагаад тэгж байгаа, ямар гүн учир холбогдолтой байсны нь яаж мэдэх билээ.

Энэ галт тэрэг Монреаль руу, Канадын аль нэг хот родог эхсэхийг асуусангүйдээ бухимдаж, цаг хожих байснаа алдав уу даа гэж бодов. Тэгээд огло харайн босож үйлчлэгчийг нь эрж олоод:

- Энэ тэрэг чинь Монреаль явдаг юм уу үгүй юу? гэж асуув.

- Дараачийн унтлагын вагонтой тэрэг тийшээ явна шүү.

Өөр төөр нэлээд юм асуумаар байсан боловч эвгүй санагдсан тул депо дээрээс очиж лавлахаар болов.

Галт тэрэг уухилж уугчсаар, түржиг таржиг гэсээр буудал дээр ирэхэд Херствүд Керрид:

- Эндээс шууд Монреаль явсан дээр гэж бодож байна. Ямар галт тэрэг хэдийд явахы нь мэдээд ирье гэв.

Херствүдийн санаа тун их зовох боловч мэдэгдэхгүйг хичээж байлаа. Керри түүнийг том нүдээрээ үргэсэн тором шиг л харахаас биш, чухам яахаа шийдэж чадахгүй л байв.

Галт тэрэг зогсогц Херствүд түрүүлэн гарлаа. Керрийг буухад нь туслах гэж буй царайлан ийш тийш хулгай нүдээр сэм ажиглавал өөрийг нь ажиглан таних хүн алга шиг болохоор билетийн касс руу явж очоод:

- Монреаль руу галт тэрэг хэдийд явах вэ? гэхэд:

- Хорин минутын дараа явна гэлээ.

Херствүд хоёр зөөлөн суудлын билет худладаж аваад Керри дээр яаран ирэв.

- Эндээс шууд явахаар болов гэж Керрид хэлэхдээ Херствүд түүний хичнээн аяншин ядарч явааг огт анхаарсангүй,

- Яасан зовлонтой юм, дуусах цаг ирдэг ч болоосой гэж Керрийн гуингтайгаар хэлэхэд Херствүд:

- Монреаль хүрээд л дажгүй болно гэв.

- Юу ч авч гарсангүй, ядахнаа нусны алчуур ч үгүй явна шүү гэхэд:

- Зүгээр, тэнд очоод л юу хэрэгтэйгээ аваарай. Оёдолчин дуудсан ч болно гэж Хертствүд тайлбарлав.

Галт тэрэг хөдлөхөд бэлэн боллоо хэмээн зарлахад тэр хоёр орж суулаа. Галт тэргийг хөдөлмөгц Херствүдийн дотор онгойв бололтой сүүрс алдав. Гаталгааны онгоцоор голыг даван гарахад Херствүд санаа алдан арагш налан суулаа. Тэгээд сэтгэл нь уужирч Керрийг авч яваагаа санаж:

- Удахгүй хүрнэ, тийм их хол биш, өглөө маш эрт хүрнэ гэхэд Керри хариу дуугарсангүй.

- Гуанз байгаа бол уу, үзээд ирье, өлөрхөж байна шүү гэж Херствүд бас хэлэв.

АЯЛАХЫН САЙХАН, ТЭНГИСИЙН ХӨЛГҮҮД

Төрж өсөөн нутгаасаа гарч үзээгүй хүнд харь газар нутгийг үзэх хачин сонин байдаг. Тэр бол сэтгэл баясган баярлуулахдаа хайр сэтгэлийн дараа л ордог байх шүү. Урьд өмнө үзээгүй юмныхаа дэргэдүүр хүн эстоон өнгөрдөггүй болохоор мэдрэцийн тусгал болсон оюун ухаан нь бодит юмсын нөлөөнд заавал ч өртдөг нь зүй. Тийм үедхайр сэтгэлтэн, уй гашуу, үхэл зовлон бүгд мартагдана. “Би алсыг зорьж явна” гэсэн эгэл нэгэн өгүүлбэрийн цаана мэдрэхийн бүхэл бүтэн ертөнц хурна.

Керри, хурдаа аван цахилах галт тэрэгний цонхоор жирэлзэн мяралзан өнгөрөх юмсыг ажиглаж байхдаа ийм хол газар хүнд мэхлэгдэн, эрхэнд нь орчихоод, замд хэрэг болох хамгийн наад захын аар саар юм ч авч чадаагүй явж буйгаа мартаад байлаа. Заримдаа Херствүдтэй хамт яваа гэдгээ ч мартаад хөдөө нутгийн тэр танил мэт аж ахуй, тосгоны тохилог хөөрхөн байшингуудыг ихэд сонирхон харж явав. Тун зугаатай, цоо шинэ амьдрал эхэлж буй мэт бодогдоно. Өөрийгөө хүний эрхэнд яваа ч гэж бодохгүй байна. Ирээдүйн горь айдвар ч тасраагүй явна. Том хотод яаж ч болох боломж буй ажээ. Боол мэт хүлэгдэж байсан уяа гинжнээсээ ангижирч эрх чөлөөтэйгөө золгож ч байгаа юм билүү. Вмыг яаж мэдэх вэ. Аз жаргалтайгаа золгож гэж яваа ч юм билүү? Иймэрхүү юм бодоход амьдралдаа хийсэн алдаа нь өчүүхэн төдий, тун шалихгүй санагдана. Горь тасраагүй цагт ухаан нь олдож таарна.

Маргааш өглөө нь Монреаль хотноо тэд эсэн мэнд хүрч ирэхэд Херствүд аюулаас мултарлаа гэж бодоод хөл газар хүрэггүй шахам баярлаж байв. Керри умард нутгийн хотын шинэ уур амьсгалыг шохорхон сонирхоно. Херствүд урд үүгээр ирж байсан удаатай ажээ. Тэгэхлээр бууцж байсан зочид буудлаа нэхэн санаж нэрий нь олов. Тэднийг галт тэрэгний буудлын гол хаалгаар ороод явж байхад зарлагчийн хэлэх үгэнд уг зочид буудлын нэр гарч байлаа.

- Зочид буудалд очиж өрөө тасалгаа авдаг хэрэг гэж Херствүд хэлэв.

Херствүд, бүртгэл дээр очиж жижүүрийг нь ирэхээс өмнө дэвтрий нь үзэж байхдаа ямар нэрээр явъя даа хэмээн бодож бхйтал жижүүр нь ч ирлээ, удаан бодох зав ч үгүй болов. Тэгтэл замдаа сүүхний цонхоор нэг газар бичээстэй нэр харсан нь санаанд орж ирэв. Аятайхан ч нэр шиг санагджээ. Тэгээд Херствүд:

- “Ж.В.Мурдок, гэргийн хамт” гээд дурайтал бичив. Аргайгүй эрхэнд л нэрээ өөрчилсөн хэрэг. Харин овгоо өөрчлөх гэж зүрхэлсэнгүй.

хөлсөлж авсан өрөө нь Керрид таалагдсан бололтОЙ.

- Халуун ус байгаа. Хирнээсээ салж болно гэж Херствүдийг хэлж байхад Керри цонхны дэргэд очиж гадаах байдлыг ажиглав. Херствүд тольдож үзвэл зөндөө тоосонд дарагдсан байлаа. Сольж өмсөх дотуур хувцас ч байхгүй, яадахнаа үсээ самнах сам ч үгүйгээ мэдлээ.

- Алчуур, саван, сам авчруулья. Усанд орчихоод хоолонд ороход бэлэн болоод байгаарай. Би үсчинд ороод ирье. Хоол идчихээд гадуур гарч хувцас хунар хайч гээд Херствүд малилзан инээв.

Керри “За” гэж хэлээд эргэдэг сандалд суухад Херствүд зарцын ирэхийг хүлээн зогсож байлаа. Төдхөн үүд цохих чимээ гарч орж ирэхэд нь:

- Саван, алчуур, уух хүйтэн ус авч ирээрэй гэв.

- За тэгье ноёнтон гуай

- За би ч явъя даа гээд Херствүд, Керрийн дэргэд тулж очоод гараа сарвайв. Гэвч Керри, гары нь барьсангүй. Херствүд:

- Та надад уурласан хэвээр л байна уу? гэж эелдгээр асуухад:

- Өө, үгүй дээ гэж хайхрамжгүйхэн хариулав.

Надад огт хайргүй гэж үү.

Керри хариу дуугаралгүй цонх руу ширтсээр байв.

- Намайг жаахан ч гэсэн хайрладаггүй гэж үү? Надад хайртай гэж хэлж байсан биз дээ? гэж Херствүд хэлээд гары нь шүүрэн атгахад Керри гараа татаж авахыг оролдов.

- Та яах гэж намайг мэхэлсэн юм?

- Надад өөр арга даанч байгаагүй юм даа. таныг дэндүү их хүсдэгтээ о энэ шүү дээ.

- Танд намайг хүсэх эрх байхгүй шүү дээ гэж Керри нэлээд ёжтой хэлэв

- За Керри минь, та одоо надтай хамт байгаагаас хойш тгэж яриад яах юм. Надад бага ч гэсэн хайртай болохыг л бод доо хэмээн харин ч өөрөө хэлмэгдсэн этгээд мэтээр харж зогслоо.

Керри үл таашаан толгой сэгсрэв.

- Одоо цоо шинээр эхэлье. Та өнөөдрөөс эхлэн миний эхнэр болтугай гэхдээ гары нь барьсаар л байв.

Керри зугтах янзтай босоход Херствүд харин ч бүсэлхийгээр нь тэврэн авлаа. Керри ноцолдсон боловч дийлсэнгүй. Херствүд тас тэвэрчээ. Хамаг биенийх нь шунал тачаал агшин зуурд галын дөл дүрэлзэх адил болж, хайр сэтгэл нь ноцох шиг болов. Тас тэврүүлсэн Керри:

- Алив болиоч, намайг тавь гэлээ.

- Намайг хайрлхагүй, миний эхнэр болохгүй гэж үү?

Керри, уг нь түүнд хэзээ ч муу байгаагүй билээ. Дөнгөж саяхан хүртэл урьдынх нь хайртай байсныг санаж нэлээд нааштайгаар үгий нь сонсож байсан шүү дээ. Их ч сайхан хүн, зоригтой ч хүн гэж боддог болов.

Харин одоо энэ бодлоосоо буцахад бэлэн болж хэсэг гөжүүдэлж үзсэн боловч чанга тэврээд байхтай нь зэрэг өөр болж эхлэв. Ямар нэгэн өөр мэдрэц бий болж, тэвэрч буй хүнийхээ хүчтэй, тэчъяангуй, хайртайг мэдрэнэ. Керри гон бие гозон толгой, Үгүй гэж гөжүүдлээд энэ хүний хайрыг авахгүй хаачих билээ? Керри, тэр хүний халуун хайр сэтгэл, шунаглан дурлах нөлөөнд нь автаж гөжүүдлэх нь буурч байх шиг байв. Херствүд, эрүүгий нь тулж нүд рүү нь ширтэн харлаа.

Тэр хүний нүдэнд соронзонгийн татах хүч яасан их байна. Керри огт мэдээгүй явжээ. Түүний үйлдсэн олон нүглийг тэр агшинд Керри мартлаа.

Херствүд улам чанга тэврэн үнсээд авлаа. _ Керри ноцолдоод нэмэргүйгээ мэдэж:

- Надтай суух юмуу гэж л асуулаа. Харин хэрхэн гэрлэх боломжийг бодсонгүй ажээ.

- Яг өнөөдөр гэрлэн гэж Херствүд сүр жавхлантайгаар хашгирах нь халаг хэлэв.

Тэгтэл хаалга цохих чимээ гарахд Херствүд арга буюу Керрийг тавилаа.

- За, бэлэн болоод байгаарай, түргэлнэ шүү гэхэд Керри

- За гэлээ

- Би дөчөөд минутын дараа ирэх байх гэж Херствүд хэлээд хаалга нээхээр ухасхийхэд Керрийн царай нэлээд улайж, амьсгаа нь нь давчидсан байдалтай байв.

Херствүд, шатаар буугаад үсчин хаана байгааг хайв. Мань эрийн магнай тэнийж баярласан харагдана. Керрийг тийнхүү дийлж авсан нь сүүлийн хэд хоногийн таричлгаа шаналгааг арилгаж чадахуйц их амжилт байлаа. Амьдрал гэгч үнэхээр сайхан санагдах болжээ. Ижил дасал болсон газраасаа зүг буруулан ингэж зугтсан нь аз жаргалыг зөгнөсөн ч байж мэднэ. Үер бороо зогсож тэнгэрт татсан солонгын тэртээ нэг үзүүрт бөөн алт байгааг хэн байг гэх билээ.

Херствүдийг үсчний газраар орохоор явж байтал танил дуу гарсанд зүрх нь ёгхийгээд явчихав.

- Хүүе, Жорж, сайн байна уу, газрын хаанаас гараад ирэв ээ? гэхэд Херствүд түүнийг хармагцаа танив. Хуучин танил найз, мөнгөний захын жууч Кенни гэгч ажээ.

Хувийн бага сага ажлаар явж байна гэж Херствүд хариулаад тархиа цахилгаан мэт түргэн ажиллуулж эхлэв.

- Таныг энд явж байх юм гэж үнэндээ бодсонгүй. Энэ буудалд байгаа юу? гэж ихл найрсгаар асуухад Херствүд бүртгэлийн дэврэт өөрийн гараар бичсэн нэрээ бодож зовохны сацуу:

- Тиймээ гэв,

- Энд удах уу даа?

- Үгүй, ганц хоёрхон л өдөр болно.

- Өө, тийм үү, өглөөнийхөө хоолонд орсон уу?

- Орчихсон гэж Херствүд хээв худал хэлээд – одоо би үсчин орох гэж явна гэлээ.

- Надтай ганц нэг хундага юм уух юм биш үү?

- Үдээс нааш амжихгүй, дараа л больё,, та энэ буудалд байгаа юмуу гэж зоогийн газрын эрхлэгч агсан энэ хүн асуув.

- Тийм гэж Кенни хэлээд- Чикагогаар сонин юу байна даа гэв.

- Хуучин хэвээр шив дээ.

- Авгайтайгаа яваа юу?

- Үгүй шүү.

- За тэгвэл хоёул өнөөдөр дахин уулзана шүү. _ Би хоолондоо орох гэж явна. Над дээр орж ирээрэй.

- Ирнэ гээд Херствүд цааш явлаа.

Тэр хүнтэй тийнхүү тааралдж ярьсан нь бүхэлдээ том сорилт болов. Үг болгон дээрээс эвгүй вч болж мэдэхээр байлаа. Гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр Херствүд мянга түмэн зүйлийг нэхэн санаж, алд үлдсэн Чикаго хот, эхнэр, тохилог хээнцэр зоогийн газар гээд юм бүхнийг нь энэ хүн биеэр төлөөлж буй мэт санагдсан ажээ. Тэгээд элдвийн юм ярилцаж цаг сайхан өнгөрөөхийг хүсэж буй тэр хүн нь ээн зочид буудалд байгаа юмсанжээ. Одоо юу юугүй Чокагогийн сонинууд ирнэ. Орон нутгийн сонингууд тэдгээрээс сонирхолтой зүйлийг нь түүвэрлэн авч энэ өдөртөө хэвлэн нийтэлнэ. тэгэхлээр, мөнгөний авдар тоносон хулгайч учраас о энд ирсэн юм байж гэж төдхөн мэдэгдэх аюул байсан учраас балмагдахдаа саяхан Керрийг дийлж хөл газар хүрэхээргүй баярлаж байснаа ч мартжээ. Үсчинд арай л зүрхээ аран ёолсоор орсонгүй.

Бушуухан шиг эндээс зайлж хөл багатай зочид буудалд очихоор дотроо шийдэж байв.

Үсчнээс гараад явахад хөлийн өрөөгөөр хүн хар үзэгдэхгүйд ихэд баярлан шатаар яаран өгслөө. Керрийг аваад арын хаалгаар нь гарчихъя. Өөр, хүн цөөхөн газар очиж хоол унд идэж ууя гэж бодов.

Гэтэл хөлийн өрөөгөөр явж байтал бас нэг хүн түүнийг яах аргагүй ааж буй харагджээ. Тэр бол тагдгар намхан биетэй, муухан хувцастай яагаад ч юм хутган үймүүлэгч этгээд гэмээр толгойтой ердийн нэг ирланд хүн байлаа. Тэр хүн, зочид буудлын жижүүртэй ярилцан зогсож байсан боловч Хертсвүдийг жигтэйхэн ажиглан харж байв.

Зоогийн газрын эрхлэгч агсан маань тэр хүний ширтэн харж буйг мэдэрч юун хүн болохы нь ч мэдлээ, өөрөөр хэлбэл цагдаагийн газрын мөрдөгч этгээд гэдгий нь ойлгожээ. Херствүд түүнийг ажиглаагүй юм шиг бушуухан шиг гэмгүй царайлан өнгөрөхийг хичээвч толгойд нь түмэн бодол эргэлдэж эхлэв Одоо юу болох бо? Энэ улс намайг яах бол? Хэргэтэн этгээдийг баривчлан эргүүлж тушаах хууль байдаг. Тэр нь чухам ямар хууль байдгийг огт мэдэхгүй юм даа. Баривчилж ч магадгүй шүү. Керри мэдэж орхивол яана, ай мөн хэцүүеэ. Монрелаьд байхын арга алга. Эндээс л даруйхан тонилохын мөн болж эхлэв.

ЭРгэж очиход нь Керри усанд орчихсон хүлээж байв. Сэргэчихсэн, хэзээ хэзээнээс илүү царайлаг харагдах боловч биеэ нэлээд барьсан байдалтай байв. Түрүүчийн байснаасаа нэлээд өөр хөндий, хайр сэтгэлийн шинж тэмдэг огт үл илэрнэ. Херствүд үүнийг нь мэдээд улам хэцүүдэв. Тэвэрч барьж сүйд болсон ч үгүй, ородох ч зүрх нь хүрсэнгүй. Нөгөө талаар саяхан шатны дор юу боллоо- тэр нь нөлөөлж байв.

-Бэлэн үү? Гэж Херствүд эелдгээр асуухад Керри:

- Бэлээн гэв.

- Бүр гадагш гарч хоол идье. Энд нэг онц биш санагдаад байна.

- Тэгье тэгье.

Тэр хоёрыг тийнхүү гадагш гарахад түрүүчийн ирланд хүн Херствүдийг нүд салгалгүй ширтэн зогсож байлаа. Дэргэдүүр нь ямар ч болсон ажиггүйхэн өнгөрөөд Херствүд тэр хотын тухай Керрид бага сага юм ярьж эхлэв. Тэгтэл ч нэг хесторан тааралдж түүнд орлоо.

Монреаль хот Чикагогаас их өөр байсан тул Керри хачирхаж:

- Энэ ер нь хачин хот юмаа гэхэд Херствүд:

- Чикагог бодохноо хөл багатай шүү, өөрт чинь аятайхан санагдаж байна уу? гэв.

Өрнө нутгийн тэр агуу том хотод дасаж эхэлсэн Керри:

- Үгүй, аятайхан санагдахгүй байна гэлээ.

- Нээрэн ч тийм дээ, сонирхоод байхаар хот биш.

- Юу байгаа юм? гэж Керри, Херствүдийн энд ирэх гэснийг гайхаж асуув.

- Онцын ч юм байхгүй л дээ, гэхдээ хүн цөөнтэй, сувиллын газартай, газар орных нь байдал тун сайхан.

Керри түүний ярихыг сонсовч санаа нь нэг л таатай биш байлаа. ӨӨрийнхөө байдлыг бодохлоор өөр төөр юмны тухай үнэлэлт өгөхтэй манатай байжээ. Керрийн тийнхүү сэтгэл дутууг мэдээд Херствүд уухайн тас хийн олзуурхаж:

- Хоёул энд удахгүй ээ. Хоолоо идчихээд захиалсан хувцасаа аваад л тэгсгээд Нью-Йорк руу явьч. Тэнд сайхан л даа. Чикаго хотоос ч том шүү гэлээ.

Херствүд эндээс эсэн мэнд дээрээ бушуухан зайлахын мөн болж байв. Тэр цагдаа нар яах нь вэ, Чикагогаас эзэд нь юу гэх нь вэ тэрий нь мэдээд л Нью-Йорк руу яноах юмсан, тэнд нуугдахад хялбархан гэж бодож байна. Тэр бол яаж ч байсан их боломжтой, ид шидтэй газар болохыг Херствүд сайн мэдэх ажээ.

Гэвч иймэрхүү юм бодох тусам өөрийнх нь байдал даанч арчаа муутай болох нь тодорхой болж байв. Монреальд ирлээ гээд ямар чнэмэр болсонгүйг өөрөө ойлголоо. Эзэд нь түүнийг олох гэж мөрдөх цагдаагийн газар болох Пинкертоны эрүүлчдийг эсвэл Мони, Боландын тандуулуудыг хөлслөх биз. Канаадаас явах гэтэл нь бариад авч мэднэ. Тэгэхлээр энд арга буюу хэд хэдэ сараар хоригдох дээр хүрвэл яана. Одоо гэмээнээ ямаршүү янзтай байгаа билээ.

Херствүд зочид буудалд эргэж ирээд өглөөний сонин харахаас айдас нь хүрч байв. Хийсэн хэргийнх нь тухай юу гэж бичсэний нь мэдэхийг хүсэж Керрийг эндээ байж байгаарай, би

доошоо нэг буугаад ирье гэж хэлчихээд сонин шүүрдэж үзэхээр явлаа. Зэгсэн таних юмуу сэжигтэй хүн харагдсангүй. гэсэн ч хөлийн өрөөнд сонин унших нь эвгүй санагдсан учир дээш гарч нийтийн том тасалгаанд орж цонхны хавьцаа очиж суугаад уншиж гарлаа. Түүний үйлдсэн хэргийн талаар тун жаахан юм бичсэн байв. Хүн амины хэрэг, аваар осол, гэрлэлт гэх хэдхэн мөр үг байжээ. Болдогсон бол тэр хэдэн мөрийг аваад хаячихсан гэж Херствүд гуингтайгаар бодов. Аюулаас мултарч энэ хол газар ирлээ гээд нэмэр болсонгүй, цаг мөч болгонд сэтгэлий нь зовоох юм нэмэгдэх тул Херствүд даанч муухай алдаа хийснээ ухаарч байлаа. Мэдсэнсэн бол амархнаар мултран гарах арга зам байсан байхдаа, даанч мэдсэнгүй гэж гуниглан бодно.

Өрөөндөө орохдоо уг сонингуудыг Керрийн гарт оруулахгүйн тулд гадаа орхижээ. Керри цонхоор юм хараад зогсож байсан тул,

- Бие чинь зүгээр биз? Керри гэхэд'

- Өө зүгээр гэлээ.

Херствүд дэргэд нь очоод юм ярих гэтэл үүдний хонх дуугарав.

- Миний захисан юмыг авчирч байгаа байх гэж Керри хэлэв.

Херствүд үүлдийг нээвэл өнөө нэг сэжиг бүхий этгээд байхыг танив.

- Та Херствүд ноён уу? гэж тэр хүн их л даажигнасан байдалтай асуув.

- Тийм байна гэж Херствүд тайвнаар хэлэв.

Тиймэрхүү этгээдүүдийг Херствүд тамиры нь мэдэх учир баахан зэвүү нь хүрчээ. Зоогийн газарт бол иймэрхүү хүмүүс хамгийн доогуур үзэгддэг ажээ. Херствүд өрөөнөөсөө гарч ирээд үүдээ хаав.

- Та намайг энд ямар хэргээр ирснийг мэдэж байгаа биз дээ? гэж нөгөө хүн дуугаа намсгаж ирээд асуухад Херствүд мөн аярахнаар:

- Гадарлаж байна гэв.

- Та тэр мөнгө өгөхгүй байх санаатай байна уу?

- Энэ бол миний мэдэх рэрэг гэж Хертсвүд хариуд нь царай барайлган хэлэв. Эрүүлч, түүнийг хүйтнээр харж:

- Та тэгж чадахгүйгээ өөрөө мэдэж байгаа шүү дээ гэв.

- Эрхэм минь аан гэж байа. Та энэ асуудлын талаар ойлгоогүй байна гэж ойлгуулах гэж би тайлбарлах ч үгүй. Би юу хийх гэснээ хэнээр ч заалгалгүй хийх хүн, та намайг уучилна биз гэж Херствүд ихэмсгээр хэлэв.

- Та цагдаагийн газрын гарт орсон байж ийм юм яриад ямар ч ашиггүй. Би таныг чадья даа гэвэл таныг их зовоож чадна. Та зочид буудалд өөр нэг зээлдэж бичсэн байна, гэргийтэйгээ гэж худалд хэлсэн байна. Гэвч таныг чухам хаана байгааг сониныхон мэдээгүй байна л даа. Тэгэхлэр та

цхаалаг байх хэрэгтэй биз гэж нөгөө хүн хэл.в

- Та юу сонирхоод байгаа хүн бэ?

- Та тэр мөнгөө эргүүлж өгөх хүн үү, үгүй юу?

Херствүд дуугай болон газар ширтэж байснаа:

- Энэ талаар танд тайлбарлах хэрэг алга. Та ч надаас асуугаад юу хийх вэ. Би тэнэг хүн биш ээ мэдэж байгаа. Харин би таны юу хийж чадах, юу эс чадахыг мэдэж байна. Та хүнийг их довоож чадах байх л даа, тэглээ ч гэсэн тийм аргаар мөнгийг олж авахгүй. Би одоо яахыгаа шийдчихсэн хүн. Фицжеральд, Мои хоёрт аль хэдий биччихсэн бодохоор надад хэлэх юм алга. Та, тэднээс хариу иртэл хүлээж бай гэв.

Тэгж ярилцаж байхдаа Херствүд Керрид дуулдуулахгүйн тулд үүднээс улам холдон явсаар байв. Тийм учраас тэр хоёр нийтийн том өрөө рүү ордог мухарт хүрээд байв.

- Тэгэхлээр та мангий нь эргүүлж өгөхгүй гэж байгаа юмуу? Гэхэд нь Херствүдийн уур хүрч шар нь хөдлөв. Маш олон юм бодогдов. Хулгайч биш, тэр мөнгийг авья гэсэндээ авсан юм биш, Фицжеральд, Мои хоёрт үнэнээ хэлж гэм хуучин хэвийнхээ байдалд орж болно байх гэж бодов.

- Танд энэ тухай яриад яах вэ, би та нарын эрхийг мэдэж байна, гэхдээ уг зүйлийн учрыг мэдэх хүмүүстэй ярилцах нь зүйтэй гэж бодож байна гэв.

- Та ямарч гэсэн мөнгөө аваад Канадаас зайлж чадахгүй шүү.

- Би аваад явах гээгүй байна, харин явахаа болохоор хэнээр ч цагдуулахгүй гэж хэлээд Херствүдийг эргэхэд цагдаа хойноос нь ширтэн харсаар хоцров. Херствүд явсаар өрөөндөө орчихов.

- Ямар хүн бэ? гэж Керрийг асуухад Херствүд:

- Чикагогаас явж байгааминий нэг найз л байна гэв.

Сүүлийн долоо хоногийн турш сэтгэлээр зовж байсан Херствүдэд ингэж цагдаатай ярилцах болсон нь маш хүчтэй цохилт болж, ихээхэн гутарч эхэлжээ. Уг явдлыг бодохоос ой нь гутаж эхлэв. Ялангуяа өөрийг нь хулгайч хэмээн мөрдөж байгааг бодохоос тэвчихийн аргагүй болов. Асуудлын ганц өрөөсгөл талыг шүүрч аваад ямар нэг явдал дээрээс түүнийг дэвэргэн мушгидаг олон нитийн санал гэгч яасан шударга биш бхйдаг юм гэж Херствүд бодно. Сонин болгон л мөнгий нь авчихаж гэнэ гэж бичих мөртлөө юунаас болж авав гэдгийг огт орхичих юм гэж гомдоно. Амьдралын ямар шүү их будлиан, зовлонгийн улмаас хүн тиймэрхүү явдалд орж болдгийг тэд огтхон ч анхаардаггүй аж. Одоо ч гэсэн яагаад ийм хэрэгт холбогдох болов гэдгийг ярихаасаа өмнө юу юугүй л яллаж эхэлсэн байна.

Херствүд, Керритэй өрөөндөө сууж байхдаа яг тэр өдрөө мөнгий нь эздэд эргүүлж өгөхөөр шийджээ. Фицжеральд, Мои хоёрт хамаг учир шалтгаанаа бичээд мөнгий нь цахилгаанаар явуулчихъя гэж шийдэв. Тэд уучлаад, тэр ч байтугай хуучир ажлаа ирж хий гэж ч магадгүй гэж горьдов. Эздэдээ захидал биччихсэн гэж нөгөө эрүүлчид худалд хэлж байснаа ч үнэн болгох юм,

Тэгээд энэ хотоос явна гэж бодно.

Уг асуудлыг нэг тийш болгоход ингэх нь зүйтэй юм гэж бүхэл бүтэн цагийн дотор байн байн бодсоор байжээ. Эздэдээ эхнэртэйгээ ямар шүү байсан тухайгаа бичье гэснээ арай л зүрхэлсэнгүй. Тэгж тэгж сүүлд нь хэдэн нөхөдтэйгээ баахан ууж халамцаад байсан үедээ мөнгөний авдар цоожгүй задгай байхыг санамсаргүй мэдээд мөнгий нь гаргаж үзэж байгаад авдрынхаа хаалгыг санамсаргүй хааснаас л ийм болсон юм. Одоо чингэсэндээ, бас та нарыг ингэж сэтгэлий нь зовоосондоо маш их харамсаж байна. Та нарт учруулсан хохирлоо буюу авсан мөнгөө ихэнхий нь одоо эргүүлэн өгч, үлдсэн хэсгийг аль болох хурднаар олж өгнө гэжээ.

Захидлынхаа төгсгөлд хэрэв Фицжеральд, Мои хоёр ноёнтон болох талтай гэж үзвэл хуучин үүргээ гүйцэтгэж болох юм гэдгээ битүүхэн үгээр мэдэгдсэн байна.

Бичсэн захидлынх нь агуулгаас үзэхэд л тэр хүн хичнээн их бажгадаж байсан нь мэдээж ажээ. Тэр ноёд нь зөвшөөрлөө ч гэсэн Херствүд яаж хуучин ажилдаа орохов дээ, тэрүүн шиг муухай шившиг байхгүй гэдгийг ч бодох чадалгүй болжээ.

Херствүдийн ухаан самуурч байгаа бололтой заримдаа эхнэрийнхээ тухай, Керрийн тухай, мөнгөний хэрэгцээтэй байгаа тухайгаа мартаад байв. Ер нь одоохондоо эрүүл саруулаар сэтгэж чадахгүй байлаа. Харин хариу ирэхээс нааш мөнгий нь явуулалгүй, захидлаа л бичээд явуулжээ.

Ямар ч болтугай Керри нэгэнт хамт байгаа болохоор түүнтэйгээ аль болохоор баяр баясгалантай байхыг хичээж байв.

Үдийн алдад тэнгэр арилан нээлттэй цонхоор алтан нарны туяа орж ирлээ. Болжморууд шулганалдан жиргэнэ. Агаар тэнгэр цэлмэн амьтад баясан дуу шуушиан, инээх баясах дуулдаж эхлэв. Херствүд, Керригээс нүд салгаж чадахгүй ширтэнэ. Санаа сээтгэлийнх нь тэр хар муухай, зовлонгийн дотуур зураих нарны алтан туяа гэвэл Керри л юм. Чикаго хотын жижигхэн цэцэрлэгт уулзаад байхдаа нэг удаа хайртай гэж хэлсэн шигээ одоо хайраа бшрэн өгч хүзүүдэж авдаг ч болоосой, тэгвэл миний жаргалын дээд болох юмсан гэж халаглан сууна. Тэгвэл алдсан юм байхгүй гэсэн үг, бүгдийг нөхлөө гэсэн үг, өөр юуг ч юман чинээ санахгүй ажээ.

Херствүд суудлаасаа босож Керрийн дэргэд очиж:

- Керри минь, чи надтай хамт байна биз? гэж асуулаа.

Керри өөдөөс нь дооглосон янзтай харснаа тэр хүний нүдэнд бэрхшээл зовлонд улам жинтэй болсон үнэн зүрхний гүн хайр илрэхэд уяран хайлж эхлэв. Тэгээд өөрийн эрхгүй инээмсэглэв.

- Би одоогоос эхлэн чиний юм бүхэн чинь больё. Намайг битгий зовоогооч. Би чамд үнэнч хань чинь больё. Хоёул Нью-Йорк хотод очиж сайхан байртай больё. Би дахин ажилд ороод хоёул аз жаргалтай амьдаръя, чи минийх болохгүй юмуу?

Керри их л анхааралтай сонслоо. Керри түүнд нэг их дуртай биш боловч тухайн байдал, түүни ойр дотно байгааг бодохоос хайрлах сэтгэл төрж эхлэв. Энэ хүнийг нэг үе гайхан биширч явсан бол одоо харин хайрлаж хэзээ ч яваагүй юм. Өөрөө сайн бодоод үзэхүл Керри үүнийгээ ухаарах л байсан биз. Гэвч тэр хүчтэй шунал тэчъяалын нөлөөгөөр тэр хоёрын зааг тэгсгээд арилжээ.

- Чи надтай байх уу, үгүй юм уу?

- Байнаа гээд Керри толгойгоо дохиход

Херствүд тэврэн авч озож үнсэн үлгэлээ.

- Харин та надтай сууна шүү.

- Би өнөөдөр ингээд л гэрлэх зөвшөөрөл авна.

- Яаж?

- Шинэ нэрээр. Би нэрээ ч шинэтгэнэ, шинээр ч амьдарна. Миний нэр Мурдок гэдэг болно.

- Өө, яасан эвгүй нэр вэ?

- Яагаад?

- Надад эвгүй дуулдаж байна.

- За тэгвэл ямар нэр авъя даа?

- Ямар ч яахав, тэр нэрийг л битгий ав.

Херствүд, Керрийг тэвэрсэн хэвээр нэг хэсэг бодож байснаа,

- Вийлер гэвэл яах вэ?

- Тэр зүгээр.

- За тэгвэл Вийлер гэе. Би өнөөдөр л гэрчилгээ авна.

Тэгээд л тэр хоёр нэг лам дээр очоод гэрлэчихсэн байлаа.

Удалгүй Чикагогоос хариу ирлээ. Мои ноёны бичүүлсэн захидал байв. Херствүдийн тийм юм хийсэнд их гайхаж, ер нь тийм юм болсонд их харамсаж байна. мөнгөө буцааж өгөх юм бол угаас өөрийг нь муу санаж явдаггүй байсан болохоор мөрдөж мөшгөн зовоохгүй. Харин буцаж ирэх тухайд бол ямар нөлөөтэй болох талаар бодож хараахан шийдээгүй байна. Энэ тухай дахин ярилцаад ойрын үед өөрт чинь бичье... гэсэн байлаа.

Захидлын бүх агуулга санааг бодохул Херствүдэд ямар ч горьдлого байхгүй болсон бөгөөд тэд мөнгөө л түвэг багатайгаар олж авахсан гэж байгаа нь ил байв. Херствүд баларснаа мэдлээ. Тэгээд тэдний ирүүлсэн бие төлөөлөгчөөр есөн мянга таван зуун доллары нь явуулж өөртөө мянга гурван зууг нь үлдээхээр шийдэж энэ тухайгаа цахилгаанаар мэдэгдэв. Мөн тэр өдөр зочид буудалд нь хүрч ирсэн тэдний бие төлөөгөчид Херствүд учрыг тайлбарлаж өгөөд мөнгө хүлээн авсан гарын үсэг аваад Керрийг одоо явахад бэлд гэв. Херствүд тийм явдал болсонд хэсэг хугацаагаар санаагаар унах байдалтай байсан боловч тэгсгээд тайтгарав. Хэдийгээр мөнгий нь өгсөн ч гэсэн, цагдаа барьж аваад буцааж магадгүй хэмээн Херствүд айх тул мэдэгдэлгүй явахыг бодлоо, гэвч энэ нь бараг боломжгүй байв. Тэгээд Керрийн хайрцагтай юмыг галт тэрэгний

буудалд хүргүүлэн, буухиа тэргээр Нью-Йорк руу явуулав. Түүнийг даган мөрдөж байгаа хүн мэдэгдэхгүй байсан боловч шөнө болсон хойно л явжээ. Анхны өртөөн дээр юмуу эсвэл Нью-Йоркт буумагц нь цагдаагийн газраас бариад авч магадгүй гэхээс яс нь хавталзаж явлаа.

Херствүдийн хулгай хийсэн, дотроо үхтлээ айж явааг огт мэдэхгүй байсан Керри тэр өглөө нь Нью-Йорк хот орж ирэхэд хотыг харан их сонирхон баярлаж байв. гудсон мөрний эрэг даган явахад дув дугариг ногоон толгод Керрийн анхаарлыг ихэд татлаа. Гудсон мөрний тухай, агуу том Нью-Йорк хотын тухай урьд сонсож байсан бол одоо нүдээрээ харж гайхан сонирхож байв.

Галт тэрэг, Спутен Дуивил хүрээд Харлем мөрний зүүн эргээр даган явахад Херствүд дотроо бухимдаж Керрид одоо бид хотын захад гарлаа гэж хэлэв. Урт урт галт тэргүүд эгнээ эгнээгээр зогсдог Чикаго хоттой адилгүй болохыг Керри ажиглав. Харлем голд хэдэн хөлөг, Ийст мөрөнд нэлээд олон зогсож байгааг хараад Керрийн залуу зүрх уохилно. Энэ нь тэнгис далай ойр буйн шинж ажээ. Дараа нь таван давхар тоосгон байшингууд ярайн эгнэсэн гудамжаар явж байгаад хонгилд оров.

Харанхуй, утаан дундуур нэг хэсэг явж байгаад ил гарч ирэхэд үйлчлэгч “төвийн_ их өртөөн дээр ирлээ” гэж зарлав. Херствүд босож гар тээшээ шүүрэн авав. Түүний санаа туйлын их зовж байгаа ажээ. Керритэй хамт вагоны хаалган дээр зогсож байгаад буув. Хэн ч отоогүй боловч мань эр ийш тийш хулмалзан явлаа. Балмагдаж явсандаа болоод Керрийгээ ч мартаж өөрөө түрүүлэн явав. Галт тэрэгний буудал өнгөрөхөд түгшээ нь сааран эхэлжээ. Хажуугийн замд гарахад түүнийг морин тэрэгчдээс өөр анхаарлы нь татсан юм тааралдсангүй. Херствүдийн дотор сая л онгойж уртаар гүн санаа алдаад Керритэй хамт яваагаа санах.

- Намайг орхиод явчих нь уу гэж бодлоо шүү гэж Керри хэлэхэд:

- Жилсир хүрэхэд ямар тэргэнд суудаг билээ гэж бодож явлаа гэж Херствүд худалд хэлэв.

Керри шинэ хотыг ихэд сонирхон анхаарч байсан болохоор түүний хэлсэн үгийг бараг сонссонгүй.

- Нью-Йорк хэдэн хүнтэй вэ?

- Нэг сая гаруй хүнтэй гэж Херствүд хэлээд нэг морин тэрэг дуудав.

Ингэхдээ урьдын адил санаа амар байсангүй. Урьд гарах зардлыг ер боддоггүй байсан бол одоо толгойд нь тэр санаа анх удаа зурсхийн орж иржээ. Тун эвгүй санагдана.

Зочид буудалд орж цаг үрснээс байр хөлсөлж суусан нь дээр гэж шийдээд Керрид хэлбэл цаадах нь зөвшөөрөөд:

- Өнөөдөртөө байр олж авах юм шүү гэв.

Херствүд Монреальд яаснаа гэнэт санаж нэртэй томхон зочид буудалд орвол Чикагогийнхнаас тааралдаж магадгүй байсан тул суудал дээрээсээ өндөсхийж дэлбэгчид:

- Бельфордод очно шүү гээд эргэж суув. Тэнд өөрийг нь таньж мэдэх хүн бараг байхгүй гэдгийг Херствүд мэдэж байв.

- Орон сууцных нь байшингууд хаана байдаг юм? гэж Керри асуухыг бодохул гудамжны хоёр талаар эгнэсэн таван давхар хананы цаана айлууд суудаг юм гэж бодсонгүй.

- Энд тэндгүй байгаа. Нью-Йоркт зүлэг гэж байхгүй. Энэ байшингууд чинь дандаа айлын байр шүү дээ гэж энэ хотыг нэлээд сайн мэддэг байсан Херствүд тайлбарлан хэлэхэд Керри юун дээр ч гэсэн өөрийхөөрөө боддог болж байгаа тул:

Өө тэгвэл онц биш юм байна шүү дээ гэв.

СҮР ИХТЭЙ ОРОН, ЗАЙГУУЛЧИЙН ХҮСЛЭН

Херствүд, Чикагод ямар ч байр жэзэлж байга гэсэн хамаагүй Нью-Йоркт далайн өчүүхэн дусал шиг байв. Тэр үед Чикагогийн хүн ам хагас сая орчимд хүрч байсан боловч том том баячуул цөөнтэй бөйлаа. Баячуул нь дунд зэргийн хөрөнгөтэй хүмүүсийн сүр хүчнийг бүрмөсөн дарахаар тийм их бэлтэй болж хараахан чадаагүй байж. Хүмүүсийн хамаг анхаарал нь театр, уран сайхан, нийгэм шашны болон бусад бүхий л салбарт тус нутгийн алдар цуутангаар дүүрчихээд хэр баргийн хүнийг эс анхаарах тийм байдалд ороогүй авай. Чикагод алдаршихад улс төр, худалдаа хэмээх хоёрхон зам байсан бол Нью-Йоркт тийм зам тавь жар байсан бөгөөд тэр бүрийн төлөө хэдэн зуугаараа өрсөлдөж байсан учраас алдар цуутангууд маш олон байв. тэнгист халим энд тэндгүй язганаж байсан болохоор муусайн жижиг загас хэрггүй болж байжээ. Өөр үгээр хэлбэл Херствүд Нью-Йоркт юу ч биш байлаа.

Тиймэрхүү байдалд аюултай тал байдаг боловч түүнийг төдий л анхаардаггүй өнгөрдөг учраас элдвийн эмгэнэлт явдлын эх үүсвэр болох тал байдаг. Ихэс дээдэс нь доордост муугаар нөлөөлөх уур амьсгалыг буй болгодог. Тийм амьсгал амрахан түргэн тардаг. Сүрлэг орд харшуудын дундуур, гоё ганган сүүх тэргэн дотор, алт мөнгө гялалзсан дэлгүүр, гуанз, төрөл бүрийн зоогийн газруудаар ороод үзсэн ч, анхилам үнэртэй цэцгэс, торго дурдан, сархдын үнэр авсан ч, хээнцэр ганган, хөгжөөн баясгалант газруудын дотроос хадах инээдэм хөхрөлдөөнийг сонссон ч, хуйнаас нь сугалсан сэлэмний өнгө шиг гялсхийх нүдний харцыг ажсан ч, эрхэмсэг дээдэс хүчтэнгүүдийн уур амьсгал гэгч юу болохыг мэдэж болох ажээ. Энэ бол жинхэнэ сүр жавхлан биш гэж мэтгэхийн хэрэгцээ алга. Бүгдээрээ тэр баялгийн төлөө эрмэлзэж, түүнийг эзэмшихийг хүн төрөлхтөн амьдралынхаа гол зорилго гэж үзэж байгаа цаг тэр уур амьсгал хүний сэтгэл санааг эвддэг зүйл хэвээр байх болно. Тэр бол химийн хорт бодис л гэсэн үг. Түүний нэг өдөр нь химийн хорт бодисын нэг дусал мэтээр бидний ойлгоц, хүсэл, эрмэлзлийг өөрчилдөг болохоор тэдгээрт маань арилшгүй ул мөр үлдээж байна. Долингоршоогүй оюун ухаанд тийм нөлөөний нэг өдөр нь, дадаагүй биед хар тамих хэрхэн нөлөөлдгийн адил юм. Нэгэнт нөлөөд нь автвал утга учиргүй нүгэл, үхэлд зайлшгүй хөтлөн аваачдаг хүсэл мөрөөдлийн зовлон эхэлдэг юм. аяа, бүтээгүй хүслэн гэдэг үү. Хүний хүсэл шуналыг дуудан өдөж даллан уриалсаар эцсийн эцэст үхэл ялзралд хүч нь эвдрэн бусниж хүнийг заяаных нь чанарт оруулнам.

Херствүдийн насны зан араншинтэй хүн бол хоосон мөрөөдөл, залуу насны гал халуун хүсэлд автах нь үгүй, залуу хүний сэтгэл зрхэнд усан цацал адилаарундрах итгэл найдварын хүчгүй билээ. Эндхийн уур амьсгал нь арван найман настай хүний сэтгэл зүрхэнд оргилж байдаг тийм хүслэнг бий болгож чадахгүй байна. Тэгэхлээр ийм уур амьсгалд хэзээ ч дасаж чадах найдваргүй байгаагийн улмаас Херствүдийн гаслан улам зузаарна. Херствүд энэ хотод ирж байсан болохоор энэ хотын бүхий л бололцоог ашиглаж, тохитой аж төрж чадахыг сайн мэдэж байсан юм. Нью-Йоркт түүний хүндэтгэн эрхэмлэж байсан бүхэн нь буюу эд хөрөнгө, албан тушаал, алдар нэр энэ бүхэн нэг дор бөөгнөрсөн тул сүрдэн зүрхшинэ. Зоогийн газрын эрхлэгч байхдаа аяга тагш юм хувааж уух завшаан гардаг байсан тэр нэр цуутангуудын ихэнх нь чухам энэ үй олон хүнтэй хотоос хөлсөн улс байлаа. Энэ хотын орд харш, тэдгээрт оршин суугч хүмүүсийнх нь тухай үлгэр домогт гардаг юм шиг хачин сонин юм дуулддаг байжээ. Насан турхруугаа баячуултай хаяа хатган суух боловч зуун мянга буюу таван зуун мянган доллартай байлаа ч гээд нижгэр баячуулын хэртэй туйлахад бэнчин хүрдэггүй юм гэнэлээ гэдгийн үнэн болохыг энд ойлгож болох ажээ. Нийтийн дотор нэр цуутай баян болохын тулд, хүний хойно орохгүй гэвэл хэмжээлшгүй их хөрөнгө хэрэгтэй болох тул энэ хотод ядуу хүн амь зуухын аргагүй юм. Хань нөхдөөсөө тасарч амин зуулга төдийгүй нэрээ алодаж амь зуухын эрхэнд энд мунгинаж яваа

Херствүд элдвийг сайтар эргэцүүлэн бодлоо. Өвгөн хүн биш байсан боловч мөдхөн өвгөрнө гэдгээ мэдэхтэй ухаалаг байв. Тийм ч учраас гангалж гоёсон, итгэл төгс, хүч тэнхээтэй яваа хүмүүсийг хархаас онцгой санагдана. Тэр хээнцэр ганган байдал өөрийнх нь арчаагүй хоёр газар тэнгэр газар шиг ялагаатай байлаа л даа.

Түүнийг арчаагүй муу явааг хэн ч мэдэхээр болоод байв. Баригдахаас айхаа байлаа ч гэсэн энэ бол амар жимэрсуухын Sinequanon биш гэдгийг Херствүд төдхөн ойлголоо. Нэг аюулаас мултралаа гэхэд дахиад л нэг аюул гачигдахын зовлон залгажээ. Ганц жилийн дотор одоогийнхоосоо тав дахин их хөрөнгөөр туйлж байсан хүн маань мянга гурван зуу гаруйхан долларыг Керрийн хамтаар таван жилд орон байр, хоол хүнс, хувцас хунар, юм хүм үзэхэд хэргэхийн төлөө зүтгэх хэрэгтэй байлаа. Херствүд, Нью-Йоркт ирсэн анхныхаа өдрөөс эхлэн энэ талаар бодсон учир эртхэн шийдэмгийхэн хөдлөхгүй бол болохгүй гэж боджээ. Өглөөний сонингуудад зарласан худалдаа наймааны ажлын зарлал үзээд ажил эрэхээр гарчээ.

Ажил хайхынхаа өмнө орон байрны талаар асуудлаа шийдсэн байв. Керри хоёул хамт яваад Амстердамын их талбайн Далан наймдугаар гудамжны таван давхар байшингийн гуравдугаар давхрын нэг байранд оржээ. Тэр гудамжны байшингууд нь алаг цоогдуу байсан болохоор зүүн талын цонхоор нь Төв цэцэрлэгийн ногоон модны орой, баруун талын цонхоор нь Гудсон мөрний ус цэлийн харагддаг байв. зургаан өрөөтэй халуун устай тэр сууцны хөлсөнд сар бүр гучин таван доллар төлөх байсан нь тэр үедээ дундаж хөлс байсан боловч Херствүдийн зардалд мэдэгдэхүйц жинтэй байв. Керри эндхийн сууцны өрөөний хэмжээг Чикагогийнхтай зүйрлэн үзэж энэ тухайгаа Херствүдэд хэлэхэд:

- Хуучин байшингуудада орвод дээр юм олдох байх, гэхдээ тохиологийн хувьд эндхийнхээс дор шүү дээ , хонгор минь гэв.

Баяр нь шинэ бөгөөд хүрэн модон хэрэглэлтэй учраас Керри их л сонирхож байв. төвийн халаалгатай байсан нь тун их тохилог болгожээ. Цахилгаан зуух, халуун хүйтэн ус, өргүүр шат, ярьдаг хоолой, жижүүр дуудах хонх зэрэг нь залуу хүүхэнд их тааламжтай санагджээ. Иймэрхүү юмыг үнэлж үзэх гэрийн эзэгтэйн шинж Керрид чамлалтгүй байв.

Херствүд, сууцныхаа дотоод төхөөрөмжийн талаар нэг компанийхантай тохиролцон бүрэн тохижуулсных тавин доллар бэлэн төлж бусад үний нь сар бүр арван доллараар төлж байх болжээ. Зэсэн дээр “Ж.В.Вийлер” гэсэн үсэг цохиулж үүдэн дээрээ шуудангийн хайрцагныхаа дээр хадуулжээ. Анхандаа хаалгачин, Керрийг Вийлер хатагтай гэж дуудахад хачин мэт санагддаг байсан боловч сүүл сүүлдээ дасаж өөрөө яг тийм нэртэй юм шиг санах болов.

Херствүд орон байраа тохижуулж авсны дараа сонинд гарсан зарлалаар хөөж ямар нэг зоогийн газар хувь нийлүүлэн ажил явуулахаар шийдэж нэлээд хэдэн газраар орсон боловч өөрөө урьд Адамс гудамжинд сайхан зоогийн газар эрхэлж байсан учир тэдгээр нь тун доожоогүй санагдаж хий дэмий хэдэн өдрөө гарзадлаа гэж бодсон ч зарим талаар ашигтай хэдэн зүйл сонсож авсан байв. Жишээ нь: Таммани Холл хэмээх харгис байгууллага байдаг тэр бол тус хотын бүхий л амьдралд айхтар их нөлөөтэй, ер нь цагдаагийн газартай тун сайн харилцаатай байхгүй бол горьгүй гэдгийг мэдэж авав. Хамгийн их хөлжиж өөдраг яваа зоогийн газрууд гэдэг нь Фицжеральд Моин эрхэлсэн хууль зүйг хичээдэг зоогийн газраас тэс өөр харин ч хуулийг аль болохоор зөрчиж байдаг болохыг мэдэж авчээ. Орлого ихтэй нэг нь хоёрдугаар давхартаа тусгай нууц уулзааны өрөө, архидлагын газартай ажээ. Тэр зоогийн газруудын эздийн өег байдал, цамцныхаа ханцуйд хийсэн очир алмасан тээг, цэвэр нямбай хувцас зэргийг ажихад сархдаар

худалдаалах нь их олз омгийн ширгэшгүй ундарга болдог нь тодорхой байлаа.

Херствүд хайж явсаар хамгийн сүүлд нь Воррен гудамжинд байдаг нэг зоогийн газар очвол тэр нь овоо юм шиг санагджээ. Бага сага тордвол нэлээд тохилог юм байна. Эзэн нь тэрнийгээ их магтаж байх ба нээрэн ч аюулын олз омогтой юм шиг байв.

Худалдаачин, доншуур наймаачин гэээд л бусад мэргэжлийн зэгсэн бэлтэй улс л манайд ордог юм. Явуулын улсыг хавьтуулдаггүй гэж эзэн нь ярив.

Херствүд кассанд нь орж буй мөнгө, тэдний явуулж буй худалдаа наймааны ажлыг ажин хэсэг зогслоо. Тэгснээ:

- Танай орлого чинь хоёр хүнд хангалттай гэж бодож байна уу? гэхэд цаадах нь:

- Хэрэв та энэ талаар ажил хэргийг мэддэг бол өөрөө ажаад андахгүй ойлгох болно. Энэ бол миний эзэмшиж байгаа хоёр газрын зөвхөн нэг нь. Нөгөө нь Насау гудамжинд байдаг юм. Би хоёуланд нь зэрэг ажиллаж чадахгүй байна. Хувь нийлүүлэх аятай хүн тааралдаж гэм хувь хөрөнгөө аваад тэрнийгээ эрхлүүлэхэд болох л байна гэхэд Херствүд:

- Би бага зэрэг туршлагатай хүн л дээ гэж тоомжиргүйхэн хэлсэн боловч Фицжеральд, Моин зоогийн газрыг эрхэлж байсан гэж хэлэх зүрх хүрсэнгүй.

- Тэгвэл та өөрөө л мэддээ гэж эзэн хэлэв.

Тэр хүн зөвхөн гурван хувийн орлого өгнө, мянган доллар нийлүүлгэнд авна, тэгээд зоогийн газраа эрхлүүлнэ гэжээ. Үндсэн хөрөнгөөс орлого бодохгүй юм байж.

Тэр ажлын болзол нэлээд зүгээр мэт Херствүдэд санагдсан боловч сардаа зуун тавин долларын орлого орох эсэх нь мэдэгдэхгүй байв. Херствүд өөрийн гэр орны бүх зардалд сардаа тэдий хэрийн мөнгө орно гэж тооцоолж байжээ. Зөндөө олон газраар ороод тохиром юм олдохгүй байсан болохоор Херствүд удаанаар бодож дүлэгнэхийн араггүй болж ямар ч гэсэн гурван хувийн орлого нь сардаа дор хаяад зуун доллар оруулах биз, цаашдаа нэмж олж болох байгаа гэж сэтгээд хувь нийлүүлж ажиллахаар болж мөнгөө өгөөд маргаашаас нь эрхлэгчийнхээ ажлыг хийж эхлэх болов. Тийм ажил олсондоо хөрөөч Керрид сайрхан ярьсан боловч удалгүй сэтгэлий нь зовоож элдвийг бодоход хүргэх юм гарч ирлээ. Түнш нь зан муутай, архинд дуртай, ууж согтууран агсам тавьдаг золиг шиг амьтан байжээ. Ажил дээр тийм юм гарахыг Херствүд насандаа үзээгүй явжээ. Түүнээс гадна орлого нь тогтмол биш байлаа. Чикагод байсантай нь огт адилгүй, орж гарах хүн амьтан нь тогтмол биш, яаруу сандруу орж ирээд гардаг хүмүүс л голцуу байх болохоор үг солих ганц ч хүн олдохгүй байх нь Чикагод байсантхй зүйрлэхэд даанч уйтгартай санагдана.

Түүнээс гадна дунд зэргийн зоогийн газрын чимэг болж хол ойрын элдэв сонин зүйл тарааж суудаг сайхан хувцасласан алдар цуутай буюу нийгмийн сор болсон тийм хүмүүсийг Херствүд үгүйлэх болжээ. Бүхэл сар болоход ганц ч тийм хүн үзэгдсэнгүй. ажлынхаа газар эл хуль оргиод оройн сонин харж суухдаа урьд аяга тагш юм хувааж, олон удаа цагийг хамт өнгөрөөж байсан зарим нэр цуутай хүмүүсийн тухай хааяа дурдсан байхыг олж үзнэ. Тийм хүмүүс бол Фицжеральд Моин зоогийн газар юмуу Хоффман хэмээх зоогийн газраар л явна уу гэхээс биш энэ хавиар шагайхгүй гэдгийг Херствүд мэдэж байлаа.

Ядахнаа энэ эрхэлсэн ажил нь орлогоор санасанд нь хүрэхгүй байсан болохоор гэр орныхоо зардлыг аль болохоор багасгахад хүрч байлаа. Энэ нь түүнд их л доромж санагдана.

Эхний үед ажлаа дуусгаад орой хүрч ирж Керритэйгээ хоол ундаа идэж уух тун сайхан байжээ. Зургаа долоон цагийн хооронд үдшийнхээ хоолыг идээд өглөөний есөн цаг хүртэл гэртээ байх бололцоотой байв. Гэвч удалгүй уйдаж эхлэн эрхэлсэн ажил нь баахан олхиогүй санагдах болжээ.

Ажил эрхлээд бараг нэг сар болж байхад нэг өдөр Керри:

- Энэ долоо хоног гадуур гарч хувцас хунар авдаг юм билүү гэж тун амархан юм бодож хэлжээ.

- Ямар хувцас?

- Өө, яах вэ, гадуур гарахад л өмсч болохоор юм авах гэсэн юм.

- Тэг л дээ гээд Херствүд инээмсэглэсэн боловч санхүүгийнхээ боломижийг бодохлоор одоохондоо тийм юм авахгүй байвал сайнсан гэж бодов. Энэ талаар дараа өдөр нь тэр хоёр юу ч ярилцсангүй харин нөгөөдөр өглөө нь Херствүд ингэж асуув:

- Чи хувцас авсан уу?

- Аваагүй л байгаа шүү гэж Керри хэлэв.

Херствүд нэг юм бодож байгаа юм шиг хэсэгхэн дуугай байснаа:

- Чи хувцас авахаа хэд хоног хүлээхгүй юу? гэхэд Керри:

- Бололгүй яахав гэж хэлэхдээ Херствүдийг мөнгөөр дутагддаг хүн гэж ер боддоггүй байсан болохоор яах гэж тэгж хэлж байгааг нь ойлгоогүй боловч сониучилж:

- Яагаад тэр билээ? гэв.

- Би бүх мөнгөө хувь нийлүүлэх ажилд өгчихсөн болохоор бэлэн мөнгөөр тааруухан байна шүү. Гэвч мөнгөө удалгүй эргүүлж авах гэж найдаж байна гэв.

- Өө, тийм байлгүй, чи надаад түрүүний хэлэхгүй яасан юм гэж Керри цовоолгоор хэлэв.

- Хэлээд байх хэрэгцээ уг нь байгаагүй юм л даа.

Керри хэдийгээр үг дуугүй зөвшөөрсөн боловч Херствүд, Дрүэ хёр нэг зүйл дээр адилавартай байна гэж бодов. Юу гэвэл Дрүэ ямагт шалтгаан зааж имй тийм нэг ажил дуусгаад ингэнэ тэгнэ гэж хойш тавьдаг зантай хүн байж. Энэ бол агшин зуурын бодол боловч бас ямар нэг шинэ юм цухуйлгасан зүйл юм. Херствүдийн талаар Керрийн бодсон шинэ зүйл байлаа.

Иймэрхүү аар саархан юм цаашдаа олширч сүүл сүүлдээ Керрид юм бодогдуулах болжээ. Керри бол маанаг хүн огт бишээ. Ханилан суусан хоёр хүн бие биенээ ойлгохгүй удаан байж болдоггүй. Нэгнийх нь сэтгэлийн зовлон нөгөөдөө хүссэн ч хүсээгүй ч заавал мэдэгдэж таарна. Бишдэж эхэлбэл тэгсгээд аяндаа мэдэгддэг л дээ. Херствүд аятайхан хувцасладаг хэвээр байсан боловч

Канадад өмсч байснаасаа илүү юм байсангүй. Хувцас хунараар барагтайхан байсан хэрнээ нэмж авахгүй байгааг нь Керри андахгүй байлаа. Бас үзвэрийн газраар явах нь цөөн, хоол ундны талаар юм дуугарахгүй, ажилдаа л нэг их дарагдсан хүн шиг дуу шуу багатай байдаг болжээ. Өнөөх өгөөмөр, амарлингуй, Херствүд биш болж, яах аргагүй их хувирсан байна.

Үнэхээр зан нь хувирч нандин юмаа ч аминчлан ярихаа больсныг Керри төдөлгүй анзаарав. Юу болж байгаагаа ярихгүй нуугаад, ганцаараа бодол болдог болов. Керри юухан хээхнийг ч гэсэн заавал асууж мэдэхэд хүрч байв. Энэ бол эмэгтэй хүнд тун эвгүй зүйл. Бие бизндээ мих хайртай бол ийм юмыг өнгөрөөж болдог, гэхдээ л юм үлддэг, харин тийм хайргүй хүмүүс бол дотроо муу юм бодож эхэлдэг юм.

Үнэнийг хэлэхэд Херствүд муугаа үзэж буй боловч ихээхэн тэвчээр гарган яваа хүн ажээ. Маш аюултай алдаа хийж баларсан боловч энэ зэрэг яваагаа бас яамай гэж бодох ухаантай хүн мөн атал хуучин байдлаа одоогийнхтойгоо харьцуулан бодох нь цаг тутам, өдөр хоног өнгөрөх бүр улам их болжээ.

Хажуугаар нь хуучин танил тал явсан хүмүүстэйгээ тааралдах бий гэхээс зүрх алдах болсон нь энэ хотод ирээд удаагүй байтал Бродвейгээр явж байхдаа нэг тийм хүнтэй тааралдсанаас хойш бүр их нэмэгджээ. Тэр хүнтэй яг тааралдаад хоёул бие биенээ таньсан болохоор цаадах нь шууд ойртон ирэхэд танихгүй царайлах арга олдоогүй юм байж. Чикаго хотын бөөны худалдааны нэг пүүсийн төлөөлөгч хийдэг хуучин танил найз тэр хүн нэгэнт тийнхүү тулгарса учир эргэлзээхийх янзтай байсан боловч гар сунган:

- Сайн байна уу? гэхэд нэгэн адил балмагдсан Херствүд:

- Сайн, юутай байна гэв

- Зүгээр. Би энд бага сага юм худалдаж авах ажлаар л явж байна. Чи энд суудаг бол уу юу?

- Тийм. Воррен гудамжинд байгаа шүү дээ.

- Өө, тийм үү? Сайн байна. Би очиж уулзанаа.

- Тэгээрэй.

- За баяртай гээд нөгөө хүн нь найрсгаар инээн цааш явав.

Херствүд түүнийг тийнхүү яваад өгмөгц дотроо, “Миний хаягийг ч тодруулж асуусангүй, ирнэ гэж худалд хэлж байгаа юм байна” гэж бодоод духныхаа дааварлаж ирсэн хөлсийг арчиж үүнээс хойш л таньдаг хүнтэйгээ тааралдахгүй юмсан гэж чин үнэнээсээ бодож байв.

Угаас нэлээд бодь сэтгэлтэй хүн байсан боловч иймэрхүү аар саар юм зан араншинд нь их нөлөөлөх болжээ. Хөлжөөд л авбал юм бүхэн сайнаар эргэнэ гэж найдаж байв. Керрийг гэргийгээ болгочихсон, байрныхаа төхөөржмийн хөлсийг цаг тухайд нь төлчихөөд байгаа, ажил төрөл маань овоо өөдрөг байна. Керрийг зугаацуулж юм хүм үзүүлэхийн хувьд одоохондоо энэ хярааны байхад болох л юм байна. Яваандаа болох байгаа гэж бодно.

Мань эр, хүний зан чанар хэврэг талтай байдгийг гэр бүлийн амьдралын бэрхшээлийг сайтар

бодоогүй байжээ. Керри бол залуу хүн. Аль аль нь ааш гаргах цагтаа гаргадаг нь мэдээж. Дэндвэл хоол идэж суух зуураа ч гэнэт дүрсхийн хэрүүл маргаан үүсэж мэдэх л байлаа. Тиймэрхүү юм ямар ч сайхан гэр бүлд гардаг л даа. Аар саархан юмнаас болсон тийм явдлыг хоёр биендээ үнэнхүү хайртай улс бол ор мөргүй мартаж чадна, харин тийм хайргүй бол атгаг санаад сүүлдээ бүр даамжирна.

АЗТАЙ ХҮН. БРОДВЕЙН БАЯСГАЛАН

Шинэ хотын болон өөрийнх нь байдал Херствүдэд зовлонтой санагдаж байсан бол хүний эрхээр явж байгаа Керри хотыг туйлын их сонирхон сэтгэгдэл сайтай байжээ. Эхлээд төдий л гайхалтай санагдаагүй. Нью-Йорк сүүл сүүлдээ дур сонирхлыг нь татаж эхэлсэн билээ. Тунгалаг агаар, хүн ихтэй гудамж талбай, хэн хүнийг огт үл анзаарах энэ бүхнийг Керри ихэд гайхаж байжээ. Өөрийнх нь сууж байгаа тийм жижиг өрөө тасалгаа байдгийг мэдэхгүй боловч санаанд нь таарч байв. Шинэ модон хэрэгсэл нь гоёмсог харагдах бөгөөд сав суулганы шүүгээ нь Херствүдийн бүрдүүлсэн гоё сайхан сав суулгаар дүүрэн гялалзана. Өрөө бүрдээ тохирох зохих ёсны зүйлсийг тавьсны дотор хүлээн авах өрөөндөө Керрийн хүссэнээр төгөлдөр хуур авч тавьжээ. Керрид туслуулахаар шивэгчинтэй болж, Керри төдхөн хоол хийхдээ тун чадамгай болсон байв. Керри амьдралдаа анх удаа хүний зүй ёсны эхнэр болон хүмүүсийн нүдэнд зөв харагдах болов гэж өөрөө ч бодох болжээ. Бодол санаа нь гэнэн хонгор болохоор наад зах нь нэг байшинд байгаа арван айл олон жил болсон хэрнээ яагаад танилцахгүй, бие биенээ хайхрахгүй байдаг юм, хачин юм гэж бодно. Яагаад далайн хөлөг, усан онгоцууд манан будан дотор олон зуугаараа яндангаа чих дөжрөм удаан дуугаргаж байдаг юм бол гэж ч гайхна. Далайн зүгээс тийм дуу чимээ гарч байгаа нь хүртэл гайхмаар санагдана. Цонхоор нь цэлийн харагдах Гудсон мөрний ус, энд тэндгүй сүндэрлэн босож буй асар том байшингуудыг харах бүхрдээ сонирхоно. Энд түмэн бодол төрүүлэх юм даанч олон бөгөөд бүхэл жилийн турш дандаа шинэ сэтгэгдэл төрүүлэх юмаар дутахын зовлон байхгүй, уйдаж сонь буурах явалгүй байжээ.

Бас нэг зүйлийг өгүүлэхүл: Херствүд Керрийг хайрлах нь ихээхэн онцлогтой байв. Өөрөө хичнээн их сэтгэлээр шаналж байвч Керрид тэр тухайгаа хэзээ ч мэдэгдэхгүйг хийчээнэ. Урьдын адил толгой дээгүүр цээж түрсэн байдалтай явна. Шинэ нөхцөл байдалд түвэггүй зохицож, Керрийн авьяас, бага сага амжилтад баярлаж байлаа. Орой бүр тогтмол цагтаа хүрч ирэхэд хоол бэлэн ширээ сайхан зассан байхыг хараад ямагт баярлана. Тэр өрөө нь жижиг учраас тохилог сайхан мэт санагддаг байжээ. Өрөөнд юу хэрэгтэй вэ тэр бүхэн нэгд нэгэнгүй байх шиг, таатай харагдана. Цас шиг цагаан бүтээлгтэй ширээн дээр өнгө өнгийн шаазан таваг өрж, улаан даавуу бүрхүүлтэй дөрвөн салаа чийдэнтэй гэрэлтүүлэг тэдгээрийг нүдэнд зөөлөн өнгөөр тусгана. Керри, шивэгчнийхээ хамт шарсан мах, котлетыг тун амтлаг бэлдэж дээр нь лаазтай зүйлээр хачирласан нь өө хэлэхийн аргагүй ажээ. Керри, нарийн боов хийх урлагт боловсорч төдхөн өөрийнхөө хийсэн нарийн боов дүүрэн тавгуудыг ширээн дээр баяр бахдалтайгаар тавьдаг болжээ.

Иймэрхүү маягаар хоёр, гурав, дөрвөн сар өнгөрөв. Өвөл болж түүний хамт гэрээс гарах хэрэгцээ багасахад театрын талаар яриа ч цөөрч ирэв. Херствүд гэр орныхоо зардлыг хүргэх гэж ихээхэн ковж байсан боловч үүнийгээ огт мэдэгдэхгүйг хичээж байв. Орлогоо ирээдүйд их болгохын тулд олсноо эргүүлж хийгээд байгаа мэтээр Керрид хэлдэг байв. Өөрөө тун цөөн мөнгө зарж, Керрид ч гэсэн юм хүм худалдаж авахад нь гар их татаж байж тэр нэгэн өвлийг баржээ.

Хоёр дахь жилийн нүүх үзэхэд эрхэлсэн ажил нь зэгсэн өөдрөг болж Херствүдийн хүсэж байсан зуун тавин долларын орлого сар бүр орох болжээ. Харамсалтай нь энэ завсар Керри олон юм үзэн дотроо нэлээд юм бодох болж, Херствүд ч хэд хэдэн танилтай болж авсан байлаа.

Керри, угаас эршүүд нүүрэмгий биш даруу номой зантай хүн болохоор тухайн байдлаасаа даврахгүй байлаа. Бишгүй л болж байна гэж сэтгэл өег байна. Хааяа театрт нөхрийн хамт орно, тэнгисийн эргэ буюу хотын үзэсгэлэнт газруудаар тун ховор өдрийн од шиг явна. Херствүдийнх

айл хөршгэй танилцаж орж гардаггүй байлаа. Херствүд анх Керрийг эргүүлж байхдаа жигтэйхэн наалинхай цэмцгэр амьтан байсан бол одоо түүнийгээ больж эрээ цээргүй болсон нь зүй. Хоорондоо үл ойлголцох юмуу санал зөрөлдөх юм гарахгүй байлаа. Үнэнийг хэлэхэд мөнгө багатай, танил тал гэх юмгүй хүнээс хардаж сэдмээр юу гарах билээ. Керри түүний ажилдаа чармайн зүтгэж байгааг нь сайшааж байсан болохоор Чикагод байсан шигээ зугаа цэнгэл хөөцөлдөж чадахгүй болсондоо гонсойхгүй байв. Нью-Йорк хот бүхэлдээ, өөрийнх нь орон байр ч гэсэн Керрид таалагдсан хэвээр ажээ.

Херствүд олз омог нэмэгдээд ирэхийн хамт танил талтай болж эхэлснийг дээр удрыдсан билээ. хувцас хунар ч нэлээд авах болжээ. Гэр орныхоо амьдралыг ихэд тоож байсан боловч заримдаа өөр газар наргихыг болох талтай зүйл гэж бодох болжээ. Анхны удаа гэрийнхээ хоолыг идэж чадахгүй болсон тухайгаа хүнээр хэлүүлж ажил гараад цагтаа очиж чадахгүй нь гэж мэдэгдсэн байна. Керри хоолоо ганцаар идэж суухдаа дахиад л ийм юм битгий гараасай гэж бодож байв. Хоёр дахь удаагаа ирж чадахгүй болсон тухайгаа мэдэгдсэн боловч цаг их өнгөрсөн хойно хожуу хэлүүлжээ. Гуравд ахь удаагаа бүр хэл сураггүй алга болсноо сүүлд нь учирлан тайлбарлажээ. Тэгэхдээ тэр явдал бол ойр ойр биш хэдэн сарын дотор болсон хэрэг л дээ.

- Жорж, чи хаана байв? гэж Керри анх удаа асуусан юм байж.

- Ажил дээрээ, зарим тооцоо хийж дуусгах хэрэгтэй байв.

- Гэртээ ирээгүй чинь тун харамсалтай, би хичнээн сайхан хоол хийгээд хүлээж байсан гэж бодно гэж Керри эелдгээр хэлэв.

Хоёр дахь удаадаа бас л тийм шалтаг зааж өнгөрсөн боловч гурав дахь удаад нь Керри дотроо нэлээд өөр юм бодон уурлажээ.

- Тун их ажил гараад гэртээ ирж чадсангүй гэсээр Херствүд шөнө орой болсон хойно ирээд хэлэхэд:

- Хүнээр хэлүүлчихэж болсонгүй юу? гэж Керри өөрийнхөөрөө зүтгэв.

- Уг нь хэлүүлье гэж бодож байсан боловч ажилдаа үхэлдэж байж мартчихаад нэг мэдсэн чинь дэндүү орой болчихсон байлаа.

- Би хичнээн сайхан хоол бэлдээд байсан гэж санана.

Херствүд, Керрийг ажигласаар ёстой л гэрийн эзэн авгай байхдаа таарсан хүн юм гэж боджээ. Херствүд, Керрийг Чикагод байхдаа урлагийн талаар авьяастай байсны нь мэдхээс гадна энд ирээд амьдралын эрхээр гэрийн мухар сахиж ганц ч танил талгүй өөрийг нь бодоод гэр орноо бодоод бүхэл жил болсон хойно тийм хачирхмаар дүгнэлт хийжээ. Тийм дүгнэлт нэгэнт хийсэн хойно ийм эхнэртэй болсондоо санаа нь амарч имйрэхүү байдлаар байгаад байж болох юм чинь илүү дутуу юм өгөх ч хэрэггүй, үзүүлэх ч хэрэггүй гэж бодох болжээ. Тэгээд оромжоо тордоод, хоол унд залгуулаад, зохих шаардлагатай хувцас хунары нь авч өгөөд о хот орны элдэв дур сэтгэл булаасан юм үзүүлэх ч хэрэггүй, хүн амьтантай танил тал болгох ч хэрэггүй гэж бодно. Тэгдээ нэг удаа театрт ганцаараа орсон байна. Бас нэг удаа шинэ найзуудтайгаа покер тоглож өнгөрөөжээ. Мөнгөн орлогоо нэмэгдээд ирэхийн цагт тиймэрхүү зан гаргаж эхэлсэн боловч Чикагод байсантайгаа адил тэгж туйлах бэнчин ч арай байсангүй. Түүнээс гадна таних хүн

хартай тааралдах вий гэхээс үхтлээ айдаг болохоор их хөлийн газраар явж чадахгүй байв.

Керри сүүлл сүүлдээ бага зэрэг хар авч байсан боловч угаас тиймэрхүү юмнаас нэг их сүйд болтлоо дөвчигнөдөг хүн биш. Херствүдэд угаас нэг их гүн хайртай биш байсан болохоор хардаж сэрдэж зовох юмгүй байлаа. Керрийг тийнхүү амарлингуй байгаад ч Херствүд баярлах боловч, чухам яагаад тийм байдаг юм бол гэж учир шалтгааныг нь хөөцөлдье гэж бодсонгүй. Гэртээ ирсэнгүй гэж Керри сүйдтэй юм болгож эс загнана. Хүн хартай уулзаж ярилцах, орж гарах газар, зөвлөж ярих нөхөд байлгүй яах вэ гэж бодно. Энэ талаар Херствүдийг аргагүй гэж үнэхээр бодох боловч харин өөрийгөө тоохгүй мартагч дээр хүрвэл яавч тэвчихгүй билээ. Ерөнхийдөө гайгүй мэт санагдавч Херствүд нэлээд өөр болж буйг Керри ажиг байлаа.

Далан наймдугаар байшиндаа хоёр дахь жилээ болж байхад тэдний нэг хөршийн байр суларч тэр байранд нь залуухан уарайлаг авгайтай хүн орж, Керри тэр хоёртой танилцжээ. Хоёр айлын дунд нэг өргүүр шат байдгаас болж танилцах зам нээгдсэн юм байж. Өргүүр шатаар дэлгүүрээс авсан хүнс тэжээлийн зүйлсийг гаргаж ирэх, доош нь хог новш хаягдлыг гаргаж хаяхад хэргэлэдэг эвтэйхэн төхөөрөмж байжээ. Тэр өргүүр шат руу ороход тус хоёр байрнаас нэг нэг жижиг хаалга онгойдог юм байж. Хэрэв байрны жижүүрийг шүгэлдэхэд зэрэг сонсвол хоёр айлаас гарах хүн заавал тааралдана. Нэг өглөө Керри сонингоо авах гээд гартал бас тийм зорилгоор хажуугийнх нь шинэ айлын хорин гурав орчим насны, царайлаг, бараан үстэй, хүүхэн гарч иржээ. Тэр хүүхэн шөнийнхөө бошинзтой, үс гэзгээ аялуулаагүй байсан боловч Керрид тун аятайхан, нүдэнд дулаахан санагджээ. Цаадах нь баахан ичиж зовсон янзтай муухан мушийн инээмсэглэжээ. Керри түүнтэй танилцахсан гэж бодогдож байхад цаадах нь Керрийн гүндүүгүй байрын царайг ихэд таашааж бас танилцах хүсэр төрсөн ажээ.

- Манай хажуугийн байранд орсон айлын авгай хүүхэн тун царайлаг аятайхан хүүхэн харагдсан шүү гэж Керри өглөөний хоол идэх зураа Херствүдэд хэлэхэд Херствүд:

- Юу улс юм бол? гэв.

- Би мэдэхгүй. Хонхных нь бичгэн дээр Вэнс гэж байна билээ. хөгжим тун сайхан тоглох сонсодсон, лав тэр хүүхэн байх.

- Энэ хотд ямар янзын хүмүүс байдгийг яаж мдэхэ вэ, тийм ээ? гэж Херствүд Нью-Йоркийнхан хөрш улсаа боддог зангаар ингэж хэлэв.

- Би энд жил гаруй болоход энэ байшинд суудаг есөн айлын ганц ч хүнийг танихгүй байна. Энэ айл нүүж ирээд сар гаруй болоход өнөө өглөө л нэгнийх нь барааг олж харлаа гэж Керри хэллээ.

- Юу нь муу байхав дээ? гэхдээ мяар ч улс байгаа юм билээ, хэн мэдэхэв. Аль өөдгүй амьтдыг тэр гэх вэ гэхэд Керри:

- Тийм дээ гэлээ.

Тэгээд өөр төөр юм ярилцан энэ талаар дахин үг дурсаагүй байтал нэг хоёр хоногийн дараа Керри зах орохоор гартал өмнөөс нь Вэнс хатагтай ирж байгаад тааралджээ. Вэнс хатагтай таньж толгой дохиход Керри хариуд нь инээмсэглэв. Тийнхүү лавтай танилцах үүсгэл эхлэв. Тэгж санамсаргүй тохиолдоогүй бол танилцахгүй байсан байж болох юм.

Тэрнээс хойш Вэнс авгайн барааг харалгүй хэдэн долоо хоног болсон боловч өрөөнийхөө нимгэн ханаар түүний хөгжимдөхийг сонсож тоглож буй сайхан ая дуу болон чадамгай хөгжимдөж байгааг нь бахархаж байв. Керри өөрөө муухан шиг хөгжимддөг болохоор Вэнс хатагтайн тоглох нь урлагийн дээд хэмжээнд хүрч буй мэт санагдаж байжээ. Бага сага сонсож үзэж ажсан зүйлээсээ үндэслэн бодоход тэр хөрш айлын хоёр бол боловсон, чинээлэг улс шиг санагдана. Тийм учраас Керри тэндэнтэй танилцахад дуртай байлаа.

Нэг өдөр Керрийн хонх дуугарахад шивэгчин нь гал тогооны өрөөнөөс товчийг дарж ерөнхий хаалганы цоожийг гаргажээ. Хэн дуудсан юм бол гэж Керри гуравдугаар давхрынхаа үүдэн дээр гараад доош харж байтал Вэнс хатагтай гаднаас орж ирээд:

- Та намайг уучлаарай, би гарахдаа гадаа хаалганыхаа түлхүүрийг мартчихжээ, тэгээд хонхы тань дарсан юм гэв.

Гадаа хаалганыхаа түлхүүрийг марстан улс дандаа л ингэдэг л дээ. Тэгэхдээ уучлалт гуйдаггүй юм байж.

- Зүгээр зүгээр, харин хонх дарсанд тань баярлаж байна. Би ч заримдаа мартдаг юм гэж Керри хэлэв.

Вэнс хатагтай түр зогсож:

- Тэнгэр тун сайхан байна шүү гэв.

Тийнхүү яваа яваандаа ойртож танилцсаар сүүлдээ бие бизнээрээ орж гардаг танил болсон ажээ. Керри тэр залуу хүүхнийг тун их аятайхан хүн гэж таашаажээ.

Тэдний байр адилавар боловч Вэнсийнх арай илүү, танилцаад төдий л их удаагүй байтал нэг өдөр Вэнс хатагтай,

- Та өнөө орой манайхаар орж миний нөхөртэй танилцахгүй юу. Тантай танилцахсан гэдэг юм. Хэзэр тоглодог биз дээ? гэхэд:

- Бага зэрэг тоглоно гэж Керри хэлэв.

- За тэгвэл хэзэр тоглоно шүү. Нөхөр чинь ирвэл аваад орж ирээрэй.

- Өнөө оройн хоолондоо ирж чадахгүй байх.

- Тэгвэл яах вэ, ирсэн цагт нь дуудъя.

Керри тэгье гээд тэднийд ороход Вэнс гэж бүдүүн эр байхыг үзэв. Тэр бол Херствүдээс ялимгүй дүүмэд бөгөөд тэр хөөрөхн хүүхнийг царайгаараа биш мөнгөнийхөө хүчрээр олж суусан болов уу гэж бодмоор. Тэр хүн, Керрийг хармагцаа аятайхан санагдаж налигнан эхлэхдээ хэзэх тоглохыг зааж, Нью-Йорк болон тэр хотын үзмэр зугаалгын газруудын талаар баахан ярилаа. Вэнс хатагтай хөгжимдөж байлаа. Тэгж байтал ч Херствүд орж ирэв.

Керри, Вэнс хатагтайг түүнтэй танилцуулахад:

- Би тантай танилцахдаа баяртай байна гэж хэлээд урьд Керрийг эргүүлэхдээ яаж дур сонирхлы нь татаж байсан шигээ налигнан сайхан аашилж байв.

- Та авгайгаа оргоод алга боллоо гэж бодов уу? гэсээр Вэнс Херствүдэд гараа сарвайн танилцахдаа хэлэхэд.

- Надаас илүү сайхан нөхөртэй болж байгаа юм байх л гэж бодлоо шүү гэж амы нь дагуулж хэлэв.

Тэгээд Херствүд Вэнс авгайтай ярилцан эхлэхэд Керри сүүлийн үед мартагнаж эхэлсэн түүний овжин зулгүй байдал цухалзаж эхлэхийг нэн даруй ажиглав. Бас Вэнс хатагтайг бодвол хувцас хунар дортойгоо мэдэж авлаа. Энэ бол хоосон бодол биш үнэн байдал байсан тул Керри өөрийнхөө байдлыг тодорхой ойлголоо. Амьдралаа уйтгартай байдгийг ухаарч хуучны гуниг нь сэргэж урам зориг нь мохож эхлэв. Хүсэл чадлыг эргэүүлэн бодох болов.

Керри түргэн зантай адгуу хүн биш байсан болохоор яаран цухалдсангүй. Гэхдээ л амьдралын аятайхан боломж тохиолдоход аянд нь хөтлөгдөн явахаас буцахгүй байв. Херствүд юу ч ажсангүй. Керри тэс өөр амьдрал байдаг юм байна гэж бодсон байхад Херствүд тэрний нь ажсангүй. Керрийн нүдэнд уйтгар гунигийн тэмдэг илрэхийг ч анзаарсангүй. Тэр ч байтугай Керри гэрэтээ ганцаар байхаас бүр уйдаж жигтэйхэн сайн найз болж эхэлсэн Вэнс хатагтайтай ямагт хамт явахыг хичээх болжээ.

Нэг өглөө Херствүд Вэнс хоёрыг чиг чигийнхээ ажилд яваад цаг хэртэй болоод байхад Вэнс хатагтай дөнгөж босож хэдсрэн үзмэн хүрэн бошинзтойгоо Керрийн үүдийг тогшин орж ирээд:

- Өглөөний жүжгэнд хоёул явъя гэжээ.

Вэнс хатагтайг ажваас эрх танхи, нөхөр нь их хайрладаг, хүссэн бүхнийг нь биелүүлж өгдөг мэт санагджээ. Тэгээд Керри:

- тэгье л дээ. Юу үзэх гэж байгаа билээ? гэхэд Вэнс хатагтай:

- Нат Гудвинийг үзэх гэсэн юм. Миний бодоход тэрнээс чадамгай али жүжигчин байхгүй байх. Сонингуудад бичихдээ хамгийн сайхан жүжиг гэсэн байдаг шүү гэв.

- Гэрээс хэдийд гарах вэ? Нэг цагт гараад Гучин дөрөвдүгээр гудамжаар явж Бродвейгээр орьё. Түүгээр явахад жигтэйхэн сайхан. Медисон - Сквер театрт шүү дээ гэж Вэнс хатагтай хэлэв.

- Аа, сайхан байлгүй. Билет нь ямар үнэтэй бол?

- Нэг доллараас хэтрэхгүй байлгүй.

Вэнс хатагтай гэртээ орж нэг цагт гарч ирэхдээ маягтай гоё хар даашинз өмсөж түүэтэйгээ өнгө нийлүүлсэн ганган бүрх малгай толгой дээрээ тавьжээ. Керри бас аль байдгаараа гоёж тун ганган харагдлах боловч найз хүүхнийнхтэйгээ зүйрлэхэд даанч их ялгаатай байсан тул зүрх нь шимшрэв. Вэнс хатагтайд алтан эдлэл дээр нь овор нэрийнх нь толгой үсэгтэй ногоон сарсан гар цүнх, угалзаар чимсэн торгон ачлуур гэх мэт Керрид байхгүй олон хөөрхөн юм байв. Тэр эмэгтэйг бодвол Керрийн хувцас цөөн, чанар намбаар хаана нь ч хүрэхгүй байлаа. Тэр хоёрыг

ханилаад явж байхыг харсан хэн боловч илүү ганганаар нь Вэнс хатагтайг илүү шохоорхох биз гэж Керри бодно. Энэ бол яах аргагүй үнэн боловч бас шударга биш талтай юм. Юу гэхэд бие бялдрын хувьд Керри мөн байргашиж төрөлхийн царай зүсээрээ хэний ч дор орохооргүй болжээ. Өмссөн хувцасных нь үнэ цэнэ, загвар маяг ялгаатай боловч хүн бүхний нүдэнд давын өмнө тусахаар тийм содон биш байв. гэлээ ч гэсэн Керри өөрийн байдлыг голж чамлах нь улам их болсон юм.

Бродвейн их гудамжаар зугаалан явах нь тэр үед ч одоогийн нэгэн адил маш сайхан байв. Тэр гудамжаар өдрийн жүжиг эхлэхийн өмнө, дараа нь дэгжин авгай хүүхнүүд гоё ганганаа гайхуулах гэж ирцгээдгээр үльбарам харчуул ч гэсэн аль болохоор гоёчихоод тэр ганган хүмүүсийг шохоорхон сонирхох гэж ирцгээдэг байж. Хотын хамгийн ганган дэгжин царайлаг хөөрхөн гэсэн эмэгтэй эрэгтэй хүмүүс тэнд цуглана. Эмэгтэйчүүд нь хамгийн дэгжин малнайгаа тавьж, гутлаа өмсөж, бээлийгээ хийгээд хөтлөлцөн дэлгүүр хоршоо, театраар явах тул Дөрөвдүгээр гудамжнаас Гучин дөрөвдүгээр гудармж хүртэл тийм хүмүүсээр нэл дүүрнэ. Эрэгтэйчүүд нь ч өөрцгүй хамгийн сүүлдийн үеийн ганган дэгжин гэсэн загварын хувцсаа өмсөж ирцгээнэ. Энэ үед Бродвейн их гудамжаар оёдолчин хүн ирвэл хувцасны дээд зэргийн загвар үзэж, гулатчин ирвэл гутлыг яаж өнгө хэлбэрийг нь тааруулдгийг, талгайчин ирвэл малгай гэдэг яахлаараа хүний толгой биеийн чимэг болж чаддагийг үзэх билээ. Дэгжин хуваст дуртай хүн шинэ хувцасандаа салхи үзүүлэхдээ заавал Бродвейн гудамжаар явадг гэдэг бол үнэн. Өглөөний жүжигтэй өдрүүдэд энэ гудамжаар ямаршуу юм болдгийг харуулсан нэг дуу гарч олны дотор их тарсныг үзэхүл тэнд үнэхээр тийм юм болдог байсныг нотолно. Тэр дуу нь “Бродвейгээр явах ямар эрх түүнд байна” гэсэн нэртэй байсан бөгөөд тус хотын клуб урлагийн газраар ихэд таржээ.

Керри, энэ хотод ирснээс хойш Бродвейд ийм юм болдгийг үзэх байтугай сонсоо ч үгүй байв. Гэтэл вэнс хатагтай аль хэдийн мэддэг байсан төдийгүй харин бусдыг үзэх, өөрийгөө ч үзүүлж гайхуулан шүлэнгэтүүлэх, хувцасны загвар маягаас хоцрохгүй гэж зориуд байнга очдог байсан ажээ.

Гучин дөрөвдүгээр гудамжинд трамвайгаас буугаад найзынхаа хамт сүрхий догь байдалтай явж байхдаа эргэн тойрон миегнэх гоё ганган хүмүүсээс нүд салгаж чадахгүй байв. Сайхан харчуул ганган авгай хүүхнүүдийн ширтэн харцгаахад Вэнс хатагтай гэнэт алхаа гишгээ бие цогцсоо өөрчлөн нохилох байдалтай болоход нь Керри гайхна. Энд хүн рүү мэлийтэл ширтэхийг буруушаадаггүй, харин ч зүйн хэрэг гэж үздэг бололтой. Өөрийг нь ч гэсэн тун олон хүн сонирхон шохоорхож байгааг Керри гэнэт мэдрэв. Өө хэлэхийн аргагүй сайхан пальто, бортгон малгайтай, гартаа мөнгөн балтагтай таяг барьсан ганган харчуул эмэгтэйчүүдийн хажууцгаар шүргэх шахам явж өнгөрөхдөө нүд рүү нь гөлөрч бас зохих хариуг авна. Авгай хүүхнүүд даашинзныхаа хормойг шүрчигнүүлэн явахдаа наалинхайтан инээмсэглэж, үнэртэн танартныг элбэг ханхлуулна. Энд сайн юм муудаа дарагддаг байна. Уруул нүдээ будаж, үс гэзгээ янзлан дэгжирхэж, талимаартан учиртайхнаар ширтэх хүн хичнээн гэж санана. Хээнцэр ганганы үзэсгэлэнгийн газар ороод ирснээ Керри гэнэт мэдрэв. Алт мөнгөн эдлэлийн дэлгүүр алхам бүрд тааралдана. Цэцгийн дэлгүүр, төрөл бүрийн үнэт ангийн үсний болон эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувцасны дэлгүүр дараа дараагаар тааралдана. Гудамжаар дүүрэн сүүх жууз тэрэг зогсоно. Алтадмал товч, туузтай хачин маяглуулж хийсэн зарцын хувцастай хаалгачид, байшингуудын орц хаалган дээр сүрлэгээр зогсоно. Хөх цэнхэр хүрэм, бариу цагаан өмд, хүрэн өнгийн шагайвчтай дэлбэгч нар, дэлгүүрт наймаа хийхээр орсон эзэн авгай нарыгаа хүлээн хүлцэнгүй зогсоно. Бродвей тэр аяараа баячуулын гял цал болсон ертөнц мэт санагдах агаад

Керри тэр ертөнцөд багтаагүйгээ цхаарч байлаа. Керри хичнээн хичээвч тэдний дотор Вэнс хатагтай шиг хэнэггүй догь байдалтай байж чадахгүй, гагцхүү хамт яваа хүүхнээсээ хувцас муутай юм гэж улсууд бодож байгаа байх гэж зовно. Тэгээд олигтойхон хувцастай болж авахаас нааш энд дахин ирэхээ больё гэж дотроо шийдэж, эднээс дутахгүй хувцаслачихаад гайхуулж байхсан. Тэгж чадсан цагт яасан сайхан бол! гэж мөрөөднө.

ВАЛЬТАСАРЫН НАЙР. ТӨЛӨГЧ МЭРГЭН

Керри тийнхүү гадуур зугаалж их сонин сэтгэгдэл төрөөд жүжгийг үзжээ. Гол дүрд тоглодог жүжигчин нь инээдмийн жүжиг тоглох талаараа нэрд гарсан хүн байв. харьшуулах зорилгоор инээдмийнхээ жүжигт хүний уй гашууг харуулсан зүйл бас хольж оруулжээ.

Керри тайзна урлагт ман их дуртайг бид мэдэх билээ. Чикагод нэг удаа дурсаж явмаар их амжилт олж байснаа мартдаггүй ажээ. Оройн цагаар ганцаар эргэлддэг сандал дээр суугаад сүүлийн үеийн марзан романаар хань хийхээс өөр юмгүй ганцаардаж байхдаа тэр тухайгаа санан мөрөөдөх явдал бишгүй олон байв. Жүжиг үзэж суухдаа жүжигчдийн ур чадварын талаар үнэлэлт өгч болох газар нь голж магтмаар газар нь магтана. Зарим газар нь өөрөө тоглох юмсан, тэгвэл ингэнэ тэгнэ гэж хүртэл боддог байж. Үзэх болгондоо гүн сэтгэгдэлтэй буцаж, дараагийн өдөр нь тэр талаар заавал нэхэн санадаг байв. Өдөр тутмын амьдралын аар саар юмаар оролдохын хажуугаар тийнхүү тайзны урлаг сэтгэл зорхийг нь бас эзэмдэж байлаа.

Театрт орох болгондоо амьдралд үзэж туулсан юмныхаа улмаас сэтгэл ихэд догдолсон ирэх нь цөөн байжээ. Харин өнөөдрийн хувьд бол тэр л бүхий үзсэн хээнцэр ганган, баян чинээлэг, баяр хөөртэй ертөнцийн төрүүлсэн хүсэл мөрөөдлийн ая дуу хаа ч байсан намдахгүй сонсогдоор авай. Хажуугаар минь олон зуугаараа өнгөрөн явж байсан тэр эмэгтэй хүмүүс юун улс вэ? Хаанаас тийм их, үнэ цэнэтэй торго дурдан, алт, мөнгөн эдлэл олно вэ? Тэр их ганган дэгжин авгай хүүхнүүд ямар сайхан газар суудаг бол? Хана туургаа торго магнагаар хулдаж, авдар саваа алт мөнгөөр угалзлуулж хөл төвих газар бүхнээ хивсээр бүрсэн байдаг байх даа. Гэр орондоо мөнгөөр худцладаж авч болох бүхнийг багтаж ядталаа чихсэн байж тааран. Тэр голигор агсам сайхан морьд нь ямар сайхан жүчээнд байдаг бол? Зарцын гэхэд тийм сайхан гоёмсог хувцас өмсөөн тэр дэлбэгчид, тэр гоёмсог сүүх жууз тэрэгнүүд нь ямар орон байранд байдаг бол? Орд харшинд нь өдрөөс удтахгүй гэрэл гийж, линхуагаас дутахгүй үнэр ханхалж, гэрийнх нь засал зураг шиг цэмцийж, идэх уух ширээ нь тансаг идээгээ дааж ядан байдаг байх даа. Нью-Йорк хот тийм орд харшаар пиг дүүрэн байх, тэрнээс биш ганган дэгжин, ихэмсэг, гоёмсог, энэ олон авгай хүүхнүүд хаанаас гарч ирэх билээ. Тэднийг дулаан тусгай байранд үржүүлэн өсгөдөг байдаг ч магадгүй. Керри өөрөө тэдний эгнээнд орж чадаагүйгээ бодохоос, хүсэж мөрөөдөж явсан нь бүтээгүйгээ бодохоос зүрх нь шимширч өвдөж байлаа. Сүүлийн хоёр жил тийнхүү ганцаардан суусан, өөрөө тийм хэнэггүй явснаа бодохоос ман их гайхаж, санасан бодсондоо хүрч чадаагүйдээ гонсойно.

Тэр жүжиг нь алт мөнгөн эдлэлээр дүүрэн гэр оронд сууж, торго, дурданд хөрвөж жаргал эдлэх мөртлөө хайр сэтгэл, хар сэрээс болж зовлон эдэлж яваа эр эм хүмүүсийн байдлыг харуулсан сэдэвтэй юм. Тиймэрхүү янзаар амьдрахыг насан туршдаа мөрөөдөж байдаг хүмүүс тиймэрхүү жүжиг үзээд сэтгэл нь их хөдөлдөг билээ. тэр жүжигт юугаар ч эс гачигдах мөртлөө зовж байгаа хүмүүсийг харуулсан байна. Алтан сандал дээр сууж авбал жаахан зовж үзэхийг хэн эс хүсэх билээ. Анхилам үнэр шингэсэн хивс хана туургы нь чимж, агар зандан ширээ сандар гэрээр дүүрч, ажил төрлийг нь зарлаг гоцго нар хийдэг атал зовж үзэх бас сонин биш үү? Тийм байж зовно гэдэг бас гайхалтай сайхан мэт санагдана. Керри тийм байхыг хүслээ. Тийм амьдралын дотор байгаад ямар ч зовлон эдэлсэн яадаг юм, тэгэх бололцоо олддоггүй юм гэлээ гэхэд тийм амьдралыг дүрслэн жүжиглэхсэн гэж хүсэж байв. Үзсэн харсан зүйл нь гүн сэтгэгдэл төрүүлсэн учир тэр жүжгийг үзэхэд ер бишийн сайхан санагджээ. Урлагийн тэр зохимол ертөнцийг жинхэнэ үнэн мэтээр итгэн үзэж суухдаа тэр байдлаас салж буцаад бодит байдалдаа орохыг хүсэхгүй байлаа. Завсарлагаар урд талын эгнээ лоожинд суусан ганган дэгжин хүмүүсийг харж

Нью-Йоркийн талаарх сэтгэгдлээ бас баяжуулав. Энэ хот тэр аяараа жаргал цэнгэл хөгжөөн найрын ертөнц юм гэдгийг одоо л мэдэж авчээ, урьд нь бүхлээр нь үзэж ч чадаагүй байв.

Театраас гараад явахад Бродвей дахин шинэ шинэ юм харуулав. Театрт ирэх замдаа үзсэн харсан юмс нь одоо бүр ч яруу тод, бүр ч туйлдаа хүрсэн байдалтай харагджээ. Тийм жигтэйхэн сайхан юмыг Керри нүдэндээ хэзээ ч үзээгүй явжээ. Ийм амьдралын хагас хугасыг ч гэлээнэ эдлэхээс нааш аж төрж амьд явна гэж бодох байтугай тэгж явах найдлага байна гэж бодох ч эрх алга гэж сэтгэв. Энд авгай хүүхнүүд мөнгөөр ус цас шиг тоглож байхыг харав. Гоё сайхан дэлгүүрүүдийн дэргэдүүр гарах бүрийд ийм болох нь харагдаж байв. Тэр ганган дэгжин авгай хүүхнүүдийн хамгийн голчилдог юм нь цэцэг, алт мөнгө, эрдэнийн чулуу, амттан бололтой. Гэтэл Керри Сард ганц хоёрхон удаа гэрээс гарч иймэрхүү юмаар нүд хужирлахад л арайхийн хүрэх гуйлгачны хэдхэн мөнгөтэй явж байна.

Тэр орой жижиг тохилог байр нь ч олигтой юм биш, хүмүүсийн жаргалаа эдэлж суудаг тийм газар биш санагджээ. Шивэгчнээ хоол хийж байгааг харавч хайхарсангүй. Саяхан үзсэн хошин жүжгийнх нь төрөл бүрийн үзэгдэл байн байн санагдана. Зугтаж зугтаж эцэс сүүлд нь өөрөө сэтгэлтэй хүндээ унаж өгсөн нэг эмэгтэй болж тоглосон гайхалтай царайлаг жүжигчин эмэгтэй Керрид юм болгоноос илүү байн байн санагдаж байв. Тэр эмэгтэйн гоо үзэсгэлэнд Керри биширчээ. Өмсгөл нь урлагийн дээж, зовлон нь маргахын аргагүй үнэн мэт. Гуниг гансрал нь Керрид тун ойлгожтой байв. Тэгэхлээр тэр үзэгдлийг Керри тэр хүүхнээс доргүй тоглож чадмаар санагдана. Зарим газры нь илүү ч тоглож болохоор бодогдож, зарим үгий нь амандаа давтаж байв. Гагцхүү тийм юманд тоглох бололцоо л олддогсон бол, амьдрал маань ямар сайхан уудам уужуу болох бол. Үзэгч олны зүрх сэтгэлийг хөдөлгөж чадахсан гэж бодно.

Херствүдийн орж ирэхэд Керри гунигласан байдалтай бодолд автан эргэлддэг сандал дээрээ цонхны хажууд ганхасхийн сууж байв. Их сонин сайхан юмнууд бодож байсан болохоор тэрнийгээ замхруулахгүйн тулд Херствүдийн асуусан юманд ганц үгээр хариу хэлэх буюу заримдаа хэлэхгүй байв. Херствүд түүний тийнхүү гунигтайхан дуугай байгааг ажиглаж байснаа:

- Юу болоо вэ, Керри? Гэж асуухад Керри:

- Юу ч болсон юм алга, өнөө орой бие жаахан базаахгүй байна гэв. Херствүд дэргэд нь тулж ирээд:

- Бие чинь өвдөө юу, яагаа вэ? гэхэд цаадах нь бараг уцаарлаж:

- За гайгүй дээ. Бие ялимгүй о эвгүй байна гэв.

Херствүд цааш явангаа ялимгүй цухуйсан хантаазаа зассанаа:

- Их муу хэрэг байна даа, өнөө орой театрт юм үзье гэж бодсон юсан гэхэд Керри:

- Би явмааргүй байна. Өнөө өглөө би жүжиг үзсэн гэв.

Тийм сайхан юм бодож суусан хүнийг үймүүлж бодлы нь замхраасанд Керри дургүй байлаа.

- Өө тэгээ юу? Юу үзэв?

- “Алтны уурхай”

- Ямар юм дээ?

- Жигтэйхэн сайхан

- Тэгээд өнөө орой юм үзмээргүй байгаа юмуу?

- Үзээсэй гэж бодогдохгүй л байна.

Гэвч тэгсгээд гуниглахаа байж, хоол ундаа идээд бодол нь өөр болж театрт очихоор болов. Ходоодонд хоол орохоор гайхмаар өөрчлөлт гардаг явдал байдаг шүү дээ. Тийнхүү театрт дахин очсоноор сэтгэлийнхээ доголдлыг түр боловч намтгажээ. Гэхдээ маш гүнзгийгээр юм боджээ. Хичнээн мартаж садаарахыг бодовч амьдралаа чамлах санаа дотроос нь гарч өгөхгүй байлаа. Байн Байн бодогдоно гэдэг бас гайхалтай зүйл! Зөөлөн хатуугаа иднэ гэгчээр салшгүй тэр нэгэн бодол цаагуураа юутай их газар авна вэ.

Тэр өглөөний жүжиг үзсэнээс хойш төдий л удалгүй, нэг сар хэртэй болсон хойно Вэнс хатагтай нэг орой Керрийг бидэнтэй театрт явахгүй юу гэж урьжээ. Херствүдийг оройнхоо хоолонд ирэхгүй гэж тэд Керригээс сонссон байж.

- Бидэнтэй хамт явахгүй юм уу? Гэртээ хоол хийх гээд яах юм. Бид Шеррийн ресторанд ороод тэндээсээ Лицеум театрт очих гэж байгаа юм, хамт явъя л даа.

- Тэгьеэ, тэгье гэж Керри дуртай зөвшөөрөв.

Тэр үед Дельмонико ресторантай өрсөлдөж байсан Шеррийн ресторанд таван цаг хагаст очихын тулд Керри бүр гурван цагаас эхлэн гутлаа бэлдэж эхлэв. Түүний гоёж гоодоход ганган Вэнс хатагтайн нөлөө илт харагдаж байлаа. Сүүлийн үед гарч байсан шинэ дэгжин хувцасны талаар Керрид дандаа хэлж өгдөг байж.

Байсгээд л иймэрхүү, тиймэрхүү бүрх малгай гарч байгаа авахгүй юмуу, дугариг танан товчтой, бээлий гарч байна лээ үзсэн үү? Гэх мэтээр ямагт хэлж өгдөг байв.

- За найз минь дараа гутал авахдаа зузаан ултай, товчтой, лаакан туфли заавал аваарай. Энэ намрын хамгийн шилдэг сайхан загварын гутал юм шүү.

- Баярлалаа, би олж авъя гэж Керри хэлнэ. Дараа нь бас нэг удаад:

- Альтманы дэлгүүрт ямар сайхан цамц гарсан гэж санана. Хичнээн хөөрөхн загвараар хийж вэ. Чамд таармаар нэг цамц байна лээ, би бүр хараад л чамд яг таарах юм байна гэж бодсон гэв.

Тиймэрхүү зөвлөлгөөний нь Керри ганган хүүхнүүдийн хоорондоо ярилцдаг яриа биш нөхөрсөг сайн санаагаар хэлж байна гэж бодох учир хэрэг болгон сонсож байдаг байв. Вэнс хатагтай, Керрийн гүндүүгүй сайн занг нь таашаах учир түүнд хувцасны сүүлийн үеийн загварын талаар зөвлөлгөө өгөхдөө урамтай байв.

Нэг удаа Вэнс хатагтай:

- “Лорд, Тейлорын” дэлгүүрт гарч байгаа цэнхэр хөхө өнгийн саарж даавуун банзал авахгүй яагаа вэ, доогуураа тавиу, одоо л хамгийн дэгжиндээ орж байгаа, тэгээд бас хөх цэнхэр өнгө нь өөрт чинь яг таарна гэжээ.

Керри үгий нь ман их сонирхон сонсож байв. Херствүдтэй бол иймэрхүү яриа ер ярьж үзээгүй байж. Керри сүүлийн үед ийм тийм юм байнга авья гэж хэлэхэд нь Херствүд зөвшөөрч байсан боловч авах зүйлийн талаар таарах таарахгүй гэж огт ярилцдаггүй байв. Херствүд, Керрийн зүгээс шинэ хандлага гарч байгааг ойлгож байсан бөгөөд юм л болбол Вэнс хатагтайг магтах тул хэнд уруу татагдаж байгааг нь мэджээ. Нэг хэсэгтээ юу хэрэгтэй гэсний нь авч өгч байсан боловч сүүлдээ Керрийн хэрэгцээ арай хэтэрч байна гэж бодох боловч өөрийнхөөрөө хайртай байсан болохоор дураар нь шиг л байлгаж байв.

Херствүд, хүссэн бүрийг нь авч өгч байсан боловч тийм юм хүм олж авлаа гэж Керритэй хамт баярлах нь үгүй тул намайг хайхрахаа больж байгаа юм байх даа гэсэн бас нэг сэтгэлийн сэв сууж эхэлсэн байна.

ЯЧмар ч байлаа гэсэн Вэнс хатагтайн зөвлөлгөө талаар өнгөрсөнгүй. Шинэ найз нөхөдтэйгээ театрт очих тэр орой Керри тун аятайхан хувцасласан байлаа. Керри “цайны” ганц даашинзтай ч гэсэн тэр нь тун догь зохих тул их баяртай байв. Керри, хорин хэдэн настай царайлаг хүүхэн харагдах тул Вэнс хатагтай илэн далангүй магтахад Керрийн бумбагархан хацар улаартан, том нүдэнд нь баярласны шинж тодхон.

Бороо ормоор байсан болохоор Вэнс ноён авгайнхаа хүсэлтээр сүүх дуудуулав.

Керрийг тэдний зочдын тохилог жижиг өрөөнд орж очиход Вэнс ноён:

- Танай хар хүн бидэнтэй хамт явахгүй юмуу? Гэхэд Керри:

- Үгүй, явж чадахгүй, өнөө орой хоолондоо ирж чадахгүй гэж хэлүүлсэн байна билээ.

- Тэгвэл бид хаана байгаагаа мэдэгдсэн бичиг орхисон дээр байх. Ирээд бидэн дээр очих зав гарч юу магад.

- Нээрэн тийм, одоохон бичээд орхил гэж Керри хэлэв. Энэ санааг Керри өөрөө сэдсэнгүй.

- Найман цаг хүртэл “Шерри” ресторанд байх болно гэж бичээрэй. Өөрөө мэдэх байлгүй гэж Вэнс нэмж хэлэв.

Керри, хөлийн өрөөгөөр даашинзныхаа охромойг шажигнуулсаар явж гэртээ орж бээлийтэй гараараа бичиг бичиж орхиод тэднийд эргэж ороход гаднаас танихгүй нэг хүн ирсэн байв.

- Миний үеэл дүү Эмс гэдэг хүн. Вилер хатагтай тантай танилцуулъя. Бидэнтэй хамт явах гэж байгаа, тийм байх аа? Боби? Гэж Вэнс хатагтай тэр хүнийг танилцуулав.

- Тантай танилцсандаа баяртай байна гэж тэр залуу Керрид мэхийн ёслоход Керри түүний өндөрш ганагар нуруу, сахал үсээ цэвэрхэн хуссан, залуухан, нэлээд царайлаг болохы нь ажиг.

- Эмс маань Нью-Йоркт хэдхэн өдөр болох юм, бид жаал зугаа юм үзүүлье гэж бодож байгаа юм гэж Вэнс хэлэв.

Керри тэр хүн рүү харж:

- Та явуулын хүн юм биз дээ гэхэд цаадах нь:

- Тиймээ, би саяхан Индианополисоос ирээд байна, энд долоо хоног орчим болно гээд Вэнс хатагтайг гоёлоо дуусгаад гарч ирэхий эь хүлээн исэр дээр суулаа.

Дуугай байгаад байх эвгүй санагдах тул Керри:

- Нью-Йоркт үзэх юм ихтэй их сайхан хот байгаа биз гэж зориглон хэлэв.

- Ганцхан долоо хоногт үзэж барахаагүй том хот юмдаа гэж Эмс эелдгээр хэлэв.

Тэр залуу тун аштайхан зантай элдвийн маяггүй, бас тэгээд балчир залуугийн бүрэг байдал нь хараахан арилаагүй тул хүнтэй ярихдаа сурамгай биш байсан боловч аятайхан хувцасласан, лоны дотор догь байдалтай байж чадах ажээ. Түүнтэй ярилцахад хэцүү биш санагджээ.

- За одоо явахад бэлэн болох шиг байна. Сүүх ч гадаа хүрээд иржээ.

- За явцгаая, нөхөд минь. Боби чи Вилер хатагтайд үйлчлээрээй гэж инээмсэглэсээр гарч ирсэн Вэнс хатагтай хэлэв.

Боби инээмсэглэн Керрийн дэргэд очиж, баярласан барьц алдсан байдалтайгаар:

- Оролдоод үзье л дээ, та надаар нэг их бөөцийлүүлэхгүй юм байгаа биз дээ? гэхэд Керри:

- Гайгүй болов уу гэж найдаж байна гэв.

Тэд шатаар бууж сүүх тэргэнд орж суухад Вэнс хамгийн сүүлд орж сүүхний хаалга хавхийтэл хаагаад:

- За явъя гэв.

- Бид маань юу үзэх гэж байгаа билээ? гэж Эмс асуув.

- “Лорд Чамли”, голлон тоглогч нь Созерн

- өө, ёстой сайн жүжигчин дээ, хичнээн инээдтэй гэжж гэж Вэнс хатагтай хэлэв.

- Сонинд их л магтсан байхы нь үзсэн гэж Эмс хэлэв.

- Эргэлзэх юм алга, бүгдээрэнд маань таалагдах байх гэж Вэнс үг шургуулав.

Эмс, Керрийн хажууд сууж зохих ёсны халамж үзүүлэх ёстой байлаа. Яасан царайлаг, яасан залуухан эхнэр вэ гэж бодовч гагцхүү хүндэтгэх сэтгэлтэй байсан нь түүний хөөмхий зангүйнх байв. Тэр бол угаас ургийн холбоог хүндэтгэдэг хүн байсан болохоор Индианополисынхаа сууж болмоор царайлаг охидыг бодож байлаа.

- Та эндхийн унаган нутгийн хүн үү? Гэж Эмс Керрийгээс асуухад:

- Бишээ, биш, би энд ирээд хоёрхон жил болж байна гэв.

- Өө, тийм үү, гэхдээ та энэ хоттой танилцаж амжихуйц удсан байна даа.

- Амжсан юм алгаа, анх ирснээсээ илүү гавтай мэдэх юм байхгүй л байна.

- Та баруун зүгийн хүн биш биз?

- Тийм ээ, Висконсон муж.

- Энэ хотын ихэнх хүн нь дандаа л саяхан ирсэн улс байдаг шиг байх юм. Индианд байсан мийн мэргэжлийн олон хүн энд ирчихсэн сураг дуулдлаа.

- Та ямар мэргэжлийн хүн бэ? гэж Керрийг сонирхоход цаадах нь:

- Би нэг цахилгааны компанид ажилладаг хүн гэлээ.

Тэр хоёр тийнхүү заримдаа ерөнхий юмны тухай заримдаа нэлээд инээд хүрхмээр аар саар юм ярилцсаар нөгөө рестораныхаа гадаа хүрч ирсэн бөгөөд тэр хоёрын ярианд эр эм хоёр Вэнс хажуунаас нь хааяа оролцож байв.

Тэдний явж байгаа гудамжаар хөл хөдөлгөөн ихтэй, зугаа цэнгэлийг хайсан хүмүүс үй олон явааг Керри ажжээ. Сүүх тэргэнүүд ч олон, явган хүмүүс ч тоогоо алдсан харагдана. Тавин есдүгээр гудамжаар вагон тэрэг зай завсаргүй давхилдана. Тавин есдүгээр гудамж, тавдугаар өргөн чөлөөний уулзвар дээр байх хэдэн шинэ зочид буудлын гэрлүүд нүд гялбам цжэхэлзэх бөгөөд тэдгээр зочид буудал Плаз хэмээх талбайг эмжээрлэн сүндэрлэх тул тэр хавийг хээнцэр орд харшид суудаг хүмүүсийн газар гэж бодогдмоор ажээ. Баячуулын үүр болсон тавдугаар гудамжаар дүүрэн сүүх тэрэг хөшилдөж, оройн хувцастай ноёд миеэгнэнэ. “Шерри” рестораны үүдэнд хүрч очиход сүр бараатай хаалгач сүүхний хаалгыг онгойлгон дотрохи эрхмүүдий нт гарахад туслав. Шатаар дээш гарахад залуу Эмс, Керрийг сугадан явлаа. Тэднийг хөлийн өрөөнд ороход тэндээс салдаггүй улс нь аль хэдийн ирчихсэн бужигнаж харагдав. Тэд гадуур хувцсаа өлгүүлээд адбиш хээнцэр их өрөөнд нь морилон оров.

Тэр ер бусын сайхан юмыг Керри насандаа үзээгүй явжээ. Херствүд амьдралдаа хавчигдаж байсан болохоор иймэрхүү ресторанд Керрийг оруулж чадаагүй байж. Энд шинээр орж ирж байгаа хүнд өө хэлэх юм олдохгүй, магтя гэхнээ үг дутахаар тийм байдал ноёрхох ажээ. Керри, тэр рестораны тухай “Морнинг”, “Ивнинг Ворлд” сониноос энэ ресторанд бүжиг, будаалга, багт наадам зэрэг болдог тухай уншиж байснаа саналаа. Тийм ийм хатагтай гурав дахь өдрийн орой өөрийн нэрэмжит будаалгыг “Шерри” ресторанд өгнө, залуу ноён тэр тэр арван зургаанд “Шерри” ресторанд цөөн тооны анд найзтайгаа наргина гэх мэтээр баячуул ихсийн хүрээлэнгийнхий зарлуулсан тогтмол үгтэй зүйлсийг Керри өдөр болгон дуртай уншиж сонирхож байсан болохоор гайхмаар ховдог хүмүүсийн тэр гахайлатай ганган хээнцэр газрыг ойлгож ядсангүй. Керри одоо тэр газар биеэр орж үзэх нь ээн ажээ. Хөлийн өрөөгөөр орохоор шатаар өгсөхөд хаалган дээр нь тарган пагдгар эр зогсох ба өрөөн дотор бас нэг пагдгар бүдүүн эр зогсохоос гадна орж ирэгсдийн таяг, пальто, малгай зэргийг нь тусгай хувцастай залуус хүлээн авч байлаа. Баячуулын хоол иддэг энэ газрыг гоёмсог, гэрэл гэгээтэйг хэлж баршгүй, Вэнс хатагтай ийм газар сүүх тэргээр ирээд залуу нас, дэгжин сайхан хувцас, баян чинээлгэрээ бахархахы нь ч хэлж баршгүй. Баян тарган явах гэгч яасан ч сайхан юм гэж бодогдоно.

Хоёр, гурав, дөрөв, тав, зургуул суусан маягтай сайхан засаан эгнээ эгнээ ширээний дундуур Вэнс түрүүлэн алхав. Анх орсон хүнд тэнд байгаа хүмүүсийн омог бардам ихэмсэг байдал маш илэрхий ажээ. Ярайсан олон чийдэнгийн хурц гэрэл ширээн дээрх болор шилэн аяга хундагад тусан цацарч, хана туургаар нэг алтан шармал гоёл чимэглэлийн гэрэл бүгд холилдон гял цал гэх тэл нүд дастал ялгахуйяа бэрх. Ноёдын цас шиг цагаан цамцны энгэр зах, хатдын тод өмсгөл, зүүсэн очир алмас эрдэнэсийн чулуу эд бүгд гоц содон гялалзана.

Керри, Вэнс хатагтайгаас дутахгүй омог бардам байдалтайгаар явж очоод ахлах зөөгчийн заасан сандал дээр суулаа. Керри тэндэх аар саар юм бүхнийг гярхай ажих агаад хоол зөөгчид, тэдний ахлагчийн нахилзаж бөхөлзөн сандар бүрий нь ойртуулж дөхүүлэх, суухыг урин хоёр гардан зангах мэтээр зулгуйдах нь цаанаа хэдэн доллар атгуулна гэсэн үг ажээ.

Тэнд нэгэнт орж суусан хйоно соёлт ертөнцийн хүмүүс гайхаж хачирхаад учры нь олдоггүй баян америкчуудын гайхуулдаг үрлэгэн ходоодонд цөвтэй хоол унд эхэлж гарна гэсэн үг. Хоолны далбагар цэсэнд эгнээсэн түмэн янзын хоолыг бодохул бүхэл бүтэн армийг нэг удаа хооллоод гаргасан ч хүрэхээр агаад жирийн үнээр иднэ гэвэл инээдтэй юм болж хувирах өндөр үнийг жагсаасныг ажвал таваг шөл гэхэд л тавин цент буюу доллар, дөчин янзын хясааны зургаа нь жаран цент, гачир, загас, мах авах гэвэл хэр баргийн хүн ердийн нэг зочид буудалд хоног өнгөрөөж болох үнэтэй байна. Тэр гоёмсог хийсэн цэсэнд нэг доллар тавин цент юмуу хоёр доллар гэсэн тоо голцуу харагдана.

Керри үүнийг ажиглаад цэсийг нүд хэсүүлэн харж байтал шарсан тахианы үнэ харагдахал өөр нэг цэсийг өөр тохиолдолд буюу Чикагод анх удаа ирээд нэг сайхан ресторанд Дрүүг дагаж ороод харж байснаа санах. Гэвч энэ нь хуучны гунигт дууны нэг ая түр санагдаад алга болдгийн адил төдхөн мартагдав. Тэр цагт Керри одоогийнхоосоо огт өөр ядуу, өлсгөлөн, амь зогоож явсан бөгөөд ажил эрээд эрээд олдохгүй Чикаго хот тэр чигээрээ хүйтэн царайлан үүд хаалга ч тайлж өгөхгүй янзтай тийм хүйтэн цэнгэг ертөнцөд явж байсан билээ.

Алтадмал хүрээнийх нь өнцгөөр янагийн мариалаг тэнгэр дагнис цэцэг жимсний дээгүүр амгалан хальж харагдах хөөндийн өндөг мэт цайвар ногоон хөхөмдөг дөрвөлжин дөрвөлжин хээ угалз ханаар нь дүүрэн байхад дээвэрт нь тэг дундах бөнжгөр бөнжгөр чийдэн, талст унжлага, алтадмал зүүмгүүдтэйгээ холилдон багшрах дэнлүүний цоморлиг нь хүртэл голцуу алтан хээ угалзаар дүүрэн байлаа. Улаан хүрэндүү модон шал нь гял цал буух агаад хашаа л харвал ирмэг гарган засаан шилтэй том том толь цэлийж эсрэг талынхаа юм бүхнийг хэдэн арав, дуу дахин үелүүлэн тусгах ажээ.

Ширээнүүд нь онцгой гойд биш гэхнээ бүтээлэг, алчуурууд дээр нь Шерри, мөнгөн хэрэглэл дээр нь Тиффани шаазаг хэрэглэл дээр нь Хэвиленд гэсэн үгтэй агаад ширээ бүр дээр байх улаан ягаан бүрхүүлтэй жижиг дэнлүүний гэрээл суугчдын хувцас, нүүр царайн өнгийг зөлрүүлэн өөрчилнө. Рестораны үйлчлэгч бүр нь бөхөлзөж нахилзах аяга таваг янзлах мэт аар саар юм бүхэнд намбатай хөдөлж хүн бүрийн дэргэд шалмаг очиж бөхөсхийн толгойгоо далжийлган, тохойгоо сүвээндээ тулган анхааран халамжлан “яст мэлхийн шөл за мэдлээ”, “нэг таваг за мэдлээ, хясаа-зургаан ширхэг, за мэдлээ, ноёнтон минь, “хэрээни й нүд чидүүн жимс за мэдлээ” гэх мэтээр ухиалаг шалмаг үйлчлэх нь рестораны бас нэг чимэг болно.

Вэнс урьдчилан санал хүслий нь мэдэж аваад хоолныхоо захиалгыг нэгмөсөн өгөөгүй бол хоол зөөгчид тус бүр дээр ирж тэгж үйлчлэх байсан буйгаа. Керри тэнд байгаа хүмүүсийг ихэд ажиглана. Нью-Йоркийн ихэс дээдэс гэгч ийм улс байдаг вий, баячуул өдөр хоногоо ингэж

өнгөрөөдөг юм байж гэж бодлоо. Нийгмийн бүх давхаргын амьдралыг түүний өчүүхэн ухаан яаж ойлгох билээ. Ганган авгай бүр үдийн алдад Бродвейн гудамжаар ирж өдрийн жүжигт ордог, сүүх тэргээр явж үдэш болохоор гуанзанд ордог юм байна гэж бодлоо. Хээнцэр гялалзсан орд харшинд сууж, гаднаа сүүх тэрэг хүлээлгэж, хаа л явбал зарц гоцго зарсан улс байдаг байхад Нью-Йоркт ужиг удаан хоёр жилийг өнгөрүүлэхдээ ийм газраар ганц ч орж үзээгүй явжээ.

Энд Вэнс өөрийнхөө дундаа орсон мэт агаад үнэ цэнэ хайхралгүй дуртай хоолоо захиж байгаа нь Херствд урьд тэгдэг байсныг санагдуулав. Вэнс, бүгдэд нь шөл, хясаа, шарсан мах, гачир захиж бас хэд хэдэн шил дарс захив. Захисан дарсыг нь сүлжмэл торонд хийгээд ширээнийх нь хажууд тавив.

Эмс энд байгаа хүмүүсийг төдий л шохоорхсон бишээр харахыг нь Керри хажуугаас нь ажвал дух өндөртэй, томхон зоримог маягийн хамартай, цэвэрхэн эрүүтэй, өргөн сайхан амтай, бараан хүрэн халимгаа хажуу тийш нь хагалсан ер нь аятайхан залуу ажээ. Керрид цаанаа л нэг хүүхдэрхүү шинжтэй харагдавч нас бие гүйцсэн эр билээ.

Эмс нэлээд удаан дуугай юм бодож сууснаа Керрид:

- Мөнгийг ийм маягаар үрдэг улс надад тун муухай санагддаг юм гэхэд Керри түүний нүүр рүү хараад тоглосон янзгүй байгаад нь бага зэрэг гайхаж, өөрийнх нь хэзээ ч бодож байгаагүй ямар нэг юмны тухай бодож байгаа шиг болохоор, сонирхсон байдалтайгаар:

- Тийм гэж үү? Гэхэд цаадах нь:

- Тийм ээ, жинхэнэ үнээс нь илүү үнэ төлж байна шүү дээ, эн улс гайхуулж байгаадаа л ингэж байгаа хэрэг гэв.

- Байгаа мөнгөө яаж я зарж байсан хамаагүй юм биш үү гэж Вэнс хатагтай хэлэхэ хоолоо захиалсан мөртлөө хоолны цэс үзсээр байсан Вэнс:

- Тэглээ гээд хэнд ч хор болохгүй шүү дээ гэв.

Эмс дахин хажуу тийш харахад Керри бас л духы нь ажлаа. Хачин хачин юмны тухай бодож байгаа мэт санагдах бөгөөд хүмүүсийг ажих нүднийх нь харц хачин зөөлөн ажээ.

- тэнд сууж байгаа тэр авгайн гоёлыг хараач гэж Эмс дахин Керри руу харж толгойгоороо дохин хэлэхэд Керри түүний нүдний чигээр баримжаалж:

- Аль? Гэж асуухад цаадах нь:

- Тээр тэр өнцөгт. Хатгасан зүүгий нь хараач гэв.

- Яасан том юм гэж Керри дуу алдав.

- Би насандаа ийм том эв хавгүй хачин алмас үзээгүй юм байна гэж Эмс хэлэв.

- Нээрэн дэндүү том юм.

Керри, яагаад ч юм тэр залуугийн амыг дагамаар санагдаж, бас өөрөөсөө илүү боловсролтой

илүү ухаалаг хүн юм гэж боджээ. Ер тэр залуу тийм хүн байх шиг байв. Керрийн нэг сайн тал гэвэл өөрөөсөө илүү ухаантай хүн байдаг гэж бодож чадна. Керри насандаа уулзаж учирч байсан олон хүнийг эрдэмтэн хүн байх гэж бодож байсан нв цөөнгүй. Дэргэд нь суугаа тэр хурц тунгалаг нүдтэй буриа залуу Керрийг таашаах боловч учры нь төдий л ойлгоогүй юмыг ойлгож байх мэт санагджээ. Эр хүн ийм байх сайхан хэрэг гэж Керри бодож суув.

Тэдний яриа Алберт Российн бичсэн “Охидыг яаж хүмүүжүүлэх вэ?” гэсэн тэр үед их сонирхогдож байсан нэг номын тухай яриа болж хувирав. Түүнийг Внс хатагтай уншсан, нөхөр нь сонинд гарсан хэдэн шүүмж олж уншсан байв.

- Хүн ном бичээд их дуулиан дэгдээж чаддаг л юм байна. Тэр Российн тухай мөн их ярилцах болжээ гэж Вэнс Керри рүү харж хэлэхэд:

- Би тэр хүний тухай сонсоогүй юм байна гэж үнэнээ хэлэв.

- Би сонссоон. Олон ном бичсэн хүн. Энэ сүүлчийнх нь тун сайхан гэж Вэнс хатагтай хэлэхэд Эмс:

- Нэг ч их сайхан бичдэг хүн биш дээ гэж хэлэв.

Керри түнийг төлөгч мэргэн хүн юмуу гэсэн маягтайгаар нүүр рүү нь ширтэн харав.

- Тэрний бичсэн юм нь Дора Торн шиг дандаа дэмий юмнууд гэж Эмс нэмж хэлэв.

Керри үүнийг хувийн зэмлэл гэж бодлоо. Керри урьд Дора Торныг уншсан, тун аятайхан зохиол шиг санагдсан байж. Өөрт нь аятайхан шиг байсан бол бусад хүмүүс голцуу сүйд болон магтдаг байв. Гэтэл энэ тунгалаг нүдтэй саруул толгойтой оюутан сурагч шиг энэ залуу үгээр доог тохуу хийж байдаг байна. Огт тоохгүй, унших гэж цагийн гарз хийх хэрэггүй гэсэн байдалтай ярьж байдаг байна. Керри, анх удаа юу ч мэддэггүйгээ ойлгож ичингүйрэн доош духайв.

Эмсийн үгэнд ёжлон шоолсон юмуу мэдэмхийрэн онгирсон зүйл огт үгүй байв. Түүнд имйрэхүү зан ерөөс ч байхгүй бололтой. Ухаантай хүний л боддог бодол байх. Юмыг зөв бодно гэдэг ийм байдаг аж, дахин өөр юмны талаар юу гэж өөрийнхөө бодлыг хэлэхийг нь сонсохсон гэж Керри бодов. Керри үгий нь анхааралтай сонсон санаа нийлж байгаа нь Эмс гадарлаад одоо голцуу түүнд хандах ярих болов.

Хоол зөөгч нахилзаж бөхөлзөн авчирсан тавагтай хоолоо халуун эсэхий нь шалгаж тэмтрэх, халбага сэрээ хутга байрлуулан тавих зэргээр улам сайхан сэтгэгдэл төрүүлэх гэж аар саар юм аялуулж байх зуур Эмс, Керри руу толгойгоо яоимгүй далжийлган Индианополисынхаа тухай эвлэгхэн ярьж өгч байв. Тэр залуу үнэхээр саруул ухаантай, ялангуяа ухааныхаа гол нурууг цахилгаанд зориулсан ажээ. Бусад салбарын талаар ч гэсэн юм мэддэг хүн амьтны талаар ярихдаа хүн муу хэлэхгүй ээлтэй ярина. Үирээний чийдэнгийн улаан бүрхүүлийн өнгөнд толгойных нь үс элсэрхэг өнгөтэй, нүднийх нь харцанд цог гялалзах шиг. Урагш бөхийсхийхэд нь Керри энэ бүгдий нь ажиж тун залуу хүн болохы нь дахин лавтай мэдлээ. Тэр залуу Керригээс хол давуу ажээ. Херствүдээс ухаалаг, Дрүэгээс эрүүл саруул, болосвролтой, цагаан цайлган, санаа сайтай, сайхан ч хүн шиг санагдана. Керри бодохдоо өөрийг нь огт сонирхохгүй, амьдралдаа буюу аливаа асуудалдаа ямар ч падгүй гэсэн янзтай байхыг ажиглавч юм ярихдаа өөрт нь хандаж байгаа болохоор аятайхан санагдаж байлаа.

Эмс хоол идэх зуур бага зэрэг халамцаж:

- Би баяжихыг нэг их боддоггүй, ямар ч гэсэн мөнгөө энэ мэтээр үрэх болтлоо баяжихыг дурладаг хүн биш гэж Керрид хэлэв.

Керрийн бодлоор цоо шинэ имй дүгнэлт өөрт нь анх удаа ман их нөлөө үзүүлэх тул:

- Тийм гэж үү? Яагаад тэр билээ? гэж асуув.

- Тийм байлгүй яахав. Ямар хэрэг байна? Хүн тийм боллоо гээд аз жаргалтай болох уу? гэж Эмс хариу болов.

Керри энэ үгэнд эргэлдэвч нэгэнт түүний амнаас гарч байгаа болохоор ойшоож үзэхээс аргагүй санагдав.

“Энэ хүн имй чадал чансаатай хойно гон бие гозон толгой явсан ч аз жаргалтай байж чадах байх л даа” гэж Керри дотроо бодов.

Вэнс эр, эм хоёр бараг зогсоо зайгүй ярьж байсан болохоор Эмс хааяа завсар хооронд нь тиймэрхүү үг хэлбж байсан авч их жинтэй санагдана. Ерөөс тэр залуугийн байгаа байдал Керрид үг хэлсэн ч хэлээгүй ч нөлөөтэй байсан болохоор үг нь цөөдөхгүй байлаа. Тэр залууд юмуу тэр залуугийн байдаг ертөнц нь Керрийн сэтгэл зүрхэнд ямар нэг талаал таатай санагдах мэт ажээ. Эмс, Керрийн санаанд тайзан дээр болж байсан үзэгдэл, чухам юуны улмаас гэдэг нь үл мэдэгдэх боловч хүмүүс гуьж гутарч байсан тэр үзэгдлийг санагдуулна. Эмс, энэ хоорвоогийн амьдрал, Керрийн амьдрал хоёрын гаслант ялгааг үгүй болгох мэт санагдах бөгөөд тэр бол гагцхүү түүний тайван хэнэггүй байдлаас тэгж санагдаж байгаа ажээ.

Тэд зоогийн газраас гарахад Эмс Керрийг сугадаж яваад жуузанд суулгав. Тэгээд бүгд театр руу явав.

Жүжиг үзэж байхдаа Керри, Эмсийн хэлэх үгийг их л анхааралтай сонсож байлаа. Керрийн сэтгэлийг догдлуулсан үзэгдлийн талаар Эмсийн хэлэх үг Керрид таатай санагдана.

- Жүжигчин байх гэдэг сайхан юм гэж би боддог, та юу гэж боддог вэ? гэж Керри нэг удаа асуухад Эмс:

- Тимй шүү, сайн л жүжигчин болж чадах юм бол театр гэдэг чинь их чухал зүйл гэв.

Зөвхөн ийм үг сонсоход ч Керрид зүрх овлзон хөөрчээ. Жүжигчин болж чаддаг ч болоосой, сайн жүжигчин болох юмсан. Энэ хүн ухаантай учраас ойлгож байна. Сайн жүжигчин болох юм бол энэ мэтийн хүн сайшаан үнэлэх юм байна. Тэр залуугийн хэлсэн үг нь Керрийг үнэлсэн үг биш байлаа ч гэсэн өөрийг нь сайшааж буй үг шиг л санагджээ. Яагаад тийм санагдаж буй учрыг өөрөө ойлгохгүй байв.

Жүжиг дууссаны дараа Эмс тэдэнтэй хамт явахгүй, шууд тэндээсээ сууж байгаа газар луугаа явах болсныг мэдээд Керри өөрийн эрхгүй:

- Та чинь бидэнтэй хамт буцахгүй юм уу гэхэд Эмс:

- Уучлаарай, би эндээс холгүй гучин гуравдугаар гудамжинд зочид буудалд буусан хүн шүү дээ гэхэд Керри өөр юу ч хэлсэнгүй дотроо яагаад ч юм гэнэт тийм юм болсонд гонсойжээ.

Тэр оройн сайхан зугаалга мөд дуусах нь гэж тэртэй тэргүй бодож байсан ч бас хагас цагийн зай байна гэж бодох бөлгөө. Амьдралыг бүрдүүлж байдаг энэ хувь, энэ цаг гэгч үү. Хичнээн гуниг зовлонг давхар давхар тээнэ вэ.

Керри, Эмсийн гарын зориуд жишимгүй байдалтай барьж салах ёс гүйцэтгэж ямар аамаа байсан юм гэж бодох боловч сууж явсан тэрэг нь Эмсгүйгээр ханхайгаад байлаа.

Керри гэртээ хариад тэр оройнхоо явдлыг нэхэн санахад тэр залуутай дахин тааралдах болов уу үгүй болов уу хэмээн аргагүй бодогдож байв. Дахин уулзсан уулзаагүй ямар хамаа байх билээ гэж дахин дахин санагч нэг л биш байна.

Херствүд аль хэдийн гэртээ ирчихсэн орондоо орсон байв. Хувцсаа тайчин энд тэндгүй ундуй сундуй хаяжээ. Керри үүдэнд нь очсон боловч тийнхүү байдлы нь хараад орохоос дургүй нь хүрч унтахыг яарсангүй. Тэгээд баахан бодож бясалгахаар шийдэж гал тогооныхоо өрөөнд буцаж ороод эргэлддэг сандал дээрхээ суун жигтэйхэн гараа чанга гэгч нь атгалаа. Элдэв дээдийн олон юм, хүсэл мөрөөдлийнх нь будан манангийн дотроос ирээдүйн төлөв нь аажмаар тодрон харагдах шиг болно. Горилох хүсэх, зовж зүдрэхийн тоо тоймгүйг яана. Эргэлддэг сандал дээрээ тийнхүү ганхсаар ахуйд ухаан бодол нь сийрэгжээд ирэх мэт болно.

ХОТЫН ГАДУУР. ОН ЖИЛ УРСАН ӨНГӨРНӨ

Түүнээс шууд уламжлан гарсан уршиг гэмээр юм мэдэгдсэнгүй. Ийм тохиолдолд уршиг нь тэр даруйдаа илрэх нь үгүй билээ. Өглөө болоход өөр юм бодогдоно. Дасаж заншсан амьдрал яах ч аргагүй нэгэн хэвийнхээ байдал руу хэнийг боловч татна. Хүн өөрийнхөө амьдралын арчаагүй байдлыг хааяа хааяа л анзаарна. Эрс тэс юманд учрахын хамт бид сэтгэлийн зовлонгоо мэдэрдэг. Тийм юмгүй бол зовлон арилаад л явчина.

Керри түүнээс хойн бахь байдаг амьдралаараа хагас жил гаруй арай ч илүү хугацааг туулж өнгөрүүлэв. Эмстэй дахин нагц ч тааралдсангүй. Вэнсийнхээр бас нэг ороод гарсан гэж найз авгайгаасаа дуулжээ. Залуу инженер баруун нутагтаа буцсаныг сонссоноос хойш Керри тэр хүний тухай түүний үлдээсэн сэтгэдлийг яваа яваандаа мартагнаж байсан боловч санаа бодлынх нь нөлөө огт мартагдаагүй бөгөөд тийм амархан хэзээ ч мартагдахгүй гэж хэлж болох байв. Одоо Керри хосгүй сайн сайхан хүн гэдгийг төсөөлөх болж эрчүүлийг, ялангуяа ойр дотно эрчүүлээ түүнтэй л зүйрлэж бодох болсон байна.

Бараг гурван жил шахуу хугацаанд Херствүд нэгэн хэмийн жигд амьдралтай байлаа. Уруудаж доошоо явсан ч үгүй, өөдөлж ахисан ч үгүй байлаа. Хажуугийн хүн ажиглавал ингэж хэлэх байсан биз. Ахиж базаах юм түүнд байсангүй. Харин сэтгэл санааны талаар их өөрчлөлт гарсан нь цаашдаа херствүдийн хувь заяа яаж эргэх вэ гэдгийг ч хэлж болохоо байжээ. Хамгийн гол нь юунаас болов гэхээс Чикогогаас гарч явснаас хойш түүний нэр төр албан тушаал явуургагүй болсон явдал байлаа. Худалдаа наймааны хүний биеийн байдал, түүний ажил төрлийн өсөцтэй тун төсөөбтэй байдаг юм. Нэг бол нас шүд нь гүйцэж эрийн цээнд хүрч байгаа хүн мэт хүчтэй, эрүүл чийрэг ухаалаг бодол, нэг бол хижээл насандаа орсон эр хүн мэт бие тэнхээ доройтож, идэвх чадал суларна. Өөрөөр байх номгүй. Бас зарим хүний идэр залуу насны хүчээ авах чадал нь тасраад дунд зэргийн насны хүний тухай хэлж байгаа юм доройтож эхэлдэг, тийм үед бол энэ хоёр үзэгдэл бие биерүүгээ тэнцүүвтэр болж гаднаа илрэх нь үгүй байдаг. Гэвч тэгзнэж байгаад дэнснийх нь таван авсны зүг хазайж эхэлдэг: эхлээд алгуур, тэгснээ хурдасч эхлээд уруудах үзэгдэл ёроолдоо хүртэл зогсолтгүй явна. Иймэрхүү юм баян хүний хувьд тохиолдох нь цөөнгүй. Капиталын өсөц зогсчихолгүй, орлого зарлаг нь тэнцчихгүй байвал сүйрнэ гэж байхгүй. Одоо үед баячуул залуу мэргэжилтэнг авч ажиллуулж чадсанаар ажил төрлөө өөд татаад авах явдал цөөнгүй байна. тийм залуу хүмүүс баяныхаа аж ахуйг өөриймсгөөр үзэж дорвитой байлгахыг хүсэх учир хамаг хүч чадлаа эзнийхээ эд хөрөнгийг арвижуулахын төлөө зүтгэдэг ажээ. Баян болгон өтлөх насаа тултал өөрөө зүтгэх юм бол хүч нь барагдаж зориг нь мохох билээ. тэгээд өөрөө тэр, хөрөнгө нь ч тэр нэг мэдэхнээ баларч дөрвөн зүг найман зовхист замхраад алга болох бизээ.

Харин одоо тэр хоёр зэрэгцэ шугам хэрхэн өөр болдгийг үзье. Хөрөнгө бол эзнийхээ нэгэн адил бие махбод юм, тэгэхдээ ганц эзнийх нь ухаан, чадал түүнд хүрэхгүй учраас өөр ухаан чадлыг нэмж авахыг шаарддаг юм. Эзний ухаан хүч хоёр шавхагдаад ирэхийн хамт амьд явахы нь дэмжих залуу хүч-холбоотон буй болохын зэрэгцээ бас өнөөх өндөр цалинд татагддаг залуу хүмүүс ч байх шүү дээ. Хөрөнгө гэгч нь хамтын нийгэмлэг буюу улс хөгжин дэгжиж буй цагт хэвээр байж чадна. Эрэлтийг хангах аливаа нэг зүйлийг үйлдвэрлэхэд тэр хөрөнгө хамааралтай байх аваас хөгжлийн тэрхүү явцад өөрөө чухал зүйл болно. Тийм цагт бол эднийг бөөцийлөн тэтгэх хэрэгцээ алаг болно. Ийм үед алсын харааг бодлогоосоо удирдлагын чадвар илүү чухал болдог юм. Эзэн хүн арчаагүй болло ч гэсэн эд хөрөнгө нь доройтох байтугай харин ч өсөн нэмэгдэх болж хэний ч эрх мэдэлд шижлээ гэсэн байсар л байх болно. Тэгэхлээр зарим эзэн,

Өөрийнхөө ажиллагааны чадал доройтож явааг мэдэхээ байдаг. Хөрөнгөө барагдаж, явай муутай болоод ирэхлээр л тэд одоо урьдынхаа адилаар ажиллаж чадахаа больсноо мэддэг ажээ.

Херствүд шинэ нөхцөл байдалд ороод эхлэхдээ одоо залуу зандан нас маань өнгөрсөн гэдгийг бодож болох байлаа. Тэгж бодоогүй байсан бол ганц л шалтгаан байсан хэрэг: алгуур доройтож байгаа нь мэдэгдэхээр тийм тэнцвэржүү байдалд байсных юмаа.

Өөрийнхөө тухай бодож ямар хүн болохоо дүгнэж сураагүй хүн болохоор Херствүд ухаан санаандаа түүнчлэн бие бялдартаа гарч буй өөрчлөлтийг ойлгож чадахгүй байсан байна, гэхдээ ерөнхийдөө ядрах болсноо мэдэрч байжээ. Урьдынхаа амьдралыг одоогийнхтойгоо дандаа зүйрлэж бодоод доройтож явна гэж ухаардаг байсан учир дүнсийн уруу царайлах буюу ямар ч болтугай гунигтайхан явах болжээ. Удаан хугацаагаар гутаж гуньж явбал цусанд катастат хэмээх онцгой хор буй болдог байхад баяр баясгалантай сэтгэл хангалуун явбал анастатхэмээх химийн ашигтай бодис ялгарч байдгийг туршлагаар магадлан тогтоожээ. Сэтгэлээ зовоосноор бий болох хор хүний бие махбодод харшиж бие тэнхээг нь мэдээжээр муутгадаг ажээ. Херствүд чухам тийм хоронд хэлмэгдэж байв.

Энэ нь сүүл сүүлдээ зан араншинд нь нөлөөлж эхэлжээ. Нүднийх нь харц урьдынх шигээ хурц сэргэлэн биш, алхаж гишгэх нь эв зүй муутай болсон юм шиг болж дандаа бодолд авьяан бэл алдсан өртэй хүн шиг болжээ. Шинэ танилууд нь алдар цуутангууд биш харин шалиг самуун юм хөөцөлдсөн өөдгүй амьтад ажээ. Тийм хүмүүс, Чикагогийн зоогийн газраар нь байнга эргэддэг агсан ганган дэгжин догьчуул шиг уулзаж учрахаас сэтгэлий нь сэргээх улс биш юм. Тэгэхлээр эцэс төгсгөлгүй үр дүнгүй бодолд автахаас өөр юм Херствүдэд үлдсэнгүй л дээ.

Ворен гудамжин дахь тэр зуушныхаа газраар орж гарах хүмүүст баяр хүргэж нахилзаж бөхөлзөх, аятай тавтай байлгая гэсэн бодол нь багадан багассаар авай. Тэгээд орхиж явсан хуучин газрынхаа дорвитойг нь бага багаар ухаарч байв. Угн нь Адамс гудамжинд хийж бйасан ажлаа төдий л тоолгүй явж дээ.

Албан тушаал ахиж, арвихан олз олж, илүүчлэх мөнгөтэй хүн болж авах тун амархан мэт тэр цагт мань эр боддог байсан бол одоо тэгнэ гэхэд даанч хүрэхийн аргагүй хол газар шиг санагдана. Херствүд хуучин газраа хэрмээр хүрээлсэн хот байж гэж бодох болов. Үүдэнд нь сахиул зогсоно. Дотогшоо хамаагүй орж болохгүй. Дотор байгаа нь гарч ирээд юун хүн үүд хаалга татна вэ гэж ч сонирхох хүсэлгүй, зугаа цэнгэлдээ жаргасан хүмүүс юу гэж гаднын тийм амьтдыг тоох билээ, мартаж орхино. Гэтэл өөрөө одоо гадна гарч дээ.

Дотор нь нэвтэршгүй хотын дэвсгэр дээр юу юу болж байгаа тухайг Херствүд оройн сонин болгоноос сониучлан уншина. Европ орохоор усан хөлгөөр мордов гэсэн хүмүүсийн нэрсийн дотор хуучин зоогийнх нь газраар байнга орж гардаг байсан алдар цуутай хүмүүсийнх нь нэр тааралдана. Театрт зориулсан мөрүүдэд өөрийнх нь сайн таньтж мэдэх хүмүүс амжилттай өөдрөг явааг нь цөөнгүй олж уншина. Эдгээр хүмүүс ч гэсэн урьдын адил бас зугаа цэнгэл хөөж яваа бизээ. Тэд пульманы галт тэргээр орон даяар л тэнээ биз, тэдний тухай сонингуудад шагшин бичихдээ ганган дэгжин зочид газрын буудлын газруудаар саатан морилсон тухай тэр улс нь бүгд нэрд гарсан алдартай хүмүүс байхад Херствүд ... одоо нэр мартагджээ. Вилер гэдэг чинь хэн бэ? Ворен гудамжны зоогийн газар гэдэг чинь юу юм? Юу ч биш.

Иймэрхүү бодол эгэл хүний толгойд орж ирэхгүй, энэ бол гагцхүү ухаан нь ихэд хөгжсөн хүмүүсийн тархинд л орж ирэх зүйл гэж уншигчдаас арцах хүн гарах аваас би гагцхүү ухаан нь

ихэд хөгжсөн хүмүүс тийэрхүү юманд ухаанаа зарж өөрийгөө зовоохгүй байж чадах тийм ухаан сийлж, сэтгэлийн тийм зоригийг бий болгож чаддаг юм шүү гэдгийг анхааруулмаар байна. Ухаан муутай улс л эд юмыг нэг их юманд бодчихоод хэдэн зуун доллар алдчихвал үхэх гээд байдаг юм. Гэтэл эд баялгийн сүүлчийн үлдэгдэл алга болоход л Эпиктет сая инээдээ барьж чаддаггүй юм.

Херствүдийн тэр гунигт бодол, гутрангуй ааш зан зоогийнх нь газрын ажил явдалд барагцаалбал гурав дахь жилийн эцсээр нөлөөлж эхэлжээ. Зоогийн газрын хамгийн өөдрөг байсан үед ордог байсан хүмүүсийн тоотой зүйрлэвэл түүгээр орох улсын тоо мэдэгдэхүйц их хорогдож эхэлсэн ажээ. Энэ явдалд Херствүд маш их түгшин их ч уцаар болж эхэлжээ.

Орлого маань энэ сард урьдах сарынхаасаа дор байна гэж Херствүд нэг орой Керрид үнэнээ хэлсэн байна. Бага сага юм худалдаж авах хэрэгтэй байна гэж Керрийн хэлэхэд хариуд нь ингэж хэлсэн байж. Херствүд өөртөө хувцас авахдаа хэзээ ч зөвлөж ярилцдаггүй байсныг Керри энэ удаа саналаа. Мөнгө битгий нэхэж байг гэж бодоод л ингэж байна гэж Керри анх удаа бодов. Ингэж бодоод зэвүү нь хүрсэн боловч хариу үгээ их л зөөлөн аяар хэлжээ. Херствүд, Керрийг бодохоо бүр больсон байжээ. Венсийнхэнтэй нийлж л хааяа сэтгээл сэргээхээс өөр сайхан цаг Керрид олдохыг байжээ.

Тэгтэл ч тэднийх гэнэт Нью-Йоркаас түр нүүх болсноо хэлжээ. Хавар болох дөхөж байсан цаг, умар зүг нүүхээр шийджээ.

- Манайх байраа хөлслөхөө болиод, харин юм хүмээ хадгалуулна гэж бодож байгаа. Бид зунжин энд байхгүй, тэгэхлээр байрны хөлс төлж байх ямар хэрэг байх вэ? тийм эе гэж вэнс авгай Керрид ярьжээ. Түүнээс гадна буцаж ирээд хотын төв рүү сууна гэж бодож байгаага ч хэлжээ.

Керри түүнийг сонсоод тун их гонсойжээ. Вэнс авгай тун аятайхан үерхэж байсан бөгөөд тэр байшинд өөр таних хүн огт үгүй ажээ. Дахиад л ганцаардана гэхээс Керри үнэхээр зүрх нь шимширч байлаа.

Вэнсийнх ч явах боллоо. Херствүдийн зоогийн газрын орлого унаж эхэлсэн байв. Керри ганцаардах болж, хар хүн нь ч гуньсан дүнсгэр царайлсан амьтан болж хувирсан нь давхар зовлон байв. Аль аль нь Керрид хэцүү байв. Тэгээд ууртай уцаар болж, Херствүдэд уцаарлахаасаа өөрийнхөө амьдрал хувь тавиланг бодохоос илүү их бухимдах болов. Энэ амьдрал гэгч ер нь юу юм бэ? Хаашаа ч эргэсэн бөөн уйтгар зовлон. Амьдралаас хүртсэн сайн сайхан юм хаана байна? Энэ бөгс ч эргэх зайгүй энэ өмгөр байрнаас өөр юу байгаа юм? Вэнсийнхэн юу л үзье гэснээ үзэж жаргаж байхад энд гав ганцаараа өдөр цагийг барж ядан ганцаардаж суух яасан их зовлон бэ? Ингэхийн тулд л хорвоод мэндэлсэн байх нь уу? Иймэрхүү уйтгар гунигтай бодол ар араасаа орж ирэхэд сүүл сүүлдээ тэсэхийг болин сэтгэлийнх нь зовлонг бага ч гэхнээ нимгэлэх цорын ганц юм болсон хар нулимс л асгарах болжээ.

Ийм байдал бишгүй удаан үргэлжлэхэд Керри Херствүд хоёр нэгэн маягийн уйтгарт амьдралыг хоног тоолон өнгөрөөж байлаа. Дараа нь улам бүр дордож эхлэх нь тэр. Шинэ хувцас хунарт дурлах шунал хүслий нь бага ч болтугай дарах санаагаар, Херствүд зардла гэгч хичнээн амаргүй болохыг ойлгуулах бодолтойгоор:

- Би өөрийнхөө түншгэй удаан хугацаагаар эв түнжинтэй байж чадахаа болиод байх шиг байна гэхэд нь Керри:

- Яагаад? гэж асуув.

- Хичнээн мулгуу, хичнээн шунахай муу ирланд хүн гэж санана. Зоогийн газраа жаал өөд татья гэхэд ер үг сонсохгүй юм. Одоогийн хэвээр байвал яавч өөдлөхгүй.

- Чи ятгаж барахгүй байна гэж үү.

- Хичнээн олон удаа яриад болж өгөхгүй байгаа юм. Одоо өөрийн гэсэн л нэг газартай болж авахыг бодохоос өөр арга мухардлаа.

- Тэгээд яагаа вэ?

- Би чинь зоогийн газар хамаг мөнгөө хийчихээд байгаа хүн шүү дээ. Нэг хэсэг хямгатайхан шиг байж чадах юм бол өөрийнхөө гэсэн зоогийн газартай болж орлого олзоо арвитгах бололцоо гарахаар байгаа юм л даа.

Керри, одоо ч гэсэн илүү их зарчихаад байгаа юм алга даа гэж өөрийн эрхгүй бодох зуур:

- Илүүхэн хямгатай байж яагаад болдоггүй гэж? гэж асуухад Херствүд:

- Байраа арай жижгэрүүлж, ядаж нэг жил хэртэй хямгатай байх юм бол учиртай. Тэгвэл энэ зоогийн газар оруулсан мөнгөтэйгээ нийлүүлээд олигтойхон газар нээж чадах байна. Тэр цагт чиний хүссэнээр амьдарч болно гэж би бодож байна гэв.

- Тийм бол надад цааргалах юм алга гэж Керри аман дээрээ хэлэх боловч дотроо ингэж ч доройтох гэж дээ хэмээн гонсойж байв. Байраа багасгах дээр хүрнэ гэдэг ч ядуурч байгаагийн ёр шүү дээ гэж бодов.

- Арван зургадугаар гудамжны цаадах Зургадугаар өргөн чөлөөний хэсэгт жижигхэн хөөрхөн байр зөндөө байх юм. Тэндээс тохирохоо шилж авч болох байна.

- Тэгмээр байгаа бол би очиж үзье л дээ.

- Нэг жилийн дараа гэхэд энэ түншээсээ салж болох байх, энэ хүнтэй иймэрхүү янзтай байсан цагт ердөө ч өөдлөхгүй гэж Хертсвүд хэлэв.

Байраа солих явдал ажил төрөлд нь их учир холбогдолтой юм байлгүй гэж бодсон Керри:

- Тэгвэл би явж байр үзэж ирье гэлээ.

Ингэж ярилцсанаас хойш даан удалгүй тэр хоёр байраа сольж нүүсэн бөгөөд Керри тун их гутарсан ажээ. Сүүлийн үед тохиолдсон муухан явдлуудын дотроос энэ явдал хамгийн хүчтэй муугаар нөлөөлжээ. Керри, Хертсвүдийг зуурдаар ханилж буй хүн гэж үзэхээ нэгэнт больж жинхэнэ ханиа гэж бодох болсон байв. Ямар ч юм боллоо гэсэн түүнтэй л хамт нэгийгээ харахаас өөр хувь тавилангүй гэж бодох болжээ. Харин урам зориг муутай, үг цөөнтэй болох нь улам мэдэгдэхүйц болж, урьдын гялалзуур золбоолог байсан байдал нь арилж байгаад Керри харамсах болов. Завьж болон нүднийх нь хавиар атираа ихсэж байгаа нь түүний өтөлж буйн шинж байлаа. Тиймэрхүү шинж тэмдэг олноор илрэх болжээ. Керри өөрөө алдаа хийсэн, Херствүд л өөрийн хүчээр оргуулсан гэж олонтаа бодогдох болжээ.

Тэдний орсон шинэ байр нь Зургадугаар өргөн чөлөөний ойролцоох Арван гуравдугаар гудамжны нэг байшин дахь дөрвөн жижигхэн өрөө байв. Цонхорр нь гол мөрөн ч харагдахгүй, гадуур нь тарьсан мод ч байхгүй, гудамжны байшингууд нь бүгд саяхан барьсан, хүн олонтой учир Керрид таалагдсангүй. Тэр шинэ байшинд арван хоёр айл суух бөгөөд боломжийн хүмүүс мэт санагдавч Вэнсийнтэй зүйрлэвэл хаана ч хүрэхээргүй байжээ. Вэнс мэтийн хүмүүс бол илүү сайхан байранд суудаг нь мэдээж.

Керри тэр жижигхэн байранд шивэгчин ч хэрэглэсэнгүй. Байраа овоо аятайхан тохижуулан суух боловч тэглээ гээд сэтгэлий нь сэргээх юмгүй байв. Херствүд бас нэг шатаар доошлон буурч байгаагаа дотроо ойлгох боловч өөр арга даанч алга гэж бодоод ямар ч болтугай нэг хэсэгтээ ингэсхийж байхаас өөр домгүй гэж бодно.

Херствүд, Керрийг театрт дагуулж явахаа олшруулж, идэх уух юмаа арвитайхан болгож байснаар мөнгө өнгөөр нэг их санаа зовох юмгүй, нэг жилийн дараа гэхэд л дажгүй болно гэж итгүүлэхийг хичээж байж. Гэвч энэ бол байнгын байдал биш бөгөөд мань хүн ямагт ганцаар элдвийг бодож суух дуртай болж байв. Түүнд сэтгэлийн балайртан доройтох аймшигт өвчин тусаж эхэлсэн бололтой. Сонин унших, бодолдоо автахаас өөр юу ч сонирхохыг больсон байлаа. Хайр сэтгэл гэгч ч түүнд баяр баясгалангийн эх ундарга больдгоо больжээ. Иймэрхүү дорой амьдралд нэгэнт орсон болохоор тэр тавилангаараа л болтугай гэж бодох болсон бололтой.

Уруудах замд зогсоол юмуу тэгшхэн газар гэх юм олон байдаггүй билээ. Херствүдийн сэтгэл санааны байдал түнштэй нь холдуулсаар байгаад цаадах нь Херствүдээс салахын түүсболжээ. Гэвч энэ явдал тэр хоёрын аль алины бодсоноос хавьгүй түргэн шийдэгдсэн нь уг зоогийн газрын байрлаж байсан байшингийн эзний тааллаар болсон ажээ.

Нэг өглөө Шонеси “Херальд” сонины “Үл хөдлөх хөрөнгө” гэсэн хэсгийг хуруугаар зааж Херствүдэд:

- Та үүнийг уншсан уу? гэхэд Херствүд:

- Үгүй ээ, уншаагүй, юу болоов? Гэж сонины нь харахад цаадах нь:

- Энэ байшингийн маань эзэн газраа худалдчихсан байна шүү дээ гэв.

Херствүд өөрийн эрхгүй:

- Нээрэн үү? Гэж дуу алдаад сонинг уншваас: “Өчигдөр ноён Август Вил, Ворен Хүдсон гудамжны уулзварт байдаг 25x75 фут хэмжээний газраа ноён Ж.Ф.Слосонд тавин долоон мянган доллараар худалдав” гэсэн байв.

- Түрээсний маань хугацаа хэзээ дуусах билээ, хоёрдугаар сард билүү? гэж Хертсвүдийн асуухад түнш нь:

- Яг үнэн гэлээ.

- Шинэ эзнийх нь бодлын талаар энд огт дурдаагүй байна гэж Хертсвүд хэлээд сонинг дахин уншиж эхлэв.

- Яах бодолтой байгааг нь бид мэд сонсох байлгүй гэж Шонеси харуи болов.

Үнэхээр, тэр хавийнх нь газрыг ч худалдан авсан шинэ эзэн Слосон, өөрийн газар дээр ихэвчлэн албыан байгууллагын зориулалттай байшингуудыг хамгийн сүүлчийн арга техникээр барих бодолтой байгаа нь мэдэгджээ. Зоогийн газар байсан тэр хуучин байшинг бүр нураах болжээ. Тэнд жил хагасын дотор цоо шинэ байшин барих төлөвлөгөөтэй байж.

Иймэрхүү мэдээ аажим аажмаар дуудахад эцэст юу болох бол гэж Херствүд санаа зовно. Тэгээд нэг удаа энэ талаар түнштэйгээ ярилцахдаа:

- Та ойролцоо нэг газар зоогийн шинэ газар нээх үү? Гэхэд Шонеси:

- Ямар хэрэг байх вэ? Энэ хавьдаа байшингийн аятайхан булан олдохгүй шүү дээ гэв.

- Өөр газар хэрэггүй гэж бодож байгаа юмуу?

- Би л лав тийм осолтой юм хийхгүй.

- Байдал тийнхүү огт өөрөөр эргэх болсон явдал Херствүдэд юун аюултай санагдах болжээ. Гэрээгээ цуцална гэхэд мянган доллар алдана гэсэн үг, үлдсэн хугацаанд яагаад ч мянган доллар олж чадах найдваргүй байлаа. Хуучин түнш нь өөрөөс нь залхаж нэг булан олоод зоогийн газрыг нээлээ гэхэд ганцаараа л байх янзтай байна гэж Херствүд тааварлах болов. Одооноос л аргаа бодохгүй бол санхүүгийн талаар бүр балрах нь гэдгээ Херствүд ойлгоод байсан болохоор жижиг байрандаа санаа амар сууж, Керритэйгээ байна гэж хөөрөх ч чадалгүй гунигт дарагдах болов.

Херствүд хичнээн эрж сураглавч аятайхан боломжтой ажил төрөл олдохгүй байлаа. Тэр ч байтугай гурван жилийн өмнө Нью-Йоркт ирж байхдаа хэний ч нүдэнд золбоолог харагдаж тоогдож байсан бол одоо сүр сүлдгүй болсон ажээ. Толгойд нь эргэлдэх түгшүүртэй бодлын харгайгаар нүднийх нь харц ч сандарч тэвдсэн байдлыг илэрхийлэх тул энэ нь бусдад олигтой юм бодогдуулахаа больжээ. Урьд хүнтэй ярилцахдаа мянга гурван зуун доллар бэлэн гаргаж чадах юм гэдэг байсан бол тэр нь одоо байхгүй болжээ. Сар хэртэй хугацаа өнгөрөхөд Херствүдийн байдал бас л сайжирсангүй учир шинэ эзэн гэрээни й хугацааг сунгахаас татгалзаж байна гэж Шонеси хэлжээ.

Шонеси царайгаа зовж буй хүнийрхүү болгохыг хичээн:

- Зоогийн газар маань ингээд л сүүлчийнхээ өдрийг үзэх бололтой гэхэд Херствүд царай барайлган:

- Одоо яана гэх вэ, тийм болсон бол болохоос л биш гэжээ.

Херствүд, цаад хүндээ өөрийн санаа бодлыг мэдэгдэхгүй, тэгж бах тавы нь ханаахгүй ажээ.

Түүнээс хойш ганц хоёр хоног болоход ийм юм болж буйг Керрид ямар нэг байдлаар урьдчилан хэлэхээс өөр замгүй болов.

- Ажил маань тун базаахгүй болж байна даа гэж болгоомжтойгоор эхлэн хэлэхэд Керри:

- Юу болоо вэ? хэмээн гайхсан байдалтай асуув.

- Зоогийн газрын маань байдаг байшингийн эзэн тэр газраа худалджээ. Шинэ эзэн нь түрээсний хугацаа сунгахаас татгалзсан байна. Тэгэхлээр ажил маань хаагдах болж байна гэв.

- Өөр зоогийн газар нээж болдоггүй юмуу?

- Таарах өөр газар олдохгүй янзтай. Тэрнээс гадна түнш маань надтай хамтран ажиллахгүй юм шиг байна.

- Өнөөх хувь нийлүүлж оруулсан мөнгөө ч алдах нь тэр үү?

- Тэгж байгаа юм гэж Херствүд гөлийн хэлэв.

- Арай дэндүү юм биш үү?

- Залилж байгаа хэрэг шүү дээ. Шонеси өөр нэг газар өөрийнхөө зоогийн газрыг дахиад л нээнэ гэж Херствүд тайлбарлав.

Керри, Херствүдийн нүүрийг ширтэн хараад үнэхээр хэцүү юм болсныг ойлгов. Тэгээд эмээсэн байдалтайгаар:

- Ямар ч болсон арга нь олдох байгаа гэж бодож байна уу? гэхэд Херствүд хэсэг дуугай байснаа одоо хямгатайхан байж шинэ ажил төрөл явуулах барих энэ тэр гэж сайхан зүүдлэхээ больсон дээр болжээ гэдгийг дотроо бодоод бас л Керри түүний “сүйрч” буйг сайн мэдэж байгааг ойлгоод эцэст нь баргар царайлан:

- Яахаа ч мэдэхгүй байна, ямар болтугай оролдоод л үзнэ дээ гэв.

ЖИНГИЙН ЧУЛУУН ЗАВСАР. САЛХИНД ХӨӨГ ДӨХ ХАМХУУЛ

Керри энэ байдлыг ойлгомгоцоо Херствүдийн нэг адил бөөн бодол болж хэдэн хоног өнгөрөхөд хэрэв зоогийн газар үнэхээрт хаагдахад хүрвэл энэ нь үгүйрлийн мөр болох тул, шар наран бор хоногийг хэрхэн өнгөрүүлэхийг ухаарч байлаа. Керри анх Чикагод ирж Хэнсоныд байснаа, тэдний муу байрыг бодохоос зүрх нь өвдөх шиг болж ядуу зүдүү амьдрал шиг аймшигтай юм үгүй гэж санагдах ажээ. Ямар аргаа тийм амьдралаас мултрах билээ л гэж бодохоос өөр юм эс бодогдоно. Вэнсийнхтэй хэдэн сар найзалсан биш Керри өөрийнхөө хэр чинээг эрүүл саруул уханаар цэгнэн бодож чадахыг больсон байв. тэр эр эм хоёрын нөлөөгөөр Нью-Йоркийн тансаг амьдралын зах зухыг нүд хужирласан Керрийн сэтгэл тэр амьдралд бүрэн татагдсан байлаа. Сайхан хувцаслахыг заалгаж хаагуур очиж юу үзэж болохыг хүртэд мэдэж авсан боловч аль алиныг нь биелүүлье гэхээс бэнчин нь огт хүрэхгүй байв. Гэтэл тэр сайн сайхан гэх юм нь ямагт нүдэнд үзэгдэж, санаанаас нь уяатай мэт санагдаж байв. Байдлаа муудах тусам амт шимтнээс нь бага боловч хүртэж үзсэн тэр баян амьдрал улам даамай бодогдоно. Гэтэл одоо ядуу амьдралын хувхай гар түүнийг тэврэн авч хүслэнт ертөнцийг нь яаж ч хүсээд, тэнгэр шиг хүрэхийн аргагүй холдуулах гэж байдаг.

Ядахнаа эрхэм дээд эрмэлзлийн тухай Эмсээс сонссон зүйл дотроос нь огт гарахыг байсан байв. Эмс нэгэнт огт алга болсон боловч түүний ярьж байсан үг буюу өөрөөр хэлбэл ертөнцөд Керрийн эс мэдэх мөнгөнөөс ч илүү эрхэм сайхан юм их байдаг, өөрийнх нь дэмий зүйл гэж боддог байсан театрын тайз бол агуу их зүйл гэж ярьж байсан нь чихэнд нь сонсогдсоор амуй. Тэр залуу бол Херствүд, Дрүүэ хоёрыг бодохноо хамаагүй шударга, хүчтэй нөлөөтэй хүн байжээ. Үнэхээр их ялгаатай хүн санагдана. Хичнээн их ялгаатайг нь бодохыг зориуд бодохгүй өнгөрдөг л байж.

Херствүд, Ворен гудамжин дахь зоогийнхоо газрын оршин тогтнож байсан сүүлийн гурван сарын дотор гадуур гарах нь олширч сонингоос ажил төрлийн тухай зарлалуудыг шүүрдэн уншдаг байлаа. Энэ бол урамтай эрэл сурал биш байсан боловч зоогийн газрыг хаагдсаны дараа хэдхэн зуун доллартай үлдэх тул бушуухан нэг газар хувь нийлүүлгэнд эс өгч чадвал өөрөө хөлсний ажтлчин болоход хүрэх байв.

Сонингуудад зарласан зоогийн газрууд эсхүл дэндүү их мөнгө шаардагдах эсхүл даанч урамгүй жаахан орлоготой байлаа. Өвөл болж, сонингуудад бичиж байгаагаас үзвэл олз омог нийтээрээ хомсдох төлөвтэй учир ерөнхийдөө нэлээд цэвүүн цаг болох янзтай байв. Сэтгэлийн зовлондавтагдаж байсан Херствүд, бусдад тохиолдож байгаа элдэв зовлонг ч анзаардаг болов. Тийм тийм пүүс дампуурлаа, тийм айл идэх уух ч юмгүй өлсгөлөн байна, тэнд тийм хүн харангадаж байсан байна гэх мэтийг одоо Херствүд тогтож унших болов. “Уорлд” сонин “Энэ өвөл ажилгүйчүүдийн тоо наян мянгад хүрнэ” гэсэн дуулиантай мэдээ нийтэлжээ. Үүнийг уншихад Херствүдийн зүрх рүү зүү шаах шиг болов. “Наян мянга гэнэ шүү. Яасан аймаар юм!” гэж дотроо бодов.

Иймэрхүү юм түүнд ер бишийн зүйл мэт санагдаж байв. Урьд нь энэ хорвоогийн явдал нам гүм, эсэн мэнд л байдаг мэт санагддаг байжээ. Чикагогийн “Дейли Ньюс” сонинд иймэрхүү юм бичээстэй байдаг л байж. Гэвч түүнийг ердөө ч анхаардаггүй байв. Гэтэл одоо иймэрхүү мэдээг уншаад үзэхэд цэлмэг тэнгэрийн саруул мандлыг борооны хар үүл нөмрөн харанхуйлаад ирэх шиг болно. Тэр үүл тэнгэрийг бүхэлд нь бүрхээд Херствүдийн цаашдын амьдралыг ч харанхайлуулах аюултай мэт санагдана. Өөрийгөө зоригжуулахын тулд хааяа дотроо:

- Хм, зовохын хэрэг юу байна? Гадаа гарчихаагүй байна, бас сар хагасын зай байна. Хичнээн ядарлаа ч гэсэн хадгалсан мөнгө маань хагас жил хүрэхээр байна гэж бодно.

Ирээдүйдээ сэтгэл нь ихэд дэнслэн зовох болсон яагаад ч юм хуучин эхнэр, хүүхдээ байн байн бодох болов. Эхний гурван жилд аль болохоор бодохгүйг хичээдэг байжээ. Авгайдаа яснаасаа дургүй нь хүрч байсан болохоор түүнээс ходсондоо сайхан санагддаг байж. Түүнгүйгээр болохоол болно гэж бодогддог байсан боловч одоо ядуураад ирэхийн цагт хуучин эхнэрийгээ юу хийж байдаг бол, хүү, охин хоёр маань ямар шүү явж байдаг бол. Тэр л сайхан байшиндаа, эд хөрөнгөөр минь туйлж суугаа биз гэж бодно.

“Яалаа гэж тэд нар цугий нь авах юм, би ер яасан юм?” гэж Херствүд дотроо зэвүүрхэн бодох нь олширчээ.

Урьдын явдлыг нэхэн санаж өнөөх мөнгийг хулгайлахад хүрч байснаа элдвээр бодоход өөрөө аргагүй тийм юм хийхээс домгүй байж хэмээн биеэ цагаатгана. Онцгой юу хийж вэ? яагаад ийнхүү гаргуундаа гардаг билээ? Ийм элдвийн зовлон яагаад учрах болов? Өгчигдөрхөн л юм юмтай чинээлэг хүн байсан санагдах боловч гэнэт тэр бүхний нь булаачихсан мэт санагдана.

“Ямар ч болтугай надаас тийм их юм авах учиргүй л хүн дээ гэж эхнэрийнхээ тухай бодно. Үнэнийг хүмүүс яг үнэнээр нь мэдэх юм бол намайг онцгой ноцтой юм хийсэн хүн биш гэнэ дээ” гэж бас бодов.

Херствүд, бүх үнэнээ хэн нэгэнд уудлан ярихсан гэж хүссэнээс ингэж бодож байв гэж бодох хэрэггүй юм шүү. Энэ бол өөрийгөө ёс суртахууны талаар цагаатгах гэсэн л оролдлого байсан юм. Одоо ингэж муугаа үзэж явахдаа өөрийгөө шударга хүн болгох гэсэн л санаа байлаа.

Херствүд, Ворен гудамжин дахь зоогийнхоо газрыг хаагдахаас тав орчим долоон хоногийн өмнө “Херальд” сонинд гарсан зарлалын дагуу гурав дөрвөн газраар оржээ. Нэг нь Алтан гудамжинд байж. Херствүд тэр гудамжинд хүрч очсон боловч тэр зоогийн газрыг бүр гаднаас нь голоод шагайсан ч үгүй, харин Бауэри гудамжинд байдаг нэг догь зоогийн газраар оржээ. Тэнд Грэнд гудамжнаас холгүй тиймэрхүү зоогийн газар маш олон байв.

Тэр зоогийн газрын эзэн нь бие муудаж байгаа болохоор л түнштэй болох хэрэгцээтэй гэх бөгөөд түүнтэй Херствүд дөчин таван минут хэртэй ярилцжээ.

- Тал хувийн ашгийг хуваалцахад хичнээн мөнгө орох вэ? гэж Херствүд асуухдаа, өөрөө долоон зугаас хэтрэхгүй доллартай гэдгээ сайн мэдэж байлаа.

- Гурван мянга гэж цаадах нь шууд хэлэв.

Херствүдийн царай гөлсхийгээд явчих нь тэр. Тэгээд:

- Бэлэн авах юмуу гэхэд:

- Бэлэн байлгүй яах вэ гэлээ.

Херствүд яая даа, ашиг байна уу үгүй юу гэсэн царай гаргаж ордог ч юм билүү гэсэн янзтай бодол болсон байдал үзүүлэвч нүднийх нь харцанд гуниг тодорно. Тэгээд бодож байж больё доо

гэж хэлээд бушуухан гарч одов.

Зоогийн газрын эзэн түүний байдлыг ерөнхийд нь гадарлав бололтой. “Ярианых нь өнгө нэг л биш, хувь нийлүүлж чадах хүн биш шиг байна” гэж тэр хүн дотроо боджээ.

Тэр өдрийн цийлэлзсэн хүйтнийг хэлэх үү. Сүвээ нэвт үлээх салхин өвөл ойртсоныг сануулах ажээ. Херствүд Жаран есдүгээр гудамжны ойролцоо байдаг бас нэг зоогийн газар тийш явав. Тэнд хүрч очиход нэгэнт таван цаг болсон байв. Оройн барай бүрий болжээ. Зоогийн газрын эзэн нь нэг тарган гэгчийн герман хүн байв. Тэр зоогийн газар ч , эзэн нь ч Херствүдэд таалагдаагүй боловч:

- Би сонинд гаргасан танай зарлалын дагуу ирлээ гэхэд герман:

- Өнгөрсөөн, би зарахаа больсон гэв.

- Өө, тийм үү? Гэж Хертсвүдийн гайхахад цаадах нь:

- Тийм ээ, ярих юм байхгүй, өнгөрсөн гэв.

- Тийм бий гэж хэлээд Херствүд эргэхэд тэр герман дахин юу ч гэсэнгүйд нь зэвүү хүрч дотроо” Солиотой илжиг чинь юугаа хийж сонинд зарласан юм бэ” гэж хараалаа.

Херствүд тун их ядраад Арван гуравдугаар гудамж руугаа эргэж гэртээ орж ирвэл Керри гал тогоондоо хоол унд зэхэж байх багаад гагцхүү тэр өрөөний гэрэл асаатай байна. Херствүд, мэнд ус ч үгүй, чүдэнз зурж хийн гэрлээ асааж хоолныхоо өрөөнд орж суув. Керри үүдэнд нь очиж шайгаад:

- Өө, чи юу гэж хэлээд буцаж явлаа.

- Тийм ээ гэж Херствүд хариу дуугарахдаа худалдаж авсан оройнхоо сонинг толгйо өөд таталгүй уншиж байлаа.

Ажил хэрэг нь тун базаахгүй байгааг Керри ойлгожээ. Зан муутай байхдаа муухай харагдахы нь яана. Хоёр нүднийх нь хавийн үрчлээ тодосч, угаасаа бараавтар царай нь цэлдэн хөхөрч тун ёозгүй. Ер нь л ёозгүй болно.

Керри ширээгий нь засаж хоолы нь авчирч тавиад:

- Хоол бэлэн шүү гэж хажуугаар нь нэг юм авах гэж гарахдаа хэлэхэд Херствүд дуугай сонингоо уншсаар байлаа.

Керри ширээний ард суудал дээрээ сугаад заяа муутайдаа гуньхарч байв. Тэгээд:

- Хоол идэхгүй юм уу? гэхэд Херствүд сонингоо эвхэж хажуу тийш тавиад хоолоо мөн дуугай идэж суухдаа хааяа хааяа тэр ч юм аваад аль, энэ ч юм аваад аль гэхээс өөр юм ярихгүй байв.

Керри хэсэг огт дуугай байснаа:

- Өнөөдөр гадаа тун муухай байх шив дээ гэхэд Херствүд:

- Тийм байна гээд хоолоо үмхлэхээс өөр юм ч хэлсэнгүй.

Керри хоол унд идэж уух зуураа дандаа ярилцдаг байсан сэдвээ сэргээх санаатай:

- Зоогийнхоо газрыг хаагдана гэж бодож байна уу? гэж асуувал Херствүд нэлээд уцаарласан байдалтайгаар:

- Хаагдахы нь мэдэж байна л даа гэв.

Ингэж хэлэхэд нь тэртэй тэргүй тэр өдөр элдвийн муу юм бодож санаа нь зовж байсан Керрийн уур гэнэт шатаж:

- Чи надтай битгий ингэж ярь гэв.

Херствүд: - Үгүй ер! Гэж хэлснээ ширээний араас босож сонингоо уншин дуугай суулаа.

Керри, биеэ барьж ядан босохы нь ажсан Херствүд түүний гомдсоныг ч ойлгожээ. Тэгээд гал тогооныхоо өрөө рүү явж байхы нь хараад:

- Битгий яв л даа. Хоолоо идээч гэв.

Керри юу дуугаралгүй хажуугаар нь гараад явав. Херствүд сонингоо нэг хэсэг уншиж байснаа босож пальтогоо өмсөв. Тэгээд гал тогоо руугаа орж:

- Керри, би гадуур гараад ирье, өнөө орой бие нэг л биш гэв.

Керри хариу дуугарсангүй.

- Битгий уурла даа, маргааш юм бүхэн сайнаар эргэнэ дээ гээд харахд Керри сав суулгаа угаах бөгөөд түүнийг огтхон ч анзаарахгүй байв.

- Баяртай гэж Херствүд хэлээд гарлаа.

Энэ бол сүүлийн үед тэр хоёрын бие бизнээсээ улам хөндийрч байсны анхны сүрхий илрэл болсон бөгөөд зоогийн газрын хаагдах хугацаа дөхөх тусам тэднийд урамгүй уур амьсгал улам хүчтэй болсоор авай. Херствүд дотроо зовон тарчилж байгааг нууж чадахаа болиод байхад Керри би одоо яадаг билээ л гэж бодно. Тэгээд тэр хоёр хоорондоо бараг үгийн солиогүй болов. Херствүд Керригээс хөндийрч байснаас ийм болсонгүй харин Керри л түүнээс дөлдөг болсноос шалтгаалж байжээ. Херствүд эний нь гадарлав. Тийнхүү хайхрахгүй байгаад нь Херствүд дургүй нь хүрч байв. Тиймэрхүү нөхцөл байдалд Херствүд Керритэй аль болох найрсаг байхыг хүчхээх нь хичнээн бэрхтэй байсан боловч чармайсаар байжээ. Гэтэл Керри ерөөс тоох янзгүй ааш гаргаж байв.

Тэгсээр сүүлчийн өдөр нь болжээ. Жигтэйхэн сүртэй юм болно гэж Херствүд аль хэдийнээс бодон бухимддаг байсан бол тэр өдөр нэгэнт болохоор харин ч дотор онгойх шиг болжээ, юу гэвэл нартай дулаахан, бусад өдрүүдээсээ ялгагдах юмгүй байлаа. Тэр өглөө цайгаа уухаар хоолныхоо өрөө рүү явахдаа Херствүд өөрийн байдлыг бодсоноос нэг их ч муу биш юм даа гэж бодож байв.

- За өнөөдөр чинь энэ хорвоо дээр мий хамгийн сүүлчийн өдөр болж байна шүү дээ гэж Херствүд, Керрид алиалан хэлэхэд цаадах нь инээмсэглэв. Херствүд мөрөн дээрээсээ нэг их хүнд юм аваад хаячихсан мэт бие нь амрах шиг болж сонингоо ихэд амтархан уншиж суулаа. Херствүд хоолоо идэж дууссаны дараа:

- Би зоогийн газраараа түр орчихоод эрэлд гарна. Маргааш бүхэл өдөржингөө эрнэ. Одоо завтай болсон хойно ажил олоход амар байх гэж бодож байна гэж хэлээд инээмсэглэсээр гэрээс гарч Ворен Стрит гудамжийн үг явав.

Шонеси аль хэдийн ирчихсэн байв. Дундын хөрөнгөө тэр хоёр оруулсан хувийнхаа хэмжээгээр хуваан авчээ. Херствүд тэнд хэдэн цаг байж байгаад гадагш гарч гурван цаг орчим болоод хүрч ирэхэд урам нь нэгмөсөн хугарчээ. хэдийгээр тэр муу зоогийн газраас залхаж байсан боловч одоо ингээд бүрмөсөн хаагдаж байгааг нь бодохоос гонсойж ийм байдалд хүрээгүй болоосой гэж бодно.

Шонеси албаны хүтйэн царай гаргасан сүрхий ярвагар байв. Таван цаг болоход тэр:

- За одоо мөнгөө тоолоод хуваая гэлээ.

Тийнхүү хөрөнгөө хуваажээ. Зоогийн газрын эдлэл юмсыг түрүүний борлуулчихсан байсан тул мөнгийг нь хоёр түнш хуваан авав.

Херствүд, хамгийн сүүлчийн удаад ч эелэг сайхан зантайгаа байх санаатай их л хичээнгүйгээр:

- за ингээд баяртай гэхэд Шонеси дуртай дургүй:

- Баяртай гэж хэлээд харсан ч үгүй.

Тийнхүү Ворен гудамжинд байсан зоогийн газар устжээ.

Керри тун сайхан хоол цай бэлдээд байсан боловч Херствүд даанч их уруу царайтай иржээ.

- За юу болов доо? гэж Керри нүүр рүү нь шимтэн харж суув.

- Ингээд л дуусах нь тэр гэж Херствүд пальтогоо тайлангаа хэлэв.

Керри түүнийг ажиглахдаа мөнгө санхүүгээр хэр зэрэг үлдээ бол гэж л сонирхож байжээ. Тэр хоёр хоол цайгаа идэж уух зуур бараг ярьж хөөрсөнгүй.

- Өөр газар хувь нийлүүлж ороход мөнгө чинь хүрэхээр байгаа юу? гэж Керри асуухад Херствүд:

- Хүрэхгүй ээ, өөр юм хийж жаал мөнгө хурааж байж л болохоос биш гэв.

- Нэг газар олж орвол сайнсандаа гэж түгшүүр, горьдол зэрэгцсэн Керри хэлэхэд Херствүд:

- Болох байгаа гэж горьдож байна гэж бодлогошронгуй хэлэв.

Тэрнээс хойш Херствүд өглөө бүр пальтогоо өмсөөд гэрээс гардаг болов. Эрэлд тийнхүү гарч байсан анхныхаа үед халаасандаа долоон зуун доллартай явахад хаа нэг газар орж ажиллах юм

олдох байлгүй гэж боддог байжээ. Архи пивоны үйлдвэрийн газрууд пивоны газар олгоод өөрснөө хянаж дэмжин ажиллуулдгийг Херствүд мэдэж байсан болохоор тийм үйлдвэр дээр очъё гэж бодсон боловч тийм газрыг төвхнүүлэн ажиллуулна гэхэд хэдэн зуун доллар орох учраас мөнгөө барчих санагдав. Одоогоор гэр орны нь бүх зардал сард наян доллар болж байв. Тэгэхлээр өөрт нвь юу ч үлдэхгүйд хүрэх учир болихоор шийджээ.

- Тийм ажил таарахгүй юм байна, өөр л юм хийж мөнгө хураах хэрэгтэй юм даа гэж ухаан нь сэргэлэн үедээ бодох болов.

Ажил төрлийн талаар бодох нь их болох тусам тийм ажил олно гэдэг яггүй асуудал болж байлаа. Зоогийн газрын эрхлэгчийн ажил хайх уу? Сонингуудын зарлалаас үзэхэд тийм юм ер байсангүй. Гагцхүү олон жил ажил хийсэн буюу тийм газрын хөрөнгөний тэн хагас эсвэл гурваны нэгтэй тэнцэх хувь нийлүүлж байж тийм ажил олдохоос биш зүгээр шууд олдохгүй ажээ. Гэтэл хувь нийлүүлж орох тийм их мөнгө яаж байх билээ.

Гэлээ ч гэсэн Херствүд ажил сураглан хөөцөлдөж эхэлжээ. Хувцас хунар сайтай, гаднаас харахад тарган цатгалан золбоолог харагдах тул хэн ч гэсэн түүнийг овоо юмтай хүн байна гэж хууртмаар байлаа. Херствүд одоодөчин гурав хүрч бага зэрэг мах суусан болохоор явган их явах тийм амраггүй болжээ. Сүүлийн жилүүдэд ядахнаа бие бялдрын ажил ердөө ч хийж байсангүй. Өдөржин тэнэх дээ аль тааралдсан газраа трамбайд сууж явж байсан боловч оройхон болоход хөл нь ядарч мөрөөр нь хөшиж тавхай нь халуун оргих шиг болжээ. Байн байн босож суух ч баахан ядаргаатай санагдана.

Хүмүүс түүнийг хөрөнгөтэй хүн гэж бодож байгааг Херствүд өөрөө андахгүй мэдэж байлаа. Тэгж бодох нь улам дараа болж байлаа. Хүний нүдэнд тийм сүрхий харагддагтаа гомдож байсангүй харин тийм байдал нь өөрийн хөрөнгө чинээтэй таарахгүй байгаад л ичиж байжээ. Зочид буудлын талаар нэг бодсон боловч энэ талаар огт туршлагагүйн дээр найз нөхөд гэж нэг гол чухал зүйл байдгийг саналаа. Америкийн том том хотод түүний дотор Нью-Йоркт ч гэсэн танил тал явсан улс олон буй боловч Чикакогийн паянг нь тэд андахгүй билээ. Аль эсхүл хүнсний бараа, аар саар эдлэл буюу нийгмийн даатгалын газар ажилламаар санагдавч даанч туршлагагүй билээ.

Нэг тийш явж ажил эрнэ гэхээс хаширмаар бодогдох болов. Ямар нэг газрын үүдэнд ээлж дугаар хүлээн байж ороод ажил байна уу гэж? хүн харахад юмтай намбатай харагддаг байж тэгж царай алдана гэж бодохоос больё гэмээр санагдаж, голоор нь хүйт оргино.

Херствүд хотоор дэмийн тэнэж яваад нэг удаа гадаа их л хүйтэн тул нэг том гэгч зочид буудлын газар орж хөлийннх нь өрөөнд орж дулаацжээ. Аятайхан хувцастай хэн боловч тийм газрын хөлийн өрөөний зөөлөн сандал дээр хичнээн удаан суухад болдгийг өөрөө мэдэх ажээ. Тэр “Бродвей Сентрал” гэдэг зочид буудал бол Нью-Йоркдоо хамгийн дээгүүр ордог томоохон газар юм. Херствүд сандал дээр сэтгэлийнгүн зовлонтойгоор лагхийн суулаа. Иймдээ хүрэх гэж байх уу даа. Зочид буудлын хөлийн өрөөгөөр өдөржин сандал дээр сууж өнждөг улсыг “сандлын хөлчлөг” гэж нэрлэдгийг Херствүд сонсож байсан. Өөрөө ч тэднийг тэгж нэрлэж байсан цаг бий. Гэтэл одоо өөрөө хуучин танилуудтайгаа тааралдах аюултай байгаа ч гэсэн тэнд хүйтнээс хоргодон ядрахын эрхээр суухаас аргагүй болжээ.

“Ингэж явахын хэрэггүй юм байна. Хаана очихоо урьдаас төлөвлөлгүйгээр өглөө гэрээс гарч байх ямар хэрэг байна?” Эхлээд очих газраа сайн бодож байгаад явж байх хэрэгтэй юм байна

шүү гэж Херствүд дотроо бодлоо.

Ямар нэг зоогийн газар мухлаг худалдагчийн ажил олдож магадгүй юм даа. Тийм орон тоо онгорхой байх явдал бишгүй л байдагсан. Гэвч Херствүд мухлагийн худалгч хийхээ ч больё гэж бодоод тэр санаага бушуухан орхилоо. Зоогийн газрын эрхлэгч байсан байж тийм ажил хийнэ гэдэг юу гэсэн үг вэ гэж бодов.

Херствүд, зочид буудлын хөлийн өрөөнд чилтлээ сууж сууж дөрвөн цагийн алдад гэрийн зүг одов. Гэртээ орж очихдоо их л ажилтай явсан хүний байдал гаргахыг бодовч ер болж өгсөнгүй ядраад тэнд харагдах эргдэг сандал сайхан санагдах тул бушуухан очиж суугаад замдаа авсан хэдэн сонингоо уншиж гарлаа.

Керри хоол цайгаа бэлтгэнгээ хажуугаар нь явахдаа:

- Өнөөдө орон сууцны хөлс нэхсэн шүү гэхэд нь:

- Өө тийм бий гэж дуугарав.

Духаа атируулан бодвол өнөөдөр чинь хоёрдугаар сарын хоёрон, байрны хөлс тушаадаг өдөр байна гэж саналаа. Херствүд халааснаасаа түрийвчээ авахдаа анх удаа нэмж орлог олоогүй үед байрны хөлс төлөх ямар шүү байдгийг мэдрэв. Тэгээд тэвхийсэн ногоон дэвсгэртүүдээ өвчтэй хүн аминд нь орох эмээ харах адилаар харж байлаа. Хорин найман долларыг удаан гэгч нь тоолж аваад Керрийг дахин дэргэдүүрээ өнгөрөхөд, - “Май” гэж өгөөд сонингоо дуугай уншиж эхлэв. Өдөржин тэнэж элдвийг бодон тархи толгойгоо зовоож зовоож байсны хойно өдий төдий цахилгаан мэдээ унших үнэхээр мөнхийн рашаан хүртэх адил ямар сайхан амралт вэ. Тийм юм уншихад өдөржин түгшүүлж байсан юмаа түр болтугай ч мартагнах ажээ. Сонинд бичсэнээр үзвэл нэг залуухан царайлаг хүүхэн, Бруклин дэх чихрийн үйлдвэрийн зээн, баян тарган хар хүнтэйгээ шүүхэд заргалдан салах болжээ. Цааш нь: Принцийн булангийн цас мөсөнд нэг хөлөг онгоц сүйдсэн байна. Урлагийн ертөнцийн талаарх дэлгэрэнгүй, сайхан бичсэн мэдээнүүдийн дотор гарсан жүжгийн тухай шүүмж, шинэ жүжигчдийн тухай үнэлэлт, мөд гарах гэж байгаа жүжгүүдийн талаар найруулагчдын ярьсан яриа гэх мэт... Фанни Дейвенпортых, Тавдугаар өргөн гудамжинд өөрийн театртэй болох гэнэ. Августин Дэви, “Лир Ванг” тавих гэнэ. Вандербильтынхан найз нарынхаа хамт флорид орохоор улирлынхаа зугаалгыг эхлэж байгааг Херствүд олж уншив. Кендуккийн ууланд нутгийн хүмүүсийн хооронд буудалцаан болжээ. Тийнхүү Хертсвүд энэ мэтийг уншин уншин радиаторын хажуу дахь эргэдэг сандал дээрээ суусаар хоол болохыг хүлээж байлаа.

ЧАРМАЙВЧ ЧАДАЛ МӨХӨСТӨНӨ. ЗОВЛОНГ СӨРӨН

Өглөө нь Херствүд сонин уншиж худалдааны пүүсүүдийн зарлал шүүж үзээд өврийнхөө дэвтэрт хэд хэдэн хаяг тэмдэглэж авлаа. Дараа нь “Ажилд хэрэгтэй хүн авах хэрэгцээ байна” гэсэн зарлалын хэсгийг судлан уншихад дотор нь тун эвгүй оргино. Өдөржин тэнэх маш урт өдөр байгаа болохоор ямар нэг юм олоход сонин л тус болох ёстой. Зарлалд голцуу “талхчин, ачигч, тогооч, үсэг өрөгч, тэрэгчин хэрэгтэй байна” гэсэн гонжийсон урт жагсаалт харагдана. Гэрийн модон тавилгын дэлгүүрт янрав, виски архи үйлдвэрлэдэг пүүсэнл төлөөлөгч хэрэгтэй байна гэсэн хоёрхон зарлал сонирхолтой сагадав. Тийм пүүсийн талаар түрүүнд нь яагаад ч юм санасангүй. Одоохон тэр хаягаар нь очиж үздэг хэрэг хэмээн шийджээ.

Саяын хэлдэг пүүс нь: “Олсбери ба Кампани”, “Виски” гэсэн нэртэй ажээ.

Херствүдийг очиход эрхлэгчийнхээ албан тасалгаанд шууд оруулжээ.

- Эрхэм ноёнтон сайн байна уу? гэж цаад хүн өөр хотоос ирсэн захиалагч гэж бодоод мэндлэхэд Херствүд, хариу мэндлээд:

- Та, төлөөлөгч хэрэгтэй байна гэж зарлуулсан байв уу? тэгээд л ирж байна гэлээ.

Сая учры нь олсон тэр хүн уриалагхан:

- тэгсэн, тэгсэн, бид тийм зарлал өгсөн гэлээ.

- Би энэ талаар нэлээд туршлагатай болохоор танайхаар ороод үзье гэж бодсон юм гэж Херствүд догь байдалтай хэлэв.

- Өө, тийм үү? Та ямар туршлагатай гэнээ, мэдэж болохсно бол уу, гэхэд Херствүд:

- Би урьд томоохон газрын зоогийн газрын эрхлэгч явсан юмаа. Сүүлийн үед Ворен, Гүдзон гудамжинд байсан зоогийн газрын түншээр ажиллаж байсан хүн л дээ гэв.

- За тийм байж.

Херствүд, тэр хүн юу гэх нь вэ хэмээн дуугай хүлээн сууна.

- Бидэнд төлөөлөгч нь хэрэгтэй байна, тэгэхдээ бидний болзол танд таалагдахгүй байх даа.

- Би ойлгож байна. гэхдээ одоо надад шилж сонгоод байх арга алга. Тийм орон тоо байгаа юм бол дуртай л орох байна.

Пүүсийн эрхлэгч “одоо надад шилж сонгоод байх арга алга” гэсэн үгий нь төдий л таашаасангүй. Түүнд өөр төөр ажил шилж сонгох сөгөөтэй сөгөөгүй нь хамаагүй, хамгийн гол нь залуувтар хүн хэрэгтэй байжээ. Маш бага цалин аваад тун шаламгай ажиллах залуухан хүн олж авъя гэж бодож байгаа хүн юмсанжээ. Херствүд түүнд огт таалагдсангүй ядахнаа пүүсийн эздээс илүү эрхэмсэг дүртэй харагдана.

- За бид таны хүсэлтийг ярилцаж байж больё. Хэд хоногийн дараа л шийднэ, харин та бидэнд тодорхойлолтоо өгөөрэй.

- За тэгье гэж Херствүд хариу хэлээд эрхлэгчийн өрөөнөөс толгой дохисоор гарч одлоо.

Байшингийн буланд очоод өврийнхөө дэвсрээс өнөө тэмдэглэж авсан гэрийн модон тавилгын дэлгүүрийнхээ хаягийг харав. Баруун хорооллын Хорин гуравдугаар гудамжинд байдаг юм байна. Херствүд тэндээсээ шууд тийшээ явлаа. Тэр пүүс жижигхэн, харваас ядуулаг, хүмүүс нь ажилгүй сууж байх харагдан. Цалин хөлс ч гэж шальдаггүй бололтой. Херствүд цонхоор нь шагайснаа л имй газар орохын ч хэрэг алга гэж бодов.

“Эднийд долоо хоногт арваад долларын хөлс авах эмэгтэй хүн байх хэрэгтэй байх” гэж бас сэтгэв.

Өдрийн нэг цаг болоход өлөрхөж байгаагаа мэдээд Медисон-Стрит гудамжин дахь ресторанд оров. Тэнд ороод одоо хаагуур явдаг билээ гэж бодлоо. Ядарсан ч гэж жигтэйхэн. Хүйтэн салхи шавхуурдсан ёозгүй бүрхэг өдөр. Медисон-Стритын нөгөө талд хүний хөл ихтэй зүг рүү хандсан цонхтой өндөр өндөр байшин харагдах нь бүгд зочид буудал ажээ. Херствүд эндээс гараад тэдгээрийн нэгэнд орж аөлийнх нь өрөөнд сууж амрахаар болов. ТИЙМ газар дулаан ч, гэрэл гэгээ сайтай ч өчигдөр Бродвей-Сентрал зочид буудалд баахан суухад таньж мэдэх хүн тааралдсангүй. Энд с гэсэн тааралдахгүй биз гэж бодно. Хүн хар ,хөсөг тээврийн миегнэлдэх Бродвейн тийш харсан цонхны дэргэдэх цэмбэгэр зөөлөн сайхан суудлуудын нэг дээр сууж аваад Херствүд бодолд дарагдан нозоорон байв. Тэгээд сууж байхад бүр ч ягтсан биш мэт санагдана. Тийнхүү буйдан дээр суугаад гудамж руу харж байх зуур түрийвчиндээ хэдэн зуун доллартойгоо бодоход сэтгэл нь бас нэлээд амарна. Хээнцэр ганган зочид буудлын хөлийн цэлгэр өрөөнд тийнхүү суухад өдөржин ажлын эрэл хийж улаа эргэтэл гүйсэн зовлонгоо түр боловч мартагнана. Гэвч энэ бол илүү хэцүү зовлонгоос арай бага шиг зовлон руу тэмүүлээ л гэсэн үг юмаа. Цаг минут ч өнгөрч өгөхгүй санагдах ажээ. Херствүд зочил буудлаар орж гарч байгаа хүмүүс, гадаа гудамжаар яваа хүмүүсийг баахан ажиж хувцас хунар, зан байдлы нь сонжвол тэд жаргал цэнгэл эдэлж яваа нь илхэн харагдана. Нью-Йоркт ирсээр л гадуур яваа хүн харыг ингэж сайтар ажиглах бололцоотой болсон бололтой. Хийх юмгүй хүн ингэж ч суухаас өөр яах билээ. Тэр залуус яасан баяр баясгалантай, энэ хүүхнүүд юу гээч гоо үзэсгэлэнтэй харагдана вэ? Яасан сайхан хувцаслана вэ. Хүн бүр л нэг зорьсон юмандаа яарч байгаа бололтой. Харахаас нүд гялбам үзэсгэлэнтэй хүүхнүүд сээтэн хаяхыг Херствүд ажлаа. Иймэрхүү амьтадтай найз танил болоход хичнээн ч их мөнгө хэрэгтэй байж вэ. Үүнийг мань эр андахгүй. Өөрөө бишгүй л тэгж явдагсан. Харин тэр цагаас хойш мөн ч их уджээ.

Дөрвөн цөг болов бололтой. Баахан эртэвтэр санагдавч Херствүд харихаар шийдэв. Дэндүү эрт харивал Керри цаг дэмий үрлээ гэх байх гэж бодно. Эрт очьё гэж эс хүсэвч өдөр даанч өнгөрч өгөхгүй. Байрандаа очно гэдэг чинь гэртээ орно гэсэн үг. Тэгэхлээр тухлан суугаад сонингоо уншиж болно. Тэнд байхад ядахнаа Бродвейн энэ сэтгэл санаа үймүүлсэн байдал нүдэнд тусахгүй, сонингоо тайван уншиж болно. Тэгээд гэрийн зүг одлоо. Керри үдшийн бүрий болж буй, өдрийн сүүмгэр гэрэлд ном уншаад ганцаар сууж байв. Херствүд хармагцаа:

- Нүд чинь муудна шүү гэлээ.

Пальтогоо тайлаад тэр өдрийнхөө болсон явдлыг ярья гэж боджээ.

- Вискийн бөөний худалдааны нэг газраар орлоо. Тэнд л ажилд орж магадгүй.

- Тэгвэл мөн сайхнаа.

- Зүгээр гэж бодож байна шүү.

Байшингийн буланд сонин зардаг хүнээсээ “Ивнич Уорлд”, “Ивнин Сан” гэдэг хоёр сонин худалдаж аваад шууд гэртээ орж ирээд радиатор бараадан хийн гэрлээ асаав. Нөгөө унших дуртай юмнуудаа уншиж эхлэхэд урьд оройн адил өдөржингийнхөө зовлонг түр мартагнаж эхлэв.

Маргааш нь хашаа явахаа ч мэдэхгүй байсан болохоор бүр их зовлонтой санагджээ. Арван цаг хүртэл сонингоо уншиж хайсан боловч таармаар аятайхан газар олдсонгүй. Ямар ч болтугай гарч явах л хэрэгтэй гэж бодохоос зүрх рүү нь зүү шивэх шиг болж байв. Хаашаа явах вэ? Хаана очъё доо?

- Энэ долоо хоногийнхоо хоолны мөнгийг марталгүй орхиод яваарай гэж Керри тайван хэлэв.

Долоо хоногт хоолны зардалд арван хоёр долларыг Керрид гардуулдаг байв. Энэ удаа тэр тухай үг сонсмогц Херствүд ялимгүй шүүрс алдаж түрийвчтэй мөнгөө гаргаж ирэв. Түрийвчтэй хэдэн мөнгөнөөсөө байн байн авахаас л биш нэмж байгаа юм огтхон ч үгүй тул аймшигтай санагджээ.

“Бурхан минь. Ингэж байж хэрхэвч болохгүй дээ” гэж дотроо бодов. Харин Керрид сэтгэлий нь зовоогоод яахав гэж бодоод юу ч хэлсэнгүй. Тэртэй тэргүй мөд мэдэгдэх л байж. Керри ч цаадахынхаа байдлыг ухаарч мөн дотроо “Би яана даа? Яахлаараа би ингэж зовж явах учиртай хүн юм бол?” гэж боджээ.

Херствүд гэрээс гараад бас л Бродвейн тийш явав. Ямар ч болтугай жаал бодъё гэж шийджээ. Төдхөн Гучин нэгдүгээр гудамжин дахь Гранд Хотел зочид буудлын газар хүрч хөлийнх нь дулаан сайхан өрөөнд орж суух нь хориод сууцны байшингийн дундуур явган харайлгаж ядарсан түүнд амралт болох байлаа.

Үсчингээр нь орж үсээ засуулдаг хэрэг гэж бодно.

Үсээ засуулчихаад хөлийнх нь өрөөнд баахан сууж болох байсан ажээ.

Тэнд суугаад цаг өнгөрч өгөхгүй тул гэр лүүгээ эртхэн буцна. Энэ явдал хэдэн өдөр давтагдав. Өдөр болгон ажил горьдож явах түмэн зовлон санагдаж урам бүрмөсөн хугарч, ичихийн ихээр ичиж зочид буудлын хөлийн өрөөнд дэмий л суух ч залхмаар болжээ.

Цасан шуурга тавьж гэрээс гарч чадалгүй гурван өдөр болов. Нэг орой нэвсийтэл орж эхэлсэн цас өглөө босоход ч үргэлжлэн орсоор төдийгүй салхи ширүүсчээ. Нүдгүй цасан шуурга болох гэж байна хэмээн сонингуудад зарлаж байв. Цонхоор харахад газар дэлхий зузаан зөөлөн цасанд нэлэнхүй дарагдсан байв.

- Өнөөх хүн маань нүүрсээ бас авчирч өгсөнгүй гэж Керри хэлэв. Нэг хүнээс нүүрс шуудай шуудайгаар нь захиж авдаг байж л дээ.

- Яасан юм бол, би мэдээд ирье гэж Херствүд амьдралдаа анх удаа даалгавар биелүүлэх ажлыг өөрийн сайн дураар уриалагхан авч байгаа нь гэрээс гарахгүй сууж өнжих хүслээ зөвтгөх гэсэн санааных ажээ. Цас өдөржин шөнөжин орж хотын хөл хөдөлгөөн саатаж сонингуудад энэ хотын ядуу хүмүүс арчаагүй хүнд байдалд орж эхлэв хэмээн их л сүржин бичиж гарчээ

Херствүд өөрийнхөө буланд радиатор бараадан хөлөө дулаацуулан сонингоо уншиж суув. Цасан шуурганд хоригдоо гадуур гарч ажил эрэх ажлаас чөлөөлөгджээ. Ажлын тухай ахархан зуур боловч мартагнах түүнд жаргал буюу.

Тийнхүү тайван сууж байгааг нь Керри хараад сэтгэл зовно. Шуурга тавьж байлаа ч гэсэн ингэж амарлангуй суух хэрэг алга, ягтаад байгаагаа мэдсээр байж ингэж суухын хэрэг юу. Гэтэл Херствүд уншлагаа үргэлжлүүлэн Керрийг ч олигтой анзаарахгүй байв. Керри гэр орныхоо ажлаар оролдож Херствүдтэй олон таван үг дэлгэж саад болсонгүй.

Дараа өдөр нь цас зогссонгүй, нөгөөдөр нь жигтэйхэн догшин хүйтэн өдөр болжээ. Херствүд сонинд бичсэн дагуу гэрийнхээ мухарт шигдэн суусаар байв. Гэвч Керрид бага сага тус болж байсныг өгүүлбэл: нэг удаа маханд, бас нэг удаа ногоо авахаар дэлгүүрт очжээ. Тиймэрхүү аар саар ажил түүнд төвөгтэй байсангүй л дээ. Өөрөө бол дотроо: “тэнгэр муухай байхад ийм ажилд явна гэдэг бас л амаргүй хэрэг, тэгэхлээр би энэ гэрт тустай л хүн байна шүү дээ” гэж бодно.

Цаад өдөр нь тэнгэр цэлмэж сонингуудад ч цасан шуурга арилав гэж зарлажээ. Гэсэн ч гудамжаар гишгэхийн аргагүй шалбаагтай байна гээд Херствүд гэртээ шигдсээр их үдийн алдад л сонингоо орхиод гэрээс гарахчаан болов. Гадаа ялимгүй дулаарч байсан болохоор хотын гудамжны шалбааг их. Херствүд Арван дөрөвдүгээр гудамж руу явж тармбайд суугаад тэндээсээ Бродвей орох билет авчээ. Сувд хэмээх гудамжнаа байдаг нэг ундааны газрын зарлалыг олж үзсэн учир тийш очихыг зорьсон авч Бродвей хүрээд бодлоо өөрчилж:

- Тийшээ очоод ямар хэрэг байна? гэж цас шалбааг харж дотроо хэлэхдээ, - Нэгэнт л хувь нийлүүлэн орж чадахгүйгээс хойш горьдлого маань мянган тохиодлоос ганц гэсэн үг, тэгхэлээр эндээ буудаг хэрэг гээд бууж хөлийнх нь өрөөнд орж суугаад одоо яах билээ хэмээн бодол болов. Тийнхүү дулаан газар хоргодон сууж байтал нь сайхан хувцастай нэг эрхэм түүгээр явж байснаа Херствүдийг гэнэт харж нүдэндээ итгэж ядсан байдалтай ширтэн алхаагаа удаашруулснаа танив бололтой ойртож ирэв.

Тэр хүн Чикакогийн уралдааны морины том эзэн Каржил болохыг Херствүд шууд таньжээ. Керрийг анх удаа театр сонирхогчдын тавцан дээр тоглосон үед тэр хүн авгайнхаа хамт ирж танилцаж байсан ажээ.

Херствүд давхийн цочих шиг болж ихэд зовж байгаа нь түүний царайнаас тодхон харагдана.

- Өө, Херствүд байна шүү дээ гэж Заржил дуу алдан хэлэхдээ түрүүний таньсан бол ингэж уулзаж эвгүй байдалд оруулахгүй байж дээ хэмээн бодов.

- Тиймээ , та сайн байна уу? гэж Херствүд хариу мэндлэв.

- Сайн, сайн, энд байгаа юу өөрөө? Гэж Каржил ярих юмаа олж ядан хэлэхэд Херствүд:

- Үгүй, үгүй, хүнтэй л уулзах гэж явна гэлээ.

- Таныг Чикагогоос явсан гэж дуулсан, яагаад явсан юм бол доо гэж гайхдаг байсан юм.

Херствүд, тэр хүнээс бушуухан салахын түүс болж

- Би энд ирээд тун их удаж байгаа хүн шүү дээ гэв.

- Ажил төрөл амжилттай юу?

- Дажгүй ээ.

- Больж дээ.

Тэр хоёр хэдэн хормын турш бие биеэ гайхасхийн дуугай болов.

- за би дээшээ гарлаа. Хүн хүлээж байгаа. Баяртай гэж заржил хэлэхэд Херствүд хариуд нь толгой дохив.

“Барам гэж, ийм юм болно гэж би бүр мэдээд байсан юм” гэж Херствүд үүд рүү явахдаа амандаа үглэж байв.

Хесртвүд тэндээс гараад хэд хэдэн хороолол дамжин алхаад цагаа харвал дөнгөж нэг цаг хагас болж байлаа. Аль нэг газар очих юм уу ямар нэг юм хийе гэж бодно. Тэр өдөр тун ёозгүй хачин муухай байсан болохоор гадуур гармааргүй санагдах бөгөөд явсаар хөл нь даарч нойт оргихлоор тармвайд суугаад Тавин есдүгээр гудамж руу явлаа. Хаагуур явсан ч ялгаагүй санагдах болжээ. Тэнд буугаад Долдугаар өргө чөлөө рүү буцаад алхсан боловч явахын аргагүй шалбааг. Хаашаа ч явах тодорхой зорилгогүй дэмий алхах тэвчихийн аргагүй хэцүү бөгөөд хамрын шуухинаа ч хүрч байгаа бололтой. Тэгэхлээр нь байшингийн буланд очиж урд зүг явах трамвай хүлээн зогслоо. Өнөөдөр гадуур гарахын хэрэггүй байж, гэртээ харьдаг хэрэг гэж шийдээд гурван цаг хагаст гэртээ орж ирэхэд нь Керри нэлээд гайхжээ.

- Өнөөдөр даанч муухай өдөр байна гэж Херхствүд хэлээд пальтогоо тайлж, гутлаа ёольж өмсөв.

Шөнө Херствүдийн бие жаахан чичрүүлэхэд хинин уужээ. Өглөө болоход халуунтай байсан тул гэрээс гаралгүй хэвтэж Керри түүнийг бөөцийлөв: Өвчтэй байхдаа түр арчаагүйтэж, царай алдаад үс гэзгээ ч санасан юмгүй, нэг муу үхмэл өнгөтэй халаат нөмөрсөн нь сүр сүлдий нь улам дарна. Жалх нь буурсан нүд нь ёлтойгоод ихэд өвгөрсөн харагдана. Керри тэр бүхнийг ажиглаад олиогүй санагдсан нь аргагүй цаанаасаа нэг л болж өгөхгүй байж.

Орой тийшээ Херствүд жигтэйхэн царай дортой болохыг Керри ажаад орондоо орж хэвт гэжээ.

- Ганцаараа унтаж үз. Тэгсэн нь дээр байх, би оры чинь засаад өгье.

- За тэгье.

Керри ор дэвсгэрий нь засах зуураа:

- Юу болох нь вэ? Яасан хачин амьдрал вэ? гэж хувь тавиландаа гоморхож байлаа.

Өдөр нь Херствүд радиотор бараадан бээрсэн янзтай суугаад сонингоо уншиж байхад Керри дэргэдүүр нь гарахдаа ажиж хөмсөг зангидаж байсан ажээ. Тэгээд урд талынхаа зэврүүн өрөөндөө цонхны дэргээд суугаад дэвтлээ уйлсан байна. Ингээд амьдрал минь дуусдаг хэрэг үү? Ийм өмгөр өрөөнд ажилгүй суудаг, хайр халамж муутай хүнтэй насыг барах хэрэг үү? Энэ хүний хоол ундыг хийдэг эгэл шивэгчнээс өөрцгүй юм болоод байна шүү дээ гэж боджээ.

Тийнхүү нүдээ улайтал уйлчихаад ор дэвсгэрийг нь засах гэж дэнлүү асаан Херствүд дээр ороход цаадах нь уйлсныг нь мэджээ.

- Юу болоо вэ? гээд нүүр рүү нь ширтэн харах бөгөөд хоолой сөөнгөдүү, толгойтой үс нь самаагүй сэгсийх нь түүнийг улам муухай болгожээ.

- Яагаа ч үгүй гэж Керри сулхан хариулав.

- Уйлсан байна шүү дээ

- Тэр худлаа шүү.

Өөрийг нь хайрлаж өрөвдсөндөө уйлаагүйг мань эр мэдэж байлаа.

- Уйлах хэрэггүй. Санаа зоволтгүй болно гэж Херствүд хэлээд орондоо оров.

Нэг хоёр хоногийн дараа Херствүд бие ялааршиж боссон боловч тэнгэр бас л муухай байсан тул гэрээс гарсангүй. Сонин зардаг нэг итали хүн түүнд өглөөний сонин авчирч өгөх тул тэдгээрийгээ их л анхааралтай уншиж байлаа. Удалгүй хэдэн удаа гарч үзсэн боловч бас нэг хуучин танил хүнтэй тааралдсанаас хойш зочид буудлуудын хөлийн өрөөнд суух аргагүй болжээ.

Тэгээд өдөр болгон гэртээ яагаа ч үгүй эрт ирэх, гадагш гарахгүй өнхжих нь ихсэв. Ер нь өвлийн цагт ажил эрэх даанч таарамжгүй ажээ.

Тийнхүү гэрийн мухар сахихдаа Керрийн гэр зуурын ажлыг сонжин ажвал гэр орны ажлыг бөөрөнхийлөх арга чарга, арвич хамгач байх талаар багагүй дутагдалтай нь мэдэгджээ. Урьд мөнгөөр ингэж сууж яваагүй болохоор тийм юмыг ажигладаггүй байж. Гэрт ажилгүй суухад хэд хэдэн долоо хоног харвасан сум шиг өнгөрчээ. Керри мягмар гариг болгонд мөнгө нэхэж авна.

- Манайх аль болохоор хэмнэж чадаж байгаа биз дээ? гэж нэг мягмар гаригийн өглөө Херствүд асуухад Керри:

- Би чадахынхаа хэрээр л арвилдаг даа гэв. Энэ удаад Херствүд нэмж юу ч хэлсэнгүй, харин маргааш нь:

- Гэнсвүртийн зах дээр очиж үзсэн үү? Гэв.

- Тийм зах байдгийг би мэдэхгүй шүү дээ.

- Тэндээс юм авах их хямд гэж хэлэлцэх юм.

Керри энэ бодлыг нь огт тоосонгүй. Тиймэрхүү зүйлийг ердөө ч сонирхсонгүй явжээ.

- Нэг кило мах хэдээр авч байгаа вэ? гэж Херствүд бас нэг өдөр асуухад Керри:

- Янз бүр л байдаг. Гуяны мах хорин хоёр цент ч байх шиг.

- Их үнэтэй юм биш үү?

Энэ мэтээр Херствүд өдөр болгон асуух болж сүүлдээ юмны үнэ тогтоох хэнээтэй мэт болж гэр орны ажилд оролцох нь ч идэвхжив. Анх ялимгүй юмнаас эхэлжээ. Нэг өглөө Керри гадагш гарах гэж малгайгаа өмсөж байхад Херствүд хаашаа явах нь вэ? гэж асуугаад талханд явлаа гэхэд нь би яваад ирэх үү дээ гэхэд Керри уухайн тас явуулжээ.

Тэрнээс хойш байсгээд л:

- Юманд явах хэрэг байна уу? гэж асуудаг болов. Тэгсээр Керри түүнийг юм болгонд гүйлгэх болов. Харин долоо хоног бүр авдаг арван хоёр доллараа авахыг байжээ. Хожим нэг мягмар гаригийн өглөө Керри:

- Чи надад мөнгө өгөөч гэхэд Херствүд:

- Хэд хэрэгтэй байна? гэв. Керри учры нь сайн ухаарч байв.

- Таван доллар. Нүүрсчинд өгөх өр.

Мөн тэр өдөр Херствүд хэлэхдээ:

- Байшингийн буланд сонин зардаг итали хүн чинь бас нүүрс худалддаг, нэг бүшелий нь хорин таван центээр өгдөг гэж байна лээ. Би түүнтэй наймаа хэлэлцээд ирэмз гэв.

Керри энэ үгий нь үл тоомсорлон:

- Тэгвэл тэгнэ л биз гэснээ, - Жорж, манай нүүрс дуссан, өнөөдөр хоол идэх юм бол нүүрс хэрэгтэй байна гэв.

Херствүд, Керрийн пу шаардахыг хүлээдэг болов. Шаардсан бүгдий нь худалдаж авахаар хоршоо дэлгүүр рүү явна, гэхдээ хэмнэж харамлах арга сүвэгчилсээр байв. Нэг орой сонингоо авч ирэхийн хамт:

- Би өнөөдөр хагас фунт л мах авлаа шүү, бид хоёр нэг их иддэггүй шүү дээ гэсээр орж ирлээ.

Тиймэрхүү аар саар хорголоо тоолсон явдалд Керри бүр залхаж, сэтгэл зүрх нь шаналан өвдөж амьдралынх нь өдөр хоног харанхуйлах мэт болно. Энэ эрийн өөр болсныг яана. Ингэж ч хачин болох гэж дээ. Гэрийн мухар сахиад өдөр жин сонин уншаад л сууна. Хорвоо надад падгүй гэсэн шиг л байх болжээ. Сайхан өдөр бол арван нэгээс дөрвөн цагийн хооронд гадуур гарахчаан болно. Керрид хийх ч юм олдохоо больж тэр хүн нүдэнд нь улам зэвүүн харагдах боллоо.

Херствүд дор орсон байдлаасаа гарах зам олохгүйдээ гуныж гутарна. Үлдсэн цөөн доллар нь сар бүр улам цөөрнө. Одоо дөнгөж таван зуун доллар үлдсэн тул энэ хэд маань л хэдүй болсон ч аминд орно хэмээн ихэд нарийлдаг болжээ. Херствүд гэрийн мухар сахидаг болсон үедээ хуучин муу хувцасныхаа зүйлийг өмсөх нь зүйтэй гэж үзэх болов. Тэнгэр муухай нэг өдөр Херствүд:

- Өнөөдөр гадаа тун олиггүй байна, муу хувцастайгаа гарья гэж уучлал гуйсан байдалтай анх удаа хэлжээ.

Тэгсгээд дандаа муу хувцсаа өмсдөг болсон байна.

Урьд сахлаа хусуулах гэж арван таван цент, цайны мөнгө гэж арван цент гарзаддаг байснаа больж эхлэв. Эхлээд тавин цент өгч нэг үзсэнээ сүүлдээ бүр больж арван центээр засдаг үсчинд ордог болов. Сүүл сүүлдээ өдөр болгон сахлаа хусуулах гэж явахаа ч больжээ. Гурав өнжөөд сахлаа хусуулдаг болсноо долоо хоногт ганц удаа хусуулах болов. Бямба гариг гэхэд сахал самбай нь бавайх болжээ.

Өөрөө өөрийгөө хүндлэхээ нэгэнт больж эхэлсэн хойно Керри юунп нэг их хүндэтгэх билээ. Энэ хүн чухам яагаад ийнхүү лойж эхлэв хэмээн бодох болсон байна. Түрийвчиндээ овоо хэдэн доллартай, өмсөе гэвэл сайхан хувцастай, сайхан хувцсаа өмссөн үед хүний нүдэнд олзлогдохгүй харагдана. Чикагод Керри муугаа үзэж явснаа мартаагүй боловч тийм байдлаас гарах гэж зориг мохолгүй тэмцдэг байсан билээ. гэтэл Хертсвүд тэгэхгүй, тэр ч байтугай сонины зарлалыг ч сонирхохоо байжээ.

Дотроо хэлмээр санагдаж байсан зүйлээ хэлэх тохиолдол гарсныг дурдвал: Нэг орой Керри гал тогоондоо мах шарж байхад Херствүд орж ирээд:

- Яасан их тос хэрэглэдэг юм? гэхэд Керри:

- Илүү амттай болгох гэж энэ шүү дээ гэхэд:

- Одоо тосны үнэ хачин их нэмэгдэж байна гэв.

- Хэрэв чи ажлаа хийж байсан бол ийм юм анзаарахгүй байсан даа гэж Деррийг хариулахад Херствүд дахин үг хэлэлгүй цааш явж сонингоо уншиж гарсан боловч дотроо зэвүү нь хүрсээр байв. Анх удаа л Керригээс тийм хатуу үг сонсчээ.

- Тэр шөнө Керри ор дэвсгэрээ зочныхоо өрөөнд засаж унтсан байна. Энэ бол ер бишийн явдал байлаа. Хертсвүд сурсан зангаараа унтлагынхаа өрөөнд орж гэрлээ асаалгүй орондоо орсон хойноо л Керри алга байгааг мэджээ. “Яасан хачин юм? Ном нушаад унтаагүй байгаа юм байхд аа” гэж бодоод дахин өөр төөр юм бодсон ч үгүй дугжраад өглөө сэрвэл Керри хажууд нь алга байв.

Энэ явдал анх удаа тохиолдсон боловч яасан ийсэн тухайг нь огт ярилцсангүй өнгөрсөн нь хачин билээ.

Маргааш нь орой тийш болоход Керри:

- Өнөөдөр миний бие нэг л базаахгүй, би нагцаар унтмаар байна гэлээ.

Гурав дахь шөнө нь Керри ямаоч тайлбар хэлэлгүйгээр ор дэвсгэрээ зочныхоо өрөөнд засав. Энэ бол Херствүдэд сүрхий цохилт байсан боловч юу ч хэлэлгүй тэсэн өнгөрлөө.

За яах вэ ганцаараа унтвал унтаж л байг гэж дотроо бодовч хөмсгөө өөрийн эрхгүй зангидаж байлаа.

ХАВТГАЙ ТАШУУГААР. АЗ ХИЙМОРИЙН ХООСОН ҮЗЭГДЭЛ

Эр эм Вэнс шинэ жилээс өмнө Нью-Йоркт буцаж ирсэн бөгөөд тэр хоёр бүр нарийвчлан хэлбэл Вэнс хатагтай Керрийг мартаагүй байсан боловч Керри хаягаа тэдэнд хэлж өгөөгүй учраас л тэднийхээр ирээгүй ажээ. Керри, Херствүдийн хамт Далан наймдугаар гудамжинд сууж байхдаа л Вэнс хатагтайтай захидлаар харилцаж байсан байна. түүнээс хойш захиа бичихээ байсан нь Керри ер нь тиймэрхүү зантай бөлгөө. Арван гуравдугаар гудамжинд арга буюу шилжин суух болсноосоо хойш захидал бичихээ зогссон төдийгүй хаягаа ч мэдэгдэхгүйг хичээх болжээ. Байраа сольж тэнд очсоны мэдвэл амьдрал нь доройтож эхэлснээс л болж дээ гэж тааварлах болов уу хэмээн нэрэлхэж байв. Тэгээд Керри ямар ч арга ололгүй Вэнс хатагтайд захидал бичихээ больж харамсах болов. Вэнс хатагтай Керрийг яагаад гэнэт сураг тасрав гэж бодохдоо Лав Нью-Йоркоос явчаад л тимй болов, одоо хэзээ ч дахин уулзалдахгүй юм байлгүй гэж бодож байжээ. Тэгтэл нэг удаа Арван дөрөвдүгээр гудамжны дэлгүүрээс юм авах санаатай явж байтлаа гэнэт Керритэй тааралдсандаа маш их гайхсан билээ. Керри бас дэлгүүрээр орох ажилтай явж байжээ.

- Хүүе? Вилер хатагтай сайн уу? Хаанаас гараад ирэв ээ энэ чинь. Яагаад маайхаар орохоо больсон бэ? Та нарыг яасан юм бол гэж би дандаа боддог байсан шүү гэж Вэнс хатагтай дуу алдан хэлээд гярхайлан ажив.

Керри гэнэт тааралдсандаа баярлавч гэлмэх шахаж:

- тантай тааралдсандаа их баярхлаж байна. манайх эндээс холгүй, танайхаар нэг орё гэж дандаа боддог байсан боловч үнэндээ чухам хаана байгаагий нь мэдэхгүй байсан шүү гэв. Вэнс хатагтай ингэж уулзалдана гэж үнэндээ бодоогүй явжээ.

- Манайх Тавин наймдугаар гудамжны хоёр зуун арван наймдугаар байшинд байгаа. Долдугаар өргөн чөлөөний бараг л булан гэсэн үг дээ. Манайхаар очно биз дээ гэж Вэнс авгай дахин лавлав.

- Заавал очно.Тантай уулзахсан гэж би аль хэдийнээ хүсэж байсан л даа. Аль түрүүний уулзах ёстой байсан, гэтэл тэгээгүй, үнэнийг хэлэхэд муухай юм боллоо. Гэхдээ ... гэж Керри очихоор амлав.

- Танайх хаана орсон бэ? гэж Вэнс хатагтай үгий нь гүйцэд ч хэлүүлэлгүй асуучихлаа.

- Арван гуравдугаар гузамж, зуун арван хоёр. Баруун талынх нь гэж Керри дурамжхан хэлэв.

- Өө тэгвэл эндээс ойрхон юм байна шүү дээ гэж найз хүүхэн нь хэлэв. Керри:

- Тиймээ ойрхон, та манайхаар ороорой л доо гэв.

- Ингэж уулзах гэж мөн сайхан аа гэж Вэнс хатагтай давтаж хэлээд инээд алдахын хамт Керрийн хувцас хунар баахан муудсан байхыг ажиж бас ч сууж байгаа газры нь бодовл эднийх ядарч байгаа бололтой гэж төсөөлөв.

Вэнс хатагтай, Керрид хэзээний сайн байдаг болохоор одоо ч гэсэн яаж тус больё доо гэж бодож байх шиг байв.

- Хоёулаа ийшээ орох уу гэж ойрхи нэг дэлгүүрийг зааж эхлэв.

Керри гэртээ буцаж очиход Херствүд сонингоо уншсаар сужж байв. Биеэ өөд татахыг бүр больсон бололтой. Сахал самбайгаа лав л дөрөв хоног хусуулаагүй харагдана.

- Ийм байхад нь Вэнс ороод ирвэл яана! гэж Керри дотроо бодов.

Байдал үнэхээр тэвчихийн аргагүй ягтсан мэт санагдах тул Керри толгойгоо цөхөрсөн байдалтайгаар сэгсрэн, цөхрөнгөө барсан цнзтай холл идэх зуур:

- Өнөөх бөөнийхөө худалдааны газраас асуусан уу? гэж асуув.

- Асуугаагүй. Тэднийх тийм ажлын туршлагагүй хүн авахгүй гэнэ билээ.

Керри дахин үг хэлэх чадалгүй болох мэт санагдсан тул тэр тухай ярихыг болиод түр дуугай болсноо:

- Өнөөдөр Вэнс хатагтайтай тааралдлаа гэхэд Херствүд:

- Өө, тэгээ юу? гэв.

- Нью-Йорктаа эргээд ирчихсэн гэнэ. Сайхан гялалзаж явна.

- Нөхөр нь мөнгөтэй хойно арга байж уу. нөхөр нь олз омог ихтэй ажилтай хүн шүү дээ гэж Херствүд хэлээд сонингоо шагайв. Тэгээд Керрийн маш ядарч цөхөрсөн байдалтай харж буйг нь олж үзэлгүй өнгөрөв.

- Манайхаар ирнэ гэж байна лээ.

- Ирнэ ирнэ гээд хэзээ л ирж байлаа даа гэж Херствүд ёжилсон янзтай хэлэв.

Ихээхэн үрэлгэн авгай шиг санагдах тул Херствүд тэр хүүхэнд хэзээний дургүй байдаг байв. Керри, Хертсвүдийн ингэж хэлэхэд уур нь хүрч:

- надад мэдэх юм алга. Ирүүлээд ч яах юм билээ гэв.

- Хөнгөн дэвүүр шиг авгай даа. Мөнгөө барж ядсан баян хүмүүс л тэдний пянг даах биз гэж Херствүд ёозгүй хэлэв.

- Вэнс ноён тэр зэргийн юманд ажрахгүй хүн байх шүү.

Херствүд Керрийн хэлсэн үгний уг санааг сайтар ойлгон хэвцэглэж:

- Одоо юийм байгаа ч юмуу үгүй ч юмуу яаж мэдэхэв. Амьдрал гэдэг дандаа нэг янзаар байхгүй шүү дээ. Яаж эргэхийг хэн ч урьдаас мэдэхгүй. Нэг мэдэхд үгүйрэх ч юм билүү яаж мэдэх вэ гэв.

Түүний царайд тун шижээргүй шинж тэмдэг тодорч жаргалаа эдэлж яваа хүмүүс хэзээ нэг цагт муугаа үзнэ дээ гэж тавлан бахлах санаагаа илэрхийлэх мэтээр нүдээ ирмэж ирээд л сүрхий ёозгүй хэлэх боловч өөрийгөө тийм биш огт өөр байдлын улмаас ийм болсон хэрэг гэж үзнэ. Энэ

бол түүний урьдын биеэ баахан тоосон, хүнээр толгойгоо тмэдүүлэхгүй явж байсны сүүлчийн илрэл байлаа. Гэртээ суугаад бусад хүн харын явдылг сонирхон уншиж байхдаа заримдаа урьдынхаа даналзаж явсан зан аашийг сэргээж үзнэ. Тийм үедээ гудамжаар ядартлаа тэнэж ажил эрж сураглан муугаа үздэгээ мартагнан шар нь гозолзож:

- Надад ажил хийх чадал байна, би хөг нь өнгөрсөн хүн биш. Хийе гэж хүсээд хөөцөлдөх юм бол юм олдолгүй яахав хэмээн бодох жишээтэй.

Тэгж бодсон цагтаа бушуухан хувцаслаж сахал үсээ хусуулж, бээлийгээ гартаа хийж гайгүй сайн татаад ганасхийн алхаж гарна. Тэгэхдээ хаана очих тодорхой зорилгогүй зүгээр л зан оёгтоо хөтлөгдөн гарах билээ. Ер нь гадуур гарч ямар нэг юм хийх хэрэгтэй үедээ л гэрээс цухуйна.

Гарах бүртээ мөнгөө үрнэ. Юу гэвэл хотын захиргааны байшингаас холгүй газарт мөрийтэй хөзөр тоглодог хэдэн нөхөдтэйгээ санаж тэдэн дээр очиж тоглох, нөхөрсөг үг ярилцах нь түүний нэгэн хэмийн уйтгар гунигтай амьдралд өөр амьсгал оруулдаг байлаа.

Херствүд хөзөр мөрийтэй тоглохдоо нэлээд сайн гэгдэж явсан цаг бий ажээ. Заримдаа зуу, түүнээс ч олон доллар хождог удаа ч бий. Гэвч тэр үед тэр зэргийн мөнгө бол хонжоо биш, харин тиймэрхүү тоглоомонд амт нэмэрлэхийн төдий өчүүхэн зүйл байж. Одоо Херствүд нэг тоглоод азаа үзье гэж бодов.

- Ганц хоёр зуун доллар хожиж болох байлаа. Би чинь покер тоглохоо мартаагүй шүү дээ гэж Хертсвүд бодож байв.

Ийм бодол толгойд нь олон удаа орж байсан боловч одоо л нэг үзээд алдахаар шийдэж буйг хэлэх нь зүйтэй мэт.

Түүний анхны орсон мөрийтэй тоглоомын газар нь гарцнаас холгүй оршдог Баруун гудамжин дахь нэг зоогийн жижиг газрын дээд талд байв. Херствүд тэнд хэд хэдэн удаа ирж үзсэн байжээ. Хэдэн ширээнд суун тоглож байсан чудаатай, заримдаа зүгээр ажиглан зогсдог байв. Энэ удаа тавьж байгаа мөнгө нь нэг ихгүй мөртлөө хонжоо нь овоо их санагджээ. Тэгээд Херствүд хөзөх хуваахын даваан дээр надад хуваагарай гэлээ. Сандлаа ойртуулж суугаад авсан хөзрөө харав. Усад нь түүнийг хулгай нүдээр шимтэн ажиглаж байлаа. Эхлээд Херствүд муу тоглов. Таван саланги мод ирж сольж авах мод ч байсангүй. Гэвч тоглоомоо үргэлжлүүлэв.

- Би өнжив гэж Херствүд хэлэхээс өөр аргагүй болов. Имй хөзөртэй хүн эхнийхээ бооцыг алдахаас өөр замгүй.

Дараа нь овоо мод ирсэн тул сүүл сүүлдээ хожсоор тэндээс гарахдаа түрийвчиндээ нэлээд хэдэн доллар нэмсэн байв.

Маргааш нь Херствүд дахин тоглож олз олох санаатай бас иржээ. Энэ удаа аз дутахад гурван ноён авчихжээ. Түүний эсрэг талд суусан нэг ирланд залуу их дайчин байдалтай бөгөөд Таммани-Холлынхон ерөөс тиймэрхүү улс байдаг л даа. Тэр залуу сайн хөзөр авчээ. Тэр хүн мөрийгөө хамаагүй нэмэн тоглохыг Херствүд ажаад их гайхав. “Энэ этгээд айлган сүрдүүлж байгаа байж мэднэ, гэхдээ л сурамгай хийж байна даа гэж Херствүд бодов. Херствүд модондоо итгэж чадахгүй байж болох байсан боловч ширээний ард суугаад мөрийцөж байгаа мөрийчингүүд үнэн бодит байдлыг түшиглэхээсээ тоглогч этгээдийнхээ санаа бодлыг мэдэх гэж

их хичээдгийг мэдэх тул давгүй царайлж ямар ч байсан тийм байхыг хичээлээ. Өөрөө эртхэн болихгүй бол энэ этгээд түрийвчтэй мөнгийг минь бүгдийг хоосолж мэдэх этгээд байх шиг байна хэмээн Херствүд айх нь айж л байв. гэтэл сайн мод ирж байхад ихээхэн дэнчин тавьж байгаад их мөнгө яагаад хожиж болохгүй билээ хэмээн бодож байхад нь нөгөө ирланд залуу:

- Бас гурвыг нэмлээ гэхэд Херствүд:

- Тэгвэл тав болгочихъё гэхэд ирланд:

- Би ч гэсэн адил гэжээ.

- Надад, дахиад нэмлээ гэж Херствүд хэлээд мөнгөө гаргаж тавилаа.

Нөгөө залуу нь бах нь ханаж буй янзтай ярвайн инээмсэглэхийг Херствүд ажтал цаадахи нь бас тавыг нэмлээ гэжээ.

Херствүдийн духны хар хөлс цувавч улайран тоглосоор хэрээ мэдэлгүй, нэг мэдэхэд бооц нь жаран долларт хүрчээ.

Херствүд угаас нэг их хулчигар хүн биш байсан брловч энэ удаа тийм их мөнгө нэгмөсөн алдвал яана гэж бодохоос хамаг бие нь сулраад явчих шиг болжээ. Сүүл сүүлдээ бууж өгөхөөс домгүй болж модондоо итгэхийг болив.

- Танд юу ирсэн бэ? гэж Херствүд мөрийцөгч этгээдээсээ хөзрөө нээнгээ асуудах цаадах нь:

- Би холбоо хөзөртэй гээд цаасаа дэлгэлээ.

Херствүд урам нь нэгмөсөн хугарч, дуулдах төдийгөөр:

- Би өөрий чинь хожчихлоо гэж бодсон юм шүү гэв.

Нөгөө залуу бүх дэнчингийн мөнгийг хумин авахад Херствүд тэндээс гарч шат уруудах замдаа мөнгөө тоолж үзээд:

- Гурван зуун дөчин доллар гэж амандаа хэлэв.

Зоогийн газар хаагдсанаас хойш яасан ч олон доллар үрж вэ. гэртээ буцаж ирээд одоо дахиж л тоглохоо больё гэж хатуу шийдэв.

Вэнс хатагтай тэднийхээр орно гэж байсныг Керри мартажгүй байсан тул Херствүдэд учирлахыг оролддог болов. Хүний нүдэнд бүү муухай харагдаач гэж л гуйдаг болов. гэртээ орж ирэнгээ муу хувцсаа өмсөөд суудаг бахь байдгаараа л суухал нь Керри:

- Чи яах гэж энэ муу хуучин юм өмсөж суудаг юм? гэхэд Херствүд:

- Гэрт шинэ хувцастай суух ямар хэрэг байна? гэж өөдөөс нь асуув.

- Аятайхан хувцастай байхад өөрт чинь эвтэйхэн биш үү. Манайхаар хүн орж ирвэл яана?

- Жишээ нь хэн байх вэ?

- Вэнс хатагтай ч магадгүй шүү дээ_

- Тэрүүнтэй би уулзах хэрэгцээ байхгүй гэж Херствүд царай барайлган хариу хэлэв.

Биеэ гаргуунд нь орхиж сонингоо уншихаас өөр юм сонирхохоо байсны нь бодохоос Керри здэвүү хүрэхээр үл барам үзэн ядах болжээ.

“Өдөржингөө ажилгүй гэрийн мухар сахиад суух. Тэрүүнтэй уулзах хэрэгцээ байхгүй гээн шүү. Үгүй ер яасан ичдэггүй амьтан бэ?” гэж Керри дотроо бодлоо. _ гэвч тэр өдөр үнэхээр Вэнс хатагтай найз хүүхэнтэйгээ уулзана гээд тэднийхээр ирсэн явдал Керрид даанч гашуудалтай юм болов. Вэнс, хоршоогоор хэсэж явснаа гэнэт тэднийхээр орохоор шийдсэн байж. Нэг муу шат шиг юмаар нь өгсөөд үүдий нь тогшжээ.

Керри гэртээ байхгүйд тэр хатагтай харамсжээ. Херствүд, Керрийг ирж явна гэж бодоод үүд нээсэн байж. Гэнэт Вэнс хатагтай байхыг үзээд жигтэйхэн бантжээ. Угийн давилуун ихэмсэг зан нь унтарч байсан боловч энэ удаа гэнэт оргилох шиг болов. Тэгээд хүчээр:

- Өө. Вэнс хатагтай юу, Сайн байна уу? гэхэд нүдэндээ итгэж ядсан цаадах нь:

- Сайн сайн байна уу? гэлээ.

Түүний хичээн өөр болсныг тэр хатагтай дор нь ажсан бөгөөд Херствүд бүр бажгадан зочин эмэгтэйг ор гэе үү байя уу хэмээн аль ч учраа олохгүй үүдэн дээрээ зогсож байв.

- Гэргий тань гэртээ байгаа юу?

- Байхгүй байгаа. Гадагш гарсан, ингэсгээд ирнэ, та орж байхгүй юу гэхэд нөхдийнх нь амьдрал хачин өөр болсныг ажсан Вэнс хатагтай:

- Үгүй, үгүй, би тун яаруу явна. Би энүүхнээр явж байгаад түр ороод гарья гэж бодсон юм. Хүлээх зав байхгүй. харин манайхаар заавал очоорой гэж гэргийдээ хэлээрэй гэв.

- Хэлнэ хэлнэ гээд Херствүд арагш ухран үүдээ хаав.

Гийчин явсанд дотор нь онгойх шиг болов. Гэвч маш их ичсэн учир эргэдэг сандал дээрээ очиж суугаад атгасан гараа чанга базлаа, бодол боллоо. Керри байшингийн нөгөө талаас ирж байсан тул холдон яваа Вэнсийг таньж ядсаар өнгөрөөжээ. Хичнээн ч онийж хараад нүднийх нь хараа ялгаж чадсангүй.

- Манайхаар хүн ирээ юу гэж Херствүдээс юу юуны түрүүнд асуулаа.

- Ирсэн шүү, Вэнс хатагтай ирсэн гэж Херствүд буруугаа хүлээсэн байдалтай хэлэхэд Керри ихэд догдолсон байдатайгаар:

- Чамтай уулзаа юу гэв.

Энэ асуулт түүнийг суран ташуураар ороолгоод авах шиг болж хөмсгөө зангидав. Тэгээд:

- Би хаалга онгойлгосон болохоор юм үзэх нүдтэй юм бол намайг харсан байлгүй гэхэд Керри гараа зангидан салганаж:

- Үгүй ер. Юу гэж хэлж байна, надад үг хэлүүлсэн үү? Гэхэд Херствүд хээв нэг:

- Юу ч гэж хэлээгүй, их яарч байна л гэсэн гэж худал хэлэв.

Керри ердийн дөлгөөн байдлаа алдаж:

- Чи тэгээд имй хувцастайгаа байсан хэрэг үү? Гэхэд Хертсвүд харин уурлаж:

- Тэгээд яах гэж? Би тэрний чинь ирнэ гэж яаж мэддэг юм гэлээ.

- Чи ирнэ гэдгий нь сайн мэдэж байсан шүү дээ. Манайхаар ирнэ гэж байна билээ гэж би чамд бишгүй хэлсэн шүү дээ. Өөр костюмаа өмс гэж би чамаас хичнээн олон удаа гуйсан бэ. Яасан муухай амьтан бэ гэж Керри хашгирав.

- За чи боль доо, нэг их сүйдтэй юу болсон юм? Тэр баян хүүхэнтэй чи тэртэй тэргүй эн зэрэгцэж үерхэж чадахгүй шүү дээ гэж Херствүд бавтнав.

- Намайг үерхэх гэж байна гэж чамд хэн хэлээ вэ? гэж Керри уурсан омогдов.

- За чи намайг хувцас мөссөнгүй гэж битгий нэг их юм болгоод хэрүүл гуй. Намайг чи яалаа гэж... гэхэд Керри түүний үгийг тасалж:

- Би хүслээ гээд ч чадахгүй маань үнэн л дээ. Гэвч хэнээс болоод тэр билээ? Чи гэртээ дэмий суугаад, өөртөө хамаагүй юманд хошуу дүрээд байхдаа яадаг юм. Яагаад чи явж ажил олохгүй гэрт шигддэг юм? гэлээ.

Энэ бол нартай өдөр тэнгэр ниргэлээ гэх шиг юм болов.

Херствүд, галзуу мэт босон харайж:

- Чи юу гэнээ? Би байрны хөлс төлж байна. Энэ орон байранд байгаа ... гэхэд:

- Байрны хөлс төлж байгаа чинь үнэн. Гэтэл чи байранд хоосон дэмий суухаас өөр ажил байхгүй юм шиг бүү ярь. Чи гурван сарын турш гэрийн мухар сахиж гал тогоонд хошуу нэмэхээс өөр юу хийсэн юм? Чи ер нь надтай яах гэж суусан юм, мэдмээр байна гэж Керри хэлэв.

- Би чамтай суугаагүй гэж Херствүд ярвайн хэлэв.

- Тэгвэл чи Монреальд яасан юм?

- Ямар ч болтугай би чамтай суугаагүй шүү. Тэгж боддог бол больсон дээр. Чи ч өөрөө мэдэж байж мэдэхгүй царайлах хэрэг алга.

Керри түүнийг хэдэн хормын турш ншдээ том болгон ширтлээ. Херствүдтэй хууль ёсоор гэрлэсэн гэж бодож байжээ.

- Тэгвэл чи юу гэж худал хэлсэн юм? Чи намайг яах гэж хүчээр оргуулж явсан юм? гэж Керри уурсан хэлэхдээ хоолой нь чичрэн уйлах дөхөв. Херствүд уруулаа муугай гэгч нь ёрволзуулан:

- Хүчээр гэнэ шүү. Хэн чамайг хүчилсэн юм? гэхэд Керри туйлын их бухимдан гагцхүү:

- Үгүй ер. Үгүй ер. Гэхээс өөр юм хэлж чадалгүй хашгирсаар урьд талын өрөө рүүгээ гүйн оров.

Херствүдийн уур хилэн бадарч биеэ барихаа ч болив. Энэ бол түүнийг бие махбодын болон сэтгэл санааны талаар ихээхэн догдлуулсан явдал болов. Херствүд нүүрээ гараараа арчаад ийш тийш харснаа тэр өрөөнөөс гарч хувцас хунараа сольж эхлэв.

Керрийн байгаа өрөөнөөс чимээ анир огт үгүй. Херствүд хувцаслаж буй чимээнээр Керри цурхирахаа больсон ажээ. Ганц ч улаан мөнгөгүй орхиод явчих нь уу гэж айж байсан байна. Харин бүр түүнээс сална гэж бодоход санаа зовох юмгүй байв. Хувцасны шүүгээ онгойлгон дээд тавиураас нь бүрх малгайгаа аваад хаалгы нь хаахыг сонсоод гараад явчлаа гэдгийг Керри мэдмэгцээ босож усан нүдлэхээ ч болив. Цонхоор харвал Херствүд Зургадугаар өргөн чөлөө чиглэн алхаж яваа харагдана.

Херствүд, Арван гуравдугаар гудамжаар явснаа Арван дөрөвдүгээр гудамжийг хөндлөн гарч Юнион талбайн зүг алхав. Тийнхүү алхах зуураа “Ажил эрэх хэрэгтэй, гэрээс гарч ажил эр гэсэн шүү дээ” хэмээн дотроо бодсоор байлаа.

Керрийн зөв гэдгийг ухаан нь сэхээрсээр атал Херствүд өөрийгөө зөвтгөх гэж оролдоно.

“Тэр Вэнс авгай ирж байж л имй юм боллоо, юу гээчийн гайтай золиг вэ. намайг хичээн айхавтар ажваа, юу гэж бодон байгаагий нь мэдсэн л дээ”.

Далан наймдугаар гудамжинд байхдаа Вэнс хатагтайтай хэд тааралдаж байснаа Херствүд саналаа. Тун их баян хүүхэн шиг харагдахлаар нь өөрөө ч тэдний зиндааны хүн шиг харагдах гэж оролддог байжээ. Гэтэл тийм муухай хувцастай байхад нь тааралдана гэдэг юу гэсэн хэл вэ. Ингээд Херствүд хөмсөг зангидан уруу царайлан:

- Шуламсыг даа! гэж хэд хэд давтан хэлэв.

Херствүдийг гэрээс гарахад дөрвөн цаг арван таван минут болж байсан бөгөөд Керри уйлж байлаа. Тэр орой хоолгүй өнжих болжээ.

“Юу гээчийн чөтгөр шиг хэрэг вэ. Би тийм ч муу хүн биш, бүр яахаа алдсан ч хүн биш” гэж Херствүд өөрөө өөрийнхөө шившгийг хаацайлах санаатай бодож явна. Талбай дээр очоод эрэн тойрон нүд хэсүүлэн харвал хэд хэдэн том зочид буудал харагдана. Нэгэнд нь очиж хоол идэхээр шийджээ. Тэр үедээ Нью-Йоркийн хамгийн догь ресторан байсан “Мортон Хаусын” сайхан цэлгэр өрөөнд өгсөн явж ороод зөөвөлчтэй сандал дээр суун сонингоо уншиж байлаа. Тийм үнэтэй хоол унд идэхэд түрийвчний мөнгө тун цөөрч байгааг ч Херствүд бодохгүй байв. Тэрээр хар тамхичин аятай мартагнахыг л их юманд бодох болжээ. Сэтгэлээ бага ч болтугай сэргээх, хүслэнгээ аар саар боловч биелүүлж байхыг бодох болжээ. Маргааш юу болохыг бодох сөгөөгүй болж, дахин ямар гай нүүрлэхийг тунгаан бодох сэхээгүй болж байв. “Мөд ганц ч долларгүй болно” гэсэн бодлоо үхэл зайлшгүй ирнэ гэдэг шиг түр болтугай ч мартахыг хичээж байх ба бараг тэгж бодохгүй байж чадахыг дөхөж байлаа. Ганган дэгжин хувцастай хүмүүс зузаан хивсэн

дээгүүр хойш урагш хөлхөлдөхийг хараад урьд цагийнх нь дөмөг явсан үе бодогдоно. Тэр зочид буудалд байгаа залуухан царайлаг эмэгтэй цүнхэг зайнд төгөлдөр хуур дарж байх нь ихэд тааламжтай санагдсан тул Херствүд дөхөж суугаад сонингоо шагайж байв.

Тэр оройн хоолонд Херствүд бүтэн хагас доллараа заржээ. Найман цаг хагасын алдад хоолоо идэж дуусаад харахад хүмүүс тарж байх ба гудамжинд дэггүй хүмүүсийн бөөмнөрөх нь улам их болж байв. Хаашаа явъя даа, гэртээ очно гэхэд Керри унтаагүй байгаа, тийшээ өдийд явж болохгүй. Ер нь энэ шөнө очихоо больё. Би чинь өөрийн толгой мэдэлтэй хүн. Херствүд хайрцаг янжуур худалдан авч гадаа гарвал жууч худалдаачин, морин тойруулгын төлөөлөгч, жүжигчин гэх мэт өөрийнх нь мах цусны тасархай гэмээр баахан хүн байшингийн буланд зогсоно. Тэнд Херствүд зогсож байхдаа Чикагогынхаа явдлыг санаж тийм цагийг хэрхэн өнгөрөөж байснаа бодов. Мөрийтэй тоглоомоор өнгөрүүлсэн явдал олон бий ажээ. Тэгж санамцаа мөрийтэй хөзрөөр тоглоё гэж бодов. Херствүд жаран доллар алдсанаа санаж, “Тэр удаад би олигтой тоглож чадаагүй юм даг. Бууж өгөх хэрэггүй байсан юм. тэр этгээдийг сүрдүүлж болох л байсан. Тэр орой нэг л хийморьгүй байснаас тийм болсон” гэж бодов.

Тэгээд хожих ямар бололцоо байсан, яаж тоглоцгоосон, тэр залууг бага зэрэг сүрдүүлсэн л бол болох байж гэж бодлоо. “Хөзрөөр мөрийцөхөд миний нас тогтсон, хожиж болно, энэ орой үзэлцдэг хэрэг гэж” шийдэв.

Дэнчийнгийн их мөнгө нүдэнд нь үзэгдэх шиг болно. Хэдэн зуун доллар хожиж юу магад, аз мэдэх хэрэг. Мөрийтэй тоглоомоор хөлжиж баян цатгалан яваа хүнийг алиныг тэр гэх вэ, зөндөө л байдаг!. “Тэд ч гэсэн эхлээд над шиг мөнгө гэх шалих юмгүй улс байсан шүү дээ” гэж Херствүд дүгнэлт хийв. Тийнхүү урьдын шигээ санан тэрүүхэнд байгаа нэг тоглоомын газар очихоор болов. нэгдүгээрт ингэж бодсон, цаашилбал зоогийн газар сайхан хоол унд идэж ууугаад холимог дарс балгаж сэнгэнэсэн сайхан ороомол навчин тамхи татсанаас болоод өөрийнхөө арчаагүй байдлыг мартагнан бараг л хуучин цагийн догь Херствүд болчихлоо. Тэгэхдээ урьдын Херствүд яагаад ч болж чадаагүй юм, яагаад гэвэл одоо энэ хүний нүнжиг нь зад үсэрч, зүүд зэрэглээ шиг юмны хойноос хөөцөлдөж байгаа амьтан болсон шүү дээ. Тэр хөзрийн өрөө нь эртдийнхээс бараг ялгаагүй гагцхүү арай дөмөг ундааны газрын арын өрөө байжээ. Херствүд хэсэг ажиж зогссоноо төдхөн сонирхол татагдан тоглож гарлаа. Эхлээд эртдийн адил тун овоо тоглон нэлээд хожиж эхэлснээ бага зэрэг алдан эхлэхэд улам улайран хор шар нь гозолзон үзэлцэж гарав. Нэг удаа гартаа муухан модтой байсан боловч дүүрсэн хэрэг хэмээн сүрдүүлэх арга хэрэглэн нэлээд их мөнгө хожиж магнай тэнийн баярлаж байв.

Урам нь бадарч энэ орой аз хийморьтойгоо байх юм гэж бодлоо. Өөр хэн ч түүн шиг тийм азтай биш байх шиг санагджээ. Дахин нэг удаа барагтайхан хөзөр барьсан боловч мань хүн мөн л сүрдүүлэг хэрэглэж эхэлсэн боловч цаадуул нь сайтар ажиглан санаа бодлы нь дотро нь орсон мэт таамаглаж байлаа. “Би гурван дадартай хүн болохоор бууж өгтөл нь тавина” гэж нэг нь боджээ. Дэнчингээ нэмж эхэлцгээв.

- Дахиад арвыг тавилаа.

- Мөн адил гэж мөрийцөгч нь хэлэв.

- Бас арав.

- Мөн алил.

- Бас арав.

- Мөн адил.

Тэгсээр байгаад банканд маш их мөнгө цугласны дотор Хертсвүдийн далан таван доллар ороод байлаа. Өрсөлдөгч этгээд нь тун сүрхий бодож бодож “энэ этгээдийн мод үнэхээр мундаг байвал яана?” гэж бодсон ч хөзрөө нээхээр шийдэв.

- Таны хөзөр юу вэ? гэхэд Херствүд хөзрөө гаргавар тэр нь дарагджээ. Тийнхүү далан таван доллараа нэг дор алдсандаа Херствүд их цухалдав. Тэгээд дахиад нэг үзье” гэж гонсойсон байдалтай хэлэв. Цаадахь нь “тэгвэл тэгье” гэлээ.

Зарим тоглогчийг гарч явахад оронд нь сонирхогчид орж суув. Херствүд бага зэрэг хожиж алдаж ээлж дугаартай байсан боловч нэг мэдэхнээ цаг талийж арван хоёр дөхөж баахан ядарсан тул дахиад хорин доллараа алдаж зүрх рүүгээ зүү шивүүлэх шиг болов.

Шөнийн нэг цаг арван таван минут болж байхад л Херствүд тоглоомын газраас гарчээ. хөл татарсан хоосон хүйтэн гудамж түүнийг доромжлон угтах мэт санагдана. Херствүд, Керритэй хэрэлдсэнээ ч юман чинээ бодолгүй баруун тийш чиглэн алхаж байлаа. Шатаараа өгсөөд өрөөндөө юу ч болоогүй аятай орж явчив. Сэтгэл зүрх нь мөрийтэй тоглоомд мөнгө алдсан явдалд л тарчилж байлаа. Ороо сандайлж суугаад мөнгө тоолоход нэг зуун ерэн доллар, хэдэн жижиг мөнгө л үлдсэн байв. Мөнгөө цааш нь хийгээд хувцсаа тайчиж эхлэв.

“Би гэдэг хүн яаж орхио вэ” гэж Херствүд өөрөө өөрөөсөө асуулаа.

Өглөө нь Керри түүнтэй бараг үгийн зөрөөгүй байв. Херствүд ажлын эрэлд гарсан маань дээр юм даа гэж бодлоо. Керритэй эвгүй муухай харьцсанаа мэдэж байсан боловч түүнтэй эвлэрэх талаар ямар ч оролдлого хийсэнгүй, цөхрөнгөө барж байлаа. Хоёр гурван өдөр гэрээс гарч явахдаа жинхэнэ нүнжигтэй хүний байдлаар буюу түүний ойлгож байгаагаар жинхэнэ баян хүний байдлаар явах ёстой байсан боловч даанч их мөнгө орсон нь гомдолтой ажээ. Түрийвч нь дахин гучин доллараар нимгэрснийг нь эс өгүүлэн хэлэхэд Херствүд тэгж хэд хоног гадуур гарч мөнгөө хамаагүй зарснаас бие сэтгэл хоёроороо ихэд доройтжээ. Чухам тийм дээрээ хүрмэгц мань эр эрүүлээр сэтгэхийг хичээн ухаанаа зарж эхлэв.

- Өнөөдөр байрны хөлс нэхэж хүн ирнэ шүү гэж Керри хэлэв.

Энэ бол гурван өдрийн өмнө Керрийн амнаас гарч байгаа үг байв.

- Өө тийм үү?

- Тийм ээ, өнөөдөр хоёрон.

Херствүдийн зовхи буугаад явчлаа. Тэгснээ түрийвчээ арга буюу гарган ирэв. “Орон сууцны хөлс төлнө гэдэг шиг мондийн юм байдаг гэж үү” гэж Херствүд хэлэв.

Сүүлчийнхээ ганц зуун долларт орох дөхөж байлаа.

ЗОРИГ НЬ СЭРГЭЖ, АЖЛЫНХАА ЭРЭЛД ДАХИН ГАРАВ

Сүүлчийн тавин доллартаа орох болсон тухайг нь нарийвчлан ярих хэрэг алга. Херствүд хичнээн нарийллаа ч гэсэн түүний долоон зуун доллар нь дөнгөж зургадугаар сар хүргээд дуусчээ. Сүүлчийн зуун доллар үлдэхийн үед Херствүд одоо сүйрэн балрах цаг удахгүй болов хэмээн мэдэж байсан юм.

- Манайд мөнгө даанч их ороод байх юм, ямах хачин юм гэж Хертсвүд нэг удаа махан дээрээс болж хэлэхэд нь Керри:

- Миний бодоход нэг их зарчихаад байгаа юм алга шүү дээ гэв.

- Мөнгө маань дуусах гэж байна. Яагаад ийм амархан дуусаж байгааг би ойлгохгүй байна.

- Нөгөө долоон зуун доллар чинь уу?

- Ганцхан л зуу л үлдлээ.

Херствүд аймаар гутарсан байдалтай харагдана. Керри ч гэсэн урсгалаар л явж байсан шиг бодогдлоо. Гэхдээ тиймэрхүү юм болно гэдгийг аль түрүүний мэдэж байжээ. Тэгээд:

- Жорж, чи гарч ажил хайвал яасан юм, ямар нэг юм чамд олдмоор юм даа гэхэд Херствүд:

- Бишгүй эрлээ. Хүн ажилд авахгүй байхад заавал ав гэх эрх байх биш хэцүү байна шүү гэв. Керри түүнийг ширтэн харж,

- Зуун доллар чинь удахгүй дуусна, тэгэхлээр юу хийе гэж бодож байна% гэхэд цаадах нь:

- Мэдэхээ болиод байна, ажил л эрдэг байх гэв.

Ийм үг сонсоод Керри айх шиг болов. Одоо яана хэмээн цухалдан бодож эхлэв. Театрын урлаг бол өөрийнх нь хэзээний хүслэн болсон алт мөнгөөр гял цал болдог тэр ертөнцөд нэвтэрч болох хаалга мэт бодогдоно. Чикагод үйлээ үзэж байхдаа тзатрын тайзыг бараадахаар оролдож байсан бол одоо бас л тэгж үзэхээс өөр замгүй санагджээ. Херствүд мөн ажилд орохгүй юм бол өөрөө одоо ямар нэг юм олж хийхийг бодох хэрэгтэй. Одоо л ингэж гараад ажил олохын төлөө энд тэндэх газруудын хаалга үүдийг татдаг ч юм билүү гэж бодлоо.

Театрт ямар аргаа хөөцөлдөж орох вэ, лав л Чикагод байхдаа буруу аргаар хөөцөлдсөн байжээ гэж санав. Бодвол тэр талын ажил жич эрхэлсэн хүмүүс байдаг байх, тэд хүслийнх нь дагуу ажилд орох бололцоо олгож өгдөг байж магадгүй яа.

Түүнээс хойш нэг хоёр хоногийн дараа нэг өглөө хоол цайгаа идэж уун ярилцаж байх зуураа Керри Сара Бернхардт Америкт тоглохоор ирэх гэсэн зарлал байна гэжээ. Херствүд ч тэр зарлалыг уншсан байж.

- Тайзан дээр ямар аргаар гардаг юм бол гэж Керри зүгээр сонирхсон байдалтай асуув.

- Мэдэхгүй шүү. Жүжигчин элсүүлж авах тусгай төлөөлөгч хүмүүс байдаг байлгүй.

Керри кофегоо оочлон дээш ч харсангүй.

- Тийм байнгын ажилтай хүмүүс байдаг хэрэг үү?

- Тийм л бол уу гэж бодож байна шүү.

Керрийн шохоорхон асууж шалгааж байгааг Хертсүүл анзаараад:

- Чи чинь арай жүжигчин болох юмсан гэж бодсоор байгаа юм биш биз дээ? гэхэд Керри:

- Үгүй, үгүй, зүгээр сонирхсон юм гэлээ.

Яагаад ч юм Херствүд түүнийг жүжигчин болгох дургүй байдаг байж. Гурван жилийн турш ажигласнаараа Херствүд, Керрийг тэр талаар хэзээ ч нэг их юманд хүрэхгүй гэж бодох болсон билээ. Дэндүү эгэл, дэндүү найрсаг зантай санагддаг байж. Түүний бодлоор жүжигчин хүн гэгч хамаагүй илүү сүржин годгонуур тонгочуур маягийн хүн байж таарах ажээ. Түүгээр ч барахгүй театрын тайзан дээр очих юм бол жудаггүй эрхлэгчийн идэш болж амархан хувираад бусдаас ялгаагүй юм болно гэж бодох бөгөөд бусдын адил гэж мань эр юу хэлж байгаагаар сайн ойлгож байлаа. Керри царайлаг хүн, амжилт амархан олж мандахлаар намайг яаж ч магадгүй гэж муу санаандаа боддог байжээ.

- Жүжигчин болно гэдэг чинь чиний бодож байгаагаас хамаагүй хэцүү ажил байгаа байх шүү, би бол тийм бодлыг аль хэдийн орхих байсан.

Керри энэ үгийг нь сонсоод жүжигчин болох авьяасгүй гэж басамжилж байна гэж бодов.

- Чикагод намайг сүрхий авьяастай юм гэж чи өөрөө хэлж байаагүй билүү?

Маргалдаан гарах нь гэж болгоомжлоод Херствүд:

- тэгж байсан, үнэн, гэхдээ Чикаго, Нью-Йорк хоёр чинь газар тэнгэр шиг ялгаатай шүү дээ гэв.

Керри хариуд нь юу ч дуугарсангүй, дотроо гомджээ.

- тэргүүн зэргийн жүжигчинд бол театр сайхан ажил, харин эхэлж байгаа хүнд дээш ахина гэхэд даанч их цаг хугацаа орно гэж Херствүд ярилаа.

Сэтгэл нь ялимгүй хөдөлсөн Керри:

- За бүү мэд дээ, мэдэх юм алга гэжээ.

Энэ явдал эцэстээ юу болох вэ гэсэн бодол түүний толгойд харван оров. Юу гэвэл: өөрийг нь ингэж баларч байх үед Керри теарт орж амжилт олбол намайг хаячихаж магадгүй гэж боджээ. Херствүд ерөөс Керрийн оюун цхааны хэр чадлыг яагаад ч юм сайн ойлгож чадаагүй байв. Хүний сэтгэлийн агуу их чанарыг мань эр ерөөс ойлгоогүй хүн учраас тэр билээ. Хүн ухаанаараа биш ч гэсэн сэтгэлээрээ агуу их байж болдог гэдгийг хэзээ ч мэдэж аваагүй ажээ. Чикагогийн тэр нэгэн Аври Холл хэмээх сайн дурын жүжгийн тоглолтыг тодорхой нэхэн саная гэхнээ тэр бол олон жилийн тэртээх зүйл байлаа. Түүнээс гадна энэ эмэгтэйтэй бишгүй удаан хугацаагаар амьдарч үзсэн боловч тийм бишрэм авьяастай гэмээр юм огт үл санагдана.

- Би мэдэж байна аа, би л бол тэр тухай ер бодохгүй. Жүжигчин болно гэдэг эмэгтэй хүнээс маш их мэргэжил шаардах ажил шүү гэж Хертсвүдийг мэдэмхийрэхэд Керри:

- Намайг тийм юм бүү хөөцөлд гэж байгаа бол өлсөж өлбөрсөн дээр болж байгаа хэрэг үү? Ер нь чи ингэхэд яагаад өөрөө ажил олж хийдэггүй хүн бэ? гэв.

Херствүд бэлээхэн хэлэх үг байсангүй, ер нь тэгээд тиймэрхүү үг сонссоор чих нь дөжирчээ. Тийм учраас ч :

- За боль доо гэв.

Ийм яриа болсны эцэст Керри “энэ юу гэж хэлж байсан ч хамаагүй, далдуур хөөцөлдөнө” гэж шийджээ. Энэ хүний аяыг дагаж явж гуйлгачин болохоо больё. Жүжигчин болж чадна. Нэг газар орж л чадах юм бол цааш нь болно. Тэр цагт энэ хүн юу гэх бол? гэх мэтээр бодоод Бродвейн нэг сайхан жүжигт тоглох болж орой бүр жүжигчнийхээ хувцасны нүүр болон нүүр будаж гоёх өрөөнд ордог болсон, арван нэгэн цагийн алдад орой бүр жүжиг тараад гарахад үүдэн дээр сүүх тэрэгнүүд хүмүүсээ хүлээн байгаа нь нүдэнд харагдах болжээ. Өөрөө гарамгай жүжигчин болно уу, байна уу тэр хамаагүй мэт бодогдоно. Гагцхүү театрт л орж авах нь хамгийн гол бөгөөд нэг орчихвол хүрэлцэхүйц цалин аваад дуртай хувцсаа худалдан авч, өөрийн мэдлээр зарж байх мөнгөтэй болж, дуртай тийшээгээ явж байх бололцоотой болбол хичнээн сайхан билээ гэж бодож байлаа. Керрийн толгойд имйэрхүү бодол бүхэл өдөржин эргэлдлээ. Тийм амьдралын өнгө жавхаа нь Херствүдийн сүр сүлд доройтохын хэрээр улам хурц өнгөлөг жавхаалаг санагдах болжээ.

Тиймэрхүү бодол Херствүдийн толгойд ч орж ирээд байдаг болсон нь гайхалтай мэт билээ. мөнгө хариугүй дуусахын алдад бага ч гэсэн тус нэмэр болох юм юу байдаг билээ гэж бодох болсноос тэр бизээ. Керри хэдэн доллар олдог болбол бас ч нэмэр шүү дээ. Тэгээд гайхал маань нэг өдөр иймэрхүү бодлоо гаргаж хэлэхэд хүрчээ.

- Би өнөөдөр Жон Дрейктэй тааралдлаа. Энэ намар энэ хавьд зочид буудал нээх гэнэ. Тэр цагт намайг ажилд авна гэсэн гэж Херствүдийн ярихад Керри:

- Тэр чинь юун хүн бэ? гэв.

- Чикагогийн Грэнд Пэсификийн экэн байхгүй юу.

- Өө, тийм бий.

- Би жилд мянга дөрвөн зуугаад доллар авах юм байна.

- Сайхан хэрэг ээ? гэж Керр баярлан хэлэв.

- Энэ зуныг л бараад орхивол учир байнасанж. Тэгвэл дажгүй болохсон. Би хуучин зарим нөхөдтэйгээ ч холбоо барьж эхэллээ гэж Хертсвүдийг худал хэлэхэд Керри чин үнэн гэж бодоод нээрээ л энэ зуныг давж орхивол цаашдаа болох юм байна, одоо даанч хэцүүдэж байгаа хүн юм даа гэж бодов.

- Чи одоо хэдэн доллартай байгаа вэ?

- Ердөө тавьхантай үлдсэн.

- Бурхан минь Яана аа. гурван долоо хоногийн дараа бас л байрны хөлс төлөх цаг боллоо.

Херствүд толгойгоо гараараа тулаад газар ширтэн сууснаа:

- Чи нэг театрт ордог юм уу? Яавал дээр вэ? гэв.

Санаа бодлы нь хэн нэг хүн дэмжсэнд нь баяласан Керри:

- Нээрээ тэгсэн л дээр байхаа гэж хэлэв.

Херствүд, Керрийн баярлаж байгааг ажаад:

- Би ямар л ажил тааралдана, хамаагүй хийнэ. Заавал нэг юманд орно гэлээ.

Нэг өглөө Херствүдийг гараад явсан хойно Керри гэр орноо янзалж цэвэрлэхээд аль олигтой өөдтэй гэсэн хувцсаа өмсөөд Бродвейн зүг гарч одов. Энэ хавийн газрыг хамаг сүрлэг тос бүхний төв гэхээс өөрөө тодорхой мэдэхгүй байсан бөгөөд энд гурван театр байдаг, тэгэхлээр нөгөө төлөөлөгчийн газрууд нь бас л энэ хавьдаа байх чөстой гэж бодож байв.

Ямар ч болтугай Медисон талбайн театр дээр очиж төлөөлөгчийнх нь газрыг сураглая гэж шийдэв. Ингэх нь л зүйтэй мэт санагджээ. Тэгээд тэр театрын мөнгө хураагчаас асуухад, тэр хүн толгойгоо цонхоор цухуйлган:

- Аан? Театрын төлөөлөгч үү? Би мэдэхгүй. “Зарлалаас” асуухгүй юу, тэнд мэдэж магадгүй гэхэд Керри:

- Тэр чинь юу юм бэ? сонин сэтгүүл хэлж байна уу? гэхэд тийм юм мэдэхгүй байгаад нь баахан гайхсан нөгөө хүн:

- Тийм дээ, ямар ч сонин сэтгүүлийн мухлагаас олдоно гэж эелдэгхэн хэлээд ясан царайлаг бүсгүй вэ гэж бодлоо.

Керри мухлагаас “зарлал” худалдаж аваад л театрын төлөөлөгчдийн газар хаана байдгийг хайн уншиж эхлэв. Олоход тийм ч амархан биш шиг санагдаж, тэр Арван гуравдугаар гудамж гэдэг нь тэндээс хэд хэдэн хороолол газар орших тул тийш явалгүй чухал хэрэгтэй тэр сонингоо барьсаар харихаар шийдэж гагцхүү дэмий цаг үрсэндээ харамсаж байв.

Херствүд аль хэдийн ирчихсэн суудаг газраа сууж байлаа.

- Чи хаачив аа?

- Театрын төлөөлөгчийн газар хаанаа байдгийг мэдхээр явж байгаад ирлээ.

Зорьсон хэрэг хэр зэрэг бүтэлтэй вэ гэж асуух гэснээ зүрхэлсэнгүй, харин нэг сонин ихэд шохоорхон шүйлгэж харж байгааг нь ажаад,

- Наадах чинь юу вэ? гэв.

- “зарлал”. Тэр хүн намайг эндээс хаягууды нь олно гэсэн юм.

- Тийм юм олох гэж Бродвейгээр явсан юмуу, би мэднэ шүү дээ, надаас л асуухгүй дээ.

- Чи хэлээд өгөх чинв яасан юм? гэж Керри уншсан чигээрээ хэлэв.

- Чи өөрөө надаас асуугаагүй шүү дээ.

Керри, тэр сонины жижигхэн үсэгтэй мөрүүдийг дэмий л нүд хэсүүлэн харна. Дэргэдээ байгаа хүнийг яасан дэндүү хайхрамж халамгүй хүн юм гэж л толгойд нь бодогдож байлаа. Түүний хийж буй, хэлж буй бүхэн нь Керрид улам л дараасан болж байх тул өөрийнхөө хувь тавилан нимгэнд гомдох нь ихсэж байх ажээ. Нүднийх нь нулимс юу юугүй гүйлгэнэн ирж сормуусан дээр нь тогтов. Херствүд энэ байдлы нь ажмагц:

- Алив үзээдэхье гэв.

Тэр завсар нь дотроо уужруулах санаагаар Керри урд талынхаа өрөөнд оров. Удалгүй буцаад орж ирэхэд Херствүд харандаа барьчихсан захидлын нэг дугтуйн дээр юм бичиж байв.

Энд гурван хаяг бичихлээ гэхэд нь Керри түүнийг нь авч харвал нэг нь Бермудез хатагтай, нэг нь маркус Женкс, нөгөө нэг нь Перси Вейл гэсэн гурван нэр байхыг олж үзэв. Тэгээд түр зуурхан бодосхийж байснаа үүд рүүгээ эргэж:

- Би одоохон явлаа гэж явуут хэлэн эргэж харсан ч үгүй гарав.

Херствүд хойноос нь ялимгүй ичингүйрсэн байдалтай хаж дотроо эр хүний зоримог бодол бодохыг завдсан боловч тэр нь юм ч болсонгүй тэгсгээд удаан сууж чадалгүй босож малгайгаа өмсөв. Аль нэг тийш явах хэрэгтэй болсон тул “Ямар ч болтугай гадуур жаал алхъя” гэж шийджээ.

Гараад харсан зүг рүүгээ гэлдэрлээ.

Харин Керри нөгөө хэдэн хаягийнхаа дотроос хамгийн ойр санагдсан Бермудез хатагтай лугаа уулзахаар тийш явж очвол тэр өайшин нь хуучин орой байрыг албан гаүар болгосон бололтой байв. Бермудез авгайн албан тасалгаа нь хоёр өрөөнөөс бүрдэх бөгөөд урьд тэр нь унтлага, хөлийн өрөө хоёр байсан гэмээр ажээ. Үүдэн дээр нь “Зөвшөөрөлгүйгээр орж болохгүй” гэсэн бичиг байлаа.

Керрийг үүдний өрөөнд ороход хэдэн эрэгтэй хүн юу ч ярихгүй, хийсэн ч юмгүй сууж байв.

Керри хэн юу гэх нь вэ гээд хүлээн зогсож байтал өрөөний хаалга нээгдэж эр хүнэрхүү хоёр авгай гарч иржээ. Биеэ жадайтал барьсан хувцастай цагаан зах, ханцуй гялалзуулсан улс байв. Араас нь дөч тавь эргэм насны пагдгар, цайвар үстэй, хурц нүдтэй авгай гарч ирэ.в Ажваас тэр авгай сэтгэл сайхантай бол уу гэмээр. Ямар ч болтугай инээмсэглэж харагдана.

- Битгий мартаарай гэж өнөөх хоёр авгайн нэг нь хэлэхэд атигар авгай:

- Мартахгүй ээ, харин та хоёрдугаар сарын эхээр хаана байж байх вэ гэлээ.

- Писбүргт гэж цаад эмэгтэй хэлэв.

- А тэгвэл тийшээ захиа бичнээ.

- За тэгээрэй гээд тэр хоёр гарч явлаа.

Атигар авгайн царай тэр дорхноо албаны хүний хүйтэвтэр өнгөтэй болов. Эргэн харахдаа Керрийг сонирхон нүднийх нь харц түүн дээр тогтон:

- За, залуу хүүхэн ямар хэргээр явж байна вэ? гэв.

- Та Бермудез хатагтай юу?

- Мөөн.

Керри юу гэж хэлдэг билээ хэмээн үгээ олж ядан түгдэрсхийснээ:

- Та театртаа хүн авахыг мэддэг хүн үү? Гэв.

- Тиймээ.

- Та намайг авахгүй юу?

- Туршлага бий юу?

- Тун ялихгүй дээ

- Ямар жүжигчидтэй тоглож байсан бэ?

- Жүжигчид гээд байх юмгүй. Нэг л жижигхэн жүжигт...

- За мэдлээ гэж атигар авгай Керрийн үгийг таслан хэлээд

- Одоогоор хэлж мэдэх юм алга гэхэд Керрийн урам хугараад явчлаа.

- Та Нью-Йоркт туршлага олж авах хэрэгтэй хүн байна л даа, гэхдээ ямар ч болтугай хаягий тань аваад хоцоръё гэж өнөөх сайн санаатай бол уу гэж бодсон авгай нь хэлэв.

- Пагдгар авгайг албан тасалгаа руугаа явж орон ортол Керри хөдөлж чадахгүй харан зогссоор хоцров.

Сайхь авгайн таслан орхисон яриаг лангууны ард сууж байсан залуу эмэгтэй залгаж:

- Таны хаяг юу гэнээ? гэхэд Керри дэргэд нь ойртож очиж:

- Жорж Вилер хатагтай гэлээ. Цаад эмэгтэй нь Керрийн нэр усыг бүтэн бичиж аваад явж болно гэлээ.

Женск ноёны албан газар очоод ч Керри мөн иймэрхүү байдалтай тааралдсан бөгөөд нэг ялгаа нь юу байсан гэвэл ярианыхаа төгсгөлд хэрэв та орон нутгийн театрт ажиллаж байсан юмуу

эсхүл таны нэр орсон тийм хөтөлбөр байгаа бол би ямар нэг юманд авч болохоор байна гэж тэр хүн хэлсэн байна.

Гурав дахь театрын газар очиход төлөөлөгч этгээд нь:

- Та ямар ажил хийх бодолтой байгаа юм? гэхэд Керри:

- Би таны асуусныг сайн ойлгосонгүй гэхэд цаадах нь:

- Шог жүжиг, үзэгдэлд ч юмуу, аль эсвэл найрал дуучин болох санаатай юмуу гэсэн үг гэлээ.

- Би жүжигт л орж тоглохыг хүсэж байгаа юм гэж Керри хэлэв.

- Уухай, тэгвэл мөнгө төлөх хэрэгтэй болно доо гэж нөгөө этгээд хэлэхэд Керри урьд нь иймэрхүү юм болно гэж огт бодож байгаагүй нь инээдтэй боловч “Хэдийг төлөх ёстой юм” гэж асуулаа.

- Түүнийг бол та өөрөө мэдэх хэрэгтэй гэж тэр хүн овжин байдалтайгаар хэлэв.

Керри өөдөөс нь ширтэн харж мэл гайхаад өөр юу ярихаа ч мэдэхгүй байснаа:

- Мөнгө төлчихвөл та намайг ажилд оруулах юм уу? гэлээ.

- Бид ажилд авахгүй бол мөнгийг чинь буцааж өгнө.

- Өө, тэгэлгүй дээ.

Төлөөлөгч, ярилцаж байгаа хүүхнээ хашир суугаагүй хүн гэдгийг мэдээд:

- Ямар ч гэсэн тавин доллар төлчих, тавиас доош бол хэн ч хөөцөлдөхгүй гэхэд Керрийн магнай тэнийх шиг болж:

- Баярлалаа. Би энэ тухай бодъё гэлээ. Тэгээд гарахыг завдталаа гэнэт асуумаар санагдан:

- Намайг чухам хэдийд ажилд оруулах вэ? гэхэд нөгөө хүн,

- Яг төдийд гэж хэлэх хэцүү байна. Нэг долоо хоногийн дотор ч байж магадгүй, сарын дотор ч байж магадгүй. Танд таарахаар ажил гарвал бид өөрийг чинь хамгийн түрүү авна л даа.

- Өө, тимй үү гээд Керри муухан шиг инээмсэглэн гарч одлоо.

Театрын төлөөлөгч хойноос нь ширтэн харж байснаа

- Энэ эмэгтэйчүүд тайзанд л нэг их дурлах улс юм даа гэж бодлоо.

Керри тавин доллар төлдөг юмуу байга юмуу, мөнгий минь авчихаад ажилд оруулж өгөхгүй бол яана вэ? гэж баахан бодов. Керри, очир алмастай бөгж, зүү, бас хэд хэдэн үнэт эдлэлтэй билээ. Тэр бүгдээс барьцааны газар хадгалуулах юм бол тавин доллар олж болох байлаа.

Херствүд түрүүлээд гэртээ ирсэн байв. Керрийг тийм удаан эрэл хийнэ гэж бодсонгүй.

Херствүд эрлий нь ямар үр дүнтэй болсны нь шууд асуух зүрх хүрэхгүй тул:

- За сонин юу дуулдана даа гэж асуув.

Керри бээлийгээ тайлангаа:

- Ажил ердөө ч олдохгүй байна. Мөнгө төлбөл ажилд оруулж өгөхийг бодъё гэцгээх юм гэлээ.

- Хэдийг шаардах юм? гэж Херствүд асуув.

- Тавин доллар гэв.

- Өөр юм бас нэхэхгүй байна уу?

- Өө, өрөөсөн дугуйнууд л байдаг юм шив дээ. Мөнгө авчихаад ажил олж өгөхгүй байж ч мэдэх улс байна л даа.

- Би л бол тийм юманд тавин доллараа өгөхгүй гэж өөрөө мөнгөтэй байгаа юм шиг, өөрөө асуудлыг шийдэж байгаа юм шиг хэлэв.

- Мэдэх юм алга. Ямар ч болтугай эрхлэгч ганц нэг хүнтэй нь уулзаж үздэг юм бил үүдээ.

Херствүд хичнээн зовлонтой ажил болохыг огт үл анхааран тайван байдалтай, урагш хойшоо хэдэнтээ займчсанаа хумсаа мэрж эхлэв. Тиймэрхүү онцгой тохиолдолд юм бүхэн зүй ёсоороо болж буй мэт түүнд санагдах ажээ. Азнасхийж байж л хөдлөх минь дээр гэж бодов.

ХҮСЛЭНГИЙН ЕРТӨНЦ, ЦЭВДЭГ ХОРВОО

Дараа өдөр нь Керри бас л эрэлдээ гарч, “Казино” театрт ирж найрал дуучдын тоонд орох гэхнээ мөн хяслан мундсангүй. Дуучдын дунд орж аятайхан зогсоод бхйх хүсэлтэй хүүхнүүд гэдэг зээтүү бариад газар малтах хүмүүсээс цөөнгүй байдаг бололтой. Бие гоолиг, царайлаг л бол хэн хэдий чинээ авьяас чадаотай вэ гэж тэднийг ялгаж үздэггүй бололтой. Хүн тус бүрийн санаа бодол мэдлэг огт падгүй ажээ.

- Грей ноёнтой уулзах гэсэн юмсан гэж Керри “Казиногийн” хаалгаар ормогц үүднийх нь дүнсгэр царайлсан хаалгачингаас асуувал:

- Ажилтай байгаа, хүнтэй уулзах завгүй байгаа гэв.

- Хэзээ уулзах завтай байх бол та хэлж өгнө үү?

- Өөрийг чинв ирээрэй гэсэн юмуу?

- Үгүй. Тэгвэл нарийн бичгийн даргаар нь дамжуулан зөвшөөрөл авах хэрэгтэй.

- Өө тийм үү, албан өрөө нь хаана байдаг юм бэ?

Тэр хүн, өрөөнийх нь дугаарыг хэлж өгөв.

Тэнд одоо очоод ямар ч хэрэггүй гэдгийг Керри ойлголоо. Тэр хүн тэндээ орж ирэхгүй байлгүй. Керри тэгж цаг үрэхийнхээ оронд өөр газраар орсон маань дээ гэж бодов.

Бусад газар очиход бас л тиймэрхүү урамгүй болох нь даруй мэдэгджээ. Дэйли ноён урьдаас зөвшөөрөл аваагүй бол хэнийг ч хүлээн авдаггүй байж. үүний нь Керри үүднийх нь өрөөнд бүхэл цаг дэмий хүлээж сууснаа нарийн бичгийнх нь дарга нэг ёсорхог багөөд жишимгшй царайлсан Дорней гэгчээс сонсжээ.

- Та уулзъя гэсэн хүсэлтээ өөрт нь бичих хэрэгтэй дээ.

Тийнхүү Керри тэндээс гар хоосон гарч яваахас өөр аргагүй болов.

“Эмпайр” театрт очиход хүнийг тоож харах ч үгүй жишимгүй царайлсан баахан хүн бужигналдаж байхыг Керри үзлээ. Тэндхийн юм бүхэн нь хээ хуар, эдлэл тавиураар дүүрэн, юм бүхэн нь тэвхийж цэмцийсэн байдалтай харагдав.

“Лицеум” театрт очиход албаных нь өрөө гэж нэг муу умайсан мөртлөө бөөн хивс дэвсэж, хана хаалгы нь дүнзэдсэн маш сүржин сүрдмээр юм байлаа. Тэндхийн кассны хүн ч, хаалгачин ч, туслах найруулагч нь ч гэсэн ихэмсэг хямсгао, ер нь ажилдаа идээшиж онгирсон яравгар амьтад байлаа.

“даруу бай, тун даруу бай, биднээс гуйх юмтай ирсэн бол маяглалгүй бушуухан л хэл. Бид, өөрсөндөө гай болох юмгүй гэж үзвэл ямар нэг юм бодож болох юм” гэсэн амьсгал илт байлаа.

Энэ бол “Лицеум” театрын гаурын, ер нь тэр хотын газар бүхний төлөөлөгчийн газрын амьсгал ажээ. Тэр ялимгүй ажлыг эрхэлсэн этгээдүүд тэндээ л ёстой ноёд байлаа.

Керри тэндээс маш урамгүй ихэд ядарсан байдалтай гарч явлаа.

Тэр орой, Херствүд Керрийн хэрхэн тийнхүү ядартлаа ямар ч үр дүнгүй муугаа үзэн тэнэж ирснийг сонсов.

- Би тэр улсын чинь нэгэнтэй нь ч уулзаж чадсангүй, тэнэж, тэнэж, үүдэнд нь ч хүлээж хүлээж ирлээ гэхэд Херствүд юу ч хэлэлгүй өөдөөс нь харав.

- Танил талгүйгээр юу бүтэхгүй бололтой гэж Керри гутарсна байдалтай нэмж хэлэв.

Херствүд тийм бэрхшээлий нь ойлгох боловч учиргүй сандрахгүй байв. Керри явсандаа ядарч, урам хугарсан байна. Гэвч одоо амрхаас хойш дажгүй Керри эргэлддэг сандал дээрээ суугаад гадна ертөнцийг ажиглан байхдаа айсуй аюул тийм ч айхавтар биш мэт, маргааш гэж бас нэг өдөр байна гэж бодов.

Маргааш нь болоод өнгөрч, дараа өдөр нь ч болж, бас дараа ч нь ч болжээ, болохгүй гээд хааш зайлах вэ.

Керри “Казино” театрын даргатай нэг удаа уулзжээ.

- Дараачийн долоо хоногийн эхээр ир. Тэр үед би өөрчлөлт хийж магадгүй гэж тэр хүн хэлжээ.

Бие томтой махлаг, дэгжирхэг, хоолонцор, эмэгтэй хүнийг бол морийг хүн яаж шинждэг шиг л үнэлдэг хүн ажээ. Керри бол царайлаг, гоолиг эмэгтэй. Түүнийг театрын ямар нэг туршлагагүй байлаа ч гэсэн нэг газар шингээж болох юм. Тэднийхний нэг нь эртэдхэн найрал дуучин хүүхнүдэд цуарайлаг хүн цөөн байна гэж гоморхож байсан ажээ.

Дараа долоо хоногийн эхний өдөр болтол бас нэлээд хэдэн хоног байлаа. Шинэ сарын нэгэн хариугүй болох гэж байдаг. Тэгээд Керри хэзээ ч тимй их санаа зовж үзээгүй ихээр санаа зовж эхэллээ.

Санаа нь туйлын ихэд зовоод байх болсон тул Керри нэг өглөө Херствүдээс чм ер нь үнэн голоосоо ажил эрдэг юм уу, үгүй юмуу гэж асуув.

- Үнэнээсээ эрэлгүй яахав дээ гэж хэлэхдээ Кеерийн дайруулж хэлснийг ч тоолгүй өнгөрөөлөө.

- Би ямар ч ажил олдсон хамаагүй хийнээ. Одоо шинэ сарын нэгэн дахиад л хариугүй боллоо шүү дээ гэж Керри хэлээд жигтэйхэн цухалдан бачимдсан байдалтай байхыг Херствүд хараад уншиж суусан сонингоо орхиж хувцсаа сольж өмслөө.

- “Ямар нэг ажил хайх маань л зүйтэй. Архи пивоны газраар очвол ямар нэг ажил өгч магадгүй юм. Мухлагийн худалдагч хий гэсэн ч хийнээ” гэж Херствүд дотроо бодож байлаа.

Энэ удаагийн эрэл хайгуул нь бас л түрүү түрүүчийнхээсээ ялгаагүй байв. нэг хоёр газраар ороод л зориг нь мохжээ.

“Хэрэг алга, харихаас өөр домгүй боллоо” гэж бодов.

Одоо мөнгө нь хариугүй дуусах гэж байдаг, тэгээд хувцас хунараа хүртэл сонжиж харвал хамгийн

өөдтэй гэсэн хувцас нь хүртэл больж эхэлж байх шиг бөйлаа. Ингэж бодохоос цөхрөн тарчилж байлаа.

Керри түүний ирснээс хойш харьжээ.

- Би өнөөдөр хэд хэдэн эстрадын театраар орлоо. Бэлэн репертуаргүй бол амбан явахгүй юм байна гэж Керри урамгүй хэлэв.

- Өнөөдөр би архи пивоны нэг газраар орсон. Хоёр гурван долоо хоногийн дараа ажилдавч магадгүй гэсэн шүү гэж бас л худал хэлэв.

Керрийн тийнхүү тарчилж байхад өөрийгөө юугаар ч болов цагаатгах хэрэгтэй гэж бодоод ингэж хэлсэн нь нээрээ ч талаар өнгөрсөнгүй. Энэ бол залхуугийн гэм, ажилч чанараас уучлалт гуйсан хэрэг ажээ.

Даваа гаригийн өглөө Керри “Казино”-д очлоо.

- Би таныг өндөөр ир гэсэн юмуу? Гэж театрын эрхлэгч Керрийг эртдийн адил шимтэн харж асуухад Керри ихэд давхийн цочиж:

- Энэ долоо хоногийн эхээр ир гэсэн гэв.

- Өөрт чинь ямар нэг туршлага гэх юм байна уу гэж тэр хүн бараг ширүүнээр асуув.

Керри туршлагагүй гэдгээ үнэнээр нь хэлэв.

Тэр хүн цаас бичиг үзэж байснаа Керрийг дахин ширтлээ. Бачимдан зогсож буй царайлаг залуу хүүхнийг мань эр дотроо их л таашааж байв. “маргааш өглөө театрт ирээрэй” гэхэд нь Керрийн зүрх амаараа гарчих дөхлөө. “За” гэж Керри арайхийн хэлээд ажилд авах гэж байна хэмээн бодоод гарахыг завдав.

Том хотын хөл хөдөлгөөн дуу чимээ цонхоор дуулдах нь хүртэл чихэнд ч чимэгтэй мэт санагдаж эхлэв.

“Намайг нээрэн ажилд авах юм бол уу? Тэнгэр өршөөг, нээрэн байгаа?” гэж бодоод алхтал араас нь тэр хүний хэлсэн үг эргэлзээг нь үгүй болголоо.

- Өглөө эртхэн ирээрэй. Хожимдвол өнгөрнө шүү гэж тэр хүн бараг зандрав.

Керри бушуухан гарч явахыг яарна. Одоо Херствүдийн залхууг дуудаж муу бодмоор ч үгүй санагдаж байна. Ажилтай боллоо! Ажилтай боллоо! Гэсэн үг чихэнд нь хөгжмийн уран эгшиг шиг дуулдах мэт ажээ.

Их баярласандаа тэр биз, энэ явдлаа Херствүдэд бушуухан сонсгохсон гэж бодож байв. Гэвч гэрийн зүг алхан явах зуураа олон юм бодож хичнээн долоо хоног хөөцөлдөж байж ажилтай болох гэж байгаагаа, бас Херствүд хичнээн олон сар хий дэмий ажилгүй байгааг бодохлоор сэтгэл санаа нь баярлах юм байвч гонсойх юмаар элбэг байлаа.

- Энэ хүн яагаад ажилд ордоггүй юм бол? Надад ажил олдож байхад тэрүүнд олдож болмоороо

доо? Үнэнийг хэлэхэд би нэг ихх махаа идсэнгүй шүү дээ гэж бодож явав.

Өөрийнхөө үзэсгэлэнтэй, нас залуу гэдгийг мартжээ. Хүн хөгшрөхийн зовлонг Керри ойлгохгүй явна, баярласандаа болоод тийм юм бодохгүй байна.

Аз хийморийн тэнгэр тиймэрхүү л байдаг амуй.

Гэвч Керри нууцаа хадгалж чадсангүй. Юу ч болоогүй юм шиг байя гэж бодсон боловч мэдэгдээд байжээ. Херствүд түүний царайд баярын өнгө тод байхыг ажаад:

- За юу болсон бэ? гэв.

- Би ажилд орох болсон.

- Тийм үү? Гэж Херствүд дотор нь онгойж хэлэв.

- Тийм ээ.

- Ямар ажилд орох болов? гэж Херствүд асуухдаа одоо өөрөө ч гэсэн удахгүй нэг юманд орох байгаа гэж горьдоно.

- Найрал бүжигчдийн бүлэгт

- Өнөө -Казино” театрт уу?

- Тийм. Бүр маргааш өглөөнөөс эхэлнэ.

Керри их баяхтай байсан болохоор нэлээд зүйлийг өөрийн саны дураар ярьж өгөв. Херствүд сонсож сонсож сүүлд нь:

- Ямар цалинтай юм? гэхэд Керри:

- Мэдэхгүй, би асуугаагүй шүү. Бодвол долоо хоногт арван хоёр юмуу, арван таван доллар орчмыг өгөх байлгүй гэлэ.

- Тэр л орчмыг өгөх байх гэж би ч бодож байна.

Энэ үдэш толгой дээгүүр нөмөрсөн аюул нь бага зэрэг намдсан тул тэр хоёр овоо санй хоол иджээ. Херствүд сахлаа хусуулахаар гараад буцаж ирэхдээ бифштекс хийх овоо том мах авчирсан байв.

- За, би ч гэсэн маргааш өглөө ажил эрнэ гэж бодоод ажил олдох байх гэхээс урам орж газар ширтэн уруу царайлахаа больж жаал дээш харахтай болжээ.

Маргааш өглөө нь Керри эртлэн явж очиход түүнийг найрал бүжигчдийн хамтлагт оруулав. Дорно зүгийн маягаар ихэд баялаг чимсэн уудам том боловч бүүдгэрдүү гэрэлтэй тэр өрөөнөөс өчигдөр оройн үнэртэн танартны үнэр, чимэглэлийн зүйл мэдэгдэж байв. Тийм өрөө тасалгааг харахаас Керр баясан бахдахын зэрэгцээ сүрдэн зүрх алдаж байлаа. Ёстой л үлгэр домгийн юм шиг санагджээ. Энэ сайхан газар шингэхийн тулд байдаг чадал авьяасаа дайчилна даа гэж

бодлоо. Энд эгэл борог байдал, алхайж залхуурах, гачигдаж дутах, шальгүй юмаар хөөцөлдөх мэтийн юм байж болшгүй санагдана. Энд юм үзэх гэж хүмүүс аль сайхан хувцсаа өмсөж, сүүх тэргэнд сууж ирнэ. Энэ бол зугаа цэнгэл, гэгээн саруул ертөнцийн орон буюу. Имй газрын хүмүүсийн нэг нь болно гэдэг сайхан аа! Энд л байгаад байж чаддагсан бол амьдралынхаа туршид аз жаргалыг эдэллээ гэсэн үг гэж биширч байлаа.

- Нэр чинь хэн билээ? гэж дасгалыг удирдах өнөөх эрхлэгч асуув.

- Маденда, Керри-Маденда гэж Керри тэр дороо Чикагод байхад нь Дрүэгийн өгс байсан нэрийг санаж хариулав.

- За тэгвэл, Маденда авха та энд очиж зогс доо гэж Керрийн ойлгосноор их л эелдгээр хэлэх шиг болов.

Дараа нь тэр хэсэгт тоглодог байсан нэг залуу эмэгтэйд:

- Кларк авхай та энэ Маденда авхайтай хос шүү гэлээ.

Кларк авхай нэг алхам урагш гарч ирэхэд нь Керри өөрийнхөө зогсох байрыг мэдэж авлаа.

Сургуулилт эхлэхэд Чикакогийн Аври Холлд хийсж байсантай ерөнхийдөө адилавар боловч удирдаж байгаа хүн нь илүү хашгираа хүн байлаа. Урьд Миллис ноён их шаардангуй дээрэлхүү байсан бол одоогийн энэ хүн шаардангуйгаар үл барам бүдүүлэг зандчуу этгээд байв. Сургуулилт цааш үргэжлэх тусам улам уцаарлан, өчүүхэн юман дээр хоолой мэдэн уурлан хашгичиж байлаа. Тэр хүүхнүүдийн зүгээс биеэ өмөөрөх гэсэн буюу доромжлолыг дургүйцэх гэсэн өчүүхэн төдий боловч оролдлогыг туйлаас үзэн яддаг нь илэрхий бөйлаа.

Кларк авхай гэхийн оронд зүгээр Кларк хэмээн дуудаад:

- Яагаад чи хөлөө олохгүй байна гэж зандарна.

“Дөрвөөрөө, баруун тийшээ, баруун тийшээ, хүүе баруун тийшээ гэж байна шүү. Юундаа яарсан, хүний үг мэддэггүй яасан хачин амьтад вэ” гэх мэтээр дуу нь тэнгэрт тулам муухай хашгиран зандчиж гарна.

- Мейтленд! Мейтленд! Гээд л гэнэт хашгирна.

Хөөрхөн хувцасласан жижигхэн биетэй залуухан охин жигтэйхэн айчихсан урагш гарч ирэхэд нь Керри түүнийг өрөвдөж байв.

- За ноёнтон минь гэж тэр хүүхэн хэлэхэд цаадах нь:

- Чихий чинь юу бөглөж орхио вэ?

- Бөглөөгүй, ноёнтон минь.

- Эгнээгээрээ зүн тийш гэдэг үгийг мэдэх үү?

- Тэднээ, ноёнтоон.

- Тэгвэл юу гэж чи баруун тийшээ тэмүүлээд байсан юм? Эгнээг зориуд эвдэх санаатай байна уу?

- Зүгээр л...

- Зүгээр л битгий тэгж бай, чихээ нээлттэй байлга.

Керри, тэр хүүхнийг өрөвдөхөөс гадна намайг юу гэж загнах бол гэж айж байлаа.

Бас нэг залуу хүүхэн айхавтар их загнуулав.

- Алив байз! Гэж тэр хашгираад уурандаа хоёр гараа дээш сарвалзуулан хүн аймаар муухай галзуурах мэт авирлав.

- Элверс! Амандаа юу гээд байгаа юм?

- Юу ч гээгүй, ноёнтон гэхэд бусад нь үл мэдэг инээмсэглэн чичрэх дөхөн зогсож байна.

- Чи яриад байна шүү дээ.

- Үгүй ээ, ноёнтон.

- Тэгвэл амаа энэ чигээр нь л байлга. За одоо дахиад бүгдээрээ.

Керрийн загнуулах ээлж ч иржээ. Хий гэсэн бүрий нь нэгбүрчлэн шамдан хийх гэж чармайсны л гай болжээ.

- “Мейсон, Мейсон” гээд дуудаж байх сонсодсон ажээ. Керри хэийг дуудаж байгаа юм бол гээд эргээд харсан боловч өөрийгөө дуудаж байна гэж огт бодсонгүй. хажуугийнх нь хүүхэн түүнийг зөөлхөн ёворсон боловч Керри анзаарсангүй дасгалаа хийсээр байв.

- Хүүе! Хүүе! Чи чихтэй хүн үү, үгүй юу? хэмээн нөгөө этгээд хашгираад байгаа нь Керрийг дуудсан хэрэг байж.

“Яана аа!” гэж Керри хэлээд царай нь чавга шиг улайж өвдөг нь сулраад явчив.

- Нэр чинь Мейсон биш үү? Гэж найруулагч хашгирлаа.

- Бишээ ноёнтон, намайг Маденда гэдэг.

- За тэгвэл наад хөл чинь яачихсан юм? Бүжиг хийж чаддаггүй хүн юмуу?

Керри, бүжиг мэдэх учир:

- Бүжиг хийж чадна гэлээ.

- Тэгвэл яагаад бүжиглэхгүй хөлөө үхээнц чирээд байгаа юм? Надад хөгжил хөдөлгөөнтэй л хүн хэрэгтэй.

Керрийн царай ув улаан болж, уруул нь үл мэдэг өмөлзөв. Тэгээд:

- За мэдлээ, ноёнтон минь гэв:

Ууртай үглээ найруулагчийн тэр сургуулилт гурван цагийн турш үргэлжилжээ. Керри театраас ихэд ядарсан гарсан боловч баярласандаа болоод ядарснаа ч анзаарахгүй байв. Бушуухан л гэртээ очиж хий гэсэн дасгалаа хийх юмсан гэж яарч байв. Ямар ч алдаа гаргаагүй мөртлөө сайн гэгч нь давтана гэж бодов.

Очиход нь Херствүд байрандаа байсангүй. “Ажил эрэхээр явсан бололтой” гэж бодлоо. Керри жаахан юмаар өлөө дараад нэгэнт ажилтай болсон хойно өег явах цаг ирнэ гэж бодоод дасгалаа хийж гарчээ. “Алдар нэрийн уянгат эгшиг чихэнд нь цууриатна”.

Херствүд буцаж ирэхдээ гэрээс гарах үеэсээ урам муутай ирсэн тул Керри дасгалаа орхиод хоол унд шиг юм бэлдэж эхэлжээ. Гэнэт дургүй нь хүрч, миний хийх ажил багадаа юу? Ажил хийх, бас гэр орны юмаар зууралдах хэрэг үү? “Тэгэхгүй ээ! Би тоглож эхлэхтэйгээ зэрэг л ингэж байдгаа болино, энэ хүн хоолоо гадуур иддэг юм байгаа биз” гэж Керри дотроо шийдэв.

Өдөр ирэх тусам зовлонтой юм нэмэгдсээр ажээ. Найрал бүжигчдийн дотор байх гэдэг тийм ч гайхмаар биш бөгөөд долоо хоногт арван хоёрхон долларын хөлс авах байв. Тэнд хэд хоног болсны дараа тэндхийн гоцлон тоглогч эрхэм их чадалтангуудын барааг Керри олж харжээ. Тэд бол хүн бүхнийг өөрсөндөө бөхөлзөж мэхэлзүүлэх дуртай эрх ямба эдэлсэн тийм хүмүүс болох нь илт харагдана, харин Керри мэт нь юу ч биш, үнэхээр юу ч биш ажээ.

Гэртээ ирлээ гэхэд сэтгэлийн зовлон нэмэхээс цаашгүй Херствүд гэж нэг хүн байх тул Керрид давхар зовлон болж байлаа. Тэр нь ажил эрэхээ бүр больсон бололтой байв. Гэсэн мөртлөө Керрийг театр дээрээ ямар амжилттай, ямар сонин сайхантай вэ гэж шалгаах дуртай_ Тэгж байн байн асууж сурагладгий нь бодохоос Херствүд цаашид ч гэсэн аягүй бол Керрийн хүчээр амь зууж явах санаатай болох нь ил байлаа.

Керри одоо өөрийнхөө хүчээр хоолныхоо мөнгийг олж авдаг болсноос хойш улам ч зэвүү нь хүрэх болж “энэ этгээд олсон арван хоёр доллар руу минь бас шунахай нүдээ хаях гэнээ” гэж зэвүүрхэх болов.

- За тэгээд дажгүй юу гэж байн байн шохоорхон асууна.

- Гайгүй л болж байх шиг байна.

- Гайгүй байгаа биз дээ?

- Яваандаа дасах байх гэж бодож байна.

Тэгээд өнөөх сонингоо толгой дээш таталгүй уншин сууна.

- Би жаахан тос аваад ирсэн шүү, зөөлөн боов хийвэл яасан вч гэж Херствүд мартсан байснаа гэнэт санасан маягтай хэлнэ.

Тийм байдалтай байж ийм тайван байгаад нь Керри заримдаа ихээхэн гайхна. Одоо хүний эрхээр явахгүй байж болох төлөв нээгдэх янзтай болж байгаа болохоор Керри Херствүдэд зоригтой хэлмээр үг ч байна, түүнээс өө сэв ч олдог болжээ. Гэвч одоо хүртэл Дрүэд хэлж байсан шиг

шийдэмгий үгийг Хертсвүдэд хэлж чадаагүй байлаа. Энэ хүнээс яагаад ч юм цаагуураа нэг л айгаад байдаг байж. Түүнд далдуур хүч буй мэт бодогдох ажээ.

Нэг өдөр, анхны долоо хоногийн сургууль хийсний дараа гэртээ буцаж ирэхэд аль хэдийнээ цухалзах гэж байсан нэг зүйл ил гарч ирсэн байлаа, юу гэвэл Херствүд аючирсан жаахан махаа ширээн дээр тавингаа:

- Чиний мөнгө авах бас л яагаа ч үгүй байх шив дээ? хямгатай мдэж ууж байхгүй бол горьгүй нь байна шүү гэжээ.

- Болоогүй байгаа гэж гол тогоо барьж байсан Керри хэлэв.

- Байрны хөлс төлөөд арван гурвахна доллар үлдлээ.

“Ингэх л байсан юм даа, гэвч би өөрийнхөө олсон мөнгийг өөрийнхөө хэрэгцээнд зарна” гэж Керри дотроо хэлэв.

Хэд хэдэн зүйл худалдаж авах хэрэгтэй байгаагаа нэн даруй саналаа. Наад зах нь малгай нь ч гэсэн өмсөхийн аргагүй болох дөхөж байлаа. Ер нь хувцас хунарын талаар бодохгүй бол горьгүй болсон бөайв.

- Энэ орон байрын хөлс төлөх, хоол унданд арван хоёр доллар төлөхөд тэртэй тэргүй хүрэхгүй шүү дээ. Би мөнгө тимй юманд зарах ч үгүй, энэ хүн яагаад өөрөө ажилд ордоггүй юм бэ? гэж Керри бодож байна.

Анхны тоглолт хийх хамгийн чухал өдөр болоход Керри Херствүдийг очуульё гэж ч бодсонгүй, тэртэй тэргүй мань эр очно гэхгүй, үардлын нэмэр гэх байлаа. Тэгээд ч Керрийн тоглох дүр гэж хэнд ч анзаарагдамгүй байлаа.

Тэр тоглох жүжгийн тухай сонингуудад зарлал гарч голоон тоглогчдын зураг ч хэвлэгджээ. Керри хаана нь ч зарлагдсангүй.

Найрал бүжигчид тайзан дээр гарах цаг болоход Керри , чикагод яаж балмагдаж байсан шигээ их л сандарч эхэлсэн боловч гүйцэтгэх өчүүхэн дүрээ бодохоос аяндаа айдас нь замхарч эхэлжээ. Хэнд ч анхаарагдахаар биш өчүүхэн юм чинь айхын хэрэг алга гэсэн бодол орж иржээ. Нэг их хичээж чармайгаад баймаар ч юмгүй учраас биенд нь амар ч юм шиг санагдана. Бариу урт өмдтэй гарах хүмүүсийн тоонд ороогүй нь бас аз. Харин өвдөгнөөс ямхын төдий дээгүүр татах алтан саатай гоёмсог банзал өмсөж гарах арван хоёр хүүхний нэгэнд багтсан байлаа.

Керри, тайзан дээр зогсож байхдаа, тайзан дээр хөдөлгөөн хийж байх зуураа юмуу, дууны өндөр ая даган хоолой чангалах зуураа үзэгчдийг хааяа хааяа ажвал их л сонирхон зөндөө их алга нижигнүүлж байх бөгөөд нэрд гарсан жүжигчдийн зарим нь тун муу тоглож байгаагч анхаарлаа. “Би л бол энүүнээс дээр тоглоно доо” гэж Керри хэд хэдэн зүйл дээр дотроо боджээ. Чин үнэнээс хэлбэл Керрийнх зөв байсан биз.

Тоглолт дуусмагц Керри бушуухан хувцаслажээ. Найруулагч нь нэлээд олон хүнийг зэмлэж байсан боловч Керрид юм хэлсэнгүй, тэгэхлээр лав зүгээр тоглосон юм байлгүй гэж бодлоо. Керри тэнд таних хүн бараг үгүй бөгөөд “Одууд” нь хоорондоо хов жив болж эхэлсэн тул

бушуухан л явахын түүс болов. гадаа сүүх тэрэг багшралдахаас гадна догь сайхан хувцасласан царайлаг залуус хүлээн зогсоцгооно. Керрийг тэднүүс шимтэн ажиглаж байх шиг байв. Нүдээ ялимгүй ирмэвэл гэрт нь хүргээд өгөх хүн долоо олодох боловч Керри тэгсэнгүй.

Харин нэлээд долиггоршсон нэг залуу:

- Та ганцаараа явах гэж байна уу? гэж асуулаа.

Керри юу ч дуугаралгүй алхаагаа хурдасган явсаар Зургадугаар өргөн чөлөө хүрдэг тармвайд суулаа. Керрийн толгой тархинд театрын талаар бахархан бодож, бишрэхээс өөр юу ч бодогдсонгүй байсан билээ.

Долооо хоногийн шувтаргаар Керри, Херствүдийг ажил эрүүлэх санаатайгаар:

- Өнөөх архи пивоны чинь газраас юм сонсдоно уу? гэж асуухад:

- Үгүй шүү. Одоохондоо бэлэн юм гараагүй бололтой. Ямар ч болтугай нэг юм бүтэх бол уу гэж найдаж байна шүү гэж хариулав.

Керрий өөрийнхөө хүчээр олсон мөнгийг өгөхгүй өөрөө хэрэглэнэ гэж бодовч өгөхөөс өөр замгүй болох нь гэдгийг ч гадарлаж байлаа. Херствүд хувхай хоосон болох гэж байгаа болохоор яаж ийж байгаад Керрийн хэдэн долларыг салгах гэж хамаг ухаан арга баашаа зарж эхлэв. Керрийн бодь сэтгэлтэйг мэдэх учраас тэгсгээд салгачихаж болно гэж бодож байв. Ингэж бодох нь өөрт нь ичгүүртэй мэт санагдах боловч өөрөө мөд ингэсгээд нэг ажилд орох байх гэж биеэ хууран цагаатгаж байлаа. Яг тэгж бхйтал ч байрны хөлс төдөх өдөр болсон нь бүр ч далим болов.

- За тэгээд мөнгө маань дууслаа даа. Удахгүй ажилд орох байгаа даа гэж Херствүд мөнгөө тоолонгоо хэлэв.

Ингэж хэлээд мөнгө гуйх гэж байх шиг байна хэмээн Керри бодоод хулгай нүдээр түүнийг хяламхийв. _

- Хэд хоног ч болтугай өнгөрөөж чадвал учир байна санж. Дрейк есөн сард энд заавал зочид буудлын газар нээх юм.

Есөн сар хүртэл гучаад хоног байгааг Керри өөрийн эрхгүй бодоод:

- Нээрэн тэгэх юмуу? Гэж асуулаа.

- Чи тэр хүртэл намайг дэмжихгүй юу? Тэгвэл би тэгсгээл дажгүй болно гэж найдаж байна гэж Хертсвүд гуяв.

Хувь заяандаа гоморхсон Керри:

- Тэгэлгүй яахав дээ гэв.

- Олигтойхон хэмнээд байх юм бол бас учир байна. Сүүлд би мөнгий чинь буцааж өгнө.

- Би чамд тусална гэж Керри түүнд арай ч хатуурхай царай алдуулахад хүргэв үү дээ гэж бодох

боловч бас өөрийнхөө хүчээр олсон мөнгийг өөрийнхөө чухал хэрэгцээнд зарах сан гэж бодно.

- Жорж, чи яагаад ямар ч болтугай, түүр ч гэсэн нэг ажилд ордоггүй юм бэ? Дараа нь аятайхан ажилд орох боломж олдоно биз.

Херствүдийн дотор жаал онгойвч Керри тийнхүү зэмлэхэд: толгойгоо гудайлгана.

- Би ямар ч хамаагүй ажилд орно, газар ухах ажилд ч орно. Энд намайг таних хүн байх юм биш гэв.

- Тэр нь ч юу юм бэ, эрхбиш өөр ажил олдох байлгүй гэж Керри түүнийг гэнэт өрөвдөн хэлэв.

Херствүд нэгэнт шийдсэн царай гарган:

- Би заавал нэг ажил олж хийнэ гэж дахин сонингоо уншиж эхлэв.

ГЭРЭЛ, СҮҮДЭР ХОЁР. ЗАМ САЛЛАА

Херствүдийн тэгж шийдсэний үр дүн нь юу байсан гэвэл өдөр болгон ажлын эрэл хийх албагүй болов гэж итгэлтэй бодох болжээ. Гэтэл Керри, тэр сарын турш хоногийг хуруу даран тоолж санаанч зовлон эдэлж байлаа. Хувцас хунарын зүйл худалдаж авах гоёл чимэглэлийн зүйл ч өнгөрсөн хэрэг хэрэгцээ улам шаардлагатай болж байсан атал Керри хар хүчээрээ олсон хэдийгээ өөрийнхөө хэрэгцээнд зарцуулж чадахгүй болж байлаа. Аятайхан хувцас хунар авах шаардлага тулгарах тусам Херствүдийг өрөвдөх сэтгэл арилж харин ч түүнийг ад үзэн зүхэх болж байв. Херствүд дахин гуйгаагүй боловч Керрийн өөрийнх нь хэрэгцээ аргагүй их шаардлагатай тул Херствүд саад болж байна хэмээн зэвүүцэж байлаа.

Херствүд, сүүлчийнхээ арван доллар үлдэхийн хамт трамвайд суух, сахлаа хусуулах гэх мэт аар саар юманд ч Керрид гар сарвайж байхгүйн тулд тэр арвыгаа нууж үлдээгээд одоо би хэдхэн мөнгөтэй л хоцорлоо гэж хэлжээ.

- Би гар хоосорлоо. Өнөө өглөө нүүрсний мөнгө төлөөд арав_ арван таван центтэй л үлдлээ гэж Херствүд нэг өглөө хэлжээ.

- Миний түрийвчинд хэдэн юм байгаа.

Херствүд тэрний нь аваад лааз томатанд явав. Ингэж тэр хоёрын харьцаанд цоо шинэ байдал үүсэж буйг Керри бүүр түүр гадарлаж байв. Херствүд, түрийвчнээс нь яг л арван таван цент аваад явсан байх бөгөөд түүнээс хойш аар саар юмыг тэр худалдан авдаг болжээ. Нэг өглөө Керри оройн хоол хүртэл гэртээ ирж чадахгүй санаж:

- Манай гурил дууссан, чи өнөөдөр жаахан гурил авчихаарай. Мах ч үгүй болсон.Элэг, гайхан өвчүү авбал яах вэ? гэхэд Херствүд:

- Болж л байна гэлээ.

- Тэгвэл хагас юмуу эсвэл долоон зуун граммыг авчих.

- Хагасыг авахад л болно л доо гэж Херствүд хэлэв.

Керри түрийвчнээсээ хагас доллар гаргаж тавихад Херствүд хараагүй хүн болж байлаа.

Херствүд гарч арван гурван центээр жижиг савтай гурил, арван таван центээр хагас кило элэг, гахайн мах аваад хариулт мөнгөний хамт ширээн дээр авчраад тавьсныг Керри тооцож үзэж ганц улаан мөнгөний зөрөөгүй байгааг бодоод энэ хүн идэх юмнаас өөр зүйл шаардахгүй байхад нь би арай ч хатуурхаж байна уу даа гэж дотроо жаахан өрөвдөж, ингэсгээд ажил олж хийнэ биз, муу юм хийж байгаа хүн биш гэж бодлоо.

Гэтэл тэр орой театр руугаа ортол найрал бүжигчдийн нэг охин цоо шинээр хувцаслаж энгэр дээр нэл цэцэг хатгачихсан их л баяртай байгаа бололтой сайхан шүдээ яралзуулан инээмсэглэхэд Керри мөн найрсгаар инээмсэглэн мэндлээд дотроо: “Энэ хүүхэн ингэж сайхан хувцасласан байна. Би ч гэсэн авсан мөнгөө өөрийнхөө хэрэгцээнд зарах юм бол ингэж чадна шүү дээ. Гэтэд надад зүүчих аятайхан зангиа ч алга гэж” бодов.

Керри, өмсөж яваа гутлаа зориуд харж бодолхийлснээ:

- Юу ч болсон энэ хагас сайнд гутал худалдаж авна гэж дотроо шийджээ.

Найрал бүжгийн хүүхнүүдийн дотроос хамгийн цуарайлаг, зан ааш хөөрхөнтэй нэг жаахан хүүхэн Керрийг муу санаагүй хүн гэж итгээд их л дотносох болжээ. Тэр бол сэтгэл сайхантай, бусдад тусархуу тийм хүн боловч нийгмийн ёс суртахууны хатуу шаардлагыг нэг их тоодоггүй, сэргэлэн цовоолог жижигхэн Манон ажээ.

Найрал бүжигчдийг хоорондоо битгий ярилц хэмээн хориглодог боловч тэд заримдаа бага сага юм амжуулдаг л байж.

- Өнөө орой их дулаахан байна шүү гэж тэр жижигхэн хүүхэн Керрид хэлэхэд Керри өөртэй нь хэн нэг нь ярилаа гэж баярлаад:

- Тийм байна, тун дулаахан байна гэлээ.

Цаадах нь ягаан өнгийн урт өмд өмсөж толгой дээрээ хуурмаг алтан саатай малгай тавьсан байлаа.

- Би арай л шатаж үхсэнгүй, яасан халуун байна вэ гэж нөгөө хүүхэн хэлэхэд Керри түүний нүүр рүү харвал хөөрхөн улаан царайтай том цэнхэр нүдтэй бөгөөд духных нь хөлс бурзайсан байв.

- Би ийм их хөдөлгөөн хөлхөөтэй дуурь ерөөс үзээгүй гэж нөгөө охин хэлэхэд Керри, тийм туршлагатайд нь гайхаж

- Чи урьд нь тоглож байсан юмуу? Гэж асуув.

- Зөндөө, чи тоглож байгаагүй гэж үү?

- Би анх удаа л тоглож байгаа маань энэ.

- Тийм үү? “хатан хааны найз” гэдэг жүжигт таныг тоглож байсан гэж бодсон шүү.

Керри толгой сэгсрэн:

- Үгүй ээ, чи биш гэв.

Бүжигчдийг тайзан дээр гарах болсон тухайг мэдэгдсэн тусгай гэрэл тайзны ард асаж, хөгжим нижигнэж эхэлсэн учир тэр хоёрын яриа тасрав. Дахин яриа үргэжлүүлэх бололцоо тэр орой олодоогүй боловч маргааш орой нь тайзан дээр гарахаар бэлтгэж байх хоорондоо өнөөх охин Керритэй бас хэдэн үг сольж амжжээ.

- Эднийхэн дараагийн сард бусад газраар явж тоглох гэнэ лээ.

- Тийм үү?

- Тийм. Чи явах уу?

- Авч явна гэвэл явж л таарах байх даа.

- Аа, эд нар ч чамайг авч явна гэнэ л дээ, би ч явахгүй. Эд нар нэмэгдэл хөлс өгөхгүй, хамаг зардлыг өөрөөр чинь гаргуулах болно. Би Нью-Йоркоос гарч явахгүй. Энд тэртэй тэргүй очих газар зөндөө байхад:

- Орох өөр театр олдоно гэж үү?

- Олдоноо олдоно. Бродвейд л лав энэ сард шинэ театр нээгдэх гэж байгаа. Эднийх гадагш явах юм бол би эндээс гараад тэнд орохыг бодно.

Керри түүний ингэж ярихыг ихэд сонирхон сонсоод энэ театрыг гадагш явах юм бол явалгүй байж өөр газар орохыг бодвол яасан юм, ер нь театр орох нэг их хэцүү байдаггүй юм шиг байна гэж бодов.

- Цалин адилхан байдаг юмуу? Гэж Керри асуулаа.

- Адил даа. Зарим нь арай илүү өгдөг л юм. Энэ театр олигтой өгөхгүй юм.

- Надад арван хоёр доллар өгч байгаа гэж Керри хэлэхэд нөгөө хүүхэн:

- Тийм гэж үү? Надад арван таван доллар өгдөг. Гэтэл ча надаас ч илүү их юм хийдэг шүү дээ. Би л бол тэгж чадуулахгүй. Чамайг мэдэхгүй гэж бодоод л бага өгч байхгүй юу. Арван тавыг авах ёстой л доо гэв.

Надад өгөхгүй байгаа шүү дээ.

- Хэрэв та өөр театрт очих юм бол илүү цалин авна. Чи тун сайхан тоглож байгаа. Найруулагч ч сайн мэдэж байгаа гэж нөгөө аятайхан зантай охин нь хэллээ.

Үнэнийг хэлэхэд Керри бусдаасаа илүү намбатай ур чадвартай тоглож байсан л даа. Энэ бол түүний төрөлхийн намбатай хөдөлгөөн, эгэл даруу байдлынх нь ач байлаа.

- Бродвейд очвол надад илүү цалин өгнө гэж бодож байна уу?

- Өгөлгүй яах вэ? Надтай хамт очоорой, би ярилцаад өгөмз гээд цаад охин хэлэв.

Керри энэ үгийг сонсоод баярлав. Тайзны энэ жижигхэн охин Керрид үнэхээр их таалагдаж байлаа.. Алтан саатай малгай духдуулан тавьж, цэрэг эрийн байдал гаргасан тэр жаахан хүүхэн сүрхий туршлагатай, хэнээр ч толгойгоо мэдүүлэхгүй хүн шиг санагдана.

- Энэ маягаар ажил олдоод байх юм бол би ирээдүйдээ зовох юмгүй юм байна гэж Керри бодов.

Гэвч өглөө босоод л гэр орны ажлаар зууралдах, Херствүд гэж ажилгүй дэмий сууж хоолны савнаас өөр увидасгүй амьтан байхыг бодохоос хувь тавиландаа гомдож эхэлнэ. Херствүд маш нарийн тооцоотой зарж байгаагийн үрээр хоол унд бхйранд мөнгө нь хүрэх боловч өөр илүү гарах юмгүй байв. Керри өөртөө гутал болон өөр төөр юм худалдан авснаас болж байрны мөнгө ч төлөхөд хүрэхгүйд хүрч байлаа. Байрны мөнгө төлдөг гайтай тэр өдөр болохоос нэг долоо хоногийн өмнө гэнэт Керри мөнгөө бодож үзвэл яагаад ч хүрэхгүй болсон байлаа. Тэгээд Керри

түрийвчээ инээж:

- Яана аа, байрны хөлс төлөх мөнгө хүрэхээ байсан байна гэхэд Херствүд:

- Чамд одоо хэдий хэр мөнгө байна гэв.

- Надад одоо хорин хоёр доллар байна. Гэвч энэ хагас сайнд авах хэдэн доллараа нэмээд орон сууц бусад зардалд өгнөө гэж бодоход дараагийн долоо хоногт юу ч үгүй болох нь байна шүү дээ. Нөгөө зочид буудал нээх хүн чинь яасан бэ, энэ сард нээх нь үү?

- Нээх байх аа, нээнэ гэж байна билээ гэснээ – тэр талаар зовох хэрэггүй. Идэшний худалдаач зээл өгөх байлгүй. Ийм олон сар жилээр юм авч байсан болохоор ганц нэг долоо хоногоор хойшлуулж зээлдэх байлгүй гэв.

- Лавтай итгэж байна уу?

- Тэгнэ л гэж бодож байна.

Яг тэр өдрөө Херствүд дэлгүүрийн эзэн Ослож гэгч дээрээ очоод пүү кофе авахдаа нүүр рүү нь эгц ширтэн:

- Долоо хоногийн сүүлчээр тантай тооцоогоо хийвэл та зөвшөөрөх үү? Гэхэд Ослож ноён:

- Вилер ноён минь, зөвшөөрөлгүй яах вэ, болно гэлээ.

Хүнд бэрх цагт ч гэсэн догь байдалтай байж чадлаг Херствүд өөр олон үг хэлсэн ч үгүй. Ажил нь амархан л бүтэх шиг болов. Херствүд гадагш нэг харснаа авч өгсөн кофегий нь аваад гарч одлоо. Цөхрөнгөө барж буй эрийн арга саам ийнхүү эхэлж дээ.

Байрныхаа хөлсийг төлөөд хүнсний дэлгүүрт тавьсан өрөө төлөх хэрэгтэй болоход Херствүд өөрийнхөө арван доллараас төлчихөөд долоо хоногийн эцэст тэр мөнгөө Керригээс авчээ. дараа нь Осложоос бас л зээл авч доллараа үрэхгүй байсан бөгөөд түүнд хагас сайнд төлөх ёстой мөнгөө дараа долоо хоногийн дөрөв дэх юмуу тав дахь өдөр өгч байв.

Тэр элдвийн бэрхшээлээс гарахсан гэж Керри хичээнэ. Гэтэл Херствүд түүнийг ямар нэг зүйл мэдэж хийх эрхгүй мэтээр боддог бололтой. Олсон хэдээр нь хамаг зардал төлүүлэхийг л бодохоос биш өөрөө ганц ч юм олж нэмэрлэхийг бодохгүй байжээ.

“Санаа зоволтгүй гэх мөртлөө юу ч хийхгүй, зүгээр суугаад миний хэдийг хүлээгээд байдаг. Өөрөө ажил олж хийвэл таарна. Хэн ч гэсэн ольё гээд хөөцөлдөх юм бол долоон сарын дотор ажил олохгүй яадаг юм” гэж Керри бодлоо.

Үзэмжгүй муухай хувцас өмсчихөөд уруу царайлан суудаг тийм хүнтэй цагийн барах үнэхээр уйтгартай болсон учир Керри хааяа өөр газраар орж сэтгэлээ сэргээх болжээ. Долоо хоногт хоёр удаа өглөөний тоглолттой байдаг болохоор өдөр гэртээ ирэхгүй, тэр хооронд Херствүд өөрөө хүйтэн зууш бэлдэж иддэг байв. Бас хоёр өдөр нь арван цагаас нэг хүртэл их үзлэг тэй байв. Түүнээс гадна өнөөх алтан саатай малгай өмсдөг, цэнхэрхэн нүдтэй охин, бас өөр хамт ажилладаг үеийнхээ ганц нэг хүүхнийхээрээ ордог болжээ. Гэртээ орж ирэхэд нөхөр нь гэж нэг уруу царайлсан ажилгүй хүн байдаг болохоор тийнхүү зарим нөхдийнхөөрөө орж гарч байх нь

Керрид сэтгэлээ сэргээх тун сайхан амралт мэт санагддаг учраас л тэгдэг байв.

Цэнхэр нүдтэй “байлдагч” охины нэрийг Осборн-Лола Осборн гэнэ. Одоо бүхэлдээ албан газрын контор болсон, дөрөвдүгээр өргөн чөлөөний ойролцоох Арван есдүгээр гудамжны нэг байшинд ганц өрөөнд сууна. Өрөөний нь цонхоор харахад саглагар навч сөчиртэй том том мод бүхий хашаа хачин сайхан үзэгдэнэ.

- Танайх Нью-Йоркт байдаггүй юмуу? Гэж Керри нэг өдөр асуухад, Лола:

- Байх нь ч байдаг, гэхдээ би тэдэнтэйгээ хамт байж таардаггүй, би өөрийнхөө эрхээр байх дуртай хүн. Танайх энд биз дээ? гэхэд:

- Тийм ээ.

- Гэрийнхэтэй байдаг уу?

Керри нөхөртэй гэж хэлэхээсээ ичжээ. Цалин хөлсөө чамлаж, ирээдүйнхээ тухай тэр найз охнитойгоо нэг биш удаа ярилцаж байсан болохоор одоо нөхөртэй гэж үнэнээ хэлж чадахгүй байв. Тэгээд:

- Садангийхаа хэдэн хүнтэй байдаг гэв.

Осборн охин, Керрийг тийм л байх ёстой гэж шууд бодох тул өөрийнхөө чөлөө цагийг өөртэй нь адил эдэлж явах бололцоотой гэж боджээ. Тэгээд Керрийг ямагт хамт ийш тийш түр гарах юмуу гэртээ орохыг урих тул Керри хоол ундныхаа цагаас ч нэлээд хожуу ирэх нь олширсныг Хертсвүд мэдэвч түүнтэй маргаж хэрүүл өдөөд ч яахав гэж боддог байв. Хэд хэдэн удаа Керри хожуу ирж хоол ундаа бушуухан хийчихээд театр руугаа ум хумгүй явах ядвал гарчээ.

- Танайх чинь үдээс хойш бас үзлэгтэй байдаг хэрэг үү? Гэж Хертсвүд дотроо дургүйцэж сэжиглэсэн санаагаа арайхан нууж асуужээ.

- Үгүй ээ, би өөр газар орох санаатай ажил хайж байгаа шүү.

Энэ нь үнэн байсан боловч бас өөр шалтгаан байгаагаа түүнд нэгд нэгэнгүй тоочсонгүй. Осборн Керри хоёул, Бродвейд нээгдэх шинэ театрын найруулагчтай очиж уулзчихаад тэндээсээ шууд Осборны өрөөнд гурван цагийн алдад иржээ.

Хертсвүдийн тийнхүү асуусныг эрхэндээ халдсан хэрэг гэж Керри үзжээ. Керри тэртэй тэргүй ихээхэн эрх мэдэлтэй байгаагаа ухааран бодохгүй байлаа. Хүн угаас эцсийн эцэст олж авсан, шинэ рэх дархаа эрхэмлэдэг зантай билээ.

Хертсвүд тэр бүхнийг тодорхой мэдэж байсан боловч угаас нэлээд овжин ухаалгаас гадна тэр зэргийн юмнаас болж юуюугүй хэрүүл өдөх хүн биш ажээ. Хертсвүд сэтгэл санаагаар тайлбарлахын аргагүй их гутарч байсан болохоор Керрийг тийнхүү улам хөндийрөн холдох болгож ажил төрөл олж биеэ өөд татах бололцоог ч сайн дураараа алдаж байлаа. Гэвч өдөр болгон шахам зөөлөн үглэх, гомдох байдал гаргах болсон нь тэр хоёрын хоорондын харилцааг улам л холдуулан хөндийрүүлэхээс өөр нэмэр болохгүй байлаа.

Нэг өдөр найрал бүжигчин хүүхнүүд сургуулилж байхыг ар хударгаас харсан найруулагч нь

бүжгийн удирдаачид нэг үг хэлснээс хойш Херствүд Керри хоёрын хөндийрөх зай улам тэлж эхэлсэн байх юм.

- Баруун талаасаа дөрөв дэх, одоо эргээд үзүүрт нь гарч байгаа хүүхнийг хэн гэдэг гэж найруулагч асуухад бүжгийн удирдаач нь,

- Ө, тэр үү, Маденда хатагтай гэдэг юм гэлээ.

- Тун аятайхан харагдаад байна. Эгнээнийх нь тэргүүнд оруулчихбол дээр юм биш үү?

- За тэгьеэ

- Тэгэх хэрэгтэй. Тэгвэл одоо байгаа тэр хүүхнээс чинь хамаагүй дээр харагдах болно доо.

- За тэгнээ, эгнээний толгойд тавья.

Маргааш орой нь Керрийг дуудуулжээ. Зэмлэх л бололтой юм шиг байж:

- Чи өнөө орой эгнээнийхийгээ удирдана шүү гэж удирдаач нь хэлэв.

- За ноёнтоон гэж Керри хэлэв.

- Хөгжөөнтэйхэн шиг байж үз, хөгжөөнтэйхэн шиг л байх нь чухал шүү.

Эгнээг удирддаг байсан хүүхэн өвчтэй байгаа юм байхдаа гэж керри гайхаж байсан боловч нөгөө хүүхэн нь байх бөгөөд өөрийг нь их л ёоз муутай харж байхыг үзээд намайг дэвшүүлж байгаа юм байна гэж бодов.

Керри толгойгоо нэг тийш ялимгүй хазайлган үзэмжтэй байлгаж чаддагаас гадна гараа эзэнгүй унжиж байдаг хэрэггүй юм шиг байлгахгүй харин ч яах аргагүй хэрэгтэй мэт байлгаж чаддаг байв. Тийм болохоор эгнээний урд зогсохлоороо нийтэд нь дээ татах сайн нөлөөтэй байлаа. Бас нэг орой найруулагч:

- Энэ хүүхэн биеэ ямар шүү янзтай аятайхан байлгахыг чадаж байна гэж хэлээд өөртэй нь ганцаарчлан уулзахсан гэж бодовч найрал дуу бүжгийнхний хэнтэй нь ч ганцаарчлан уулзаж ярилцах журам байгаагүй ажээ.

- Цагаан цувааныхаа эгнээний манлайд энэ хүүхнээ тавьчих гэж найруулагч бас нөгөө удирдаачид зөвлөн заажээ.

Цагаан цуваа гэдэг нь хөх өнгийн хажлага, мөнгөн чимэглэлтэй цас шиг цагаан даавуун хувцастай хорь гаруй хүүхнээс бүрдэнэ. Эгнээний манлайд байх хүүхэн мөн адил өнгийн хувцастай байх боловч бусдыгаа бодвол погон, мөнгөн бүстэй, нэг ташаан дээрээ богино сэлэм зүүсэн байна. Керрид тэр хувцас нь сайхан зохих тул хэдэн өдрийн дараа тэр хувцас хэрэгсэлтэйгээ тайзан дээр баяр бахдаотай гарч иржээ. Цалингий нь арван хоёр биш арван найман доллар болгосонд Керри онцгой их баяртай байв.

Энэ тухайгаа Хертсвүдэд огт хэлсэнгүй.

“Бүх мөнгөө өгөхөө больё, бишгүй л хүрэхээр өгч байгаа юм чинь илүү гарсан мөнгөөрөө өөртөө юм авна” гэж Керри шийдсэн байв.

Ажилд ороод хоёр дахь сар тийнхүү болоход Керри өөрийн бодсоноор дараа ньяхав ийхэв гэж бодолгүй өөртөө нэг овоо хувцас хунарын зүйлийг худалдан авсан байна. Байрны хөлс төлөх, хажуугийнхаа мухлагаас авсан зээлийг төлөх хугацаа ойртож байлаа. Ямар ч болтугай өөрийгөө жаал өөд татах нь чухал гэдгийг Керри сайтар ойлгосон байв. Хамгийн түрүүнд нэг цамц авчээ. Түүнийг авч байхдаа илүү гарган авч байгаа мөнгө маань даанч арвигүй байна, харин олсон бүх мөнгөө өөртөө зарцуулах юм бол зөндөөн их юм авч болох юм байна гэж бодлоо. Ганцаараа байсан бол байрны хөлс, хоол унданд бас л мөнгө зарна, тэгэхлээр бүх мөнгөө хувцас болон өөрийн аваасай гэсэн юманд зарчихаж чадахгүй гэдгийг бодохгүй байв.

Дараа нь бас нэг юм худалдаж авсан чинь нэмэгдэл мөнгөө өгөөд ч хүрэхгүй болохоор нь өнөөх арван хоёртоо халдахад хүрчээ. Керри арай ч даварчихлаа гэдгээ мэдэж байсан боловч бүсгүй хүний гоёж гангалах дур нь дийлдсэнгүй. маргааш нь Херствүд:

- Манайх хүнсний мухтлагт энэ долоо хоног таван доллар дөчин центийн өр тавьсан шүү гэхэд Керрийн царай ялимгүй барайж:

- Өө, тийм үү? Гээд цүнхээ онгойлгоод – Надад ердөө ч найман доллар хорин цент байна шүү дээ гэхэд:

- Сүүний хүнд бас жаран центийн өртэй гэж нэмж хэлэв.

- Тийм байх, бас нүүрсний хүнд өртэй гэж Керри хэлллээ.

Херствүд юу ч хэлсэнгүй. Гэ орныхоо зардлыг хайхралгүй шинэ шинэ юм худалдан авч байгаа, дуртай цагтаа орой үдэш алга болж, ер нь нэг юм болох гээд байна гэдгийг мэдэж л байлаа. Керри шуудхан:

- Надад мэдэх юм алга. Би бүгдийг төлж чадахгүй. Миний авч байгаа цалин бага шүү дээ гэв.

Энэ бол шууд өдсөн хэрэг байлаа. Херствүдийн уур хүрсэн боловч биеэ барилаа.

- Би бүгдийг чамаар төлүүлээд байя гэж байгаа юм биш л дээ. Намайг нэг ажилд ортол аргалж байгаач л гэж байна гэхэд Керри:

- Өө, тэр яах вэ, дуулаагүй үг биш дандаа л ингэж хэлдэг шүү дээ. Миний авч байгаа мөнгө, төлөх өр хоёр тэнцэхгүй байна. Би яахаа ч мэдэхийг болиод байна гэв.

- Би ч оролдоод л байгаа шүү дээ. Тэгээд намайг яая гэж? хэмээн Херствүд дуугаа өндөрсгөн хэлэв.

- Чи нэг их улайхгүй байна л даа. Би хөөцөлдөж байгаад л ажилд орлоо шүү дээ.

Херствүдийн уур ихэд хүрч бараг хэрцгий үг хэлэхэд дөхөн:

- Би бишгүй л хөөцөлдсөн. Чи өөрийнхөө амжилтаар намайг бүү далайлга. Намайг ажилд ортол дэмжиж байгаач л гэж гуйсан. Би бас бүр яадгаа алдчихсан хүн биш шүү. Сэхэхээ л сэхнэ гэлээ.

Херствүд үгээ жинтэйхэн хэлэхийг бодсон боловч хоолой нь ялимгүй чичирч байлаа.

Керрийн уур дорхноо гарч муухай юм болов уу даа гэж зовно.

- За яах вэ, энд байгаа мөнгө маань энэ гэж мөнгөө гаргаж ширээн дээр тавьснаа: - Бүгдийг төлж барахаар цалин авахгүй байгаа шүү дээ. Бямба гариг хүртэл хүлээх юм бол бас нэг хэдийг авна, тэрийгээ өгнө гэлээ.

- Хүнсний мухлагийн өрийг л одоохондоо өгчихье. Бусад мөнгө чамд байг гэж Херствүд гуингтайхан хэлэв.

Керри мөнгөө буцааж түрийвчиндээ хийгээд хоолоо эртхэн болгох гэж бэлдэж эхлэв. Тэр члимгүй хэрүүлийн дараа өөрийгөө бага зэрэг буруу юм хийлээ гэж Керри бодсон бололтой. Гэвч тэгсгийгээ тэр хоёр тус тусынхаа бодолд автаж эхэлсэн ажээ.

Хэлж байгаагаасаа илүү мөнгө авч байгаа хүн юм. Өөрөө боларван хоёр доллар авч байгаа гэнэн, тэгтэл худалдаж авч байгаа зүйлүүдээс нь бодоод үзэхэд тийм биш. За тэр ч яах вэ. Тэр мөнгөө өөртөө хэрэглэж л байг. Би ингэсгээд нэг ажиолд орно, тэр цагт яадагсан өөрөө мэдэг, чөтгөр гэж Херствүд бодож байв.

Херствүд уурандаа ийм юм бодож байгаа гэвч хожим яа ийхээ ч урьдлан төлөвлөж байж мэдэх чилээ.

“Уурлавал уурлаж л байг. Гэрээс гарч ажил олж хий гэж хэлэхгүй яадаг юм. Би заавал энэ хүнийг дэмжих учиргүй” гэж Керри бодно.

Энэ завсар Керри, Осборны найз хэдэн залуутай танилцжээ. Тэд нь их л хөнгөн хийсвэр, зугаа цэнгэл хөөцөлдөх дуртай улс шиг санагджээ. Тэд, үзээс хойш зугаалганд гарья гэж Осборныхоор орж иржээ. Яг тэр үед нь Керри тэднийд сууж байв.

- Хамтдаа явцгаая гэж Лола хэлдэг байна.

- Үгүй, ба явж чадахгүй гэж Керри хэлэхэд цаадах нь:

- Өө, юу гэсэн үг вэ, чи явахгүй гэж юу хийх юм? хамтдаа явъя л даа гэв.

- Би гэртээ таван цаг гэхэд харьсан байх ёстой.

- Яах гэж?

- Хоол ундаа идэж уухгүй юу?

- Эд нар чи бид хоёрыг хооллоно, гайгүй?

- Үгүй, үгүй, би явахгүй чадахгүй

- За яв л даа. Их санй залуус шүү. Чамайг харих цагитч инь л хүргээд өгнө. Төв цэнгэлдэхээр л очно шүү дээ.

Керри жаахан бодож байснаа арга буюу тэдэнтэй хамт гарах болж:

- Харин би дөрвөн цөг хагаст харина шүү гэлээ.

Энэ үг Лолагийн нэг чихээр ороод нөгөөгөөр нь гараад явчжээ.

Керри бол Дрүүэ, Хертсвүдтэй танилцсанаас хойш залуучуудыг нэн ялангуяа хөнгөн хөвсөргөн залуучуудыг дотроо огт тоохгүй болсон байлаа. Тэднийг бодохноо илүү хашир суусан санагдана. Тэдний магтаж сайрхах нь балай тэнэг санагдана. Гэсэн ч өөрөө бие бялдар, сэтгэл санаагаараа ч залуу хүн болохоор тэдэнд татагдаж байлаа.

- Бид цагтаа яг буцна, Маденда авхай, Цагаас чинь хожимдуулчихна гэж бүү зов, тэгэхлээр хамтдаа явна биз дээ? гэж тэдний нэг нь баөхлзөж тонголзон хэлэв. Керри инээмсэглэж:

- Ай, бүү мэд гэв.

Тэд тийнхүү сүүх тэргээр зугаалганд гарахад Керри гоё сайхан хувцастай хүмүүсийг сонирхон ажиглаж, залуу хүмүүсийн тэнэг магтаал, зарим хүмүүсийн дотор алиа шог гэж үнэлэгддэг хошин шогорхуу яриа хөөрөөг нь сонсож явлаа. Тавин есдүгээр гудамжны эхнээс авахуулан Урлагийн музейн, хавиар үргэлжлэн Зуун арван Долдугаар өргөн чөлөөг шувтартал үй олон сүүх тэрэг ярайна. Ганган дэгжин хувцас, гоёмсог сүүх тэрэг, агсам ажнай хөлгүүд гэх мэт тэр бүхий л гоо үзэсгэлэнт юманд нүдээ унагачих дөхөж явлаа. Тэр бүгдийг харахлаар өөрийнх нь ядуу зүдүү байдал бодогдон зүрх рүү нь зүүгээр шивэр шиг болж байв. Гэвч Керри тийм юм бодохгүй, ядахнаа Херствүдийг бодохгүй санаатай байлаа. Херствүд Керрийг дөрвөн цагт ирэх байх гэж хүлээсэн нь тавд ч, зургаан цагт ч ирсэнгүй. Эргэлддэг сандал дээрээсээ босоход зургаан цаг болчихсон байв.

- Гэртээ ирэхгүй юм байлгүй дээ гэж Хертсвүд гунигтай гарцаар үглэв.

“Ийм л болж байгаа хүн дээ. Өөрөө өөдөлж яваа болохоор намайг тоохоо больж байна” гэж бодлоо.

Цаг, тав арван тав болж байх үед л Керри харих цаг болсон гэж бодон санадчжээ.

- Цаг хэд болж байна? Миний харих цаг болсон байх гэхэд нэг залуу нь мэлгэр нүүртэй гоё цагаа хараад:

- Тав арван тав болж байна гэлээ. Керри:

- Өө, яана аа гэж дуу алдсанаа арагш сүүрс алдан суугаад, - Өнгөрсөн борооны хойноос эсгий хэвнэг нөмрөв гэгчээр одоо өнгөрчээ гэхэд одоо мөд сайхан хоол унд идэж уугаад дараа нь театрт орж дараа нь дотно сайхан яриа дэлгэхийг хүсэж байсан нэг залуу нь:

- Яг үнэн гэж хэлэв. Тэр залуу Керрид жигтэйхэн сүйд болж байлаа.

- “Дельмоникод” очиж хоолловол яасан юм, Орин?

- Тэгэлгүй яах вэ гэж Орин нь хөгжи лтэйгээр хэлэв.

Керри, Хертсвүдийн тухай бодов. Оройнхоо хоолонд ирж чадахгүй болсон тухайгаа анх удаа ийнхүү түүнд урьдаас хэлсэнгүй ажээ.

Тэд зугаалгаасаа буцаж ирээд зургаан цаг арван таван минут гэхэд зоогийн газар орж суужээ. “Шерри” хэмээх ресторанд болж байсан явдал санагдахад Керрийн зүрх өвдөх шиг болов. Түүнд Вэнс хатагтай, өөрийг нь эзгүй хойгуур шагаж Херствүд хачин муухай хувцастай угтахыг үзсэнээс хойш дахин ер уулзалдсангүй нь бодогдов. Бас Эмс санагдлаа. Тэр залуугийн тухай бодоход түүний дүр сэтгэлд нь ултай бууна. Тэр бол өөрийнх нь уншсан номноос илүү саайн ном уншсан, танилцаж таарлаж явсан залуу байжээ. Түүний эргэхэмлэн үзэг бодол санаа нь халуун дотно санагдана. “Сайн жүжигчин болж чадвал их л сайхан даа” гэж хэлж байсны нь тод саналаа. Керри одоо өөрөө ямар жүжигчин болоод байгаа бол.

Керри авхай та юу бодоо вэ? Алив би юу бодсоны чинь таах уу? гэж хөгжөөнтэй залуу нь хэлэхэд Керри:

- Өө, яах юм, битгий таах гэж оролд гэлээ.

Керри тиймэрхүү юм бодохоо тэр дорхноо болиод хоол идэж эхлэв. Нэлээд мартагнан овоо хөгжөөнтэй болжээ. Харин театраас тарсны дараа дахин үргэлжлүүлэн зугаалах тухай ярилцаж эхлэхэд Керри толгой сэгсрэн:

- Үгүй, үгүй, би чадахгүй. Тоглолтын дараа манайд хүн ирнэ гэсэн гээд огт зөвшөөрсөнгүй.

- Өө, Маденда авхай, гайгүй шүү дээ гэж залуу гуйлаа.

- Үгүй, би чадахгүй нь. Харин та нарт их баярлалаа, намайг уучлаарай гэж Керри хэлэхэд нөгөө залуу бүр урвайгаад явчихад найз залуу нь

- За найз минь, битгий уруу царайл. Театрын дараа бас оролдоод үзье, бодлоо өөрчлөх ч юм бил үү юмыг яаж мэдэх вэ гэв.

НИЙТИЙН МӨРГӨЛДӨӨН, СҮҮЛЧИЙН ОРОЛДЛОГО

Театрын дараа зугаалганд нь Керри оролцсонгүй. Ингэж алга болсноо юу гэж хэлдэг билээ гэж бодсоор гэрээдээ бушуухан очихоор яарчээ. Ирэхэд нь Херствүд хэвтчихсэн байсан боловч Керри йг өөрийнхөө орны хажуугаар гарахад босож:

- Өө, чи ирээ юу? гэв.

- Тэглээ.

Өглөөнийхөө хоол цайн дээр Керри буруугаа наминчилсан байдалтайгаар их л хулчиганаж:

- Өчигдөр орой гэртээ эрхтэн ирэх гээд чадсангүй гэхэд Херствүд:

- Өө, Керри минь, энэ талаар яриад яах вэ, ямар хамаа байх вэ, надад тайлбарлаад хэрэггүй шүү дээ гэвэ.

- Ирэх гээд чадсангүй л дээ гэж Керри царай ялимгүй улайлган хэлснээ цаадахыгаа “Би мэдэж байна” гэсэн байдалтай байхыг хараад:

- За яах вэ, юу л гэж бодвол бодохоос, ямар хамаатай юм гэв.

Түүнээс хойш Керри, гэр орныхоо талаар улам ч хайхрамжгүй болов. Ер нь тэр хоёр бие биентэйгээ ярилцаад байх ямар ч үндэсгүй мэт болжээ. Керри өөрөө санаад өгнө гэж байхгүй дандаа л Херствүдээр гуйлгаж байж зардлын мөнгө өгөх учраас тэгж царайдаж байхаас Херствүдийн үстэй толгой арзасхийдэг болов. тэгээд мах, талхны мухлагаар аль болох цөөн орох болж Осложийн дэлгүүрээс арван зургаан долларын зүйл нөөцлөн авсан байлаа. Тэгээд өөр дэлгүүрээс авах болж, бас махныхаа мулхагийг ч сольсон байлаа. Ингэж байгаагаа Керрид ердөө ч хэлсэнгүй. Өгсөн мөнгий нь авч зараад бас өдий төдий өр тавьдаг болсон учраас эцсийн эцэст заавал нэг хэрэг мандах байлаа.

Тиймэрхүү байдлаар есдүгээр сарыг баржээ.

- Дрейк ноён зочид буудлаа нээх болоогүйюу? Гэж Керри хэдэн удаа асуусан байна.

- Болоогүй юм шиг байна. Арван сард магадгүй юмуу даа.

Керри тэр хүнийг ч бодохоос зэвүү хүрэх болж “барагтайхан эр” юм гэж бодох болсон багөөд айл амьтнаар хэсэх нь улам олширч нэг их биш ч гэсэн аваг мөнгөнийхөө ихэнхийг хувцас хунарт зориулж байлаа. Тэгж байтал ч тэр театрынхан сарын дараа гадагш тоглолтоор явах болж “Сүүлчийн хоёр долоо хоног” гэсэн зарлал сонин болон зарлалын самбарууд дээр гарчээ.

- Би гадны тоглолтод нь явахгүй гэж Осборн хүүхэн хэлжээ.

Керри, түүний хамт өөр нэг театрын найруулагч дээр очиж уулзахад юуны өмнө:

- Урьд тоглож байсан туршлага байна уу гэхэд:

- Би “Казинод” байдаг гэхэд найруулагч:

- Өө, тийм бий гээд эцсийн эцэст долоо хоногт хорин долларын цалинтайгаар тэднийд тоглох болжээ.

Керри их баярлаж одоо ч энэ хорвоод амьдрах замтай болов, авьяас чадвары нь хүмүүс тоох болов гэж бодов.

Амьдралынх нь байдал ихээхэн өөр болоод ирмэгц гэр орных нь байдал тэвчихийн аргагүй санагдах болжээ. Ядуу, зүдүү, байнга зовлонтой буюу тийм санагдах болсон учир тэр оромжноос аль болох холуур яюмаар санагдана. Шөнийн хоногт ирж унтана, гэлээ ч гэр орноо аялуулах гэж нэлээд их ажил хийдэг байв. Херствүд юу ч хийхгүй суух нь их. Эргэлддэг сандал дээ суучихаад л эргэлдэж сонин унших буюу хөөрхийлөлтэй хувь заяандаа гомдон гиюүрч сууна. Арван сар, тэр ч байтугай бүр арван нэгдүгээр сар өнгөрч хөхөө өвлийн хүйтэн болоход мань хүн дэмий л суусаар байв.

Керри өөдрөг явааг Херствүд гадарлаж байлаа. Өмсөж зүүх нь улам сайжирч нэлээд ганган хувцаслах болов. Гэртээ ирж очиж байгааг нь харах бөгөөл заримдаа Керрийн мандаж алдарших ирээдүйн тухай ч боддог байлаа. Хоол унд чанаргүй муу юм идэж уусаар их ч турж байв. Хоолных нь дуршил ч бага болжээ. Хувцас хунар нь элэгдэж хуучирч гуйлгачных шиг болох дөхөж байлааа. Тийнхүү дэмий л хоёр гараа элгэндээ эвхэн хүлээн суухдаа чухам юу хүлээж байгаагаа ч мэдэхгүй ажээ.

Яваа явандаа гай зовлон нь тэвчихийн аргагүй болж иржээ. Өрөнд баригдаж эхлэв. Керри улам хайхрахаа больж, эзгүй байранд ганцаараа гиюүрэн сууж, гадагш харвал цас боосон хахир өвөл харагдана. Энэ бүхний эцэст сүйд болох нь гарцаагүй байлаа. Керрийг байрандаа байхад Ослож өөрийн биеэр тэднийхээр орж ирсэн нь сүйдтэй юм болох нь тэр ээ.

- Би өрөө нэхэж ирлээ гэж мухлагийн эзэн хэлэхэд Керри нэлээд гайхаж:

- Хэдий өртэй юм гэж асуув.

- Арван зургаан доллар гэв.

- Пөөх, тийм их гэж үү? Үнэн юмуу? Гэж Керри, Херствүдээс асуухад Херствүд:

- Үнэн гэлээ.

- Өө, тимй үү, би ер сонсоогүй юм байна.

Керри, Херствүдийг дэмий хэрггүй юманд мөнгө зарлаа гэсэн байдалтай харж байв.

- Үнээн, бид өдий мөнгөний юм авч хэрэглэчихсэн шүү дээ гэж Хертсвүд хэлээд үүд рүү очиж: - Би өнөөдөртөө төлж чадахгүй нь байна шүү гэж царайдангуй хэлэхэд, Ослож:

- За тэгээд хэзээ өгөх вэ? гэлээ.

- Бямба гаригаас наана л лав өгч чадахгүй нь ээ гэж Херствүд өчив.

- Чаавас! Гэж мухлагийн эзэн эвгүйцсэнээ, - Сайхан юм болж байх шив дээ! Би өрөө бушуухан авах хэрэгтэй байна. Би өөрөө мөнгөний хэрэгтэй болоод байна шүү дээ гэв.

Керри, тэр хоёрын энэ яриаг нэгд нэгэнгүй сонсон цаад талын өрөөндөө зонсож байхдаа ийм балай гайтай юм болох гэж хэмээн ихэд зовж байв. Херствүд ч их зовжээ.

- Та ингэж яриад яахав дээ. Та бямба гаригт ирвэл би ямарч болтугай хагас хугасы нь ч гэсэн өгч болох байх гэж Хертсвүд хэлэв.

Мухлагийн эзэн ч гарч явлаа.

Өр нэхэмжлэлийг Керри үзээд ихэд гайхаж:

- Яаж энэ өрийг төлөх юм, би л чадахгүй гэхэд Херствүд:

- Чамаар төлүүлэх гээгэй шүү дээ. Байхгүй юмыг хаанаас олох вэ. Тэр хүн хүлээнэ л биз гэлээ.

- Яагаад ийм их өр тавьчихдаг юм, гайхалтай юм байна даа.

- Хоёулаа л идсэн шүү дээ.

- Үгүй мөн хачин юм даа гэж Керри сэжиглэсэн хэвээр гайхсаар байна.

- Тэнд очиж зогсчихоод ингэж ярихын хэрэг юу байна? Намайг ганцаараа ийм их өр тавьчихлаа гэж бодож байна уу? Намайг л дэмий өр тавьчихаж гээд байгаа юмуу даа? гэж Херствүд хэлэхэд Керри:

- Ямар ч болтугай дэндүү их байна, би төлж барахгүй юм байна, миний авдаг цалингаас давж байна шүү дээ гэв.

- За яана гэхэв гээд Херствүд дуугай болон суулаа. Ийм ч болох гэж дээ хэмээн бодохуй зүрх нь өвдөв.

Керрийг гараад явахад Хертсвүд яая даа хэмээн бодол болон суусаар хоцорлоо.

Тэр үед Бруклинд трамвайн ажилчид ажил хаях гэнэ гэсэн дам үгийг сонингуудад нийтлэх болов. Тэд ажлын цаг урт, цалин бага гэж дургүйцэж байсан ажээ. Ажилчид, эздийг буулт хийлгэх гэж өвлийн улирлыг сонгон авдаг заншилтай байв.

Херствүд сонинг уншаад тийм ажил хаялт гарвал гудамжны хөдөлгөөн зогсох юм байна гэж бодов. Керритэй тар түр хийхээс нэг хоёр хоногийн өмнө ажил хаялт эхэлжээ. Цас орох шинжтэй тэнгэр бүүдийж манан татсан нэг орой Бруклины трамвайчид ажил хаялаа гэсэн мэдээ сонингуудад зарлгадав.

Энэ өвөл ажилгүйдэл ихэсч мөнгөний зах дээрч базаахгүй юм болно гэж сонингуудад бичиж байсныг Херствүд ажилгүй сууж байгаа хүн болохоор андах мэдэж, их л сонирхож байжээ. Урьд өдөрт хоёр доллар авдаг байсан бол сүүлийн нэг хоёр жилийн дотор “түр ажиллагсдыг ашиглах арга их хэрэглэн цалин хөлсий нь тэн хагасаар хорогдуулж ажлын цагийг арав, арван хоёр,

Тэр ч байтугай арван дөрвөн цаг болтол сунгалаа гэж трамвайн жолооч, үйлчлэгчид, эсэргүүцэн ажлаа хаясан байна. “Түр ажиллагсад” гэдэг нь гудамжны хамгийн их хөдөлгөөнтэй хамгийн их хөлтэй үед ганц удаа явахдаа хорин таван центээр рейс хийчихээд л ажилгүй болчихдог тийм

улсыг хэлдэг байжээ. Тэд ажил шгорьдож өглөөгүүр тэнгэр муухай байсан ч ирээд л хэдийд ажил өгөхийг хүлээн байдаг байж. Тэд ихдээ л хоёр удаа явж гурван цаг гаруй цагаа үрээд тавин ц?нтийн хөлс авдаг байв. Хүлээсний мөнгө гэж өгдөггүй байжээ.

Тийм журам улам газар авч байгаа болохоор тэнд ажиллаж өдөртөө тогтмол хоёр долларын хөлс авдаг долоон мянган ажилчны бараг нь тэгж чадахаа мөд болих нь гэж ажилчид гомдол гаргажээ. Тэгээд түр журмыг бүрэн устгаж ажлын цагийг арваас хэтрүүлэхгүй, өдөрт хоёр доллар хорин таван центийн хөлс олгож аль гэсэн шаардлага тавьжээ. Ажилчид энэ шаардлагаа нэн даруй биелүүлэхийг шаардсан боловч трамвайн олон компани шийдвэртэй эсэргүүцжээ.

Херствүд эхлээд ажил хаягдчын талд орж тэдний шаардлагыг шударга зүйл хэмээн үзэж байсан бөгөөд хойшдоо түүний ажиллгаа ямар ч байлаа гэсэн эцсээ хүртэл тэдний тэд байсан гэж болох билээ. Бүх мэдээг баргий нь уншаад “Уорлд” сонинд хэвлэсэн мэдээллийн гарчгийг онцгой сонирхон уншиж үзвэл түүнд трамвайн долоон компаний нэг хаяг боссон ажилчдын тоог ч тодорхой бичсэн байхыг олж үзлээ.

- Тэд ийм цагаар ажлаа хаядаг нь тэнэг хэрэг биш үү, гэвч зорьсондоо хүрээсэй билээ л гэж” Херствүд дотроо бодов.

Маргааш нь ажил хаялтын талаар бүр ч тодорхой зүйл хэвлэсэн байв. “Бруклинийхэн явган явж байна”, “хөдөлмөрийн эргүүл гүүрээр гарах замыг хаав”, “Долоон мянга орчим хүн ажлаа хаяад байна” гэх мэтээр “Уорлд” сонинд бичсэн байв.

Херствүд тийм зүйлийг уншаад юу болж төгсөх талаар өөрийн таавар гаргаж байлаа. Хөрөнгөтөн эздийг даанч их хүчтэй гэж тэр боддог байна. ажил хаягчдын тухайд “Тэд дийлэхгүй биз дээ. мөнгөгүй байж яаж дийлэх вэ. Кампаниудыг цагдаа хамгаална. Тэд хамгаалуулна л даа. тэрнээс гадна хотынхонд унаа хэрэгтэй шүү дээ” гэж бодож байв.

Херствүд эздийн талд байгаагүй ч гэсэн тэднийг хүчтэй учир дйлдэхгүй гэж бодож байв. Өмч хөрөнгө, нийтийн хэрэгцээ хоёроос яаж гарах билээ. “Энэ ажилчид яагаад ч дийлэхгүй дээ” гэж бодлоо. Тийнхүү уншиж байх зуураа нэг кампаниас гаргасан мэдэгдлийг олж уншсан нь:

“Атлантик өргөн чөлөөний төмөр замын газраас тусгайлан зарлах нь:

“Манай кампаний жолооч, үйлчлэгч, бусад хүмүүс гэнэт ажлаа хаясан учраас бид, бусдын хүчинд автаж ажил хаяхад хүрсэн үнэнч хүмүүсийг ажилдаа буцаж орохыг уриалж, энэ тухайгаа нэгдүгээр сарын арван зургааны арван хоёр цагийн өмнө өргөдлөөр мэдэгдэхийг хүсэж байна. Өргөдлийг хүлээн авмагц зохих хамгаалалтыг ханган янз бүрийн чиглэлд ажилд гаргана. Өргөдөл ирүүлээгүй хүмүүсийг халагдсанд тооцож оронд нь тус кампани шинэ хүмүүс авах болно”

Гарын үсэг: Ерөнхийлөгч Бенжамин Нортон” гэжээ.

Бас ажилд авна гэсэн нэг зарлал байхыг уншвал:

“ АНУ-ын Вестинхаузын галт тэргийг Бруклинд жолоодох мэргэшлийн жолооч 50 хүн хэрэгтэй байна. Хамгаалалтыг хангана” гэжээ.

Зарлал, бичиг бүрт “хамгаалалтыг хангана” гэсэн байхыг Хертсвүд ажиглаад “Эзэд хүчтэй байгаа нь илт байна. Тэдний талд цагдаа байна, тэгэхлээр ажил хаягчид юу ч хийж чадахгүй гэсэн үг” гэж бодно.

Иймэрхүү юм бодож байтал нь Ослож орж ирж, дараа нь Керритэй тар түр хийсэн хэрэг байжээ. Тэртэй тэргүй уур хүрмээр юм их байсан боловч Керрийн хэлсэн үг юм юмнаас адаг байв. Керри түүнийг урьд нь одоогийнх шигээ ингэж муугаар бодож бараг хулгайч гэж хэлж байсан удаа ер үгүй билээ. Тийм их өр яагаад тавьчихдаг билээ гээд сэжиглээд байсны нь яана. Гэтэл Хертсвүд аль болохоор хэмнэж аль болох бага мөнгө зарж байсан ажээ. Керрийг л их зовоохгүй вмсан гэсэндээ, мах, талхны мухлагийн эздийг хуурч байсан байна. Өөрөө тун бага иддэг, бараг юм идэхгүй шахуу байж.

- Үхсэн хойноо! Би ажилд орохоо л орно, яахаа байчихсан хүн биш шүү гэж Хертсвүд хэлжээ.

Нээрээ заавал нэг ажилд оръё гэж шийдсэн байлаа. Тийм үг сонсож суух дэндүү доромж санагдсанаас гадна цаашдаа иймэрхүү юм зөндөө гарах төлөвтэй байлаа.

Херствүд суудлаасаа босоод цонхоор харвал бүрхэг байлаа. Бруклинд очъё байз гэж бодоод:

- Очиход яадаг юм? ажилд орж болохоор байх шиг байна. Өдөрт хоёр доллар авах нь бөайна шүү дээ гэж бодоход нь “Тэнд очиж байж ажил хаягчдад зодуулж бэлтгвэл яана?” гэж хажуунаас нь хүн хэлэх шиг болжээ.

“за тэр ч гайгүй байлгүй”. Цагдаа нар хамгаалж байгаа. Галт тэрэг жолоодох хүнийг хамгаална гэсэн байх чинь билээ” гэж бодоход бас л хажуунаас нь “Чи жолоодож чадахгүй байж ямар хэрэг байна?” гэх шиг болов.

Тэгэхэд Херствүд, “Би жолоочоор орохгүй, кондуктор хийж болно шүү дээ” гэж дотроо бас мэтгэлээ.

“Жолооч л илүү хэрэгтэй байгаа даа”

“Хэнийг ч гэсэн авч л таарна даа”

Херствүд хэдэн цагийн турш яая даа гэж эргэлзсээр байгаад сүүлд нь ийм ашигтай чухал ажилд адган яарах хэрэггүй гэж боджээ.

Маргааш өглөө нь Херствүд өөрийнхөө дөмөг гэсэн хувцсыг өмсөж, сонины нэг хуудсанд жаахан талх, мах боож аваад явахыг завдаж байхыг Керри ажиглаж, их л сонирхож байлаа. Тэгээд:

- Чи хаачих нь вэ? гэж асуулаа.

- Бруклин оръё гэж хэлээд Керрийг яах гэж тийшээ явах нь вэ? гэж сонирхон байгаа бололтой харж байгааг нь ажиглаад:

- Тэнд очвол ажил олдож магадгүй байна гэлээ. Керри ихэд гайхан:

- Трамвайчин болох гэж үү?

- Тиймээ.

- Айхгүй байна уу?

- Юунаас айх гэж? Цагдаа хамгаалж байгаа шүү дээ.

- Өчигдөр гурван хүнийг урвагч гээд үхтэл зодсон гэж сонинд бичсэн байна лээ.

- Тэгсэн л байна лээ. Гэхдээ сонины бичсэн болгонд итгэх хэрэггүй. Ямар ч болсон трамвай ажиллуулах шаардлагатай байгаа биз дээ гэж Херствүд хэлээд шийдсэн байдалтай цөхрөнгөө барсан хүний янзтай харагдахад нь Керри дотроо өрөвджээ.

Урьдын овжин хүчирхэг Херствүдийн шинж тэмдэг үзэгдэх шиг болжээ. Гадаа тэнгэр бүрхэг ганц нэг нэвсгэр цасан ширхэг хаялж авай.

“Таарсан өдрөө ч тийшээ явах нь дээ” гэж Керри бодов.

Тийнхүү энэ өдөр Херствүд Керригээс өмнө гэрээс гарсан нь ер бусын тохиолдол болсон бөгөөд Арван дөрөвдүгээр гудамж, Зургадугаар өргөн чөлөөний зүг чиглэн явж тэндээсээ трамвайд суужээ. Бруклины төмөр замын захиргаан дээр ажилд орох гэсэн олон хүн өргөдөл өгч байгаа очсон хүн болгоныг ажилд авч байгаа тухай соннид бичсэнийг Херствүд олж уншсан байлаа. Тэндээсээ цааш нь их юм бодож дуугай дүнсгэр царайлсаар сорин зүтгүүрт тэрэг, гатлах завиар дамжсаар нөгөө зорьсон газраа хүрэхээр явахад хол, ганц нэг тааралдах галт тэрэг бүгд зогссон, хүйтэн бүрхэг өдөр байсан боловч мань хүн дүнсийн зүтгэсээр л байжээ. Бруклинд хүрч очиход ажил хаясан газар болох нь хүмүүсийн байдлыг ажсан ч тод харагдана. Хэд хэдэн замд явж байгаа галт тэрэг ганц ч үл үзэгдэнэ. Байшингийн уулзвар булан, ойр хавийн газраар хэсэг бүлэг хүмүүс эргэлдэнэ. “Флэтбуш”, “Проспект Парк, билетний үнэ 10 цент” гэсэн бичигтэй, дэрээ модон сандалтай, задгай хэдэн вагон замаар явж байна. Тэдгээрт суусан хүмүүс даарч, царай дортой харагдана. Ажилчид эзэдтэйгээ жижиг дайн хийж байгаа нь андашгүй ажээ.

Зорьсон газрынхаа ойр дөхөж ирэхэд тэнд хэдэн хүн бас хэдэн цагдаа байв. Бас тэртээ хэдэн буланд ажил хаясан хүмүүс юмуу даа гэлтэй нэлээд хэдэн хүн ажиглан зогсож харагдана. Эндхийн байшин барилга нь бүгд жижиг, модон байшин агаад гудамжаа цардаж яанзлаагүй ажээ. Нью-Йорктой зүйрлэхэд Бруклин үнэхээр ядуу дорой нв илхэн байна.

Херствүд, тэр бүлэг хүмүүсийн яг дундуур орж явахад тэр хавьд байсан цагдаа, тэдний дэргэд ирчихээд байсан хүмүүс ажиглаж байв. Цагдаа нарын нэг нь:

- Та юу хайж явна? Гэв.

- Би ажил хайж яваа хүн.

“Энэ шатаар дээш гарч хонтоорт нь ор” гэж цэнхэр шинээлт хэлэв. Цагдаагийн нүүрийг ажваас одоо болж буй явдлын талаар төдий л нэг их зүйл бодсон төдийгүй боловч зүрхнийхээ угт ажил хаягсдын талд байгаа болохоор “урвагчийг” үзэж ядаж байсан хэрэг. Бас журам сахиулах цагдаагийн хүч, сүр сүлдийг зүрхнийхээ угаас хүндэлдэг хүн. Харин түүний нийгмийн учир холбогдлын талаар хэзээ ч бодож байгаагүй, тийм бодол санааны ч хүн биш билээ. Тэгэхлээр тийм хоёр сэтгэгдэл түүний дотор бие биеийг хазаарлан тэнцүүлж өөрийг ньч барьж байдаг

ажээ. Тушаал авч гэм мань эх, энэ ажил эрж яваа хүний төлөө өөрийнхөө төлөө тэмцэхийн адил тэмцэх л хүн. Харин цадаагийнхаа цэнхэр хувцаснаас салчих юм бол түүний хавиргыг хугалахаас ч буцахгүй хүн.

Херствүд шороо тоосондоо дарагдсан новширхуу шатаар нь дээш гарч хонтоорт нь орвол наагуур хориг татсан урт ширээний ард хэдэн албан хаагч сууж байгааг олж үзэв. Урт ширээний ард сууж байгаа хүмүүсийн дотроос дунд зэргийн насны нэг хүн түүнийг харж:

- За, та ямар хэргээр явж байна? гэхэд Херствүд:

- Танайх ажилд хүн авч байгаа юу? гэлээ.

- Та галт тэрэгний жолооч уу?

- Үгүй, жолооч биш.

Херствүд, тэднийг хүн сураглаж ядаж байгаа болохоор өөрөө ийм байдалтай эхэллээ ч гэсэн эндээ авдаггүй юм гэхнээ өөр хэсэгтээ авч таарна, энд хүн авсан ч аваагүй ч яах вэ өөрөө мэдэг гэж бодчихоод дажгүй зогсож байлаа. Тэр хүн:

- Бидэнд уг нь туршлагатай хүн хэрэгтэй байгаа юм гэхэд Херствүд хэнэ ч үгүй инээмсэглэж байв. Тэгснээ нөгөө хүн:

- Гэвч та сурчих юм байгаа биз дээ, нэг чинь хэн билээ? гэхэд:

- Вилер гэлээ. Нөгөө хүн жижигхэн цаасан дээр нэрийн нь бичээд:

- Депо руу ороод мастерт үүнийг өг. танаар юу хийлгэхийг тэр хүн мэдэх болно” гэлээ.

Херствүд бууж гадагш гарлаа. Заасан газар руу нь шууд явахад цагдаа нар араас нь ажиглаж байв.

- Үзээд алдья гэсэн бас нэг хүн ирж дээ гэж цагдаа Кили, цагдаа Масида хэлэхэд цаадах нь:

- энэ ч жавтий хүртэж таарах байхаа гэж тайван хэлэв.

Тэд, ажил хаялт юу болохыг бишгүй үзсэн улс байжээ.

АЖИЛ ХАЯЛТ

Херствүдийн очсон депод хүн гэхээр юмгүй зөвхөн гурван хүн л зааж зааварлах ажил хийж байлаа. Амьжиргаа тасарсны эрхэнд наашаа ирсэн бололтой, царай алдсан, өлөн зэлмүүн хүмүүс ажил олж хийх санаатай ээлж дугаар хүлээн олноор зогсож байлаа. Тэд аль болохоор сэргэлэн цовоо байхыг хичээвч муугаа үзэж маягаа хэмлэж байгаа байдлаа далдалж чадахгүй байна.

Херствүд депогоор дамжин явсаар хашаалсан том газар орвол тэнд нь олон салаа зам, салбарууд харагдана. Тав зургаан вагонд шинэ хүнийг жолоо барьж сургах ажил эрхэлсэн хэдэн хүн байгаа бололтой. Тэнд бас өдий төдий хүн сурах ээлж хүлээн үүд хавьд нь зогсоно. Херствүд ч тэр байдлыг үг дуугүй ажиглан хүлээж байв. Тэр хүмүүсийг Херствүд түр ажсан боловч вагоныг нь л илүү сонирхож байв. Гэвч тэр хүмүүс нь харахаас базаахгүй хүмүүс санагджээ. Нэг, хоёр нь ямарьс гэмээр туранхай, хэд нь бүдүүн тарган, бас хэд нь хэдийг гордойсон харах царайнаасаа элдвийг үзэж туулсан өөдгүй этгээдүүд байжээ.

- Цагдаа нэмж дуудах юм гэж сонинд бичсэн байсныг ушсан уу? гэж тэдний нэг нь хэлж байхыг Херствүд сонсов.

- Тэгнэ гэсэн байна лээ, ер нь дандаа гэж байдаг шүү дээ гэж нөгөө нэг нь хэлэв.

- Биднийг яадаг бол, гайгүй байгаа даа? гэж бас нэг нь хэлэх бөгөөд чухам ямар хүн болохыг Херствүд олж харсангүй.

- Гайгүй байхаа.

- Сүүлчийн вагон уолоодож явсан шотланд нөхрийг чих рүү нь нүүрсээр шидсэн гэж надад ярьсан шүү гэж хажуунаас бас нэг нь хэлэхэд тэднүүс хулчганасан байдалтэй инээхчээ аядав.

“тавдугаар өргөн чөлөөний замд явсан нэг нөхөр л харин муугаа баахан үзсэн бололтой, цагдаа нарыг хүчр ирэхээс нь өмнө цонхных нь хамаг шилийг хагалаад өөрийг нь гудамжинд гаргаад хаясан гэнэ” гэж нэг нь сунжруулан ярив.

“Тэгэх нь тэгсэн гэнэ лээ, харин өнөөдөр цагдаагийн хүчийг нэмэгдүүлсэн” гэж бас нэг нь хэлэв.

Херствүд, тэдний яахианы утгыг нэг их анзаарсанч үгүй, гэхдээ тэд нэлээд айж байгаа, тгээд сэтгэлээ хуурч тайвруулахыг л бодож буй мэт санагдана. Херствүд хашаа руу хараад өөрийн ээлжийг хүлээн зогсож байв.

Ард нь байсан хоёр хүн нэлээд яриа хөөрөөтэй улс байв.

- Та трамвайчин уу? гэхэд нөгөө нь:

- Би юу? Үгүй. Би цаасны үйлдвэрт ажиллаж байсан хүн гэв.

- Би өөрөө аравдугаар сар хүртэл Нью-Йоркт ажиллаж байсан юм гэж түрүүчийнх нь хэлэв.

Тэр хоёр заримдаа шивнэх шахам ярих тул зарим үг нь дуулдахгүй, тэгж байснаа дахиад л чанга чанга дуугаар ярилцаж гарна.

- Эднүүсийн ажил хаядаг нь зөв л дөө, гэхдээ би эрх биш нэг ажилд орохгүй бол амьдрах аргагүй боллоо. _

- Харин тимий ээ. Би Ньюаркад ажилтай байсан бол юу гэж энд ирэх билээ.

- Одоо амь зуух хэцүү болоод байна шүү, ядуу хүнд яах ч арга алга. Гудамжинд өлбөрөөд ойчлоо гэхэд туслах хүн олдохгүй даг аа.

- Яг үнэн. Миний ажиллаж байсан газар хаагдаад би ажилгүй болчихсон юм. зуны турш баахан бараа үйлдвэрлээд тэр нь зарагдахгүй болох дээр эзэд үйлдвэрээ хаачих нь тэр гэх мэтээр ярилцахад Херствүд хааяа чих тавьж бөайсан боловч өөрийгөө тэднээс дээр юм гэж бодож байлаа. Бас тэд дэндүү бүдүүлэг аминдаа арчаагүй бусдын эрхэнд дөртэй үхэр шиг явдаг улс мэт санагджээ. Урьд өөдрөг явахдаа иймэрхүү хүмүүсийг тоодоггүй байсчлан “муусайн новшнууд” гэж бодлоо.

- Дараа ч нь гэж мастер дуудахад нөгөө хоёрын нэг нь Хертсвүдийг ёворч:

- Таны ээлж болсон байна шүү дээ гэлээ. Херствүд явж очоод тавцан дээр гарав. Мастер нь оршил болгон олон таван үгийн хэрэггүй гэж бодоод шууд л зааварлах ажлаа эхлэв.

- Энэ бариулыг харж бхайгаа биз дээ? гэхэд вагоны дээвэрт зоосон залгуурыг хуруугаар зааж:

- Энэ бол асаах унтраах үйлдэл юм. Вагоноо өөр тийш нь эргүүлбэ гэвэл энэ дээр нь дарна. Явуульч гэвэл энэ дээр нь дарна. Унтраая гэвэл голынхыг нь дарах хэрэгтэй.

Херствүд амархан юм даа гэж бодоод инээмсэглэж байв.

- Энэ бариулаар хурдаа тохируулна. Ийшээ болговол цагт дөрвөн милийн хурдтай явна. Харин ийш нь тулгавал цагт арван дөрөв орчим милийн хурд гарна гэж нөгөө хүн хуруугаараа зааж зааварлав.

Херствүд, урьд нь вагоны жолоочийн хэрхэн жолоодож явааг хардаг байсан болохоор мэддэг юм шиг ялимгүй дадлага хийвэл ядах юмгүй гэж сэтгэн их л тайван харж байлаа.

Цааш нь нөгөө хүн хэдэн зүйл нэмж хэлж өгөөд:

- за одоо ухраая гэв.

Херствүд вагоныг ухран депо руу орохыг тайван харж зогсов.

- Хөдлөхдөө тун зугуухан хөдөлж байхыг нь хэзээ ч мартаж болохгүй. нэгдүгээр араагаараа явуулж байгаад дараачийнхад нь алгуурхан шилжүүлж байх хэрэгтэй. Ихэнх шинэ хүн шууд эцсийн араандаа залгадаг гэм бий. Иэр их муу. Аюултай, мотороо эвдэж мэднэ. Тэгж л болохгүй.

- Мэдлээ гэж Херствүд хэлээд мастерын тайлбарлан ярихыг хүлээн сонссоор байв.

- За, одоо та бригад үз дээ гэж мастер нэг хэлэхчээн болов.

Зоогийн газрын эрхлэгч агсан эр маань бариулаас нь бариад их л аяархан эргүүлэв гэж бодсон

чинь хурдлах араанд нь оруулаад вагоноо ухасхийлгэж хүчинд нь өөрөө хаалга руу шидэгдэв. Аз болоход мастер нь тоормослон зогсоов. Херствүд мэл гайхан сандраад бушуухан байрандаа буцаж зогсов.

- Та энэ талаар л их болгоомжтой байх хэрэгтэй гэж мастер хэлэв.

Тооромс барих, хурд тохируулах гэдэг санаснаас ихээхэн адармаатай, тийм ч амархан сурчих зүйл биш болохыг мэджээ. Хэрэв мастер нь тусалж зааварлаж өгч байгаагүй бол мань эр арын хашаа руу нэг хоёр удаа орчих байсан бизээ. Мастер нь тэвчээртэй хандаж загнахгүй байсан боловч ердөө ч инээхгүй байв.

- Хоёр гараа зэрэг ажиллуулж сурах хэрэгтэй. Ер нь нэлээд дадлага хэрэгтэй шүү гэж хэлэв.

Тийнхүү сургуулилсаар байтал өдрийн нэг цаг болж гэдэс нь өлсөж байв. Цас будран хүйтэн зэвхий даасан өдөр байлаа. Богино замд хойш урагш холхиулсаар байгаад их ядарчээ.

Вагоноо мухарт нь оруулж орхиод хоёул гарав. Херствүд дцпод орж вагоны гишгүүр дээр сууж сонины цаасанд гэрээсээ боож гарсан идэх юмаа гаргаж ирэв. Даруулж уух ус ч байсангүй, талхны хатууг хэлэх үү, гэвч Херствүд амтархан иджээ. Хоосон ходоод руу явуулах л юм байсан нь их юм болжээ. Бараг бүхэл хахлаар нь идчихээд ийш тийш харвал хүнд хүчир ажлын мөр ялгаагүй, эхнээсээ дуустлаа дандаа хэцүү бэрх ажил болохыг ойлгож эхэлжээ. Доромж мэт санагдахаасаа хүнд хэцүү нь даамай ажээ. Хэн ч хийсэн хөнгө ажил гэж бодохгүй дээ гэж Херствүд сэтгэж байв.

Херствүд юмаа идчихээд дахиад л ээлжээ хүлээн зогсов. Уг нь үдээс хойш тасралтгүй дадлага хийх бодолтой байсан боловч хооронд нь хүлээсээр хамаг цагийг нь барчихсан байжээ. Тэрсээр орой болж өлсөж цангахын зовлон зэрэгцэж бас тэр шөнийг яаж өнгөрөөдөг билээ гэж бодов. Нэгэнт таван цаг хагас болсон учир юуны өмнө нэг юм идэж уух хэрэгтэй болов. харъя гэвэл хоёр цаг хагас тэр хүйтэнд унаатай унаагүй явах болно. Түүнээс гадна өглөө долоон цагт бэлэн бай гэсэн болохоор гэртээ харивал хар үүрээр босохоос өөр аргагүй болно. мөнгө гэвэл хоёр долоо хоногийн нүүрсний үнэ төлөх гэж Керригээс аваад хадгалж байсан ганц доллар арван таван цент өвөрт нь яваа.

“Энэ хавьд л нэг газар хоног өнгөрөөдөг газар байх ёстой, өнөө Ньюаркийн залуу хаана байгаа бол, асууя байз” гэж Херствүд бодов. Тэгээд тэнд ээлжээ хүлээгээд хүйтэнд зогсож байсан нэг залуугаас асуухаар шийдэв. Тэр залуу нь насаар дөнгөж хорь юмуу хорин нэг орчим гэмээр боловч гуйранч амьдралаас болоод эцэнхий туранхай гэж яах аргагүй харагдана. Амьжиргаа нь жаал дээшлээд ирэх юм бол дороо царай орж додийгоод явчих маягийн залуу санагдана.

- Мөнгөгүй явж байгаа хүнийг яадаг юм бол? гэж Херствүдв эвтэйхэн асуухад цаадах нь өөдөөс нь сүрхий ажиглаж буй бололтой харснаа:

- Та хоолны тухай хэлж байна уу? гэлээ.

- Тиймээ, бас хонох газар. Би өнөө орой Нью-Йорк руу буцаж чадахаасаа өнгөрлөө.

- Мастерт л хэл дээ, тэгвэл болох байх. Би л лав ярилцсан.

- Өө, тимй үү?

- Тийм тийм..надад юу ч байхгүй. гэр лүүгээ ч харьж чадахгүй нь, газрын мухарт муудаг хүн гэсэн.

Херствүд үүнийг сонсоод хоолойгоо засав.

- Энэ дээр байр байдаг юм байна гэж би бодсон. Чухам ямар юм байгааг нь мэдээгүй, ямар олигтой л юм байв гэж дээ. Бас хоолны талон өгч байна билээ. Хоол ч гэж хариугүй жаахан юм өгч байна лээ.

Херствүдийг дүсгэр царайлан инээмсэглэх аядахад цаад залуу нь тачигнатал чанга инээж Херствүдээс аятайхан үг сонсох санаатай:

- Тоглоом биш шиг санагдаж байгаа биз? гэхэд Херствүд,

- Биш юмаа гэв.

- Одоохон очиж уулзвал дээр бишүү, явчина шүү гэж цаадах нь хэлэв.

Херствүд үгэнд нь орж очиж уулзаад:

- Өнөө шөнийн хоног өнгөрөөх газар байх бол уу? Нью-Йорк руу буцвал би... гэхэд цаадах нь үгий нь таслан:

- Энэ дээр хэдэн ор бий шүү дээ, тэнд унтаж болно гэлээ.

- Өө, болж дээ, гялайлаа.

Хоолны талон хэлье үү гэснээ нэг л хэлэх эв нь олдож өгсөнгүй тул өнөө шөнөдөө өөрөө аргалахаар шийдэв.

- Маргааш өглөө л хэлье гэж Херствүд дотроо шийдээд, тэндээсээ ойролцоо орших хямдавар ресторанд орж хооллоод хүйтнийг хэлэх үү, бас ганцаар эвгүй тул зааж өгсөн газар луу нь шууд очжээ. Үдэш орой болсон хойно вагон жолоодох сургууль хийх хэрэггүй гэж цагдаагийн газар зөвлөсөн гээд нөгөө мастер нь ч явчихжээ.

Хоног өнгөрүүлэх өрөө нь шөнийн ээлжийн ажилчдад зориулсан газар бололтой. Есөн ор, хоёр гурван модон сандал, савангийн модон хайрцаг, жижигхэн цүдгэр пийшин харагдах бөгөөд түүнд гал улалзана. Херствүд тэнд их эрт орж иолээ гэж бодсон боловч өөрөөс нь хүн урьтаж орж ирээд зуухны дэргэд гараа ээн сууж харагдана. Херствүд дэргэд нь хүрч очоод бас гараа ээлээ. Тэнд байгаа хамаг юм нь харахаас заваан олиггүй сагадах боловч яана гэх вэ тэсээд л өнгөрөх хэрэгтэй түр зуур юм чинь дажгүй гэж Херствүд сэтгэлээ зогоов.

- Хүйтэн бхйгаа биз гэж тэнд байсан хүн асуухад Херствүд :

- Яггүй байна гэв. Тэгээд нэг хэсэг дув дуугай байцгаав.

- Унтахад аятайхан газар ч биш шив дээ гэж нөгөө хүн хэлэхэд Херствүд:

- Оргүйгээс яахав дээ гэв. Бас дуу чимээ тасарлаа.

- За би ч хажуулддаг юм билүү дээ гээд нөгөө хүн босож нэг орон дээр очиж зөвхөн гутлаа тайлан бүхлээр сунна хэвтээд хөнжил шиг юмаар нь хучиж хиртэй муухай ороолтоор толгойгоо ороов. Тэр байдлыг харахад тун эвгүй санагдсан боловч Херствүд тэр тухай бодолгүй зуух руугаа ширтээд өөр юм бодлоо. Тэгснээ унтаж амрахаар нэг орон дээр нь очиж гутлаа тайлж хэвтлээ.

Херствүд тийнхүү хажуулахаар зэхэж байхад энд ирэхийг зааж өгсөн нөгөө залуу нь орж ирээд Хертсвүдийг олж хамрагц танимхайрч:

- Оргүйгээс яахав дээ гэж хэлээд нүд хэсүүлэн харж байв.

Херствүд үүнийг өөртөө зориулж хэлэв гэж бодсонгүй харин зүгээр л амныхаа зугааг гаргаж байна гэж бодсон учир юу ч хэлсэнгүй. Тэгхэлээр залуу нь Херствүдийг зан муутай байна гэж бодоод аяархан исгэрснээ өөр хүн унтаж бахйгааг хараад больж таг дуугай болов.

Херствүд эхэндээ овоо нямбайрхаж өөрийнхөө хувцсаар хучин хиртэй бүтээлгийг шамлан нүүрнээсээ холдуулж байсан болвч төдхөн өдөржин ядарсны улмаас үүрэглэж эхлэв. Дулаан унтахын эрхэнд өнөөх бүтээлгээ голохоо больж татаж шургасаар байгаад хүзүү толгойгоороо лав гэгч нь хучаад дугжирч эхлэв.

Өглөө нь тэр муу өрөөн дотуур нь хэдэн хүн хөлхөн хүнгэнэлдэж эхлэхэд сайхан зүүд зүүдэлж байсан Херствүд нойрноосоо сэржээ. Чикагод хуучин сайхан гэр орондоо байна, охин Жессика нь нэг тийш явах гэж байна, тэр тухай ярилцаж байна гэж маш тод зүүдэлж байсан учир энэ муу өрөөнд байгаагаа мэдмэгц давхийн цочих шиг болжээ. Херствүд толгой өндийн харвал хүйтэн цэвдэг үнэн байдал түүнийг амархан сэрээжээ.

“Боссон маань дээр дэг ээ” гэж амандаа үглэв.

Тэр давхарт нь ус ч үгүй ажээ. Хүйтэнд гутлаа углан босож бие шилгээж жихүүцэв. Хувцас нь хумиралдаж толгойтой үс нь өрвийжээ.

- Монди! Гэж мань эр малгайгаа өмсөнгөө хэлэв.

Шатаар буухад хөл хөдөлгөөн хэдийнээ ихэссэн байлаа.

Усны цорго, дор нь урьд морь усалдаг байсан бололтой онгоцорхуу юм байх боловч алчуур алга, өөрийнх нь амны алчуур өчигдөр яахаа алдтал хир буртаг болсон ажээ. Тэгээд мөс шиг хүйтэн усаар нүүрээ булхаад мастерынхаа байдаг газар очиход тэр нь хэдийнээ ирчихсэн байв.

- Өглөөнийхөө цайг идэж уусан уу? гэж тэр эрхмийг асуухад Херствүд:

- “Үгүй” гэвэл цаадах нь:

- “Таны ээлж арай болоогүй байна, энэ хооронд амжуулсан нь дээр биз” гэхэд нь Херствүд яая даа байз гэсэн байдалтай хэсэг дуугай байснаа зориг гаргаж:

- Хоолны талон олдох болов уу гэв.

- Ав, май гээд нөгөө хүн нь нэг талон гаргаж өгөв.

Херствүд, өчигдөр оройнх шигээ нэг жаахан шарсан мах, муухай кофе хоёор өл залгажээ. Тэгээд буцаж очиход нь:

- Энэ вагоныг ингэсгээд авч гарна даа хэмээн мастер нь хуруугаараа зааж эхлэв.

Херствүд харанхуй оргисон депо доторх вагоны шатаар өгсөж ороод дохио хүлээв. Сэтгэл нь нэлээд түгших боловч зарим талаар уужрах шалтгаан байсан билээ. Ямар ч болтугай энэ харанхуй хар нүхнээс л бушуухан гарч үзэхсэн хэмээн хүлээж ядав.

Ажил хаялт эхлээд дөрөв дэх хоног нь болж байсан цаг бөгөөд байдал бишдэж байжээ. Энэ завсар ажил хаялт нь удирдаж байсан хүмүүсийн болон сонингуудын зөвлөлгөөнөөр тайван байдалтай явж иржээ. Ширүүн арга огт хэрэглээгүй байж, гэхдээ зарим нэг газар вагоныг зогсоож ажилд орсон хүмүүстэй хэлэлцээ хийн мөн зарим жолооч нарыг вагоноос гарган хөөж явуулж байсан, түүнчлэн зодож нэлээд сүрхий шарх олгосон явдал тав зургаа орчим гарсан боловч түүнийг нь зохион байгуулалтгүй зарим этгээд ийм явдал гаргалаа гэж ажил хаялтын хороодоос буруушааж байжээ.

Гэвч эздийн зүгээс ямар ч арга хэмжээ авахгүй цаг хонжиж, цагдаа нараар туслуулан одоо ажил хаягчдын эсэргүүцлийг давлаа гэж өдөр болгон зарлаж өдөр ирэх тутам замд гарах вагон нэмэгдэж байсан болохоор ажил хаясан хүмүүсийн уур хилэн бадарч ширүүсэх царайтай болж байсан ажээ. Тайван арга бол төмөр замын эздэд л сайхна идэш болж байна гэж ажил хаягсад ойлгож эхэлсэн байв.

Тийнхүү ажил хаяад долоо хоног орчим болсны дараа тэвчээр алдагдан тайван аргаас тулалдааны аогад шилжин энд тэндгүй галт тэргийг дайран ажил хаялтаас урвасан этгээдүүдийг зодож залхаан, төмөр зам эвдэлж, буу шийдэмдээ хүрө гудамж талбайгаар мөргөлдөөн олонтаа болж ширүүсэн ирэхэд эздийг хамгаалсан цэрэг цагдаагийн хүч ихэд зузаарчээ.

Херствүд тийнхүү уур амьсгал эрс өөр болж буйг мэдээгүй байв.

- Одоо вагоноо гаргаарай гэж мастер гараар дохин хэлэхэд Херствүдийн адил ажилд шинээр орсон кондуктор ар тийш үсрэн очиж явах дохио болгон хонх хоёр удаа дарав. Херствүд, аргаагаа залган депогийн хаалгаар гарган гудамжнаа гарч ирэхэд хоёр бүдүүн цагдаа Херствүдийн хоёр талдорж зогслоо.

Кондуктор дахин дохионы хонх дуугаргахад Херствүд цааш хөдөлгөн явав. Хоёр цагдаа ийш тийшг тайван харж явна. Нэг нь бүдүүн дуугаар:

- Өнөөдөр яггүй жиндүү хүйтэн өдөр байх чинв гэхэд нөгөө нь:

- Өчигдрөөс хойш биш санагддан боллоо. Дандаа ийм ажилд гарвал ч хэцүүдэх юм өайна гэнэ.

- Би ч өөрцгүй тэгж бодож байна.

Сүвээ гэвт үлээсэн хүйтэн салхинд даарч явахдаа мастерынхаа: “Вагоноо жигд хурдаар явуулаарай. Жи нхэнэ унаа хэрэглэх гэж байгаа хүн л биш бол сууя гэсэн болгоны зоргоор зогсож

болдоггүй юм шүү. Ялангуяа олон хүн цугласан гауар зогсож болохгүй” гэж байсан үгий нь санаж яваа Херствүдийг тэр хоёр огт анзаарахгүй байлаа.

Хоёр цагдаа хэсэг дуугай байснаа, нэг нь:

- Сүүлчийн вагон эсэн мэнд өнгөрсөн юм байхдаа, харагдахгүй байна гэв.

- Манайхаас хэн байсан юм бол гэж нөгөө нь асуухдаа вагоны жолоочийг хамгаалж явсан цагдаагаа хэлжээ.

- Шефер, Райян хоёр явсан.

Дахин чимээ тасарч, галт тэрэг ч жигд хурдаар явсаар байлаа. Хотын энэ хэсэг хүн цөөнтэй учир Херствүдэд олон хүн тааралдахгүй ажээ. Тэгэхлээр түүнд энэ байдал муугүй ч гэсэн даанч хүйтэнд даарах нь хэцүү санагдана. Гэтэл өмнө нь юу юугүй эгц тойролт харагдсан тул Херствүд мотороо унтраан тоормосоо хүчтэй дарав. Нэгэнт хожуу тоормослосон болохоор тун их огцом эргэлт болжээ. Өөрөө ойчих дөхөөд сандарсандаа нэг юм хэлэх шахсан боловч хэлсэнгүй өнгөрлөө. Зүүн гар талд нь явсан цагдаа:

- Иймэрхүү газар болгоомжтой байх нь дээр байх шүү гэж хэлэхэд Херствүд нэлээд ичиж:

- Тийм шүү гэв.

- Иймэрхүү газар энэ замд олон тааралдана шүү гэж баруун гар талд нь явсан цагдаа хэлэв.

Тэр буланг тойртол хүн нэлээд олшрон харагдаж эхэлжээ. Өмнө нь нэг хоёр явган хүн үзэгдэнэ. Нэг хаалганаас бидон барьсан жаал гарч ирээд:

- Урвагч! Урвагч гэж хашгирсан нь Херствүдэд тааралдсан анхны доромжилсон үг байв. Херствүд тэр үгийг сонссон боловч огт тоохгүй өнгөрөхийг боджээ. Тэр зэргийн үг цаашдаа ч сонсох бололтой гэж бодов.

Цаашхан нэг булан дээр зогсож байсан хүн зогсох дохио өгч байгаа харагдахад нэг цагдаа нь:

- Зогсож болохгүй шүү, тэр яаж ч мэдэх хүн байна гэв.

Херствүд үгэнд нь орсныхоо зөвийг гудамжны өнцөгт хүрэхийн алдад мэдэв. Зогсолгүй өнгөрөхийг нөгөө хүн мэдмэгц гараа зангидан занаж “Өө, муу өөдгүй новш! “ гэж хашги рав. Мөн өнцөгт зогсож байсан зургаа долоон хүн хурдлан өнгөрч буй галт тэрэгний хойноос баахан хараал хэлэн хашгиралдав.

Херствүдийн урам нэлээд хугарч үнэн байдал бодож байснаас хавьгүй аюултай байгааг ойлгов.

Тэндээс гурав, дөрвөн байшин өнгөрөхөд зам дээр хэсэг бөөн юм харагджээ.

- Уухайс, тэдний хийснийг хараач! гэж нэг цагдаа хэлэхэд нөгөө нь:

- Эдэнтэй ч үзэлцэж таарав бололтой гэв.

Херствүд ойртож очоод гүйцэд зогсоож амжаа ч үгүй байтал нь олон хүн цуглараад ирэв. Тэдний ихэнх нь ажил хаясан жолооч, кондуктор, тэднийг талархагчид байжээ.

- За найз минь наадхаасаа гар л даа. Чи хүний амнаас хоолы нь булааж авах гээд яах нь вэ гэж нэг нь эв зүйгээр хэлэв.

Херствүдийн царай хувхай дааж, тоормс, бариулаасаа зуурчихаад яах учраа ч олохгүй мэл гайхаж байна.

- Арагшаа болцгоо! Эндээс зайлцгаа! ХҮН АЖЛАА хийж байхад битгий саад хийгээд бай гэж нэг цагдаа өнгийж хэлэв.

Ажил хаягсдыг толгойлж байгаа нэг хүн, цагдаагийн хэлсэн үгтийг огт тоолгүй гагцхүү Херствүдэд хандаж:

- За, найз минь, бид чинь чам шиг л ажилчин улс шүү дээ. Хэрэв чи өөрөө жолооч байгаад бидэн шиг дарлуулж байгаа бол ажил хаячихаад байхад чинь оронд чинь хүн ороод ажиллахад бас л эвгүй санагдана шүү дээ. Эрхээ олохын төлөө тэмцэж байхад нь саад хийвэл дуртай байхгүй шүү дээ! гэхэд нөгөө нэг цагдаа нь бүдүүлгээр:

- Наадахыгаа унтраа. Алив эндээс зайлцгаа гээд цугласан олны өмнө бууж очоод манчуургаа далайхад нөгөө нь бас дэргэд нь очиж хоёул:

- Арагшаа та нар! Эндээс зайлцгаа! Та нар яах гээд байгаа юм? Үайл гэж зэрэг хашгирав.

Зөгий, үүрэн дээгүүрээ эргэлдэж байгаа юм шиг л бужигналдаж байлаа.

- Намайг битгий зодох гээд байгаарай, би яагаа ч үгүй байна гэж ажил хаягчдын нэг зоригтой хэлэхэд цагдаа манчуургаа далайн:

- Эндээс тонил! Үгүй бол толгой руу чинь ороолгоно шүү гэв.

- Чөтгөрт алгадуулмар гээд ажил хаягчдын нэг нь цагдааг түлхэн баахан муухайгаар хараав.

Цагдаа түүний толгой руу ороолгоход нүдээ түргэн түргэн хэд анивчсанаа толгойгоо гараараа барьж хөл нь салтархинаснаа арагш ухарч эхлэв. Үүний хариуд нэг нь цагдаагийн ар шил рүү зангидсан гараараа буулгаад авлаа.

Галзууртлаа уурласан цагдаа баруун зүүнгүй ороолгон дайрахад нөгөө нь түүндээ тусалж бас хараалын билэнч муу үг урсгаж гарлаа. Цагдаагийн ташуур манчуурганаас амжилттай булгаж чадаж байсан болохоор ноцтой шархтаж бэртсэн хүн байсангүй. Тэд замын хажууд гарч бөөгнөрөн зогсоод цагдаа нарыг элдэв муухайгаар нь дуудаж шоолон дооглож байлаа.

- Кондуктор яасан? Гэж цагдаагийн нэг нь Херствүдийн дэргэд сандран ирж зогссон хүнийг харж зандрав. Тэр нь кондуктор мөн бөгөөд болж буй явдлыг хараад айхаасаа илүү гайхан сонирхон харж байсан ажээ.

- Чи яагаад нааш бууж ирээд эн чулууг зам дээрээс зайлуулдаггүй хүн бэ? Юу гэж тэнд зүгээр зогсоод байгаа юм? Өдөржин тэгээд зогсох гээ юу? Буу гэж цагдаа хашгичив.

Херствүд айж сандарсандаа амьсгаадан бушуухан нөгөө кондукторын хамт өөрөө дуудагдсан юм шиг бууж очлоо.

- Одоо бушуул гэж цагдаа хэлэв.

Гадаа их хүйтэн байсан боловч тэр хоёр цагдаа халууцаж галзуурсан мэт байлаа. Херствүд, кондукторын хамт том том чулуунуудыг зам дээрээс авч зайлуулсаар халууцталаа ажил хийлээ.

- Ай муу урвагч. Хулчгар новш . Муу хулгайч чинь хүний ажил хулгайлж, хүнийг тонон дээрэмдэж байгаагаа мэдэж байна уу? Гайгүй, чи тэгж л бай, сайнаа үзэхгүйдээ гэх мэтээр хүмүүс хашгиран занаж байв.

Ийм үгийг ганц хүн хэлж байсан биш тал талаас нь олон хүн хэлж элдэв дээдийн билэнч муу үгээр хараан зүхнэ.

- Нүгэлтэй муу хар дээрэмчингүүд та нар ингэвэл ингэж л бай. Бузар ажлаа хийж л бай. Ядуу ардын цус шүүс сорогч чононууд сөнө түгэй гэж нэг хүн хашгирлаа.

Нэг ирланд авгай байрныхаа цонхыг онгойлгон толгойгоо цухуйлган:

- Бурхан та нарыг өлбөрөөж үхүүлнэ дээ гэснээ, - Чамайг ч өөрцгүй, цуст яргачинг! Чи хүүгийн минь толгойг хагалах нь уу, хүний үнэргүй яргачин чинь! Гэхэд цагдаа дуулаагүй мэт юм хэлээгүй боловч цугласан олны зүг харахдаа:

- Хөгшин шуламсыг чөтгөр аваачвал таарна гэж амандаа бувтнав.

- Замын хажуугийн чулууг үайлуулж дуусмагц Херствүд жолооныхоо ард суулаа, кондуктор ч хөдлөх дохионб хонхоо хоёр гурав дуугаргалаа. Хоёр цуагдаа ч Херствүдийн хоёр талд зогсдоогоороо зогслоо. Хүмүүс баахан хараал тавьж зүхэн занаж байна. Хаалга үүдээр нь чулуу орж ирж эхлэв. Нэг чулуу Херствүдийн толгойг арай л оночихсонгүй, бас нэг чулуу арынх нь цонхон дээр тар нярхийн буулаа.

- Хурдлаарай! Гээд нэг цагдаа өөрөө бариулаас нь шүүрэн авч хэлэв.

Херствүд тэр ёсоор хурдлан давхиулахад шидсэн чулуу, хараал зүхлийн үгүүд хойноос нь үерийн ус шиг дагалдав.

- Миний хүзүү рүү цохьсон этгээдийг ч би сайн чадсан даа гэж нэг цагдаа хэлэхэд нөгөө нь:

- Биднийг муу үгээр дайрсан тэр нэг залууг би танина, хариугаа авна даа, чамаас.

- Олон хүн харагдахлаар нь зодоон болж таарлаа гэж бодсон шүү.

Херствүдийн сэтгэл ихэд хөдлөн донсолж элдэв муу юм бодогдон гөлрөн явна. Энэ болсон явдла түүнийг сүрхий цочоов. Жинхэнэ үнэн байдал санаанаас нь хавьгүй өөр ажээ. Уг нь хулчгар зангүй учраас саяын тохиолдсон явдлаас зориг орж ямар ч болтугай эцэст нь хүртэл зорьсноороо байхаар шийджээ. Саяын энэ явалт хамаг бодол санааг нь эзэмдэж байсан болохоор Нью-Йорк руу, орон гэрээ ч бодсонгүй.

Тэд энэ удаа Бруклины хамгийн хүн ихтэй хэсэгт саадгүй орж ирлээ. Хүмүүс галт тэрэгний хагарсан цонх, Херствүдийн үжир даасан муу хувцас хунарыг ажин харна. Энд тэндээс –урвагч” гэх мэтийн бэлэнч муу үг сонсдох боловч галт тэргийг дайрсангүй өнгөрөв. Хотын төв дэх эцсийн буудал дээр цагдаагийн нэг нь болсон явдлын талаар утсаар мэдэгдэхээр буужээ.

“Бидний замыг отоод ббаахан этгээдүүд юм бээдэж байна. Тийш нь хүн хар явуулж зам цэвэрлэх хэрэгтэй байна” гэх нь сонсдов.

Галт тэргийг буцаад явахад хүмүүс муухай харж харааж зүхэж занаж байсан боловч халдан довтолсонгүй учир Херствүд депогийн бараа харагдахтай зэрэг дотор нь онгойж сүүрс алдлаа.

“За ямар ч атугай эсэн мэнд мултарлаа” гэж дотроо бодлоо. Галт тэргийг дотор оруулаад Херствүдийг түр амарч бай гэсэн боловч төдхөн дуудав. Энэ удаа түүнийг өөр хоёр цагдаа хамгаалан явах болов. Херствүд урьдахаа бодохноо овоо дадлагатай бөгөөд айх зовох нь ч бага болж галт тэргээ танил болсон гудамжаар давхиулан явж эхлэв. Харин цас хайлж хүйтэн салхи сүвээ нэвт үлээсэн тун ёозгүй өдөр байсан болохоор даарахын зовлон нь галт тэрэгний хурдлахад улам ч даамай болж байв. Хувцас нь тиймэрхүү ажилд даанч таарамжгүй учир жолооч нарын хэрхэж байсныг санан дагжин чичрэх биеэ шилгээн хөдөлгөж, хөлөө дэвслэн, гараа үрчиж байх боловч дуугай л явав. Санаснаас огт өөр аюултай юм тохиолдож байгаа болохоор энд хэрэггүй л ирж дээ гэж бодох боловч больё гэтлээ нэг их гутарч хулчийсангүй. Нохой долоомор ажил, таарсан цагтаа ч энд ирж дээ гэж дотроо бодох нь бодож байлаа.

Энэ ажлаас халшран няцахгүй байсны гол шалтгаан нь бол Керрид доромжлуулсан явдал ажээ. Дотроо өөрийгөө хөг нь өнгөрсөн хүн биш гэж бодсоор байлаа. Одоохондоо иймэрхүү ажил хийж байгаад ч гэсэн бага сага мөнгө хурааж аваад хүний зэрэгтэй болж болох байх гэж итгэсээр амуй.

Ийнхүү бясалган бодол болж явтал нь нэг жаалын шидлсэн бөөн шавар гар дээр нь бууж жигтэйхэн айхтар өвтгөсөнд нь уур нь ихэд хүрч:

- “Чөтгөрийн зулбадас” гэж хараал тавилаа.

- Шархдуулчихаа юу? гэж цагдаагийн нэг асуухад Херствүд:

- Үгүй гэв.

Нэг эргэх газар хүрээд хурдаа сааруулахад тэр булан дээр зогсож байсан алт тэрэгний жолооч агсан боловч одоо ажил хаяад байгаа нэг хүн Херствүдэд хандаж:

- Найз минь хүний мөстэй байгаач, наад тэргээ орхиод гараач. Бид амьжиргаагаа жаахан ч болтугай дээшлүүлэх гэж л тэмцэж байгаа юм шүү дээ. Бид эхнэр хүүхэдтэй, тэднийгээ тэжээх хэрэгтэй байна гэх мэтээр үнэнээ тоочин учирлаж эхлэв.

Херствүд түүнийг хараагүй царайлан дээгүүр харсаар хурдаа нэмэн явж өнгөрөхөд хойноос нь өнөөх хүн юм хэлсээр л хоцров.

Өглөөнөөс үд өнгөртөл Херствүд гурван удаагийн рейс хийлээ. Өгсөн хоол нь хийсэн ажилд нь огт таарахгүй бөгөөд хүйтэнд даарах нь тэсэхийн аргагүй мэт санагдана. Замын эцэс болгон дээр

дулаацах гэж бээрсэн амьтан гал хөс бараадаж байсан боловч чичирсээр байлаа. Тэндхийн нэг хүн түүнийг өрөвдөж дулаан малгай, хурган бээлий хоёроо түр хэрэглүүлхээр өгсөнд Херствүд жигтэй их баярлажээ.

Үдээс хойш хоёр дахь удааг явж байтал нь замын дунд орохын алдад зам дээр нь хуучин утасны мод хөндлөн тавьчихаад байгаа олон хүний дунд орж очжээ.

- Энэ зүйлээ зам дээрээс зайлуул гэж хоёр цагдаа омогдон хашгирахад хүмүүс бах тав нь ханасан байдалтай:

- Үгүй ер, горьдов оо. Дуртай юм бол өөрснөө зайлуулахгүй юу? хэмээн хашгиралдав.

Хоёр цагдааг буухад Херствүд дагаад буух гэлээ.

- Чи эндээ байсан дээр, тэгэхгүй бол нэг нь орж ирээд аваад явчихна шүү гэж нэг цагдаа нь хэлэв.

Олон хүн учир нь олдомгүй жигтэйхэн шуугилдаж байсны нэг нь яг хажууд нь:

- Найз минь үүнийгээ орхи, хүний нүнжгээ бод. Ядуу бидний эсрэг битгий тэмц. Эзэдтэй л тэмцээч гэж хэлэх дуулдав.

Харвал нөгөө гудамжны булан дээр зогсоод үг хэлж байсан хүн мөн байв. Херствүд хэлж буй үгий нь сонсоогүй царай гаргаж байлаа.

- Энийгээ орхиод гар л даа. Ядуу хүмүүсийн эсрэг тэмцээд ямар хэрэг байна. Орхиж үз гэж тэр хүн ухаантай үг хэлж байв.

Хаанаас ч юм бас нэг цагдаа хүрч ирээд дахин цагдаа хэмж ирүүлэхийг шаардахаар утастана хэмээн явав. Херствүд яах ч учраа олохгүй гайхан, айн гөлөлзөж байв. Нэг хүн гэнэт түүнийг заамдаж аваад:

- Эндээс тонил гэж зандраад хүчлэн чирч гаргахыг оролдов. Херствүд ууртайгаар:

- Чи эндээс зайл гэлээ. Нэг залуу ирланд вагон руу харайн орж:

- Муу урвагч чамд яахыг үзүүлээд өгье гээд далайн цохиод нь Херствүд булсандаа л эрүү үүгээ цохиулалгүй мөрөн дээрээ хальт цохиулав. Цагдаа яаравчлан хүрч ирээд баахан хараал тавьж:

- Эндээс бушуу тонил хэмээн зандрав.

Херствүдийн царай хувхай дааж, бие нь чичрэн ухаан алдах дөхжээ. Одоо л тун ноцтой санагдана. Хүмүүс түүнийг элдвээр доромжлон занаж зүхнэ. Нэг жижигхэн охин шоолж байгаа харагдав.

Херствүд яая даа хэмээн эргэлзэж байтал эргүүлийн тэргээр баахан цагдаа нэмэн иржээ. Замыг түргэн цэвэрлэж саадгүй болгов.

- За, одоо явнаа гэхэд галт тэрэг хөдлөн явлаа.

Буцах замд нь депогоос хоёр гурван километрийн тэртээд яахаас ч буцахааргүй уур хилэн нь бадарсан маш олон хүмүүстэй тааралджээ. Хажуугаар нь түргэхэн гараад явчих гэж бодсон боловч замы нь бас л хаачихсан байв. Бүр хэдэн байшин барилгын тэртээ явж байхад нь хүмүүс ямар нэг юм дамнаад явж байгаа нь харагдсан ажээ.

- Нөгөөдүүл чинь бас тэнд байна гэж цагдаагийн нэг нь дуу алдав.

Нөгөө нэг нь тэвчээр үнэхээр алдсан байдалтайгаар:

- Одоо та нарт нэг жаахан юм амсуулаад өгье гэж заналаа.

Херствүдийн нуруугаар хүйт оргилоо. Хүмүүс мөн түрүүвийн адил элдвээр хашгиралдан эхэлснээс гадна юмаар шидэж эхлэжээ. Нэг хоёр цонхыг хага шидэхэд Херствүд чулуунд арай л цохиулчихсангүй бултаж амжлаа.

Хоёр цагдаа хоёул үсрэн буугаад тэдний өөдөөс очиход цаадуул нь вагон руу дайрлаа. Тэдний дунд нэг жаахан охин гэмээр эмэгтэй үзүүртэй модб арьсан харагдана. Тэр эмэгтэй тэн их ууртайгаар Херствүдийг хатган завдахад арайхийн бултлаа. Үүнийг харж зоригжсон хүмүүс вагон дээр авиран гарч Херствүдийг чирэн буулгаж, юу ч хэлж, дуугарч ч амжаагүй байтал нь унагаад авчээ. Сүвээлдэн очихдоо Херствүд зүгээр байгаач, надад бүү халд гэв.

- Ай муу адгийн шаар гэж нэг хүн хараах дуулдлаа.

Херствүдийг өшиглөх нэг нь өшиглөж гараараа нүдэх нэг нь нүдэж гарахад алах нь гэж бодоод өөрийг нь чирч яваа хоёр хүний гараас мултрахыг оролдон тэмцэв.

- За бос, зүгээр байна шүү дээ, бос бос гэж хүн дуугарав.

Херствүд тэдний гараас мултран сэхээ орж харвал хоёр цагдаа нь дэргэд нь байгааг танив. Тамирдсанаас муужран унамаар санагдах бөгөөд эрүү нь нойт оргиход тэмтэрч үзвэл цус болсон байв. Сандчин амныхаа алчуурыг тэмтрэн эрэх зуураа:

- Хутгалчихсан байна гэхэд цагдаа нарын нэг нь:

- За зүгээр, жаахан л шалбарсан байна гэлээ.

Херствүдийн ухаан саруул болж эргэн тойрон харлаа. Жижигхэн мухлагт оруулаад орхисон байжээ. Эрүүгээ арчин гадагш харахад олон хүн язганалдан, вагон ч зонсож авай. Эргүүлийн галт тэрэг бас нэг өөр тэрэг харагдана.

Херствүд хэд алхан гадагш сайтар харвал түргэн тусламжийн тэрэг ч ирж явааг олж үзэв. Бас цагдаа нар хүмүүсийг дайрч заримы нь баривчилж байгаа харагдана. Нэг цагдаа үүдээр шайгаж:

- За гараад ир, вагондоо суугаад явж болно гэхэд баахан тээнэгэлзсэн байдалтай гарвал бие нь дааран жихүүцэж бас айдас хүрнэ.

- Кондуктор хаана байна? гэхэд

- Өө, тэр чинь одоо энд алга гэж цагдаа хэлэв.

Херствүд явж очоод салганасхийн орж суутал буун дуу гарлаа. Мөр рүү нь нэг юмаар дэлсээд авах шиг санагджээ.

- Хэн буудав? Ямар золиг нь буудав гэж цагдаа өндөр дуугаар хэлээд хоёр цагдаа хоёул үсрэн бууж нэг барилгын тийш гүйлээ. Херствүд байзнасхийснээ бууж тэнхээ алдсан янзтайгаар:

- Түй! Надад даанч ахадсан юм болж байна гээд бушуухан булан ороож хажуугийн гудамжаар түргэн түргэн алхах зуураа:

- Пүх, пүх хэмээн амьсгаадаж байлаа.

Нэг их холдож чадаагүй байхад нь жаахан охин тааралдаж сүрхий ажиглаж харснаа:

- Эндээс бушуухан холдсон нь дээр байх шүү гэлээ.

Нүдгүй шуурган дундуур тийнхүү гэрийн зүг явсаар харанхуй болсон хойно гатлах газар хүрч иржээ. Завинд тухлан суусан зорчигчид Херствүдийг ихээхэн сонирхож харж байв. Толгой түрүү нь дүйрсээр амуй. Цасан шуурганд мөрний ус гайхмаар мяралзан долгиотохыг ч сань эр огт ажих сөхөөгүй явлаа. Тэндээс бхйрандаа хөлөө чирсээр нэг юм хүрч ирэхчээ аядав. Байрандаа орж ирэхэд өөдөөс нь халуу дүүгнэ. Керри байхгүй л байв. Түүний авч ирж орхисон оройн хоёр сонин ширээн дээр харагдана. Херствүд гэрлээ асаагаад суулаа. Тэгсгнээ босож мөрөө яасан юм бол гэж шалгаж үзлээ. Жаахан л шалбарсан байлаа. Дотор нь элдвийн муу юм бодогдсоор нүүр гараа угааж үсээ самнав. Жаахан юм идмээр санагдан эрж байснаа сүүл сүүлдээ өлсөбөгүй юм шиг болж эргэлддэг сандал дээрээ эвтэйхэн суухад хачин сайхан амрах шиг болов. Сонин байгааг түр мартаад эрүүгээ тэмтэрч нэг үзлээ.

- Үгүй мөн жигтэйхэн юм боллоо шүү гэж дотроо бодсон нь ухаан нь нэлээд сэргэж буйн шинж байлаа.

Тэгснээ сонингуудаа хараад ялимгүй сүүрс алдсанаа “Уорлд” сонинг уншиж гарлаа. “Бруклинд ажил хаялт өргөжиж байна”, “Хотын энд тэндгүй ширүүн тулалдаан болж байна” гэх мэт гарчигтай зүйлс байгааг олж үзлээ. Херствүд, сонингоо эвтэйхэн засаж бариад тухлан уншихдаа ажил хаялтын талаар өгүүлсэн зүйлсийг нэгд нэгэнгүй гүйлгэн харлаа.

ХАВРЫН УРЬ, ХООСОН ДУН

Херствүдийг Бруклинд хэрэггүй л очсон юм гэж үзсэн хэн хүн боловч түүний тэнд очоод ажилд орох гэж оролдоод бүтэлгүй болсон явдал өөрт нь муугаар нөлөөлсөн гэдгийг ойлгох хэрэгтэй билээ. Керри бол бүр буруугаар ойлгосон байлаа. Херствүд түүнд тодорхой яриагүй болохоор ажил хийх дургүйдээ л анхны бага сага бэрхшээл тохиолдохтой зэрэг ухарсан байна гэж боджээ.

Керри тэр үед нэг инээдэмт бүжгэн жүжгийн дорнодын үзэсгэлэнт хүүхнүүдийн нэг болж тоглож байсан бөгөөд тэр нь жүжгийн хоёрдугаар үзэгдэлд эзэн хаан татвар эмсээ шалган үзэх үеэр тэднийг түүний урдуур гаргадаг тийм үйлдэл байжээ. Тэдний хэн ч ярих үүрэггүй байсан боловч тэр орой Херствүдийг депогийн газар хоноглодог тэр орой нэртэй хошиг жүжигчин нь тэр хүүхнүүдийн хамгийн наад талынхад нь хандаж тэр нь Керри байв бүдүүн гэгчийн хоолойгоор “ - Чи чинь хэн гээч нь байна даа? гэхэд үзэгчид хөхрөлдсөн бөгөөд Керр хариу хэлчихмээр санагдахтай нь зэрэг зориглон, “Таны дуулгаварт зарц чинь байна гэхихжээ”.

Хэлсэн хариу нь онц гойд юмгүй байсан мөртлөө үзэгчдэд тун их таалагдаж догшин ширүүн эзэн хааны өмнө байгаа өчүүхэн эмэгтэй тэгж аятайхан хариулсан нь уг байдалд үнэхээр чимэг болсон тул үзэгчид үнэн голоосоо баясан инээлдэв. Хошин жүжигч хүмүүсийн инээлдэхэд мээсийж, дахин инээлгэх гэж:

- Таны нэрийг Смит гэдэг бол уу гэж санасан юм гэлээ.

Керри тэгж хэлчихсэнээсээ хойш бие нь айж чичрэх шиг болов. Яагаад гэвэл тэнд оролцож байгаа хүн журмыг эдвэж өөрийн дураар ямар нэг үг хэлэх буюу хөдлөгөөн хийвэл торгох буюу халах ч ёстой байжээ. Тэгээд одоо яах ч учраа олохгүй болоод байлаа.

Гэтэл дараачийн үзэгдэлд орохоо хүлээн хөшигний ард өөрийн байрандаа зогсож байтал алдартай хошин жүжигч дэргэдүүр нь гарахдаа Керрийг таньж ухаалаг хүүхэн байна гэж бодохын хамт:

- Тийм үгээр хариу хэлж болох байх шүү, харин өөр үг хэрэггүй биз дээ гэхэд нь Керри номхноор,

- За, баярлалаа гээд явсан хойно нь хамаг биеэ чичирч байгааг мэдэв.

- Чи ч азтай юмдаа, бидний хэн нь ч нэг үг хэлэх эрхгүй шүү дээ гэж жүжигчдийн нэг нь хэлэв.

Тэр явдлын үнэ цэнийг мэтгэх явдалгүй байлаа. Керрийг мандаж гарах нь гэж тэдний бүлгийнхэн ойлгожээ. Маргааш нь мөн тэр үгийг хэлэхэд үзэгчид алга нижигнүүлэн ташихад Керри урамшин баярлаж мөдхөн заавал нэг юм болох байх гэж баярлан бодсоор харьжээ. Гэртээ орж ирэн Херствүдийн барааг харахтайгаа зэрэг урам нь энэ даруй хугарч ийм дэмий байдлаас ангижрахсан гэж хүсэж мөрөөдөх сэтгэл төрөв.

Маргааш нь Керри, Херствүдэд тохиолдсон явдлыг асуув.

- Цагдаа дагалдуулахгүйгээр ганц ч галт тэрэг явуулахгүй байна. дараачийн долоо хоногоос нааш хүн авахгүй юм байна.

Дараачийн долоо хоног болоход ба л өөрчлөлт гарсангүй. Херствүд улам санаагар унаж унхиагүйдэх нь даамжирч байх шиг санагдана. Керрийг өглөө босоод сургуулилгандаа явах гэх мэтийг мэдэхээс цаашгүй дуугай л сууж хоцорно. Хийдэг юм нь гэвэл сонин л уншина. Гэхдээ уншиж байвч өөр юм бодчихсон суух байх нь олонтаа тохиолдох ажээ. Нэг уда сонингоо уншиж байна гэсэн чийн харин Чикакогийн өөрөө гишүүн нь байсан клубийнхээ тухай бодчихсон сууж байснаа анх удаа ажиглажээ. Нэг мэдэхнээ газар ширтчихээд бодолд автан хуучин танил хүмүүсийнх нь дуу хоолой, хундага тулгаж байгаа чимээ ч дуулдах шиг болжээ.

Херствүдийг инээдтэй сайхан юм ярьж өгсөнд нь баярлалаа гээд найз Вокер нь “Хертсвүд, чи үнэхээр дэгжин амьтан юм даа” гэж хэлж байгаа нь яг сонсдох шиг болж Херствүд өөрөө ганган дэгжин хувцасласан усгал зөөлөн ааш гарган инээмсэглэж байгаа ч юм шиг санагдана. Херствүд дээш харвал сууж буй өрөө нь амьд амьтангүй үхээрийн газар мэт бодогдов. Цаг чаг цаг цохих тод дуулдаж эхлэхэл өөрийгөө жаахан зүүрмэглэж дээ гэж бодов. Гэвч брьаж байсан сонин нь хэвээрээ уншиж байсан зүйл нь нүднийх нь өмнө бас яг хэвээрээ байсан болохоор зүүрмэглэсэн биш гэж бодлоо. Ер нь л хачин мэт санагдсан ажээ. Дараа нь дахин иймэрхүү байдал тохиолдоход хачин мэт санагдахаа больжээ.

Мах, ногоо, талхны худалдагч, нүүрс зардаг хүмүүсээ байнга сольж зувчуулах болсон учраас зарим нь гэрээр нь ирж өр нэхнэ. Херствүд мөнгөгүй болохоор элдэв арга мэх хэргэлэх болж заримы нь сайхан үг хэлж аргална, заримы нь ирэхэд үүдээ тайлахгүй, гэртээ байхгүй мэтээр өнгөрөөнө. тэгээд мөнгөтэй байсан бол төлчихгүй яахав. “Манжинг шахаад цус гарахгүй манийг шахаад мөнгө гарахгүй” гэж хүртэл бодно.

Керрийн найз, жижигхэн байлдагч болдог Осборн найзынхаа ажилттай өөдөг яваад нь баясан оровч гаравч даган салахаа байжээ. Өөрийгөө хэзээ ч их юманд хүрч чадахгүй гэдгээ ойлгодог ч байж. Тэгээд Керригээс салахгүй дагахаар шийджээ.

- Чи алдаршина, ийм сайхан чадвартай хүн заавал мандана гэж найзыгаа бишрэн магтана.

Керри хэдийгээр аймхай боловч авьяас билэг нь үнэхээр их ажээ. Буёсад хүн өөрийнх нь тухай ингэж бодож байгаа бол тийм л байхаас болохгүй, нэгэнт тийм байх ёстой бол зориглон зүтгэх ёстой гэж Керри ч бодно. Амьдралын хуримталсан туршлага, ядарч явсан цаг нь түүнд их хэрэг болж байлаа. Эр хүний магтаал амлалын сайхан үгэнд хууртахыг больжээ. Эр хүн зангаа хувиргаж, санасан бодсоноос өөр болдгийг мэдэж гадарлажээ. Ямар ч зусардал магтаалын урьханд орохоо нэгэнт өнрөрчээ. гагцхүү ухаанаар давуу, ариун санаатай Эмс мэт суут ухаалаг хүн түүний сэтгэл дүрхийг хөдөлгөж чадах байлаа.

- Манай жүжигчид надад тун ч таалагдахгүй юм, бүгдээрээ биеэ жигтэйхэн тоочихсон улс санагдах юм гэж Керри нэг өдөр Лолад хэлэхэд цаадах нь:

- Беркли ноын аятайхан сайн хүн биш гэж үү? Гэж тэр хүнийг ганц хоёр удаа инээмсэглэсэнд нь сайн хүн гэж бодоод асуухад Керри,

- өө, аятайхан нь ч аятайхан хүн, гэхдээ сүүн цагаан сэтгэлтэй хүн биш, хоёр нүүр гаргадаг хүн л дээ гэв.

Лола, Керригийн ойр дотно болж байгааг мэдээд ингэж асуув.

- Чи сууж байгаа байрныхаа хөлсийг төлдөг үү?

- Төлдөг, юу гэж?

- Халуун устай, хөөрхөн, хямдхан байр байгаа юмаа. Надад ганцааранд маань арай томдоод, хоёр хүнд бол таарах өрөө, хөлс нь ч хямдхан долоо хоногт хоёулангаас нь зургаахан доллар авах юм.

- Хаана байгаа юм?

- Арван долдугаар гудамжинд.

Гурван долларын хөлс төлнө гэдгийг Керри зүгээр юм даа, тэгвэл өөрт маань арван долоон доллар үлдэж байх юм гэж нэгэнт тооцон бодсон боловч:

- Уг нь зүгээр юм байна, байраа сольдог юм билүү яадаг юм билээ, сайн хэлж мэдэхгүй байна гэв.

Энэ тухай дахин ярилцаагүй байэ байтал Херствүд_, Бруклин очиж бүтэлгүй ирсэн, бас жүжигт өөрийн санаачлагаар үг хэлж байж сайшаагдсан хоёр явдлын дараа уг асуудлыг дахин хөндсөн ажээ. Тусдаа байранд орчихвол эрх дураар байх юм шиг бодогдоод байх болжээ. Херствүдийг яадагсан өөрөө мэдэг гээд хаячихаад явъя гэж бодовч сүүлийн үед зан байдал нь хачин болоод байгаа учраас нэхэл дагал болоод байвал эвгүй вч болно гэж айх ажээ. Жүжиг тоглож байхад нь хүртэл энд тэндгүй эрж сураглаад байвал яана. Магадгүй эр шүү. Тэгнэ гэж лавтай хэлж болохгүй ч гэсэн болзошгүй юм даа. Тэгвэл олиггүй юм болж амар заяа үзүүлэхгүй, хөөдөж мэднэ. Ингэж бодохоос Керри их зовж байлаа.

Гэвч Керрийг ялимгүй дэвшүүлэн тоглуулах болсон явдал энэ асуудлыг нэг тийш болоход дөхөм болов. Тэдний дотроос сэтгэлтэй бүсгүй болж тоглодог нэг хүүхнэ ажлаасаа гарах болсонд оронд нь Керрийг тоглуулах болсон юмсанж. Ийм сайхан мэдээ сонсоод Осборн охин:

- Цалин хэдий юм өгнө гэж байна даа? гэхэд Керри:

- Асуусангүй шүү гэлээ.

- Асуух хэрэгтэй шүү. Асуухгүй бол өгөхгүй ч байж мэднэ. Додоо хоногт дөчин доллар өгөөрэй гэж хэлэх хэрэгтэй.

- Ай, тэгж хэлж чадахгүй.

- Юу гэсэн үг вэ. Хэлэх л хэрэгтэй гэж Лола дуу алдан хэлэв.

Керри асуухаар болсон боловч хэлж зүрхлэхгүй хүлээзнээд эвий нь тааруулах гээд байтал найруулагч нь тийм ийм хувцас өмсөж зүүх шаардлагатай гэхэд нь:

- Надад ямар цалин өгөх юм бэ? гэж асуув.

- Гучин таван доллар.

Үүнийг сонсоод Керри хачин их баярласандаа дөчин доллар өгөхгүй юмуу гэж ч гуйхаа мартжээ.

Керри хөлгүй баярлаж найз охиндоо сносговол цаадах нь гүйн ирж наалдахад Керри түүнийгээ арай л тас тэвэрчихсэнгүй.

- Цаадуул чинь өгвөл зохихоосоо бага л өгч дээ. Ялангуяа үнэтэй хувцас хунар авах хэрэгтэй болохоор багадаа юм байна гэж Лола хэлэв.

Керри тийм шаардлагатайг сонсмогцоо энэ тухай бодох нь боджээ. Тэгээд мөнө хаанаас олох вэ? Иймэрхүү юм болно гэж хадгалж хураасан мөнгө алга. Байрны хөлс төлөх өдөр мөд болох гэж байна. Тэгээд, өөрийхөө чухал хэрэгцээг бодож, “байрны хөлс төлөхгүй, тэр байранд ч суухаа байя. Энэ удаа мөнгөө өөрөө хэрэглэе нүүе” гэж дотроо шийджээ.

Осборн охин дахин шалгааж:

- Хоёулаа тэр өрөөнд нь орё л доо, тэрүүн шиг аятайхан хямдхан өрөө хаанаас олох вэ гэсэн явдал Керрийн шийдийг баттай болгож:

- За тэгье гэж ам дүүрэн хэлэхэд хүргэжээ.

- Ямар сайхан юм, хичнээн сайхан сууна гээч гэж Лола их баярлав.

Керри ялимгүй бодол болсноо:

- Би орох нь орноо, гэхдээ эхлээд жаахан байзная гэв.

Ингэж шийдчихээд байхад нь байрны хөлс төлөх өдөр нь ойртож, бас шинэ шинэ хувцас худалдаж ваах шаардлага тулгарч ирсэн болохоор Керрийн өөрийн шийдийг давхар зөвтгөх гэж Херствүдийн залхууг ад үзэх болов. Херствүд ажил хийх нь бүү хэл, үг дуугарахгүй шахам болж улам дор орсоор байв.

Байрны хөлс төлөх өдөр ойртоход Херствүдийн толгойд ч элдвийн бодол орж ирэх болж, энэ олон өрөөнд сууж их мөнгө төлөх, байрны эздэд өр хорин найман доллар төлнө гэдэг юу гэсэн үг вэ, үнэндээ хэцүү нэхүүлж сууж бололцоо байхгүй болжээ. “Керрид ч хэцүү л байгаа. Хямдхан шиг байр олбол зүгээр юм даа” гэж боддог байв.

Энэ бодлоо өглөөнийхөө хоолон дээр хэлсэн байж.

- Энэ байрны хөлс даанч их юмдаа, тимйээ?

- Үнэхээр тийм гэж Керри түүний санааг ойлголгүй хэлэв.

- Хоёул жижигхэн байранд орсон дээр бид дөрвөн өрөөгөөр яах юм гэхэд нь Керри сая учры нь ухаарчээ.

Хэрэв яг энэ агшинд царайгий нь ажсан бол Херствүдийг өөрөөс нь салахгүй санаатай байгаад дургүй нь хүрч байгааг олж харах байлаа. Херствүд, байраа багасгая гэхдээ нэг их гүнзгий юм бодоо ч үгүй байж л дээ. Керри тэр үгий нь сонсоод, болгоомжтойгоор:

- Ай, мэдэх юм алга гэв.

- Аятайхан шиг хоёр өрөө олох л байлгүй.

Энэ үгийг нь сонсоод Керри маш зэвүүрхэж дотроо: “Тэгнэ вий”. Нүүх суухын зардлыг хэн төлөх юм? Энүүнтэй хоёр өрөөнд ороод хамт суух гэж үү гэж бодов. Дэмий юм болохоос өмнө юу ч гэсэн одоохон шаардлагатай хувцсанд хэдэн мөнгөө заръя гэж шийдээд яг тэр өдрөө хувцас худалдаж авчээ. Тэгээд ганц л юм хийх дутуу болов.

- Лола, би тэр байранд чинь орох болсон шүү гэж очиж уулзаад хэлэхэд цаадах нь хөлгүй баярлан:

- Өө тийм үү? Яасан сайхан юм хэмээн дуу алдав.

- Одоохон болох уу? гэж Керри тэр өрөөнд нүүж орох тугайхаа бодон асуухаг найз охин нь:

- Бололгүй яахав хэмээн цангинав.

Тэгээд хоёул тийшээ очиж үзэхээр явава. Керри арван доллартай байсан болохоор байрны хөлс, хоолондоо хүрнэ гэж бодож байв. Нэмэгдсэн цалиндаа хүртэл бас арван долоо хоног байна, яагаад гэвэл шинэ рольд арав хоногийн дараа тоглоно, түүнээс хойш долоо хоноод л цалин авах вч гэж тооцжээ. Тэр шинэ өрөөний хөлс гэж гурван доллар төлжээ.

- Одоо би энэ долоо хоногийг дуустал л гол зогоох юмтай үлдлээ, өөр юу ч үгүй болсон гэж Керри найз хүүхэндээ үнэнээ хэлэхэд тэр нь:

- Өө, дажгүй надад хэдэн юм бий. Хэрэг болбол аваарай, би хорин таван доллартай шүү гэв.

- Зүгээр, бллох байх гэж бодож байна.

Тэр хоёр тийнхүү хоёр өдрийн дараа Баасан гаригт нүүхээр болов. Нэгэнт ийнхүү шийдсэн хойноо нэг л санаа нь зовоод болсонгүй. Гэмт хэрэг үйлдэж буй мэт санагдах ажээ. Өдөр болгон Херствүдийг ажиглахад түүнтэй хамт байх дур гутравч цаанаа бас өрөвдмөөр санагдаж байв.

Керри тэндээс гарахаар шийдсэн оройгоо Херствүдийг хулгай нүдээр ажиглавал цаадах нь амьдралын бэрхшээлд нухлагдан ядарч байгаа болохоос уг нь тийм ч хулчгар унхиагүй амьтан биш боловч сайн ажиглахад нүднийх нь гал буурч, царай зүс нь өтлөх янзтай болж, үс нь бууралтах маяг нэгэнт орсон харагдана. Одоо бүр блрахын даваан дээр байгаа хэрнээ түүнийгээ мэдэхгүй эргэлддэг сандал дээр суучихсан сонингоо уншсаар байв.

Одоо ингээд салаад явахаас хойш гэж Керри бодоод түүнд бага зэрэг халамжтай хандах болов.

- Чи яваад лаазтай буурцаг аваад ирэхгүй юу гээд хоёр долларын дэвсгэрт гарган тавихад Херствүд тэр мөнгийг нэлээд гайхсан янзтай харснаа:

- Тэгье тэгье гэлээ.

- Бас аятайхан хэрээннүд байвал авчихаарай, оройн хоолонд хэрэглэх юм шүү гэж Керри нэмж хэлэв.

Херствүд босож мөнгө авч пальто малгайгаа өмсөв. Аль аль нь их хуучирч муудсаныг Керри

ажиглав. Урьд нь тийм харагддаггүй байсан бол одоо жигтэйхэн содон байв. Одоо тийм хувцаснаас өөр юугаа ч өмсөх билээ дээ? Чикагод байхдаа бишгүй ганган хүн байсан. Трэ нэгэн цэцэрлэгт хүрээлэнд анх удаа болзонд ирээд уулзаж байхад ямаршуу дэгжин эр байв даа. Мөн ч ганган, мөн ч цэвэрхэн байж_ Бүгд энэ хүний буруу юу?

Херствүд дэлгүүр рүү явж ирээд авсан идэх юмныхаа хамт хариулт мөнгийг тавихад Керри:

- Наад мөнгө чинь чамд байг, дахиад өөр юм авах хэрэг гарна гэв.

- Үгүй, чамд л байг, гэж Хертсвүд догирхсон маягтай хэлэхэд Керри стэгэл нэлээд хөдөлж:

- Чамд л байж байг л даа, авах юм бишгүй мундахгүй гэв.

Херствүд баахан гайхсан боловч Керрийн нүдэнд хичнээн өрөвдөлтэй харагдсанаа яахин мэдэх билээ. Керрийн хоолой зангирч эгээтэй л мэдэгдчихсэнгүй.

Керри угаас уяхан сэтгэлтэй хүн болохоор энэ зэргийн ямар ч юманд уярах хүн билээ. Урьдынхаа явдлын нэхэн санахдаа Дрүүг хаяад явчдаг маань муухай юм болсон юм даа гэж бодохоос түүнтэй тааралдахгүй юмсан, ичгэвтэр гэж бодно. Гэтэл тгэж явсан нь Керрийн буруу биш байсан, харин Херствүд, таны нөхөр чинь өвчтэй байна, дуудлаа гэсээр худал хэлэн авч явахад үнэхээр Дрүүг яачсан юм бол хэмээн өрөвдөн гэрээс тийнхүү гарсан билээ. Тэр хоёрын ийнхүү нэгмөсөн салахад Херствүд ямар үүрэг гүйцэтгэснийг Дрүү мэдэхгүй учир Керри бүдүүн зүрх гаргасан гэж л боддог байх гэж сэтгэх ажээ. Тэгээд ч ичгүүртэй мэт бодогдоно. Түүнд сэтгэлтэй хайртай байсандаа биш, ер нь өөртэй сайн юм хийсэн хэнийг ч болов ачйи нь бачаар хариулахгүйг боддогоос тэр юм.

Яагаад ингэж сэтгэлээ уяруулахад хүрч байгааг Керри эргээүүлэн бодсонгүй. Харин Херствүд иймэрхүү байгааг нь ажиглаад дотроо: “Керри ер нь ийм өрөвч сэтгэлтэй хүн дээ” гэж бодов.

Үдээс хойш очиход жаахан бүсгүй Осборн нь юм хүмээ боон баглан нүүхэд бэлдэн дуу аялж байснаа:

- Өнөөдөр хоёулаа зэрэг нүүгээд орчихгүй яасан юм? гэв.

- Өө, би баасан нүүнэ, харин чи надад өнөө хэлж байсан хорин таван доллараа зээлдүүлэхгүй юу? гэхэд Осборн цүнхээ гарган:

- Зээлдүүлэлгүй яах вэ гэхэд Керри:

- Би бага сага юм худалдаж авах хэрэгтэй байна гэлээ.

Жаахан хүүхэн найздаа тус болж байгаадаа баярлан хөөрч:

- Зүйтэй, тэгэх л хэрэгтэй гэв.

Херствүд сүүлийн хэдэн өдөр гагцхүү дэлгүүр буюу сонины мухлагаар орох төдий, гэрээс гаралгүй уйдсан боловч тэнгэр муухай байсан болохоор арга буюу гарч чадахгүй бас хэд хоног болов. Гэтэл баасан гаригт тэнгэр маш сайхан болж эдн тэднгүй болжмор шулганалдан амьд амьтны зоо тэнийн хөхөө өвлийн хүйтний дараа хаврын налгар дулаахан урирал болдгийг хүн

амьтанд сануулжээ. _ Хөх тэнгэрт алтан наран мэлтийж тунамал сайхан туяагаа цацраан авай. Керри цонхоор нээн урьхан дулаан салхи сэвэлзэн орж ирэхэд:

- Өнөөдөр гадаа жигтэйхэн сайхан байна гэхэд Херствүд:

- Өө, тийм үү? Гэлээ.

Өглөөний цайны дараа Херствүд хувцсаа сольж өмсөөд гарах гэхэд нь Керри догдолсон сэтгэлээ арай чүү барин:

- Үдийн хоолон дээр ирэх үү? Гэхэд Херствүд “Ирэхгүй” гэж гараад Долдугаар өргөн чөлөөгөөр орон Харлем мөрнийг чиглэн явав.

Архи пивоны үйлдвэрээр урьд нэг орж явахад тэндээс мөрний усанд хэд хэдэн хөлөг онгоц байхыг харсан ажээ. Тэнд ямар шүү газар байдгийг одоо очиж сонирхмоор санагджээ. Тавин есдүгээр гудамжаар явж өнгөрөөд Төв цэцэрлэгийн баруун биеийг барин явсаар Далан наймдугаар гудамж хүрэв. Тэнд мэдэх байшин барилгууд тааралдахаас гадна олон шинэ байшин нэмэгдсэн байв. Юу ч үгүй байсан газрууд энд тэндгүй байшинтай болжээ. Тэндээссээ буцаж Цэцэглэгийн зүг явсаар Зуун аравдугаар гудамж хүрснээ Долдугаар өргөн чөлөөгөөр дахин орж, нэг цагийн алдад өнөөх сайхан мөрнийхөө эрэгт хүрчээ. Баруун эргээрээ зөөлөн элсэн манхан, зүүн талаараа модтой өндөр өндөр толгодооор хүрээлэгдсэн тэрхүү мөрөн яг нүднийх нь өмнө могой мэт тахиралдан харагдав. Хаврын урьхан сэвшээ салхи Херствүдийн сэтгэлийг сэргээхэд, нуруугаа үүрэн тэр хавийн газрыг сонирхон хэдэн хором зогслоо. Тэгснээ эргэж эргийн болдог даган алхаж өхлөг завиудыг сонирхов. Оройн харуй бүрий ойртож, сэрүү татан ирдэг дөрвөн цаг болоход Херствүд гэрийн зүг буцахаар шийдэв. Нэлээд өлөрхөж байсан болохоор гэртээ очиж дулаацаж хоолоо идэхээс сайхан юмгүй санагдлаа.

Байрандаа таван цаг хагаст хүрч ирэхэд нэгэнт харанхуй болсон байв. Цонх нь гэрэлгүй, сонин худалддаг хүний авчирч хийсэн сонин хэвээрээ байхыг бодоход Керри ирээгүй л байж. Херствүд түлхүүрээрээ онгойлгож гэрлээ асааж, жаал амрахаар суув. “Керри одоо ирлээ ч гэсэн хоол тэртэй тэргүй оройтох нь л дээ” гэж бодов. Зургаа хүртэл уншиж суугаад жаахан юм хийж идэх санаатай босов.

Тэгээд хартал өрөө байр нь нэг л өөр болчихсон шиг санагдахлаар, энэ чинь юу вэ? гэж бодоод эргэн тойрон ажвал өөрийнх нь дандаа суудаг газар нь нэг дугтуй харагдмагц мань эр учрыг дор нь ухаарав. Херствүд түүнийг шүүрэн авахад хамаг биеэр нь хүйт оргих мэт болов. Дугтуйн чанга шажигнан дуугарсныг яана. Дугтуйтай зурвасны дотор ногоон дэвсгэрт байлаа. Херствүд тэр мөнгийг гартаа атган, зурвасыг уншваас доорх зүйлийг бичжээ.

“Хайрт Жорж оо, би хэзээ ч эргэж ирэхгүйгээр явлаа. Хөлсий нь төлж чадахгүйгээс хойш ийм байртай байх ч хэрэг алга. Би бололцоотой бол чамд туслахсан, гэвч би хоёр биенээ тэжээж бас байрны хөлс төлж байх хир чинээгүй байна шүү дээ. Авч байгаа хэдийгээ хувцас хунарт зарах шаардлагатай байна. Би хорин доллар охилоо, илүү чадсангүй, байгаа маань л энэ. Тавилга хэрэгслээ яахыг өөрөө мэдээрэй, надад хэрэггүй”.

КЕРРИ

Херствүд, зурвасыг унагаад өрөө байраа нүд хэсүүлэн тайван харав. Юу юу алга байгааг мэдлээ. Задгай галын дээд талд байдаг хананы цаг алга. Керрийнх юм байж. Өрөө өрөөний гэрэл асаан явж үзэхэд нарийн эдлэлийн хайрцагт байсан бүх аар саар эдлэл бүгд байхгүй. Ширээн дээр бүтээлгээстэй байсан тоотой бүтээлгүүд байхгүй. Хувцасны шүүгээг онгойлгоход Керрийн юм бүгд алга. Үхээгний шургуулгыг татаж үзэхэд Керрийн дотуур хувцас бас алга. Авдар нь ч алга. Херствүдийн хувцас байдаг газраа өлгөөстэй хэвээр байна. Бусад бүх зүйл ч байдаг байдаг газраа байлаа.

Херствүд, зочныхоо өрөөнд орж ирээд газар ширтэн баахан суухад чив чимээгүй байдал хачин эвгүй санагджээ. Жижигхэн байр нь гэнэт аймаар хов хоосон санагдаж, өлөрхөж байснаа ч мартжээ. Шөнө орой болсон юмсуу гэмээр бодогдов.

Херствүд, дугтуйд байсан мөнгийг атгасан хэвээр, байгаагаа гэнэт мэдэв. Керрийн бичсэнээр хорин доллар байлаа. Тэр өрөөнийхөө гэрлийг унтраалгүй өөр нэг өрөөндөө оров. Байр нь эзгүй ханхай оргих нь улам улам тэсвэрлэмгүй санагдана.

- Эндээс гарах хэрэгтэй юм байна гэж ганцаараа шивнэх маягтай хэлэв.

Гав ганцаараа болж шүү дээ гэж бодохоос зүрх нь ёгхийлээ.

- Намайг хаяад явах нь энэ үү! Хаяад явах нь энэ үү гэж дахин давтан амандаа бувтналаа. Тийм олон хоног дулаанд нь хоргодож байсан энэ байр одоо хүнийх болж таарлаа. Ингэж бодохоос хамаг бие нь хүйт оргин дагжих шиг болоход эргэлддэг сандал дээрээ лагхийн суугаад юун тухай ч онцгойлон бодсон юмгүй, зүгээр мэлрэн шанаагаа тулан баахан суулаа.

Тийнхүү байснаа өөрийгөө гэнэт өрөвдөж хайрлаж байсан хүнээ алдсандаа бачимдан:

- Намайг орхиж явах хэрэггүй л байсан юм даа, би нэг юм олж хийнэ шүү дээ гэж ганцаараа үглэв. Тэгээд хөдөлгөөнгүй маш удаан сууж байснаа:

- Би бишгүй л хөөцөлдсөн шүү дээ, хөөцөлдөөгүй гэж хэлэгүй биз дээ? гэж тов тодхон хэлэв.

Шөнө дунд болсон байхад Херствүд эргэлддэг сандал дээрээ шал ширтэн суусан хэвээр л байлаа.

ЕРТӨНЦИЙН ЗУСАР НЬ ИЛЭРЛЭЭ. ХАРАНХУЙГААС ШИРТЭХ НЬ

Керри тохиолог өрөөндөө ороод Херствүд намайг явчсаныг мэдээд яагаа бол гэж бодлоо. Юм хүмээ санд мэнд хагас дутуу аялуулчихаад л театр руугаа явах зуур Херствүд тосоод зогсож байж магадгүй гэж айж байсан боловч зэгсэн байсангүйд нь баярлаж түүнд талархмаар байв. Жүжгээ дуусан дуустал тэр талаар бодоогүй боловч дууссаны дараа Херствүд отоод зогсож байж магадгүй хэмээн бас айлаа. Тэр мэтээр нэлээд олон хоног өнгөрөхөд Херствүд намайг зовоохгүй нь гэж Керри бодох болж айхаа больжээ. Тэгэн тэгсээр тэрхүү байранд гуниглан байсан үйл лайгаа хааяа санамсаргүй бодохын төдийг эс тооцвол мартагнаж эхэлсэн ажээ.

Мэргэшил хүнийг хичээн түргэн эзэмддэг нь гайхмаар. Керри, жижигхэн Лолын хов живийн ярианаас театрынхны зан араншингийн талаар их юм мэдэж авав. Ямар сонингууд театрын тухай бичдэг, тэдгээрийн аль нь эмэгтэй жүжигчдийн талаар их сонирхон бичдэгийг ч мэдэж авав. Тэгээд өөрийнх нь багтан тоглодог бүлгийн тухай болон бусдын тухай хэвлэсэн зүйлсийг нарийвчлан анхааралтай унших болжээ. Яваандаа сонин хэвлэлд нэрээ гаргах юмсан гэж мөрөөдөх болов. Бусдын адил алдар нэрээ мандуулахыг хүсэж нэрд гарсан бусад жүжигчдийн талаар магтаж буюу шүүмжлэлтэй бичсэн зүйлсийг амтархан уншиж байлаа. Тийнхүү ямагт гял цал гэсэн ертөнцөд Керри бүхий л санаа сэтгэлээрээ татагдах болов.

Тэр үед сонин сэтгүүлүүд, царайлаг эмэгтэй жүжигчдийн зураг хөргийг ихэд сонирхдог байснаа сүүлдээ бүр зан болжээ. Сонинууд, ялангуяа ням гаригийн сонинууд театрын амьдралд том том хуудас зориулж алдар цуутай жүжигчдийн нүүр царай, бие бялдын байдлыг харуулсан зургууд нийтлэх болжээ. Сэтгүүлүүд ямар ч болтугай цоо шинээр гарч байсан стэгүүлүүдийн хоёр гурав нь “царайлаг оддынхоор” үл барам дуулиантай болсон зарим жүжгийн үзэгдлүүдээс зургий нь тавих болов. Керри түүнийг улам сонирхон алгасалгүй уншина. Оролцон тоглож байгаа бүжгэн жүжгээс маань хэвлэлд гарах болов уу, миний зургийг гаргадаг сонин олддог болов уу? гэж сонирхохо болов.

Шинэ рольд тоглох болсон тэр нэг ням гаригийн орой тахйзан дээр гарахынхаа өмнө Керри сонины театрын тухай буланг харж байлаа. Үнэндээ өөрийнхөө нэрийг гаричх байх гэж хайж байгаагүй боловч тэр булангийн хамгийн сүүлчийн хэсэгт чухал мэдээнүүдийн дотор гэнэт анхаарлы нь туйлын их татсан зүйл үзэгдэх шиг болсонд бизэр нь халуу оргих шиг болж уншвал:

“Абдуллын авгай нар” гэдэг бүжгэн жүжгийн хөдөөний хүүхэн Катиш болж тоглож байсан Инэц Кэрюгийн оронд одоо тэр бүлгийнхээ дотроос хамгийн авьяаслаг Керри Маденда тоглож болжээ” гэсэн байв.

Керри түүнийг уншаад хэлж баршгүй их баярлан хөөрч байв. Мөн сайхнаа. Одоо л нэг. Удаан хүлээсэн магтаалын үг сонинд гардаг байна. Авьяаслаг гэсэн байна шүү. Ганцаараа байсан ч чанга инээхгүй өнгөрч чадсангүй. Лола олж уншсан бол уу?

- Маргааш орой миний тоглох гэж байгаа тухай энд бичсэн байна гэж найздаа хэлэхэд цаадах нь дэргэд нь гүйн ирж:

- Тийм үү? Яасан догь вэ? гээд тэр зүйлийг уншиж үзсэний дараа:

- Хэрэв чамайг сайн тоглох юм бол дараачин дугаартаа бүр дэлгэрэнгүй бичнэ дээ. Миний зургийг нэг удаа “Уорлд” сонин хэвлэж билээ гэв.

- Өө, тийм бий?

- Тэгэхээр барах уу, бүр хүрээлж ирээд л хэвлэсний нь яана гэж жаахан найз нь бахархан хэлэв.

Керри инээснээ:

- Миний зургийг ганц ч удаа гаргаагүй байна шүү дээ гэхэд Лола:

- Хэвлэнэ дээ харж л байгаарай. Одоо зургий нь байнга, хэвлэж байгаа жүжигчдээс ч чи илүү сайн тоглож байна шүү дээ гэв.

Ийм үг хэлсэнд нь Керри түүнд туйлын их баярлаж ер нь өөрийнх нь хамт баярлаж байгааг нь бодохоос Лолад хайр нь хүрч баөйлаа. Тэгж магтах нь үнэндээ сэтгэл санааны чухал дэмжлэг болж байжээ.

Керри шинэ рольдоо амжилттай тоглосон тул сонинд бас энэ тухай бичив. Үүнд нь Керри урамшин хөөрч одоо л энэ хорвоо гэдэг чинь намайг тоож эхэлж байна гэж бодлоо.

Керри анхныхаа долоо хоногийн гучин таван долларыг авахад тэр нь асар их мөнгө шиг санагджээ. Тэгсэн атлаа байрны хөлсөнд дөнгөж гурван доллар төлнө гэдэг инээд хүрмээр ажээ. Лолагийнхаа хорин таван долларыг өгсний дараа өөрт нь бас долоон доллар үлдсэн байна. Түрүүчийн байсан дөрөвтэйгээ нийлүүлэхэд арван нэгэн доллартай болов. Тавыг нь хувцасны газар урьдчилгаанд өгөв. Дараагийн долоо хоногийн цалин авахад бүр ч их баярламаар байж, юу гэвэл байрны хөлсөнд гуравхан доллар төлж, хувцасны урьдчилгаанд таван доллар өгөөд л бусад нь өөрт нь үлдэх тул түүнийгээ хоол унд болон дуртай юмандаа зарж болох байлаа.

- Театр маань тавдугаар сард хаагдах байх тэгэхлээр зуны зардлаа бодож мөнгөө хадгалах нь зүйтэй шүү гэж Лола зөвлөхөд Керри:

- Нээрэн тэгдэг хэрэг гэлээ.

Хэдэн жилийн турш бага мөнгөөр аргалж байсан хүнд долоо хоног тутам гучин таван доллар авна гэдэг бол тун их мөнгө ювм. Керрийн түрийвч ногоон долларуудаар зузаарсаар байлаа. Одоо олсон мөнгөө гагцхүү өөртөө зориулдаг болсон учраас Керри өөртөө гоё ганган хувцас гоёл чимэглэлийн зүйл худалдан авч сайн чанартай хоол идэх болж өөрийгөө өөд татаж байв. Тэгсгээд танил найз нарын тоо ч олшроод иржээ. Лолагаас салдаггүй хэдэн залуутай юуны өмнө танилцсан бөгөөд харин өөрийн бүлгийнхээ жүжигчидтэй танилцах гэж тусгай цаг албан ёсны урилга зарлага хэрэг болоогүй билээ. Тэдний нэг нь Керрид наалдан хэдэн удаа гэрт нь хүргэж өгөв. Тэр залуу театрын ажил тарсан нэг орой:

- Нэг газар очиж хоол идэх юм биш үү гэхэд Керри:

- За тэгвэл тэгье гэлээ.

Орой хүртэл зугаа цэнгэл хөөх дуртай хүмүүсээр пиг дүүрсэн рестораны ягаавтар гэрэлд Керри дагуулж яваа залуугаа ажиглан голж байв. Тэр нь дэндүү дэгжирхэж биеэ тоосон байдал үзүүлнэ. Гоёж гангалах, хөлжих тухай яринаас өөр юм ярихгүй агаад тэндээс гараад инээмсэглэн:

- Та гэр өөдөө шууд явах хэрэг үү? Гэхэд Керри энэ талаар ямар ч эргэлзээгүй мэтээр:

- Тэгэлгүй яах вэ гэв.

“Харахад гэнэн баймаар боловч тийм биш юм” гэж тэр хүн бодож түүнийг улам хүндэтгэж, улам шохоорхох сэтгэл төржээ.

Керри, Лолагийн хамт цаг сайхан зугаатай өнгөрөөхөөс ухарсангүй. Сүүх тэргээр явж зугаалах, жүжиг тарсны дараа зоогийн газраар орох, өдрийн цагаар гангалчихаад Бродвейгээр хэсэх мэтээр цаг өнгөрөөх явдал бишгүй олон байв. Тийнхүү том хотын зугаа цэнгэлийн ерөнхий хүрээлэнд татагдан орж байлаа. Тэгж байтал ч долоо хоног тутамын нэг удаа гардаг сэтгүүлд Керрийн зургийг томоохноор хэвлэсэн байлаа. Ингэнэ гэж Керри урьдаас мэдээгүй байсан болохоор: “Авдууллын авгай нар” гэдэг бүжгэн жүжигт тоглодог, үзэгч олны хайрыг татсан Керри Маденда” гэснийг уншаад амьсгаа нь давчдах шиг болжээ. Алдартай зурагчин Саронигаар, Лолагийн үгэнд ороод зургаа хэд дахин авахуулсан юм байж. Сонин сурвалжлагч тэндээс зургий нь олж авсан байж л дээ. Доош бууж тэр сэтгүүлээс хэд хэдэн хувийг худалдан авья гэж бодсон боловч хэндээ ч гэж олныг авах билээ, харин Лола л лав сонирхоно гэж боджээ.

Хүний харьцааны хувьд нийслэл хот аргагүй л хүйтэн цэвдэг газар. Керрийн авдаг хэдэн доллар нь юу ч биш бөгөөд баян цатгалан, алдар цуутангийн ертөнц гэгч хавьтаж очихын аргагүй хол хэвээр л байв. Хүмүүс танилцахдаа хөнгөн шалиг юм л бодохоос биш үнэндээ нөхөрсөг сайн санаа гаргах нь үгүй ажээ. Дур хүслээ л хангахыг бодохоос биш хүнд муу юм хийж орхиузай гэж бодох амьтан ганц ч үгүй. Херствүд Дрүү хоёроос нэгэнт гашуун туршлага олж авсан билээ.

Явах хүмүүс нь бүрэлдэж өгдөг юм бол тавдугаар сарын дундуур юмуу эцсээр тэднийхэн өөр хотоор очиж тоглох юм гэж Керри дөвөрдүгээр сард сонсчээ. Керрийг явна уу гэвэл яая даа гэж бодож байв. Лолагийн хувь гэвэл цалин багатай болохоор энэ хавьдаа ямар нэг театрт ажил олж болох байв.

- “Казино” театр энэ зун нэг юм тавих гэж байгаа юм гэнэ. Тэнд очиж асуухгүй юм гэж Лола хэлэхэд Керри:

- Тэгье, тэнд чинь очиж сурагладаг хэрэг гэлээ.

Тийнхүү очвод тавдугаар сарын арван зургаанд нэг ир дээ гэжээ. Өөрийнх нь театр таванд хаагдах байв.

- Гадагш тоглолтоор явах саналтай хүмүүс гэрээгээ байгуулаарай гэж театрын дарга үарлажээ.

- Битгий гэрээ байгуулаарай, болохгүй шүү. Би ч явахгүй гэж Лола хэлэв.

- Надад ажил олдохгүй бол яах билээ? гэж Керри итгэж чадалгүй асуув.

Хэрэгцээтэй үедээ найз нараасаа мөнгө зээлдчихдэг жижигхэн Лола өөрийнхөөрөө зүтгэж:

- Би л яасан ч явахгүй дэг. Нэг удаа яваад сохор зоос ч үгүй ирсэн гэв.

Керри түүний үгийг бодож байлаа. Урьд нь гадагш тоглолтоор явж үзээгүй болохоор мэдэх юм өөрт нь алга байв.

- Ямар ч болтугай ганц зуныг аргалчихаж болох байлгүй. Би л лав аргалаад байсан юмдаг гэж

Лола нэмж хэлэв.

Керри гэрээ хийсэнгүй.

“Казино” театрын дарга Керрийн тухай огт мэдэхгүй байсан боловч Керригээс сонинд бичигдэж байсан ба зураг нь сэтгүүлд гарсан бас театрын зарлалд байдгийг дуулаад нэлээд сонирхов. Тэгээд Керрийг үг ярьдаггүй рольд тоглуулах, долоо хоногт гучин доллар өгөх болжээ.

- За, би чамд хэлээгүй юу? Нью-Йоркаас явж болохгүй, явсны чинь маргаашаас эхлээд л мартаж эхэлнэ гэж Лола өөрийнхөө зөв юм хэлж өгсөндөө бахдан хэлж байлаа.

Керри хөөрхөн хүүхэн байсан болохоор ням гаригийн сонингуудын театрын буланд зориулсан булангийнхаа зураг чимэглэлд Керрийн зургийг тавьжээ. Тун царайлаг учраас зургийнх нь дор нэлээд хэдэн мөр үг бичсэн байв. Керри түүнийг үзээд маш их баярлав.

Гэвч театрын эзэд үүнийг огт мэдээгүй мэт урьдын адил нэг их анхаарч тоохгүй байсаар байв. Керрийн тоглодог роль нь тун ялимгүй буюу ноёны хэдэн хатны ганц ч үг дуугардаггүй нэг нь болж хэдэн үзэгдэлд харагдах төдий өнгөрнө. Хошин зохиолын зохиолч нь тийм рольд тоглох эмэгтэй жүжигчин их үүргэ гүйцэтгэж чадна гэж мэдэж байсан боловч түүнийг шинэхэн орсон хүн гэж танилцуулсан болохоор ер нь тийм рольд тоглох хүн байсан байгаагүй адил гэж хэлсэн байжээ.

- За, үглээд байхын хэрэг юу байх вэ, анхны долоо хоногт олигтой юм болж өгөхгүй бол тийм роль байлгаад яадаг юм, хасаж л орхиё гэж найруулагч нь зохиолчид хэлж байж.

Керри тэдний ийм нууц санааг яаж мэдэх вэ. Тэгээд өөрийг нь бас л хамгийн үл ажиглагдам юманд тоглуулж байгаад нь урам хугаран хөмсөг зангидан бэлдэж эхэлсэн байлаа. Сүүлчийн үзлэг болоход Керрийг харахаас урамгүй дүнсгэр байгаа нь ил байлаа.

Керри тийнхүү дүнсгэр байгаа нь найруулагчид ихээхэн зугаатай инээд хүрмээр санагдсан тул зохиолчид энэ тухай хэлэхэд цаадах нь:

- Харин ч зүгээр юм биш үү, Спарксыг бүжиглэхэд нь бүр илүү уруу царайл гэж хэлээч гэв.

Керри өөрийнхбөө хөмсөг зангирч уруул нь өмөлзөх дөхөж байгааг огтхон ч гадарлаагүй ажээ. Найруулагч нь түүний дэргэд ойртон ирээд:

- Маденда авхай илүүхэн уруу царайл гэв.

Керри ингэж хэлэх нь зэмлэснийх гэж бодоод жуумалзав.

- Үгүй, хөмсгөө зангид, түрүүчийнх шигээ хөмсгөө зангид гэж найруулагч дахин хэлэв.

Керри өөдөөс нь гайхсан нүдээр ширтэв.

- Хөмсөг зангид гэж байна шүү. Спарксыг бүжиж байх үед нь тун их ууртай байдал харуул. Тэгвэл ямар болох нь вэ гэдгийг би мэдмээр болоод шаардаж байна гэж найруулагч хэлэв.

Энэ нь Керрид тийм хэцүү биш байсан тул хөмсгөө бага зэрэг зангидаад өгөхөд их л инээдтэй

байсан болохоор найруулагч ч тэсгэлгүй инээд алдав.

- Зүйтэй, дандаа л иймэрхүү байдалтай байгаад байх юм бол үзэгчдэд тун аятайхан санагдах болно гэсэнээ Керрийн дэргэд ирж:

- Үзэгдлийнхээ трушид дүнсгэр царайлахыг оролд, аль болох ширүүн ааштай хүн шиг харагдахыг хичээ. Үзэгчид хараад их ууртай байгаа юм байна гэж бодог. Тэгж бодогдуулж чадвал роль чинь инээдэмтэй болохоор байгаа юм гэлээ.

Анхны тоглолтын орой Керри өөрийнхөө тоглосон ролийг ямар ч сонирхолгүй зүйл гэж боджээ. Хар хөлсөө цугтал баясалдан инээлдэж байсан үзэгч олон Керрийг огт анхаарахгүй байгаа бололтой. Хичнээн хөмсгөө зангидаад зангидаад нэмэр болсонгүй, үзэгч олны хараа бусад жүжигчдийн зүг хандсаар ажээ.

Хоёрдугаар үзэгдлийн үед урт унжруу ярианд нэлээд залхаж байсан үзэгчид тайз хэсүүлэх харахын зуур Керрийг хөх даахинз өмсчихсөн хөөрхөн царай нь байдгаараа хөмсгөө зангидсан байхыг ажиглав. Эхлээд энэ бол жүжигчний ямарнэг юманд дугуйцэн байгаа нь болохоос бас хаанаас л үзэгчдэд зориулсан байдал байв гэж тэд боджээ. Гэтэл Керри хөмсөг зангидаастайгаа жүжигчин болгоноо ёозгүй хүрхийн харж байхлаар үзэгчдэд тун инээдэмтэй санагджээ. Урдуур эгнээгээр суусан малигар ноёд Керрийг тун амттайхан хоол юмдаа гэж дотроо бодоцгоогоод хүчээр зангидсан хөмсгийг нь үнсэж байгаад тэнийлгэхсэн гэж бодож байжээ. Керри үнэхээр сэтгэл алдам байлаа.

Тайзны тэг дунд дуулан алиалж байсан хошин жүжигч, инээмээр юм болоогүй байтал жиг жуг инээлдэхийг сонсчээ. Дахиад л жиг жуг инээлдэнэ. Жүжигчдийг тоглож дуусахад үзэгчид нижгэнэтэл алга ташдаг байсан бол тэр удаа ойлгтой юм болсонгүй, хэдхэн хүн дуртай дургүй шал шол хийлгэв.

Яагаад ийм болдог билээ? гэж хошин жүжигч бодоод ямар нэг таалагдахгүй юм болж дээ гэж гадарлав.

Гэтэл жүжигчин тайз охирод явах зуураа Керри ганцаархнаа хөмсөг зангидан зогсож, үзэгчид хи-хи-хи хэмээн инээлдэх дуулдав.

- “Ай монди гэж! Миний амжилтыг ингэж баллахыг би хэрхэвч хүлээхгүй. Намайг хийдгээ хийж байхад эсхүл энэ хүүхэн зайлах хэрэгтэй, эсхүл би зайлах хэрэгтэй болов” гэж гол хошин жүжигч дотроо бодов.

- Юу болоо вэ? Тэр чинь өөрийнх нь л гүйцэтгэх үүрэг шүү дээ, өөрөөр хэлбэл үзэгчдийг илүү инээлгэх нэмэлт тоглолт хийж байгаа шүү дээ гэж найруулагч нь жүжигчний тавьсан эсэргүүцлийн хариуд итгүүлэх санаатай хэлэхэд жүжигчин:

- Та ингэж бодож байгаа хэрэг үү? Миний ролийг сүйдэлж байна гэж хэлж байна шүү дээ, би ингэх юм бол чадахгүй гэж дуугаа өндөрсгөн хэлэв.

- За яах вэ, юу ч гэсэн жүжиг дуусаг. Маргааш орой хүртэл яах ийхээ бодоцгооё.

Гэвч дараачийн үзэгдэл болоход яавал зохих нь ил бболжээ. Керри тэр хошин жүжгийн голлон

тоглогч нь болж хувирчээ. Үзэгчид түүнийг харах тусмаа таашаан баясаж байлаа. Бусад бүх тоглогчид түүнтэй зүйрлэхэд тоогдохоо больж харин Керри тайзан дээр гарч ирснээрээ л үзэгч олонд үнэхээр зугаатай хөгжилтэй байдлыг бий болгож чадаж байлаа. Найруулагч болон бүх жүжигчид Керри их амжилт олж буйг ойлгов.

Өдрийн сонингуудад шүүмж бичигчид Керрийг ялалтыг төгс болгожээ. Хошин жүжгийн тухай сонингуудад магтсан дэлгэрэнгүй өгүүлүүд гарч бүгд л Керрийг байн байн шагшин магтахдаа түүний чадал нь үзэгчдийн элгийг хөшгөл инээлгэж байгаадаа байна хэмээн ам нийлэн өгүүлжээ. Сонины тайзны урлагийн шүүмжлэгч бичихдээ:

“Маденда авхай бол “Казино” театрын тайзнаа хэзээ ч үзэгдэж байгаагүй хамгийн авьяаслаг жүжигчин юм. Түүний тоглолт нь тайван, цаанаасаа заяаны хөнгөн шогоор нэвт бөгөөд тэр нь сайн сархад ходоод биеийг тааламжтай болгон халаах мэт. Маденда авхайг тайзан дээр байнга гаргахгүй байгааг үзвэл түүний тоглож буй роль нь гол биш бололтой, гэвч үзэгч олон нь хэн нь гол болж байгааг өөрсдийнхөөрөө үнэлчихдэг шүү дээ. Ноёны бага хатан болж тоглож байгаа тэр жүжигчин хүүхэн тайзан дээр гарч ирмэгцээ үзэгч олны сайшаалыг олж дур сонирхлы нь татаж чадлаа. Хувь тавилангийн эгзэг гэдэг үнэхээр хачин юм даа” гэжээ.

“Ивнин Уорлд” сонины шүүмжлэгч хотынхонд “таарах” наргиантай юм олж хэлэх гэхдээ бичсэн зүйлийнхээ төгсгөлд “Сэтгэлээ сэргээе гэвэл Керрийн хөмсгөө зангидахыг үзээрэй” гэжээ.

Энэ нь Керрийн цаашдын амжилтад гайхмаар их нөлөөлжээ. Бүр маргааш өглөө нь найруулагч нь өөрөө Керрид баяр хүргэж зурвас илгээн:

“Та, хотынхны сэтгэл зүрхийг ганц дайралтаар эзэмдэн авах шиг байна. Миний бие аны болон өөрийн төлөөнөө нэгэн адил баяртай байна” гэж бичсэн байв. Жүжгийн зохиолч ч нэгэн адил баяр хүргэжээ.

Тэр орой Керрийг таетргаа орж ирэхэд найруулагч нь туйлын элгэмсгээр мэндэлж:

- Стивенс ноён нэг дуу бэлдсэн байна. Тэрнийгээ дараачин долоо хоногт танаар дуулуулах юмсан гэж байна билээ гэж жүжгийн зохиолчийн хүсэлтийг дамжуулан хэлэхэд Керри:

- Яанаа, би дуу дуулж чаддаггүй шүү дээ гэв.

- Нэг их хэцүү юм биш, тун хялбархан, та л дуулбал яг таарах дуу гэж зохиолч өөрөө хэлж байдаг шүү.

- За тэгвэл яах вэ, оролдоод үздэг байх даа гэж Керри эелдгээр хэлэв.

- Та хувцсаа сольж өмсөхийн өмнө миний өрөөнд нэг орж ирэхгүй ву, тантай ярилцах жаахан юм байгаа гэж дарга хэлэхэд Керри за гэв

Керрийн орж очиход нь тэр хүн нэг цаас гарган ирж шууд:

- Бид таныг цалингийн талаар гомдоохгүйг бодож байна.

Гэрээ ёсоор бол та гурван сарын турш долоо хоногт гучин долларын хөлстэй байх ёстой. Одоо долоо хоногт нэг зуун тавин доллра болгоод хорин сарын хугацаатай болговол та юу гэж бодож

байна? гэхэд чихэндээ итгэж ядан:

- Өө, бололгүй яах вэ гэв.

- Тэгвэл та энд гарынхаа үсгийг зурчихгүй юу гэлээ.

Керри тэр бичгий нь харвал дээр нь бичсэн тоо тавьсан он сар нь л өөр болохоос бусад талаараа түрүүчийнхтэйгээ адилхан байв. Сэтгэл нь ихэд догдолсноос үсгээ зурахад гар нь салгалж байлаа.

“Долоо хоногт зуун тавин доллар гэдэг чинь юу гэсэн үг вэ гэж Керри тэндээс гарсан хйоно аман дотроо хэлэх бөгөөд тийм их мөнгөний учир холбогдол чухам юу болохыг төсөөлж чадахгүй байв, саятан ч гэсэн төсөөлдөг гэж үү? Тэр бол шавхагдашгүй их бололцоог дотроо хадгалсан нүд гялбам гялалзсан зүйл л санагдана.

Энэ үед Бликер гудамжин дахь гуравдугаар зэргийн зочид буудлын газар сууж байсан Херствүд, Керрийн гялалзсаэ амжилтын тухай уншиж байлаа. Эхлээд чухам хэн гэгч жүжигчний тухай бичсэнийг ч мэдээгүй байснаа хэн болхоы нь мэдмэгц эхнээс нь дуустал нь хүртэл дахин уншив.

- Аргагүй л мөн байх нь, мөн, болж дээ гэв.

Тэгээд тэр заваан дочид буудлынхаа хана туургыг харав.

“Аз нь шовойж дээ” гэж Хертсвүд бодоход нүдэнд нь гэрэл гэгээ, цэцэг навч, сүүх тэрэг, элдэв төрлийн гоёл чимэглэлээр бялхсан урьдын тарган цатгалан гял цал амьдрал нь үзэгдэх шиг болов. Одоо Керри орд харшийн дотор оржээ. Гунигт хүйтэн ертөнцөд байсан түүнийг баячуулын ертөнц хаалгаа цэлийтэл нээгээд хүлээж авсан байна даа гэж бодохоос Керри түүнээс аливаа алдан цуутангийн адил маш хол байгаа мэт санагдав.

“За яахав, ингэж л яваг, би саад хийхгүй ээ” гэж Херствүд бодов. Энэ бол нэгэнт нухлагдаж талхиулсан боловч бас ч ор сураггүй аога болсон бус омог бардам бодлын цөхөрсөн шийд байлаа.

ЭНЭ БОЛ ГАЙХАМШГИЙН ЕРТӨНЦ БИШ, АЛТ БАЙЛАА Ч АВЧ БОЛДОГГҮЙ НЬ

Керрийг театртаа эргэж ирэхэд жүжгийнх нь өрөөг өөрчилчихсөн байв.

- Энэ бол одоо таны өрөө шүү. Матенда авхай гэж үйлчлэг нарын нэг нь хэлжээ.

Ингэхлээр хэдэн шатаар дамжин гараад ордог байсан, бөгс эргэх зайгүй өмгөр өрөөнд бас өөр нэг жүжигчинтэй хамт байх хэрэгцээгүй болж, жижиг жүжигчдийн барааг нь ч хараагүй гэмээр юм юмтай нэлээд том тохиолог өрөөнд орж байх болсондоо Керрийн дотор онгойж цэлсхийгээд явчих шиг болов. Бие мах бодь нь жаргалтай санагдах агаад түүнд оюун бодол нь хараахан оролцоогүй байлаа гэж хэлж болном. Үнэнийг хэлэхэд бодсон юмгүй бие сэтгэлийн жаргалыг эдэлж байсан юм.

Магтуулж хүндлүүлсээр байгаад Керри шинэ буурь суурьтай болж буйгаа ойлгож эхлэв. Одоо түүнийг захирч тушаах хүнгүй болж харин ч хүнээр гуйлгуулж, тэгэх мөртлөө ихээхэн хүндтэй гуйлгах болжээ. Керрийг эгэл даруу бошинзтойгоор тайзан дээр гарч ирээд тоглоход бусад нь атаархсан байдалтай харах бөгөөд харин урьд өөртэй нь адил буюу өөрөөс нь илүү гэж дээрэлхүү янзтай байсан нэг нь одоо –бид чинь хичнээн найз байлаа даа” гэсэн маягтай аргадангуй инээмсэглэх болов. гагцхүү гол хошин жүжигч өөрийн амжилтыг Керригээс болж буурлаа хэмээн хорсох тул их л ёоз муутай байх ажээ. Зүйрлэн хэлбэл, өөрийг нам цохисон хүний гарыг үнэсэхээс татгалзаж байлаа.

Керри хэдийгээр ялихгүй юманд тоглож байгаа ч гэсэн үзэгч олон өөрт нь баяр хүргэж байгааг мэдээд их баярлаж байв. Гэхдээ тийм их сүйдтэй сайхан тоглож байна гэж өөрөө бодохгүй байсан болохоор сэтгэл дундуур санагдах ажээ. Тоглолтын завсарлагаар нөхөд нь түүнтэй ярилцахад зовсон байдалтай инээмсэглэж байв. Керри сагсуурч онгиорх зангүй хүн юм. Урьд ямар байсан тэр хэвээрээ л байхаас биш ихэрхэж дээрэлхэх тийм юм эс мэднэ. Жүжиг тараад Лолагийнхаа хамт гэрт өөдөө явахдаа театрын захиргаанаас өөрт нь зориулж бэлдсэн сүүх тэргээр явна.

Дараачин долоо хоногт нь Керри амжилтынхаа анхны шимийг амсаж, хүндэтгэлийн хундага дараалан дараалан ирэх мэт байв. Их цалингаа авч эхлээгүй байсан ч хамаагүй байлаа. Амласан тэр их цалинд итгээгүй хүн байгаагүй бололтой. Захидал бичиг, урилга тасралтгүй цувах болов. Зүсий нь үзээгүй, сургий нь сонсож байгаагүй, Визер ноён гэгч нэг хүн хаягий нь яаж байгаад ч юм олж аваад нэг өдөр бөхөлзөж нахилзсаар орж ирээд:

- Та намайг ийнхүү орж ирснийг минь өршөөгөөрэй, гэвч би таныг байраа сольж орох бололтой байгаа болов уу? гэж мэдэхээр ирсэн юм гэхэд Керри:

- Би энэ талаар бодсон юм байхгүй шүү гэв.

- Би бол Бродвейп шинээр нээсэн Виллингтон зочид буудлын төлөөлөгч хүн. Та манай зочид буудлын тухай сонингуудад бичсэнийг анхаарсан байлгүй.

Үнэхээр Бродвейд жигтэйхэн сайхан ресторантай нэг зочид буудал нээгджээ гэдгийг сонссон байжээ. Визер ноён цааш нь хэлэхдээ:

- Манайд хэдэн сайхан тохилог өрөө байгаа юм. Хэрэв та зуныхаа байх орон байрны талаар

шийдээгүй байгаа бол манай тэр байруудыг үзэхгүй юу? Манай зочид уудал бол өрөө болгондоо халуун устай үйлчилгээ үлгэр жишээч, дээш доош буух олон өргүүр шат мэт бүхий л зүйлтэй газар юм шүү. Ямар болохы нь та өөрөө гадарлаж байгаа бизээ гэхэд Керри яриагийн нь тайван сонсож байдлы нь ажиглаж байхдаа энэ хүн намайг арай саятан гэж бодоогүй байгаадаа хэмээн бодож байв. Тэгээд:

- Танайх ямар хөтсэй суулгадаг юм? гэж асуув.

- Чухам энэ талаар л тантай аминчлан ярих гэж ирсэн юм. Манай хөлс бол уг нь өдөрт гурваас тавин доллар хүртэл байдаг юм гэхэд Керри тэссэнгүй:

- Баварваань! Над шиг хүн төлж хэзээ ч барахгүй юм байна гэв.

- Аргагүй, би таныг ойлгож байна. Харин тайлбарлаж хэлэх юм байна. Манай ердийн хөлс тийм байдаг юм, гэхдээ бид бусад ямар ч зочид буудлын нэг адил жич гийчинтэй байлгах журамтай. Та энэ тухай бодоогүй байж болох юм., гэвч таны нэр бол бидэнд онцгой ач холбогдолтой байгаа юм шүү.

- Аа тийм юмуу гэж Керри учры нь сая ухааран хэлэв.

- Тэгэлгүй яах вэ, зочид буудал болгон өөрийндөө сууж байгаа хүмүүсийн нэр төрөөс их шалтгаалдаг. Нэр цуутай таны мэт жүжигчин суух юм бол, та итгэхгүй ч байж мэднэ. Өөр бусад нэртэй төртэй хүмүүс манай зочид буудал өөд тэмүүлэх нь их болно шүү дээ гэж хэлээд бөхөлзөхөд Керри ичингүйрч нүүр нь улайсхийсэн боловч тэр хүний урьж байгааг яая даа байз хэмээн алгуурсан байдалтай бодож байв.

Нөгөө хүн нь бортго мэт бүрх малгайгаа аяархан базалж, толь шиг гялалзэх өрөөсөн гутлаараа шал тэпхийн гишгэснээ:

- Ингэхлээр хэрэв та болно гэж бодож байгаа бол би одоо таныг зочд буудалдаа төвхнүүлэх талаар хөөцөлдье. Үнэ цэнийн талаар зовох юм байхгүй. Тэр талаар яриад ч яах вээ. Зуны цагт хэдийхэн юу орох вэ, хэдхэн юм өөрөө л мэдээд өгвөл болох нь тэр гэхэд нь Керри нэг юм хэлэх гэсэн боловч цаад хүн үгээ үргэлжлүүлэн:

- Та тэгээд өнөө маргаашгүй очно биз дээ, хичнээн л хурван ирвэл төчнөөн л сайн байсанж. Танд бид хамгийнхаа сайхан, гэрэл гэгээ ихтэй, цонх нь гудамж руу харсан тийм өрөөнүүд өгнү шүү гэхэд Керри зочид буудлын төлөөлөгчийн үлэмж найрсаг байгаад нь уярч:

- Би танд их баярлалаа. Танай буудалд очих их дуртай байна. Би зохих хөлсий нь төлөлгүй, нэг их... гэтэл цаад хүн:

- Та энэ талаар бүү зов. Бид үүнийг таны санаанд таарахаар янзалж чадна, өдөрт гурван доллар төлөөд байхад болно гэж бодвол тэр ёсоор л болгоно. Та тэр мөнгийг долоо хоногийн эцэст юмуу сарын эцсээр үйлчлэгч хүндээ өгчихөөд түүнээс баримт авч байвал тэр маань байрны хөлс болох юм гэснээ түр азнаж байгаад:

- Та одоо очиж өрөө тасалгаануудаа үзэхгүй юм уу? гэхэд Керри

- Тэгвэл зүгээр л байна, гэвч би өнөө өглөө үзлэгтэй болохоор чадахгүй нь ээ гэхэд төлөөлөгч:
- Заавал одоохон гэж байгаа юм биш л дээ, хэдийд ч болно, Өнөөдөр үдээс хойш амжих болов уу?
- Болноо, болно гэж хэлснийхээ дараа нэгэнт Лолагийнхаа тухай санаж:
- Би нэг охинтой хамт суудаг юм. Тэр маань намайг хаа ч очсон хамт байх болно, энэ тухай хэлэхээ мартжээ, яадаг билээ гэхэд Визер ноён найрсгаар:
- Өө, тэр тэгэлгүй яах вэ, та хэнтэйгээ хамт байх таны тааламж мэдэх хэрэг. Бид тэр бүгдийг бүгдий нь ёсоор хамтад үйлчлэх болно гээд мэхэсхийн нахилзсанаа үүдний зүг араараа ухрав. Тэгснээ:
- Дөрвөн цагийн алдад таныг хүлээж байж болох уу? гэв.
- За тэгье гэж Керри хэлэв.
- Би тэнд таныг хүлээж байх болно гэж Визер ноён гарч одов.

Үзлэгийн дараа Керри тэр сониноо Лолад хэлэхэд Виллингтоныг театрын дарга нарын бүлэг мэт санаад:

- Нээрэн үү? Тэгвэл яасан сайхан хэрэг вэ? Үгүй ман сайхнаа. Ёстой гоё. Яагаав чи бид хоёр өнөө нэг хоёр залууг уриад байхад нь очиж хоол идсэн тэр газар чинь байхгүй юу. Санаж байна уу? гэлээ.
- Санаж байна, санаж байна.
- Тэрнээс сайхан юм хаана байх вэ,
- Хоёулаа үзээс хойш очиж үзсэн дээр байхаа гэж Керри хэлэв.

Визер ноён, тэр хоёрт хоёрдугаар давхарт гурван өрөө бас халуун усны өрөө үзүүлжээ. Өрөөнүүд нь шоколад мэт хүрэн улаавтар өнгө голцсон бөгөөд дэвссэн хивс хийсэн хөшгүүд нь бас тиймэрхүү өнгөтэй байв. Зүүн талын гурван цонх нь Бродвейн хөл ихтэй гудамж руу харсан, бас гурав нь хажуугийн гудамж руу харжээ. Унтлагын хоёр хөөрхөн өрөөнд нь цагаан паалан мэт өнгөн дээр алтан боронзон хээ угалз гаргасан ор засаж тэдгээрийн өнгө үзэмжинд тааруулан будаж янзалсан сандал хайрцгуудыг хослуулан тавьжээ. Гурав дахь буюу гийчний өрөөнд нь төгөлдөр хуур, нүсэр том бүрхэвчтэй дэнлүү, бичгийн шрээ, хэдэн хөнгөн эргэлддэг сандал, номын тавиур, янз бүрийн нарийн ширийн зүйл бүхий нарийн эдлэлийн гоёмсог хайрцаг зэрэг юмс байна. Хананд нь зураг хөрөг диван дээр нь өдөн дэр, шалан дээр нь хүрэн өнгийн ямаан хилэнгээр хулдсан хөлийн исарууд байна. Тиймэрхүү байр ердийн үнэлэлтээр бол долоо хоногт нэг зуун долларын хөлс хүрдэг ажээ.

- Хичнээн гоё вэ гэж Лола өрөөн дотуур явж байхдаа хэлэв.

Керри торон хөшгийг нь нээж олон хүн бужигналдах Бродвейн гудамжийг харж байхдаа:

- Их тохилог аятайхан байр юмаа гэв.

Халуун усных нь өрөө гэрэл гэгээ ихтэй, уудам зайтай, ханыг нь цагаан шаазан хавтангаар өнгөлсөн байна. онгоцы нь гантиг чулуугаар хийсэн, хөх хүрээвч гаргасан, хоолой цоргууды нь дицэджээ. Хананы нь нэг талд дугариг толь шигтгэн суулгаж, гурван газарт бадамлах зул адил чийдэнгүүдийг цогцлон байгуулжээ.

- Санаанд тань таалагдаж байна уу? гэж ноён Визер асуухад Керри:

- Яриангүй таалагдж байна.

- За тэгвэл та дуртай цагтаа ирж ороорой, бэлэн байгаа юм шүү. Түлхүүрий нь манай үйлчлэгч нарын нэг өгөх болно.

Гудамж нь үргэлж хивс дэвссэн, хөрийн өрөөг гантиг чулуугаар чимсэн, хүлээлэгний өрөө мөн гойд сайхан тохижуулсан байхыг Керри ажиглаж чухам иймэрхүү газрыг урьд мөрөөддөг байснаа санах.

Керри, Арван долдугаар гудамжин дах жижигхэн өрөөний тухай бодохын хамт Лолад:

- Хоёулаа өнөөдөр нүүгээд орвол яасан юм? гэхэд цаадах нь:

- Тэгье тэгье гэв.

Маргааш нь түүний хайрцаг савыг шинэ байранд зөөн оруулжээ.

Пүрэв гаригийн өглөө өглөөний тоглолт дуусаад хувцсаа сольж байтал үүдий нь тогшиж хүн уулзья гэсэн нэрийнхээ хуудсыг ирүүлснийг Керри үзээд туйлын их гайхан зовох шиг болж:

- Намайш одоохон гарч очлоо гэж хэл дээ гэж эелдгээр хэлчихээд нэрийн хуудсы нь дахин уншиж “вэнс хатагтай” гэж хэлэв.

Одоо нэгэнт хүнгүй байсан тайзан дээгүүр Керрийг гарч ирэхэд Вэнс:

- Хүүе, олдохоо байсан оргодол минь, чи чинь ийм хүн байсан юм бий гэж дуу алдан угтав.

Керри баясан инээж байлаа. Найзынхаа өчүүхэн ч зовсон шинжгүй байгааг нь ажвал гагцхүү санамсаргүй тохиолдлын улмаас л тэр хоёр ийнхүү удаан хугацаагаар уулзаж чадалгүй явснаас биш уг нь үнэхээр үй зайгүй найз нар юм даа гэж хэн ё бодмоор ажээ.

- Өөрөө ч мэдхээ болиод байна шүү гэж Керри эхлээд зовж байсан хэрнээ тэр хэзээний сайхан зантай гоолиг найз хүүхнээ үзээд дахин түүнд халуун сэтгэл төрж эхлэв.

- Ням гаригийн сонинд зургий чинь үзээд таньсан юм гэтэл нэр чинь өөр болохоор бүр гайхчихлаа. Тэгээд чамайг мөн байна, биш ч гэлээ өөр адилхан хүн байдаг байж, очиж заавал үздэг хэрэг гэж бодоод ирлээ. Амьдралдаа ийм гайхмаар юм үзээгүй, тэгээд ч чи дажгүй шив дээ гэж Ванс авгайн ярихад Керри:

- Дажгүй, чи өөрөө сайн биз дээ? гэв.

- Үгүй мөн сайхан хэрэг шүү, ийм их амжилт олж, сонин болгонд магтуулна гэдэг чинь юу гэсэн

үг вэ. Чамайг чинь ихэмсэг болчихоо бол уу ч гэж бодлоо, наашаа ирэхдээ бас жаахан айж л байлаа шүү гэхэд Керри, нүүр нь бага зэрэг улайж:

- Хаанаас даа, дэмий юм ярих гэж, би чамтай уулзахдаа хичнээн дуртай байдаг билээ гэв.

- Ямар ч гэсэн би олоод л уулзлаа. Одоо хоёулаа яваад хоолонд орвол өөрт чинь зав байна уу? Мартсан хаана сууж байгаа вэ?

- “Виллингтон” зочид буудалд байгаа гэж Керри хэлэхдээ өөрийн эрхгүй омог бардам ая өнгөтэй хэлчихэв. Энэ нэрийг сонсоод ихэд сэтгэгдэл төрсөн Вэнс хатагтай:

- Өө, тийм үү? Гэж бараг л хашгирлаа.

Керритэй уулзаад Хертсүдийн тухай асуумаар санагдавч эвгүй юм болж мэднэ, ер нь хаяж таарсан байх, аргагүй шүү дээ гэж Вэнс хатагтай бодов.

- Баярлалаа, гэхдээ өнөөдөр амжихгүй, ажил гэж жигтэйхэн их, орой долоо хагаст театр дээрээ ирэх ёстой. Харин өөрөө манайд оройн хоол идэх юм биш үү? Гэхэд Вэнс авгай Керрийг шунаг нүдээр ажиглан харж:

- Уг нь тэгмээр байна, гэхдээ би зургаан цаг гэхэд гэртээ заавал байна гэчихсэн хүн гэлээ. Тэгээд энгэр дээрээ зүүсэн жижигхэн алтан цагийг харснаа:

- Би одоо явалгүй горьгүй, манайхаар очихоор бол хэзээ очихоо надад хэлээрэй гэв.

- Хэдийд ч яахав дээ:

- Тэгвэл маргааш очих уу? Одоо манайх “Челси” буудалд байгаа шүү дээ.

- Бас нүүчихсэн юмуу? Гэж Керри чангаар асуугаад инээв.

- Тэгсэн. Би нэг газар зургаан сараас удааж байж чаддаггүй юм. Тэгээд нүүгээд байдаг юм. Таван цаг хагаст очоорой, битгий мартаарай.

- Би мартаггүй гэж Керри хэлээд тэр хатагтайн гарч явахад хойноос нь ажиглан зогсож байхад одоо энэ хүүхэнтэй нэг зиндаадн болсон юмуу, дээгүүр ч гарсан юмуу даа гэсэн бодол төрөв. Түүний халамжлан тэтгэх гэсэн ч юм шиг байдлыг ажихад чухам хэн нь чингэвэл зохистой юм дээ гэж Керрид бодогдсон ажээ.

Одоо өдөр болгон “Казино” театрын хаалгачин Керрид хэд хэдэн захидал гардуулах болов. Түрүүчийн нэг дэх өдрөөс л хойш ийм болжээ. Тэр захидлууд ямар утга агуулгатай байдгийг Керри андахгүй байв. Голцуу хайр сэтгэлийн нялуун үгтэй байна. Урьд Колумб хотдоо байхад анх удаа тиймэрхүү нэг захидал авснаа санах. Тэрнээс хойш найрал бүжигч болсоноос хойш эрчүүл хамт зугаалж наргия гэсэн захидал ирүүлэх болсон ажээ. Тийм захидлуудыг Лолатой хоёул уншиж хөхрөлддөг байсан, Лалад ч бас зарим нь бичдэг байж.

Одоо захидал бичигчид туйлын олон болсон тул баглаа баглаа захидал унших дээр хүрч байв. Баячуул хайр сэтгэлтэйгээ илэрхийлэн баахан юм бичсэнийхээ сүүлд хичнээн юутайгаа хүртэл дурддаг байж, жишээ болгон нэг захидлын хэсгийг сийрүүлбэл:

“Би өөрийнхөө мэдэлд нэг сая доллартай хүн, инэгхлээр таны хүсэл мөрөөдлийн тань дагуу тосонд умбуулж, торгонд өнхрүүлж чадах байна. Юу л дуртайгий чинь авч өгөх чадал чинээ байгаа юм. Би ингэж хэлэхдээ мөнгөөрөө гайхуулах гэсэн биш, харин танд хайр сэтгэлтэй болохоор хүсэл мөрөөдөл бүхний тань биелүүлэх хүсэлтэйгээ хэлж байгаа маань энэ юм шүү. хайр сэтгэлдээ дийлдээд л танд бичиж байгаа маань энэ. Би бодол сэтгэлээ өөрт чинь хэлийг ихэд хүсэх тул надад хагасхан цаг хайрлаж уулзахыг туйлаас хүсье”.

Керри иймэрхүү захидлуудыг Арван долдугаар гудамжны байранд байхдаа хөөрч баярласандаа биш боловч нэлээд сонирхон уншдаг байсан бол одоо энэ хээнцэр зочид буудлын газар суух болсноос хойш тэдгээрийг төдий л сонирхохгүй болжээ. Гэсэн ч хөөргөн зантай хүн болохоор өөрийнхөө сайн чанарыг шууд илчлэх хэлбэрийг хөөргөн зан гэдэг тийм захидал ирэхэд бас л залхаж дургүйлэхгүй байв. Хүмүүсийн бөхөлзөн долигнож хэлэх үгээ олж ядан зулгуудах нь тун ч аятайхан санагдах ажээ. Гэсэн ч Керри өөрийн урьд одоогийн байдлаа сайн ялган ухаарч байсан юм. Урьд нь нэр ч үгүй, мөнгө ч үгүй явсан билээ. Одоо хоёулантай нь боллоо. Урьд хүнээр хүндлүүлж, хүн хайр сэтгэлээ түүнд илэрхийлж байсангүй бол одоо аль алины нь хүртэх болов. Яагаад ингэдэг билээ? Эрчүүл гэнэтхэн өөрийг нь гоо үзэсгэлэнтэйгий нь гайхан магтах болсныг бодохоос Керрийн хөх инээд хүрдэг болов. Энэ бүхний улмаас Керри тоомжиргүй, улам хашир болж байлаа.

- Лола, чи нааш ир дээ, энэ этгээдийн бичсэнийг үзээч гээд залхсан байдалтай дуугаар:

“Надад хагасхан цаг хайрлахгүй юу” гэнэ, Үгүй, энэ эрчүүл яасан тэнэг улс вэ” гэхэд Лола Осборн:

- Бичсэнээс нь үзэхэд мөнгө ихтэй хүн юм даагэв.

- Бүгдээрээ л ингэж бичих юм гэж Керри зүгээр хэлэв.

- Уулзахад яадаг юм? Юу ярихы нь сонсохгүй юу гэв.

- Тэр ч гонж доо. Юу хэлхий нь би сайн мэдэж байна. Тийм улстай би хэзээ ч уулзахгүй гэхэд Лола түүнийг нүдээ том болгон гайхаж харснаа:

- Чамайг яавал гэчнэ, уулзахад зугаатай биш үү? Гэхэд Керри толгой сэгсрэн:

- Чи бас тэгж байгаад их адайр зантай юмаа гэж цэнхэр хувцас өмсөж жагсаалтын цэрэг болж тоглодог тэр жаахан охин хэлэв.

Тийнхүү аз жаргалынх нь тэнгэр нааш харжээ. Хэдийгээр их цалингаа аваагүй боловч хүмүүс түүнийг нэгэнт ойлгож итгэсэн мэт тэр долоо хоног нижгэр өнгөрөв. Огт мөнгөгүйгээр буюу зохих мөнгий нь төлөхгүй байлаа ч гэсэн мөнгөтэй баячуулын мөнгөөр зодож олдог хээнцэр ганган баян тарган амьдралыг Керри амсаж байлаа. Харийг дээгүүр ордог орд харш боловч үүд хаалгаа цэлийтэл нээгээд морилон орооч хэмээн гүйх болсон шиг байв. “Велингтон” зочид буудлын энэ гайхам сайхан өрөөнүүд аяндаа өөрийнх нь орон болов. “Челси” зочид буудлын Вэнс хатагтайн эзэмшиж буй хээнцэр сайхан өрөөнүүд бас түүнийг урьж байна. Баячуул цэцэг барьж, хайр сэтгэлийн захидал бичиж, хэмгүй их хөрөнгө мөнгө амлах болов. Гэсэн ч хүсэл мөрөөдөл нь зах хязгааргүй ажээ. Зуун тавин доллар. Зуун тавин доллар! Гэдэг чинь юу гэсэн үг вэ. Алладины агуу эрдэнэсийн ордны хаалга нээж өгөх мэт л санагдана. Болж буй явдлын улмаас

түүний толгой тархи бараг л эргэмээр болж, хэмгүй их мөнгөтэй байх цагт амьдрал маань ямаршуу сайхан байх бол гэж мөрөөдөн бодох нь улам улам ихсэж байв. Урьд хожид энэ дэлхийн хуурай болон далай тэнгисийн али алинд байгаагүй их жаргал эдлэх юм мөрөөдөж байлаа. Тэгж байтал ч хүслэн болсон их цалин долоо хоногийнх нь зуун тавин доллар нь буулаа.

Цалингийнхаа ногоон дэвсгэртүүдийг тоолбол: хорьтын дэвсгэр гурав, аравт зургаа, тавт зургааг өгчээ. Тийм дэвсгэртүүдийг авч явахад ч зай эзлэхгүй амар ажээ. Мөнгий нь тавьж олгосон нярав инээмсэглэн гардуулж баяр хүргэн:

- За, Маденда хатагтай мөнгөө аваарай, зуун тавин доллар байгаа. Тоглосон жүжиг тань их амжилт олсон юм байна даа гэхэд Керри:

- Тийм шүү, үнэхээр тэгсэн гэв.

Керрийн дараа тэдний бүлгийн нэг барагтайхан жүжигчин хүүхэн цалин авахаар очиход нярав:

- Хэдийг авах юм? гэж нэлээд ширүүн асуух нь дуулдав.

Керри тун эртэдхэн өөрөө хэдхэн доллараа авах гэж хүлээн зогсож байсан билээ. Бас гутлын үйлдвэрт ажиллаад дөрвөн доллар хагасыг авахад мастер нь тэр дугтуйд хийсэн хэдэн долларыг гардуулахдаа эгээ л хунтайж хөөрхий гуйлгачинд юм хайрлаж бахйгаа юм шиг байсныг нэхэн саналаа. Одоо ч гэсэн Чикакогийн тэр гутлын үйлдвэрт хувцас муутай өдий төдий олон хүүхэн эгнэн суугаад оёдлын машины дуунд нуруугаа чилтэл хамаг биеэ ядартал ажиллаж, гэдэс өлсөн хагас цагийн завсарлагаа хүлээн авчирсан юм идэж уухыг хүлээн байгаадаа, Яг хагас сайнп тэр хүүхнүүд одоо Керрийн авч байгаагаас хавьгүй өчүүхэн мөнгийг биеэ хэдэн зуу дахин зовоож байж авч байгаа даа. Одоо надад ямар амар болж вэ, хорвоо үнэхээр сайхан жаргалтай санагдана. Сэтгэл нь ихэд баясан тааламжтай байсан болохоор одоо зочид буудал руугаа явгаар явж очоод энэ бүх сайхан зүйлийнхээ тухай хүсэн мөрөөдөж бодмоор санагджээ.

Сэтгэлийнхээ аяг дагах дээр хүрэх юм бол мөнгө өөрийнхөө яалт ч үгүйг төдхөн илрүүлдэг ажээ. Керри зуун тавин доллараа гартаа оруулж авсны дараа түүгэрээ чухам юу хийхээ сайн мэдэхгүй байв. Гарт баригдаж, нүдэнд үзэгдэх биетэй бодитой юмны хувьд тэр мөнгөө хэдэн өдөр хэвээр нь хадгалан баясаж байсан боловч сүүлдээ больсон ажээ. Гэвч зочид буудлынх нь хангамж мөнгө үрэх шаардлагагүй. Авсан хувцас хунар нь нэг хэсэгтээ сэлбэг шаардахааргүй байсан билээ. Тэгээд ганц хоёр өдрийн дараа бас дахиад зуун тавин доллар авна. Тэгэхлээр одоогийнхоо байдалтай байгаад байя гэхэд нэг их хэрэглэгдэхээргүй мэт санагдаж эхэлжээ. Хэрэв үүнээсээ илүү болж ахиж дээшилье гэвэл илүү ихийг хавьгүй ихийг авах хэрэгтэй болох билээ.

Нэг өдөр театрын урлагийн шүүмжлэгч ирж ярилцлага хийжээ. Тэр бол мвыг сүрхий оновчтой хэлж чаддаг, шүүмжлэгчдийн мэргэн, нэр цуутангуудын маанагийг харуулах талаараа чадамгай, өөрөөр хэлбэл уншингч олны зугааг гаргаж чаддаг хүний нэг байв. Керри түүнд хэдийгээр таалагдаж энэ тухайгаа сонинд нуухгүй бичээд харахад царайлаг, хөөрхөн ааштай жүжигчин, харин аз л дайрсан хүн юм гэж бичжээ. Энэ үг Керрийн зүрх рүү хутга шаах мэт болсон ажээ. “Херальд” сонины газраас хоосон үгээгүүчүүдийн хөдөлшгүй цондонд зориулан мөнгө олохоор Керрийг бусад алдар цуутангийн хамт тоглож өгөхийг урьсан байна. Бас нэг залуухан жүжгийн зохиолч өөрийн бичсэн жүжигт Керрийг тоглуулах юмсан гэж ирэхэд нь чухам юу гэх учраа ч олсонгүй. Энэ ч гэсэн бас л зүрхий нь шимшрүүлсэн юм болжээ. Тэгээд мөнгөө банкинд

хадгалах нь зүйтэй юм гэж боджээ. Хамаг юм цаашдаа дандаа шулуухан явах юм бол уу гэж бодож байсан нь тийм биш болох нь мэдэгджээ.

Зун цаг учраас л иймэрхүү байдалтай болчихов уу даа гэж Керри сүүлдээ бодов. Хотод сонирхол татмаар онцын юмгүй байв. Жүжгүүд гэхэд л өөрийнх нь тоглодгоос өөрцгүй бүгд адилхан шиг санагдана. Тавдугаар өргөн чөлөөний баячуул гадагш явахад орд харш нь эл хуль болсон байв. Мэдисоны өргө чөлөө ч эл хуль болов. Дараачийн улиралд ажилд орох гэсэн жүжигчид Бродвейгээр нэг хөлхөлдөх болжээ. Хот бүхэлдээ хөл татарсан байхад Керрийн орой үдшийн ажил гэж барагдахгүй их байв. Яршигтай ч санагдах болжээ.

- Яагаад ч юм надад их л уйтгартай санагдаад байх боллоо, чамд бас тэгж байна уу? гэж Керри Бродвей руу харсан нэг цонхныхоо дэргэд сууж байхдаа Лолагаас асуухад:

- Үгүй, бараг л үгүй дээ. Чи өөрөө хаашаа ч гарахгүй болоод л тэр шүү дээ гэж Лола хариулав.

- Би хаагуур явах юм.?

- Өө, зөндөө газар байлгүй яах билээ. Чи л өөрөө хэнтэй ч хаашаа ч гарахгүй байгаа болохоос биш гэж Лола өөрийнхөө хамт явж наргиж зугаалж байдаг хэдэн залуугаа бодож хэлэв. Надад захидал бичиж байгаа хүмүүстэй би хамт явах хүсэл алга, би тэдний ямар улс болохыг андахгүй мэднэ.

Лола, Керрийн өөдрөг явааг бодоод:

- Чи уятгарлах ёсгүй. Чиний зиндаанд хүрэхийн туд юугаа ч хайрлахгүй зүтгэх хүн мянга түм бий шүү гэхэд Керри дахин цонхоороо гудамжраар явах олон хүнийг харж:

- Бүү мэддээ гэв.

Хийх юмгүй шахам байсаар Керри залхаж эхлэх нь тэр билээ.

ЯДУУ ХҮНИЙ ГАЙХМААР ХУВИРАЛ

Херствүд, байрныхаа модон хэрэгсэл зэргийг худалдаж далан доллартай болж зочид буудлын хямдхан өрөөнд орж суугаад халуун зун өнгөрч намрын сэрүүн орохыг мэдрэн сонингоо уншсаар уруу царайлан сууж байлаа. Мөнгө нь төдхөн барагдаж дуусах шахаж байгааг бодохоос санаа зовж өдөрт тавь тавин центээр төлөхийн оронд гучин тавин цент төлөх бүр хямдхан өрөө олж мөнгөнийхөө насыг ялимгүй ч гэсэн уртасгахыг оролджээ. Херствүд, Керрийн тухай олонтоо сонсож байв. “Уорлд” сонинд зургий нь хоёр ч удаа олж үзсэн, бас “Херальд” сонины нэг хуучин дугаарт хэдэн жүжигчний хамт тэтгэмжийн фондод зориулсан тоглолт хийсэн тухай ч олж уншжээ. Энэ бүгдээс түүнд янз янзын л юм бодогдож байлаа. Ер нь юм бүхнээс ажиглаад байхад Керри түүнээс улам улам холдсоор бараагүй болж Херствүдийн хүсэн мөрөөддөг байсан тэр ертөнцөд шингээд алга болох төлөвтэй. Театрын зарлалд ноёны нэг хатан болж тоглож байгаа борогхон шиг хувцастай эгэл даруу зургий нь олон удаа олж харахдаа заримдаа хөөрхөн царайг нь ажиглан зогсох цаг цөөнгүй байв. хувцас хунар нь тамтаггүй хуучирч муудаад ер нь өөрийнх нь дүрс байдал Керрийнхээс өдөр шөнө шиг ялгаатай болсон байлгүй гэж бодож байв.

Керрийг “Казино” театрт ажиллаж байхад Херствүд түүнтэй уулзъя гэж үнэндээ хэзээ ч оролдоогүй хэрнээ ямар ч болтугай түших хүнтэй юм шиг бодох ажээ. Цаг хугацаа нэлээд улиран өнгөрөхөд Керри мөн тэндээ л байгаад байгаа болохоор дандаа л тэндээ байх юм бодов. Гэтэл есдүгээр сард тэднийхэн гадагш тоглолтоор явсны нь Херствүд мэдсэнгүй. Хорьхон доллартай болоод ирмэгц Херствүд нийтийн ширээ, сандал, исар бүхий нийтийн том өрөөнд орж арван таван центийн хөлс төлөх болжээ. Энд Херствүд хэдэн цагийн турш бодол болон нүдээ анин суухдаа урьд ямар шүү их юм мөрөөдөж явснаа нэхэн санаж байлаа. Энэ нь яваа яваандаа зан болж хувирсан байх юм. Энэ нь эхлээд зүүд биш, харин Чикагогийн тарга цатгалан амьдралыг нэхэн санаж байна гэж бодох бөгөөд доогийнх нь байдал хичнээн золгүй муу санагдах тусам тэр үеийнх нь явдал улам сайхан том тод харагдах бөлгөө.

Хэдийнээс тийм болсноо яг тодорхой мэдэхгүй байлаа ч гэсэн нэг өдөр тийнхүү сууж байгаа хуучин танил найзтайгаа уулзаж ярилцаж байсан үгээ гэнэт дуулдахаар хэлжээ. Фицжеральд энд Мон гэдэг зоогийнхоо газар байна, тэгээд Өмнөд Чикагогийн нэг газрыг худалдаж авах санаатай мөнгө оруулж байсан болохоор үнэ цэнийх нь тухай ноён Сагар Моррисонтой ярилцан жижигхэн тохилог албан тасалгаандаа ганган дэгжин хувцастайгаа байна гэж сэрүүн мөртлөө зүүдэлсэн байж.

Би таныг кампанидаа оруулъя гэвэл та юу гэж үзэх вэ? гэж Моррисоны хэлэх дуулдах шиг болжээ. Тэгэхэд нь Херствүд дуулдахуйцаар:

- Үгүй, чадахгүй юм байна. Би бүх мөнгөө өөр юманд оруулж байгаа гэж яг хэдэн жилийн өмнө хэлж байснаа давтан хэлээд, хөдөлгөөндөө сэрэв.

Үнэхээр ганцаараа ярив уу гэж гайхаж байна. Сүүлд бас тэгж ганцаараа дүнгэнэтэл ярьснаа мэдэв.

- Чи яагаад үсэрдэггүй юм? Тэнэг минь? Үсрээч гэж хэлээд сэржээ.

Энэ нь мань эр, урьд жүжигч нартай уулзахдаа ярьдаг байсан инээдтэй шог яриа байж. Ганцаараа ярьж өөрийнхөө дуунд сэрэхдээ Херствүд инээмсэглэсэн хэвээр байв. Хажууд нь сууж байсан нэг өвгөн нэлээд дургүйцсэн маягтай хавчигнан хялайн харж байв. Херствүд инээхээ

болив. Хөгтэй ярины утга санаа толгойд нь агшин зуур бодогдоход ичих шиг болж бушуухан шиг босож гадаа гарлаа.

Нэг өдөр “Ивнин Уорлд” сонины зарлалын буланг харж байтал “Казино” театрт шинэ жүжиг тоглоно гэсэн байхыг олж үзээд ихэд сэрдхийв. Яагаад гэвэл Керрийг байхгүй байгаа юм байна гэж боджээ. Өчигдөрхөн л Керрийн тоглодог жүжиг гарах тухай зарлал байхыг харсан санагдав, гэтэл тэр нь хуучин зарлал байсан ажээ. Керрийг энэ хотоос явсан юм байх гэж бодохоос сандарсан нь учиртай. Ямар ч атугай Керри эндээ байвал түшиг болох юм шиг боддог байж. Гэтэл яваад өгсөн болохоор тэвдэж, хэдийд эргэж ирэх юм бол гэж таахыг оролдоно. Айдас нь хүрэх шиг болжбосож харанхуй шахам өрөөнд ороод үлдсэн хэдэн доллараа сэмхэн тоолж үзвэл аравхан доллар байв.

Нийтийн, хоног өнгөрүүлдэг байранд хамт байдаг бусад хүмүүс яаж аргалдгийг Херствүд сонирхов. Хийж байгаа ажилгүй л улс шиг. Гуйлга гуйдаг байж магадгүй, гарцаагүй тэгдэг байх. иймэрхүү улст аравтын зоос мөн олныг өч явсан цагаа бодлоо. Гудамжинд гуйлга хийж яваа хүн олныг үзсэн. Өөрөө гуйлга хийвэл мөнгө олох юм биш байгаа гэж бодлоо. Гэвч ингэж бодохоос ухаан алдтлаа аймаар санагдав.

Нийтийн хоног өнгөрүүлэх байранд тийнхүү байсаар тавьхан центтэй үлджээ. Идэж уухаа хасаж биеэ муудтал хэдэн доллараа арилгасаар одоо нэгэнт барж дуусчээ. Өөрөө эцэж турсныг хэлэх үү, хувцас нь ч тамтаггүй болжээ. Тэгээд ямар нэг юм олж хийх санаатай явсаар хэдэн өдөр өнгөрөхөд хорьхон мөнгөтэй үлдсэн нь ганц өглөөний хоолонд ч хүрэхгүй болох нь тэр.

Хамаг зоригоо гарган Бродвейгээр явж Бродвейн төв зочид буудалд хүрч жаал явж байгаад зориг мохон хэсэг зогсов. Хажуугийн нэг хаалган дээр нь сүрхий ширүүн харцтай бүдүүн хаалгач эр гадагш харан зогсож байв. Херствүд түүнээс асууя гэж шийдээд цаашаа эргэж явахаас нь өмнө дэргэд нь очоод:

- За найз минь танай зочид буудалд чинь надад хийчмээр ажил байхгүй биз? гэж асуухдаа хүртэл тэр хүнийг өөрөөсөө доогуур хүн гэж бодсон ажээ. Хаалгач түүнийг гайхан дув дуугай харсаар байхад Херствүд:

- Би ажил ч үгүй, мөнгө ч үгүй болсон хүн. Ямар ч болсон нэг ажил хийх хэрэгтэй байна. Би урьд юу хийж байсан, ямар хүн байсан гэдгээ яриад яах вэ. Ямар аргаар нэг юм олж хийх билээ, та надад хэлж өгвөл би их баярлах байна. Түр хэдхэн хоног болтугай ч хийчих юм баайхад болох байна гэхэд нөгөө хүн тоохгүй байгаа байдал харуулах санаатай дуугай харж гөлөрсөөр байсан боловч Хертсвүдийг дахин ярих бололтойг ажаад

- Надад мэдэх юм огт алга. Дотор орж л асуух хэрэгтэй гэв.

Херствүд ийм хариу сонсоод урам нь орсон нь гайхмаар бөгөөд

- Би таныг надад хэлж чадна гэж найдсан юм гэжээ.

Гэтэл шинэ найз нь ууртайгаар толгой сэгсэрч байв.

Шөнийн зоогийн газрын эрхлэгч байсан хүн маань шууд дотогш орж очвол зочид буудлын хариуцлагатны нэг нь тэнд санасамргүй тааралджээ. Хесртвүд түүний нүд рүү шууд ширтэн:

- Та надад хэд хоног хийх ямар нэг ажил өгөхгүй юу? Би заавал одоо л ажил хийх шаардлагатай байгаа хүн гэхэд туранхайвтар тэр эрхлэгч:

- Үнэхээр тийм байна, харах царайнаас чинь андашгүй байна гэж хэлэх гэж буй байдалтай харав.

- Би өөрөө урьд шөнийн зоогийн газрын эрхлэгч явсан хүн болохоор энд хүрч ирлээ. Би баларч яваа хүн, гэхдээ одоо тэр тухайгаа яриад яах вэ. Надад хийх ажил л хэрэгтэй байна, ганц долоо хоног ч байтугай ажил л хийх юмсан гэхэд нөгөө хүн Херствүдийн нүд галзуу хүнийх шиг хачин гялалзахыг ажив.

- Ямар зочид буудлын эрхлэгч байсан юм? гэхэд Херствүд:

- Зочид буудал биш, би Чикагогийн Фицжеральд, Моин шөнийн зоогийн газрын эрхлэгчээр арван таван жил болсон хүн гэхэд зочид буудлын хүн:

- Тийм бий, Яагаад тэндээсээ гарчихсан юм?

Тийм хүн явсан гэхэд Херствүдийн байдлыг харахад үнэмшмээргүй байсан ажээ.

- Өөрийнхөө л тэнэгээс болсон юм даа. Одоо тэр тухай яриад яахав. Та сонирхож байгаа бол тодорхой ярьж өгч бололгүй яахав. Одоо би сохор зоос ч үгүй болчихоод өглөөнөөс хойш хэлэн дээр юм тавиагүй яваа хүн.

Зочид буудлын хүн Херствүдийн адал явдлыг сонирхож байгаа бололтой. Иймэрхүү хүнээр юу хийлгэх гэж хичээх билээ, гэвч Херствүд улайм цайм шалаад байхлаар нь нэг юм аргалахыг болов. Тэгээд нэг хүнд:

- Олсеныг дуудаад ир гэв.

Хонх дуугаргаад зарлалыг явуулахад доод ажилчдын ахлагч Олсен гэгч нь хүрч ирлээ.

- Олсен, гуанзны чинь хавиар энэ хүнээр хийлгэчихмээр ажил байна уу? Энэ хүнд ажил өгч тусалмаар байна гэж эрхлэгчийг хэлэхэд Олсен.

- Ноёнтон минь, ямар юм хийлгэдэг билээ мэдэхгүй л байна даа. Гэвч та хэлж байгаа болохоор нэг юм бодъё доо гэв.

- Тэг. Гал тогоонд аваачаал энэ хүнд идэх юм аг гэж Вилсонд хэл.

- За ноёнтон минь гээд Херствүдийг дагуулан явлаа. Эрхлэгчийн нүднээс холдохтой хамт доод ажилчдын ахлагчийн зан дороо хувирч:

- Ямар элэнцгийгээ хийлгэдэг билээ гэхэд Херствүд таг дуугай болов. Энэ мэтийн барлагийг Херствүд дотроо зэвүүрхэн үл тоомсорлож байлаа.

- Та энэ хүнд идэх юм өгөөрэй гэхэд тогооё ихээхэн гайхаж Херствүдийг толгойноос нь хөлий нь хүртэл ажиглаж түүний нүдний харцанд гярхай, цагтаа цалгиж явсны шинжийг тааварлаад:

- За тэнд суу даа гэв.

Ийм маягаар Херствүд Бродвейн Төв зочид буудалд орсон боловч тэнд удаагүй юм. Аливаа зочид буудалд байдаг хар бор ажил хийхэд Херствүд бие бялдрын талаар ч, санаа сэтгэлийн талаар ч тэнцэхгүй байлаа. Өөр олигтой ажил байхгүй болохоор түүнийг галчийн туслагчаар ажиллуулж, бас зооринд юухан хээхэн хийлгэж байв. Ер нь түүгээр элдэв бусын юм хийлгэж түүнийг зарахгүй хүн ч гэж байхгүй, болж галч тогооч, хаалгачин манаач, харуулынхан бүгд л түүнд дээрэлхэнэ. Ядахнаа Херствүд жожгирон дуу шуу муутай байх болохоор цаадуул нь дургүйцэнэ.

Гэвч Херствүд тэр бүхий л доромжлолыг тэвчин хүлцэж байшингийн дээврийн хонгилд шөнийн хоног өнгөрөөн юу өгснийг нь идэж уучихаад долоо хоногт өгч байсан хэдэн доллары нь үрэлгүй хадгалах санаатай цуглуулдаг байлаа. Тэгсээр эцэж туран нүднээс гарав.

Хоёрдугаар сарын нэг өдөр түүнийг нүүрсний кампанийн кондор руу зарж явуулжээ. Цас орж, бас орсон цас нь хайлж нойтогносон жигтэйхэн муухай өдөр байв. шавар дундуур туучуулсаар гутал нь нэвт норж, нойтон голтой юм арайхийн явж иржээ. Маргааш нь хамаг бие нь эвгүй оргин хөдөлж чадахгүйд хүрч дэндэсхийвэл суугаад байсан тул үргэжл гялалзаж байхыг эрхэмлэдэг цаадуулын нь дургүй их хүрчээ. Үдээс хойш авчирсан хүнсний зүйлд зайчлахын тулд хэдэн хайрцагтай юм зайлуулж өөр газар хураах байв. Херствүдийг нэг авдартай юм аваад яв гэхэд нь тэр том хайрцагтай юмыг нь даасангүй.

- Яагаад байнаа? Чадахгүй нь үү? Гэж ажилчны ахлагч асуув.

Херствүд өргөн санаатай байдгаараа оролдсон боловч хүч хүрсэнгүй.

- Чадахгүй нь ээ гэж Херствүд арайхийн хэлэв. Царай нь харваас хөдөс шиг цонхийжээ.

- Өвдөө юу?

- Тэгсэн шиг байна.

- Тэгвэл сууж бай даа.

Херствүд суусан боловч төдхөн бие нь бүр муудаж дээврийнхээ муу орон дээр арай чарай хүрч очоод өдөржин хэвтжээ.

- Нөгөө Вилер гэдэг хүн өвдсөн байна гэж нэг гоцго жижүүртээ хэлэхэд цаадах нь:

- Яасан юм бол? гэв.

- Бүү мэд. Их л халуунтай байна билээ.

Зочид буудлын эмч түүнийг үзээд:

- Эмнэлэгт хэвтүүлсэн дээ байх, уушгины хатгаа авсан байна гэв.

Тэгээд ядуучуудын эмнэлэгт аваачиж хэвтүүлжээ.

Гурван долоо хоногийн дараа нэг муу сэхэхчээн болсон боловч тэнхээ тамир огт үгүй байсан тул гарч чадалгүй байсаар тавдугаар сарын нэгний алдад нэг юм гарчээ.

Урьдын сэргэлэн цовоо явсан шөнийн зоогийн газрын эрхлэгчийн сүр сүлд нэгмөсөн үхэж хаврын нарны илч бараадан байгаа нь хүний л сүг харагдана. Нүүрнийх нь мах шуугдаж цонхийсон хувхай дааж, гар нь мөн ужирч, бие нь хувцасныхаа тамтгийг ч даамгүй харагдана. Жигнэж үзлээ гэхэд одоо хувцастай юутай хүйтэйгээ дөчин таван килоос илүү татахгүй билээ. Зочид буудлын газраас түүнд хямдхан хүрэн өнгийн пальто, нэг муу томдсон өмд зэрэг хувцасны сэлбэг, хэдэн задгай мөнгө, захиас хэдэн үг хэлээд тэтгэврийн газар очсон дээр биз гэжээ.

Херствүд дахиад л нөгөө Бауери дахь нийтийн хоногийн газар очиж одоо яаж цааш амь зуух тухай бодлоо. Гуйлгачин болоход ганц л алхам үлдээд байлаа. Тэгэхлээр:

- Одоо яадаг билээ? Өлбөрч үхэх хэрэг үү? Гэж бодов.

Нар дуниартсан Хоёрдугаар өргөн чөлөөнд Херствүд анх удаа гуйлга хийхээр гарахад өмнөөс нь сайхан хувцастай нэг эрхэм Стувесаньт цэцэглэгээс гараад яарамгүй алхан айсуйг хараад тэр хүнээс гуйгаад үзье хэмээн зоригоо байдгаараа чангалан дөхөж очоод:

- Та надад арван цент хайрлахгүй юу, би ингэж гуйхаас аргагүй болоод байгаа өхүн юмаа гэж шууд хэлэхэд тэр хүн өөрийн нь ажиглаж ч харалгүйгээр хантаазныхаа халаасыг тэмтрэн аван цент гаргаж:

- Май гэлээ.

- Танд их баярлалаа гэж Херствүд аль болох найрсаар хэлбэн боловч тэр хүн анзаарсангүй.

Тийнхүү анхны гуйлга нь ажилттай болсонд нэг талаар урамшивч нөгөө талаар ийм байдалд хүрсэндээ ичиж, одоо яаж ийж байгаад бас хорин таван цент олчих юм бол болох нь тэр гэж бодов. Тэгээд баахан эргэлдэж хүмүүсийг шинжин явсаар энэ л хүн юм хайрлаж магадгүй гээд бас эвийн нь таарулах гэсээр бхитал их л уджээ. Нэг хүнээс гуйгаадахсан чинь юу ч өгсөнгүйд бантаж сандарсаар цаг хэрийн хугацаа өнгөрсөн хойно сая сэхээ авч оролдлогоо сэргээв. Бас нэг тавтын мөнгө олсны дараа хорин центийг их удаж байж олов.

Дараа өдөр нь баахан гуйлга хийсэн боловч ихэнх юм юм хайрлахгүй гагцхүү ганц хоёр хүн өгчээ. Сүүл сүүлдээ гуйлга хийхэд хүний царай зүсийг судлах хэрэгтэй юм гэж ойлгоод ажиглах болжээ.

Явж байгаа хүнийг юм гуйж зогсоох тун эвгүй ажээ. Херствүдийг харсаар байтал гуйлга хийсэн нэг хүнийг цагдаа баривчилсан тул өөрийгөө баригдахцй хэмээхээс их айх болов. Гэвч ингээд явж байтал юмыг яаж мэдэх вэ аз болж жаахан юм өгөх хүн олдож магад гэж бодоод явж байв.

Нэг өглөө явж байтал нь “Казино” театр буцаж ирлээ, Керри Маденда оролцон тоглох жүжиг тавина гэсэн зарлал байхыг үзээд их баярлажээ. Сүүлийн үед Керрийг ихэд мөрөөддөг байж. Ийм их өөдрөг амжилттай яваа хүн яасан их мөнгөтэй байгаа бол. Ингэж ядарч яваа цагтаа ч гэсэн түүнийг царайдаж юм гуйхаасаа маш их зовох ажээ. Сүүлдээ бүр албарч үхэхийн даваан дээр Херствүд:

- Керригээс гуйгаад үздэг хэрэг, надад хэдэн доллар өгөх байлгүй гэж нэгэнт шийдэв. Тэгээд үдээс хойш Казино театрыг зүглэн явж очоод гаднаас ирэхий эь угтах гэж театрын хажуугаар хойш урагш хэд алхав. Тэгснээ тэртээ нэг байшингийн ойролцоох Брайант гэдэг цэцэглэгт

хүлээн суулаа.

- Надад жаахан ч гэсэн тус болох ёстой доо гэж амандаа байн байн бувтнана.

Зургаа хагас болхоын үед Херствүд гучин есдүгээр гудамж руу харсан театрын орц хавиар сүүдэр шиг эргэлдэхдээ ажилд яаран яваа хүн мэт хэлэн удаа урагш хойш хурлан хурлан алхаж өнгөрөхдөө тэр завсар уулзах гэсэн хүнээ алдуузай хэмээн бас айж байлаа. Чухал цаг ойртлоо гэж бодохдоо зовох боловч ядарч өлсөж яваа болхоор тэр зэргийн юманд юун нэрэлхэхтэй мантай. Тэгтэл ч жүжигчид ирж эхлэхэд Херствүдийн сэтгэл догдолж, жигтэйхэн болж уулзаж чадмааргүй санагдав.

Керрийг ирлээ гэж бодоод урагш ухасхийсэн чинь биш байлаа.

“Одоо ч удахгүй ирнэ дээ” гэж дотроо бодоод шууд уулзахаас зовох шиг болохын гадна өөр газраар дотогш орчуузай гэж бас айж байлаа. Ходоод нь хов хоосдож, хорсож өвдөнө.

Хажуугаар нь сайн сайхан хувцастай, хүмүүс өнгөрөх бөгөөд хэн ч түүнийг үл тооно. Театр, зочид буудал олонтой тэр газар оройн зугаа цэнгээ эдлэх гэжсүүх тэргээр хүрэлцэн ирэх хүмүүс авгайчуулын хамт миегнэнэ.

Гэнэт нэг сүүх тэрэг ирж дэлбэгч нь хаалгы нь онгойлгов. Херствүдийг яаж ч амжаагүй байтал нь тэр тэрэгнээс хоёр хүүхэн гармагц хурдан хурдан алхсаар театрт орчихов. Тэр хоёрын нэг нь Керри мөн гэж Херствүд бодсон боловч даанч санаандгүй байж байтал ирж, бас хэтэрхий ганган сайхь үзэгдэл дэндүү холоос харагдаад өнгөрсөн болохоор лавтай таньсангүй. Херствүд театрынхны ордог хаалга дахин нээгдэхгүй болж, харин үзэгчид хөгжилдөн ирж байгааг жаал харж зогсон өлсөн ядарснаас хамаг бие эь чичрэх шиг болоход түрүүний хардаг маань Керри мөн байж гэж бодоод буцлаа.

“Бурхан минь, би чинь ямар ч болов жаахан юм олж идэлгүй горьгүй гэж Херствүд амандаа бувтнаад тэр жаргалтай олон хүний миеэгнэх гудамжнаас бушуухан зайлан одлоо”

Бродвейн хавьд хүн хамгийн их цугладаг цагаар Хорин зургадугаар гудамж, Бродвей, түүнчлэн Тавдугаар өргөн чөлөөний уулзвар газраар үдэш болгон нэг хачин хүн эргэлдэх болжээ. Тэр үед театр луу хүмүүс тасралтгүй цувж, цахилгаан чийдэн, театрын зарлалууд алхам бүрд мяралзана. Шар шар дэнлүү асаасан хөлсний болон сүүх тэргүүд цувна. Хүмүүс хосоороо буюу хэд бүлгээрээ хөгжилтэй инээлдэн ярилцан тасралтгүй ирж байна. тавдугаар өргөн чөлөөгөөр ганган чинээлэг, бас авгайгаа сугадсан дэгжин эр тэдний дунд харагдах бөгөөд нэг клубээс нөгөөд шилжиж байдаг тийм хүмүүс ч олон үзэгдэнэ. Гудамжны нөгөө талд зугаа цэнгэлд тэсгэлгүй хорхойтой, биеэ би гэж боддог болтой ихэмсэг ганган хүмүүс гэрэл гэгээ нь дур сонирхлыг нь татах хээнцэр гоёмсог зочид буудал, биллиард тоглодог газартай зоогийн газруудаар пиг дүүрэн бужигнана. Зугаа цэнгэлийг түмэн янзаар нь эдэлж, амсах гэсэн хүмүүстэй том хотын шөнийн амьдрал тийнхүү ид дундаа бужигнана.

Тэр нэг хачин хүн гэдэг нь урьд цэрэг байгаад манай нийгмийн дутагдал, шударга бишээс болж ихэд хэлмэгдээд шашныг гүнээ шүтэх болж бурхны өмнө хийх бучнт үйл бол ядуу хүмүүст тус болох ганц зам юм гэсэн дүгнэлтэд хүрсэн байжээ. Тэгээд юугаар тусалдаг байж вэ? гэвэл өөрөө амьжиргаагаар бусдаас дээрэлхэх юмгүй шахам байж шөнийн хоног өнгөрөөх гэсэн хоргодох оронгүй болсон хүмүүст оромж олгож байх гэсэн их л сонин шийдтэй болсон хүн байв.

Сайхь бадриун биетэй, юүдэнтэй цув өмссөн хүн, тэр хаваир бужигнах хөгжөөнтэй олон хүний дунд өөрийнхөө зогсдог гауар ирж зогсоод асрал үзүүлэх хүмүүсээ хүлээн авах бөгөөд цаадуул нь ч түүнийг андахгүй мэдэх жаээ. Эхлээд тэр хавийнхаа олон янзаар хувирч буй байдлыг жишимгүйхэн ажиглан гав ганцаар зогсоно. Бидний тухайлан ярилцаад байгаа тэр ройн түүнтэй тааралдсан цагдаа мэндлэхдээ түүнийг “ахмад” гэж хүндтэй нэрээр дуудав. Тэр хүнийг тэр хавьд дандаа байхыг харсан нэг жаалхүү түүнийг энэ удаа ихэд ажиглав. Хажуугаар нь явж өнгөрөх олон хүний ихэнх нь түүний өмссөн хувцсыг хараад бага зэрэг сонирхохоос биш, хөдөөнөөс орж ирэн нэг юм л хий дэмий сэлгүүцэн исгэрч байгаа юм байлгүй гэж бодоцгооно.

Хагас цаг өнгөрөхийн алдад энд тэднээс хачин сонин хүмүүс тэнд ирж байв. Хөлхөлдөгч олны дотор дэмий сэлгүүцэн тэдэнд ойр дөхөм байхыг хичээх хүн энд тэднгүй үзэгдэх болов. Навс болсон хувцастай нэг хүн гудамж огтлон гарч ирээд цувтай хүнийг гэмгүй царайлан харав. Бас нэг хүн, Тавдугаар өргөн чөлөөгөөр гарч ирээд ийш тийш нэг харснаа цаашаа салтирганаад алга болов. Баурид байдаг бололтой хоёр гурван хүн Медисон талбайн тэндээс Тавдугаар өргөн чөлөөнд гарч ирээд цааш ойртохыг зүрхэлсэнгүй. Гэтэл юүдэнтэй цув өмссөн нөгөө цэргийн хүн маань юу ч олж ажиглаагүй мэт аяархан исгэрэн урагш хойш хөлхсөөр байв.

Оройн есөн цаг болоход том хотын дуу чимээ жаал намдаж эхлэв. Зочид буудлуудын золбоолог өнгө намдаж, оройн жавар чангарч эхлэв. Тал талаас тодорхой зорилгогүй мэт боловч юм юм ажиж харж үүд хаалга татсан арав орчим хачин хүн үзэгдэх болов. гэтэл хүйтэнд даарсан бололтой нэг нь урагш гарч ирэв. Тэр хүн, Хорин зургадугаар гудамжны сүүдэр газар даган Бродвейг өнгөрч байн байн зогсож, тойруу замаар явсаар нөгөө цувтай хүний дэргэд очив. Түүний хөдөлж барьж байгааг нь ажвал нэг бол ичиж байгаа, эсвэл айж яваа маяг ил. Уг нь түүнийг харсан хүн зуур замдаа тэгсгээд зогсоно гэж огт бодмооргүй шуудхан алхаж байжээ. Гэтэл гэнэт цэргийн огцорсон өнөөх хүний дэргэд очмогцоо зогсох нь тэр.

“Ахмад” түүнийг таньснаа мэнд ч үгүй ус ч үгүйгээр мэдэгдэхэд цаад хүн ялимгүй мэхэсхийснээ аман дотроо юм гуйх маягийн юм бувтнав. Нөгөөдх нь явган хүний замын хажуу руу гар гэж заагаад:

- Тэнд хүлээж байгаарай гэв.

Үүгээр юм бүхэн шал өөр болж, цэрэг агсан хүн ойр ойрхон гишгэлэн ёсорхгоор зугаалгаа үргэжлүүлж чадсангүй, бусад хүмүүс ч урагш ухасхийлээ. Тэд, жолоодон явах хүндээ баяр хүргэх сөгөө ч үгүй эхний ирж зогссон хүний зүг бүдчиж хадчин, хөлөө чирэн нусаа байн байн татсан амьтад ирлээ.

- Яасан хүйтэн лүд вэ.

- Өвөл өннөрсөнд л би баяртай байна.

- Бороо орж магадгүй байх чинь.

Ингээд янз бүрийн хүмүүс нийтдээ арваад болов. Нэг хоёр нь бие биенээ таних учир хоорондоо ярилцана. Зарим нь зайдуухан явах боловч тэднийгээ бараадсан хөлөө чирсэн амьтад харагдана.

Тэд хоорондоо юм ярилцаж эхлэх маягтай болсон боловч цэргийн хүн агсан нь тэдний тоог авч урд нь гараад:

- Бүгдэд чинь шөнийн хоног өнгөрөөх орон хэрэгтэй байгаа биз дээ? гэхэд хариуд нь ам амандаа нэг юм хэлэхчээ болж дулаан газар толгой хоргодож өнгөрөх шиг сайхан юм хаана байна вэ гэдгээ илэрхийлэх шиг болов.

- За тэгвэл жагсаатах, би нэг юм блдье, харин би ган ц мөнгөгүй хүн шүү гэхэд цаадуул нь мурий тахир эгнээрхүү юм болж ирэв.

Одоо тэднийг ажвал гол шинж нь тод байна. Нэг нь модон хөлтэй юм. Бүгдээрэнгийн нь бүрх малгайн хүрээ доош буусан, ер мөсөж өлгөсөн нь Хестер гудамжинд зардаг хуучин муу хувцасны оронцогтой харагдана. Өмд нь урагдан бөөн нөхөөс болсон, гадуур цамц пальто нь салбайн, үжир даасан навтас болжээ. Шөнийн хурц гэрэлд заримынх нь хамар улайж, хацар шанааны яс ёрдойж, нүднийх нь арьс унжжээ. Нэг, хоёр нь бараг яс арьс болсон, шоронгийн хоригдол мэт үзэгдэнэ. Тэднийг тийнхүү нэг дор байхыг сонирхсон хүмүүс ганц хоёроор цугларсаар сүүлдээ бүр олон болов. Гэр оронгүй нөгөөдүүлийн нэг нь ярьж хэлэхэд “ахмад”:

- Чимээгүй гэснээ – Эрхэм ноёд оо, энэ хүмүүс бол толгой хоргодох оронгүй улс юм. Энэнд энэ шөнийн хоногийг өнгөрөөх орон хэрэгтэй байна. гудамжинд унталтай биш, чадахгүй шүү дээ. Би эдний нэгийг НЬ хоног төөрүүлэхэд арван хоёр цент азрцуулах хэрэгтэй байгаа юм. Надад мөнгө өгөх хүн байвал одоо өгөхийг хүсье гэв. Хэн ч хариу дуугарсангүй.

- За, та минь, хүлээж л бай, бидэнд өгөх хүн олдох байлгүй, арван хоёр мөнгө ч уг нь их мөнгө бишсэн.

- Май арван тав, надад илүү өгөх юм даанч алга даа гэж нэг залуу урагч гарч ирэн нүдээ бүлтийлгэн байж хэлэхэд “ахмад”:

- За больж дээ, юун сайн юм гэж хэлэнгээ нэгий нь мөрнөөс нь татаж хажуу тийш нь гарган онцгойхон зогсоосноо:

- Одоо надад гурван цент л байна. Цаана нь энэ улсыг бас аргалах хэрэгтэй байгаа, за байз тоолодохьс: нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа, долоо, найм, ес, арав, арван нэг, арван хоёр-арван хоёр байна. Дараачин хүнд ор дэвсгэр олж хонуулахад есөн цент хэрэгтэй байна. Би өөрөө хамт яваад орон олоод өгнө. Хэн есөн цент өгөх гэж байна? гэхэд дунд зэргийн насны нэг хүн түүнд тавтын мөнгө өгөв.

- За, найман центтэй боллоо, одоо дөрвөн цент өгвөл нэг хүн орох дулаан оронтой болох нь дээ, өгцгөөвөл буян болох байна, ноёдминь. Өнөө орой нэг л гар татацгаагаад байх шиг, та минь, та нар өөрсдөө дулаан орон байртай, улс, харин эд нарыг яах билээ?

Ойролцоо зогсож байсан нэг хүн “май” гээд цент өгөхөд “ахмад”:

- Уухай, юун сайн юм. Одоо би хоёр хүнээ ортой болгож бас таван цент цаана нь үлдлээ шүү дээ, одоо долоог нэг нь өгвөл бас нэг хүн маань дулаан байранд хонох нь гэлээ.

- Тэрний нь би өгч орхиё гэж бас нэг хүн дуугарав.

Херствүд, тэр орой Зургадугаар өргөн чөлөөгөөр явж байгаад Хорин зургадугаар гудамж руу санаандгүй эргэсэн байв. Туйлын их өлсөж явсан болохоор унаж орхих нь уу гэмээр ч санагдаж

байж. Сэтгэл санааны талаар ч больчихсон явж. Керитэй яаж нэг уулздаг билээ? Арван нэнэг цагаас нааш жүжиг тарахгүй. Тэргээр ирсэн бол явахдаа бас л тэргэнд суугаад арилна. Гудамжинд тун эвгүй байдалд зогсоож л уулзахад хүрэх нь дээ гэж бодохдоо өлсөж сульдсан нь юмны адаг санагдаж байв. гэтэл өнөө орой уулзаж чадахгүй бол бүхэл хоног хүлээх дээр хүрнэ. Идэх хоол ч үгүй, орж унтах орон ч үгүй тийнхүү цөхрөнгөө барж явжээ.

Бродвейд ойртон очоод ахмад ба түүний хүмүүсийн барааг олж харсан боловч тэднийг гудамжны номногч лам юмуу эсхүл эм зардаг лам байж байгаа юм бол уу гэж бодоод тойроод гарах гэснээ чийдэнгийн тод гэрэлд өөрийнх нь танил, нийтийн байранд хоног төөрүүлж байдаг хүмүүс нь харагдаж зарим нь онцгойрон зогсож байгааг таниад юу ч билээ гэж бодсоор дэргэд нь очжээ.

Нөгөө ахмад, хүмүүсээс мөнгө хайрлахыг гуйж гувшиж байгаад: “Энэ хүмүүст ямал ч болтугай шөнийн хоног өнгөрөөх оромж олж өгөх хэрэгтэй байна шүү дээ” гэсэн үг сонсоод Херхствүд ихэд гайхан дотор нь амрах шиг болсоноо нэг хүн сэмхэн ирээд нөгөө зогсож байсан хүмүүсийн захад очоод зогсоыхг хармагцаа өөрөө ч нэрэлхээд нэрээ идэх биш, энэ шөнийн хүйтнийг яана, ийм аятайхан завшаан гарч байхад алдаж болохгүй тэгж байтал маргааш болоход бас юуны магад гэж бодоод мөн хүмүүсийн ард очиж зогсчээ.

Шөнө хонох дулаан байрны мөнгө нэгэнт олсон хүмүүс хийморь нь овоо сэргэж юм хүм ярьж хөөрөн бараг л хөхрөлдөх дөхөж буй бололтой. Улс төр, шашин, засгийн газрын бодлого, сонинд хэвлэгдсэн зарим дуулиантай явдал, дэлхий дахинд болж буй хамгийн сүртэй үйл явдлын тухай хүртэл ярилцаж эхэлснийг Херствүд чагнаж эхлэв. Ихээхэн сонирхолтой зүйлийг нь сөөнгөдүү чахруун дуугаар хүчлэн ярихад хариуд тодгүй боловч шагшиж гайхсан маягийн хариу үн хэлэх ч сонсдоно. Харин зарим дэндүү их ядарч зүдэрсэн, уруу царайлсан нэг нь огт чимээгүй дүлий дүмбэ оргин тэр яриаг нь тээршаасан байдалтай ярвайж, гөлрөх буюу мөн хялайна.

Удаан зогсор ядаргаатай, Хүлээсээр Херствүд залхаж эхэлжээ. Юу юугүй унамаар санагдан, хоёр хөлөө ээлжлэн арай ядан зогсож байтал сая нэг ээлж нь иржээ. Өмнөх хүн нь зохих мөнгөө олоод азтайчуудынхаа эгнээнд очиж зогсоход одоо Херствүд эгнээний эхний хүн болов. Ахмад ч түүний өмнөөс гуйлга гуйж л байлаа.

- Эрхэм та нар минь энэ хүнд арван хоёр цент хайрлавал ор дэвсгэртэй болгож өглөө гэсэн үг шүү дээ. Орох оронтой бол энэ хүн юугаа хийж энэ хүйтэнд энд үйлээ үзэн зогсох билээ.

Энэ үгийг сонсоход Херствүдийн хоолой зангирмаар боллоо. Өлсөж ядраад уйлах нь халаг байна.

- За, май гэж нэг хүн ахмадад зохих мөнгийг өгөхөд ахмад нь шөнийн зоогийн газрын эрхлэгч агсны мөрөн дээр зөөлнөөр алгадан:

- Тэнд очоод зогс доо гэв.

Нэгэнт тэнд очихтой болсон хойно Херствүдийн дотор онгойлоо. Өрөвч хүмүүс байгаа цагт хорвоо гэгч тийм ч их муухай биш санагдаж эхлэв. Бусад нь ч тэгж л бодож байгаа бололтой.

“Ахмад маань сайн хүн шүү” гэж Херствүдийн өмнө зогсож байсан чогжгорхон биетэй, эрээн бараан хорвоод элдвийг үзэж хувь заяанд тоглуулж гүйцсэн бололтой нэг хүн хэлэхэд Херствүд,

тоомжиргүйхэн:

- Тиймээ гэв.

Тэдний нэг нь эгнээнээсээ гарч ар тийшээ хараад:

- Пөөх, яасан олон болчихоо вэ гэж санаа алдан хэлэхэд нэг нь:

- Нээрэн олон байна, өнөөдөр лав зуу гаран хүн болох вий гэв.

- Хүүе, тэр тэргэнл байгааг хараач гэж бас нэг хүн нь дуу алдав.

Явган хүний замын хажууд үнэхээр нэг жуузтэй ноён хүрчирэн зогсоод ахмадад бүхэл дэвсгэрт өгөхөд ахмад гялайлаа гэж аваад өөрсдийн хүмүүс рүү эргэв. Энгэр дээрээ очир алмасан эрдэн гялалзуулсан жуузтай ноёныг холдон явахад тэр хүмүүс араас нь ам ангайн хүзүү сунган биширсэн мэт хэсэг зуур ширтэвэ.

Энэ мөнгөөр есөн хүн аргалж болох байхаа. За байз, одоо хэд үлдээд байна хэмээн хүмүүсээ тоолоод одоо долоохон үлдэж дээ. Ноёд минь хэн надад арван хоёр цент өгөх вэ? гэж ахмад гуйлгаа үргэжлүүлэв.

Мөнгө олигтой түргэн арвижиж өгөхгүй, хүмүүс сийрч цөөрсөөр байдаг. Тавдугаар өргөн чөлөөгөөр хаа ганц нэг тэрэгтэй, явган хүн үзэгдэх болж, Бродвейд ч хөл татарлаа. Ганц нэгхэн хүн л юун улс бөөгнөрөөд байгаа юм бол гэж сонирхон ахмадын гуйлгын хариуд хэдэн зоос өгөөд эргэж ч харалгүй алга болж байлаа.

Гэвч ахмал зорьсондоо хүрэх гэж зориг шийдэмгий, цөөн боловч шамдамгүй үгээ хэлж гуйсаар байв.

- Эрхмүүд минь түргэлж үзээч, би шөнөжингөө зогсолтой биш, энэ улс ч даарч хөрч сүйд боллоо. _ Дөрөвхөн цент өгчих хүн алга уу? гэж байснаа сүүлдээ бүр дуугарахаа больж олон хэдэн центээ арьан хоёр болмогц нэгийг нь оромжтой хонох хүмүүсийнхээ эгнээнд шилжүүлэн газар шагайн урагш хойш холхисоор байв.

Жүжиг тарж, театрын гэрэл унтарч арван нэгэн цаг ч болов. Дахин хагас цаг өнгөрөхөд хоёрхон хүн л хоногийн мөнгөгүй үлдсэн байв.

- Одоо арван найман цент л хэрэгтэй байна, арван найман цент л хэрэгтэй байна, надад зургаа нь байгаа юм, эрхмүүд минь өгч үзээч. Би өөрөө бас Бруклин хүртэл явах хүн, тэрнээсээ өмнө энэ улсыг оромжинд оруулж өгөх хэрэгтэй, одоо арван найман цент л өгвөл бүгд дулаан байранд хоног өнгөрөөх болоод байна.

Мөнгө өгөх хүн гарсангүй. Ахмад урам хугаран газар шагайж, хааяа “арван найман цент” гэж үглэн урагш хойш хөлхсөөр. Тэр хэдхэн центнээс болуж түрүүчийн гуйлгаар олсон өдий төдий мөнгөний ид шидийг үзэхгүй болох нь уу гэмээр санагдах ажээ. Хөрстүдийг үзэхгүй болох нь уу гэмээр санагдах ажээ. Хөрстүд тийнхүү удаан зогсож өлсөж ядрахын улмаас орь дуу тавимаар болж байв.

Тэгтэл Тавдугаар өргөн чөлөөгөөр театраасаа жүжгийн малгай толгой дээрээ тавьж торгон

даашинз шүрчигнүүлсэн, нэг хатагтай хар хүнээ дагуулсаар гарч иржээ. Херствүд түүнийг хараад Керри одоо иймэрхүү яваа гэдгийг санаж бас урьд авгайгаа театраас яг ингэж дагуулан гарч байснаа нэхэн саналаа.

Тийнхүү харж байтал нь нөгөө хатагтай тэнд зогсож буй сонин хүмүүсийг ажиглаж өөрийгөө даган явсан эрийг тэдний зүг илгээв. Ганган дэгжин тэр эр нь хүрч ирээд гартаа браьсан дэвсгэртийг ахмадад-

- Май хэмээн гардуулахад ахмад хариуд нь талархлаа илэрхийлээд өөрийн асрамжны хүмүүст хандаж бидэнд маргааш нь нэмэр болгох хэдэн юм хайрлав гэлээ.

Тэгээд сүүлчийн хоёр хүнээ эгнээнд оруулж хүмүүсээ тоолон:

- Зуун гучин долоо. За, нөхөд минь аятайхан жагсаарай. Одоо удахгүй, ялимгүй тэсэж үзээрэй гээд өөрөө жагсаалын тэргүүнд очиж “Урагшаа” гэхэд Херствүд ч тэднийхээ хамт хөдлөв.

Тэд, Тавдугаар өргөн чөлөөгөөр явж Медисон талбайг огтлон гарч Хорин гуравдугаар гудамжаар эргээд цааш Гуравдугаар өргөн чөлөөгөөр орон мурий эгнээгээрээ явав. Шөнө ажилтай буюу шөнөжин сэлгүүцэж явдаг хүмүүс тэр хачин хүмүүсийг оснирхон харна. Байшин барилгын буланд ярилцан зогсох цагдаа нар тэднийг хайхрамжгүй харахын сацуу танил болсон “ахмадад” толгой дохиж байв. Тэд Гуравдугаар өргөн чөлөөгөөрөө явсаар Наймдугаар гудамжаар ороод өнөөх хоногийнхоо газар хүрэхэд тэр нь хаалттай бололтой. Гэсэн ч тэднийг ирнэ гэж хүлээж байжээ.

Ахлагч нь хүмүүсээ гадаа үлдээгээд өөрөө дотогш орж хэлэлцэхээр явав. Төдхөн хаалга нээгдэж тэднийг “жагсаалаараа яваад орцгоо” гэв. Нэг хүн, тэднийг удирдан явж хаана ямар өрөө хэдэн хүн орохыг зааж өгч шууд цоожий нь гарган өгч байв. Херствүд эргэж харвал “ахмад” нь бүгдийг байранд орж дуустал ажиглан харсаар зогсож байгаад орж дуусахлаар нь сая цуваа лавлан нөмрөөд шөнийн харанхуйд гарч одлоо.

Херствүд, өөрийг нь оруулсан бүдэг гэрэлтэй жижигхэн муу өрөөний орон дээр суухдаа:

- Би ч ингэж байж удаан тэсэхгүй нь ямар ч болтугай хэлэн дээр идэх юм олж тавихгүй бол өлбөрч үхэх нь гэж дуулдахаар хэлэв.

БУЛИНГАРТСАН УС

Керри, Нью-Йоркт эргэж ирснээсээ хойш нэг орой тоглолтын дараа хувцсаа солиод явахыг завдаж байтал гадаа хүмүүс ярилцах чимээ гарч таньдаг хүн ч дуугарах шиг болов.

- Зүгээр, би Маденда хатагтайтай уулзах гэсэн юм.

- Тэгвэл та нэрийнхээ хуудсыг оруулчих л даа.

- Өө, ямар зовлонтой юм май.

Хагас доллар атгуулсны дараа Керрийн өрөөний үүдийг цохих эрх олж авсан ажээ. Керри хаалгаа нээв.

- За тэгнээ тэр. Сани байна уу? Би чамайг хамрагцаа л таньсан шүү.

Керри, тун эвгүй яриа үүсэх нь гэж айгаад аргашаа алхам хэртэй ухрав.

- Чи надтай гар барихгүй юмуу, Гомдоогүй биз дээ. Гар барья л даа. даанч!

Керри, тэр хүний хэзээний сайхан зантайг нь бодож инээмсэглэн гараа өглөө. Уулзаагүй удсан боловч бараг хувираагүй, урьдын адил цэвэрхэн ганган хувцастай, царай нь улаа бутарсан лагсдуу биетэй эр хэвээр харагдана.

- Үүдний хүн намайг оруулахгүй гээд болдоггүй шүү, тэгэхлээр нь мөнгө атгуулж байж орж ирлээ. Чамайг гарцаагүй мөн гэж бодсон. Чи үнэхээр сайхан тоглож байдаг шүү. Чамайг тийм сайхан тоглоно гэдэгт би итгэж байсан. Өнөө орой танай театрын хавиар явж байгаад орж үзье байз гэж бодлоо. Хөтөлбөрт нэр чинь байсан л даа, гэвч юу билээ санахгүй байсан, тэгсэн чинь харин чи тайзан дээр гараад ирэх нь тэр, хичнээн гайхсан гэж санана. Ёстой мэл гайхаж цэл хөхөрнө гэгч л болсон. _ Чикагод байхдаа би чамд өгсөн нэр байна шүү дээ тийм ээ?

Дрүэг тийнхүү мэрийгээд байхлаар Керри, эелдэгхнээр:

- Тийм ээ гэв.

- Би чамайг хармагцаа л таньсан. Чи тэгээд сайн сууж байна уу?

- Өө, бишгүй сайн сууж байна. Чи өөрөө сайн биз дээ? гэж хэлэхдээ Керри тэр хүнтэй гэнэт уулзсандаа бантаад тайвширч хараахан амжаагүй л байлаа.

- Би юу? Сайн сайн, одоо би энд байгаа шүү дээ.

- Өө, тийм үү?

- Тийм, энд ирээд зургаан сар болж байна, энд нэг салбар хариуцаж байгаа.

- Яасан сайхан хэрэг вэ

- Чи тэгээд театрт хэзээнээс тоглох болоо вэ?

- Гурван жил орчим болж байна.

- Үгүй ер. Хачин юм даа, би чинь дөнгөж сая л мэдлээ шүү дээ. Би чамайг уг нь театрт тэнцэнэ гэж боддог л байсан, дандаа тэгж хэлдэг байсан биз дээ? гэхэд нь Керри инээмсэглэж:

- Тиймээ гэв.

- Чи мөн сайхан харагдаж байна. Хүн ингэж сайхан болдгийг би ер мэдэхгүй юм, чи чинь өндөр ч болчихсон юмуу даа?

- Би юу? бага зэрэг магадгүй шүү.

Дрүү хувцас хунары нь, үсий нь толгой дээрээ хазгайдуухан тавьсан бүрх малгайгий нь харж ширтсэнээ нүд рүү нь ширтэхэд Керри нүдээ зориуд буруулав. Дрүү хуучин харьцаагаа тэр хэвээр нь юу юугүй сэргээхийг хүссэн нь илт байв.

Керри, түрийвч, алчуур зэргээ авя явахыг завдахад Дрүү:

- Хүүе, хоёул өнөө орой хамт хоолонд орох юм биш үү? Би нэг найзтайгаа яваа, гурвуул хамт орьё гэхэд Керри:

- Өө, би чадахгүй, өнөө оройдоо л лав чадахгүй, өглөө эрт тоглолттой гэв.

- Өө, тэр яадаг юм. Чи ир л дээ. Би тэр хүнээ аргалъя. Хоёул сайхан ярилцаж сууя л даа.

- Үгүй, үгүй, чи надаас бүү шалгаагаад бай. Би тийм орой хүртэл ресторанд байдаг ч хүн биш.

Гэвч Дрүү өөрийнхөөрөө зүтгэж:

- Тэгвэл зүгээр жаал сууя л даа гэхэд Керри, толгой сэгсрэн:

- Өнөөдөр л лав чадахгүй, дараа л болох уу даа гэв.

Юм гэдэг өөр болж дээ гэсэн бодол Дрүүгийн дотор бодогдож буй нь Керрид андашгүй байв. Өөрт нь дандаа сайн байсан хүндээ дэндүү хатуурхан гомдоох хэрэггүйг Керри ойлгох учир саяын хэлснээ цагаатгаж:

- Чи зочид буудалд маргааш ир л дээ, тэгээд хоол хамт идэж болох байна гэхэд Дрүү урамшиж:

- За тэгье, чи хаана байгаа вэ? гэв.

- “Вольдорф” гэж Керри саяхан нээгдсэн хээнцэр гоёмсог зочид буудлыг нэрлэв.

- Хэдэн цагт?

- Гурван цагт ир л дээ.

Маргааш нь Дрүү болзсон цагтаа хүрч ирэхэд Керри түүнтэй тийнхүү уулзаж буйдаа баярласан шинж огт байсангүй. Гэвч Дрүү хэзээний зангаараа сайхан аашилж өөрийнхөөрөө их л ганган

хээнцэр байх тул энэ удаагийн уулзалт олигтойгоор төгсөхгүй гэж бодож байсан Керрийн сэжиг арилав. Дрүү урьдын адил хэмжээ хязгааргүй чалчиж байлаа.

- Энэ зочид буудал мөн ч дэгжиж байна шүү гэхэд Керри:

- Тийм байна гэлээ.

Яснаасаа онгиороо хүн болохоор Дрүү өөрийнхөө алба тушаалын талаар нэгд нэгэнгүй тоочин ярьж эхэлжээ. Яриан дундаа мань эр:

- Би одоо ингэсхийж байгаад өөрийн гэсэн газартай болох гэж хоёр зуун мянган долларын зэллэг авах гэж байгаа гэлээ.

Керри их л сонирхон чагнана.

- Мартсан, Херствүд хаана байгаа вэ? гэж Дрүү гэнэт асуув.

Керрийн нүүр бага зэрэг уласхийв. Тэгээд:

- Энд, Нью-Йоркт байгаа байхаа, уулзаагүй удаж байна гэлээ.

Дрүү хэсэг түгдэлрсхийн суулаа. Шөнийн зоогийн газрын эрхлэгч агсан хүн Керрийн амьдралд одоо чухам ямар нөлөөтэй байгааг сайтар мэдэхгүй байсан Дрүү одоо дотор нь онгойв бололтой. Керри түүнээс салж таарсан байх ёстой гэж Дрүү яагаад ч юм бодсон удаа бий ажээ.

- Тиймэрхүү юм хийсэн хүн аргагүй алдаанд оролгүй яах вэ гэж Дрүү хэлэхэд Керри юу гэсэн үг болхы нь ойлгоогүй учир:

- Тиймэрхүү юм хийсэн хүн гэж юу хэлж байна? гэхэд цаадах нь:

- Өө, чи мэдэхгүй яах вэ гээд энэ талаар ямар ч эргэлзээ байхгүй гэсэн шиг гараа сажихад Керри:

- Үгүй, би мэдэхгүй, чи юу хэлэх гээд бйана? Гэж шалгаахад Дрүү:

- Үгүй ээ, яагаа вэ, өнөө Чикагогаас явахдаа... санахгүй байна гэж үү? Гэв.

- Би чиний яариад байгаа юмы чинь ердөө ойлгохгүй байна, юу гээд байнаа чи гэж хэлээд Керри дотроо: “энэ хүн намайг Херствүдтнй оргож явсныг үнэхээр их муугаар бодсон юм байх даа” гэж бодов.

Дрүү огт үнэмшихгүй янзтай:

- Чикагаас оргохдоо арван мянган доллар аваад явчсаны нь чи мэдсэн байлгүй яахав, мэдээ биз дээ? гэхэд Керри:

- Яалаа гэнээ? Мөнгө хулгайлсан хэрэг байх нь уу?

Дрүү ялимгүй зовох шиг болж:

- Юу ч гэлтэй юм дээ, чи мэдээгүй хэрэг үү? Гэлээ.

- Яаж мэдэх вэ, ердөө мэдээгүй.

- Тэгсэн юм, их хачин юм болсон, сонингуудад бүгдэд нь бичсэн.

- Хичнээн мөнгө авсан гэнээ?

- Арван мянган доллар. Сүүлд нь ихэнхий нь буцааж өгсөн юм гэж дуулдсан.

Керри, сайхан хивс цул дэвссэн шал ширтэн бодол болов.

Өөрийг нь хуурч оргуулан явсан цагаас эхлэн түүнээс хойш өнгөрсөн бүх жилүүдийн турших явдлыг бодож үзэхэд ман олон юман дээр нээрэн учиртай тал байсан нь санагдах болов. Тэр их мөнгийг ч гэсэн өөрийнх нь төлөө л авч явсныг Керри ойлголоо. Ингэхлээр тэр хүнийг үзэн ядахын оронд харин ч өрөвдмөөр санагдав. Хөөрхий минь, тийм юм хийсэндээ энэ олон жилийн дотор сэтгэлийн ямар их зовлон эдэлж яваа бол!

- харин Дрүэ энэ завсар сайхан хоол идэж, дарс уусандаа халамцаж, сэтгэл санаа нь сэргээд Керритэй хуучин цагийнхаа явдлыг сэргээж болох нь гэж горьдож бөйв. Керри одоо хэдийгээр их дээгүүр хүн болсон ч гэлээ амьдралд нь шурган орж болох юм бодож “Мөн ч сайхан аа! Яасан ганган, ямар үзэсгэлэн гоо харагдана вэ. Ямар ч их алдан нэртэй вэ!” гэж дотроо бодоод одоо урлагийн тайзан дээр алдаршиж Вольдорф зочид буудлын газар сууж байгаагийн нь бодохоос улам хорхой нь хүрч хүсэл шунал ь хязгааргүй оргилж байлаа.

- Эври клубт тоглосон тэр орой чи хичнээн их сандарч байснаа санаж байна уу? гэж асуухад Керри инээмсэглэв.

- Тэр орой чамаас өөр илүү сайхан тоглосон хүн байгаагүй юмдаг. Тэгэхэд би, бид хоёрын амьдрал одоо л шулуун замдаа орж сайхан болох нь гэж бодож байсан шүү гээд ширээн дээр нь тохойлдон ойртож эрээ цээргүй яриахад нь Керри нэлээд ёоз муутайгаар:

- Чи тэгж ярих хэрэггүй дээ гэв.

- Би чамд хэлэх юм байна...

- Хэрэггүй гэж Керри хэлэнгээ босож, - Театр руугаа явах цаг миньч болж байна. Чамайг орхиод явахаас өөр замгүй боллоо. За явлаа гэв.

- Жаахан хүлээгээч дээ. Чамд зөндөө зав байгаа шүү дээ гэж Дрээ гуйлаа.

- За, үгүй дээ гэж Керри зөөлөн хэлэв.

Дрүэ их л дурамжхан босож Керрийг өргүүр шатан дээр хүргэж өгөөд:

- Би чамтай хэзээ дахин уулзаж болох вэ? гэж асуухад Керри:

- За яах вэ, тэгж байгаад л нэг уулзана биз. Энэ зун би эндээс явахгүй шүү дээ. За сайхан нойрсоорой гэв.

Өргүүр шатчин хаалгаа онгойлгож Керридаашинзныхаа хормойг шарчигнуурсаар ороход Дрүү:

- Баяртай гэлээ.

Дрүүгийн урам хугарч хөлийн өрөөгөөр угжийн алхахдаа Керри өөрөөс нь дэндүү холдож хүссэн нь биелсэнгүйд шуналтэчъяал нь дахин буцалж эхэлжээ. Керри ер нь намайг тоосонгүй гэж Дрүү бодсон байна. гэтэл Керри огт өөр юм бодож байв. Яг тэр орой Керри “Казино” театр руугаа явах замдаа Херствүдийг ажиглалгүй өнгөрсөн байж. Харни маргааш орой нь мөн явж байгаад түүнтэй гэнэт улаан нүүрээрээ тааралджээ. Тэр орой Херствүд өлсөн зүдрэхийн туйлд хүрч Керрийг заавал олж уулзах эсхүл зурвас бичиг явуулж байгаад ч гэсэн уулзъя гэж шийдсэн байжээ. Эхлээд Керри тэр галбиргүй уранхай ноорхой хүнийг Херствүд гэж атньсангүй. Тийм өлсгөлөн ядуу хүн тийм ойрхон тааралдсанд Керри давхийн цочсон байна. гэтэл нөгөө хүн нь аярхан:

- Керри, би чамтай хэдхэн үг сольж болохсон бол уу гэхэд Керри хармагцаа таньж хэрэв дотор нь түүнийг үзэн ядах сэтгэлийн зйүл байсан бол тэр дорхноо үгүй болсон байна.

Дрүү, түүнийг мөнгө хулгайлсан гэж хэлснийг Керри мартаагүй явжээ.

- Бололгүй яах вэ, Жорж минь, чи яагаа вэ? гэж Керри бараг шивнэж хэлэхэд Херствүд:

- Би өвдөөд, дөнгөж сая л эмнэлгээс гараад явж байна. Бурхны хишгийг бодож чи надад хэдэн юм хайрлахгүй юу? гэлээ.

Керрийн сэтгэл ихэд зовж түүнийгээ нуухын тулд чармайхад уруул нь өмөлзөж байлаа. Тэгээд:

- Би чамд өгөлгүй яах вэ, харин чи яагаа вэ? гэж асуугаад түрийвчээ уудалдж дотор нь байсан бүх мөнгөө нэг тавт, хоёр хоёртыг гаргаж ирээд – Одоо миний биенд яваа нь энэ байна гээд өгөв.

- Би өвдөөд гэж хэлсэн шүү дээ гэж Херствүд бараг уцаарлах маягтай хэлсэн нь бас учиртай байж яагаад гэвэл өөрийг нь дэндүү өрөвдөж, арчаагүй болсныг нь хэтэрхий цохон тэмдэглэж байгаа чюмуу, бас тэгж байгаа хүнээс гуйлга хийж юм авч байгаа нь даанч арчаагүй санагдсан юм бол уу даа.

Херствүд, Керрийн өгсөн мөнгийг:

- За яахав, би бололцоотой болсон цагтаа мөнгий чинь буцааж өгнө гэж хэлэв.

Керри, Херствүдийг ажиглан харахад хажуугаар яваа хүмүүс Керрийг ажиглаж байв. Хүмүүс сонирхож байгаа бололтойг Керри тааварлахад Херствүд ч бас тэгж бодов. Керри яахаа сайн мэдэхгүй:

- Надад хэлэхгүй яасан юм? Одоо чи хаана байгаа юм? гэхэд Херствүд:

- Би Вауэрид нэг өрөөнд сууж байгаа. Тэр талаар энд чамд юу гэж хэлэх билээ. Одоо зүгээр гэлээ.

Херствүд, Керрийн тийнхүү байн байн шалгаагаад байхад нь өөрөө сайн явж байгаа болохоор хүний мууд дурлаж ингэж байна гэж бодоод зэвүү нь хүрэх шиг болжээ. Тэгээд:

- За чи яв даа. Их баярлалаа. Чамайг би дахиж зовоохгүй гэж хэлээд бушуухан эргэж зүүн тийшээ алга болоод өгсөн тул Керри хариу үг ч хэлж чадсангүй.

Энэ явдал Керрид хэдэн өдрийн турш бодогдон сэтгэлий нь зовоож байсан боловч сүүл сүүлдээ намжсаар гайгүй болжээ. Дрүү дахин ирсэн боловч Керри түүнтэй уулзсан ч үгүй явуулжээ. Түүнтэй уулзаж байх хэрэгцээгүй гэж бодсон аж.

Дрүүг ирээд байна гэхэд нь Керри зарцад:

- Намайг байхгүй байна гэж хэл гэсэн байна.

Керри тийнхүү хүн амьтантай ч нэг их ойртохгүй, ганцаараа зожигдуу, биеэ барьсан, амгалан тайван байдалтай явахад нь хүмүүс их сонирхох болжээ.

Түүнээс хойш төдий л удалгүй театрын захиргаа нь Лондонд очиж тоглохоор шүүйдсэн байв. Тэр зун эндээ байна гэхэд орлогоор базаахгүй нь гэж боджээ.

- Лондоныхныг салж чадахгүй болтол нь тоглоод үзэх юм биш үү? Гэж захирал нь нэг өдөр асуухад Керри:

- Бүр чадахгүй бол яана гэж айж байна шүү гэв.

- Зургадугаар сард тийшээгээ ямар ч болтугай явах гэж байгаа гэж захирал нь хэлэв.

Тийнхүү юуюугүй явах болчихоод байсан тул яарч тэвдэх юм гарч Херствүдийг ч мартжээ. Херствүд Дрүү хоёул Керрийг бүр яваад өгсөн хойно л явсны нь дуулжээ. Дрээ нэг удаа ирж асуугаад, Лондон явчсаны нь мэдээд дуу алдан хашгирах дөхсөн ажээ. Тэгээд урам нь баахан хугаран сахлынхаа үзүүрийг химлэн хэсэг зогсож байснаа урьдын явдал буцашгүй өнгөрчээ гэж бодов.

“Энэ хүүхнээс болж сүйд болоод ч яах юм билээ” гэж бодовч зүрхнийхээ угт өөрөөр мэдэрч байсан амуй.

Херствүд, тэр урт зун намар хоёрыг яаж ийж аргалсаар баржээ. Нэг удаа мань эр, бүжгийн газар хаалгачингаар орж сар хиртэй ажилласан байна. Заримдаа хоосон хонож, заримдаа гуйлга гуйж, заримдаа гадаа хонож дахин хэд хоногийг барав. Өлсөж үхэийн даваан дээр очихдоо тэтгэврийн газраар очиж бага сага юм олж авч байлаа. Өвөл болсон хойно Керри буцаж ирээд өөр жүжигт тоглож эхэлсэн боловч Херствүд мэдээгүй явжээ. Херствүд, хэдэн долоох ногийн турш гуйлга хийн хотоор тэнэж явахад Керри Маденда Лондонгоос буцаж ирээд тоглож байна гэсэн цахилгаан зарлал энд тэндгүй гялалзаж байлаа. Дрүү мэдсэн боловч уулзахаас зүрхшээжээ.

Яг тэр үеэр Эмс Нью-Йоркт буцаж ирэв. Өрнөд нутагт нэлээд амжилт олж, одоо энд ирээд Вустер гудамжинд шинжилгээний лаборатори нээсэн ажээ. Тэр залуу, тэнс хатагтайгаар дамжуулан Керритэй уулзжээ. Гэвч тэр хоёрын хооронд ноцтой юм юу ч болсонгүй. Херствүдтэйгээ хамт байгаа юм байлгүй гэж тэр үед бодож байснаа дараа нь тэр хоёрыг салсан гэж дуулжээ. Тэгээд чухам яагаад сласан сарнисан тухай нь хөөцөлдсөн ч үгүй.

Эмс, Вэнс хатагтай хоёр Керрийн тоглосон жүжгийг үзжээ. Тэгээд Эмс, Вэнст:

- Шог жүжигт тоглоод дэмий юм байна даа. Өөр юманд тогловол хамаагүй дээр тоглож чадах хүн юм гэж хэлжээ.

Нэг өдөр вэнсийнд тэр хоёр тааралдаад их л нөхөрсгөөр ярилцжээ. Харин Керри тэр залууг урьд нэгэн цагт ихэд сонирхон боддог байсан бол одоо тиймгүй болсондоо гайхаж байв. Тэр үед Керри хүсэл мөрөөдөл болж байсан зүйлий нь Эмс илэрхийлж байх шиг байсан бөгөөд одоо нэгэнт хүссэндээ хүрсэн болохоор өөр болжээ. Нэгэнт амжилтанд хүрсэн учраас одоо түүнийг өөрийгөө хүэдэтгэх ёстой гэж үзэх нь халаг байсан буюу. Гэвч Эмс, сонинд бичигдэж байгаа түүний алдах цууг огт тоохгүй харин ч тэрнээс илүү их авьяас илрүүлж чадах эмэгтэй гэж бодно. Керрийг нэг үе драм сонирхож байсны нь санаад Эмс:

- Та тэгээд драмд орсонгүй юу? гэхэд Керри:

- Үгүй шү, одоохондоо ороогүй байна гэв.

Эмс өөдөөс нь таашаасан байлагүй харахад Керри арга буюу:

- Тэгж байгаад орж бололгүй дээ гэж нэмж хэлэв.

- Орсон дээр л дээ. Та бол шог-драмын жүжигт тоглох мю бол хамаагүй илүү сайхан дүрийг бий болгож чадах хүн гэлээ.

Тэгтлээ гүнзгий мэдэж байгаа байдалд нь Керри их гайхаж хүний дотрыг тий их таньдаг хүн байх юм даа гэж бодоод:

- Яахлаар нь та тэгж боддог билээ? гэж асуув.

- Яагаад гэвэл таны сэтгэл зүрх чинь илүү хүнлэг санагдах юм.

Керри инээгсэлэн бага зэрэг улайв. Тэр залуу ний нуугүй ярьж байгаад нь Керри хайлж улам дотно мэт болов. Урьд түүнийг дээд зэргийн сайхан чанарын хүн гэж бодож байсан нь сэргэх шиг болов.

Керри баярласан нь илт байсан бөгөөд:

- Мэдэхгүй юм даа гэж хэлэхэд Эмс:

- Би таны тоглож байгааг үзсэн. Их сайхан болж байна лээ гэв.

- Танд таалагдсандаа би баярлаж байна.

- Шог жүжигт тоглосон гэхэд ч үнэхээр сайхан тоглосон шүү.

Тэр удаа тэр хоёрын яриа үүгээр тасарсан боловч дараа дахин уулзжээ. Керрийг бас нэг гийчний хамт орж очиход Эмс бодол болчихсон шал ширтэн сууж байж. Олон жилийн дотор уйгагүй хөдөлмөрлөсний ул мөр андашгүй агаад Керри түүний нүүр царайны юунд нь дуртай байснаа ч мэдэхгүй байна.

- Ганцаараа байгаа юмуу?

- Хөгжим сонсож байна.

Залуу эрдэмтнийг огт сонирхрогүй Керрийн найз эмэгтэй нь:

Би түр яваад ирье гээд орхин гарлаа.

Эмс, өмнөө зогсох Керрийг ажсанаа:

- Сайхан хөгжим байгаа биз? гээд өөрөө чих тавин улам анхааралтай сонсов. Керри, тэр хөгжмийн онцгой сайхныг мэдэрч:

- Үнэхээр сайхан байна гэлээ.

- Суухгүй юу гээд дэргэдэх сандлаа ойртуулж өгөв.

Тэр хоёр нэг хэсэг хөгжим чангаад дув дуугүй байв. Хоёулангийн сэтгэлд адил сэтгэгдэл төрөвч Керрийнх чухамхүү зүрхээрээ дамжиж байлаа. Керри урьдын адил хөгжим сонсохдоо дуртай байв.

- Яагаад ч тэр юм бүү мэд, би хөгжим сонсохлоороо ямар нэг юмаар дутах шиг болдог юм гэж Керри цээжин дотроо учры нь эс тайлж чадахуйц гуниг мэт төрхтэй зэрэг хэлэв.

-Тийм байна, би таныг ойлгож байна гэж гэнэт тэр хүүхний өөрийн бодол санааг илэн далангүй хэлж байгаа онцлогий нь анхаарч:

-Та гутарч байх хэрэггүй шүү дээ гэв.

Эмс, түр зуур бодолхийлж байснаа огт өөр юмны тухай яриа үүсгэх мэт боловч тэр нь тэр хоёрын сэтгэлд яг таацжээ.

-Хорвоо хүсмээр юмаар диг дүүрэн байдаг боловч нэг зэрэг олныг эрмэлзэж болдоггүй юм. Тэгэхэлээр сунгаад ч гар хүрэхгүй юманд сарвайх хэрэг юу байх билээ.

Хөгжим сонсоход Эмс босож Керрин өмнө биеэ амраах гэсэн мэтээр согсов.

-Та яагаад драммын сайн театрт шилждэггүй юм гэж асуугаад нүүрий нь ажиглав. Керрийн дулаан харцтай дүрлэгэр нүд өмөлзөхийг завдан буй адил харагддаг ам нь Эмсийн бодлыг зөв гэж буй мэт байв.

-Шилждэг ч юмуу гэж бодож байна шүү

-Таны заяаны чинь газар мөн дөө.

-Та тэгж бодож байгаа юмуу?

-Тиймээ

-Та өөрөө мэдэхгүй байгаа байх даа, гэвч таны нүд амы чинь ажихад тийм л юманд илүү таарах юм гэж би бодох юм.

Хүн үнэн санаанаасаа тэгж хэлж буйг бодохоос Керрийн сэтгэл догдолж ганцаардмал уйтгарт байдал нь өргөс аваад хаяхын адил алга болов. Тэр хүний хэлж байгаа үг нь хоосон магтаал биш харин гярхай нүдээр ажиж гүн бодлоо шинжилсэн байлаа.

-Таны нүд , ам учиртай юм гэдгийг би тантай анх уулзахдаа л ажсанаа санаж байна. Ялангуяа амны чинь байдал их онцгой. Таныг би уйлах гээд байгаа юмуу даа гэж бодож билээ.

Керри тэр үгэнд хайлж, зүрхэндээ баярлан;

-Их л хачин юм да гэв.

-Тэгээд би таныг ерөөсөө заяаны тийм юм байгна гэж ойлгосон, одоо ч тийм нь батлагдлаа. Таны нүдний харц ч өөрцгүй бас тийм. Энэ бол сэтгэлийн гүнд бөйгаа чанарын л илрэл шүү дээ гэхэд Керри сэтгэл нь бүр их догдолж түүний өөдөөс эгцлэн ширтэж харав.

-Гэвч та үүнийгээ өөр өмөддэггүй байж болох юм гэж Эмс хэлэв.

Керри тийм магтаалын үг сонсоод нүднийхээ харцыг бууруулав.

Тэр хүний бодож, ярьж байгаа шиг байж чадаасай гэж Керри өөрөө бодно. Түүний хэлсэн үгнээс болж шинэ хүсэл эрмэлзлийннүүд хаалга тийнхүү нээгдэж эхлэв.

Керри энэ тухай олон хоног бодсон бөгөөд Эмстэй хэдэн долоо хоногийн хойно бас уулзжээ. Энэ удаагийн уулзалтаар Керри урьд Чикагод байсан үеэс эхлэн түүнээс хойш маш удаан хугацааны дотор урьдынхаа хүсэл мөрөөдлийг орхисноо мэдэж авчээ. Яагаад тэгсэн юм бол?

-Та, драммын театрт л орвол их амжилт гаргана гэдгийг би сайн мэдэж байна. Би таны тоглохыг ажиглаад... гэж Эмс ярихад Керри:

-Тэгээд? гэв

Эмс, оньсогоо таасандаа баярлах мэтээр:

-Таны нүүр царайны байдл маш олон зүйлийг илэрхийлж чаддагт хамаг учир багйаа юм. Сэтгэлийг хөдөлгөдөг сайхан дуу, уран зургийн увдисын аль алийг илэрхийлж чадаж байна. Энэ хүн төрөлхтний бүхий л эрмэлзлийн зүй ёсны тусгал юм шүү дээ гэхэд Керри хэлж буй үгнийх нь учир утгыг гүйцэд ухааралгүй нүд дүрлийлгэн ширтлээ.

-Хүн бол өөрийнхөө эрмэлзлийг илэрхийлэхийг оролддог юм. Гэтэл ихэнх нь сэтгэлээ илэрхийлж чаддаггүй юм. Тэгэхлээр бусдын хүчээр илэрхийлэхийг хүсдэг. Ийм учраас авьяас чадалтай хүн хэрэгтэй болдог. Тийм хүмүүсийн зарим нь хүний сэтгэл эрм элзлийг хөгжмөөр, зарим нь шүлгээр, зарим нь эмгэнэлт жүжгээр илэрхийлж өгдөг юм. Бас заримдаа байгаль маань хүний бүх зүрх сэтгэлийнх нь эрмэлзлийг нүүр царайд нь бичиж өгсөн юм шиг заяадаг байна. Тэгээд нүүр царайг гнэ сэтгэл зүрхнийх бүх эрмэлзлийн толь болгодог байх юм. Таныг чухам тэгж заяасан байна даа гэж Эмс хэлээд үгийнхээ утга санааг ой тойнд нь хүргэхийг хичээн өөдөөс нь харахад Керри санааг нь ойлгосон байлаа.

Өөрөөр хэлбэл, хүний хүсэл эрмэлзлийг нүүр царай маань илэрхийлдэг юм байна даа гэж бодсон ажээ. Үнэхээр тийм бол сайхан харэг гэж баярлаж байлаа.

- Энэ бол танд хариуцлага хүлээлгэж байна гэсэн үг. Та нэгэнт тийм авьяастай төрснөөс тэр шүү дээ. Энэ бол таны гавьяа ч биш, өөрөөр хэлбэл, та тийм авьяасгүй байж ч болох байсан. Та тийм авьяастай болохны тулд юу ч төлөөгүй. гэвч нэгэнт танд тийм юм заяасан хойно түүнийгээ ашиглах хэрэгтэй шүү дээ гэхэд Керри:

- Юу гэсэн үг вэ? гэв.

- Драмын жүжигт л тогло гэсэн үг дээ. Зөв төрх чинь хүний нүдэнд дулаан, дуугарах дуу хоолой чинь уянга эгшиг баян байна. Үүнийгээ бусдад зориулаач. Тэгвэл таны энэ увдис хэзээ ч алдагдахгүй.

Керри энэ үгийн сүүлчийн хэсгийнх нь учрыг ойлгоогүй ч гэсэн шог жүжигт тоглоод олсон амжилт нь чамлалттай буюу огт юу ч биш гэсэн үг юм гэдгийг ойлгожээ. Тэгээд:

- Таны хэлсэн үгийн учрыг нэг л олигтой ойлгохгүй байна шүү гэхэд Эмс:

- Таны нүд, ам, зан төрхөд онцлог байна, хэрэв энэ бүгдийгээ зохих ёсоор нь чиглүүлэхгүй гагцхүү өөрийнхөө хэрэгцээг хангах төдийд хэрэглэх юм бол заяаныхаа увдисыг алдаж мэднэ. Нүдний чинь гал буурч, ам уруулын чинв байдал өөр болж, тоглох ур чадвар чинь алга болно. хаанаас тэгэх вэ гэж өөрөө бодож байж магадгүй, гэвч байгаалиас заяасан юмыг энхрийлэн тордож байхгүй бол биш болдог юм шүү дээ гэдгийг л хэлэх гэсэн юм гэлээ.

Эмс өөрийн бодсоныг Керрид ойлгуулах гэж хамаг ухаан бодлоо зарцуулан чармайхдаа Керрийн урам зоригийг бадрахыг эрмэлзэж байлаа. Керрид хэрэгсэхгүй хаяж үл болох тийм чухал нандин авьяас байна гэж Эмс бодсоноос тийнхүү улайран ухуулж байсан буйзаа.

Керри түүний үгийг сонсоод өөрөө нэлээд буруутай мэт үзэж,

- таны хэлж байгаа зөв юм байна гэж би ойлголоо гэж алмайдуу маягтай хэлэв.

- Би л бол өөрчилнө.

Энэ ярианы нөлөө нь тогтуун усанд шидсэн чулуу шиг бөйлаа.

Керри хэдэн хоногийн турш эргэдэг сандал дээрээ суучихаад бодол болж байв. Тэгснээ Лолад:

- Би, хошин жүжигт тоглохоо ингэсгээд болино байгаа гэхэд цаадах нь:

- Өө, яагаад тэр билээ гэхэд

- Эмгэнэлт жүжгэнд тогловол илүү амжилттай болох байх гэж бодох юм.

- Яагаад ийм бодол толгойд чинь орж ирэх болоо вэ?

- Яагаад нь ч юу байхав, ер нь би хэзээний ингэж боддог байсан юм.

Гэвч Керри шийдэж чадахгүй дэмий л гуингласаар. Тэр илүү болно гэсэн зүйлээ буюу тэгж санагдсан зүйлийнхээ мөрийг хөөе гэж шийдтэлээ мөн ч удлаа, одоогийн байдал нь гомдолгүй тохилог санагдлаа ч гэсэн идэвхгүй хоосон хүслэн болгон өнгөрөөж суух ажээ.

ДИЙЛДЭГСДИЙН ТАВИЛАН. ЯТГЫН ЭГШИГ

Тэр үед Херствүд ядрахынхаа туйлд хүрээд очих болсон өнөөх ахмадын эрхэлдэг тиймэрхүү тэтгэмжийн газар тум хотод олон байжээ. Тэдгээрийн нэг нь Арван тавдугаар гудамжнаа орших Буянт эгч дүүсийн тэтгэмжийн газар гэгч мөн агаад тэрхүү айлын сууц агсан улаан тоосгон байуингийн хаалган дээр өглөгийн модон хайрцаг үргэлж дүүжлээстэй байх бөгөөд түүн дээр тус тэтгэмжийн газар ирж тусыг хүртэх хэнд боловч өдөрт үнэ төлбрөггүй хоол олгоно гэсэн зарлал харагдана. Тэр туйлын эгэл жирийн зарлал нь үнэнэ хэрэг дээрээ маш олон гуйлгачинд аяга хоол хайрлана гэсэн үг. Нью-Йорк хотод тэр мэтийн тэтгэмж тусламжийн газар зөндөө бөйх учир хангалуун яваа хмүүс тэдгээрийн үүдээр гарахдаа хаягий нь харах ч үгүй өнгөрнө. Тэдгээрийн үйл ажиллагааг эс мэдэх хүн өглөөний цагаар Зургадугаар өргөн чөлөө, Арван тавдугаар гудамж хоёрын тэр хөл ихтэй газар ажиглан зогсвол зай завсаргүй цувах олны дотроос насандаа элдвийг үзэж авах царайгүй болсон, өмссөн хувцас хунар нь тамтгаа алдаж, өөрөө хоёр хөлөө храйхийн чирч явах тийм хүмүүс хэдхэн хором болгонд ялгарах салж буйг олж үзэх болно. Үүнийг өдрийн хүйтний эрч хичнээн их болох утсмаа төчнөөн тодорхой ажиж болох аж. Дотрохи зай хооллох өрөө нь харуигүй өмгөр болохоор нэг удаад хорин тав-гучаас илүү хүн оруулж эс чадах тул бусад нь гадаа урт эгнээ болон хүлээх агаад оруулах ээлж журмыг нарийн сахихаас өөр юмгүй. Энэ газрын үйл ажиллагаа өдөр болгон имй маягаар явж эдүгээ нэгэнт олон жил болсон тул хэзээ язааны ажил мэт санагдаж түүнийг анхаарч сонирхох хүнгүй болсон гэхэд болох ажээ. Тэр ядуу хүмүүс аяга хоол олж идлэх гэж өвлийн хүйтэнд ч осгож үхтлээ хичнээн цагаар хүлээн зогсох амуй. Энд хэнээс юу ч асууж байцаахгүй, ямар ч үйлчилгээ байхгүй, гагцхүү хоол идүүлээд явуулна. Зарим нь өвөлжин, өдөр бүр ирж зогсоно.

Энэ газрын үүдэн дээр түмний эхний шинжтэй бүдүүн тарган авгай ямагт зогсож оруулж хооллож болно гэсэн хүмүүсийнхээ тоог авч байх аж. Ядуус ээлжийн журмыг хатуу баримтлан үг дуугүй цувран байх агаад яарч тэвдсэн адгасан байдал үл харагдана. Тэднийг харахнаа оршуулгын цуваа гэлтэй. ГУнын эвэр хуга хөлдмөөр чимчигнэсэн жавартай салхинд хөөрхий тэднүүс гараа үрчин, хөлөө дэвслэн зогсоно. Гар хуруу, нүүр царай нь бээрэн өнгө зүс нь өөр болсон харагдана. Тэднийг гэгээн цагаан өдрийн гэрэлд шинжин харваас хоорондоо юутай төстэй, Тэд бол зуны дулаан улиралд цэцэглэгийн сандлууд дээр суун өнжиж орой болохоор тэндээ хонодог гэр оронгүй гуйлгачингууд юм.

Шөнө дундын цагаар Бродвей ба Аравдугаар гудамж руу харсан мухлагийнхаа хажуу хаалган дээр ирж гуйсан хүнд ширхэг жижигхэн талх өгч тэтгэмж үзүүлсээр бараг хорин таван жил болсон талхчин Флайшман гэгч хүн хотын нөгөө захад суудаг амуй. Тийнхүү сүүлийн хорин жилийн турш тэдний хаалган дээр шөнө болгон гурван зуу орчим хүн ирж хаалган дээр нь тавьсан том хайрцагтай талхнаас хувиа аваад шөнийн харанхуйд алга болдог байжээ. Анх эхэлсэн цагаас нь аваад эдүгээг хүртэл тэр хүмүүсийн шинж байдал, тоо толгойд гарсан өөрчлөлт бараг үгүй. Эндхийн амьдралыг ажиглаж байсан зоарим хүн тэр олон жилийн турш олон хүн ер байнга ирдгийг андахгүй болсон байв. Лав л хоёр нь арван таван жилийн турш нэг шөнийг ч алгасаагүй буй. Ер нь дөч юмуу гуч гаруй хүн тэндхийн орон тооны хүмүүс шиг бараг алгасахгүй ирнэ. Бусад нь бол зүс үзүүгүй хүмүүс харагдах аж. Аж ахжин хямралтай, хүнд гачаа тохиолдсон үед тэднийхээр ирэх хүмүүсийн тоо гурван зуугаас давна. Ажилгүйдэл багатай аж ахуй сэргэн мандаж буй үед ирэх хүн заримдаа цөөрнө. Ер нь өвөл ч бай, зун ч бай, шуургатай ч бай, үгүй ч бай, ээлтэй гайгүй цаг ч бай, гай түйтгэх дүүрэн цаг ч бай, Флайшманы талхны хайрцаг болзооных нь газар болдог тэр уйтгар гунигт ядуу хүмүүсийн тоо гурван зуу орчимд аанай эргэлдсээр байх ажээ. Тэр хоёр тэтгэмжийн газраар энэ жилийн хахир хүйтэнд Херствүд байнга

очдог нэгэн болжээ.

Нэг жигтэйхэн хүйтэн өдөр Херствүд гадуур гуйлгаа гуйж ганзага хоосон байхдаа үд хүртэлдэмий тийнхүү явсаар эртхэн ээлж дугаарт орох санаатай өнөөх тэтгэмжийнхээ газра хүрч очвол өөртэй нь адил хэдэн амьтан бүр арван нэгэн цагийн алдад Зургадугаар өргөн чөлөөнөөс гараад нимгэн муу хувцсаа хүйтэн салхинд дэрвүүлсээр тэнд хүрч очсон байлаа. Түрүүлж ирсэн нь гуанзанд хамгийн түрүүчээр орох гэж Арван тавдугаар гудамж руу харсан есдүгээр хорооны зэвсгийн сангийн байшингийн хаалт хашааны төмөр сараалж налан зогсоно. Гуанз нээгдтэл бас бүхэл цагийн зай байсан болохоор тэд үүднээс нэлээд зайдуу зогсож байсан боловч хүмүүс нэмэн нэмэн ирэх тул түрүүлж ирсэн эрхээ алдахгүйн тулд үүд рүү дөхөн ойртож авай. Херствүд Долдугаар өргөн чөлөөний тэндээс хүрч ирээд тэдний дотор орж хаалга руу бусдаас бүрр ойр дөхөн зогсов. Гэтэл түүнээс аль түрүүн ирсэн хүмүүс бушуухан хаалга руу дөхөн ирээд үг хээлгүй боловч ямар нэг мэдэгдэх дохиогоор Херствүдийг хойгуур орж зогссон чинь таарах байх шүү гэж ойлгуулав.

Тийнхүү тэндээсээ хөөгдөж урам хугаран ээлж дугаараар зогсох хүмүүсийн хамгийн шувтарганд орох нь тэр. Нэгэнт журам сахигдсан хойно адгуусны чанартай дайсагнах сэтгэл замхран алга болжээ.

- Үд болох тун дөхсөн байх ёстой гэж нэг нь хэлэхэд бас нэг нь:

- Тийм ээ, би ирээд цаг шахуу хүлээж байна гэв.

- Лүд шиг хүйтэн бэ.

Тэд, одоо ингээд орох ёстой хаалга руугаа нүд цэвчилгүй ширтэв. Хүнсний дэлгүүрийн хүн хүрч ирэн хэдэн сагстай идэх юм дотогш авч орлоо. ҮҮнийг хараад хүнсний худалдаачдын талаар болон хүнсний барааны үнийн тухай бага сага яриа гарав.

- Махны үнэ тэнгэрт хадаж байна гэнэ.

- Дайн гарсан бол яах вэ? Нэлээд юм болох байсан байх аа.

Тэнд ирэх хүмүүс улам олон болсоор ээлж дугаарт зогсож буй хүмүүсийн цуваа гонжийсон урт болоход дээгүүр байгаа нэг нь одоо удахгүй орно гэж баярлаж байхад шувтаргаар зогсох нэг нь мөддөө вмны бараа харахгүй нь хэмээн гонсойх аж. Түрүүчээр зогсож байгаа хүмүүс сүүлчээр байгаагаа харах гэж байн байн эргэж харна.

- Эхний хорин тавд л багтсан бол үүдэнд хичнээн ойр байсан ч ялгаагүй шүү дээ, бүгд хамт орохоос хойш гэж эхний хорин тавд багдсан нэг хүн хэлж байна.

- Чаавас! Гэж Херствүд тийнхүү арагшаа хөөгдөхөд хүрсэндээ бувтнав.

- Нэгдсэн татвар гэж нэг юм байдаг. Тийм юмгүйгээр журам тогтож чадахгүй гэж бас нэг хүн хэлэв.

Өлсгөлөн тэр хүмүүс үүд рүү байн байн хяламхийн бээрч буй гараа үрчин хөлөө дэвслэн голцуу дуугай зогсоно.

Саатан хүлээсэн цаг болж үүд нээгдэн түмний эхийн шинжтэй авгай гарч ирээд ээлж дугаарын журмыг сахиулан ганц ганцаар нь оруулсаар хорин тав болоход нөгөө авгай бадриун гараараа таслан зогсоов. Зургаан хүн ам мөлтөс довжоон дээр гарсан байлаа. Тэдний нэг нь шөнийн зоогийн газрын эрхлэгч агсан маань билээ. Тийнхүү хүлээх зуур зарим нь юм ярьж, зарим нь муу заяандаа гоморхож, Херствүд мэтийн зарим нэг нь дув дуугүй хүрхийн зогсох аж. Тэгж байтал орох ээлж нь болж хоол идэж гарахдаа ингэж махаа идэж байж голоо зогсоох гэж дээ хэмээн бараг уурласаар явлаа.

Түүнээс хойш хоёр долоо хоног орчим болоод нэг орой арван нэгэн цагийн үед Херствүд шөнө орой болсон хойно өнөөх жижиг бөөрөнхий талх үнэгүй өгдөг газрын үүдэн дээр тэвчээр гарган зогсож авай. Тэр өдөр мань эрийн хувьд туйлын азгүй муу адар байсан боловч өдөр нь хоол идэж чадахгүй буюу орой ихэд өлсөх дээр хүртэл хүрээд ирж байх ийм газар байдаг чинь догь хэрэг шүү хэмээн сэтгэлээ тэуээн бясалган бодох байдалтай зогсном билээ. Арван хоёрт хэдхэн минут дутуу байхад талхтай том хайрцгийг цаанаас гарган ирж яг арван хоёр болоход лагс биетэй зоос мэт дугариг нүүртэй герман хүн гарч ирээд хайрцагны дэргэд зогсон: - “За авч болно шүү” гэхэд хүлээж байсан хүмүүс ухасхийн ойртож хүн бүр хувиа аваад зүг бүр таран одов. Энэ удаа шөнийн зоогийн газрын эрхлэгч агсан маань шөнийн хоног өнгөрөөх газрынхаа зүг оногдсон талхаа мэрэн харанхуй гудамжаар таг чиг хөлөө арай чарай зөөнө.

Нэг сар гарахын алдад Херствүд өөрийгөө нэгэнт өнгөрлөө гэж бодоход хүрч байв. Амьд явах шиг сайхан юм хаа байх билээ гэж боддог байсан бол үргэлж өлсөн цангаж ядаж зүдэх болсноос хойш хорвоогийн сайн сайхан гэдэг түүнд баахан хуурамч бөгөөд ойлгомжгүй санагдах болсон амуй. Заримдаа юм бүхэн нь урагшгүй болоод ирэхтэй зэрэг ингэж муугаа үзэж явснаас үхсэн минь дээр гэж бодох авч, тэнгэр овоо болоод ирэх юмуу, хэн нэг нь хорин таван мөнгө хайрлаж орхивол нөгөө бодол нь өөр болон хүлээзнэхээр шийднэ. Херствүд, өдөр бүр хуучин сонин энд тэнд байвал Керрийн тухай сураг олж мэдэх санаатай шүүн унших боловч бүхэл зунжин, намаржин огт юу ч олсонгүй. тэгээд ч сүүл сүүлдээ юм уншихлаар нүд нь хөшиж авчин болж ч мэдмээр болоход толгой хоргоддог сүүмгэр гэрэлтэй тэр оромжиндоо сонин уншихаа ч больж эхлэжээ. Муу чанарын мөртлөө алдаг оног олдох хоол түүний биеийг туйлдан эцээхэд хүргэжээ. Одоо шөнийн хоногийг толгой хоргодох юмтай өнгөрүүлж байх хэдэн мөнгө л олдож байвал дээд заяа гэж бодох болжээ.

Хүмүүс, Херствүдийн ноорхой уранхай хувцас, яс арьс болтлоо турж эцсэн байдлы нь хараад хэзээний гуйлгачин тэнүүлч гэж үзэх болжээ. Цагдаа нар түүнийг мөрдөн хавчина, зоогийн болон тэтгэмжийн толгой хоргодуулах газрынхан бараагий нь хармагц хөөж тууна, жирийн хүмүүс түүнээс бушуухан буруулан зугадах болсон тул гуйлга гуйхад улам улам хэцүү болж байв.

Хичнээн хүнээс гуйж үзсэн боловч нэг нь ч царай өгөхгүй харин салыхн түүс болон зугатаж байхыг мэдээд Херствүд одоо хөгөө бүрмөсөн өнгөрчээ гэж бодов.

- Ноёнтон минь, та надад буян болохгүй юу, би өлсөн үхэх нь гэж сүүлчийн удаа гуйлгахийж үзлээ.

- Ай муу новш бушуухан тонил, чамд юу өгдөг юм гэж загнуулжээ.

Херствүд хүйтэнд бээрч улаан хөөх болсон гараа халаасандаа хийлээ, нүднийх нь нулимс ч гүйлгэнээд ирлээ.

- Нээрэн би новш юм, үнэн хэлж байна. Сайн сайхан явж байлаа, мөнгөтэй байлаа. Одоо юу хийх вэ, дуусгая гэж дотроо бодоод үхэхээр шийдэн Баурын зүг эргэхдээ: “Хүмүүс гэрлийн хий тавиад үхдэг атал би яагаад болдоггүй билээ?” гэж бодов. Тэгээд хоног төөрүүлдэг жижигхэн өрөөнд хийн гэрлийн асаалга байдгийг санаж тэр газар чухам түүний тавьсан зорилгод зорьж цаанаасаа заяасан мэт санагдсан боловч тэнд очиж жижигхэн өрөө эзлэхэд арван таван мөнгөний хөлс авдгийг санаж арван таван мөнгөгүйгээ гэнэт санажээ.

- Эргээд явах замдаа үсчний үзэсгэлэнтэй газраас сахал үсээ засуулаад гарч явсан нэг эрхэмтэй тааралдаж:

- Та надад юухан боловч өгч хайрлахгүй юу? гэж гуйхад цаадах нь нэг сайн ажиж харснаа халаасандаа арван мөнгө эрсэн боловч хорин таван мөнгө байсныг авч өгөөд бушуухан салахын түүс болж:

- Май, за эндээс тонилж үз гэлээ.

Херствүд бодол болсхийн гэлдэрнэ. Нөгөө хүний өгсөн том зоос гялалзан сайхан харагдах бөгөөд өлсөж байгаага мэдэрч бас арван зоосоор нь толгой хоргодож хонох байр олдоно. Тэгж бодохлоор үхье гэж байснаа түр ч болов болив. Ер нь хүн юу өгөхгүй мөртлөө загнаж доромжлохоор л үхэх нь зөв юм гэж бодогддог аж. Өвлийн дунд сарын жигтэйхэн нэг өдөр хүйтрэн бүүдийж байснаа хоёр дах өдрөөс нь цас даржээ. Херствүд морь муутай байсан тул өдөржин яваад аравхан цент олсноо хоолонд өгчихжээ. Үдэш болоход цэцэглэгт ба Жаран долдугаар гудамжны хавиар эргэлдэж байснаа шөнийн хоног өнгөрөөх гэж Бауэрийн тийш эргэжээ. Өглөөнөөс орой хүртээ өдөржин тэнэж, хамраараа шургачиж, ойчтолоо ядраад нойтон гуталтай хөлөө арай чарай зөөсөөр, нимгэн хуучин пальтоныхоо оронцгийн захыг чихэндээ тултал буулган цоорч элэгдсэн бүрх малгайных нь хүрээ бүшр доош бууж сэтэрхийгээр нь чих нь цухуйх бөгөөд хоёр гараа халаасандаа шаасан харагдана.

“Бродвей хүрдэг хэрэг” гэж дотроо шийдэн очиход өдөр шиг гэрэл энд тэндгүй гялалзан мяралзана. Хүмүүс оройнхоо хоолыг идэхээр яарч буй бололтой. Хаашаа ч харсан байшин бүрийн цэлийсэн гэрэлтэй цонхуудаар нь баяр хөөртэй хүмүүс үзэсгэлэнт хээнцэр зоогийн газар ороод наргиан цэнгээнээ эхэлж байгаа харагдана. Тал бүрээс сүүх тэрэг, галт тэргүүд, хүн пиг дүүрэн бууж буй үзэгдэнэ.

“Ингэж явахын хэрэг юу байна, би бол нэгэнт өнгөрсөн хүн, үхэж байхдаа л таарсан толгой” гэсэн бодол Херствүдэд орж ирлээ. Хүний нүдэнд үнэхээр олзлогдмоор учир хүн болгон заавал ажна. Цагдаа нар ч энд гуйлга хийх гэж байгаа юм бол уу гэж хардан нүд салгалгүй ширтэнэ. Херствүд дэмий балай гэлдэрч явж байж нүд гялбам хаягтай нэг хээнцэр зоогийн газрын цонхоор харван асар том цэлгэр шилнийх нь цаана алтан шаргал, аранзал улаан голёл чимэглэл нов ногоог далдуу мод, цас шиг цагаан бүтээлэг, гял цал оргисон гангар шаазан эдлэл нүдэнд тусаж нэн ялангуяа ганга дэгжин, жаргалаа эдлэн суух олон хүн тун ч гайхалтай харагджээ. Өлсөж туйлдан ухаан санаа нь хэдийгээр балартаж явсан боловч харахтайгаа зэрэг гайхашран давхийн зогсож, шулхнаг нь хүртэл шавар шавхайд холилдсон нүднээс гарсан атлаа дотогш тэнэг харцаараа ширтэн:

- Идэцгээ, зөв идэцгээ. Энэнээс хэрэгтэй юм хэнд ч байхгүй гэж амандаа бувтнав.

Ингэж хэлсний дараа дуу нь улам доройтож бодож санаж байсан ухаан нь бүүдийрч эхлэв.

- Айхтар хүйтэн байх чинь, аймаар хүйтэн байна даа гэж хэлэв.

Бродвей, гучин есдүгээр гудамжинд Керрийн нэрийг “Керри Маденда” гэсэн гэрлэн бичээс бас “Казино кампани” гэсэн бичээс гялс гялс хийнэ. Туяа нь тал тал тийшээ цацрах тэр бичигтэй гэрэлд ойр хавийн цас шалбаагтай зам, гарц тодхон харагдана. Нэн тод учраас Херствүдийн анхаарал татагджээ. Херствүд өлийн харвал Керрийн биений хэмжээгээр зургийг алтан жаазанд хийсэн үзэгдэнэ. Херствүд түүнийг хараад нусаа татан, загатнаад байгаа юм шиг өрөөсөн мөрөө хөдөлгөв. Өөрөө дэндүү их зовж байсан болохоор ухаан санаа нь ээдий бүүдийхэн бөйлаа. Тэгээд.

- Энэ чинь чи юу, би чамд олигтой хүн байж чадсангүй юу? гэснээ эрэмбэ дараатайхан болох гэж оролдсон боловч ухаан нь самуураад болж өгсөнгүй. Мөнгөний тухай бодогдохлоор:

- Мөнгөтэй болоо л доо. Надад хэлэн юм өгч л таараа гэж сэтгэлээ.

Тэгээд хажуугийн хаалга руу чиглэн явснаа төдхөн яах гэж тийшээ явж байгаагаар мартаад хэсэг бодол болж бээрсэн гараа дулаацуулах санаатай халаасандаа царвугаа даартал шургууллаа. Тэгснээ “Аа тийм хажуу хаалгаар нь оръё” гэж бодсон шүү дээ гээд алхлаа. Орцонд нь хүрч очоод шагайвал манаач түүний сүрхий ширтэн дэргэд нь хүрч ирээд:

- Юу вэ? Эндээс бушуухан тонил гэхэд Херствүд:

- Би Маденда хатагтайтай уулзах гэсэн юм гэлээ.

- Чи юу? Яалаа гэнэ ээ? гэж нөгөө хүн ёжлон асуугаад:

- Одоохон чамайг эндээс тонил гэж байна хэмээн түлхэж эхлэв. Херствүд хариуд нь яаж ч чадахгүй түлхэгдэн явахдаа дэмий л:

- Би Маденда хатагтайтай уулзах гэсэн юм, би зүгээр л ... гэсэн боловч цаад хүн хүчлэн түлхэж хөөгөөд хаалгаа тавхийтэл хааж орхилоо. Херствүд цасан дээр хүчтэй өнрхөн унасан учир, өвдөж бас ч ичих шиг болж баахан тэнэг үгтэй хараал тавив. Муу навтаснаасаа цасыг гүвэх зуур:

- Ай муу хувхай, би чам шиг юмыг цагтаа зарж л явсан вч гэж хашгирав.

Бас Керрийг аль муугаар дуудаж занаж зүхмээр санагдсан боловч ухаан нь самуураад тэгсгээл мартлаа.

“Тэр чинь надад идэх юмны өглөгтэй хүн, надад идэх юм өгөх учиртай хүн” гэж хашгирч үзсэнээ аргаа барж Бродвейн зүг дахин эргэж гуйлга гуйн уйлагнасаар ухаан нь нэг орж нэг гарч буй боллолтой ээдий бүүдий юм явлаа.

Түүнээс хойш хэдэн өдөр өнгөрч нэгэн үдэш өвлийн жин хүйтэн тачигнахад орж гарч өайсан ухаан эцсийн нэг шийд гаргажээ. Бүр дөрвөн цагаас эхлэн тэнгэр харанхуйлан өтгөн цас лавсан орж эхэлснээ хацар хуруу чимчигнүүлсэн хүйтэн салхи шавхуурдан цасан шуурга болов. Төдхөн газрын хөрсийг зургаан ямх зузаан цас бүрхэж хүний хөл, сорьдын туурай шороотой хлин хүрэн бор юм болгон хувиргав. Бродвейгээр ийш тийш зорчих хүмүүс дулаан дээл өмсөж бас шүхэр барьцгаасан харагдана. Баурын гудамжаар явах хүмүүс захаа босгож малгайгаа чихээ хүртэл

даран хавчигналдана. Үйлдвэр худалдааны эзэд жуулчлагч чинээлэг хүмүүс их хотын аль тохилог зоог цэнгээний газруудаар тух таваа олж ядна. харин Бауэрын гудамжаар гэрэл нь тэртээ тэнд сүүмэлзэх жижиг мухлагуудын хавиар бээрч даарсан хүмүүс хөлхөлдөнө. Вагонууд гэрлээ эрт асааж, дугуйнуудынх нь харчигнах дуу чимээ наалдан барилдах цасанд бүдгэрч, хот бүхэлдээ нэвсгэр зузаан цасан хэвнэг нөмөрсөн мэт авай.

Яг тэр үед Керри, Волдорф зочид буудлынхаа тохилог өрөөнд суугаад Эмсийн уншаарай гэсэн “Эцэг Горио” хэмээх зохиол уншиж байлаа. Бальзакийн тэр зохиол Керрийд маш сонирхолтой санагдаж Эмс юун ашгүй уншаарай гэсэн юм хэмээн ихэд амтархан сууж салж чадахгүй уншина. Түрүүчийн уншиж байсан ном зохиол нь хичнээн шалихгүй утга учир ядуу байсныг Керри одоо ойлгожээ. Сүүлдээ ядарч эвшээн босож цонхон дээрээ очиж Тавдугаар өргөн чөлөөгөөр эцэс төгсгөлгүй цувах тармвайн цувааг ажиглав.

- Гадаа их муухай байна уу даа? гэж Лолагаас асуухад Лола:

- Жигтэйхэн. Цанаар явж болохуйц цас орох нь шиг байна гэж жижигхэн найз охин нь хариу хэлэв.

- Ээ, Лола минь, чи тийм л юм бодож байна. Ийм үед толгой хоргодох орон гэр ч үгүй хүмүүсийг чи өрөвдөхгүй байна уу? гэж саяхан Горио эцгийн зовлонгийн тухай уншиж байсан сэтгэгдэлд автсан Керри хэлэхэд Лола:

- Өрөвдөлгүй яах вэ, гэсэн ч ба яана гэх вэ, би өөрөө ч хоосон хүн шүү дээ гэв:

Керри инээмсэглэж:

- Чи баян байсан бол хүн нэг их өрөвдөхгүй байх шүү гэхэд Лола:

- Өрөвдөх байх шүү, харин намайг ядарч явахад хүн юу ч өгдөггүй байсан шүү гэв.

Керри гадаа цасан шуурга тавьж буйг хараад:

- Яасан аймшигтай юм болж байна вэ гэхэд цасан дээр шургачиж ойчиж байгаа нэг хүнийг харсан Лола инээж:

- Хүүе тэр хүнийг хараач, хүн ойчихлоороо яасан инээдтэй харагддаг юм бэ? гэв.

- Хоёулаа өнөө орой тэрээд очих юм шүү гэж Керри алмайрсан байдалтай хариу дуугарав.

“Империал” хэмээх зочид буудлын хөлийн өрөөнд дөнгөж сая орж ирсэн Чарльз Дрүэ гоёмсог пальтоныхоо цасыг шилгээв. Тэнгэр муухай болохын хамт байр руугаа яарснаас гадна харанхуй хүйтэн цагаар аль сайхан орон байранд наргин цэнгэхийг хүсэмжилжээ. Сайхан хоол идэж аваад гоёхон бүсгүй дагуулж аль нэг театрт очих гэж л бодсон аж.

-Сайн уу, Харри гэж эвтэйхэн зөөлөн сандал дээр суух нэгэн залуутай мэнд усаа мэдэхэд цаадах нь:

- Өө, дажгүй гэлээ.

- Тэнгэр мөн ч муухай байх чинь.

- Хэлээд яах вэ, би өнөө орой хаачдаг билээ гэж бодож суулаа.

- Хоёул хамт явууж. Чамайг нэг гоё хүүхэнтэй танилцуулж өгье.

- Хэн гээч вэ?

- Дөчдүгээр өргөн чөлөөнд байдаг хоёр хүүхэн. Сайхан шиг наргина даа. Би чамайг яаж олъё доо гэж явсан юм.

- За тэгвэл тэр хоёры чинь аваад хоолонд орвол яасан юм?

- Тэгэлгүй яах вэ. Жаахан хүүлэзнэ, би дээш гарч хувцсаа сольчихоод ирье.

- За тэгвэл би ч гэмээнэ үсчинд ороотохъё.

- Тэг тэг гээд Дрүү шинэхэн гутлаа хяхтнуулсаар өргүүр шат руу явлаа. Дэнгийн эрвээхэй эцэж цуцахаа мэдэхгүй дэрвэлзсээр л авай.

Нью-Йорк тийш цагт дөичн милийн хурдтайгаар тэр орой цасан шуурганаар хурдлан яваа пульманы галт тэрэгний нэгэн өрөөнд гурван хүн сууж явна.

Цас шиг цагаан элгэвч, цамцтай галт тэрэгний үйлчлэгч өрөөнүүдийн үүдээр яаран явахдаа:

- Хоолонд орох дохионы анхны хонх дуугарсан шүү гэж зарлана.

- Би дахиж тогломооргүй байна гээд зөрүүд байдлаараа гараа татан авч байгаа хав хар үстэй, баян тарган амьдралдаа ташууран ихэмсэг зантай болсон залуухан эмэгтэй нь хэлэхэд хамгийн сүүлийн үеийн дэгжин хийцтэй костюмтай залуу нөхөр нь:

Одоо хоолондоо орох уу даа гэв.

- Үгүй, хоол идмээргүй байна. Тоглох ч дур алга.

- Жессика, зангианыхаа зүүг цааш нь дар, дандаа гарч ирчихээд байх юм гэж бас л насандаа ахадмаар дэндүү их гангалж хувцасласан эх нь хэлэв.

Жессика эхийнхээ үгэнд орж зангианыхаа зүүг засаад өтгөн хар үсээ гараар илж бугуйнд нь зүүсэн эрдэнийн чулуун нүүртэй цагаа харлаа. Нөхөр нь авгайхаа хичээн хүйтэн царайтай байгаа гэсэн ч үзэсгэлэн гоог нь ширтэн ажиж сууна. Тэгснээ:

- Ийм муухай агаартай газар удах хэрэг алга, хоёр долоо хоногийн дараа гэхэд бид Ромд байх болно доо гэв.

Херствүд хатагтай, өөрийнхөө буланд суугаад инээмсэглэнэ. Баян хүргэнтэй байх, тэгээд бас санхүүгий нь гардан мэдэж байх шиг сайхан юм гэж хаана байх билээ.

- Хөлөг онгоцонд тэнгэр ийм байх саад болохгүй биз? гэж Жессика асуухад нөхөр нь:

- Хаанаас! Хөлөн онгоцонд тэнгэр ямар ч байсан саад болж чадахгүй гэж сэтгэлий нь тайвшруулав.

Тэдний сууж байгаа өрөөний хажуугаар Чикагогийн банкны эзний гялалзсан халимагтай хүү явах агаад тэр залуу энэ их зантай хөөрхөн хүүхнийг ихэд шохоорхох ажээ. Одоо ч гэсэн тэр залуу үүдээр нь гарахдаа түүнийг харалгүй өнгөрч чадсангүй. Жессика үүнийг сайн мэдэж байсан болохоор зриуд нүүрээ буруулах нь хүний даруу ичимхий зангаас биү харин ихэмсэг онгиороо байдлаа нотлон харуулсан хэрэг билээ.

Яг энэ үед Херствүд Бауэрын ойролцоох догол гудамж дахь урьд бүдэг шар өнгөтэй байсан боловч өдгөө бороо шороо, хөө утаанд огт өөр болсон бохир, дөрвөн давхар байшингийн үүдэнд уван цуван ирж бөөгнөрөн түгжээтэй хаалганых нь өмнө хөлөө дэвслэн бээрэх шахан зогсох хүмүүсийн дотор зогсоно. Тэдний үжирч үнгэгдсэн бүрх малгай нь хэвээ алдаж хүрээ нь чих рүү нь буужээ. Биед нь таараагүй пальторхуу юм нь хайлсан цасанд хүндрэн мөрий нь дарах агаад захы нь босгожээ. Шуудай шиг болсон өмдний шулхнаг дороос зантгар толгойтой хоншоороороо эргэсэн савхин гутал цухуйна. Тэд дотогш орох гэж тэмүүлэхгүй хааяа дотор асах сүүмгэр гэрэл, гудамжаар яваа хүмүүсийн зүг хялахийн хөлөө дэвслэн хоёр гараа халаасандаа лав шаасан байна. Энд тэндээс нэмж ирэх хүн олширсоор л. Тэдний дотор буурал сахалтай, нүд нь ширгэсэн өвөгчүүл ч харагдана. Дунд зэргийн асны боловч өвчинд нэрвэгдэж зүс царай алдсан залуувтар хүмүүс ч харагдана. Тарган гэж хэлмээр хүн ер үзэгдэхгүй. заримых нь царай хөдөс шиг цагаан, заримых нь бүр ягаан тоосго шиг хачин улаан харагдана. Заримых нь мөр бөх шиг ёрдойно, зарим нь модон хөлтэй, зарим нь яс болтлоо турсан учир хувцас нь жодгор модонд өлгөөтэй мэр харагдана. Бүгдээрийнх нь чих нь дэлдийж, хамар нь улайж, уруул нь омголтож, нүдэнд нь цус хурсан ажээ. Тэдний дотор эрүүл царайтай, эгц нуруутай, сэргэлэн харцтай ганц хүн үзэгдэхгүй. шавхуурдах салхи, цасанд тэд хуйлран бүдэчсээр шагай шиг бөөгнөрнө. Заримых нь улаан нүцгэн гар харагдана. Заримых нь оронцог болсон бүрх малгай нь хөлдөж унах шахсан чихийг нь хаацайлж чадахгүй аж. Тэр хүмүүс дулаацах санаатай зэрэг зэрэг хөлөө дэвсэлнэ.

Үүдэн дээр цугларах хүмүүсийн тоо нэмэгдэх тутам муухай хараалын үг сонсдох нь олширно.

- Муусайн үхээрүүд чинь, яагаад үүдээ онгойлгодоггүй юм.

- Тэр цагдаа мануухайг хараач. Биднээс нүд салгалгүй байна.

- Өвөл гэдгийг мартчихаа юм болов уу.

- Ингэж байснаас энэ муж улсын шоронд сууж байсан дээр гэх мэт үг дуулдах аж.

Гэнэт хүтйэн салх хүчтэй сүрдхийн салхилахад гэр оронгүй тэр хүмүүс шахцалдан гуйвж түлхэлдэхэд хэн нь уурлаж уцаарласангүй, хэн нь ч гомдол гаргасангүй, хэн нь занаж зүхсэнгүй. Тийнхүү муугаа үзэн зогсох үйл тамыг мартагнуулах үг хэлэх хүн ч гарсангэй. Тэдний дэргэдүүр жууз тэргэндээ ганайн суусан нэг ноён явж өнгөрөхөд байшингийн яг үүдэнд зогсож байсан хэн нэг нь:

- Тэр амьтны заларч байгааг хараач гэхэд бас нэг нь:

- Тэр даарахын зовлон үзэхгүй хүн гэхэд өнөөх жууз аль хэдийн бараагүй алга болсон боловч бас нэг гуйлгачин:

- Хүүе, хүүе, хүүе гэж хашгирч байлаа.

Үдэш орой болсоор байхад хүмүүс гэр гэрийн зүг яарна. Дэлгүүр худалдааны газрын жижиг албан хаагч, худалдагч хүүхнүүд хурдан хурдан алхлан өнгөрнө. Хүн пиг дүүрэн суулгасан трамвайнууд түрчигнэн явна. Хийн гэрэл энд тэндгүй счээ. Байшингийн цонхоор жигд улаавтар гэрэл харагдана. Өнөөх хүмүүс үүдээ сахин хүлээн зогссоор л байна.

- Эд нар ер нь үүдээ нэхээ больсон юм биш биз дээ? гэж нэг нь сөөнгө дуугаар хэлэхэд бүгдийн сонирхол татагдаж түгжээтэй хаалгыг цөм шимтэн ширтэх болов.

Тэд үүд рүү яг л нохой шиншиж, савраараа маажлах адил ширтэж эхлэв. Дөл мөрөө хавчигнуулан, нүд амаа хөдөлгөн гэнэ гэнэ хараал, гэнэ гэнэ дуу алдан үглэх амуй. Цас лавсан орж, салхинд хуйлран шавхуурдана. Тэд ч цөхрөнгөө баран хүлээсээр л байна. хуучин бүрх малгай, ёрдгор мөрнүүд дээр нь цас овоолсоор байвч хэн ч шилгээн сэгсрэх нь үгүй. дундуур зогсож буй хүмүүсийн амьсгаа биеийн илчинд дулаацахад цас ч хайлж, муусайн малгайнуудынх нь унжсан захнаас дуслан хамрыг нь даган урсахад түүнийг гараараа арчих сөгөөтэй амьтан ч алга. Хайлаагүй үлдэх цас нь улам зузаарсаар байв. Хесртвүд хүмүүсийн голд орж чадаагүй захад нь салхи цаснаас буруулах санаагаар толгой гудайлган байдгаараа бөгцийн зогсоно.

Хаалганы дээгүүр гэрэл гялсхийхэд хүмүүс дэрхийн бушуухан дотогшлохыг хүлээв. Цоож торхийхэд хүмүүсийн чих дэлдэсхийн хөл дээрээ хавчигнан хөдөлдж бас бүдэгхэн дуугаар хүнгэнэлдэхэд хэн нэгэн этгээд: “Аяар, аяар, битгий чихэлд” гээд үүд нээв. Даарч бээрсэн тэд ганц хормын төдий хугацаанд адгуус мэтээр шуухиналдан ороод алга болох нь яг л голын дээрх манан замхрахтай адил аж. Орой зургаан цаг болж байсан болохоор хүн бүр үдшийнхээ хоолонд яарч байсан боловч эднийг энэ газар хоолгүй гагцхүү хоосон ор угтана.

Херствүд, арван таван центээ гаргаж өгөөд оногдсон аягын чинээ өрөөндөө оров. Тэр нь модон ханатай шороо тоосонд дарагдсан харанхуй нүх адил юм. Жаахан тасалгааг арайхийн гэрэлтүүлэх сүүмийсэн хийн дэнлүү асна. Херствүд хоолойгоо засаад үүдээ цоожлов. Тэгээд хувцсаа яарамгүй тайлж эхлэв. Юуны урьд цасцаараа үүдний доогуур гарсан том нүхийг далдлав. Хантаазаа ч бас тийм зорилгод хэрэглэв. Үнгэгдэж урагдсан хуучин муу бүрхээ тайлаад ширээн дээр аяархан тавилаа. Тэгээд гутлаа тайлаад сунан хэвтлээ.

Тэгснээ гэнэт нэг юм санасан юм шиг босож хэн ч түүнийг олж харахгүй хав харанхуйн дунд хэсэг тээнэгэлзэн зогсож байснаа хийн цоргийг нээсэн боловч чүдэнз зурсангүй. Тэгээд хав харанхуйд хэсэг зогсож хамарт нь хачин муухай үнэ хан хийхтэй зэрэг сая тэмтчин байж орон дээрээ очлоо. Тийнхүү сунан хэвтэхдээ үл мэдэг дуулдахаар:

- Хэрэг байна уу даа? гэж хэлэв.

Керри анх амьдралынхаа зорилго буюу ямар ч болтугай хүний хүсэл мөрөөдлийн дээд гэж санаж сарвайж явсандаа нэгэнт хүрсэн ажээ. Өмсөж зүүх, гоё ганган хувцас, өөрийн гэх сүүх тэрэг, оршин суух орон сууц, банканд хадгалуулсан мөнгөө бодоход ч дутуу юмгүй болжээ. Өөрийнх нь өөдрөг явааг тоож биширсэндээ уулзаж учирсан газар бүрдээ толгой дохин мэхэлзэж инээж мишээж явдаг найз нөхөдтэй ч болов. Түүнд энэ бүхнийг хүсэж мөрөөдөж байсан цаг бий билээ. Бишрэн шүтэж алгаа өвдтөл таших хүмүүс ч бий болжээ. Нэр алдрыг дагалдан явагч эдгээр зүйлс урьд машчухал хэрэгтэй мэт санагддаг байсан бол одоо ердийн зүйл болон хувирч огт сонирхлы нь татахаа больжээ. Керри тун царайлаг, хүний нүдэнд дулаан харагдаж усгал зөөлөн сайн

ааштай гэгдэх боловч их л ганцаардмал явах ажээ. Чөлөө завтай цагтаа байнга эргэлддэг сандал рээр суугаад дуу аялан хүсэл мөрөөдөл болно.

Амьдралд бясалгах дуртай оюун бодлын хүн, мэдрэц голдуутай эмзэгхэн чанарйын хүн гэж байдаг. Тэгээд түрүүчийнхээс нь жанжин, төрийн зүтгэлтэн, дараачийнхаас нь яруу найрагч, хүслэнд автагддаг хүмүүс, урлагийн хүмүүс төрдөг ажээ.

Ийм хүмүүс хүсэл мөрөөдлийн сэжүүр бүхэнд ятганы утас адил уянгалж, дээд эрмэлзлийн ухрах татрах бүрийд санаа сэтгэл нь дагалдан хөдөлнө билээ.

Хүн төрөлхтөн дээд эрмэлзлийг ойлгоогүйгээсээ дор хүсэн мөрөөдөгч хүнийг ч бас л ойлгоогүй байгаа юм. Хууль, эгэл жирийн ёс суртахууны шаардлага хүсэн мөрөөдөгчид хэтэрхий хатууддаг юм. Хүсэн мөрөөдөгч, гоо сайханд автаж, түүний алсын дэвэлт бүрийг алгасалгүй мэдрэн хойноос нь хөлөө эцтэл уйгагүй хөөцөлдөхөөс үл буцна. Чухамхүү ингэж л Керри гоо сайхныг сэтгэлдээ хөөцөлдөн мөрөөдөн дуу аялан суух ажээ.

Үүнд оюун ухаан их суурь эзэлдэггүйг тэмдэглүүштэй. Керри анх Чикагод ирж байхдаа тэр хот урьд хожид үзэгдээгүй их аз жаргалыг өгнө гэж бүүр түүр бодоод өөрийнхөө төрөлхийн занд автан тэр аз жаргалын хойноос хөөцөлдөж эхэлсэн юм. Сайхан хувцастай, тохилог чинээлэг амьдардаг хүмүүсийг хараад тэднийг жаргалтай улс хэмээн бодож, тийш тэмүүлж байлаа. Чикаго, Нью-Йорк, Дрүэ, Херствүд, ганган хээнцэр амьдрал, урлагийн тайз энэ бүхэн бол түүнд тохиолдсон зуурдын явдлууд байв. Чухамдаа бол тэдэнд биш, харин тэдний төлөөлж байсан мэт тэр амьдралд л татагдаж байсан бөлгөө. Түүний бодол буруу агсныг улирах цаг харуулжээ.

Хүний амьдрал гэгч юутай их будлиан бэ! Бид түүнийгээ хичнээн муу ойлгоно вэ! Анхнаасаа хал үзэж хашир таниагүй ядуу охин Керри яав даа. Амьдралд сайхан санагдсан бүхнийг хүсэн мөрөөдөж тэмүүлэвч, элгэн хад мөргөх шиг болжээ. “Сайхан юмыг хүсэж болно, гэхдээ ариун шударгын мөрөөр явахгүй бол бүү ойрт!” гэж хуулинд дурдсан мэт болой. “Шударга хөдөлмөрөөс өөр аргаар өөрийгөө дээш татаж үл болно” гэж нийтээр мөрдвөл зохих ёсон хэлэх мэт. Гэтэл ариун цагаан хөдөлмөрөөр амь зуух хэцүү, алжаал их болохул, хэрэв тэр зам урт, дэндүү урт болоод сайн сайханд хэзээ ч хүргэхээргүй аваас гагцхүү хөлийг ядрааж зүрхийг шаналаах аваас, хэрэв сайн сайханд татагдах нь хэтэрхий болж шулуун замаасаа гажиж, хүсэл мөрөөдлийнхөө зүйлст түргэвтэр хүрч очиж болох хажуугийн замаар орвоос түүн рүү анхных нь чулууг хэн хаяж таарах вэ? Замаасаа гажсан нэгнийг гай бус илүү сайныг хүсэмжлэх шунал л залж явах нь олонтаа тохиолдном. Шүүн тунгааж бодох зангүй эмзэгхэн хүнийг гай бус, сайн санаа хөтлөх нь олонтаа тохиолдном.

Керри, тарган цатгалан, гял цал амьдралд орлоо гээд аз жаргалыг олсонгүй. Тэр нэгэн цагт Дрүэ түүнд шохоорхож байхад Керри “Би одоо мандлаа” гэж бодож байсан ба Херствүд түүнээс ч илүү болоход “Би аз жаргалаа оллоо” гэж бодож байлаа. Гэсэн ч хүйтэн цэвдэг энэ ертөнцөд түүний эрээн бараан амьдралд эрээ цээргүй холилдож л эс явбал хажуугаар нь өнгөрөөд явчих шиг болно, тэгээд ч Керри одоо ганцаархнаа үлдсэн хэрэг. Керри ядарч зүдэрч яваа хүнд хэзээ ч гар татахгүй тус болно. Бродвейгээр алхаж явахдаа одоо ганган дэгжин хүмүүсийг нэг их юманд бодохоо ч больжээ. Харин гоо сайхан, энх тунх байдал ямар нэг хэмжээгээр хосолж харагдвал аятайхан санагдах амуй.

Прүэ дахин хөөцөлдөхөө больж үзэгдэхээ байв. Херствүдийн үхсэн тухайг ч Керри мэдээгүй аж. Хорин долдугаар гудамжны үзүүрийн зогсоолд долоо хоног бүр ирдэг хав хар өнгөтэй галт онгоц

энэ удаа аяархан хөвөн буцахдаа түүний хүүрийг бусад нэр үл мэдэх үхэгсдийн хамт Потерс Филд хэмээх оршуулгын газар авч оджээ.

Тийнхүү Керри, тэр хоёр хүнтэй харилцаа холбоогоо бүрмөсөн тасалжээ. Гагцхүү Керрийн хүсэл мөрөөдлийн улмаас л тэр хоёр хүн түүний амьдралын замд холбогдсон ажээ. Хоёулаа түүний өөдрөг явахын баталгаа мэт болж байсан үе ч бий. Хамгийн сайн сайхан бүхнийг төлөөлөгч, амар жимэр тарган цатгалан амьдралыг бүрэн эрхт итгэмжлэх бичгээ барьсаар бэлэглэж буй төлөөлөгч мэт байсан цаг бий. Тэдний төлөөлж байсан ертөнц нь нэгэнт сноирхлыг татахаа больсон цагт элч төлөөлөгч нар огцордог нь зүйн хэрэг билээ. Одоо Херствд урьдын адил ганган дэгжин, нэр цуутайгаа хэвээр хүрээд ирж гэмээнэ ч Керрийг татаж чадахгүй, яагаад гэвэл түүний ертөнц, түүнчлэн Керрийн одоогийн байдал аль аль нь аз жаргалыг авчирдаггүй юм гэдгийг ойлгосон байлаа.

Одоо Керри ганцаар сууж байгааг нь харвал гоо сайхны хойноос ухаанаараа биш мэдрэцээрээ хөөцөлдсөн хүн хичнээн бартаатай замаар явдгийн тод жишээ болох билээ. Хичнээн олон удаа цөхрөнгөө барахад хүрч байлаа ч хүсэл мөрөөдлөө хаяж чадахгүй дахиад л хүлээдэг асан ажээ. Эмс дараачийн замы нь хэлж өгсөн. Керри тэр замаар нь яваад бас л цаашлах болно. Ертөнцийн хараа үл хүрэх алс оргилын солонгортон туяарах гэрлийн зүг Керри хэзээд тэмүүлэх билээ.

Ээ Керри! Керри! Ээ, хүний зүрх сэтгэлийн сохор шунал аа! Гоо сайхан хаана байна, тийшээ л яваад бай, урагшаа! Урагшаа! Намуун бэлчээрт идээшлэх хонины хүзүүн дэх ганц хонхны дуу жингэнэсэн ч, аглаг хээр нутгийн гоо сайхан гялалзлаа ч, зуурдын тааралдах нүдний дулаан харц ч байлаа хүний зүрх гэгч мэдэрч даган баясаж хариу болгодог ажээ. Явах хөл ядарч горь тасрахын цагт зүрх шимширч, сэтгэл гансарна. Тэр цагт цадаж өегших юм байдаггүйг мэдэгтүн. Цонхныхоо дэргэд эргэдэг сандал дээрээ суугаад ганцаархнаа мөрөөдөн мөрөөдөн байх болноо! Цонхныхоо дэргэд эргэдэг сандал дээрээ суугаад хэзээ ч үл биелэх тийм мөрөөдөлдөө автсаар байх болноо!

Төгсөв.